

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
НИЙГМИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ**

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

ПОЛИТОЛОГИ

ISSN 2227-6904

№388 (10)

X

**УЛААНБААТАР ХОТ
2013 ОН**

POLITOLOGY

SCIENTIFIC JOURNAL

№ 388 (10)

X

ISSN 2227-6904

Key title: Politology

EDITORIAL BOARD

Editor in chief:	Yo.Dovchin
Associate Editor:	S.Bazarpurev
Secretary:	J.Turtogtokh
Board members:	Ts.Ganbold
	S.Munkhbat
	Ts.Batbold
	G.Tsend-Ayush
	Ch.Ulziisaikhan

Production Editor	S.Bazarpurev
Technical Editor	Ts.Ulzijargal

ПОЛИТОЛОГИ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№ 388 (10)

X

ISSN 2227-6904

Key title: Политологи

Редакцийн зөвлөл:

Эрхлэгч:	Ё.Довчин
Орлогч эрхлэгч:	С.Базарпүрэв
Нарийн бичгийн дарга:	Ж.Төртогтох
Гишүүд:	Ц.Ганболд С.Мөнхбат Ц.Батболд Г.Цэнд-Аюуш Ч.Өлзийсайхан
Дугаарыг эрхэлсэн:	С.Базарпүрэв
Техник редактор:	Ц.Өлзийжаргал

АГУУЛГА

Өмнөх үг	1
<u>Улс төрийн шинжлэх ухааны хөгжил</u>	
Ц.Ганболд ШУКО-оос Улс төр судлал хүртэл.....	9
Ё.Довчин Улс төрийн шинжлэх ухаан: олон улс ба Монгол.....	22
Б.Эрдэнэдалай Улс төрийн хөгжил: онол, практик.....	36
Д.Одмаа Их, дээд сургуулийн улс төр судлал хичээлийн өнөөгийн байдлын шинжилгээ.....	49
С.Базарпүрэв, Э.Бат-Эрдэнэ Улс төрийн сургаалын түүх судлалд хэл шинжлэлийн арга зүйг ашиглах нь.....	55
<u>Улс төрийн шинжлэх ухааны онолын асуудалд</u>	
Ц.Батболд Бюрократ удирдлагын талаарх Макс Веберийн цогц тайлбар.....	60
И.Лхам, Д.Болд-Эрдэнэ Иргэний нийгэм гэж юу вэ?.....	75
У.Батцэрэн Улс төрийн имиж: онол, үзэл баримтлал.....	80
Д.Оюунчимэг Улс төрийн маркетингийн зарим асуудлууд.....	99
Л.Сарангэрэл XXI зуун дахь хүний эрхийн боловсролын онолын асуудлууд.....	114
<u>Монголын улс төрийн сэтгэлгээ ба орчин үе</u>	
Л.Идэр “Арван буянт номын цагаан түүх” ба монгол төрт ёсны хөгжил.....	121
Д.Болд-Эрдэнэ Монгол төрийн засаглалын эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилт.....	126
Ч.Өлзийсайхан, Ц.Өлзийжаргал	

Улс төрийн дэглэмийн шилжилт ба Монголын улс төрийн элит.....	148
Ц.Ганболд, Б.Батдэлгэр	
Монгол дахь ардчиллын бэхжилт, хөгжлийн хандлага.....	158
Г.Цэнд-Аюуш, Ө.Лувсанренчин	
Ардчиллын үзэл баримтлал ба орчин үеийн монголын нийгмийн нөхцөл байдал.....	165
Я.Төгөлдөр	
Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн байдлын шинжилгээ.....	169
Б.Одгэрэл	
Парламент дахь эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо.....	181
Д.Мягмарсүрэн	
Улс төрд нөөц баялгийн үзүүлэх нөлөөлөл.....	191
Т.Туяачимэг	
Улс төрийн намын вэб сайтад хийсэн анализ.....	201
<u>Харьцуулсан улс төр</u>	
З.Батсайхан	
Хүннү ба өмнөд, өрнөд хөршийн харилцаа холбоо.....	210
М.Мөнхзул	
Үндэсний ухамсар болон үндэсний үзэл суртлын хямрал.....	217
Г.Цэнджав	
Хаант орос улсын санхүүгийн зөвлөх түшмэлтэй байгуулсан гэрээний тухайд.....	227
Ё.Довчин	
АНУ-ын улс төрийн систем.....	232
Э.Саранцэцэг	
Бүгд найрамдах Солонгос улсын дэглэмийн өөрчлөлт ба эдийн засгийн хөгжил.....	244
Ж.Төртогтох	
The 19 th National Assembly Election and Post-Election Political Changes in Korea.....	252
С.Базарпүрэв	
Улс төрийн реализм ба олон улсын харилцаан дахь бага улсын жижиг “бодол”.....	270
Нийтлэлийн шаардлага, стандарт.....	276

CONTENTS

FOREWORD.....	1
<u>Political Science Development</u>	
Ganbold.Ts From Scientific and Communism Theory to Department of Political Science.....	9
Dovchin.Yo Political Science: Mongolia and Poreign.....	22
Erdenedalai.B Political development: theory and practice.....	36
Odmaa.D Current analysis on PS courses at universities and institutions.....	49
Bazarpurev.S, Baterdene.E Using linguistic methodology in political doctrines.....	55
<u>For political science theoretical issues</u>	
Batbold.Ts Max Weber explanation on bureaucracy.....	60
Lkham.I, Bold-Erdene.D What's a civil society?	75
Battseren.U Political image: theory, concepts.....	80
Oyunchimeg.D Some issues on political marketing.....	99
Sarangerel.L Theoretical issues of human right education in XXI st century.....	114
<u>Mongolian political thoughts and Contemporaneity (Modern time)</u>	
Ider.L “ ”	121
Bold-Erdene.D Check and balances of power in Mongolian state governance.....	126

Ulziisaikhan.Ch, Ulziijargal.Ts Political regime transition and Political elites in Mongolia.....	148
Ganbold.Ts, Batdelger.B Democracy strengthening and development tendency in Mongolia.....	158
Tsend-Ayush.G, Luvsanrenchin.O Democracy concepts and social state in contemporary Mongolia.....	165
Tuguldur.Ya Current analysis on political participation of Mongolian women.....	169
Odgerel.B Political participation of Mongolian MP women’s.....	181
Myagmarsuren.D Resources influence in politics	191
Tuyachimeg.T An analysis of Political party websites.....	201
<u>Comparative Politics</u>	
Batsaikhan.Z Hunnu and south, west neighborhood.....	210
Munkhzul.M National consciousness and national ideological crisis.....	217
Tsendjav.G Regards with contractual agreement of Tsarist Russian financial advisory officer.....	227
Dovchin.Yo USA Political System.....	232
Sarantsetseg.E Regime change and economic development in Korea.....	244
Turtogtokh.J The 19 th National Assembly Election and Post-Election Political Changes in Korea.....	252
Bazarpurev.S Political realism and minor “thoughts” of small countries in international relation.....	270
Publication standard and requirements.....	276

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Нийгмийн Шинжлэх Ухааны сургуулийн Улс төр судлалын тэнхмээс эрхлэн гаргадаг “Политологи” эрдэм шинжилгээний цуврал сэтгүүлийн ээлжит дугаар уншигчдын гар дээр очиж байна. Өмнө хэвлэгдэн гарсан цуврал сэтгүүлийн үргэлжлэл болон гарч буй энэ дугаар нь өмнөх сэтгүүлүүдийн ололт, туршлагад тулгуурласан болно.

Улс төрийн шинжлэх ухаан нь ХХ зуунд улс төрийн тухайлан судалдаг бие даасан салбар болж, нийгмийн шинжлэх ухаануудын төвлөрсөн илэрхийлэл болж гарч ирсэн билээ. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны онол-арга зүй, судалгааны арга хэрэгсэл улам нарийсан хөгжиж онолын болон эмпирик судалгаа, шинжилгээний мэдлэгүүд даяаршиж байна. Улс төрийн шинжлэх ухаан дэлхий дахинаа улам бүр эрчимтэй хөгжиж буйг Испанийн Мадрид хотноо 2012 оны 6 дугаар сард болсон Олон Улсын Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбооны XXII их хурал харуулав.

Монголд шинээр үүсэн бүрэлдэж буй улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үйлсэд энэ салбарын эрдэмтэд, судлаачид ихээхэн хүчин чармайлт гаргаж байдгийн тодорхой нэг илрэл нь энэхүү сэтгүүл юм.

Сэтгүүлийн эл дугаарт улс төрийн түүх, онол арга зүй, сургалт судалгааны орчин үеийн хөгжлийн хандлагын үүднээс өнөөгийн Монголын улс төрийн үйл явцын нэг чухал хэсэг болох улс төрийн институц, үзэл суртал, намуудын төлөвшил, хөгжлийн асуудлаар эрдэмтэд, судлаачдын бичсэн өгүүллүүдийг бие даасан сэдэв болгож оруулснаас гадна улс төрийн онол, философийн асуудлыг хөндсөн өгүүллүүдийг нийтэллээ. Мөн харьцуулсан улс төр булан нээж байна.

2012 он бол МУИС-ийн 70 жил, НШУС-ийн 65 жил, Улс төр судлалын тэнхмийн 45 жилийн ой давхцсан онцлог жил боллоо.

Манай сэтгүүл энэ дугаараас эхлэн олон улсын дугаартай болсон нь бас онцлох үйл явдлын нэг юм. Учир нь энэ бол монголын улс төрийн шинжлэх ухааны түүхэнд шинэ хуудас нээж, бидний сургалт, судалгааны ажлыг дэлхийд таниулах, олон орны улс төр судлаачтай хамтран ажиллах нөхцөл боломжийг цаашид өргөжүүлэн гүнзгийрүүлэх тодорхой алхам боллоо. Энэ нь сэтгүүлийн нийтлэлийн чанарт тавигдах шаардлагыг улам өндөржүүлж, бүтээлч санаачлагатай ажиллахыг биднээс шаардаж байна.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ
2013.05.29

МУИС-ийн 70 жил, НШУС-ийн 65 жил, Улс төр судлалын тэнхмийн 45 жилийн ойд зориулсан хурлын эмхэтгэл

ШУКО-ООС УЛС ТӨР СУДЛАЛ ХҮРТЭЛ

МУИС-ийн Нийгмийн ухааны факультетийн шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхмийн товч

Ц.Ганболд

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, профессор

Монгол улсын их сургуульд Эдийн засгийн дээд сургуулийг нэгтгэж, МУИС-ийн зохион байгууллатыг өргөтгөн өөрчилсний дагуу Марксизм-Ленинзмийн тэнхимээс Шинжлэх ухааны коммунизмын онолын тэнхим нь салж, 1967 оны 10-р сарын 1-нд бие даасан тэнхим болж ажилдаа оржээ. Тэнхмийн эрхлэгчээр их сургуульд 3 дахь жилдээ философи заасан багш Д.Содномгомбо болов. Их сургуульд ЗХУКН-ын түүх долоон жил, ШУКО гурван жил зааж байгаа Д.Гарамжав, Д.Лувсанцэрэн, ЗХУКН-ын түүх шинээр заах Ж.Гаваа нар багш болов. Бүх төгсөх курст Д.Содномгомбо, Д.Гарамжав, Д.Лувсанцэрэн нар ШУКО, I-р курст ЗХУКН-ын түүх Ж.Гаваа зааж эхэлсэн байна. Анхны лаборант Ж. Доржпагма байлаа. 1967-1968 оны хичээлийн жилийн II-р хагасаас нийгмийн ухааны нэгдсэн кабинет ажиллах болов. 1968-1969 оны хичээлийн жилд спортын мастер Г.Шоовдор ЗХУКН-ын түүхийн багш болж нэг жил болоод ХААДС-д багшаар шилжсэн юм.

1969-1970 оны хичээлийн жилд орон тооны багш Ж.Гаваа, Ж.Бямбадорж, Д.Гарамжав, Д.Лувсанцэрэн, цагийн багш 6 /Ж.Бадарч, Г.Бямбажав, Х.Гунгаадорж, Д.Дамдин, Ц.Цэрэн, Х.Бадарч/ ажиллав. 1969-1970 оны хичээлийн жилээс Тэнхмийн эрхлэгч Д.Содномгомбо философийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалсан нь тэнхмийн сургалт эрдэм шинжилгээний ажилд чухал алхам болов.

1970-1971 оны хичээлийн жилд Т.Хүрэлбаатар, З.Яргай нар хагас багшийн оногдолтой **нийгмийн тодорхой судалгааны лабораторийн** эрдэм шинжилгээний ажилтан болов. Ж.Гаваа 10 сарын хугацаагаар ЗХУ-д мэргэжил дээшлүүлэхэд суралцаж, багш Бямбадорж, Лувсанцэрэн нар деканы ажил хийв.

1971-1972 оны 2-р хагаст эрдэм шинжилгээний ажилтан хоёртой болов. /социологийн лабораторид С.Нарандулам, Н.Хавх/ 1972-1973 оны хичээлийн жилд **Социологийн лаборатори** бие дааж ШУКО-ийн тэнхимээс гарч тэнхмийн зохион байгуулалтанд өөрчлөлт гарав. 1973-1974 оны хичээлийн жилийн 1-р улиралд багш Ч.Ядамсүрэн МАХН-ын ТХ-нд ажиллах болов.

1974-1975 онд Ц.Цэрэн, Х.Ганбаатар нар ЗХУКН-ын түүх заах багш болов. 1975-1976 оны хичээлийн жилд Б.Догсом ЗХУКН-ын түүхийн багш болж Ж.Гаваа 1975 оны 2-р сарын 25-наас аспирантурт суралцахаар ЗХУ-д явлаа. Багш Хүрэлбаатар ШУКО заах болов. Багш Т.Хүрэлбаатар МГУ-д 10 сараар явж 1979 оны 2-р сарын 28 нд философийн ухааны дэд эрдэмтний зэргийг амжилттай хамгаалж ирэв. Мөн хичээлийн жилд С.Биндэрьяа /ЗХУКН-ын түүх/, Ш.Содном /ШУКО/ нар шинээр багш болов. 1976-1977 оны хичээлийн жилд эрдэм шинжилгээний ажилтан Д.Нарандулам тус тэнхимд аспирант боллоо.

1978-1979 оны хичээлийн жилд ЗХУ-д ШУКО-ын мэргэжлээр төгссөн Б.Энхмандах, Г.Цэнд-аюуш нар дагалдан багшаар ажиллав. Б.Энхмандах нь ЗХУ-ын Ленинградын их сургуулийг 1978 онд, Г.Цэнд-аюуш нь ЗХУ-ын Киевийн их сургуулийг 1978 онд тус тус төгссөн юм.

1971 оноос эхлэн хичээлийн явцад оюутны идэвх, бие даасан ажиллагааг сайжруулахын тулд хичээлийн гол сэдэв асуудал эх зохиолоор **контроль, коллоквиум** авч **аттестатчилал** явуулж эхэлсэн.

1978-1979 оны хичээлийн жилд тус тэнхмийн харьяанд сэтгүүлийн 1-р ангийг шинээр нээж 29 оюутантай хичээллэсэн учир энэ ангийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж хичээл сургалт хүмүүжлийн ажлыг зохион байгуулж явуулав. Багш С.Биндэръяа уг ангийг дааж ажиллав. 1979 оноос эхлэн философийн 3-р ангид **олон улсын ажилчны хөдөлгөөний түүх** шинээр орох болсон учир тэнхмийн мэргэжилтэн А.А.Резник орлоо.

1968-69 оноос Х.Ганбаатар, С.Биндэръяа нар анги дааж тэнхмийн бүх багш нар суртал нэвтрүүлэгч боллоо. Залуу багш Б.Энхмандах **“залуу лекторын”** дугуйлан удирдан ажиллаа.

1973 оноос тус тэнхмийн лаборториос эрхлэн “оюутны эх оронч, интернационалч хүмүүжил ба “хөдөлмөрийн хүмүүжил” зэрэг чухал сэдвээр суурь судалгаа хийж /Нарандулам Хавх/ эхлэв. Ийнхүү **социологийн лабортори өргөжин бэхжсэн учир 1974 оны 4 сарын 4-нд ректорын 64 тоот тушаалаар лаборторын зохион байгуулалтыг өргөтгөн эрхлэгчээр нь Н.Хавхыг томилож ажиллуулав.**

1974 онд ШУКО-ын сурах бичгийг орчуулан нэмэлт баяжилт хийж сүүлийн үеийн материалын үндсэн дээр шинэчлэн боловсруулж 1975 онд хэвлүүлэв. Энэ бүхний үндсэн дээр ЗХУКН-ын түүх, ШУКО-ын хичээлээр БНМАУ-ын их дээд сургуулиудад мөрдөх программ, семнарын хичээлийн төлөвлөгөө сурах бичиг унших ном үндэсний хэл дээр бий болсон

1982 онд МУИС-иас Политехникийн дээд сургууль салан тусгаарлагдахад нийгмийн ухааны багш нар хэрэгтэй болсон тул манай тэнхмийн багш Д.Гарамжав, Б.Догсом, Ц.Цэрэн, С.Биндэръяа, Д.Нарандулам, Г.Цэнд-Аюуш нар тус сургуульд шилжин ажилласан юм.

1982 онд Москвагийн улсын их сургууль төгссөн С.Базарпүрэв манай тэнхимд багшаар ирлээ. 1984 онд Ч.Өлзийсайхан МУИС-ийн философийн ангийг ШУКО-оор мэрэгшин төгсөж тэнхимдээ багшаар үлдсэн. 1984-1989 он хүртэл ажиллаж байгаад гэр бүлийн хамт гадаадад ажиллаж, амьдрахаар яваад 1997 онд буцаж тэнхимдээ ирсэн.

1987 онд Ш.Содном ЗХУ-ын Киевийн их сургуульд, С.Базарпүрэв Москвагийн их сургуульд тус тус аспирантурт суралцахаар явж Ш.Содном 1990 онд “Хөдөлмөрт хандах социалист харилцааны төлөвшилтийн диалектик” сэдвээр, С.Базарпүрэв 1990 онд “Оюутан залуусын нийгмийн идэвхтэй байр суурийг төлөвшүүлэх асуудал” сэдвээр докторын /Ph.D/ зэрэг хамгаалсан шижгэнэсэн эрдэмтэд тэнхимдээ ирж багшилсан юм. Улмаар 1985-1990 оны 5 дугаар сар хүртэл НУФ-ийн декан байсан Я.Долгоржав багш өөр ажилд томилогдсон тул доктор Ш.Содном 1990 оны 6 сарын 1-нээс 2009 он хүртэл НУФ, НШУС-ийн декан, захирлаар ажиллаж байсан.

1988 онд Ховд дахь Багшийн Дээд Сургуулийн нийгмийн ухааны тэнхмийн эрхлэгч Ц.Ганболд манай тэнхимд аспирантаар ирж, эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар нь доктор К.Зардыхан /тухайн үед Засгийн газрын орлогч дарга байсан/ ажиллаж байв. Ц.Ганболд 1988-1990 онд үндэсний асуудлаар засгийн газрын комисст орж, Хөвсгөл аймаг /Дархадын хотгор/, Архангай, Өвөрхангай аймаг /Орхоны хөндий/, Ховд, Увс, Баян-Өлгий, Дорнод, Сүхбаатар /Дарьганга/, Хэнтий аймагт эрдэм шинжилгээний томилолтоор ажиллаж, БНМАУ-ын Засгийн газарт зөвлөмж бичиж, үүнийхээ хажуугаар тэнхмийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд оролцож, диссертацийн ажлын

явцаа тэнхмийн хурал болон эрдэм шинжилгээний бага хурлуудад тайлагнаж байв.

1990-1991 онд манай тэнхмийн аспирант Ц.Ганболд тухайн үеийн Улсын бага хурлын орлогч дарга, Үндсэн хууль боловсруулах комиссын орлогч дарга доктор К.Зардыханы удирдлагаар Монгол улсын Үндсэн хууль боловсруулах ажилд оролцож “Монгол Улсын Их Цааз” (Үндсэн хууль) төсөл 1, “Монгол Улсын Их Цааз” төсөл хоёр баримт бичгүүд дээр ажиллаж байлаа. Ц.Ганболд 1991 онд “Ардын уламжлал ба эх оронч ухамсар” сэдвээр /Ph.D/ докторын зэрэг хамгаалж тэнхимдээ багшаар үлдсэн.

С.Зориг манай танхимд 1986 онд багшаар ирээд ШУКО-ын хичээл зааж байлаа. 1980-аад оны сүүл үеэр цаг үеийн байдал их хурдан өөрчлөгдөж, социалист орнуудад нийгэм, улс төр, эдийн засгийн өөрчлөн байгуулалтын уур амьсгал бий болсон үе байлаа. Их дээд сургуулийн багш нар, эрдэмтэд, судлаачдын лекц, эрдэм шинжилгээний илтгэл, өгүүллүүдэд шүүмжлэлт сэтгэлгээ, шинэчлэл, өөрчлөлтийн үзэл санаа ил тод ажиглагдах болсон юм. Энэ үед С.Зориг МУИС-ийн аспирантурт суралцаж “БНМАУ-ын улс төрийн системийг боловсронгуй болгох нь” сэдвээр судалгааны ажил хийж, эрдэм шинжилгээний ажлын удирдагчаар нь манай тэнхмийн эрхлэгч профессор Д.Содномгомбо ажиллаж байсан.

С.Зориг дээр хүмүүс маш их ирж уулздаг боллоо. Анхандаа Зориг тэнхмээс гарч уулздаг байсан бол яваандаа тэгэх ч боломжгүй болж ажлынхаа өрөөнд уулздаг, ярилцдаг, ер нь л ил тод боллоо. Гадаад дотоодын сэрвалжлагч нар ирж ярилцлага авч, бичлэг хийж их л хөл хөдөлгөөнтэй болов. Ингээд манай тэнхим МоАХ-ны анхны “төв штаб” болж билээ.

Дэлхийн улс төрийн томоохон хувьсгалууд ихэнхдээ тухайн улсынхаа том университет дээр төвлөрч багш оюутан залуучууд дээр түшиглэсэн байдаг тэр л зүй тогтол энд харагдаж байна. МоАХ, ШДХ, СДХ бүгд л МУИС, ТИС, ХУИС, УБДС ХоБДС дээр үүрээ засч, МУИС, түүний дотор манай тэнхим тухайн үеийн нийгмийн үүргээ зохих ёсоор гүйцэтгэжээ. Университет өөрөө их консерватив байдаг мөртлөө нийгмийн хувьсгалын үед гол төв нь байж, асаж дүрэлзэвч хувьсгалын дараа их далай мэт намуун тайван үлддэг билээ.

Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны анхны тэнхмийн үүсэл, хөгжил

Монгол дахь улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийн тухай яриа мэдээж хэрэг нэлээд эртнээс яригдах ёстой. Наад зах нь монголд төр улс үүссэн тэр цагаас бусад улс оронд улс төрийн шинжлэх ухаан үүсч хөгжсөн ерөнхий хандлага үе шаттай ойролцоо утгаар авч үзэж болох талтай. Тухайлбал, тэнгэрээс ивээлт төрийн тухай сургаал, шашин домгийн шинжтэй номлол монголын улс төрийн сэтгэлгээний түүхэнд тов тодорхой ул мөрөө үлдээсэн байдаг. Энэ мэт сургаал номлол, судалгаа шинжилгээ, сургууль дэг монголын төрт ёсны түүхийн турш өөрийн өвөрмөц өв уламжлалаа үлдээсэн байгаа¹. Бид энд 1990 оноос хойш монголд улс төрийн шинжлэх ухаан хэрхэн

¹ “Тайзун хааны 5-р оны харагчин могой жил анх дөрвөн багш томилж монголын хөвгүүд дүү нарт хятадын бичиг үсэг сурахыг тушаасан бөгөөд урьдын Яньжин хотын күнзийн сүмийг улсын сургууль болгов” хэмээх буй. Сургууль байгуулагдсан он цагийн хувьд “Юаньши”-д бичсэнээр бол 1234 он болно. “Хөх морин жилийн (1234 он) хоёр сарын 24-нд зарлиг гарч Лю овогт мөн бас Лю овогт дөрвөн хүнийг багшаар, эдгээрээс

хөгжиж ирсэн, түүнийг их дээд сургуулиудад хэрхэн зааж байгаа талаар товч өгүүлэх болно. Тухайн улс оронд Улс төрийн шинжлэх ухаан хэрхэн хөгжиж байгааг улс төр судлаачид янз бүрийн аспектаар авч үзсэн байх юм. Жишээлбэл, ОХУ дахь орчин үеийн УТШУ-ы хөгжлийн тухай тэдний өөрсдийнх нь нэр хүнд бүхий судлаачид ярихдаа ОХУ-ын үндэсний эрдэмтэд олон улсын УТШУ-ы дэлхийн конгресст оролцсон 1955 оноос Оросын улс төрийн ШУ-ы хөгжлийн шинэ үе-орчин үе эхэлсэн гэж үзсэн байна. Энэ тухай Полис сэтгүүлийн 2006 оны № 1-ээс үзэж болно. Украин, Армен, Белорусс зэрэг пост коммунист орнуудад орчин үеийн УТШУ-ы хөгжлийн тухай ярихдаа эрх зүйн орчин, институцийн хөгжил, боловсон хүчний шинэчлэл, агуулгын өөрчлөлт, гадаад харилцааны хөгжил, судалгаа шинжилгээний ажлын цар хүрээ гэх мэт чиглэлүүдээр авч үзсэн байх юм. Азийн орнуудад өөрийнхөө орон дахь УТШУ-ы хөгжлийн тухай өгүүлэхдээ улс улсдаа өөр өөр аспектаар авч үзсэн байх юм.

Тухайлбал: Political science in Asia №1, 2005 он сэтгүүлд:

- Японд түлхүүр асуудлууд, тэргүүлэх судлаачдыг танилцуулах байдлаар
- Өмнөд Солонгост судлаачдын тодорхойлолт, судалгааны арга, сэдэв
- Филиппинд УТШУ-ы түүх, нийгэмлэг, улс төр судлаачид
- Тайландад түүхчилж үзэхийн зэрэгцээ УТШУ-ы нийгэмлэгийн хөгжил
- Хятадад хэрэгжүүлж байгаа төслүүдээр

гадна орчуулагч хэлмэрч хоёрыг томилжээ. Бүгдийг захиран сургагч түшмэлээр гурван хүнийг томилжээ”.

Сургалтын хөтөлбөрийн агуулгыг дээрх баримтуудад тулгуурлан нягтлаваас: Хэл бичиг, монгол ба хятад хэл бичиг, Гүн ухаан ба түүх соёл, улс төр, Цэргийн хэргийн мэдлэг, нум сумаар харвах, Орон судлал, газар орны тухай мэдлэг, Бодис судлал, Гоо зүй, урлаг соёлын тухай мэдлэг зэрэг хичээлүүдээс бүрджээ.

1924 оны 4 сарын 5-нд Халхын 4 аймаг, шавиас зарлан дуудаж ирүүлсэн 18-30 насны 60 залуучуудаас бүрэлдсэн “Нам, улсын Түр сургууль”-ийг үүсгэн байгуулжээ.

1925 оны 1 сарын 10-ны өдөр НТХ-ны Тэргүүлэгчдийн II хурлын тогтоолын 3 дугаар зүйлд “Намын сургуулийг тусгайлан байгуулж Богд хааны Хайстай ордон буюу одоогийн Удирдлагын Академи байрлаж буй газарт Намын Төв Сургууль нээлтээ хийж, төв сургуульд Дэлгэр их Уулын аймаг, Хан Хэнтий, Цэцэрлэг Мандал, Богд хан, Хантайшир уулын аймаг, Нийслэл хот, Ховдын хязгаар, Хөвсгөл, Дарьганга, Тагна Урианхай, Баргаас ирсэн 121 эрэгтэй, 28 эмэгтэй суралцагч байв. Эдгээрээс намын гишүүн 45 хүн, эвлэлийн гишүүн 85 хүн, гишүүн бус 19 хүн байв.¹

1934 оны Намын ба улсын төв сургуулийн хичээлийн программ, төлөвлөгөөнүүдэд тусгаснаар Монгол бичиг, Дэлхийн байдал, Химийн ухаан, Цэргийн боловсрол, Тоо бодлогын ухаан, Байгалийн шинжлэл зэрэг 20 хичээл орж байсны дотор “Улс төр” гэдэг нэршлээр хичээл орж байжээ. Энэ хөтөлбөрт тусгаснаар Монголын түүх, МАХН-ын түүх, Улсын байгуулалт, Намын зохион байгуулалт, Марксизм-Ленинизмын үндэс, Дэлхий дахины түүх зэрэг нэлээд олон хичээлийг “Улс төр” гэдэг нэрийн дор багтааж нэг хичээл болгон зааж байсан байна. Харин 1938 оны үеэс “Улс төр” хичээлийн агуулгад багтаж байсан дээрх хичээлүүдийг бие даасан хичээл болгон зааж эхэлжээ. Тухайлбал, Улсын байгуулалтын тухай хичээлийг 100 цаг, Намын зохион байгуулалтын хичээлийг 70 цаг, МАХН-ын түүх хичээлийг 130 цагаар тус тус зааж байв.

- Малайзад Улс төрийн судалгаа ба угсаатан судлалын асуудлаар
 - Гонконг УТШУ-ы үүсэл, одоогийн байдал, судалгааны Ази дахь хандлага гэсэн чиглэлүүдээр авч үзжээ. Миний хувьд ОХУ болон бусад посткоммунист орнуудад хэрэглэсэн арга зүйг үндэс болголоо. Монгол дахь орчин үеийн УТШУ-ы хөгжлийн тухай ярихын тулд юуны өмнө улс төр эрх зүйн орчны тухай товч дурьдах хэрэгтэй. 1980-аад оны сүүл үеэс монголд өөрчлөлт шинэчлэлийн уур амьсгал бий болж улс төр эрх зүйн шинэ орчин бүрэлдэж эхэлсэн. Үүний нэг илрэл нь их дээд сургуулийн зарим багш нар МАХН-ын түүхээр улсын шалгалт авдгийг болиулж, түүний оронд философи, ШУКО, БНМАУ-ын түүхийн хичээлээр улсын шалгалт авдаг болох тухай санал дэвшүүлж, зарим сургуулийн оюутнууд МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх зэрэг хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөнөөс хасах тухай санал гаргаж байсан байна. Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэж, 1990-1991 оны хичээлийн жилээс МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх, Улс төрийн эдийн засгийн ухаан, ШУКО зэрэг хичээлийг их дээд сургуулийн хөтөлбөрөөс хасаж эхэлжээ. Ингээд 1990-1991 оны хичээлийн жилд зарим их дээд сургуулиудад дээрх хичээлүүдийг орохыг зогсоож, шинэ хичээлүүд орох бэлтгэл ажлууд хийгджээ. Ингээд их дээд сургуулийн зарим багш нарыг Польш, ЗХУ-д явуулж мэргэжил дээшлүүлж, МУИС-ийн ШУКО-ын тэнхмийн суурин дээр Улс төр судлалын тэнхмийг байгуулах бэлтгэл ажил 1990 онд хийгдэж, тус тэнхмийн багш нар бусад их дээд сургуулийн ШУКО, ЗХУКН-ын түүхийн багш нар бүтэн нэг хичээлийн жил Улс төр судлалын хичээлийн төлөвлөгөө, лекцийг боловсруулж, сургалт семинар хэлэлцүүлэг зохион байгуулжээ. 1992 онд одоогийн Удирдлагын Академийн төрийн удирдлагын тэнхимд богино хугацааны курс зохион байгуулагдаж, түүнд их дээд сургуульд Улс төр судлал заах багш нар хамрагджээ. 1991-1992 оны хичээлийн жилд ШУКО-ын оронд Улс төр судлал, УТЭЗУ-ы оронд эдийн засгийн онол, марксист-ленинист философийн оронд гүн ухаан, МАХН-ын түүхийн оронд монголын түүх зэрэг хичээлүүдийг заах нь зүйтэй гэж тухайн үеийн БШУЯ-ны сайдын шийдвэр гарсан байна.

1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар хуучин ШУКО-ын тэнхмийн суурин дээр Улс төр судлалын тэнхим байгуулагдаж, тэнхмийн эрхлэгчээр НУФ-ын декан, дэд доктор Ш.Содном хавсран ажиллахаар томилогджээ. Улс төр судлалын тэнхимд 7 багш ажиллаж байсан ба тухайн үед Политехникийн дээд сургууль, УБДС, АУДС, ЦДС, ХААДС зэрэг төрийн өмчийн томоохон их дээд сургууль зарим техникумын Улс төр судлалын багш нар МУИС-ийн Улс төр судлалын тэнхимд төвлөрч мэргэжлийн сургалт эрдэм шинжилгээний болон заах аргын семинарууд явуулж тус тэнхим улсын хэмжээний сургалт эрдэм шинжилгээний гол төв болж байсан.

1991 оны 12 дугаар сараас Ц.Ганболд тэнхмийн орлогч эрхлэгчээр томилогдож, МУИС-ийн захирлын 1992 оны 05 сарын 06-ны өдрийн 279 дугаар тушаалаар Ш.Содном НУФ-ийн эрдмийн зөвлөлийн дарга, Ц.Ганболд эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогджээ.

МУИС-д Улс төр судлалын салбарыг үүсгэн байгуулахад анхны сургалтын төлөвлөгөө, анхны лекц, анхны семинар, анхны судалгаа хийхэд Ш.Содном, Ц.Ганболд, Д.Содномгомбо, Х.Ганбаатар, С.Базарпүрэв, кабинетийн эрхлэгч Д.Оюунчимэг, лаборант Ж.Доржпагма нар гар нийлж, санаа бодлоо нэгтгэж, хамтран зүтгэж байсныг онцолж тэмдэглэх нь зүйтэй.

1992 онд Улс төр судлал, социологи, угсаатан судлалын чиглэлээр судалгаа шинжилгээ хийх зорилгоор нийгмийн судалгааны төвийг байгуулж, төвийн эрхлэгчээр дэд доктор Л.Бат-Очирыг томилж, дараа нь дэд доктор

Х.Нямбуу төвийн эрхлэгчээр ажиллаж байгаад хожим угсаатны зүйн тэнхим болон өөрчлөгджээ. 2003 онд МУИС-ийн НШУС-ийн сургуулийн дэргэд нийгмийн судалгааны хүрээлэн, 2004 онд монголын улс судлаачдын холбоо, 2005 онд монголын улс төрийн шинжлэх ухааны холбоо, 2006 онд МУИС-д орчин үеийн улс төрийн судалгааны төв байгуулагдлаа.

Улс төрийн шинжлэх ухааныг их дээд сургуулиудад заах эрдэм шинжилгээний ажил эрхлэхээс гадна ШУА-ийн ФСЭХ, УБАкадеми, Төрийн Удирдлагын Академи, УИХ-ын дэргэдэх судалгааны төв, Улс төрийн намуудын дэргэдэх судалгааны байгууллагууд, МЗХ-ны дэргэдэх Полис төв, Зориг сан, Альтернатив төв, Сант Марал сан, Зотол, Социологийн Академи, Сонгогчдын боловсрол төв, Сивикус, Солбицол төв, Зөгий, Жинлүүр, Монголын Лектор төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагууд улс төрийн ШУ-ны тодорхой чиглэлүүдээр судалгаа шинжилгээний ажлууд хийж ирсэн нь энэ салбарын институционал бүтцийн нэг бүрдэл хэсэг болон төлөвшиж байна. Энэхүү бүтцийн хөгжилд Соросын сан, АНУ-ын БНОУХ, Азийн сан, Конрод-Адэнаурын сан зэрэг гадаад орнуудын болон ОУ-ын байгууллагуудын дэмжлэг, туслалцаа хамтын ажиллагаа чухал нөлөө үзүүлснийг онцлон тэмдэглэж байна.

1993 онд МУИС-д Улс төр судлалын салбар байгуулагдсан нь улс төрийн шинжлэх ухааны мэргэжлийн боловсон хүчнийг эх орондоо бэлтгэх анхны том алхам болсон юм. Өөрийн тэнхмийн харъяа оюутангүй, нарийн мэргэжлийн хичээл заадаггүй тэнхим нэг л хагас дутуу юм шиг санагдаад болохгүй байлаа. Ингээд улс төр судлаач гэдэг мэргэжил байдаг эсэх талаар сонирхож судлаад үзсэн чинь ардчилал хөгжсөн орнуудад байдаг бололтой. Таньдаг найз нөхөддөө хэлж захиж байгаад БНСУ, Герман, Польшийн сургуулиудын хагас дутуу сургалтын төлөвлөгөө олж аваад /тэр үед интернэт гэж байдаггүй байлаа. /орчуулуулж дундаас нь нэг сургалтын төлөвлөгөөний төсөл боловсруулаад мэргэжил нэгт нөхөддөө танилцуулж санал бодлоо солилцож байхад зарим нь зөв санал байна гэж дэмжиж, зарим нь ийм мэргэжилтэнг их сургуульд бэлтгэдэггүй юм, эвлэл, нам улсын ажил хийж байсан туршлагатай хүмүүсийг дахин бэлтгэх замаар улс төрийн боловсрол олгодог. 10-р анги төгссөн хүүхдүүд бол балчирдана. Манайд болон бусад орнуудад тийм мэргэжилтнийг намын дээд сургуулиар бэлтгэдэг.

МУИС-д ийм анги нээлээ гэхэд хүн ирэхгүй гэж байж билээ. Тэр үед Декан Ш.Содном за ямарч байсан чиг сургалтын төлөвлөгөөгөө сайн боловсруул, хэн хэн ямар хичээлийг орж болохоор байна хуваарь хий, хоёулаа хөөцөлдөөд үзье гэж билээ. Ингэж анхны сургалтын төлөвлөгөөг 1992 онд хийж, анги нээх зөвшөөрөл авч, 1993 оны намраас анхны элсэлт авсан чинь 18-хан хүүхэд элссэн билээ. УБ хотоос Ч.Батбямба, Д.Бадамдаш, Б.Баттулга, Ж.Төртогтох, П.Батцэцэг, Бадамсүрэн, Батчимэг, Оюунсайхан, Б.Сувд-Эрдэнэ, Ц.Мөнхцэцэг, Сэлэнгээс Д.Сундуйжав, Дэлгэрмаа, Говь-Алтайгаас Я.Гансүх, Төв аймгаас Э.Алтанбагана, Ховдоос Я.Төгөлдөр, Хөвсгөлөөс С.Баярмаа, Дарханаас Мөнхцоож, Завханаас Л.Баярмагнай элсэн орж билээ. Эд нараас зарим нь гадаад дотоодын сургуулиудад шилжиж бүр ч цөөрлөө. Би ч зарим нөхдөөсөө үг сонсож байсан санагдана. Гэтэл цэргийн ерөнхий сургуульд /БХИС/ улс төрийн ажилтан гэдэг анги нээгээд тэр нь болохгүй болоод манайд БХИС-аас Өлзийбат, Н.Чулуундаваа, Ш.Батсүх, Нямбилэг нар шилжин ирж төгсөхдөө 13-уулаа төгссөн. Гэхдээ 2,3,4 дэх элсэлтүүд нэмэгдсээр манай мэргэжлийг ч хүмүүс ойлгодог болж, яваандаа НУФ дотроо хамгийн том салбар болсон.

Улс төр судлалын тэнхим салбарын хөгжилтэй салшгүй холбоотой нэг алхам бол 1994 онд боловсорлын яаман дээр МУИС-ийн математик, Улс төр судлал, социологийн тэнхимийн эрхлэгчдийг дуудсан. Тэр үед Б.Отгоннасан багш ажил гараад очиж чадаагүй, Тогмид багш бид очсон. Бусад их дээд сургуулиас янз бүрийн мэргэжлийн тэнхимийн эрхлэгчид ирсэн байсан. Учир нь их дээд сургуулиудын сургалтын төлөвлөгөөнд заавал судлах хичээлүүдийг дур дураараа оруулсан байна. Үүнийг цэгцлэх ёстой гэж биднийг дууджээ. Тэнхимийн эрхлэгч болгон л өөр өөрсдийн хичээлийг заавал үзэх хичээлд оруулах сонирхолтой байсан. Харин бүх их дээд сургуульд бүх мэргэжлийн ангид заавал үзэх цөөн хэдэн хичээлийн дотор Тогмид багш бид хоёр математик, Улс төр судлал хоёроо оруулж их л баярлаж байсан даа. Тэнхимдээ ирээд багш нартаа “Та нарын идэх хоолыг олж ирлээ” гэж “сайрхаж” байсан. Багш нарын хоол цайндаа гол нь биш Монголын залуу үеийг шинэ улс төрийн соёлоор хүмүүжүүлэх, нийгэмшүүлэхэд орчин үеийн Улс төр судлалын мэдлэг маш их хэрэгтэй байгаа юм.

1997 онд улс төрийн шинжлэх ухааны бакалаврын дипломтой анхны 13 оюутан төгссөн

1996 онд анхны магистр Ж.Мэндээ, Дашдондогийн Оюунчимэг, 1997 онд Хишигсүрэнгийн Ганбаатар, Галсанпилжээгийн Цэнд-Аюуш, 1999 онд Жанарын Төртогтох, Дашдаваагийн Бадамдаш, Доржжүгдэрийн Мөнх-Очир, Даваадоржийн Ундрах, Адъяагийн Нямдолжин, Цэрэнжамцын Мөнхцэцэг магистрын зэрэг хамгаалсан. Д.Бадамдаш, Д.Мөнх-Очир нар 2003 онд О.Машбат 2007 онд АНУ-д дахин мастерын зэрэг хамгаалсан.

Улс төр судлалаас Д.Бадамдаш, Ж.Төртогтох, түүхээс Д.Мөнх-Очир, хуулиас О.Машбат зэрэг залуучуудыг тэнхимдээ татаж “аргамжих” гэж их л ажил болж байв. Тэд их сургуульдаа элэгтэй байсан. Гэхдээ тэднийг гадаад, дотоодын өндөр цалинтай ажилд санал болгох тохиолдол их байлаа. Нөгөө талаар залуу хүмүүс амьдралаа төвхнүүлэхэд тэдгээр санал болгосон ажлууд хэрэгтэй байгааг ойлгож та нар минь тэр ажлаа хийхийн зэрэгцээ их сургууль, тэнхимдээ бас давхар ажиллахыг хичээ гэж 100 хувь, 50 хувиар багшлуулж, зарим үед тэдний ажил төрөлд нь хичээлийн хуваариа зохицуулж байв. Д.Бадамдаш өглөө 08:00-оос, О.Машбат үдээс хойш буюу ажил тарсны дараа, Д.Мөнх-Очир хагас сайнд хичээлээ ордог байлаа. Нэгэн удаа би тэднийг “**Хар үүрээр гүйдэлтэй Дашка, харуй бүрийгээр гүйдэлтэй Машка, хагас, бүтэн сайнд гүйдэлтэй Очироо**” гэж хошигнож байсан. Бүр болохгүй үед АЛЬТАРНАТИВ төвдөө /бид хамтарч байгуулсан/ цуглуулж эрчтэй, хүчтэй, нээлттэй, чөлөөтэй ажиллаж байсан. Тэдний дунд улс төр судлаач, түүхч, хуульч, социологич, эдийн засагч, сэтгэл судлаач, математикч, олон улсын харилцааны мэргэжилтнүүд байлаа. Тэдгээрээс Ж.Төртогтох, С.Мөнхбат, Ц.Мөнхцэцэг, Д.Ундрах нарын зэрэг их сургууль, эрдэм номын ажилдаа тасралтгүй, тууштай ажиллаж байгаа докторууд олон бий. Одоо тэд бүгдээрээ Монгол улсын томоохон их дээд сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал, тэнхимийн эрхлэгчид болжээ.

1997 онд Улс төр судлалын оройн анги нээгдэж, 1999 онд анхны докторын шатны сургалт эхэлж, мөн 1999 онд УБИС дээр философи-Улс төр судлалын анги, 2000 онд Шинжээч-21 дээд сургуульд социологич-улс төр судлаачийн анги, 2003 онд Ховд их сургуульд улс төр судлаачийн анги нээгджээ. Мөн Соёмбо, Чингис хаан, Их засаг зэрэг сургуулиудад ижил төрлийн мэргэжилтэн бэлтгэж байна.

1994 онд МГУ-д А.Юндэндорж УТШУ-ы докторын зэрэг хамгаалж /гадаадад/, 1998 онд УБИС-ийн тэнхмийн эрхлэгч Л.Пүрэвдорж улс төрийн шинжлэх ухааны анхны докторын /Ph.D/ зэрэг /дотоодод/ хамгаалжээ. Гэхдээ тэр үед хэдийгээр Улс төр судлалын сэдвээр хамгаалсан ч философийн ухааны докторын зэрэг өгдөг байсан.

1997-1998 оны хичээлийн жилээс **улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийг** ШУА-ийн ФСЭХ-д түшиглүүлэн философи, социологи, Улс төр судлалаар докторын зэрэг хамгаалуулах зөвлөл байгуулагдсан. Энэ зөвлөл дээр Л.Пүрэвдорж, Ю.Атар, Х.Цолмон, Т.Гантулга нар хамгаалсан.

1999 онд МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш Ё.Довчин Санкт-Петербургийн их сургуульд докторын зэрэг хамгаалсан.

2002 онд БСШУЯ-ны сайдын 2002 оны 32-р тушаалаар улс төрийн шинжлэх ухаанаар докторын зэрэг хамгаалуулах улсын хэмжээний нэгдсэн зөвлөл байгуулагджээ. Энэ зөвлөл философи, Улс төр судлалын чиглэлээр докторын зэрэг хамгаалуулдаг нэгдсэн зөвлөл байсан юм. Энэ нь бидний хувьд докторын зэргийн сургалт явуулах, улмаар хамгаалуулах эрхээ баталгаажуулахад нэг том алхам болсон юм.

2003 онд УТШУ-аар доктор хамгаалуулах дагнасан зөвлөл байгуулагдсан ба зөвлөлийн зарим гишүүд өөр ажилд томилогдож нилээд өөрчлөлт гарсан учир дахин шинэчилсэн. Цаашдаа ч байн байн шинэчлэгддэг боллоо.Сүүлийн үед БСШУЯ-наас хамгаалуулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилохдоо улс төржих хандлага ажиглагдаж байгааг яасан ч зөвтгөж болохгүй.

Энэ зөвлөлд Д.Содномгомбо, Ш.Содном Ц.Ганболд С.Базарпүрэв А.Юндэндорж, нар орж Ц.Ганболд докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж байлаа. Энэ зөвлөл дээр Д.Ганбат, Д.Загджав, Ж.Төртогтох нар хамгаалсан. Ийнхүү монгол улсад Улс төр судлалын чиглэлээр **бакалавр, магистр, докторын** шаталсан сургалт төлөвшиж иржээ.

Монгол дахь УТШУ-ы хөгжилд боловсон хүчний нөөцийг бэхжүүлэх, давтан бэлтгэх, гадаад дотоодод мэргэжлийг нь дээшлүүлэх, шинэ үеийн боловсон хүчинг бэлтгэх асуудал чухал байр суурь эзэлж ирлээ. Үүнд: Юуны өмнө МУИС-ийн Улс төр судлалын салбар, бусад их дээд сургуулиудад үндэсний мэргэжилтэнг бэлтгэж байсны зэрэгцээ Шинжээч-21, Соёмбо, Чингис хаан дээд сургууль, Удирдлагын Академи, Отгонтэнгэр, Орхон, Их засаг, Шихихутаг, Ховд их сургууль зэрэг төрийн болон төрийн бус их дээд сургуулиудад философич-улс төр судлаач, социологич-улс төр судлаач, түүхч-улс төр судлаач, нийгэм судлаач-улс төр судлаач зэрэг хос мэргэжлээр нэгжээд мэргэжилтэн бэлтгэж иржээ.

Соросын сан, СЕР, ТЕИС, Конрэд-Адэнаурын сан, Ханс зайдалын сан, Эйбертын сан, Азийн сан зэрэг гадаад орнуудын болон ОУ-ын байгууллагууд, ихээхэн туслалцаа үзүүлж байсан нь гадаад дотоодын ижил төрлийн мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоох хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, үндэсний боловсон хүчний мэргэжлийг дээшлүүлэхэд онцгой ач холбогдолтой байлаа. Үүний зэрэгцээ энэ салбарын профессор багш нар, эрдэмтэн судлаачид АНУ, Канад, Герман, Англи, Унгар, Польш, Литва, Казахстан, Киргизстан, Узбекистан, Япон, Солонгос, Хятад, Сингапур зэрэг Ази Европ, Америкийн олон оронд суралцаж, мэргэжил дээшлүүлж, зэрэг цол хамгаалж, 2005 онд МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч доктор, профессор Ц.Ганболд ОУ-ын УТШУ-ы холбоонд гишүүнээр элсэж, 2006 онд

Японы Фукуока хотод болсон ОУ-ын улс төрийн шинжлэх ухааны холбооны дэлхийн XX-р конгресст урилгаар оролцсон.

Д.Бадамдаш Америкийн УТШУ-ы холбоонд гишүүнээр элсэж, Ж.Төртогтох Азийн улс төрийн судалгааны консерциумтай хамтран ажиллаж, эдгээр олон улсын байгууллагуудын мэргэжлийн сэтгүүлүүд /эх хувиараа шинэ дугаарууд, онлайнар бүх дугаарууд/ ирж байна. Зөвхөн МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн багш нар л гэхэд давхардсан тоогоор 60 гаруй удаа 20 гаруй оронд урт богино хугацаагаар гадаад томилолтоор ажилласан байна. Монгол улсын БИС-ийн багш нар Канадын Британы Колумбын Их сургуулийн Улс төр судлалын тэнхимд, Германы Билефельдийн Их сургуулийн Улс төр судлалын тэнхимд, мөн Бельгийн Аньверпенин Их сургуулийн Улс төр судлалын тэнхимд суралцаж мэргэжил дээшлүүлсний сацуу тус тэнхмүүдээс багш нар уригдан сургалт явуулж ирсэн.

Улс төрийн ШУ-ы сургалт, судалгааны ажлын хөгжилд гадаад дотоодын санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслүүд чухал ач холбогдолтой байсан. Үүнд:

Соросын сангийн шугамаар хэрэгжүүлсэн төслүүд онцгой байр суурьтай. Тухайлбал: МУИС-ийн Улс төр судлалын тэнхим магистрын сургалтын төлөвлөгөөгөөг Соросын сангийн дэмжлэгтэйгээр Вильнюст болсон 12 орны мэргэжил нэгт нөхдүүдийн оролцоотойгоор **“Монмастер”** хөтөлбөрийг хэлэлцүүлж батлуулсан. МУИС-ийн Улс төр судлалын тэнхимд 2001-2005 оны хооронд гадаадын 30 орчим мэргэжилтэн урт богино хугацаагаар ирж ажилласны дотор 13 зочин профессор жилээс доошгүй хугацаагаар ажиллажээ. Мөн энэ хугацаанд **СЕР, AFP, ARC, IRI, CIVICUS, HESP**-ийн төслүүд амжилттай хэрэгжсний зэрэгцээ монголд суугаа гадаад орнуудын элчин сайдын яамдууд тодорхой дэмжлэг үзүүлж байсныг тэмдэглэх хэрэгтэй.

Одоо МУБИС дээр Билефельдийн Их сургуультай хамтарсан Улс төр судлалын магистрын сургалтыг сайжруулах төслийг хэрэгжүүлж эхлээд байна. Тус төслийн хүрээнд Улс төр судлалын магистрантуудын сургалтын агуулга, арга зүйг шинэчлэх үе шаттай ажлууд хийгдэх бөгөөд жил бүр Германы профессорууд уригдан ирж сургалт явуулах ба мөн тус сургуулийн багш нар очиж мэргэжил дээшлүүлэх юм. Мөн Унгар дахь Нээлттэй нийгэм Хүрээлэнтэй нягт хамтран ажиллаж ирсэн бөгөөд 2001 оноос хойш Улс төр судлалын чиглэлд 2 бие даасан судалгааны төсөл, мөн 3 шинэ хичээлийн төслийг хэрэгжүүлсэн.

Монгол дахь УТШУ-ы институционал бүтцэд МУИС болон бусад их дээд сургуулиудад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын харилцааны болон дипломат албаны чиглэлийн тэнхим салбар, төвүүд /Стратеги судлалын хүрээлэн г.м/ мөн хуулийн сургуулиуд дахь төрийн онолын тэнхим төрийн удирдлагын чиглэлийн тэнхим, салбар хүрээлэн төвүүд чухал байр суурьтай.

Ерөнхий Улс төр судлалын сургалтын агуулгын тухайд бид одоогоор дөрвөн загварыг үндсэнд нь баримталж байна. Үүнд:

1. ОХУ болон посткоммунист орнуудын шинэчилсэн загвар
2. Сөүл-Токиогийн их сургуулийн Азийн загвар
3. Охфордын буюу Европын загвар
4. Америкийн загвар

Мэргэжлийн ангид үздэг үндсэн хичээлүүдээр анхны сурах бичгүүд гарч байна. Үүнд: Ё.Довчингийн “Харьцуулсан улс төр”, А.Жамбалын “Улс төрийн сэтгэлгээний түүх”, Х.Ганбаатарын “Дундад зууны үеийн улс төрийн сэтгэлгээний түүх”, Ч.Өлзийсайханы “Элит судлал”, Ц.Ганболдын “Улс төрийн сэтгэл судлал”, А.Юндэндорж, Ю.Атар нарын “Өрнө дорнын сэтгэгчдийн улс

төрийн сургаал номлол“ г.м. Үүний зэрэгцээ МУИС-ийн “Политологи” сэтгүүл, УТБА-ийн “Шинэ толь” сэтгүүл, Удирдлагын Академийн “Төрийн захиргаа” сэтгүүл, “ALTERNATIVE” сэтгүүл, ШУА-ийн ФСЭХ-ийн эрдэм шинжилгээний бичиг зэрэг мэргэжлийн сэтгүүлүүд сургалтанд хэрэглэгдэж байна.

УТШУ-ы сургалт-эрдэм шинжилгээний ажлын хүрээнд оюутны курсын ажил, дипломын ажил, магистр докторын ажил, багш судлаачдын эрдэм шинжилгээний ажлын бичлэгийн 3 загварыг /стандартыг/ хэрэглэж байна. Үүнд:

1. МУИС-ийн эрдэм шинжилгээний бичгийн стандарт
2. Альтернатив стандарт /Европ-Америкийн загвар/
3. Харвардын систем

Бид 2006-2007 оны хичээлийн жилээс Харвардын системийг нэвтрүүлэхээр зөвлөмж боловсруулж байна. Үүний нэг давуу тал нь Интернэтээс ашигласан материалд ишлэл зүүлт хийхэд илүү тохиромжтой гэж үзэж байгаа юм.

УТШУ-ы институциональ бүтцийн хувьд манай оронд зарим нэг буруу хандлага ажиглагдаж байгааг хэлэхгүй өнгөрч болохгүй байна. Тухайлбал, дэлхийн ихэнхи университетүүдэд олон улсын харилцааны салбар нь нийгмийн шинжлэх ухааны бүтэц дотроо багтаж байдаг. Гэтэл МУИС-д олон улсын харилцааны салбар нь биеэ даасан сургууль байснаа одоо гадаад хэл соёлын сургууль, олон улсын харилцааны сургууль болон 2 хуваагдсан байдалтай байна. Мөн НШУС дотор нийгмийн шинжлэх ухаан, хүмүүнлэгийн шинжлэх ухааны салбарууд холилдсон байдалтай оршиж байна. Бүтцийн ийм байдал нь боловсон хүчний болон үүргийн /функц/ буруу тогтолцоо бий болоход хүргэж байгаа юм.

1990-ээд оны эхээр Ф.М.Бурлацкий, Ё.Вятр, А.Боднар, Т.Санистебян нарын номыг уншиж, Оросын эрдэмтдийн орчуулгын бүтээлийг ашиглаж, Улс төр судлалын анхны лекцүүдийг уншиж байсан үеэ бодоход өнөөдөр монгол дахь улс төрийн шинжлэх ухаан боловсон хүчний хувьд дахин бэлтгэгдэж, шинэчлэгдэж, шинэ үе гарч ирж, улс төрийн шинжлэх ухааны институциональ бүтцүүд бий болж /тэнхим, салбар, хүрээлэн/, үндэсний холбоо нийгэмлэгүүд, төрийн бус байгууллагууд байгуулагдаж, үндэсний сурах бичиг, гарын авлага, мэргэжлийн сэтгүүлүүд бий болж одоо орчин үеийн олон улсын жишиг хандлагатай хөл нийлүүлэн алхахын дайтай болж төлөвшиж байна.

1997 он их онцлог жил байв. 1997 онд УЛС ТӨР СУДЛАЛ-ын тэнхим нь өдрийн 4 ангитай бүтэн орон тооны 6 багштай, 100 орчим оюутантай байсан. 1997 онд Улс төр судлалын чиглэлээр анх удаа улс төрийн ШУ-ы бүрэн курсыг үзэж мэдсэн **улс төр судлаач-нийгэм судлалын багш** дипломтой анхны мэргэжилтнийг төгсгөн гаргасан. Энэ үед **Улс төр судлалын шинэ салбарыг үндсэн бүрдлийн хувьд бий болгох зорилтын эхний шат хэрэгжсэн үе** байв. Тэнхимийн үүсэл хөгжлийн хувьд 30 жилийн түүхтэй ч улс төр судлалын тэнхим болоод 10 жил ч болоогүй залуу тэнхим байсан юм. Иймд манай тэнхим НУФ-ын бусад 40, 50 жилийн түүхтэй тэнхимтэй харьцуулахад үүсгэн бий болгох замыг тавих талдаа илүү анхаарах шаардлагатай он жилүүд байлаа.

1997-1998 оны хичээлийн жилд **улс төр судлаач-нийгэм судлалын багш мэргэжлээр оройн анги** нээсэн. Оройн анги нээх болсон гол үндэслэл нь нэгдүгээрт манай мэргэжлээр элсэгчдийн эрэлт эрс өссөн, хоёрдугаарт тэнхимийн багш нарынхаа орлогын түвшинг нэмэгдүүлэх, гадагшаа хол ойр явж хувийн сургуулиудад хичээл зааж цөөн хэдэн төгрөгний төлөө ихээхэн цаг алддагыг аль болох багасгаж үндсэн ажилдаа цаг хүчээ зориулах боломжийг

нэмэгдүүлэх, гуравдугаарт шинээр үүсч төлөвшиж байгаа Улс төр судлалын салбараа багшлах боловсон хүчин, оюутан суралцагч, санхүү, материалаг баазын хувьд бүх талаар өргөтгөн бэхжүүлэх явдал байлаа.

1997-1998 оны хичээлийн жилд МУИС-ийн санхүү эдийн засаг эрхэлсэн дэд захирал, доктор Д.Бямбаатай учирлан ярилцаж, мэргэжлийн оройн ангид хичээл заасан багшийн цагийн хөлсийг хичээлийн жилд заах үндсэн болон илүү цагт оруулахгүйгээр тусд нь тооцож олгох, үнэлгээний хувьд МУИС-ийн багшийн илүү цагийн үнэлгээнээс дээгүүр байлгах, хувийн их дээд сургуулиудад хичээл заасан цагийн үнэлгээнээс мэдэгдэхүйц өндөр байх зарчмыг баримталж дүрэм журам боловсруулах тухай тохиролцож билээ. Удалгүй тэрхүү журам ч батлагдсан юм. Үүнээс хойш манай салбарын оройн ангид тухайн үеийн зарим декан, сургалтын албаны дарга, тэнхмийн эрхлэгчид захиалга өгч мэргэжлийнхээ хичээлийг заадаг болсон нь манай оройн ангийн сургалт эрдэм шинжилгээний ажлын чанарт эергээр нөлөөлсөн гэж үздэг. Харин энэ ангидаа тэнхмийн эрхлэгч миний бие ганц цагийн хичээл заадаггүй байж билээ. Тухайн үед боловсролын яамнаас орой, эчнээ анги нээх зөвшөөрөл авна гэдэг нь бараг хувийн сургууль байгуулахын дайтай төвөг бэрхшээлтэй ажил байсан юм. Сайд дарга нар, томоохон бизнесменүүдийн хувьд өөр байсан байж магадгүй.

1998-1999 оны хичээлийн жилд Улс төр судлалын салбарт эчнээ анги нээлээ. Тухайн үед орой, эчнээ ангийн оюутнууд сургалтын төлбөрөө өөрсдөө хариуцах ёстой, гэрээтэй. Төрийн албан хаагчийн хүүхдийн болон төрийн сангийн хөнгөлөлт, зээлд хамаарагддаггүй заавал өөрөө төлдөг байсан нь суралцагчийг хариуцлагжуулахад эерэг нөлөөтэй, шударга тогтолцоо боловч нөгөө талаас ар гэрт нь болон өөрт нь эдийн засгийн хувьд дарамттай, бас шударга биш талтай. Гэхдээ тухайн сургууль, факультетийн сан хөмрөгт нэмэртэй л байсан байх.

Улс төр судлалын салбарыг цаашид хөгжүүлэхийн тулд тухайн үедээ дараах бодлогын шинжтэй зорилтыг дэвшүүлэн тавиад хэрэгжүүлж байлаа.

1. Зохистой бүтцийг бий болгох замаар улс төр судлалын салбарыг УТШУ-ы сургалт-эрдэм шинжилгээний Улсын хэмжээний гол төв болгох зорилт байлаа. Ингэхийн тулд юуны өмнө багшлах боловсон хүчний хуучин бүтцээ хадгалахаас гадна шинэ хүчээр сэлбэх
2. Өндөр мэргэжлийн эрдэмтэн багш судлаачидтай болох, орон тоогоо нэмэгдүүлэх
3. Өдөр, орой, эчнээ сургалттай 200-аас доошгүй бакалаврын түвшний оюутантай тул тэдний сурлага, хүмүүжил, эрдэм судлалын ажлын чанарт онцгой анхаарал тавих
4. Магистрантур, докторантурын шаталсан сургалтанд олон улсын жишиг стандартыг нэвтрүүлэх цаашид мэргэжил дээшлүүлэх курс системийг бий болгох
5. Улс төрийн шинжлэх ухаанаар эрдмийн зэрэг хамгаалуулах индекстэй, бие даасан зөвлөлтэй болох
4. Дотоодын мэргэжлийн болон бусад байгууллагуудтай нягт хамтран ажиллаж тэдгээрийн дотор тодорхой байр суурь эзлэх
5. Гадаад харилцаагаа хөгжүүлж нэн тэргүүнд Монголд байгаа гадаадын холбогдох байгууллагуудтай байнгын харилцаатай болох
6. Матерриаллаг баазыг бэхжүүлэх

Эдгээрийн үр дүнд Улс төр судлалын тэнхим нь /1999-2000/ бүтэн орон тооны 10 гаруй багш, 50 хувийн болон байнга цагаар хичээл заадаг багш нартайгаа 16 багштай. Бүх багш нар магистраас дээш зэрэг цолтой, Профессор 1, ШУ-ны доктор 1, доктор (*Ph.D*) 5, докторант 4, горилогч 2-той. Энэ жил тэнхимийн туслах ажилтан шинээр авсан. /Ш.Жаргалсайхан ОХУ-д дээд боловсрол эзэмшсэн, орос, англи хэлтэй/ Манай тэнхим 200 гаруй оюутантай. Өдрийн 4, оройн 3, эчнээ 1, нийт 8 ангитай. Сургалт эрдэм шинжилгээний "АЛЬТЕРНАТИВ" төв байгуулагдаад үйл ажиллагаагаа явуулж байгаа. НУФ-тад багшийн тоогоороо ч оюутны тоогоороо ч ер нь их том бүрэлдэхүүнтэй хамт олны тоонд орох тэнхим болжээ. **Тус тэнхим нь салбарын ангид аа мэргэжлийн хичээлүүд орж, НУФ-ын ангиудад улс төр судлал ордог төдийгүй МУИС-ийн харъяа бүх салбар сургууль факультетэд ерөнхий Улс төр судлалын үндэс хичээл заадаг. МУИС-ийн хэмжээнд үйлчилдэг төдийгүй УЛС ТӨР СУДЛАЛ-ын сургалт эрдэм шинжилгээний чиглэлээр бусад их дээд сургуульд үйлчилдэг. Энэ утгаараа улсын хэмжээнд үйлчилдэг тэнхим болоод байна.** Магистрын сургалтын төлөвлөгөөг мөн 2 удаа шинэчилсэн. Үүний зэрэгцээ магистрын сургалтын "**Монмастер**" хөтөлбөр боловсруулж Соросын сангийн шугамаар 10-аад орны ижил төстэй сургуулиудад хэлэлцүүлж 1998 онд Вильнюст сургалт хариуцсан дэд захирал С.Даваагийн хамтаар уг төлөвлөгөөг хэлэлцүүлж экспертиз хийлгэж үнэлэлт дүгнэлт гаргуулсан.

Докторантурын сургалт 1999 - 2000 оны хичээлийн жилээс шинэ дүрэм журмын дагуу шинэчлэгдэн хэрэгжиж эхлээд байна.

Мөн **оройн ангийн сургалтын агуулгад анхаарч 1998-1999 оны хичээлийн жилээс өдрийн ангийн төлөвлөгөөгөөр явах нь зүйтэй гэж үзэж нэгдсэн стандартад шилжсэнийг ач холбогдолтой болсон гэж үзэж байна. Үүний үр дүнд оройн ангид элсэгчдийн бүтцэд энэ хичээлийн жилээс өөрчлөлт орж 10-р анги төгсөгчдөөс шууд элсэгчид зонхилох болж өдрийн ангиас ялгагдахгүй болсон. Энэ нь үндсэндээ II ээлжийн анги болж сургалтын агуулга стандарт нь чанаржсан.**

Эчнээ сургалтын хувьд 1998-1999 оны хичээлийн жилээс анхны элсэлт авч гурван жилийн сургалтын төлөвлөгөөтэй хичээллэж эхэлсэн боловч өнгөрсөн онд Гэгээрлийн Яамнаас эчнээ сургалтын талаар шинэ журам гарч 10-р анги болон коллеж төгссөн элсэгч бакалаврын өдрийн сургалтын суралцах жилээс 1 жилээр илүү хугацаагаар суралцах болсон тул энэ жил элсэлтээ түр хойшлуулаад байна. **Азийн Сангаас улирал тутамд тодорхой хэмжээний ном авахаар гэрээ хийгээд** ажиллаж байна. Одоогоор бид 350 орчим ном англи хэл дээр аваад оюутны бие даах төвд тавиад байна.

1999-2000 оны хичээлийн жилд Улс төр судлалын 3-р курсын оюутнуудыг жил бүр хөдөө орон нутагт үйлдвэрллийн буюу улс төрийн ажлын дадлага хийлгэх тухай захиргааны зөвлөлд санал оруулж ихээхэн эсэргүйцэлтэй тулгарч байлаа.

Ялангуяа археологи, угсаатан судлалын тэнхимийн эрхлэгч нар ширүүн эсэргүйцэв. Тэртээ тэргүй хээрийн дадлагын төсөв нь хүрдэггүй тэнхмүүд аргагүй л дээ. Декан маань ч төсөв хуваариладаг болохоор тийм ч дуртай биш байлаа. Гэтэл дээрхи тэнхимийн эрхлэгч нарын нэг нь "Төсөв хүрэхгүй байхад танай улс төрийнхэн хөдөө явж яадаг байна аа" гэхээр нь "Тэнд сонгогчид байдаг, сонгууль явагддаг, төрийн болон орон нутгийн засаг захиргаа иргэдийн эрх ашиг байдаг юм. Хатсан талхны булан, хайрсан гамбирны хэлтэрхий болгонд улс төр явж байдаг. Танай салбарын оюутнуудын сургалтын төлбөр

багш нарынхаа цалинг ч төлж чадахгүй байгаа шүү. Гэхдээ бид их сургуулийнхаа эрх ашгийг, шинжлэх ухааны эрх ашгийг бодоод зарим ийм салбарыг дэмжиж авч явж байх ёстой гэдгийг ойлгож байна.

Та нар манай оюутнуудын сургалтын төлбөрөөр цалинжиж, хээрийн дадлага чинь санхүүжиж байгаа. Тэрэндээ тулвал та нар оюутныхаа сургалтын төлбөрт хээрийн дадлагынхаа төсвийг нэмж тусгах хэрэгтэй. Иймд бид улс төрийн ажлын дадлагыг хөдөө, хотын аль алинд нь хийнэ” гэж нилээд үзэлцэж байж 2000 оны УИХ-ийн сонгуулийн өмнө Ц.Ганболд, С.Базарпүрэв нар улс төрийн ажлын дадлага удирдаж түүнээс хойш сургалтын төлөвлөгөөндөө тусгаж жил бүр гардаг болж билээ. **Тэнхмийн багш нартай хамтарч “Улс төрийн шинжлэх ухаан” (УБ 2001) их дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичиг бичиж, тэнхмийн эрхлэгч доктор, профессор Ц.Ганболд зохиогчдын хамтлагийн ахлагч, ерөнхий редактораар ажилласан.**

СЕР хөтөлбөртэй холбоо тогтоож хоёр зөвлөх багшийг урьж ажиллуулснаар гадаад хамтын ажиллагаанд томоохон алхам болсон.

2000 оны 04 сард “Монгол дахь нийгмийн шинжлэх ухааны сургалтын агуулгын шинэчлэлийн төлөвлөгөө” (Оюутан төвт шинэчлэлийн багц төслийг) өргөн барьж СЕР-д хандаж, улмаар МУИС, Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгээс дэмжлэг авч **2001** оны намраас туршилтын буюу бэлтгэл ажлын 2 жилийн төсөл хэрэгжүүлж **2003** оноос **“Монгол дахь нийгмийн шинжлэх ухааны сургалтын агуулгыг боловсронгуй болгох оюутан төвт шинэчлэлийн багц төсөл”** нэртэйгээр социологийн тэнхимтэй хамтарч хэрэгжүүллээ.

Манай багш нар мэргэжлийн холбоод, комисс, зөвлөлд томилолтын болоод сонгуульт албан тушаалаар тодорхой үүрэгт ажлуудын гүйцэтгэж ирлээ. **2000 оноос Альтернатив лекц зохион байгуулж, 2003 оны намраас Альтернатив судалгааны семинарыг тогтмол явуулж магистрант, докторантуудыг оролцуулж илтгэл хэлэлцүүлж байна. Мөн энэ оноос Улс төрийн шинжлэх ухааны Альтернатив сэтгүүлийг эрхлэн гаргаж эхэллээ. ШУКО-оос Улс төр судлал хүртэл бид багагүй түүхийг үлдээжээ. Бид магтаж ярих түүхтэй, маргаж хэлэлцэх бүтээлтэй хамт олон. Тийм ээ. Энэ хугацаанд Улс төр судлалаар Монгол улсын үндэсний стандартыг батлууллаа, “Улс төр судлал” мэргэжлээр бакалаврын зэрэг олгох сургалтын хөтөлбөр дээд боловсролын магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагыг хангаж баталгаажлаа.**

Бид бакалавр, магистр, докторын цэгцэрч тогтсон шаталсан сургалттай тэнхим, салбар боллоо. Бид эрдмийн цол зэрэгтэй, ажил амьдралын туршлагатай ахмад багш нартай, эрчтэй, боловсролтой, ирээдүйг бүтээх залуу үетэй,эвсэг найрсаг профессор багш нарын багтай боллоо.

Бид Монгол улсын нэр нүүрийг хаана ч аваад явах мэргэжлийн чадвартай үндэсний мэргэжилтэнтэй боллоо. Энэ бүхэн бол халуун дотно уур авьсгалтай хамт олны бүтээл, хамтарч, тусалж, дэмжиж ажилласан мэргэжил нэгт нөхдийн дэм тус. Энэ бүхэн МУИС-ийн нэр хүнд, байр суурь, үе үеийн сургууль, факультетын удирдлагуудын дэмжлэгийн үр дүн билээ. Тэдгээрийн дотор НУФ, НШУС-ийн декан, захирал асан Ш.Содномын “үлэмжхэн” хувь нэмэр, одоогийн НШУС-ийн захирал Г.Эрдэнэбаярын “эгэлгүй” их хүчин чармайлтыг тэмдэглэх хэрэгтэй.

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААН: ОЛОН УЛС БА МОНГОЛ**Ё.Довчин***МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч, профессор*

Өдгөө улс төрийн мэдлэг боловсрол, соёл нь зэрэг зиндаа, эрхэлдэг ажил, нас хүйс, үндэс угсаанаас үл хамааран хэн бүхэнд хэрэгтэй болжээ. Учир нь аж төрж буй нийгэмдээ бусадтай харьцахгүй, төртэй амьдрал ахуй нь холбогдохгүй хүн гэж үгүй. Улс төрийн зохих мэдлэггүйгээр хүн улс төрийн зүсэн бүрийн ов мэх, төөрөгдүүлэлтийн өгөөш болохдоо хялбар. Иймд иргэдэд улс төрийн тухай шинжлэх ухааны мэдлэгийн үндсийг таниулах, цаашлаад улс төрийн шинжлэх ухааныг судлах, сургах шаардлага өнөө үед онцгой ач холбогдолтой тухайд нурших хэрэггүй биз. Учир иймээс миний бие энэхүү өгүүлэлдээ улс төрийн шинжлэх ухааны үүсэл төлөвшил, цаашдын чиг хандлагын талаар олон улсын болон өөрийн орны өнцгөөс зарим асуудлыг хөндөхийг хичээсэн болно.

Хэрэв улс төрийн шинжлэх ухааныг бүхэлд нь улс төрийн сэтгэлгээ, сургаалийн хөгжлийн үр дүн байсан хэмээвээс түүний үзэл санааны өв зуун зуунаар тооцогдох бөлгөө. Нөгөө талаас “хүн - улс төрийн амьтан” учраас энэхүү шинжлэх ухаан нь хүмүүний улс төрийн амьдрал зогсолтгүй өрнөсөөр ирсний гэрч мөн. Улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжил, хувьсал өөрчлөлт эдүгээ ч маргаан мэтгэлцээний сэдэв болсоор иржээ. Түүний судлах зүйл, судалгааны агуулга, цар хүрээ, олон тооны дэд салбаруудын харилцан шүтэлцээ, тэдгээрийн ангилал, улс төрийн шинжлэх ухааны нэгдсэн нэг тогтолцоонд тэдгээрийг нэгтгэх шалгууруудын тухай төдийгүй улс төрийн шинжлэх ухаан, улс төр судлал гэх мэт түүний нэршлийн талаар ч санал зөрөлдөөнтэй байдаг. Жишээ нь, өнөөдөр судлаачид улс төр хэмээх ойлголтыг гол төлөв гурван хүрээнд авч үзэж байна.

1) улс төр бол чиг бодлого бөгөөд түүний үндсэн дээр аливаа зорилтуудыг томьёолох, хэрэгжүүлэх арга хэмжээ авч, шийдвэр гарч байдаг. Жишээ нь, олон улсын бодлого, худалдааны бодлого г.м.;

2) улс төрийг хувь хүмүүс, улс төрийн хүчнүүд засгийн эрхэнд гарахын төлөө тэмцэлдэж байдаг тодорхой хүрээ гэж ойлгодог;

3) улс төрийг илүү өргөн утгаар тухайлбал, нийгэмд хүмүүсийг удирдах урлаг хэмээн үздэг. Гэхдээ улс төрийн тухай шинжлэх ухааны судлагдхууныг хэт явцууруулахаас эхлээд түүнийг хамрах асуудлын хүрээг зах хязгааргүй тэлэх гэсэн олон янзын үзэл бодол байгааг үгүйсгэх аргагүй. Энэ бүхэн уул шинжлэх ухаан харьцангуй шинэ, улс төрийн мэдлэг өсч хуримтлагдах, бүтэцжих үйл явц эрчимтэй үргэлжилсээр байгаагийн илрэл гэж болох юм.

Хүн төрөлхтний улс төрийн сэтгэлгээ зөвхөн өрнөдөөр хязгаарлагдахгүй нь мэдээж. Гэхдээ хамгийн ул суурьтай судлагдсан, улс төрийн үзэгдлүүдийг шинжлэх ухааны үүднээс судлах үйл явц чухамхүү эндээс эх авсан гэсэн утгаар өрнөдийн улс төрийн сэтгэлгээ, улс төрийн судалгааны уламжлалыг тулгын чулуу болгон авч үзэж байгаа билээ. Хэрэв өрнөдийн улс төрийн шинжлэх ухааны үүсэл хөгжлийг ерөнхийд нь зураглан харуулбал Грекийн улс төрийн сэтгэлгээнээс эх авч Ромын эзэнт гүрний үед зарим ахицыг олж, гойд дэвшилд

хүрэлгүй дундад зууныг үдэж, Сэргэн мандал, Соён гэгээрлийн эринд бага атугай ч өөдөө өндийж, XIX зуунд мэдэгдэхүйц ололтууд гарч, улмаар XX зуунд баттай дэвжин хөгжиж улс төрийн шинжлэх ухаан мэдлэг ухааны бие даасан салбар болж мэргэжлийн жишигт хүрсэн гэдэгтэй судлаачид санал нийлдэг байна.

Сайн сайхан нийгэм, төгс төгөлдөр төрийг хэрхэн бий болгох вэ гэсэн эрин эринийг дамнасан мөнхийн гэмээр асуултын хариуг бурханы таалалтай, эсвэл санаанаас зохиосон загвартай холбон үзсэн нь бишгүй байдгийн зэрэгцээ басхүү хүмүүн төрөлхтний бодит амьдралаас ургуулан тайлбарлах гэсэн оролдлогууд ч байна. Платон, Аристотель нарын дэвшүүлсэн холимог засаглалын тухай суут үзэл санаа түүхийн нугачааг өртөөлөн дамжсаар дараа дараачийн сэтгэгчдийн тухайлбал, Макиавелли, Локк нарын логик рационал үзэл номлолд тусч, түүнийг Монтескье уламжлан авч засаглалыг хуваах онолоо боловсруулж, улмаар энэ нь Америкийн Үндсэн хуулийн эцгүүд дор улс төрийн практик амьдралд биеллээ олох болсон нь улс төрийн засаглал, түүнийг судлах шинэ эхлэлийг тавьсан гэж болно. Алексис де Токвиль улс төрийн харьцууллын арга зүйг чадмаг ашиглан Америкийн нийгэм-улс төрийн байгуулалд дүн шинжилгээ хийж тэнд Европтой харьцуулахад улс төрийн амьдрал дороос эхэлж, ард түмний өөрөө удирдах ёс америк ардчиллын ялгарах шинж болж байгааг нотлоод ардчиллын үндсэн шинж, зарчмуудыг тодорхойлсон бол Жон Стюарт Милл эрх чөлөө, төлөөллийн ардчиллын тухай өнөө ч үнэ цэнээ алдаагүй бүтээлүүдээ туурвисан нь улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн чухал урьдач нөхцөл болсон юм.

XX зуун гарч Макс Вебер нийгмийн өөрчлөлтийг нийгмийн социаль бүтэц, соёлын учир холбогдлоор судалж нийгмийн шинэчлэл, төрийн удирдлагын рациональ үндсийг онолын үүднээс тайлбарлаж улс төрийг хариуцлагын ёс зүйтэй холбон мэргэжил талаас үндэслэсэн нь улс төрийн социологид эргэлт болов. Моска, Парето нар улс төрийн элитийн нийгэмд эзлэх байр, гүйцэтгэх үүрэг, ээлжлэн солигдолтыг өөрсдийн элитийн онолоор тайлбарлаж, Михельс аливаа зохион байгуулалтаас үүдэн олигархийн төмөр хууль гарцаагүй үйлчилдэгийг баталсан бол Острогорский ардчилсан нийгэмд олон түмний намууд бюрократчлагдснаас олигархи зайлшгүй үүсч болох, үүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар нухацтай дүгнэлт хийсэн ажээ. Ийнхүү үе үеийн сэтгэгчдийн үзэл сургаал, онол номлол өнгөрсөн зууны улс төрийн шинжлэх ухааны оюун санааны үндэс суурийг бүрдүүлж өгчээ.

Хэдийгээр улс төрийн шинжлэх ухааны мэдлэг дээр дурдснаар зузаан өв уламжлал дээр суурилдаг ч улс төрийн шинжлэх ухаан онол, шинжилгээ судалгааны арга, арга зүй, зарчим, зохион байгуулалтын бүтэц бүхий академик хийгээд боловсролын бие даасан мэдлэг ухааны салбар болж бүрэлдэж гарч ирсэн үе нь чухамдаа XX зуунтай холбоотой юм. Иймээс XX зуунд улс төрийн шинжлэх ухаан зохион байгуулалт, арга зүй, онолын хувьд хэрхэн өсч бэхжсэн замыг товч атугай ч мөшгин харах хэрэгтэй болно.

XIX зууны сүүл, XX зууны эхээр нийгмийн шинжлэх ухаанууд шинжлэх ухааны орон зайд өөр өөрийн байр суурийг эзлэхийн төлөө нэг ёсны өрсөлдөөнд орсон тэр цаг үед улс төрийн шинжлэх ухаан философи, түүх, социологи, хууль зүй, эдийн засаг, сэтгэл судлал хийгээд бусад салбар ухаануудаас онол арга зүйгээрээ заагран тусгаарлаж, удаж төдөлгүй

шинжилгээ судалгааны бие даасан байдлаа бүрмөсөн “байлдан авч” чадсан байна.

Улс төрийн тухай шинжлэх ухаан шинэ тутам хөгжиж буй мэдлэг ухааны салбарын хувьд зохион байгуулалт талаас бэхжих үйл явц ХХ зууны эхнээс улам эрчимжсэн байна. Франц, Англи, Америкт улс төрөөр дагнан судалгаа хийдэг анхны байгууллагууд тухайлбал, их сургуулиудын улс төр судлалын салбарууд, түүнчлэн улс төрийн судалгаа шинжилгээний бие даасан төвүүд үүсч байгуулагдсаар байжээ. Дэлхийн нэгдүгээр дайн хүртэл улс төрийн онолын сэтгэлгээгээр америкийн эрдэмтэд европын их сургуулиудад суралцах, эсвэл мэргэжил дээшлүүлэхийг чухалчилдаг байсан зэргээс үзэхэд энэ салбарт Европ тэргүүлж байсан гэж болох ч улс төрийн шинжлэх ухааныг зохион байгуулалтын хувьд бэхжүүлэх санаачилга нэгэнт Америкийн талд шилжсэн байв. Үндэсний хэмжээний Улс төрийн шинжлэх ухааны холбоо 1903 онд энд анхлан байгуулагдаж, олон тооны мэргэжлийн сэтгүүлүүд тогтмол хэвлэгдэж эхлэсний дээр шинжлэх ухааны боловсон хүчнийг бэлтгэх тогтолцоо тэрлэсэн байна. Ийнхүү ХХ зууны эхнээс 60-аад оныг хүртэл улс төр судлал бие даасан мэдлэгийн салбарын зиндаанд хүрэх үйл явц үндсэндээ Америкт болжээ.

1920-1940 онуудад Европ тивд фашизм толгойгоо өндийлгөж улс төрийн судалгааг үзэл суртал, суртал нэвтрүүлгийн зорилгоор ашиглах, тэдгээрт захируулах болсноос хараат бус улс төрийн шинжилгээ судалгаа явуулах бололцоо хаагдсан байна. Тухайлбал, 1930-аад оны эхээр Германы дээд сургуулийн багш нарын тэн хагасаас илүү нь эх орноо орхин гарсан бол энэ орны болон Баруун Европын олон эрдэмтэд, тэдний дунд Т.Адорно, Э.Фромм, П.Лазарсфельд, К.Маркузе, К.Манхейм, Г.Моргентау, Л.Штраусс, З.Фрейд нар далайн чанад цагаачлахаас аргагүйд хүрчээ. Тэд Америкийн их сургуулиудад нийгмийн ухааны хичээл зааж, эрдэм судлалын ажил эрхлэх болсон нь нийгмийн шинжлэх ухаанууд, түүний дотор улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд шинэ түлхэц өгч жинтэй хувь нэмэр оруулсан ажээ. Дурдсан хугацаанд америкийн улс төр судлалын хөгжил бүс нутгуудыг манлайлж, улс төрийн шинжлэх ухааны нэр хүнд дээшилснийг үүнтэй холбон тайлбарлаж болох юм.

Улс төрийн шинжлэх ухаан АНУ-д эрчимтэй хөгжсний нэг хүчин зүйл нь улс төрийн судалгааны ажлыг улсаас, бас бизнесийн байгууллагууд бодитой дэмжиж санхүүжилтэд гар татахгүй байсанд оршино. Үүний үр дүнд улс төрийг дагнан судалдаг байгууллагуудын тоо огцом нэмэгдэж, дайны хоорондохь 20 жилд энэ чиглэлийн 30 орчим төв байгуулагджээ. Дэлхийн II дайны үеэр улс төрийн шинжилгээ судалгаа Европт үндсэндээ тасалдсан байсан бол АНУ-д харин ид цэцэглэн хөгжиж ихэвчлэн цэрэг-тагнуулын байгууллагуудын захиалгат судалгаанууд өргөн хүрээтэй хийгдэж, тэдгээрт өмнөө барьдаг судлаачдыг татан оролцуулах болжээ. Үүнээс уламжлан эрдэм шинжилгээ, сургалтын байгууллагуудын хэрэгцээ бий болж, дайны дараа АНУ-ын улс төрийн шинжлэх ухааны хөгжил их сургуулиад голлон төвлөрч, улс төрийн шинжлэх ухааны тэнхмийн тоо 1340 болж (К.Гаджиев.1998. с.36), улмаар улс төр судлаачдыг бэлтгэх олон улсын төв болж хөгжжээ. Ялангуяа Мичиганы их сургууль дайны дараахь жилүүдэд улс төрийн шинжлэх ухааныг Америкт төдийгүй гадаад орнуудад түгээн дэлгэрүүлэх үндсэн үүрэг гүйцэтгэсэн байна. Мөн энэ жилүүдэд америкийн улс төрийн шинжлэх ухааны зарчим, загваруудыг Европын хөрсөнд шилжүүлж “суулгах” ажил хийгдэж эхэлжээ. Ийнхүү нэгэн цагт

америкийн судлаачид Европт сурч байсан бол одоо европчууд Америкт очиж номын дуу сонсох болов.

Гэвч Европт 60-аад оноос хуучин их сургуулиуд бүрэн сэргэж, сургалт, судалгааны олон шинэ төвүүд байгуулагдаж, Европын улс төр судлагч эрдэмтдийн тоо улам бүр нэмэгдэн, тэд улс төрийн шинжлэх ухааны хөгжилд өөрсдийн хувь нэмрийг оруулж эхэлсэн байна.

Дэлхийн II дайны дараа АНУ-д Сонгуулийн судалгааны Америкийн үндэсний хороо (NES), Нийгмийн шинжлэх ухааны судалгааны зөвлөл (Social Science Research Council) зэрэг улс төрийн судалгааны хөтөлбөр, төслүүдийн санхүүжилт, зохион байгуулалтад дэмжлэг туслалцаа үзүүлдэг бие даасан байгууллагууд бий болсон нь улс төрийн шинжлэл судлалын ажил урагшлахад чухал ач холбогдолтой байв. 1961 онд хэд хэдэн их сургуулиуд хүчээ нэгтгэж Улс төр-нийгмийн судалгааны их сургуулиуд хоорондын Консорциум (Interuniversity Consortium for Political and Social Research) байгуулсан нь улс төрийн эрдэмтэн судлаачдын хийсэн судлал шинжилгээний ажлын үнэ цэнэтэй мэдээ баримтуудыг хуримтлуулсан баялаг архив үүсгэх бололцоо олгосон байна. Хэдэн жилийн дараа энэ загвараар Европын ийм Консорциум байгуулагдаж тус тивийн улс орнуудад улс төрийн шинжлэх ухааны сургалт, судалгааны төслүүдийг уялдуулан зохицуулж, санхүүжүүлж, түүнчлэн мэргэжлийн тогтмол хэвлэлтэй болсон байна.

Ийнхүү 70-90-ээд он гэхэд улс төрийн шинжлэх ухаан боловсрол, судалгаа шинжилгээний байгууллагуудын олон салбарласан тогтолцоо, ерөнхий зохицуулах төв – Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоо, хэдэн арваар тоологдох мэргэжлийн тогтмол хэвлэл бүхий зохион байгуулалтын бүтэцтэй, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн академик салбар ухаан болж хөгжиж чаджээ. Улс төр судлал бие даасан мэргэжлийн статусыг бүрэн олж, дэлхийн хэмжээнд байр сууриа бэхжүүлсэн байна. Улс төрийн шинжлэх ухааныг зохион байгуулалт талаас нь авч үзэхэд товчдоо ийм байна. Одоо улс төрийн шинжлэх ухааны онол арга зүйн хөгжлийн талаар зарим зүйлийг тодруулъя.

Улс төрийн шинжлэх ухаан мэдлэг ухааны бие даасан салбар болж үүсэхдээ нийгэм-хүмүүнлэгийн бусад салбар ухаануудаас судлагдхуун, агуулга талаас төдийгүй арга зүйн хувьд заагран тусгаарласан юм. Гэхдээ энд хоёр чиг хандлага байсан гэж үздэг. Эхний чиглэлийн арга зүйн онцлог нь улс төрийн судалгаа шинжилгээ тууштай шинжлэх ухаанч чанарыг шаардах ёстой гэдэгт оршиж байв. Шинжлэх ухаанч чанар гэдгийг позитивист утгаар буюу судалгаа шинжилгээ гагцхүү туршлагаар нотлогдсон баримтуудад тулгуурлаж энэ үндсэн дээр дүгнэлт логик дүрмийн дагуу хийгдэх ёстой гэж ойлгож болох юм. Улс төрийн үзэгдэлд ийм арга зүйгээр дүн шинжилгээ хийх нь субъектив үнэлгээнээс зайлсхийх бололцоог судлаачдад олгоно гэж тооцсон байна. Ялангуяа англо-саксоны орнуудад улс төрийн шинжлэх ухаан улам бүр позитивист чиглэлтэй болж, улс төрийн тухай шинжлэх ухааныг байгалийн шинжлэх ухаануудтай эн зэрэгцүүлэн үзэх хандлага ажиглагдах болжээ. Тэр үеийн улс төр судлал гол анхаарлаа парламент, гүйцэтгэх засаглал, төрийн захиргаа гэх мэт улс төрийн системийн формаль институцүүдэд хандуулж ирснийг улс төрийн үйл явцыг үнэн зөв ойлгоход хангалттай биш гээд харин улс төрийн үйл явцыг өөрийг нь, үнэт зүйлс, нийгмийн бүлэг давхаргын хүсэл

тэмүүлэл, улс төрийн үйл байдлыг судлах нь тулгамдсан асуудал болж байна гэж үзжээ.

Иймээс ХХ зууны 20-30-аад оны үед Г. Ласки, Г.Ласуэлл нарын барууны нэрт эрдэмтэд хүний улс төрийн үйл байдлын нийгэм-соёл, шашин, сэтгэл зүйн хүчин зүйлс, ухамсарлагдаагүй буюу далд ухамсрын сэдлүүдийг судлахын чухлыг сөхөж тавьсан байна. Энэ зорилгоор улс төрийн шинжлэл судлалд сэтгэл судлал, психоанализ хийгээд эмпирик социологийн аргуудыг зээлдэн хэрэглэх оролдлогууд хийгдсэн юм. Мөн энэ үед олон улс төр судлагчид судалгаандаа эдийн засгийн шинжлэх ухаан, түүх, антропологи, сэтгэл зүйн аргуудыг ашиглах шаардлагатайг ухамсарласан байна.

Дурдсан үед Америкт улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн Чикагогийн сургуулийнхан хэмээх нэрээр олны танил болсон эрдэмтэд, тухайлбал уг сургуулийг үүсгэн байгуулагч Чарльз Мерриам хууль эрх, түүхэн харьцууллын хуучин аргаас татгалзаж, харин үүний оронд гагцхүү баримтад тулгуурлах нь улс төрийн судалгааг объектив шинжлэх ухааны хөрсөнд буулгах болно гэж нотолж байв. Ийм парадигмын хүрээнд улс төрийн үйл явц улам бүр квантификацийн объект болж, улс төрийн судалгаанаас онол-философи, үнэлэмжийн үндэслэгээнүүд шахагдах болжээ.

Хэдийгээр тэр үед улс төр судлалд сциентист чиглэл ноёрхох болсон ч арга зүйн хоёрдахь хандлага огт унтарсан гэсэн хэрэг биш байв. Энэ нь тухайлбал, эх газрын Европт эмпирик ба онолын хэмжээсүүдийг хослуулах хандлага хөгжсөөр байсныг хэлж байна. АНУ-д ч гэсэн улс төрийн шинжлэх ухааныг тоо болгож хувиргахад хүргэж буй позитивизмыг шүүмжилж, энэ нь шинжлэх ухааны бүтээлч чанарыг хөгжүүлэхэд саад болж, улс төр судлаачдыг тодорхой практик зорилтуудыг шийдвэрлэхтэй холбоотой баримт сэлт цуглуулах төдий өрөөсгөл хандлага руу түлхэж байгааг цохон тэмдэглэж байв. Ялангуяа дайны дараахь Германы улс төрийн шинжлэх ухаан нэг талаас онол, философи, үнэлэмж, нөгөө талаас эмпирик баримт түшиглэсэн эхлэлүүдийг хослуулдаг уламжлалаа хадгалж хөгжснөөрөө онцлог байв.

Гэвч хэдийгээр бараг хагас зууны туршид улс төрийн мэдлэгийн зах хязгаар тийш шахагдаж байсан улс төрийн онол, улс төрийн философи 1970-аад он гэхэд өөрийн байр суурийг эзэлж, улс төрийг онолын үүднээс шүүн тунгааж, нэгтгэн дүгнэх бололцоо, түүний үнэ цэнийг улс төр судлагч эрдэмтэд санал нэгтэй хүлээн зөвшөөрсөн юм. Урьд өмнө норматив хэмээн улс төрийн судалгааны гадна үлдэж байсан асуудлуудыг Л.Штраусс, И.Берлин нар судлан боловсруулж, тэд улс төрийн сэтгэлгээг зөвхөн институци, хувь хүмүүс, бүлгүүдийн улс төрийн үйл байдлын эмпирик судалгаа болгон хувиргаж болохгүй, түүнд онол-философийн хэмжээс зайлшгүй байх учиртай гэж үзэж байлаа. Энэ нь улс төрийн үйл ажиллагааны мөн чанараас урган гардаг бөгөөд тэр нь ямагт нийгмийн сайн сайхныг баримжаалж байдгаас улс төрийн оролцогч заавал аливаа нэг үнэт зүйлсийг сонгох шаардлага тулгардаг ажээ. 1971 онд Жон Роулсын “Шударга ёсны онол” ном гарсан нь АНУ-д улс төрийн философийг сонирхох, либерал үнэт зүйлсийн уламжлалт номлолыг эргэж харахад хүргэж, улс төрийн онол, философийн хөгжилд шинэ зам нээсэн гэж үздэг. Роулс нийгэм дэх улс төрийн зөрчлүүдийг шийдвэрлэхийг шударга ёстой холбон авч үзсэн бөгөөд ардчилалд тулгуурлаж сайн зохион байгуулагдсан нийгмийн үндэс суурь болж чадах шударга ёсны ерөнхий зарчмуудыг

боловсруулахыг хичээсэн юм. Эдгээр зарчмуудын гол агуулга нь либерал нийгмийн хөгжлийн өнөөгийн шатанд хувь хүний эрх чөлөө ба материаллаг баялагийн шударга хуваарилалтыг хэрхэн хослуулах вэ гэдэгт хариулт өгсөнд оршино гэж хэлж болох юм (J.Rawls. 2005. pp.60-64, 302-303). Ийнхүү Роулс, бусад эрдэмтдийн дэвшүүлсэн үзэл санааны мөрөөр өргөн мэтгэлцээн өрнөснөөр улс төрийн танин мэдэхүйн онолын төвшин хийгээд эмпирик улс төрийн шинжлэх ухааны талаар эрдэмтдийн байр суурь аажмаар ойртож улс төрийн сэтгэлгээг бүхэлд нь дан эмпирик улс төрийн шинжлэх ухаанаар ойлгож болохгүй гэдэг зөвшилд хүрсэн юм. Гэхдээ АНУ-д болон эх газрын Европт хөгжиж ирсэн улс төрийн шинжлэх ухааны ялгаа, онцлогыг хүлээн зөвшөөрдөг бөгөөд тухайлбал, европын улс төрийн шинжлэх ухаан үзэл санаа, сургаалийн түүхээс эх авч төр эрх, төрийн институцүүдэд анхаарлаа төвлөрүүлсэн бол америкийн улс төрийн шинжлэх ухаан улс төрийн шинжлэх ухаан ба улс төрийн практикийн харилцан шүтэлцээг чухалчилж, түүний хөгжил ерөнхийдөө хавсарга эмпирик судалгааны чиглэлээр явсан нь илэрхий байна. Энэ бүхэн нь улс төрийн шинжлэх ухааны дурдсан арга зүйн хоёр хандлагыг тодорхойлж байгаа юм.

Дэлхийн II дайны дараа улс төрийн шинжлэх ухааны хөгжилд шинэ үе эхэлсэн нь тодорхой бөгөөд юуны өмнө улс төрийн шинжлэх ухааны цар хэмжээ байнга тэлж өргөжсөөр байв. Түүний судалгааны хүрээнд улс төрийн системүүд, улс төрийн үйл явц, улс төрийн намууд, сонирхлын бүлгүүд ба улс төрийн хөдөлгөөнүүд, улс төрийн үйл байдал ба улс төрийн соёл, олон нийтийн санаа бодол ба хэвлэл мэдээллийн хэрэгсэл, улс төрийн хошуучлал ба элит, корпоративизм ба неокорпоративизм, улс төрийн үзэл суртал ба улс төрийн философи, улс төрийн сургаалийн түүх гэх мэт олон шинэ асуудлууд түрж орж ирсэн байна. Үүний зэрэгцээ арга зүйн асуудалд ч анхаарал хандуулах болжээ. 1948 онд ЮНЕСКО-гийн ивээл дор зохион байгуулагдсан улс төрийн шинжлэх ухааны олон улсын бага хурлаас улс төрийн шинжлэх ухааны судлах асуудлыг 4 бүлэг болгон авч үзжээ. Үүнд: 1) улс төрийн онол (улс төрийн үзэл санааны түүхийг багтаасан); 2) улс төрийн институцүүд (төв орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагууд); 3) нам, бүлгүүд, олон нийтийн санаа бодол; 4) олон улсын харилцаа. Хожим 2, 3 нь “улс төрийн социологи” нэрийн дор нэгдсэн бол 2-ын зарим хэсэг “засаг захиргааны шинжлэх ухаан” болж “эрх тусгаарласан” байдаг. Харин эдүгээ 1996 онд хэвлэгдсэн хоёрдахь удаагийн “Улс төрийн шинжлэх ухааны лавлах”-д улс төрийн шинжлэх ухааны бүрдэл хэсгүүдийг улс төрийн институци; улс төрийн үйл байдал; харьцуулсан улс төр; олон улсын харилцаа; улс төрийн онол; Төрийн бодлого ба захиргаа; улс төрийн эдийн засаг; улс төрийн арга зүй гэж найман дэд салбарт хуваан үзсэн нь улс төрийн шинжлэх ухааны хөгжил, хувьслын үйл явцыг тусгасан хэрэг бизээ.

Дашрамд тэмдэглэхэд улс төр бол өөрийн огцом өөрчлөлтөөрөө ямагт гайхшруулж, эрдэмтэн мэргэд урьдчилж таамаглахын аргагүй үйл явдлуудыг байнга “бэлэглэж”, шинэ шинэ сорилтуудыг авчирч байдгаараа өвөрмөц онцлог үзэгдэл билээ. Учир иймд энэ жам ёсыг харгалзан Олон улсын Улс төрийн шинжлэх ухааны холбооноос эрхлэн 20 жил тутам гаргадаг “New Handbook of Political Science” ном буюу нэг ёсны орчин үеийн улс төр судлалын нэвтэрхий толь нь тухайн хорин жилийн улс төрийн үйл явц, үзэл онол, чиглэл хандлагуудыг нэгтгэн дүгнэсэн “улс төрийн шинжлэх ухааны үндсэн суурь хэсгүүдийн тухай, сүүлийн арван жилүүдэд эдгээр салбаруудад ажиллаж буй улс төр судлаачид, тэдний бүтээл туурвилуудын тухай мэдээллийн хамгийн

бүрэн эмхэтгэл” (Политическая наука: новые направления. 1999. с.10) болж байгаа билээ.

XX зууны хоёрдугаар хагасад Европын орнууд ч улс төрийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байсныг дурдах ёстой. Тухайлбал, Франц 1948 оны Парисын олон улсын бага хурлын дараа Үндэсний засаг захиргааны сургууль, Парисын их сургуулийн Улс төрийн судалгааны хүрээлэн, Улс төрийн шинжлэх ухааны үндэсний сан, Францын улс төрийн шинжлэх ухааны холбоо байгуулж, улс төрийн мэргэжлийн сэтгүүл гаргасны дээр 1956 оноос улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулдаг болжээ. Их Британи “Улс төрийн судалгаа”, “Британы улс төрийн шинжлэх ухааны сэтгүүл” зэрэг улс төр судлалын хэд хэдэн сэтгүүл гаргах болж, улс төр судлал, сургалтыг тус улсын 40 гаруй их сургуулиудад зохион байгуулдаг болжээ.

Гэсэн хэдий ч уул үйл хэргийг АНУ манлайлж байсныг нийгмийн шинжлэх ухаан, түүний дотор улс төрийн шинжлэх ухаанд гарсан бихевиораль хувьсгал гэрчилдэг. Чухамхүү америкийн эрдэмтэд системийн болон бүтэц-чиг үүргийн шинжилгээ, улс төрийн соёлын хандлага, харьцуулсан улс төр судлал, модернизацийн онолыг анхлан боловсруулсан билээ. Улс төрийн сэтгэл судлал, улс төрийн эдийн засаг гэсэн шинэ дэд салбарууд ч америкийн эрдэмтдийн нэртэй холбоотой билээ. Эдгээрийн дотроос онцолж тэмдэглэхэд тэр үед харьцуулсан улс төр судлал улс төрийн шинжлэх ухааны бүрэн бие даасан дэд салбар болж төлөвшсөн юм.

Өнгөрсөн зуун нийгэм-улс төрийн глобаль шинжтэй гүнзгий өөрчлөлтүүдүүдээрээ урьдахь зуунуудаас чанарын ялгаатай байв. Колонийн систем задарч шинэ залуу улсууд олон улсын тавцан дээр хэдэн арваараа гарч ирсэн хийгээд тэдгээр нийгмүүдийг хамарсан үйл явцыг модернизаци гэдэг ерөнхий нэр томъёо дээр нэгтгэн ойлгож, улмаар уг өөрчлөлт ардчиллах үйл явцын хүчирхэг давалгаагаар үргэлжилсэн юм. Улс төрийн амьдралд бүх нийтийн сонгуулийн эрх бодитой болж, улс төрд оролцогчдын цар хүрээ хэзээ ч байгаагүй хэмжээнд хүрч, улс төрийн намууд, сонирхлын бүлгүүдийн зохион байгуулалт, төлөвшил эрчимтэй явагдаж, бүх нийтийн боловсрол, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хөгжил улс төрд шууд, шууд бусаар хүчтэй нөлөөлөх болж, нэг үгээр улс төрийн транзитологийн онол практикийн эхлэлүүд тавигдсан гэж дүгнэж болох юм. Ийм өргөн далайцтай өөрчлөлтүүд мэдээж зохих үзэл баримтлал, арга зүй, аргыг шаардаж эхэлсэн нь тодорхой. Ийм нөхцөлд харьцуулсан улс төр судлалд эдгээр шинэ үзэгдлүүд, чиг хандлага, ололтыг нэгтгэх, улс төрийн шинжлэх ухааныг чанарын шинэ өндөрлөгт гаргах үүрэг оногджээ. Харьцуулсан судлаачид энэ салбарын онол арга зүй, арга техникийг боловсруулах талаар эрдэм судлалын томоохон амжилтад хүрч, улс төрийн шинжлэх ухааны үндсэн бүх асуудлуудаар харьцуулсан судалгаа хийгдэж байна гэж хэлж болно. Харьцуулсан улс төрийн хөгжлийн явцад судлаачид урьд өмнө байсан европ төвтэй харьцууллаас татгалзаж, өдгөө өрнөдийн бус улс төрийн системүүдийн талаар асар их мэдээ баримт хуримтлагдаж, газар газрын улс төр судлагч эрдэмтэд дэлхий дахины улс төрийн асуудлуудыг сонирхох нь нэмэгдэж, бусад ард түмнүүдийн улс төрийн институци, соёл, уламжлал, үнэт зүйлсэд анхаарлаа хандуулах болжээ.

Ийнхүү XX, XXI зууны зааг үеийн улс төрийн шинжлэх ухаан зохион байгуултын хувьд бэхжихийн хамт улс төрийн мэдлэг, онол арга зүйн арвин

баялаг сан хөмрөгтэй, хэдэн зуугаар тоологдох эрдэмтэн судлаачидтай, улам бүр олон улсчлагдаж, мэргэшлийн шинжийг олж буйгаараа онцлог байна. Эдүгээ улс төрийн шинжлэх ухааны өмнө хариулт хүлээсэн олон асуудал байгаагийн дотор Олон улсын улс төрийн шинжлэх ухааны сүүлчийн их хурал дээр Олон улсын Улс төрийн шинжлэх ухааны Холбооны ерөнхийлөгч профессор Л.Морлиногийн цохож хэлснээр ялангуяа ардчиллын чанарын асуудал “халуун” сэдэв болж байгаа нь тодорхой байна.

Судлаачдын нэрлэж заншснаар ардчиллын гуравдахь давалгаа хэмээх дэлхий дахиныг хамарсан үйл явц Монгол улсыг тойроогүй бөгөөд 1990 оноос манай оронд өрнөсөн ардчилсан шинэчлэл өөрчлөлттэй хамт улс төрийн шинжлэх ухаан орж ирсэн юм.

Дэглэм солигдож, монголын нийгэм улс төрийн сэтгэлгээний өмнөх парадигм үндсээрээ өөрчлөгдөх тэр мөчид хөрөнгөтний хэмээн нүд үзүүрлэгдэж байсан улс төрийн шинжлэх ухааныг бүрэн утгаар нь олон улсын жишгээр хөгжүүлэх бололцоо нээгдсэн. Урьдахь дэглэмд өрнөдийн нийгмийн тухай үзэл санааны чиглэл урсгалуудаас гагцхүү марксизмыг туйлшруулан үзэж, түүнийг нийгэм-эдийн засаг, улс төрийн бүхий л үзэгдлийг тайлбарлах онол арга зүйн үндэс, оюун санааны амьдралын цор ганц шалгуур болгосон байв. Ийнхүү баруунд нийгэм-хүмүүнлэгийн олон шинжлэх ухааны огтолцол дээр үүсч харьцангуй ахар богино хугацаанд бие даасан мэдлэг ухааны салбарын эн зэрэгт хүрсэн улс төрийн шинжлэх ухааныг хэрэг дээрээ марксист үзэл суртлаар орлуулж ирсэн байна. Үүний үр дагавар нь нийгмийн чөлөөт сэтгэлгээг боогдуулж, барууны улс төрийн шинжлэх ухааны эрчимтэй хөгжлөөс таслагдан хоцорч, улс төрийг үзэл сурталжсан өрөөсгөл ойлголтоор төсөөлж, улс төрийн судалгаа, сургалтыг албан ёсны бодлогод хатуу захируулах болсонд оршино. Үүнээс үзэхэд 90-ээд он хүртэл улс төр судлал манайд шинжлэх ухааны төгс утгаараа оршиж байсан гэж үзэх нь учир дутагдалтай билээ. Улс төрийн шинжлэх ухаан хориотой, хаалттай байхад юу ихэнхдээ нөлөөлөв гэвэл 1) нийгмийн сэтгэлгээ нэг үзэл суртлын стереотипд хүлэгдсэн; 2) тэр үеийн ЗХУ, социалист орнуудын нийгэм судлалын онол арга зүйг дагахаас аргагүй байсан; 3) социализмын нийгэм-эдийн засгийн ололтуудад олон түмэн “сэтгэл цадсан”; 4) эрх баригч элит өөрийн ноёрхлын легитимийг хадгалахын тулд улс төрийн шинжлэх ухаанаас цэрвэж болгоомжилсон зэргийг наад зах нь нэрлэж болох юм.

Гэхдээ үүгээр захиргаадалтын дэглэмийн үеийн нийгмийн шинжлэх ухааны ололтыг бүхэлд нь харлуулж үгүйсгэж болохгүй бөгөөд харин ч өмнөх үеийн бүтээсэн өв монголд улс төрийн шинжлэх ухааныг дэлхийн жишгээр үүсгэн хөгжүүлэх хөрс суурь суулгах ажлыг багагүй хөнгөвчилж өгсөн гэж хэлэх үндэстэй болов уу. Учир нь нэгд, тэр үеийн нийгмийн шинжлэх ухаануудын хүрээнд улс төр судлалын агуулгатай судалгаанууд хийгдэж олон ном бүтээлүүд туурвигдаж хэвлэгдсэн; хоёрт, хэдийгээр марксист онолоор авч үзэж байсан ч улс төрийн үндсэн институцүүд, улс төрийн шинжлэх ухааны гол гол ойлголт ухагдхуун, нэр томъёоны сантай олон нийтийг танилцуулсан; гуравт, нийгмийн шинжлэх ухаан зохион байгуулалт талаасаа зохих хэмжээгээр бэхжиж, салбарын мэргэжилтнүүд, судлаачидтай болсон; дөрөвт, социализмын үед бэлтгэгдсэн энэ чиглэлийн судлаач, эрдэмтэд шинэ нөхцөлд улс төрийн шинжлэх ухааныг эхлүүлэн хөгжүүлэхэд идэвхийлэн оролцож хувь нэмэр оруулсан байдаг.

1990 оны ардчилсан хувьсгал нийгмийн оюун санааг үзэл суртлын дарамт, онолын догматизмаас чөлөөлж, монголд улс төрийн тогтолцоо, дэглэм, үйл явцын төдийгүй улс төрийн сэтгэлгээний цоо шинэ үеийг нээсэн юм. Улс төрийн ардчилал, тухайлбал олон намын тогтолцоо, чөлөөт сонгууль, парламентат ёс, чөлөөт хэвлэл мэдээлэл, хүний эрх, эрх чөлөө түргэн хурдацтай хөгжсөн нь улс төрийн үзэгдэл, үйл явдлыг нийгмийн шинжлэх ухааны хуучин онол, парадигмаар тайлбарлах аргагүй болгосон юм. Үүний дээр социализмын практик гадаад, дотоодгүй нуран унаж, түүний онолыг дагаж баримтлах нь нэгэнт явцгүй болов.

Ийм нөхцөл байдалд улс төрийн шинжлэх ухааныг үүсгэж хөгжүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага тулгарсан байна. Нийгмийн сэтгэл зүй ч үүнийг шаардаж эхэлсэн нь тодорхой. Энэ дагуу марксист философи, социализмын онол нэг үгээр либералчлагдаж, нийгэм улс төрийн үзэгдлүүдийг шинэлэг үзэл онолоор тайлбарлах оролдлого гарч эхэлснийг тэр үеийн тогтмол хэвлэл, онолын гол сэтгүүлүүдийн нийтлэл, өгүүлүүдээс харж болох юм (“Манай индэр” сэтгүүл.1991. №4,5., “Бодрол бясалгал”.1991.№10).

Үүнийг ноёрхогч марксист сэтгэлгээнээс улс төрийн шинжлэх ухаанд шилжих үзэл санааны урьдач зарим алхмууд байсан гэж үзэж болох бөгөөд чухамдаа улс төрийн шинжлэх ухааны институцилт 1990-1991 онуудад манайд эхэлсэн нь илэрхий байна. 1990-1992 он бол эрдэмтэн, багш, судлагчид эл шинжлэх ухаантай ерөнхий байдлаар танилцах, үндсийг нь эзэмших, хичээл заах, өгүүлэл гарын авлага бичихэд өөрийгөө бэлтгэн боловсруулах, мэргэжлийн анги салбар, судалгаа, сургалтын төвүүд нээх бэлтгэл хангасан зохион байгуулалтын их ажил хийсэн үе байсан хэмээн судлаачид дүгнэсэн байдаг нь монголын улс төрийн шинжлэх ухаан тодорхой бэлтгэл үеийг дамжин хөгжиж буйг баталж байна (Жамбал, Ганболд. Политологи. 2007. 45, 82-83 талууд).

Тухайлбал, 1990-1991 оны хичээлийн жилээс МАХН-ын түүх, ЗХУКН-ын түүх, шинжлэх ухааны коммунизмын онол хичээлүүдийг их дээд сургуулийн сургалтын хөтөлбөрөөс хасч, тэдгээрийн оронд шинэ хичээлүүд заах бэлтгэл хийгджээ. Их дээд сургуульд улс төр судлалын хичээлийг заах тухай Ардын боловсролын яамны 1991 оны шийдвэрийн дагуу их дээд сургуулийн нийгмийн ухааны багш нарыг дахин бэлтгэх, улс төр судлалын хичээлийн төлөвлөгөө, лекц боловсруулах, энэ чиглэлээр сургалт, судалгааны ажлыг эрхлэх нэгж байгуулах бэлтгэл ажлууд хийгдсний үндсэн дээр 1991 онд МУИС-ийн захирлын тушаалаар хуучин ШУКО-ын тэнхимийн суурин дээр Улс төр судлалын тэнхим байгуулагдсан байна. Хэдийгээр монголд улс төр судлалыг хөгжүүлэхэд тэр үеийн Улс төрийн дээд сургууль (хуучин Намын дээд сургууль), ШУА-ийн философи, социологи, эрхийн хүрээлэн, МУИС-ийн НУФ-ын ШУКО-ын тэнхим идэвх санаачилгатай ажиллаж байсныг үгүйсгэхгүй ч улс төрийн шинжлэх ухааны академик сургалт, судалгааг дагнан эрхлэх мэргэжлийн тэнхим бий болсон нь манайд шинэ тутам энэ шинжлэх ухааныг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой болсонтой хэн ч маргахгүй бизээ. Улс төр судлалын тэнхим байгуулагдмагц их дээд сургуулиудын улс төр судлалын багш нар энд төвлөрч сургалт эрдэм шинжилгээний болон мэргэжлийн заах аргын семинарууд зохион байгуулах болсноос эхлээд тус тэнхимд улсын хэмжээний улс төрийн шинжлэх ухааны сургалт-судалгааны төв байх үүрэг хариуцлагыг оногдуулжээ. Гэхдээ улс төрийн шинжлэх ухааны судалгаа шинжилгээний ажлыг эл тэнхим

дангаараа үүрч явсан гэвэл бодит байдалд нийцэхгүй нь мэдээж. 1992 онд улс төр судлал, социологи, угсаатан судлалаар судалгаа хийх зорилгоор Нийгмийн судалгааны төв, 2003 онд МУИС-ийн НШУС-ийн дэргэд Нийгмийн судалгааны хүрээлэн, 2004-2005 онд Монголын улс төр судлаачдын холбоо, Монголын улс төрийн шинжлэх ухааны холбоо, Орчин үеийн улс төрийн судалгааны төв тус тус байгуулагдсан юм.

Түүнчлэн ШУА-ийн Философи, социологи, эрхийн хүрээлэн, Удирдлагын академи, Улс төрийн боловсролын академи, Улс төрийн намуудын дэргэдэх судалгааны байгууллагууд, Полис төв, Зориг сан, Альтернатив төв, Сант Марал сан, Сонгогчдын боловсрол төв, Монголын лектор төв зэрэг төрийн болон төрийн бус байгууллагуудын сургалт, судалгааны үйл ажиллагаа улс төрийн ухааныг хөгжүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж байгааг тэмдэглэх ёстой. Соросын сан, Иргэний боловсрол төсөл, АНУ-ын Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сан, Конрад Аденауэрын сан, Эбертын сан, Төв Европын их сургууль зэрэг олон улсын байгууллагуудын дэмжлэг туслалцааг мартаж болохгүй. Мөн МУИС-иас гадна УБИС, Соёмбо, Шинжээч-21, Чингис хаан дээд сургууль, Удирдлагын академи, Отгон тэнгэр, Орхон, Их засаг, Олон улс судлалын дээд сургууль зэрэг их дээд сургуулиудад философич-улс төр судлаач, социологич-улс төр судлаач, түүхч-улс төр судлаач, нийгэм судлаач-улс төр судлаач гэсэн хос мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэж байна. Ийнхүү монголд улс төрийн шинжлэх ухаан институци үйл явц зогсолтгүй өрнөж, зорилго нэг улс төрийн шинжлэх ухааны гэр бүл жилээс жилд өнөр өтгөн болсоор ажгуу.

1993 онд МУИС-д улс төр судлалын салбар байгуулагдаж бакалавр, магистр, докторын шаталсан сургалт явуулах үүд хаалга нээгдсэн нь улс төр судлалаар эх орондоо мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх анхны алхам болж тус тэнхмийн үйл ажиллагааны хүрээг улам өргөжүүлсэн юм. 1996 онд анхны магистр төгсч, анхны төгсөгчдөөс АНУ-д мастерын зэрэг, эх орондоо докторын зэрэг хамгаалж эхэлсэн билээ. Эдүгээ төгсөгчдөөс АНУ, БНСУ, ОХУ-ын их сургуулиуд, Төв Европын их сургуульд мастерын зэрэг хамгаалаад байна. 1997 онд улс төр судлалын анхны бакалавр 15 хүн төгсөж, мөн улс төр судлалын орой, эчнээ ангиуд нээгдсэн юм. Улс төр судлалын тэнхмийн багш нараас 1994 онд А.Юндэндорж Москвагийн Улсын Их сургуульд улс төрийн шинжлэх ухааны доктор (Sc.D) , 1999 онд Ё.Довчин Санкт-Петербургийн Улсын Их сургуульд улс төрийн шинжлэх ухааны докторын (Ph.D) зэрэг тус тус хамгаалав. 1997-1998 оны хичээлийн жилээс улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийг ШУА-ийн ФСЭ-ийн хүрээлэнд түшиглүүлэн философи, социологийн докторын зэрэг хамгаалуулах зөвлөлтэй хамтатган байгуулжээ. 1998 онд УБИС-ийн тэнхмийн эрхлэгч Л.Пүрэвдорж анх энэ зөвлөл дээр улс төрийн шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан байна.

Улс төр судлалын салбар нээгдсэн цагаас хойшхи хугацаанд 614 бакалавр, 71 магистр төгсч, 17 хүн тус тэнхмээр дамжиж докторын зэрэг хамгаалсан байна. Эдүгээ улс төр судлалын салбар Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн хамгийн олон суралцагчидтай салбар болж бэхжсэн бөгөөд одоогийн байдлаар 222 бакалавр, 55 магистрант, 24 докторант суралцаж байна. Тус тэнхмийн багш нарын 70 орчим хувь нь эрдмийн зэрэг цолтой байна.

Улс төр судлал мэргэжлийн стандарт, сургалтын хөтөлбөр олон улсын жишиг, нийгмийн хөгжил, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдан улам боловсронгуй болж ирснийг тэмдэглэх хэрэгтэй.

Тус салбар тодорхой хугацаанд бэлтгэл хангасны үндсэн дээр сургалтын хөтөлбөрийн чанарыг сайжруулах, өөрийн үнэлгээний тайлангаа хөндлөнгийн хяналтын байгууллагаар шинжилгээ хийлгэснээр энэ онд нийгмийн шинжлэх ухааны хөтөлбөрүүд дотроос улсад анх удаа улс төр судлалын сургалтын хөтөлбөр амжилттай магадлан итгэмжлэгдсэн нь манай ажлын өнөөгийн төвшин, цаашдын хандлагыг тогтоож өгсөн чухал шалгуур болсон юм. Манай улс төр судлалын салбар “Улс төрийн шинжлэх ухааны салбарт онолын болон хавсарга судалгааг олон улсын төвшинд хийж, сургалт-эрдэм шинжилгээний ажлаараа үндэсний хэмжээний гол төв байж, оюутан, суралцагсад болон нийгэмд чанартай үйлчилгээ үзүүлнэ” гэсэн эрхэм зорилгыг иш үндэс болгож сургалтын хөтөлбөр, хүний нөөц, сургалтын орчин гэсэн хүрээнд ажлаа төлөвлөж тавьсан зорилтуудаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд юуны өмнө нийгмийн эрэлт хэрэгцээний дагуу улс төр судлаачаас гадна хавсарга болон хос мэргэжлээр мэргэжилтэн бэлтгэх шаардлагад нийцүүлэн энэ хичээлийн жилээс бакалаврын сургалтын төлөвлөгөөг шинэчилснээр мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх 87 багц цагийн багтаамжтай 40 хичээлийн бүх тодорхойлолт, хөтөлбөрүүдийг дахин сайжруулж боловсруулав. Мэргэжлийн гол суурь хичээлүүд, тухайлбал улс төр судлалын үндсүүд, улс төрийн сэтгэлгээний түүх, харьцуулсан улс төр, парламент, үндсэн хууль судлал, улс төрийн элит, улс төрийн сэтгэл зүйн хичээлүүд үндсэн сурах бичигтэй болсон нь оюутнууд бие даан суралцахад тус дөхөм болж байна.

Багш нар эрдэм шинжилгээний ажлыг сургалттай эн тэнцүү анхаарч ихээхэн цаг, хүч хөдөлмөр зарж ирснийг тэмдэглэх хэрэгтэй. Тэд оюутан, магистрант, докторантын судалгааны ажлыг удирдаж, олон улсын болон өөрийн орны эрдэм шинжилгээний хуралд илтгэл тавьж, гадаад дотоодын улс төрийн шинжлэх ухааны ном эмхэтгэл, сэтгүүлүүдэд судалгааны өгүүллүүд нийтлүүлж ирлээ. Одоогийн байдлаар манай тэнхмийн багш нарын бичсэн нэг сэдэвт зохиол, ном, сурах бичиг 90, эрдэм шинжилгээний өгүүлэл 352, эрдэм шинжилгээний илтгэл 180 байна. Тус тэнхмийн залуу эрдэмтэн Ж.Төртогтох, С.Мөнхбат нарын бичсэн эрдэм шинжилгээний өгүүллүүд Японы Токиогийн их сургууль, Олон улсын социологийн холбооноос эрхлэн гаргасан эрдэм шинжилгээний өгүүллийн эмхэтгэл, Японы Кокушिकаны их сургуулийн эрдэм шинжилгээний бичигт нийтлэгдсэн бөгөөд Ж.Төртогтох англи хэл дээр хэвлэгддэг “Contemporary Political Society” олон улсын сэтгүүлийн редактораар ажиллаж байна. Тэнхим байгуулагдсны ойд зориулж тэнхмийн багш нар “Улс төрийн шинжлэх ухаан” сурах бичгээ дахин хэвлүүлж, мөн “Улс төрийн шинжлэх ухаан дээж бичиг” хамтын бүтээл гаргав. Багш Ч.Өлзийсайхан “Монгол дахь ардчилсан шилжилтийн үеийн улс төрийн элитийн төлөвшил”, Г.Цэнд-Аюуш “Улс төрийн ухамсар: түүхэн судалгаа” нэгэн сэдэвт бүтээл, Ц.Ганболд “ШУКО-гоос Улс төр судлал хүртэл” дурсамж дурдатгалын ном хэвлэгдэж, Ё.Довчин “Харьцуулсан улс төр” сурах бичиг, гарын авлагыг нэмж засварлан гаргасан байна. Тэнхмийн багш нар Соросын сан, Иргэний боловсролын сан, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн судалгааны төв, УИХ-ын тамгын газар, НХХЯ-ны төсөл, гэрээт судалгааны ажилд идэвхтэй оролцож ирэв.

Бид семинарын хичээл, онол практикийн хурал, хэлэлцүүлэг мэтгэлцээнээр дамжуулж оюутнуудад шүүн тунгааж шинжлэх сэтгэлгээ, задлан ялгаж дүн шинжилгээ хийх ур чадвар эзэмшүүлэхийн төлөө ажиллаж байна. Манай оюутнуудын улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлуудад тавьсан илтгэлүүд байнга дээгүүр байруудад шалгарч байдгийг бид бас зохих ёсоор үнэлдэг. МУИС-ийн Улс төр судлалын тэнхмээс бусад их дээд сургуулиуд, төрийн ба төрийн бус судалгааны байгууллагууд хамтран жил бүр улс төрийн шинжлэх ухааны чухал сэдвүүдээр эрдэм шинжилгээний хурал уламжлал болгон зохион байгуулж, бас эрдэм шинжилгээний “Политологи” сэтгүүлд олон улсын дугаар авч тогтмол гаргаж уг сэтгүүл мэргэжлийн хүрээнийхэнд хэзээний танил болжээ. Платон, Аристотель, Руссо, Монтескье, Поппер, Хайек, Шумпетер, Нозик, Хантингтон, Даль, Алмонд, Лейпхарт зэрэг улс төрийн сэтгэгчид, орчин үеийн нэрт улс төр судлагч эрдэмтдийн зохиол бүтээл орчуулагдан гарахад манай багш нар өөрийн хувь нэмрээ оруулсан юм.

Хүний нөөцийн хүрээнд багш нарыг хөгжүүлэхэд тус салбарын гадаад харилцаа чухал үүрэгтэй хөгжиж ирсэн. Тус тэнхим Өмнөд Солонгос, Япон, БНХАУ-ын ӨМӨЗО-ы их сургуулиудтай хамтын ажиллагааны гэрээтэй ажиллаж байна. Тэнхимийн профессор багш нар АНУ, Герман, ОХУ, Казахстан, Унгар, БНСУ, Литва зэрэг орнуудад очиж мэргэжил дээшлүүлснээс зөвхөн энэ хичээлийн жилд Япон, БНХАУ, АНУ, БНСУ, Шведийн их сургуулиудын улс төрийн шинжлэх ухааны сургууль, тэнхмүүдэд мэргэжил дээшлүүлж, лекц уншсан байна. Багш нар олон улсын болон Азийн улс төрийн шинжлэх ухааны байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог болов. Профессор Ц.Ганболд Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоонд гишүүнээр элсэж, Японы Фукуока хотод болсон Олон улсын шинжлэх ухааны ХХ их хуралд оролцсон бол Д.Бадамдаш Америкийн Улс төрийн шинжлэх холбооны гишүүнээр элссэн байна. Тус тэнхим одоо АНУ-ын Рейжисын их сургуультай мастерын хамтарсан хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Улс төр судлалын тэнхимд 2001 оноос хойш гадаадын 30 орчим мэргэжилтэн урт богино хугацаагаар ажилласны дотор 13 зочин профессор жилээс доошгүй хугацаагаар ирсэн байдаг.

Сургалтын орчныг сайжруулах нь НШУС, манай салбарын анхаарлын төвд байж анги танхимын тохижилт, техник хангамж жилээс жилд ахиц гарч ирсэн гэж болно. Давын өмнө оюутныг гадаад дотоодын холбогдох ном сурах бичиг, гарын авлагаар хангахад анхаарсны үрээр номын фонд байнга баяжиж одоо бакалаврын сургалтад мэргэжлийн хичээлийн 2344 ном ашиглаж байна. Номын сангаас гадна оюутны бие даах төв, тэнхимд оюутнууд өдөр тутам ашигладаг үндсэн сурах бичгүүд, лавлах материалуудыг бэлэн байлгахыг зорьж байна. Тэнхимийн вэбсайт нээж, багш нарыг компьютер, бусад сургалтын техник хэрэгслээр зохих хэмжээнд хангасан нь тэд Sisi програм, e-сургалтын хэлбэрийг ашиглах бололцоог бүрдүүлсэн гэж үзэж байна. Тус салбарын оюутнууд анги танхимдаа утасгүй интернет ашиглах боломжтой болов. Зориг сангаас 2010 онд улс төр судлалын салбарын оюутнуудад зориулж сургалтын иж бүрэн тоноглогдсон танхим байгуулж хүлээлгэн өгсөн нь сурах орчныг сайжруулахад бодитой хувь нэмэр болсныг тэмдэглэж байна. Ийнхүү бие биеэс нь салгахын аргагүй харилцан шүтэлцээ бүхий үйл ажиллагааны хүрээнүүд нэгэн тогтолцоог бүрдүүлж байж сая улс төр судлалын салбарын сургалт, судалгааны ажил зорилго чиглэлтэй, цэгцтэй явах бөгөөд тэр утгаараа монголын улс төрийн

шинжлэх ухааны хөгжилд нэг том урсгал болж нийлэх болно. МУИС-ийн Улс төр судлалын салбарыг хөгжүүлж бэхжүүлэх нь манай улсын улс төрийн шинжлэх ухааны цаашдын ирээдүйд нэн чухал хүчин зүйл байх нь гарцаагүй.

Өнөөдөр Монгол оронд улс төрийн шинжлэх ухаан олон улсын жишгээр хөгжих суурь нэгэнт тавигдаж бодит үзэгдэл болсныг түүний зохион байгуулалтын бүтэц, судалгааны онол арга зүй, мэргэжилтэн судлаачдын нөөц гэрчилж байна. Тухайн шинжлэх ухаан академик сургалт, мэргэжлийн бие даасан салбар болж дэлхийн улс орнуудад хөгжиж ирсэн тэрхүү жам ёсыг монголын улс төрийн шинжлэх ухаан дамжиж өнөөгийн төвшинд хүрчээ. Гэвч аливаа танин мэдэхүйн үйл явц тасралтгүй байдаг логикийн дагуу манай улс төрийн шинжлэх ухааны хөгжил эхлэлийн шатандаа явж байна хэмээн дүгнэж болох бөгөөд хийх ажлын дийлэнхи та бидний өмнө байгааг хүлээн зөвшөөрөхөөс аргагүй. Энэ хүрээнд энэ удаад дараахь гурван “эрмэлзэх зүйл”-ийг хэлье гэж бодлоо. Үүнд:

1. Улс төр судлалын хөтөлбөрийн чанарыг ямагт анхаарлын төвд байлгаж цаашид олон улсын магадлан итгэмжлэлд бэлтгэх хэрэгтэй. Үүнтэй холбоотойгоор, бас улс төрийн шинжлэх ухаан улам бүр олон улсчлагдаж буй эдүгээ цагт Олон улсын улс төрийн шинжлэх ухааны холбоотой харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх шаардлагатай байна. 1949 онд байгуулагдсан, дэлхийн улс орнуудын улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн асуудлуудыг зангидан зохион байгуулдаг олон улсын энэхүү нэр хүндтэй төв одоо 52 үндэсний холбоод, 3600 гаруй хувь хүмүүсийн гишүүнчлэлтэй, 50 Судалгааны хороотой ажиллаж, 3 жил тутам Олон улсын улс төрийн шинжлэх ухааны Конгрессыг (21 удаа) зохион байгуулж байна. Бид хувиараа, хамт олноороо, институцээрээ элссэнээр тус холбооны үйл ажиллагаа, судалгааны төсөл, их хурал, Судалгааны хороодод оролцох, мэргэжлийн ном сэтгүүл хүлээн авах, онлайн нийтлэлүүдийг ашиглах зэрэг өргөн боломж нээгдэнэ. ОУУТШУХ-ы сүүлийн хоёр их хурал профессор Ц.Ганболд монголын улс төр судлаачдыг төлөөлөн оролцсон нь гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх чухал алхам болсныг тэмдэглэх хэрэгтэй. Холбооны ойрын их хурлууд Монреал (2014), Истанбул (2016) -д тус тус болно. Эдгээрт монгол улсаас олон хүмүүс, судлаачид оролцох нь лавтай. Энэ дашрамд дурдахад улс төр судлалын багш нарыг шинээр болон давтан бэлтгэх, олон улсын хурал, байгууллагын үйл ажиллагаа, туршлага судлах, сонгуулийн ажиглагчаар оролцуулах зэрэгт улсаас зориуд анхаарах шаардлагатай байна. Ер улс төр судлалыг манай улсад шинэ тутам хөгжиж буй салбарын хувьд хөрөнгө санхүүжилтийг төрөөс зориуд анхаарч үзэх ёстойг нэг талаас монголын улс төрийн өнөөгийн байдал, нөгөө талаас бид дээр энэ шинжлэх ухааныг улс орнуудс эх орондоо хэрхэн хөгжүүлсэн жишээнээс тодорхой харсан билээ.

2. Улс төрийн сэтгэлгээ, улс төр судлал ганц өрнөдийнх биш, бас үүний хамт цэвэр улс төр гэж явцуурах учиргүй. Иймээс дорнын, түүний дотор өөрийн орны улс төрийн сэтгэлгээ, нийгэм улс төрийн түүх, орчин үеийн чухал асуудлуудыг хамтын хүчээр судалж дорвитой бүтээлүүд туурвих, энэ талаархи сурах бичиг гарын авлагуудыг олшруулах шаардлагатай байна. Үүнээс гадна нийгмийн ухаануудыг интегарцчлах, наад зах нь мастерын сургалтын салбар хоорондын нэгдсэн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, хамтарсан төсөл гүйцэтгэх, судалгаа хийхийг бодит байдал шаардаж байна. Ялангуяа олон улсын харилцаа, төрийн захиргаа бол олон улсад улс төрийн шинжлэх ухааны

судалгааны үндсэн чиглэлд тооцогддог атал манайд дурдсан асуудлуудаар хийгдэж буй судалгаа, мэргэжилтэн бэлтгэх сургалт, эрдмийн зэрэг хамгаалуулах зөвлөл улс төр судлалын бүтэц, зохион байгуулалтаас хэтэрхий хол тасархай байгааг засч залруулах нь зүйтэй юм.

3.1980-аад оноос улс төр судлалд арга зүйн плюраль зарчимд тал өгч дэмждэг болсон нь үнэн. Гэхдээ улс төрийн өөрчлөлт, хөгжлийг судлах арга зүйн институцийн ба контекстын гэсэн үндсэн хоёр хүрээнд ерөнхийдөө эргэлдэнэ. Энэ нь дэлхийн улс орнуудыг судлах, бас монголыг судлахад ч хамаатай. Яахын тулд бид гадаадын улс төрийн системүүдийг харьцуулдаг вэ гэхлээр өөрийгөө л танин мэдэхийн тулд шүү дээ. Бид статистик анализ, чанарын арга зүйг аль алиныг нь ашиглах болно. Иймээс өнөөгийн улс төрийн ерөнхий онол арга зүйг баримтлахын хамт тэдгээрийг бүтээлчээр хэрэглэж монголын улс төр бол бие даасан судлагдхуун гэдэг байр сууринаас хандах хэрэгтэй байна. Өнөөдөр манай улс төр судлаачдын хувьд монголын ардчиллын нягтрал, ардчиллын чанарыг институци талаас засаглалын чадавхи, хариуцлага, контекст талаас хүний хөгжил, эдийн засаг, нийгмийн хүрээтэй харилцан шүтэлцээнд нь авч судлах нь тулгамдсан асуудлуудын нэг гэж үзэж байна. Энэ нь хэдийгээр улс төрийн шинжлэх ухаан хэн нэгэнд засгийн эрх авах, сонгуульд ялах, эсвэл аливаа зөрчлийг шийдвэрлэх бэлэн жор бичиж өгөх зорилготой биш ч орчин үеийн онол- арга зүйд тулгуурласан эмпирик судалгаа явуулж улс төрчдөд, улс оронд хэрэг болох санаа, зөвлөмж дэвшүүлж байх нь түүний практик өгөөж байж болох юм. Мөн иргэдийн улс төрийн соёл, сэтгэл зүйн өөрчлөлт, улс төрийн оролцоо ба өрсөлдөөний тэнцвэрийн асуудал, сонгуулийн кампанийн технологи зэрэг ардчиллын үйл явцыг тодорхойлох асуудлууд даацтай судалгаа шинжилгээг хүлээж байна.

Ийнхүү улс төрийн шинжлэх ухааны хөгжил, түүний сургалт, судалгааг тойрсон асуудал олон, хийх ажил их байна. Энэ бүхэнд бид бүхний хамтын ажиллагаа хамгийн чухал байна. 1967 онд байгуулагдсан ШУКО-ын танхимаар суурь нь тавигдсан учир МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн 45 жилийн ойг өнгөрсөн онд тэмдэглэж, энэхүү чухал үйл явдлыг манай эрдмийн хамт олон эрдэм шинжилгээ, сургалтын чамлахааргүй амжилтаар угтсан билээ.

Ном зүй

1. Ганболд Ц. Монгол дахь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны сургалт судалгааны зарим асуудалд // Политологи. 2007.№3
2. Довчин Ё. Улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн тойм // Орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжил хандлага. ЭШХ. УБ., 2010
3. Жамбал А. Монгол улсад улс төрийн шинжлэх ухаан үүсэн төлөвшиж байгаа нь. // Политологи. 2007.№3
4. Гаджиев К.С. Введение в политическую науку. М., Логос.1997
5. Политическая наука: новые направления. М., 1999
6. A New Handbook of Political Science (1996) / ed. by Goodin R. Klingemann H-D. N-Y.,
7. Rawls J. (Reprint. 2005) Theory of Justice. USA.

УЛС ТӨРИЙН ХӨГЖИЛ: ОНОЛ, ПРАКТИК

Political Development

Б.Эрдэнэдалай*СЭЗДС-ийн багш, МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн докторант***ОРШИЛ**

Дэлхийн хоёрдугаар дайн улс төрийн хөгжилд чухал нөлөө үзүүлсэн. Дайны дараа Ази, Африк, Латин Америкийн орнууд улс төрийн хувьд өөрчлөгдөн шинэчлэгдэж байсан нь эдгээр улсуудын улс төрийн дэглэм, улс төрийн соёл, улс төрийн нам, элит, нийгэмшил, сонирхлын бүлэг, сонгуулийн систем, үндсэн хууль зэргийг харьцуулан судлах шаардлага гарч ирж, энэ асуудлуудыг цааш гүнзгийрүүлэн судалсан. Дэлхийн улсууд улс төрийн хувьд ингэж өөрчлөгдөж эхэлсэнтэй холбоотойгоор Америкийн Нэгдсэн Улс бусад улсуудыг судлах шаардлагатай болсон. АНУ болон Европын улсуудын судлаачдын үзэж байснаар дэлхийн улсууд улс төрийн хувьд өөрчлөгдсөнөөр шинэ шинэ үндэстнүүд төрөн гарч, тоталитар, авторитар дэглэмүүд хямралд орж, ардчилсан тогтолцоогоор солигдсоор байна. Дэлхийн өнцөг булан бүрт ардчиллын төлөө тэмцэл өрнөж, улсууд өөрсдийн аюулгүй байдлыг ханган ашиг сонирхлоо хамгаалан хоорондоо харилцах боллоо. Улс төр судлаачдын хувьд эдгээр улсуудын шилжилтийн үйл явцыг дахин судалж шинэ маягийн улс төрийн тогтолцоо, өвөрмөц онцлог бүхий модернизациудыг ялган ангилах шаардлага тулгарсан.

Энэхүү судалгааны ажлаараа 1950-1960-аад оны үеэс шинжлэх ухааны эргэлтэд орж хөгжсөн “Улс төрийн хөгжлийн онол”-ын талаар бичигдсэн судалгааны материалууд, эрдэм шинжилгээний өгүүлэл зэргийг судлах, ялангуяа энэ онолын гол гол төлөөлөгчдийн бүтээлийг судлах үндсэн дээр улс төрийн хөгжлийн онолын үүсэл хөгжил, судлах зүйл, судлаачдын үзэл баримтлал, уг онолын давуу ба сул талууд зэргийг дээрх материалууд дээрээ үндэслэн гаргаж ирэхийг зорилгоо. Бие даалтын ажлыг гүйцэтгэхдээ улс төрийн хөгжлийн онолын талаарх судалгааны бүтээл, тайлбар, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл зэрэг эх сурвалжийн агуулгад дүн шинжилгээ хийх, баримт материал цуглуулж контент анализ, бичиг баримтын шинжилгээ хийх, харьцуулан жиших, тайлбарлах зэрэг аргуудыг ашиглалаа.

Улс төрийн хөгжил

Нийгмийн амьдралын бүх хүрээнд хөгжлийн тухай асуудал яригддаг. Тухайлбал, эдийн засгийн хөгжил, оюун санааны амьдралын хөгжлийн тухай яригддаг байтал улс төрийн хөгжлийн тухай ярих нь ховор байжээ². Улс төр судлаач эрдэмтдийн үзэж байгаагаар Улс төрийн шинжлэх ухаанд “Улс төрийн хөгжил”-ийн тухай онол 1950-иад оноос эрдэм шинжилгээний эргэлтэд орж

² МУИС. Улс төрийн шинжлэх ухаан. УБ.,2010. 434 дэх тал

эхэлсэн³. Хөгжлийн тухай үзэл санаа ардчилал, олон ургальч үзэл, нийгмийн шударга ёсонд тулгуурлаж байсан. Америкийн эрдэмтэд өөрсдийн судалгаагаар шинэ тутам гарч ирсэн үндэстнүүдэд хөгжил нь ардчиллыг авчрахад туслах болно хэмээн итгэцгээж байв. Ийм учраас хөгжлийн онол нь “шинжлэх ухаанч” төдийгүй ёс зүйн чухал ач холбогдолтой гэж үзэж байв. 1960-аад оны дунд гэхэд эрдэмтэд судлаачид улс төрийн хөгжлийн хандлагыг ихээр сонирхож, хөгжлийн онолын ойлголт категори, хандлагын асуудлуудаар Ази, Африк, Латин Америкийн хөгжиж буй орнуудад судалгаа хийцгээх болжээ. Хөгжлийг хэмжих шалгуур нь ихэнхдээ Америк, Төв Европын туршлага байв. Тэд ихэвчлэн дунд анги, үйлдвэрчний эвлэл зэрэг хөгжиж буй улсуудад шинээр үүсэж бий болсон бүлгүүд, тариачдын хөдөлгөөнүүдийг судлахад анхаарсан учраас эдгээр асуудлаар олон зуун судалгааны бүтээлүүд гарчээ. Гэхдээ улс төрийн хөгжлийн тухай асуудлыг судлаачид янз бүрээр тайлбарласаар ирсэн бөгөөд одоо ч нэгдсэн шалгуур нэгдмэл ойлголтод хүрээгүй л байгаа юм.

Америкийн улс төр судлаач Л.Пай улс төрийн хөгжлийг гурван шалгуураар авч үзсэн⁴. Үүнд:

1. Тэгш эрхэд хандах байдал. Улс төрийн үйл явц дахь олон түмний оролцоо, хуулийн түгээмэл шинж, төрийн засаглалын үл залгамжлагдах шинж (нэг анги, бүлэг, кастын үе залгамжилсан ноёрхлыг үгүйсгэх) зэргийг хамааруулан үзсэн.
2. Системийн чадвар. Шинэчлэгдэх чадвар (инноваци), дайчлах чадвар (мобилизаци), оршин байх чадвар зэргийг хамааруулж үзсэн.
3. Бүтцийн дифференциаци. Улс төрийн систем нь шинэ хэрэгцээ шаардлагад маш хурдан зохицож чаддаг байх ёстой. Мөн улс төрийн институтууд мэргэшлийн өндөр түвшинд үүргээ гүйцэтгэдэг байх ёстойг хамааруулан ойлгодог.

Зарим судлаачид улс төрийн хөгжил улс төрийн модернизаци хоёрыг адилтгаж ойлгодог байхад сүүлийн үед олонх судлаачид дээрх хоёр ойлголтыг ялгаж үзэх болсон. Тухайлбал, улс төрийн хөгжил гэдэгт улс төрийн модернизациас гадна улс төрийн модификаци, улс төрийн трансформацийг хамааруулж тайлбарлаж байна.

Улс төрийн модернизаци

Модернизацийн онол нь зуу гаруй жилийн түүхтэй. Карл Маркс, Макс Веберээс эхлэн Даниэл Белл хүртэлх модернизацийн онолын гол үндэслэл нь эдийн засаг, соёл, улс төрийн чиглэлд гарч буй өөрчлөлтүүд нь хоорондоо уялдаа холбоотой бөгөөд үүнийг урьдаас таамаглаж болно гэдэгт оршдог⁵. Модернизацийн онолыг баримтлагч нэлээд олон судлаачид нийгмийн

³ J.C.Johari. *Political Development*. Comparative Politics. India, New Delhi.,2008. p.168

⁴ Lucian W.Pye. *Aspects of Political Development*. Boston: Little Brown.,1966. p.45-47

⁵ Ronald Inglehart. *Modernization and Postmodernization: Cultural, Economic and Political Change in 43 Societies*. Princeton University Press. 1997. p. 7

хөдөлгөөнт байдал ба орчин үеийн нийгмийн бүтцэд эзлэх байр суурь нь соёлын өөрчлөлтийг нөхцөлдүүлэгч гол шалтгаан болдог гэж тэмдэглэдэг⁶.

Рой Макридсын “Харьцуулсан улс төр” бүтээлд тэмдэглэсэнээр⁷, Өнгөрсөн хоёр зууны туршид Европын улсуудын улс төрийн хяналтанд байсан Ази, Африк, Латин Америкийн ард иргэд тусгаар тогтносон бие даасан байдлыг олж авснаараа ХХ зуунд тохиосон чухал үйл явдал байлаа. Дэлхийн хүн амын гуравны нэг орчим нь энэхүү үндэснийхээ тусгаар тогтносон байдлын тэмцэлд ямар нэгэн байдлаар холбоотой байдаг. Европчууд Ази, Африк, Ойрхи Дорнодын өргөн уудам газар нутгийг цэргийн технологийн хүчирхэг байдлаараа эзлэн, захирч өөрийн улсын түүхий эдийн байдлаар Барууны орнууд эдгээр орнуудыг ашиглан тонож эдийн засгийн, цэргийн, соёлын хүнд дарамтыг тухайн орны ард түмэнд үзүүлж байв. Энэ үед өрнөдийн улс төрийн шинжээчид өөрсдийн анхаарлыг голдуу Баруун Европ, Хойд Америк руу чиглүүлцгээж байлаа. Тэдэнд колонийн улс орныг судлах сонирхол байсангүй.

Колоничлол дэлхийн хоёрдугаар дайны дараа нуран унасан. Колоничлолын гол удирдагчид болох Их Британи, Франц, Голланд улсууд дотоодын зөрчил мөргөлдөөний улмаас колонийн төлөө цэргийн ямарваа нэг шинэ туршилтуудад оролцох зэргээс залхсан. Ази, Зүүн Өмнөд Азид тэдэнтэй өрсөлдөхүйц хэмжээнд очсон улс нь Япон болсон бөгөөд Японы аюул заналхийллээс болгоомжилж Англи улс Энэтхэгт тусгаар тогтнол олгохоор амлаж байжээ. Франц, Голланд улсууд Энэтхэг Хятадын Хойг болон Индонез дахь бүрэн эрхт байдлаа алдах боломжгүй байв.

Баруун Европын улсууд 1945 онд өөрсдийн тогтоосон байсан давуу байдлуудаа алдаж хуучин колонийн дарлалд байсан улсуудыг дэмжин тохинуулагч АНУ ба ЗХУ гэх хоёр том гүрэнд дэлхийн хувь заяаг шийдэх эрх олгосон. АНУ, ЗХУ хоёр хоёулаа колонийн иргэдийн эздийн дэмжлэгийг ашигласан. Европын эрх мэдэлтнүүд колониудынхаа эзэдтэй харилцах харилцаанд хүндрэл бэрхшээлүүд тулгарч байв. Тэд дэлхий дээр өөр нэг шинэ бүрэн эрх бүхий засаглагчид бусдыг булаан эзлэхийг оролдох, ямар ч тохиолдолд хийх боломжтой бага ч гэсэн зүйлийг хийх зэргийг хүлээн зөвшөөрөхгүй байв.

Дэлхийн гол гол бүс нутгууд дахь шинэ харилцааг харьцуулах нэлээд чухал үйл явдлууд болсон. Энд Францын хувьсгал, Европ болон Латин Америк дахь аж үйлдвэрийн хувьсгал, Орост өрнөсөн Коммунизмын ялалт зэрэг үйл явдлууд орно. Эдгээр түүхэн үйл явдлуудын өөрчлөлт тус бүрт нийгэм болон соёлын орчин, улс төрийн засаглал, зохион байгуулалтын шинэ хэлбэрүүдийг удирдах зэрэг шаардлагууд урган гарсан. Энэ үеэс эхлэн өрнөдийн улс төрчид шинэ үүсэн бий болсон улсуудын улс төрийн амьдралыг судалж, ажиглаж, тодорхой дүгнэлтэд хүрч таамаглал дэвшүүлж харьцуулсан улс төр судлаачдын анхаарлыг шинэ сонирхолтой асуудлууд руу татсан юм. Ер нь аливаа улс төрийн өөрчлөлт нь зөвхөн хөгжиж буй орнуудад тохиолддоггүй, аж үйлдвэр өндөр хөгжсөн оронд хүртэл явагдаж тухайн орны улс төрийн системийг улам

⁶ Pye Lucian. “*Political Science and the Crisis of Authoritarianism*”. Inkeles, Alex and David Smith. *Becoming Modern*. American Political Science Review 84/1, Cambridge University Press., 1974. p.3-19

⁷ Roi C. Macridis. *Comparative Politics*. 1986. p.421-453

боловсронгуй болгосоор байдаг. Энэ нь улс төрийн өөрчлөлт тасралтгүй явагддаг гэсэн санааг илэрхийлж байна. Аливаа улс төрийн системд тодорхой шинэ шаардлагууд тавигдаж түүнийг зөв шийдвэр болгон гаргах үүрэг хүлээдэг.

Өнөөдрийн дэлхий ертөнц мөн хувиран өөрчлөгдөж шинэ шинэ үндэстнүүд төрөн гарч, тоталитар, авторитар дэглэмүүд хямралд орж, ардчилсан тогтолцоогоор солигдсоор байна. Социалист системийн хамтын нөхөрлөл тарж бутран, дэлхийн социалист системийн орчинд дөхөж очсон ЗХУ, 15 тусгаар улс болон задрав. Дэлхийн өнцөг булан бүрт ардчиллын төлөө тэмцэл өрнөж, улсууд өөрсдийн аюулгүй байдлыг ханган ашиг сонирхлоо хамгаалан хоорондоо харилцах боллоо. Улс төр судлаачдын хувьд эдгээр улсуудын шилжилтийн үйл явцыг дахин судалж шинэ маягийн улс төрийн тогтолцоо, өвөрмөц онцлог бүхий модернизациудыг ялган ангилах шаардлага тулгарсан.

Марксистуудын формацийн онол ёсоор эдийн засгийн шахалтын үр дүнд нийгэм нэг шатнаас нөгөөд, феодализмаас социализмд шууд шилжих тухай номлодог. Энэ шилжилт хувьсгалт хүчирхийллийн аргаар хэрэгжиж болохыг тэд үгүйсгээгүй юм. Сүүлийн хоёр зууны туршид олон улс техник технологи, шинжлэх ухааны ололтын үр дүнд өөрийн тухайлсан соёл, улс төрийн тогтолцоог хайхралгүйгээр шинэчлэлт хийсэн.

Улс төрийн лидерүүд нийгмээ огцом үсрэлтээр хөгжүүлэхийг хүссэн бодлого баримталж байна. Тэд нийгэмд шинэ эрхэмлэл, хэм хэмжээг түгээн дэлгэрүүлж аж үйлдвэржилт, хөгжил цэцэглэлт, тэгш байдлыг бий болгоход ард түмнийг хандуулахыг хүсч байна. Харин тэдний энэ эрмэлзлэл нь улс төрийн амьдралын цөөн тооны хэлбэр, түүнд хүрэх олон янзын арга замаар хэрэгжиж байна. Энэ бүгдээс үүдээд өнөөдөр улс төрийн модернизацийн онолын асуудалд тавих анхаарал улам бүр нэмэгдэж байна.

Уламжлалт болон Орчин үеийн нийгэм

Улс төрийн модернизацийн онолын үндсэн судлагдахуун бол “уламжлалт нийгмээс илүү зүй зохистой нийгмийн зохион байгуулалтанд шилжих, өөрөөр хэлбэл уламжлалт нийгмээс орчин үеийн нийгэмд шилжих шилжилтийн үйл явц” юм. Иймээс энэ асуудлыг цааш тодруулахын тулд “уламжлалт” болон “орчин үеийн” нийгэм гэдгийг тогтож тайлбарлах нь зөв⁸.

Уламжлалт болон орчин үеийн нийгмийг тодорхойлсон томоохон эрдэмтэд бол Хенри Мэйн, Фердинанд Теннис нар, мөн Макс Вебер чухал оролцоотой. Макс Вебер тухайн нийгмийн хууль тогтоох ёс нь юун дээр суурилж байсан гэдгийг дэвшүүлж гол анхаарлаа хандуулан дараах ангиллыг гаргасан. Үүнд⁹:

1. Хууль ёсны эрх баригчдын гаргасан хууль ёс, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн норматив хууль ёсыг дээдэлсэн рациональ хөрсөн дээр суурилсан нийгэм.

⁸ Roi C.Macridis. Comparative Politics. 1986. p.423-426

⁹ Roi C.Macridis. Comparative Politics. 1986. p.423

2. Уламжлалт удирдагчдын хэрэгжүүлж буй хууль ёс, өмнөх үеийн уламжлалаа дээдэлж, түүнийг бүх зүйлээс дээр үзсэн уламжлалт үзэл дээр суурилсан нийгэм.
3. Харизматик эрх баригчдын тодорхойлсон дэг журам хэмээх тэдний норматив хэв загвар, бие хүний үлгэр жишээч баатарлаг чанарыг дээдэлсэн харизматик үндэс суурьтай нийгэм.

М.Веберийн гаргасан дээрх ангиллын дагуу нийгэм энгийн хэлбэрээсээ дараагийн арай боловсронгуй хэлбэрт шилжих маягаар харизматикаас уламжлалт нийгэм рүү, уламжлалт нийгэмээс рациональ үзлийг үндэс суурь болгосон орчин үеийн нийгэмд хөгжин дэвшдэг байна.

Хамгийн анхны нийгэмд хүн тухайн гол удирдагчиддаа үнэнч байж, гэр бүлийн үнэт зүйл нийгмийг эзэмддэг. Хувийн болон баатарлаг чанараараа бусдыг араасаа дагуулан харизматик удирдагчдын удирдлага дор энэ байдлыг эвдэж дараагийн нийгэмд шилждэг байна. Орчин үеийн нийгэмд зөвхөн албан ёсны хуульд захирагддагаараа бусад хэлбэрээсээ ялгагдана.

Уламжлалт болон орчин үеийн нийгэмд хувь хүмүүс нь бүлэглэлүүд, нийгэмлэгүүдээр дамжуулан улс төрийн үйл ажиллагаанд оролцох боловч Рой Макридсын үзэж байгаагаар гол ялгаа нь тэдний хэрэглээнд л байдаг байна. Уламжлалт нийгмийн гишүүд нь нүүр нүүрээ тулсан харилцаа голлох гэр бүл, гэр бүлийн хэлбэрт бүлэглэлүүд ноёрхсон байдалд амьдардаг. Хувь хүний статус түүний гэр бүлийн статусаар тодорхойлогдох бөгөөд түүнийг сургаж боловсруулах, асарч тэтгэх, хамгаалах явдлыг өөрийгөө эдийн засгийн хувьд хангаж чаддаг, нийгмийн нэгж болсон гэр бүл батлан хариуцдаг.

Өрнөдийн эрдэмтдийн үзэж байгаагаар эдийн засгийн гол үйл ажиллагаа нь хөдөө аж ахуй бөгөөд гэр бүл нь нийгэм ба бие хүнийг холбогчийн үүрэг гүйцэтгэдэг. Үнэн хэрэгтээ хүн амын ихэнх хэсэг нь мал аж ахуй, газар тариалан, ан агнуурын хөдөлмөр эрхэлж зөвхөн өөрсдийгөө тэжээхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Тэнд шинжлэх ухаан, технологийн мэдлэг их бага, хоол хүнсийг хуримтлуулах бололцоо бага, урлаг соёлд амьдралаа зориулах хүмүүс тун ховор байдаг. Байгалийн гамшиг, бороо, үер, ган гачаал, шуурга тэдний аж ахуйг зарим тохиолдолд бүрэн сүйрүүлнэ. Сүсэг бишрэл, далдын ид шид нийтийн амьдралд ихээхэн нөлөөтэй. Хүмүүс амьдралдаа тохиолдсон элдэв зүйлсийг од гариг, тэнгэр бурхантай холбон тайлбарладаг. Гэр бүлийн эрхэмлэл нь хувь хүний шударга ёс, бүрэн эрх, тухайн нийгэмд түгэн дэлгэрсэн эрхэмлэл байдаг байна. Төр нь гэр бүлтэй адил, төрийн тэргүүн хаан нь тухайн нийгэмд эцэг адил хүндлэгдэж аав хүний үүргийг гүйцэтгэдэг бөгөөд эцгийн эрхт ёс үйлчилсээр байдаг гэж үзсэн.

Уламжлалт нийгэмд нэгэн овог, угсааныхан хамтран амьдарч тэдний хүүхдүүд өөрийн овгийн ёс жаяг, уламжлалаа даган амьдардаг. Уламжлалт нийгэмд угсаатны зан үйл, ёс заншил нэлээд хүчтэй нөлөөтэй байдаг. Уламжлалт нийгмийн дүр төрхийг өнөөдөр дэлхийн аль ч өнцөг буланд буюу Ази, Африк, Латин Америкаас олж харж болно гэж өрнөдийн улс төр судлаачид үзэж байна.

Техник технологийн дэвшил хэдийнээ буурай улсуудад бага боловч нэвтэрсэн ч улс төрийн тогтолцоо, улс төрийн оролцооны уламжлалт нийгмийн хэв журам хадгалагдсаар байна. Техник, шинжлэх ухааны дэвшил нийгэм, улс

төрийн уламжлалт хэв маягийг өөрчилсөөр байна. Зөвхөн өөрийнхөө хэрэгцээг хангадаг хуучин хөдөө аж ахуй нь аж үйлдвэрийн болон зах зээлийн эдийн засгаар солигдож байна. Орчин үеийн нийгэмд бие хүний амьдралын ихэнх хугацаа нь гэр бүлийн дотор бус үйлдвэр, худалдааны байгууллагууд, албан газарт өнгөрдөг. Хүн амын их төвлөрөл нь эмнэлэг, тээвэр, боловсролын асуудлыг үүсгэн гаргаж ирдэг байна.

Орчин үеийн нийгэмд үйлдвэрчний эвлэл, корпорациуд, хөдөө аж ахуйн нэгдэл, улс төрийн намууд, их сургууль, сүм хийдүүд зэрэг хоёрдогч байгууллагууд уламжлалт нийгмийн гэр бүлүүдтэй адилгүй, энд нүүр нүүрээ харалцсан харилцаа биш тодорхой үйл ажиллагааг явуулах сонирхол бүхий нийгмийн гишүүд харилцан сайн дураараа нэгддэг байна. Гэр бүлийн хуучин үүргүүд халагдаж шинэ байгууллагуудад шилждэг. Жишээ нь, сургууль боловсрол олгож, төр засаг нь тусалж дэмжих үүрэг хүлээж, сүм хийдүүд шашны номлол түгээж, зах зээл дээр худалдаа наймаа эрхэлж, банк солилцооны үйлийг эрхлэх мэтээр уламжлалт нийгэмд гэр бүл дагнан эрхэлж байсан үүргүүд орчин үеийн нийгэмд тун их хөнгөвчлөгддөг. Төр хоёрдогч байгууллагын шинж төрхийг олж, үйл ажиллагаа нь нилээд нарийсч, хувь хүний бүрэн эрхийг халж нилээд рациональ шинжтэй болдог.

Аж үйлдвэржсэн нийгэмд төр нь зах зээлийн эдийн засгийг хөгжүүлэхэд бүх талаар анхаардаг байна. Төрийн алба нь нэг гэр бүл, омог аймгийн зорилгод бус нийгмийн бүх давхаргад үйлчилдэг. Улс төрийн зөрчил нь зах зээлээс үүддэг мэт боловч, төр зөрчлийг шийдвэрлүүлэхээр тодорхой мэргэжсэн бүлгүүд төрд шахалт дарамт үзүүлж төр нь зохицуулагчийн үүрэг гүйцэтгэнэ. Бие хүн өөрсдийн сонирхлоо өөрсдийн харъяалагддаг хоёрдогч байгууллагуудаар дамжуулан илэрхийлдэг. Энэ бүх зүйлээрээ орчин үеийн нийгэм уламжлалт нийгмээс ялгагддаг. Төрийн удирдлага нь рациональ зарчмыг удирдлага болгоно гэж М.Вебер тодорхойлжээ.

Улс төрийн модернизацийн онолын үүднээс улс төрийн тогтолцоо нь нийгмийн байгууллын хэлбэрээс бус харин ноёрхож буй хуучны уламжлалт үнэт зүйлээс орчин үеийн зүй зохистой бүтэц зохион байгуулалтад шилжих арга замаас хамаардаг байна. Ер нь улс төрийн тогтолцооны хөгжлийн талаарх олон тооны үзэл баримтлалын үндэс суурь болж буй улс төрийн модернизацийн онол нь зохистой засаглал тогтоох, ялгавартай улс төрийн системийг зохион байгуулах, олон нийтийн оролцоог өргөжүүлэхэд чиглэгдсэн улс төрийн өөрчлөлт шинэчлэлтийн эх үүсвэр, түүний мөн чанар, чиг хандлагыг тайлбарладаг.

Г.Алмонд хөгжил гэдэг нь зөвхөн шинжлэх ухаан судлах ёстой үзэгдэл биш бөгөөд хөгжиж буй үндэстнүүдийг мораль, ёс зүй, улс төрийн үнэт зүйлсийн талаас нь авч үзэх ёстой гэсэн байр суурьтай байв. В.Ростоу “Эдийн засгийн өсөлтийн үе шатууд” номондоо бүх орнууд хөгжил тийш замнахдаа уг чанартаа өөрчлөлтийн ижил үйл явцыг туулдаг. АНУ-ын тусламжтайгаар Өрнөд Европ, АНУ-ын дамжсан модернизацийн үйл явцыг хөгжиж буй орнууд давтах болно. Коммунизм, фашизм хоёр хөгжлийн тодорхой шатны бүтээгдэхүүн учраас АНУ-ын тусламжийн үр ачаар тэдгээрээс зайлсхийж болно гэж үзэж байв. Ростоу техникийн дэвшлийн үндсэн дээр нийгэм эдийн засгийн хөгжил үргэлжилдэгийг

тогтоогоод эдийн засгийн өсөлтийн нийтлэг таван шатны онолоо томъёолсон байна. Үүнд¹⁰:

1. Энгийн технологитой уламжлалт нийгэм. Энд газар тариалан давамгайлдаг бөгөөд гэр бүл болон бүлгийн холбоо их үүрэг гүйцэтгэдэг.
2. Өсөлтийн урьдчилсан систем бүрэлдэх шилжилтийн нийгэм. Шинэ элит, үндэсний үзэл үүсэж, энэ нь өөрчлөлтийн хөдөлгөх хүч нь болно.
3. Үсрэлтийн нийгэм. Хөрөнгө оруулалт нэмэгдэж, үндэсний орлогын хувь өсөхөд алдсан ашгаа үйлдвэрлэлийн шинэ салбаруудыг хөгжүүлэхэд ашигладаг. Хотжилт түргэснэ. Энэ шат нь аж үйлдвэржилттэй зэрэг эхэлнэ.
4. Боловсролын шат. Эдийн засаг олон салбарт аж ахуйн бүтэцтэй болж, машин, хими, цахилгаан техникийн үйлдвэрлэл өргөжин тэлнэ.
5. Өргөн хэрэглээний нийгэм. Эдийн засгийн бүтэц нь үйлчилгээний хүрээ ба удаан хугацаанд хэрэглэгдэх техникийн нарийн барааг үйлдвэрлэхэд ашигтайгаар өөрчлөгддөг. Олонх хүмүүсийн хэрэглээ нь зөвхөн идэж уух, өмсөхөд бус таатай байр сууц, хөргөгч, телевиз, машинтай болоход чиглэдэг. Ажиллах хүчний бүтэц өөрчлөгдөж албан байгууллага, үйлдвэрт мэргэжлийн ажилчдын тоо өсдөг.

Ростоу үзэхдээ сүүлийн тав дахь шатыг зөвхөн АНУ ба зарим талаар Канад гүйцсэн, Өрнөдийн бусад орнууд түүний босгон дээр байгаа. Харин бусад орны хувьд тав дахь шат их бага хэмжээгээр хол байгаа боловч тэдний хувьд гарцаагүй ирээдүй юм гэжээ.

Ази, Африк, Латин Америкийн орнууд өндөр хөгжсөн барууныхны туршлага, технологи, хөрөнгө оруулалтыг ашиглан хөгжлөө хурдасгах боломжтой гэж модернизацийн онолчид үзэж байв¹¹.

Модернизаци нь нийгмийн бүх хүрээг хамардаг.

- Нийгмийн хүрээний модернизаци. Хотжилт, аж үйлдвэржилтийн үр дүнд явагдах бөгөөд нийгмийн бүтцэд үндсэн өөрчлөлт орж, нийгэмд гэр бүлийн гүйцэтгэх үүрэг өөрчлөгдөн, хүмүүсийн хамтын амьдралын шинэ хэв маягууд бий болж нийгэмшилтийн процесс түргэсдэг.
- Эдийн засгийн модернизаци. Шинэ техник, технологийг ашигласны үр дүнд хөдөлмөрийн бүтээмж нэмэгдэн, нийгмийн хөдөлмөрийн хуваарь улам гүнзгийрч, бүтээгдэхүүний зах зээл өргөжин, хүнд аж үйлдвэрийн салбарын өсөлт түргэсэж, эдгээрийн нөлөөгөөр хөдөө аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэл улам боловсронгуй болдог. Дэд бүтцийн салбарын хөгжилтийг хангах, дотоодын нийт бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, эдийн засгийн хувьд хараат байдлаас гарах зэрэг нь эдийн засгийн модернизацийн эн тэргүүний зорилт болдог.
- Улс төрийн модернизаци. Гүйцэтгэх төв засаглалыг хөгжүүлэх, улс төрийн тогтвортой байдлыг хангах, хүн амыг улс төрийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцуулах, улс төрийн ардчиллыг тогтоох зорилгыг өмнөө тавьдаг.

¹⁰ W.W.Rostow. *The Stages of Economic Growth*. London: Cambridge University Press. 1960

¹¹ J.C.Johari. *Political Modernisation*. Comparative Politics. India, New Delhi.,2008. p.194

- Соёлын хүрээн дэх оюуны модернизаци. Соёлын болоод оюуны үнэт зүйлсийг тодорхойлох, боловсролыг дэмжих, бичиг мэдэх явдлыг дэлгэрүүлэх, мэдээллийн хэрэгслийг чөлөөтэй болгох, шинжлэх ухаанч үзлийг түгээн тараахад чиглэнэ.

Сүүлийн гучаад жилд Зүүн Азийн ихэнх орнууд эрчимтэй үйлдвэржиж, Япон, Хонгконг, Өмнөд Солонгос, Тайван зэрэг орнууд түүхийн асар богино хугацаанд аж үйлдвэржилтийн үе шатанд шилжин орж байгаа тул энэ утгаараа Зүүн Ази нь модернизацийн онолыг шалган харьцуулах нэн таатай хөрс болж байна¹².

Модернизацийн онолчид янз бүрийн оронд модернизаци өөр өөр хурдтай, өөр өөр аргуудаар явагддагийг хүлээн зөвшөөрч байв¹³. Зарим орны модернизаци нь нийгмийн дотоод хөгжилтэйгээ нягт уялдаатай байхад, зарим орнуудад модернизаци нь өндөр хөгжилтэй орны туслалцаатай хэрэгждэг. Модернизацийн онолчид модернизацийн таарамжтай болон таарамжгүй нөхцлүүдийг ялгаж авч үзэж байв. Таарамжгүй нөхцөлд:

- уламжлалт нийгмийн элементүүд хадгалаастай засаглал
- засгийн эрх ямба, эд хөрөнгөө алдах хүсэлгүй дээд зиндааныхан
- бичиг үсэг үл мэдэх байдал, боловсролын доод түвшин
- эдийн засгийн орчин үеийн секторуудын дорой байдал
- хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн уналт зэрэг багтдаг.

Таарамжгүй нөхцлийг таарамжтай нөхцөлд шилжүүлэх зөв бодлого баримталбал модернизаци амжилттай хэрэгжинэ гэж үздэг. Модернизацийн онолчид модернизацид нөлөөлж буй нийгэм соёлын хүчин зүйлсийг тодруулж үзэхийг оролдож байв. Жишээ нь, аж үйлдвэрлэл тухайн хөгжиж буй орнуудад шинэ зүйл бөгөөд хүмүүс уламжлалт аж ахуй, амьдралын хэв маяг зэрэг өмнөх уламжлалаасаа салж чаддаггүй байна. Модернизацийн явцад өрнийн нийгмийн үнэт зүйлс дорнын ард түмэнд таарч тохирохгүйгээс зөрчил үүсдэг. Ийм ч учраас модернизацийн онолчид нийгмийг тогтвортой болгох, зөрчлийг шийдвэрлэх арга хэрэгслийг хайсаар байна. Хөгжиж буй орнуудад модернизацийн явцад зэвсэгт хүчин нийгмийн тогтвортой байдлыг хянаж, нийгмийн өөрчлөн байгуулалтыг хангаж чадах эсэхийг тодруулан судалж байв.

Хараат байдлын онол

1950-1960-аад онуудад зарим эрдэмтэд модернизацийн ерөнхий онолыг боловсруулахдаа Ази, Африк, Латин Америкийн орнуудын модернизацийн туршлагыг судалж байсныг дээр өгүүлсэн. Мөн Японд амжилттай явагдсан модернизацийн үндсэн дээр модернизацийн явцад нийгмийн уламжлалуудыг шинэчлэлтэй зөв хослуулж болохыг тодорхойлсон. Ийнхүү 1950-60-аад оны модернизацийн онолчид модернизаци дэлхий нийтийн түгээмэл хандлагатай гэж тодорхойлж байсан ч тэд хөгжиж буй орнуудын улс төрийн лидерүүд болон зарим онолчид, ялангуяа улс төрийн зүүн чиглэлийг баримталсан онолчдын

¹² Юн-хан Чу нар. “Зүүн Азийн орнууд дахь дэглэмийн хэрэгжилт, үнэлэмжийн өөрчлөлт ба авторитаризмаас хүнийсэх үйл явц”. УТБА. Зүүн Азийн Барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ.,2005. 78 дахь тал

¹³ Samuel P.Huntington. Political Modernization: America vs. Europe. World Politics, Vol.18, No.3, The John Hopkins University Press. p.378-414. <http://www.jstor.org/stable/2009762>

зүгээс хүчтэй эсэргүүцэлтэй тулгарч эхэлжээ. Хөгжиж буй орны улс төрийн лидерүүд амьдрал дээр модернизацийн онолыг хэрэгжүүлэхдээ өөрийн улсуудад илүү хурдан хөгжил хэрэгтэйг үгүйсгээгүй бөгөөд өөр өөрийн улс үндэсний онцлогоо харгалзахыг чухалд үзэж байв.

Ийнхүү модернизацийн онолын эсрэг тэмцэл хүчтэй болохын хамт 1960-аад оноос “Хөгжлийн хараат байдлын онол¹⁴” боловсруулагджээ. Хараат байдлын онолчдын шүүмжилж байсан гол зүйл бол “модернизацийн онолын дэлхий нийтийн түгээмэл хандлага” гэсэн ойлголт юм. Тэд модернизацийн онол хөгжиж байгаа ертөнцийн эдийн засаг болон нийгмийн байдал барууны орнуудын харьцаж буй харьцаатай нийцэхгүй байгааг, модернизацийн онолууд хөгжиж байгаа нийгмүүдийн амьдрал ба түүх, соёл, улс төр, нийгмийн асуудлыг үгүйсгэдэг, хөгжиж буй орнууд шинэчлэлийг явуулах адилхан загвартай гэдгийг үгүйсгэж тодорхой баримтуудаар нотолж байжээ.

Хараат байдлын онолчдын баталснаар хоцрогдол нь дэлхийн түүхэн капитализмын үр дүн юм. Эдийн засгийн хөгжил ба буурай байдал хоёр бол нэг юмны хоёр тал юм. Хөгжсөн улс гүрэн нь хөгжиж буй буурай орнуудын байгалийн баялаг, ажиллах хүчийг ашиглан шавхах маягаар их амжилтанд хүрдэг. Эцсийн дүнд баян орон хэзээд баянаараа үлдэж, ядуу улс ядуугаараа л хоцордог. Модернизаци явуулж буй улс орон эдийн засгийн тусгаар байдлаа алдаж, хөгжилтэй орнуудын томоохон пүүс компаниудын эзэмшил болох бөгөөд ард түмний худалдан авах чадвар улам буурч, хөдөө аж ахуйн түүхий эд, байгалийн баялгийг экспортлогч хэсэг давхаргынхан л баяждаг гэж хараат байдлын онолчид үздэг.

Өрнөдийн шалгуураар гуравдагч ертөнц үргэлж сул дорой байсан ч харин өөрийн уугуул институтүүдээ түшин хөгжиж буй олон үндэстэн ажил хэргээ муугүй хөтлөн явуулж байжээ.

Энэ бүхнээс үүдэн хөгжиж буй орнууд дахь барууны хөгжлийн загвар, модернизацийн онолыг эргэж хянаж үзэх санал шүүмжлэл гарах болжээ. Жишээ нь, 1968 онд С.Хантингтон хөгжлийн онолд шүүмжлэлтэй хандаж, нийгмийн дайчилгаа, модернизаци нь институциональ хөгжил, ардчилалтай нягт холбогдохоос илүү тэдгээрийг шинээр гарч ирсэн үндэстнүүдэд хэрэг дээрээ тасалдуулж байна. Модернизаци үр өгөөжтэй төслүүдийг хэрэгжүүлэх институциональ чадавх бүрдээгүй байхад ард түмнийг улс төрийн системээс ихийг хүсэн хүлээхэд хүргэдэг учраас үндэстнийг уналт, сүйрэлд аваачдаг гэж нотолсон байна.

1960-аад оны сүүлч, 1970-аад оны эхээр хөгжлийн ноёрхогч суурь баримтлалыг шүүмжлэх явдал газар авсан байна. Хөгжлийн онолыг шүүн хэлэлцэх явцад түүний нааштай гол ололтууд болох системийн хандлага, нийгмийн өөрчлөлт, улс төрийн хувирал өөрчлөлтийг илүүтэй анхаарах болсон, улс төрийн үйл явц болон албан бус хүчнүүд, хөгжиж буй үндэстнүүд,

¹⁴ J.Samuel Valenzuela. “Modernization and Dependency”. Tony Smith. “The Underdevelopment of Dependency Theory”. Roi C.Macridis. Comparative Politics. 1986. p.481-512

тэдгээрийн харьцуулсан судалгаа зэргийг үл тоомсорлох байдалтай болсонд судлаачид шүүмжлэлтэй хандаж байв¹⁵.

Транзитологи

Нийгмийн дэвшлийн динамик шинж чанар нь нийгэм эдийн засгийн нэг тогтолцооноос нөгөөд хувьслын ба хувьсгалын замаар шилжих хөдөлгөөнөөр илүү тодорхой илэрдэг. Үүнийг нийгмийн шилжилт, шилжилтийн үе хэмээх ойлголтоор илэрхийлдэг нь түгээмэл зүйл. Өнөөдөр энэ үйл явцыг судалдаг транзитологи (шилжилт судлал) хэмээх мэдлэгийн тусгай салбар нэгэнт бий болсон байна. Транзитологи бол тоталитар болон авторитар дэглэмээс ардчилалд шилжиж буй улс орнууд дахь улс төрийн үйл явцыг судалдаг улс төрийн шинжлэх ухааны салбар юм. Транзитологи нь улс төрийн модернизацийн онолын зарим сул талыг залруулан засах зорилгоор 1970-аад оны эхээр үүссэн боловч онол, арга зүйн ерөнхий зарчмын хувьд түүнтэй ойролцоо юм¹⁶.

Гэвч улс төрийн модернизацийн онол “гурав дахь ертөнцийн” хөгжиж буй орнуудын нийгмийн шинэчлэлтийн асуудлыг голлон авч үздэг бол транзитологи нь орчин үеийн нийгмийн үндсэн бүтэц бүхий бөгөөд ардчилалд дахин шилжиж буй улс орнууд дахь улс төрийн үйл явцыг шинжлэн судалдаг. Ардчилсан дэглэм урьд нь оршин тогтож байсан улс орныг ардчилах тухай асуудал дэлхийн хоёрдугаар дайны дараа Герман, Итали дахь тоталитар фашист дэглэм, Японы авторитаризм, милитаризмын үр дагаврыг арилгах, нийгмийг дахин шинэчлэх шаардлагатай холбогдон анх тавигдсан байна. Ийм асуудал мөн авторитар засаглалын үеийн дараа ардчилсан зарчимд буцаж шилжсэн Өмнөд Европын Испани, Португал, Грек улсуудад давтагдсан юм. Цэргийн диктатур ардчилсан сонгуулиар гарч ирсэн засгийн газруудад байраа тавьж өгсөн Латин Америкийн орнуудад ч энэ шилжилт хэрэгжсэн. Энэ нь Ази, Африкийн орнуудад уламжлалт тогтолцоог халж ардчилал цоо шинээр үүсэн тогтож нийгмээ барууны хэв загвараар шинэчлэх үйл явцаас зарчмын хувьд өөр асуудал бөгөөд энэ нь ардчилсан тогтолцоонд эргэж шилжих, нийгмийг дахин ардчилах тухай асуудал юм. Юрген Хабермас үүнийг “хоцорсныгоо нөхөх” хувьсгал гэж нэрлэсэн байдаг.

1970-аад оны дунд үеэс дэлхийн бараг бүх тив, бүс нутгийг хамарч байсан ардчилсан бус дэглэм нуран унах үйл явц эрч хүчээ авч глобаль шинжтэй болсон. Ардчиллах үйл явцын хүрээнд 1980-90-ээд оны зааг үед ЗХУ болон социалист системийн орнуудад коммунист дэглэм задран унасан. Энэ үеэс посткоммунист хөгжлийн үйл явц нь транзитологийн судалгааны гол объект болсоор байна. Эхэн үедээ социалист байсан орнуудад ардчилсан дэглэм бүрэлдэх, зах зээлийн харилцаанд шилжих тухай асуудлыг улс төрийн модернизацийн онолын үзэл баримтлалын уламжлалт хандлагуудад тулгуурлан судалж байв. Эдгээр нь хамгийн ерөнхий байдлаараа улс төрийн ардчилал, зах зээлийн эдийн засаг хоёр органик, салшгүй холбоотой, ардчилалд шилжихийн тулд техник технологийн, нийгэм соёлын, нийгэм эдийн засгийн хөгжлийн тодорхой түвшин зайлшгүй чухал; ардчиллын нийгмийн бааз

¹⁵ Ё.Довчин. Харьцуулсан улс төр. УБ.,2006. 17-19 дэх тал

¹⁶ Ш.Содном. “Посткоммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2002. 24 дэх тал

суурь нь нийгэмд зонхилох байдалтай дунд анги мөн; иргэний нийгэм бүрэлдэн төлөвшихгүйгээр ардчилал үүсэн тогтнох бололцоогүй гэж үздэг онолын баримтлалууд байв.

Өнөөдөр посткоммунист шилжилтийн үйл явцыг судалж буй барууны улс төр судлаачдын дунд үзэл баримтлалын зарим ялгаа ажиглагдаж байна¹⁷. Тухайлбал, А.Лейпхарт, Ф.Шмиттер нарын эрдэмтэд Дорнод Европын орнууд болон посткоммунист орон зайд өнөөдөр явагдаж байгаа үйл явц хичнээн онцлогтой байлаа ч тэр нь ардчиллын гурав дахь давалгаанд татагдан орсон бусад бүс нутгууд дахь үйл явц, үзэгдлүүдтэй адил юм¹⁸ гэж үзэж байна. Харин Америкийн судлаач В.Барнс, С.Терри нар Дорнод Европ дахь үйл явц Латин Америкийнхаас ч ялгаатай, тэнд ардчиллыг сэргээн тогтоох тухай асуудал яригдахгүй. Посткоммунист орнуудад эрх зүйт төр болон ардчиллын бусад институтүүдийг сэргээн тогтоож байгаа биш харин цоо шинээр бий болгож байна. Эдийн засгийн хүрээнд ч мөн адил эдийн засгийн өмнөх тогтолцоог засч сайжруулах биш харин зах зээлийн эдийн засгийн шинэ тогтолцоог бүрдүүлж байна гэжээ.

Америкийн судлаач Л.Шин посткоммунист нийгмийн шилжилтийн 4 үе шатыг нэрлэсэн байна. Үүнд¹⁹:

1. тоталитар тогтолцоог эвдэн нураах
2. ардчилсан тогтолцоонд шилжих
3. ардчилсан тогтолцоог бататган бэхжүүлэх
4. ардчилсан институтүүд төгс боловсронгуй болох үе шатууд байна гэжээ.

Транзитологи ардчилалд шилжих шилжилтийг нэг чиглэлт, шугаман бус харин эргэлт буцалт ч тохиолдож болох бэрхшээлтэй нарийн төвөгтэй үйл явц гэдгийг хүлээн зөвшөөрдөг. Энэ шилжилтийн үед олон нийтийн үнэлэмжийн өөдрөг шийдэмгий байдал, бас гутрангуй, үл итгэх үзлийн аль нь ч давамгайлах хандлагатай байж болно гэж үздэг. Барууны транзитологичдын үзэж байгаагаар посткоммунист нэлээд оронд ардчилсан ирээдүйнхээ талаар пессимист үнэлэмж давамгайлж байна. Үүнээс болж тэдгээр оронд ардчилсан хөгжлийнхөө чиг баримжаанаас татгалзаж, коммунист дэглэм эргэн тогтох аюул учирч болохоос гадна авторитаризмын элементүүдийг өөртөө агуулсан үндэсний диктатур нэлээд урт хугацаагаар оршин тогтнох боломжтой гэж үздэг.

Өнөөдөр хуучин социалист орнууд нийгэм, улс төрийн нэг хэв загварын байхаа больж тэдгээр орны посткоммунист хөгжлийн үйл явцад ялгарал гүнзгийрч байгааг транзитологичид тэмдэглэж байна. Эцэст нь хэлэхэд, посткоммунист хөгжлийн үзэл баримтлал бүрэн боловсрогдож чадаагүй байна. Энэ нь нэг талаас ардчилсан шилжилтийн тухай транзитологийн онол, арга зүй боловсронгуй болоогүй, нөгөө талаас хуучин социалист орнууд дахь улс төр,

¹⁷ Ш.Содном. “Посткоммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2002. 24 дэх тал

¹⁸ Arend Lijhart. Democracies. Patterns of Majoritarian and Consensus Government in Twenty-One Countries. New Heawen-London.,1984. p.1-20

¹⁹ Ё.Довчин. Харьцуулсан улс төр. УБ.,2006. 110 дахь тал

эдийн засгийн шинэчлэлтийн үйл явцын онцлог, нарийн төвөгтэй байдалтай холбоотой²⁰ байна.

ДҮГНЭЛТ

1950-иад оны үед колонийн дарлалаас чөлөөлөгдөж байсан орнуудын талаар баримтлах улс төрийн бодлогын онолын суурь үндэс хэлбэрээр анх үүсэж хөгжсөн улс төрийн модернизацийн онолын үүднээс улс төрийн тогтолцоо нь нийгмийн байгууллын хэлбэрээс бус харин ноёрхож буй хуучны уламжлалт үнэт зүйлээс орчин үеийн зүй зохистой бүтэц зохион байгуулалтад шилжих арга замаас хамаардаг байна. Ер нь улс төрийн тогтолцооны хөгжлийн талаарх олон тооны үзэл баримтлалын үндэс суурь болж буй улс төрийн модернизацийн онол нь зохистой засаглал тогтоох, ялгавартай улс төрийн системийг зохион байгуулах, олон нийтийн оролцоог өргөжүүлэхэд чиглэгдсэн улс төрийн өөрчлөлт шинэчлэлтийн эх үүсвэр, түүний мөн чанар, чиг хандлагыг тайлбарладаг.

Аливаа улс төрийн өөрчлөлт нь зөвхөн хөгжиж буй орнуудад тохиолддоггүй, аж үйлдвэр өндөр хөгжсөн оронд хүртэл явагдаж тухайн орны улс төрийн системийг улам боловсронгуй болгосоор байдгийг судлаачид тэмдэглэсэн байна.

Модернизацийн онолчид янз бүрийн оронд модернизаци өөр өөр хурдтай, өөр өөр аргуудаар явагддагийг хүлээн зөвшөөрч байв. Зарим орны модернизаци нь нийгмийн дотоод хөгжилтэйгээ нягт уялдаатай байхад, зарим орнуудад модернизаци нь өндөр хөгжилтэй орны туслалцаатай хэрэгждэг. Хөгжлийн хандлага нь АНУ зэрэг хөгжингүй орнуудын туршлагыг хөгжиж буй орнуудад шууд буулган хэрэгжүүлсэн гэж модернизацийн онолын эсрэг байр суурь гарч ирсэн. Ийнхүү 1960-аад оноос “Хөгжлийн хараат байдлын онол” боловсруулагджээ. Хараат байдлын онолчдын шүүмжилж байсан гол зүйл бол модернизацийн онол хөгжиж байгаа ертөнцийн эдийн засаг болон нийгмийн байдал барууны орнуудын харьцаж буй харьцаатай нийцэхгүй байгааг, модернизацийн онолууд хөгжиж байгаа нийгмүүдийн амьдрал ба түүх, соёл, улс төр, нийгмийн асуудлыг үгүйсгэдэг, хөгжиж буй орнууд шинэчлэлийг явуулах адилхан загвартай гэж үзэж байв.

1980-аад оны дунд үеэс шилжилтийн дэглэмүүдийн судалгаа ардчиллын гурав дахь давалгаатай уялдан ардчиллах үйл явцыг судлахад голлон анхаарах болсон. Судалгааны энэ чиглэлийг транзитологи гэж нэрлэдэг бөгөөд гол үзэл санаа нь тоталитар болон авторитар дэглэмээс ардчилалд шилжиж буй улс орнууд дахь улс төрийн үйл явцыг судалдаг улс төрийн шинжлэх ухааны салбар гэж судлаачид үзэж байна.

²⁰ Ш.Содном. “Посткоммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2002. 28-29 дэх тал

НОМ ЗҮЙ

1. Довчин.Ё. Харьцуулсан улс төр. УБ.,2006
2. МУИС. Улс төрийн шинжлэх ухаан. УБ.,2010
3. Содном.Ш. “Посткоммунист шилжилт: үзэл баримтлал ба үйл явц”. МУИС. Политологи сэтгүүл. УБ.,2002
4. Юн-хан Чу нар. “Зүүн Азийн орнууд дахь дэглэмийн хэрэгжилт, үнэлэмжийн өөрчлөлт ба авторитаризмаас хүнийсэх үйл явц”. УТБА. Зүүн Азийн Барометр. Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа. УБ.,2005
5. Arend Lijhart. Democracies. Patterns of Majoritarian and Consensus Government in Twenty-One Countries. New Heawen-London.,1984
6. Daniele Caramani. Comparative politics. Oxford University Press.,2008
7. Huntington. Samuel. Political Modernization: America vs. Europe. World Politics, Vol.18, No.3, The John Hopkins University Press.,1966
8. Inglehart. Ronald. Modernization and Postmodernization: Cultural, Economic and Political Change in 43 Societies. Princeton University Press.,1997
9. Johari.J.C. Comparative Politics. India, New Delhi.,2008
10. Macridis. Roy. Comparative Politics. 1986
11. Pye Lucian. “*Political Science and the Crisis of Authoritarianism*”. Inkeles, Alex and David Smith. Becoming Modern. American Political Science Review 84/1. Cambridge University Press.,1974
12. Pye Lucian. Aspects of Political Development. Boston: Little Brown.,1966
13. Rostow.W.W. Politics and the Stages of Growth. Cambridge University Press.
14. Sartori, Giovanni (1987): *The Theory of Democracy Revisited*. Chatham, N.J.: Chatham House. 2 vols. All the issues, past and present, surveyed and ordered.

ИХ, ДЭЭД СУРГУУЛИЙН УЛС ТӨР СУДЛАЛ ХИЧЭЭЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Д.Одмаа

ШУТИС-НТС ОНХА, УТС-ын профессорын багийн багш

Түлхүүр үг: Багш, суралцагч, судалгаа, агуулга, хичээлийн хөтөлбөр, шинэчлэл

Боловсролын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого, стратегийн зорилт нь шинжлэх ухааны боловсролыг бүх чиглэлээр хөгжүүлэх, хүний хэрэгцээг хангах, мэдлэгийн түвшинг дээшлүүлэх, чадвартай мэргэжилтэнг бэлтгэх хүний хүчин зүйл, оюун санааны үнэ цэнийг өндөрт гаргахад оршино гэжээ. Энэ зорилтыг хэрэгжүүлэхэд манай улсын их, дээд сургуулиудад бэлтгэгдэж буй мэргэжилтний мэдлэг боловсрол, хүмүүжил төлөвшил чухал үүрэг гүйцэтгэх бөгөөд энд нийгмийн шинжлэх ухааны хичээлүүд онцгой хувь нэмрийг оруулдаг. Ялангуяа “Улс төр судлал”-ын хичээл нь иргэдэд улс төрийн мэдлэг боловсрол олгохын зэрэгцээ улс төрийн ухамсар, улс төрийн соёлтой өнөөгийн улс төрийн амьдралд оролцох чадвартай иргэн төлөвшүүлдгээрээ чухал ач холбогдолтой юм.

Улс төрийн хичээлийн түүхийг авч үзвэл бүр 1925 онд тэр үеийн Намын төв сургуульд зааж байсан бөгөөд 1938 оны үеэс улс төрийн хичээлийн агуулгад багтаж байсан бүлэг сэдвүүдийг бие даасан хичээл болгон өөрчилж, улс төрийн гэх нэршлийг хэрэглэхээ больжээ.[1] Энэ нь тэр үеийн намын бодлого, намын үзэл сурталтай холбоотой байсан болов уу. Тухайн цаг үеэс хойш Улсын байгуулалт, МАХН-ын түүх, Марксизм Ленинизмын онол, Шинжлэх ухаан коммунизмын онол зэрэг хичээлийн нэрийн доор улс төрийн ойлголтыг тодорхой хэмжээгээр заадаг байжээ.

Харин нийгмийн социалист систем нуран унаж, 1991 оны сүүлчээр ЗХУ задарсантай холбоотойгоор түүнийг судалж, зөвтгөн тайлбарлаж байсан социализм-коммунизмын онолын нэр хүнд, нөлөө буурч, учир утгаа алдаж эхлэсэн. Үүний нэг тод илрэл нь манай их, дээд сургуулиудын оюутнууд 1990-1991 оны хичээлийн жилээс шинжлэх ухааны коммунизмын онол, МАХН-ын түүхийн хичээлийг заахыг эсэргүүцэж, сургалтын төлөвлөгөөнөөс хасах тухай санал гаргаж байсан явдал юм.[2] Эдгээр нөхцөл байдлыг харгалзан үзэж, 1991-1992 оны хичээлийн жилд ШУКО-ын оронд улс төр судлалын хичээлийг заах нь зүйтэй гэж тухайн үеийн Ардын боловсролын яамны сайдын шийдвэр гарсан байна. Энэ шийдвэр гарсантай холбоотойгоор 1991 онд Улс төр судлалын хичээлийг их, дээд сургуульд заах талаар Нийгмийн ухааны зөвлөлөөс эрхлэн “Улс төр судлалын программ”-ыг товхимолын хэлбэрээр нийтлэн гаргасан байдаг.

Тэгвэл өнөөдөр их, дээд сургууль бүр өөрсдийн боловсруулсан хөтөлбөрийн дагуу энэхүү хичээлийг зааж байгаа бөгөөд кредит цагийн хувьд ч харилцан адилгүй байна. Мөн зарим сургууль заавал үзэх хичээлийн тоонд оруулдаг бол зарим нэг нь сонгон суралцах хичээл хэлбэрээр сургалтын төлөвлөгөөндөө тусгасан байдаг. Тиймээс цаашид ерөнхий улс төр судлалын хичээлийн кредит цаг,

хичээлийн хөтөлбөр, агуулга, суралцах хэлбэр зэргийг нэг мөр цэгцэлж, улам боловсронгуй болгох зайлшгүй шаардлага зүй ёсоор гарч ирж байна.

Ерөнхий улс төр судлалын сургалтын агуулгын тухайд дэлхий нийтэд одоогоор ОХУ болон посткоммунист орнуудын шинэчилсэн загвар, Сөүл-Токиогийн их сургуулийн Азийн загвар, Оксфордын буюу Европын загвар, Америкийн загвар гэсэн 4 загварыг үндсэнд нь баримталж байна.[3]

Манай улсын их, дээд сургуулиудад зааж байгаа ерөнхий улс төр судлалын хичээл нь эхний загварт хамрагдах бөгөөд дээрх чиглэл тус бүрээр одоохондоо монгол хэл дээр сурах бичиг ховор байгаа ба ОХУ болон посткоммунист орнуудын шинэчилсэн загвараар бичсэн сурах бичгүүд л сургалтанд түлхүү хэрэглэгдэж байна. Тиймээс бусад загварын хичээлийн хөтөлбөр агуулга зэргийг гүнзгийрүүлэн судлах, онолын мэдлэг хэт олгохоос зайлсхийж прагматик тал руу нь чиглүүлэх, чадамжид суурилсан хөтөлбөр боловсруулж сургалтанд нэвтрүүлэх хэрэгтэй байна. Энэ нь оюутныг сэтгэлгээний ерөнхий арга барилд сургах, мэдээллийг хүлээн авч бие даан боловсруулах чадвар эзэмшүүлэх улмаар мэдлэгээ хэрэглээ болгож чадах арга барилд сургах ач холбогдолтой юм.

Бусад улс орнуудад Улс төр судлал хичээлийг хэрхэн зааж буй тухайд жишээлбэл, Шиллер олон улсын их сургуулийн бүх хөтөлбөрт улс төр, философи, логик зэрэг нийгмийн шинжлэх ухааны хичээлүүд нь 3 кредит цагаар тусгагдсан ба сонгон суралцах хичээлийн тоонд ордог. Энэ их сургуулийн дүрэмд зааснаар 8 оюутнаас доош тооны оюутан тухайн хичээлийг сонгосон тохиолдолд бүртгэлийг цуцалдаг байна. [4] Мөн Оксфордын их сургуульд 3 кредит цагаар орох ба хичээлийн агуулгад онолын сэдэв гэхээсээ илүү гадны улсуудын улс төрийн байдал /Америк, Орос, хятад, Япон, Франц, Герман, Итали/, өөрийн орны улс төрийн тогтолцоо түүний түүх, ардчиллын онол, практик, гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглалын тухай, улс төрийн социологи, сонгуулийн үйл явц, е-засаглал, иргэдийн улс төрийн оролцооны талаар тусгадаг ажээ. [5]

Судалгааны ажлын хүрээнд төрийн болон төрийн бус 13 их сургууль, 58 дээд сургууль, гадаадын их сургуулийн салбар 5 сургуулиас судалгаа авахад 76 их, дээд сургуулийн 49 буюу 64 хувьд нь ерөнхий улс төрийн хичээл ордог ажээ. Энд нэг зүйлийг онцлоход урд нь уг хичээл орж байгаад орохоо больсон нэлээд олон сургууль байгаа бөгөөд энэ нь хувийн сургуулиудын 20 хувьд нь цагийн багш хичээл заадаг, оюутнуудын хичээл сонголтыг бодлогоор зохицуулдаг, оюутнууд улс төрийн амьдралаас хол хөндий байж, улс төрийг сонирхохгүй байх зэрэгтэй холбоотой гэж үзэж болох юм. Судалгааны дүнгээс үзвэл эдгээр их, дээд сургуулиудаас 25 сургуульд нь тус хичээлийг заавал үздэг бол 17 сургуульд 3 кредит цагаар заадаг байна. Үүнтэй холбоотойгоор нэгдүгээрт, улс төр судлал хичээлийн кредит цагийг нэмэгдүүлж /3 кредит болгох/, олон улсын жишигт ойртуулах зайлшгүй шаардлага бий болоод байна. Учир нь олон улсын магадлан итгэмжлэлийн шалгуур үзүүлэлт, стандартад зааснаар бүх хичээлүүдийн кредит цаг 3 байх ёстой ба одоогоор олон улсын магадлан итгэмжлэлд орохоор хүсэлт гаргасан МУИС-ЭЗС, СЭЗДС, Мандах Бүртгэл Дээд сургуулиуд улс төр судлалын хичээлийн кредит цагийг 3 болгоод байна. Манай улсын хувьд бизнес, эдийн засгийн чиглэлээр сургалт явуулдаг төрийн болон төрийн бус өмчийн 12 их, дээд сургууль олон улсын магадлан итгэмжлэл авахаар АНУ-ын Бизнесийн сургууль, сургалтын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх зөвлөлд хандаад байгаа [7] бөгөөд цаашид эдгээр

сургуулиуд сургалтын төлөвлөгөө, хөтөлбөртөө өөрчлөлт оруулах нь дамжиггүй юм. Хоёрдугаарт, уг хичээл нь суралцагчдад улс төрийн мэдлэг боловсрол олгодог цорын ганц хичээл учраас заавал үзэх хичээл болгох хэрэгцээ шаардлага бий бөгөөд энэ талаар эхний алхмууд хийгдэж байна. Тухайлбал, Азийн Хөгжлийн банкны санхүүжилтээр 2009-2013 оны хооронд хэрэгжүүлж буй “Боловсролын салбарын шинэчлэл” төслийн хүрээнд Монгол Улсад багш бэлтгэх тогтолцоог сайжруулах чиглэлээр олон ажил хийж байгаа. Түүний нэг нь багш бэлтгэдэг сургуулиудад улс төр судлалын хичээлийг заавал үзэх хичээлийн тоонд оруулж буйтай холбоотойгоор эдгээр сургуулиуд сургалтын төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулж эхлээд байна.

Ерөнхий улс төр судлалын хичээлийг зааж буй багш нарын тухайд 25 сургуулийн 48 багшаас асуулгын болон ганцаарчилсан ярилцлагын аргаар судалгаа авсан болно. Багш нарын 65 хувь нь МУИС, 23 хувь нь МУБИС, 8 хувь нь хувийн, 4 хувь нь гадаадын их, дээд сургууль төгссөн бөгөөд боловсролын зэргийн хувьд 2 хувь нь шинжлэх ухааны доктор, 19 хувь нь боловсролын доктор, 75 хувь нь магистр, 4 хувь нь бакалаврын зэрэгтэй байна. Ажлын туршлагын хувьд 1-5 жил 46 хувь нь, 6-10 жил 19 хувь нь, 11-15 жил 17 хувь нь, 16-аас дээш жил 19 хувь нь улс төр судлалын багшаар ажиллажээ. Эндээс үзвэл улс төр судлалын хичээлийг зааж буй багшлах боловсон хүчний хувьд мэргэжил боловсрол, ажлын туршлагын хувьд боломжийн гэж хэлж болохоор байна. Харин багш нарын 54 хувь нь улс төрийн мэргэжлийн бус нийгмийн ухааны бусад мэргэжлийн багш нар байгаа нь тухайн хичээлийг өөрийн мэргэжилтэй холбон заах явдал түлхүү ажиглагдаж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь багш нартай санал бодлоо солилцох, сургуулиудын хичээлийн хөтөлбөрийг судлах явцад ажиглагдаж байсан.

Судалгаанд хамрагдсан нэгэн багшийн нээлттэй асуултанд хариулсан байдлаас иш татвал “Улс төр судлалын хичээлийн агуулгад онолын асуудлууд түлхүү байдаг учраас ач холбогдол нь бага юм уу гэсэн бодол төрдөг. Мөн бусад их, дээд сургуулиудад мэргэжлийн хэд хэдэн багш байдаг учраас хичээлийн хөтөлбөрөө багаараа боловсруулж, хэрэгжүүлдгээрээ давуу талтай. Манай сургуулийн хувьд улс төр судлалын хичээлийн хөтөлбөр сүүлийн 2 жил шинэчлэл хийгдээгүй бөгөөд шинэчилж, баяжуулна гэхэд туршлага дутмаг байдаг” гэжээ. Мөн хичээлийн агуулга, хөтөлбөрийг прагматик тал руу нь хандуулж, хичээлээ заана гэхээр энэ талаарх ном, сурах бичиг байдаггүй, ялангуяа цөөхөн оюутантай сургуульд нийгмийн шинжлэх ухааны бүх хичээлийг 1 багш заадаг, хөтөлбөрөө өөрөө мэдэж боловсруулдаг гэх мэтчилэн багш нарт бэрхшээлтэй асуудлууд тулгардаг байна.

Мөн, санамсаргүй түүврийн аргыг ашиглаж ШУТИС, МУИС, ХУИС, ТТДС, Идэр дээд сургуулийн 200 оюутнаас асуулгын аргаар судалгаа авсан бөгөөд нийт оюутнуудын 69.1 хувь нь 20 хүртэлх насны, 26.2 хувь нь 21-25 насны, 4.7 хувь нь 26-аас дээш насны ангилалд багтаж байсан бол 60.4 хувь нь эрэгтэй, 39.6 хувь нь эмэгтэй оюутан байв.

“Танд улс төрийн мэдлэг боловсрол хэрэгтэй юу?” гэсэн асуултанд оюутнуудын 75.4 хувь нь хэрэгтэй, 23.6 хувь нь зарим талаараа хэрэгтэй, 1 хувь нь хэрэггүй гэж хариулсан бол “Та улс төрийн мэдлэг хаанаас олж авдаг вэ? гол гэсэн 1-3 хариултыг сонгоно уу” гэсэн асуултанд 86.2 хувь нь хэвлэл мэдээллийн хэрэгслээс, 78.5 хувь нь улс төрийн хичээл, сургалтаас, 41.1 хувь

нь сонгууль болохоор гэж хариулсан байна. Эндээс үзвэл улс төр судлалын хичээлийг оюутнуудад заавал судлуулах нь зүйтэй болов уу.

Оюутнуудаас улс төр судлалын хичээлийг судлах болсон шалтгааныг тодруулахад 40 хувь нь заавал үздэг учраас, 32 хувь нь улс төр сонирхолтой учраас, 25,5 хувь нь кредит цагаа нөхөх зорилгоор, 2,9 хувь нь найз нөхдийн зөвлөснөөр, 0,6 хувь нь бусад /ирээдүйд улс төр хэрэг болох учраас, би улс төрч болно... / гэж хариулж байгаа нь тэд улс төр судлалын хичээлийг заавал үзэх, кредит цагаа нөхөх, улс төрийг сонирхох гэсэн 3 шалтгааныг чухалчилж судалдаг гэдэг нь харагдаж байна.

Мөн оюутнуудаас “Та улс төр судлалын хичээлийг судалснаар улс төрийн мэдлэг эзэмшиж чадсан гэж бодож байна уу?” гэсэн асуултанд 12,3 хувь нь сайн эзэмшсэн, 53,5 хувь нь ер нь эзэмшсэн, 28,3 хувь нь дунд зэрэг эзэмшсэн, 1,1 хувь нь бараг эзэмшээгүй, 2,7 хувь нь эзэмшиж чадаагүй, 2,1 хувь нь хариулж мэдэхгүй байна гэжээ. “Хэрэв та улс төрийн мэдлэг хангалттай эзэмшиж чадаагүй гэж үзэж байвал дараах хүчин зүйлсээс аль нь илүү нөлөөлсөн бэ” /гол гэсэн 1-3 хариултыг сонгоно уу/ гэсэн асуултанд: Онолын сэдэв хэт зонхилдог-57 хувь, ном сурах бичиг хангалттай биш-31,5 хувь, хичээлийн кредит цаг бага-24 хувь, би өөрөө хичээл тасалснаас- 14,5 хувь, багшийн заах арга барил сул- 7,5 хувь, миний амьдралд улс төр хэрэггүй учраас- 7 хувь, улс төр судлал сонирхолгүй хичээл-6 хувь, бусад-3 хувь гэж хариулсан байна. Дээр дурдагдсан хүчин зүйлсээс сургууль, багштай холбоотой асуудал нь илүү их хувийг эзэлж байгаа учраас цаашид анхаарвал зохино.

Багш нарын 83,3 хувь нь, оюутнуудын 57 хувь нь өнөөгийн их, дээд сургуулиудад зааж буй улс төр судлалын хичээлийн хувьд онолын сэдэв хэт зонхилсон байдаг гэж үзсэн нь тухайн хичээлийн агуулга, хөтөлбөрт онолын сэдэв давамгайлдаг гэдэг нь харагдаж байна. Тиймээс улс төр судлал хичээлийн хөтөлбөрт дараах сэдвүүдийг тусгаж өгөхийг багш нарын зүгээс санал болгож байгаа юм. Үүнд: орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны асуудлууд, цахим улс төр, экологит улс төр, дэлхийн улс төр, монголын өнөөгийн улс төр, иргэдийн улс төрийн оролцоо, улс төрийн соёл, ухамсар, улс төрийн ёс зүй гэх мэт сэдвүүдийг нэрлэж болно. Харин оюутнуудын зүгээс улс төрийн PR, имиж, сонгууль, ардчилал хүний эрх, сонирхолын бүлэг, улс төрийн жендер, монголын улс төр, улс төрийн соёл, иргэдийн улс төрийн оролцооны асуудлуудыг илүү дэлгэрэнгүй заагаасай гэсэн саналыг дэвшүүлж байв.

Тэгвэл улс төр судлалын хичээлийг судалсны ач холбогдол нь юу вэ? /гол гэсэн 1-3 хариултыг сонгоно уу/ гэсэн асуултанд оюутнуудын 8,3 хувь нь улс төрийн соёлтой болно, 17,2 хувь нь улс төрийн идэвх оролцоо дээшилнэ, 65 хувь нь улс төрийн мэдлэг боловсролтой болно, 11,5 хувь нь улс төрийг сонирхож эхэлнэ, 5,6 хувь нь сонгууль өгч сурна, 4,8 хувь нь улс төрийн талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлж сурна, 4,5 хувь нь улс төрийн талаарх сөрөг төсөөлөл өөрчлөгдөнө гэжээ. Судалгааны дүнгээс үзвэл оюутнуудын 65 хувь нь улс төрийн мэдлэг боловсролтой болно гэж хариулсан нь энэ хичээлээр онолын асуудал түлхүү заагдаж байдгийг мөн нотолж байна.

Дээрх судалгааны дүнд үндэслэн улс төр судлалын хичээлийн агуулга, хөтөлбөрийг сайжруулах дараах саналыг дэвшүүлж байна.

1. Улс төр судлал хичээлийн жишиг хөтөлбөр боловсруулах /Сургуулиуд хөтөлбөрийн тодорхой хувийг өөрийн сургууль, мэргэжлийн онцлог тохируулан өөрчлөх боломжтой байх/

2. Улс төрийн багш нарын хамтын ажиллагааг өргөжүүлэх, харилцан туршлага солилцох нөхцөл бололцоог бүрдүүлэх, багшийг хөгжүүлэх /Хэдийгээр хичээлийн хөтөлбөрт суралцагчдад олгох мэдлэгийн үндсэн хэмжээг тодорхойлдог ч түүнийг суралцагчдад яаж хүргэх, сургалтын ямар аргаар заах, хэр шинэлэг агуулгаар мэдлэг олгохыг багш л шийддэг/
3. Хичээлийн кредит цагийг нэмэгдүүлэх /Агуулгын багтаамж ихэснэ/
4. Хичээлийн агуулгыг амьдралд ойртуулах, мэдлэгийг хэрэглээ болгох /Ном, сурах бичгийг шинэчлэх, Монголын улс төрийн амьдралтай холбох, орчин үеийн улс төрийн асуудлуудыг тусгах, суралцагчдыг улс төрийн үйл явцад ухамсартай оролцох хандлага, соёлыг төлөвшүүлэх/

Дүгнэлт

Өнөөгийн байдлаар манай улсын 76 их, дээд сургуулиудын 64 хувьд нь улс төр судлалын хичээлийг зааж байгаа бөгөөд жилд дунджаар 10000 орчим оюутан энэ хичээлийг судалдаг байна. Судалгааны дүнгээс үзвэл улс төрийн сургалтын агуулгад онол давамгайлсан хандлага зонхилж, прагматик хандлага бага байгаа нь энэхүү хичээлийг сонгох оюутны тоо багасах, кредит нөхөх зорилгоор үздэг хичээл болгох зэрэг нөхцлийг бүрдүүлж байна. Тиймээс юуны өмнө хичээлийн агуулга, хөтөлбөрийг шинэчлэх нь зүйтэй бөгөөд энэ талаар 25 сургуулийн 48 багшаас судалгаа авахад 81 хувь нь “Улс төр судлал хичээлийн нэгдсэн хөтөлбөр байх шаардлагатай” гэж үзжээ. Хөтөлбөр түүний агуулга нь орчин үеийн улс төрийн асуудлуудыг тусгасан, онол-практикийг хослуулсан, суралцагчдын сонирхол татахуйц, оюутны бүтээлч сэтгэлгээг хөгжүүлсэн байвал илүү үр дүнтэй болох юм.

Abstract

The paper mentions about how to held political training in non-majoring classes, its feature and what we should focus on in the future. Today, the credit for the political training is not assorted. For instance every university changes their credit, seminar, lecture hours as they want. And also many universities have more part-time lecturer. The lecturers formulate their lesson plan by themselves. And they have different kind of lesson content and curriculum. Therefore we conducted a survey including 13 universities, 58 institutes, 5 foreign domestic schools. Survey result showed that each school has their own plan and follow them. To determine the issues above, find out the good way and analyze. So it influences not only bad effect for the quality of lesson, but also students can't get proper knowledge about politics.

Ишлэл, зүүлт

- [1] МАХН-ын баримтын төв архив.Ф-14.Д-1.ХН-23
- [2] МУИС. Политологи. Эрдэм шинжилгээний бичиг. УБ.,2007. №281.85 дахь тал
- [3] МУИС. Политологи. Эрдэм шинжилгээний бичиг. УБ.,2007. №281.44 дэх тал
- [4] Schiller International University. General catalog. p 134-135
- [5] http://www.ox.ac.uk/divisions/social_sciences.html
- [6] Судалгаанд ШУТИС, МУИС, ХУИС, ТТДС, Идэр дээд сургуулийн оюутнууд хамрагдсан.

[7] <http://news.gogo.mn/r/100719>

Ашигласан ном, зохиол

1. Юндэндорж.А. Эртний өрнө дорнын мэргэдийн улс төрийн сэтгэлгээний онол, сургаал. I боть. УБ.,2001
2. Колин Робсон. Бодит ертөнцийг судлахуй. УБ.,2006
3. Ичинхорлоо. Ш. Судалгааны ажлын үндэс. УБ.,2009
4. Базарпүрэв.С. Улс төрийн шинжлэх ухаан. УБ.,2005
5. Бэгз.Н. Боловсролын хөгжлийн онол, арга зүйн асуудлууд. УБ.,2005
6. Өлзийхуяг.Б. Боловсрол судлал түүний үндсэн агуулга. УБ.,2010
7. МУИС. Политологи. Эрдэм шинжилгээний бичиг. УБ.,2007. №281
8. Эх сурвалж. МАХН-ын баримтын төв архив.Ф-14.Д-1.

УЛС ТӨРИЙН СУРГААЛЫН ТҮҮХ СУДЛАЛД ХЭЛ ШИНЖЛЭЛИЙН АРГА ЗҮЙГ АШИГЛАХ НЬ

С.Базарпүрэв

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор

Э.Бат-Эрдэнэ

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн магистрант

Түлхүүр үг: Улс төрийн шинжлэх ухаан, Улс төрийн сургаал, улс төрийн сэтгэлгээ, хэл шинжлэл, герменевтик, эх зохиол судлал, судалгааны арга зүй, онол, үзэл баримтлал

Улс төрийн сургаалын түүхийн судалгаанд түгээмэл хэрэглэгдэх аргуудын хүрээнд хэл шинжлэлийн /ленгвистик/ арга, арга зүй ёсоор орно. Учир нь өрнийн улс төрийн сэтгэлгээний уламжлалт гол онцлог нь сэтгэгчдийн сургаал, номлол эх зохиолоор дамжин өвлөгдөж ирсэн явдал юм. Тухайлбал, эртний Грек, Ром, Европын улс төрийн түүх, сэтгэлгээ нь улс төрийн сургаалын түүхийн цөм хэсэг нь хэмээн үзэж болно. Тухайн цаг үед бүтээгдсэн улс төрийн сургаал, номлолын түүхийг агуулсан сэтгэгчдийн эх зохиолыг судлах, дүгнэлт, тайлбар, шүүмж хийх зэрэг нь улс төрийн сургаалын түүхийн судалгаа хөгжин, төлөвших үндсэн нөхцөл хэмээн үзэж байна.

Хэл шинжлэлийн арга зүйн хандлагад багтах аргуудын хүрээнд үндсэн хоёр аргыг гол болгон авч үзсэн болно. Энэхүү хоёр арга нь герменевтикийн арга болон эх зохиол судлах аргууд юм. Герменевтикийн аргыг тодорхойлвол “Нийгмийн танин мэдэхүйн онцлогуудыг харгалзан нийгэм-хүмүүнлэгийн ухааны арга зүйн асуудлуудыг боловсруулах зорилтыг дэвшүүлж буй арга зүйн баримтлал бол герменевтикийн хандлага²¹” юм. Герменевтикийн философийн үндэс, түүнээс улбаалсан герменевтикийн арга, арга зүйг эмпирик хэмжээнд тодорхойлон авч үзвэл, тухайн бичигдэж үлдээсэн түүхийн өв, судалгааны объектыг эх бичгийн талаас нь судлан дүгнэлтийг гаргах, шинжлэх ухааны эргэлтэнд оруулах, хэл зүй, утгын хувьд алдаагүй гэдгийг батлах явдал байдаг.

Эх зохиол судлал нь тухайн сэтгэгчийн туурвисан бүтээлийг судлах, дүгнэх, шүүмж, хэлэлцүүлэг өрнүүлэх зэргээр судлах явдал юм. Иймд тухайн үеийн нийгэм, улс төрийн өнгө төрх, улс төрийн сэтгэлгээг тод томруун, баримттай харж болох сурвалж нь эх зохиол тул энэ чиглэлийн судалгаанд түлхүү хэрэглэж, хэвшүүлэх нь чухал хэмээн үзэж байна.

Улс төрийн сургаалын түүхийн судалгаанд герменевтик буюу эх бичиг судлах арга /текстлоги/ чухал ач холбогдолтой юм. Герменевтикийн аргаар улс төрийн сэтгэлгээний тодорхой төвшинд бүтээгдсэн улс төрийн сургаалын утга санаа шингэж томъёологдсон утга зохиолын дурсгалт бичгүүд, судалгааны ном зохиол, улс төрийн баримт бичгийг уг эхээр нь судалж утга санаа, агуулгыг нь тайлах, тайлбарлан ойлгоход ихээхэн ач холбогдолтой юм. Нийгэм, хүмүүнлэгийн шинжлэх ухааны судалгааны нэг гол онцлог нь ямагт өнгөрсөн үе рүү хандсан түүх судлалын шинжтэй байдаг оршино. Нийгэм нь регресс, прогресс хөдөлгөөнд байдаг. Иймд нийгмийн төлөв байдлын яг одоо өрнөж буй агшин, цаг хугацааны зураглалыг гаргах боломжгүй юм. Ийм учир нийгэм, хүмүүнлэгийн ухааны судалгаа нь судлагдахуун болж буй зүйлсийн талаарх

²¹ Г.Лодой, “Философи ба шинжлэх ухааны арга зүй” ., 2002 он ., 33-р тал

баримт, мэдээлэл, санаа, дүгнэлт, үзэл баримтлалыг зохиогч, түүнийг судлаач хоёрын ярилцлага байдаг²². Нэг ёсондоо өнгөрсөн, одоо хоёрын ярилцлагаас бий болсон ойлголтоор судалгааны үр дүн тодорхойлогддог хэмээн үзэж, аливаа салбар түүх судлалын ухаанд энэ асуудал хамааралтай байсаар ирсэн.

Герменевтикийн судалгааны аргын эх үндэс нь герменевтикийн философийн сургаал, үзэл, номлолоос эхтэй юм. “Философийн толь”-д өгүүлснээр “Герменевтик бол тайлбарлах урлаг болон онол бөгөөд бичгийн утгыг түүний объектив утга, тэдгээрийн түүхэн нөхцөлдмөл хийгээд субъектив үндсээс сурвалж авч тодруулах зорилготой. Тухайлбал, эртний Грекийн сэтгэгч Гомерийн бүтээл хэвлэх, мөн шинжлэх ухааны судалгаа хийх зорилготой холбогдон эллинизмийн үед үүсэн, цаашлаад аливаа бүтээл, ном зохиолыг тайлбарлах хүрээнд хөгжсөн” арга зүй, бие даасан хандлага юм. Улс төрийн шинжлэх ухаан, тэр дундаа улс төрийн сургаалын түүхийн судалгааны гол эх сурвалж бол тухайн цаг үед бүтээгдэн өнөөд уламжилж ирсэн эрдэмтэн, сэтгэгчдийн үзэл санаа бүхий бүтээл, ном зохиол юм. Эртний Грекийн сэтгэгч Гомер, Гесойд, Сократ, Платон, Аристотелоос эхлээд дунд үе, шинэ үе, нэн шинэ үе, орчин үеийн бүхий л сэтгэгчдийн бүтээл, ном зохиолыг судлах, түүнээс ишлэх, тухайн сэтгэгчийн үзэл баримтлал, судалгааны арга зүйг судлах гол арга нь тухайн сэтгэгчийн бүтээсэн бүтээл, ном зохиолыг судлах, түүнд дүн шинжилгээ хийх явдал юм. Харин энэхүү арга зүйг улс төрийн сургаалын түүхийн судалгаанд ашиглахад герменевтикийн аргыг үр дүнтэй хэмээн тооцож, дараах аргументыг дэвшүүллээ.

Аливаа онол, үзэл баримтлал, дүгнэлтийн утга холбогдлыг тодорхойлох, тайлбарлахад түүнийг илэрхийлж буй хэлний утгын санг шинжлэх зайлшгүй шаардлагатай юм. Энэ нь улс төрийн сургаалын түүхийн салбарт бүр ч их хамаатай ойлголт юм. Учир нь улс төрийн сургаалын түүхийн тодорхой үе болгонд дахь сэтгэгч нь өөрийн санааг илэрхийлэхдээ үг, хэллэгт өөрийн гэх утга холбогдлыг оноож хэрэглэдэг. Ийм утга холбогдол нь ихэнх тохиолдолд ердийн хэлний утгын сантай ойролцоо байх боловч улс төрийн сургаалын түүхийн салбар ухаанд өөр утгаар хэрэглэгдэх явдал байдаг билээ. Тухайлбал, “эстетик” гэх үг эдүгээ гоо зүйн ухаан гэсэн нийтлэг утгаар хэрэглэгддэг бол И.Кантын зохиолд “мэдэрч танин мэдэхүй” гэсэн утгаар хэрэглэгддэг, харин Б.Спиноза “тэнгэр бурхан” гэдэг үгийг өөрийн улс төрийн сургаалын гол бүтээл болох “Бурханы сургаал ба улс төрийн номлол” бүтээлдээ “байгаль” гэсэн утгаар хэрэглэсэн байдаг²³. Иймд тухайн улс төрийн сургаалын бичвэр, санааны утгыг зөв тогтоохын тулд тухайн сэтгэгчийн хэрэглэсэн нэр томъёо, үгний утгыг зөв тодорхойлох шаардлага гарна. Үүнийг шийдвэрлэх үндсэн гаргалгаа нь герменевтикийн арга, арга зүйг улс төрийн сургаалын түүхийн судалгаанд үр дүнтэй ашиглах явдал юм.

Герменевтик аргын улс төрийн сургаалын түүхийн судалгаанд үзүүлэх ач холбогдол бүхий хүчин зүйл нь “зохиогчийг өөрөөс нь илүү ойлгож болох” тухай ойлголт юм. Энэ нь тухайн улс төрийн сургаалыг бүтээсэн сэтгэгчийн өнөөгийн байр сууринаас тухайн сургаалыг авч үзэхэд тухайн сэтгэгчийн ухамсарлаж бодоогүй, гол зорилт болгон тавиагүй нуугдмал утга санааг илрүүлж болно гэсэн үг юм. Нэг ёсондоо улс төрийн сургаалын түүхийн судалгааны нэг чухал зорилт нь өнгөрсөн үеийн ойлголт, төсөөллийг тэр чигээр нь эдүгээд буулгах бус, харин тэрхүү ойлголт, төсөөллийг тухайн судлаач өөрийн ойлголт,

²² Г.Лодой, “Философи ба шинжлэх ухааны арга зүй” ., УБ 2002 он .,34-р тал

²³ Г.Лодой, “Философи ба шинжлэх ухааны арга зүй” УБ 2002 он ., 34-р тал

үнэлэмж, хандлагад буулган шингээж, түүнээс бий болсон шинэ мэдлэг, ойлголтыг “төлөвшүүлэх” явдал юм. Энэхүү зорилтыг герменевтик арга, арга зүйг улс төрийн сургаалын түүхийн судалгаанд хэрэглэснээр хэрэгжүүлэх бөгөөд үүнийг герменевтикийн томъёоллоор “түүхийг эдүгээчлэн хэрэглэх” хэмээн томъёолж болох юм.

Улс төрийн шинжлэх ухааны томоохон дэг сургууль болох Франкфуртын сургуультануудын үзлээр /Ю.Хабермас зэрэг/ тухайн герменевтик нь “үзэл суртлын шүүмжлэл”-ийн хувьд “зохион байгуулалттай хүчирхийлэлийг” зөвтгөх зорилготой нийгмийн засаглал, ноёрхолын хэрэгслийг хэлний шинжилгээгээр нээн илрүүлэх ёстой байна. Ю.Хабермасын үзэлд герменевтик нь орчин үеийн хөрөнгөтний философын олон янзын урсгалыг нэгтгэн нягтруулах нэгэн хэрэгсэл болсон. Хүмүүсийн ухамсартай үйл ажиллагааны бодит үр дүнг шинжлэхтэй холбогдсон улс төр, түүх, хууль зүйн болон бусад шинжлэх ухаанд герменевтик үйлдлийг ашиглаж болдог байна. Хүн төрөлхтөний түүхийн туршлага, түүхийн үр дүнг уламжлан тээгч нь хэл байдаг тухай үзэл санаа зөв зүйтэй, оновчтой, бодитой баримтлал юм. Аливаа шинжлэх ухааны мэдлэгийг уламжлан тээгч нь мөн л хэл байдаг. Иймд шинжлэх ухааны арга зүйн нэгэн чухал чиглэл нь хэл судлалын салбарын арга, арга зүйг улс төрийн сургаалын түүхийн судалгаанд ашиглах явдал нь зүй ёсны шаардлагатай гэдгийг дээр дурдсан баримтаас харахад тодорхой байна.

Түүх бичлэгийн шинэчлэлийн асуудалд герменевтик арга, арга зүй чухал ач холбогдолтой хэмээн судлаачид санал нэгтгэйгээр үзэж байна. Нэг ёсондоо түүх бичлэгийн асуудалд герменетик арга зүйн үүднээс хандах нь орчин үед сонгодог хэлбэр болсон байна. Герменевтик арга, арга зүйн үүднээс улс төрийн сургаалын түүх судлалд хандах хандлагыг дүгнэж үзвэл Хэл, Ойлгохуй, Текст гэсэн гурван ойлголтын хүрээнд хэрэгжих юм.

Улс төрийн шинжлэх ухааны түүхэнд дэх томоохон сэтгэгчдийн үзэл баримтлал, номлол, сургаалын илрэл нь тухайн сэтгэгчийн ном зохиол, бүтээл юм. Улс төрийн сургаалын түүх судлалын бичлэг бий болж, үүсэн бүрэлдсэн үе болох эртний Египет, Грек, Энэтхэг, Хятад зэрэг гол төвүүдэд өөрийн судалгааг хийж, үзэл баримтлал, сургаал, номлолоо боловсруулж байсан их сэтгэгчид болох Күнз, Сократ, Платон, Аристотель нарын сургаал, үзэл баримтлалыг судлах гол эх сурвалж нь тухайн сэтгэгчдийн бүтээл, ном, зохиолыг унших, судлах, дүгнэлт хийх явдал юм.

Тухайн улс төрийн сургаалыг бүтээж буй сэтгэгчийн үзэл санаа, сургаал, номлолын үндсэн цөм нь ямагт тэдний бүтээлд хадгалагдсан байдгийг улс төрийн сургаалын түүхээс харж болох юм. Тухайлбал, Күнз “Лунь-Юу”, Платон “Төр улс”, Аристотель “Улс төр”, Аквины Фома “Эрх баригчдын засаглалын тухай”, Гегель “Түүхэн философи”, “Христос шашны үзэл санаа, түүний хувь заяа”, Николла Макиавелли “Эзэн захирагч”, Томас Гоббс “Левиафан”, Шарль Луй де Моньтескье “Хуулийн амин сүнс”, Жон Локк “Төрийн тухай хоёр шаштир”, Жан Жак Руссо “Нийгмийн гэрээ ба улс төрийн эрхийн зарчмууд”, Макс Вебер “Улс төр судлал мэргэшил болох нь”, Вальтер Таймер /Улс төрийн үзэл санааны түүх/, К.Р.Поппер /Нээлттэй нийгэм, түүний дайснууд/ зэрэг улс төрийн сургаалын түүхийн алдартай бүтээлүүд нь улс төрийн шинжлэх ухааны өнөөгийн чиг хандлага, нийгмийн байгуулалтын үндсийг тавьсан байна. Эдгээр эх зохиол нь тухайн сэтгэгчдийн үзэл санаа, сургаалын гол цөм, үндсэн хэсэг нь юм. Күнз өөрийн хүлцэх чанар, хаад, түшмэдийн зан суртахуун, төрийн үндсэн үүргийн тухай сургаалаа өөрийн “Лунь-Юу” зохиолдоо тусгасан бол, Платон төрийн засаглалын тухай номлол буюу түүний улс төрийн сургаалын цөм нь

болох төрийг “философчид удирдах” тухай сургаал нь түүний гол бүтээл болох “Төр улс” зохиолд мөн түүнээс хойшхи улс төрийн сургаалын түүхэнд дэх сэтгэгчдийн улс төрийн үзэл санаа, сургаал номлол бүтээлүүдэд нь тусгалаа олсон байдаг.

Эх зохиол судлах аргын ач холбогдлыг өндрөөр үнэлсэн сэтгэгчдийн нэг төлөөлөгч нь К.Р.Поппер юм. Тэрээр өөрийн “Нээлттэй нийгэм, түүний дайснууд” номондоо дараах байдлаар авч үзсэн байдаг. К.Р.Поппер өөрийн энэхүү хандлагаа баталгаажуулхын тулд судлаач А.К.Рожерс болон Ж.Бернет нарын шинжлэх ухааны мэтгэлцээн, тус тусын үзлийн өрсөлдөөнийг тухай авч үзсэн байна. Тус хоёр судлаач нь Сократын залгамжлагч нь Платон мөн, биш гэдэг дээр өөрсдийн судалгаа, үзэл баримтлалаар мэтгэлцэж, шүүмжлэлийг хийсэн байдаг. Судлаач А.К.Рожерс өөрийн “Сократын асуудал”²⁴ номондоо Платон бол Сократын залгамжлагч биш хэмээн үзэх үзлийг дэвшүүлэн тавьсан юм. Мөн гэж батлах гол төлөөлөгч нь Ж.Бернет, тэрээр “Эртний Грекийн философи”²⁵ номондоо энэ санаагаа томъёолсон байна. Дээрх хоёр эрдэмтний үзэл суртлын гол зөрчилдөөн нь Платоны бичсэн алдартай дөрвөн том бүтээл дээр өрнөсөн юм. Дээрх дөрвөн том бүтээлийн хоёр нь буюу “Өмөөрөхүй”, “Критон” бүтээлүүд нь цэвэр Сократлаг шинж чанарыг агуулсан. Харин үлдсэн хоёр бүтээл болох “Улс”, “Федон” гэсэн хоёр бүтээлд Сократ харилцан ярилцагч болон гардаг ч энэ нь цэвэр Платоны өөрийнх нь үзэл бодлын тусгал”²⁶ юм хэмээн тэрээр дүгнэсэн байна. Энэхүү шинжлэх ухааны мэтгэлцээн, өрсөлдөөнийг бий болгож буй үндэс нь аливаа шинжлэх ухаан хөгжих үндэс юм хэмээн К.Р.Поппер үзэж, энэхүү эрдэм шинжилгээний шүүмжлэл, мэтгэлцээнийг өрнүүлэх эх үндэс нь тухайн сэтгэгчийн эх зохиол юм хэмээн үзжээ. Нэг ёсондоо аливаа шинжлэх ухааны хөгжих эх үндэс нь тухайн судлаачийн бүтээл, ном, зохиолыг шүүмжлэх шинжлэх ухааны шүүмж, өөрийн үзэл баримтлалыг хамгаалах хариу шүүмж, энэ хооронд үүсч буй мэтгэлцээн нь аливаа шинжлэх ухааны хөгжих үндэс хэмээн тодорхойлсон юм. Энэ үзэл санаагаа тэрээр цааш баталгаажуулж, “Үнэн хэмээх энэхүү ойлголт энгийн амьдралд дан ганц сайн сайхны илэрхийлэл баталгаа болон оршдог, харин шинжлэх ухааны хувьд хамгийн том хор уршиг юм”²⁷ хэмээн шүүмжлэлт рационалист үзэл, түүний үндэс болсон эх зохиол судлалын ач холбогдолын их үнэлсэн байдаг.

Эх зохиол судлал нь улс төрийн сургаалын түүхийг судлах судалгаанд арга зүйн шинж бүхий дараах ач холбогдолтой хүчин зүйлсийг бий болгож байна. Энэ нь тухайлсан нэг судлаачийн улс төрийн сургаал, номлолыг судлахад тухайн судлах судалгааны объект нь харьцангуй барьцтай, нөгөө талаар тухайн судлаачийн улс төрийн сургаалд дүн шинжилгээ хийх, судлаачид хоорондын үзэл баримтлал, онол, арга зүйд харьцуулалтын аргыг ашиглах ач холбогдолтой юм.

Нөгөө талаар судлаачдын бий болгосон шинжлэх ухааны арга зүй, хандлага, дэг сургуулиудыг судлах гол арга нь эх зохиол судлах арга юм. Платоны объектив идеалист хандлага, Аристотелийн шударга ёсны тухай болон, аристократизмын хандлага Гегелийн эрх, эрх зүйн хандлага, Аквины Фомагийн теологийн хандлага, Жан Жак Руссогийн радикал хандлага, Жон Локкын либерал хандлага, Макс Веберийн бюрократ хандлага, К.Попперын

²⁴ “Socratic problem” .., A.K.Rogers .., 1933

²⁵ “Early Greek philosophy” .., J.Bernet .., 1931

²⁶ A.K.Rogers, “The Socratic problem” .., 1933

²⁷ К.Р.Поппер., “Нээлттэй нийгэм, түүний дайснууд” .., хавсралт бүлэг .., 1943 он

шүүмжлэлт рационалист хандлагууд нь улс төрийн шинжлэх ухаан, улс төрийн сургаалын түүхийн салбар ухаанд ямар нөлөөг үзүүлсэн, дээрх судлаачдын энэхүү хандлага, судалгааны арга зүйг боловсронгуй болгохын тулд цаашид юу хийх ёстой вэ гэсэн асуултанд хариултыг өгч, зөв чигийг заах хэрэгсэл нь “эх зохиол судлал” юм. Иймд “Эх зохиол судлах” арга нь тухайн судлаачдын үзэл санаа хамгийн хүчтэй тусгагдсан “баримт бичиг” учир улс төрийн шинжлэх ухаан, түүний салбар судлал улс төрийн сургаалын түүхийг судалж буй судлаачдын нэн түрүүнд танилцах, ашиглах материал бөгөөд энэ чиглэлд /УТШУ-УТСТ/ бакалавр, магистрын төвшинд суралцагсдад эх зохиолын шүүмж, бие даалт, эссэ бичүүлж хэвшүүлэх нь энэ аргыг өргөн, бүтээлчээр ашиглаж дадах үндэс болно.

Платон судлалын нэрд гарсан судлаач бол Макдональд Корнфорд юм. Тэрээр өөрийн эх зохиол судлах арга, арга зүйг дараах байдлаар тайлбарлаж, энэхүү аргыг үлэмж ач холбогдолтой хэмээн өөрийн үзлийг дэвшүүлсэн байдаг. Тэрээр аливаа эх зохиолтой танилцахад хамгийн чухал асуудал нь тухайн текстийн /эх зохиолын/ эхний өгүүлбэр хэрхэн эхэлж байна вэ? Түүний утга санаа агуулга нь чухам юу вэ? Улмаар тухайн текстийн төгсгөлийн өгүүлбэртэй хэрхэн холбогдож байна вэ? гэдэг асуудал чухал юм хэмээн үзжээ²⁸. Макдональд Корнфорд Платоны “Агуйн тухай ёгт үлгэр” зохиолыг эх зохиол судлах аргаар тайлбарлахдаа нэн түрүүнд тухайн эх зохиолд анализ хийж, системчлэх хэрэгтэй хэмээн үзжээ. Энэ нь нэг талаас Платоны үзэл санаа, гаргах гэсэн санааг философийн үүднээс түлхүү тайлбарлахад чухал нөлөөг үзүүлдэг байна. Нөгөө талаас энэхүү зохиолд гаргасан Платоны санааг улс төрийн үүднээс нь түлхүү тайлбарлах хоёр загварыг гаргаж судлах, гэсэн хоёр загварыг гаргаж энэ дагуу судлах нь илүү үр дүнтэй болохыг тэмдэглэсэн явдал юм. Харин энэхүү хоёр загвар бүхий хандлагын аль нэгийг нь хэт барилгүй, ижил хэмжээнд авч үзэх нь чухал гэдгийг анхааруулсан байна. Тэрээр энэхүү арга зүйг үндэс болгон их сэтгэгч Платоны гол бүтээл болох “Төр улс”, “Агуйн тухай ёгт үлгэр” гэсэн хоёр зохиолыг “эх зохиол судлах” аргаар судлан, судалгааны явцдаа дээрх арга зүйг боловсруулсан байна.

Хураангуй: Научный метод, это путь познания, способы и приемы исследования. Научная значимость и познавательная ценность применяемого метода определяется в конечном счете его эвристическим потенциалом, его способностью обогатить науку новым знанием об изучаемом объекте, выявить новые моменты в исследуемых явлениях и привести к более содержательному и более глубокому их пониманию. Ленгвистика и Герменевтика является методологией гуманитарных наук, онтологией и универсальным способом философствования. Являясь методологией гуманитарных наук, герменевтика, ленгвистика выходит за их пределы.

Ном зүй

1. Карл Раймунд Поппер. “Нээлттэй нийгэм түүний дайснууд”, 1943 он
2. A.K.Rogers, “The Socratic problem” ., 1933
3. “Философын толь”., УБ 1994 он
4. Г.Лодой., “Философи ба шинжлэх ухааны арга зүй” ., УБ 2002 он

²⁸ Улс төрийн боловсролын академи, “Шинэ толь” ., Х.Пүрэвтогтох “Агуйн тухай ёгт үлгэр” /Платон/ зохиолд хийсэн эргэцүүлэл ., 132-р тал., № 23 .,1998 он

УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ОНОЛЫН АСУУДАЛД**БЮРОКРАТ УДИРДЛАГЫН ТАЛААРХ МАКС ВЕБЕРИЙН ЦОГЦ ТАЙЛБАР****Ц.Батболд***МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор*

Түлхүүр үг: бюрократ, бюрократууд, хүнд суртал, хүнийсэлт, давхраажилт, рационал, легаль засаглал, мэргэжсэн, зайлшгүй

Товч агуулга: Уг өгүүлэлд нягт зохион байгуулалттай захиргааны дэглэм бүхий бюрократ тогтолцооны талаарх М.Веберийн өгсөн тайлбарыг тодруулсан. Рационал бюрократ нь хувь хүнээс хамааралгүй, “бодит”, устгагдашгүй, зайлшгүй хэрэгцээт байдалтай бөгөөд нийгмийн давхраажилтыг бий болгож, рационализмыг түгээн сурталчилдаг байна.

М.Вебер зохион байгуулалтын бюрократ загвар бол удирдлагын бусад тогтолцоог бодвол илүү үр ашигтай гэж үзсэн байна. Зөвхөн хэн нэгэн хувь хүнд хандсан бус, бүх хүнд хамааралтай дүрэм зааврууд болон шийдвэр гаргах үйл явцтай бюрократ удирдлага, зохион байгуулалт нь мэргэжлийн тооцоо судалгаанд тулгуурлан үр дүнтэй байх нөхцөлийг хангаж байдаг. Тиймээс “бюрократ тогтолцоо хүний хувийн шинж чанараас хол байх тусам, сэтгэл санааны аливаа илрэл, тухайлбал хайрлах, үзэн ядах, өөрөөр хэлбэл тооцоо судалгаагүй, сэтгэл хөдлөлийн үүднээс хандах аливаа илрэлээс ангид байснаар албан үүрэг, даалгаварыг хэрэгжүүлэхэд илүү үр дүнтэй байдаг. Удирдлагын бюрократ тогтолцоо бол тогтвортой, нягт нямбай байдал, сахилга дэг журмыг тогтооход удирдлагын бусад бүх хэлбэрээс давуу талтай. Ажлын үр ашиг, шийдвэрийн цар хүрээ, ер нь удирдлагын аливаа зорилтыг хэрэгжүүлэхэд нэн шилдэг хэлбэр мөн гэж М.Вебер үзэж байв.”²⁹ Бюрократ удирдлагын талаарх М.Веберийн цогц тайлбарыг товч авч үзэе.

Бюрократ зохион байгуулалтын гол шинжүүд:³⁰

“Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эрх мэдлийн сүр хүч нь доорх өөр хоорондоо харилцан хамаарал бүхий санаануудыг хэрхэн хүлээн зөвшөөрч байгаагаас үүдэлтэй. Үүнд:

1. Бюрократ байгууллага нь өгөгдсөн хуулийн хэм хэмжээнд **хамтын, эсхүл үнэт зүйлсийн хүрээнд** тухайн цаг мөчийн боломжит нөхцөлд тулгуурлан, үгүй бол нөхцөл байдлын зайлшгүй шаардлагад нийцүүлэн, эсхүл хэн нэгэн хүч давуу этгээдийн тулгалтыг хүлээн зөвшөөрч, эсхүл аль алин дээр нь үндэслэн байгуулагддаг бөгөөд тухайн корпоратив **бүлгийн гишүүн нь ажлын хэсгийн талбар дээр хамгийн багадаа хуулийн хэм хэмжээг** харилцан хүлээн зөвшөөрсөнөөр **дуулгавартай**

²⁹ Нигроу Ж, Нигроу Л. 1996. Орчин үеийн төрийн удирдлага. УБ., ТЗУХИ.

³⁰ M.Weber The Essentials of Bureaucratic Organization: An Ideal-Type Construction. /Readin in Bureaucracy/ New York., 1968. The Free Press.

зүтгэж болох юм. Гэсэн хэдий ч энэхүү үйл ажиллагаанд албан тушаал эрх мэдэл бүхий этгээдүүд тухайн талбар дээрээ нөлөө бүхий байр суурийг эзэлж, байгууллагынхаа үйл ажиллагаанд хамаарал бүхий хэн бүхнийг захирдаг байна.

2. Хуулийн хэсэг бүхэн ерөнхийдөө зориуд бэлтгэгдсэн цомхон дүрмүүдийн нийлбэр цогцуудаас тогтдог. Цаашлаад захиргааны хууль нь зарим тохиолдолд доорхи зарчмаар тогтдог тохиолдол байна. Захиргааны үе шат нь сонирхлын эрэл, энэ нь нэгдмэл бүлгүүдийн дотроос хууль дүрмийн үндсийг дагах, эдгээр нь ерөнхийдөө тохирон боловсруулах, мөн бүлгийн удирдлагын журмын зөвшөөрөл олгох, эсхүл багаар бодоход зөвшөөрөл олгохгүй байх.
3. Тийм ч учраас эрх мэдэл, албан тушаал бүхий этгээд ямар нэгэн байгууллагыг эзэгнэдэг. Тэрээр эрх мэдэл, албан тушаалынхаа хүрээнд захирамж гаргахдаа, тухайн зүйлд хувь хүнийхээ зүгээс хандах ёсгүй. Энэ нь хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн ямар ч эрх мэдлийн хүрээнд, тухайлбал жирийн нэгэн албан хаагчаас аваад хотын захирагч, яамны сайдын хувьд ч хүчин төгөлдөр байна.
4. Харин ямар нэгэн тушаал захирамжийг хүлээн авагч нь тухайн байгууллагын нэгэн гишүүний хувьд л уг ажлыг гүйцэлдүүлдэг байх бөгөөд тэр зөвхөн хуулийг хүндлэн дээдэлдэг гэж үздэг. Энэ тохиолдолд тухайн этгээд нь аль нэг орон нутгийн нэгжийн жирийн иргэн байх юм.
5. 3-р зүйлд залруулга хийхэд, аливаа байгууллагын гишүүн нь дээгүүр албан тушаалын этгээдийг хүндэтгэн харилцахдаа хувийн зүгээс хандахгүй, харин энэхүү харилцааг албан ёсны байлгах нь гол байдаг. Тийм ч учраас түүний хүлээх ёстой үүрэг нь буюу үзүүлэх ёстой хүндлэл нь зөвхөн тодорхой хязгаар бүхий эрх мэдлийн тойрогт л түүнд оногдоно.

Хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн эрх мэдлийн үндсэн категорууд:

1. Аливаа дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулж буй байгууллага.
2. Тодорхойлогдсон чадварын хүрээ. Энэ нь:
 - а) Тодорхой цар хүрээ бүхий, ажлын нэгэн системчлэгдсэн хэсгийг гүйцэтгэхээр тусгагдсан үүрэг даалгавар.
 - б) Энэхүү үүрэг даалгаврыг гүйцэлдүүлэхэд тусгагдсан үйл явцын үе шатыг гүйцэлдүүлэх талаар ажилтан нь эрх мэдэл бүхий этгээдтэй урьдчилан тохирох.
 - в) Улмаар тухайн ажлын үйл явцад нөлөөлж болох нэн чухал элементүүдийг ойлгомжтойгоор тодорхойлох болон тухайн нөхцөл байдлыг нь зааж тусгасан байх.

Мөн энэ маягаар зохион байгуулагдсан эрх мэдлийг хэрэгжүүлэгч нэгжийг “удирдлагын нэгж” гэж нэрлэдэг. Маш өргөн цар хүрээг хамардаг улсын болон хувийн байгууллагуудын хувьд, зэвсэгт хүчин, нам, тэр бүү хэл орон нутаг, сүм хийдийн хувьд ч удирдлагын нэгж оршдог. Сонгогдсон ерөнхийлөгч, сайд нарын танхим, эсхүл парламентийн гишүүд ч удирдлагын нэгжийн нэг хэсгийг бүрдүүлцгээдэг. Харин удирдлагын нэгж бүхэн хүч нөлөөтэй байдаггүй.

3. Аливаа байгууллагын дотоод зохион байгуулалт нь дээрээсээ доош чиглэгдсэн иерархи тогтолцоотой байдаг. Энэ нь нэг ёсондоо доод салбар нь дээд хэсгийн захиргаа заавар дор үйл ажиллагаагаа явуулдаг

- гэсэн үг юм. Харин доороос дээд захиргаандаа санал гомдол гаргаж, шаардлага тавьж байх эрхтэй байдаг.
4. Ямарваа байгууллагын зохион байгуулалтыг цэгцэлж, горимд оруулдаг дүрэм, журмууд нь тодорхой хэлбэртэй дүрэм эсхүл хэм хэмжээгээр байдаг. Энэ хоёрын аль алинд тухайн хууль дүрэм байна гэж үзвэл тодорхой үе шат бүхий дадлагажуулалт чухал болно. Улмаар энэхүү тодорхой үе шат бүхий дадлагажуулалтанд хамрагдсан хүн л тухайн байгууллагын удирдах албанд гишүүнээр орох эрхтэй болох бөгөөд цаашид албан тушаал ахих бүрэн боломжтой болох юм. Тухайн байгууллагын үйл ажиллагаа улс төрийн, шашин зан үйлийн, эдийн засгийн, ашгийн эсхүл тэс өөр зүйлд чиглэгдсэн байлаа ч хамаагүй удирдах албаны ерөнхий зохион байгуулалт нь дээрээс доошоо байх тохиолдолд албан хаагчдаас бүрэлдэнэ.
 5. Босоо удирдлагын ерөнхий зохион байгуулалтын үндсэн зарчим нь удирдах зөвлөлийн гишүүн нь тухайн байгууллагын эзэмшигч, эрх мэдэл нөлөө бүхий хүн байхыг хориглодог юм. Удирдах албаны албан хаагчид, ажилчид нь байгууллагын үйл ажиллагаа болон нэгээхэн хэсгийг ч эзэмшдэггүй байна. Харин ашиг орлого нь тэдний хэрэгцээг хангахад зарцуулагдах бөгөөд албан хаагч нь өөрийн хэрэглээний талаарх тайлан тооцоог гаргах үүргийг хүлээдэг байна. Мөн байгууллагын хүрээнд байх байгууллагын өмч хөрөнгийн талаар болон албан хаагчийн хувьдаа хэрэглэх хөрөнгө мөнгөний талаар нилээд ялгаж салгаж өгсөн зарчмууд байдаг. Түүнчлэн албаны үйл ажиллагааг явуулах байр, конторыг бусад амьдралын орчингоос тодорхой хэмжээгээр зааглаж өгсөн байдаг.
 6. Босоо удирдлагын байгуулалтад өөрийн эрх мэдлийг ашиглах, завших үйлдэл ажилчны зүгээс огтхон ч гардаггүй. Шүүгчдийн болоод албан хаагчдын хоорондын харилцаанаас хамааралгүйгээр, хаана л эрх мэдэл байна тэнд эрх мэдлээ урвуугаар ашиглах, шамшигдуулах бус, харин тухайн эрх мэдэлд хяналт тогтоох механизм үйлчилнэ.
 7. Хэдийгээр зарим тохиолдолд уулзалт, зөвшилцөөнөөр удирдлагын зүгээс шийдвэр, дүрэм журам, дүгнэлтүүдийг баталдаг ч тухай бүр нь эмхлэн цэгцэлж, бичгээр үйлдэх нь чухал байдаг. Энэ нь дор хаяж ямар нэгэн чухал шийдвэр, дүрэм журмыг шийдвэрлэхийн өмнөх үе шатны зөвшилцөөнд байх ёстой зүйл юм. Бичиг баримт болон байгууллагын дотоод зохион байгуулалтаас орчин цагийн аливаа хамтын ажиллагааны гол цөм болсон “байгууллага” бүрэлддэг.
 8. Хууль ёсны эрх мэдэл гэдэг нь маш олон хэлбэрээр илрэн гарч болно. Доорхи шинжилгээ нь захиран тушаах хэлбэрийн удирдлагын хэсгийн зохион байгуулалтад голлон чиглэх юм. Энэ шинжилгээгээр бюрократ зохион байгуулалтын хамгийн цогц тайлбарыг гаргаж ирэх болно.

Дээрх хэсгүүдэд хууль ёсны эрх хэмжээний системийн хамгийн эрх бүхий этгээдийн талаар ямар нэгэн зүйл дурьдагдаагүй билээ. Учир нь энэ нь шинжилгээний хамгийн эцсийн үе шатанд хийгддэг дүгнэлтийн үр дүн юм. Мөн огт өөр категорит хамрагддаг маш олон төрлийн захиран тушаах онцгой, дархан эрх мэдэл, удирдлагын босоо хэт дарангуй хэлбэрүүд байдаг. Жишээлбэл, бүх нийтийн сонгуулиар сонгогдон гарч ирсэн бүрэн эрхт ерөнхийлөгч, үе залгамжлан хаан ширээнд суусан хаант засаглал зэрэг нь энэхүү уламжлалт харизматик шинжийг агуулдаг нь үнэн юм. Зарим хэлбэр нь тодорхой цэгтээ

босоо удирдлагатай боловч голчлон бюрократ, харизматик шинж хоёрыг хоёуланг нь хослуулсан, нэг талаар засгийн газар хэлбэртэй байна.

Хуулиар тогтоосон эрх мэдлийн хэм хэмжээг илэрхийлэх хамгийн цэвэр, оновчтой хэлбэр бол бюрократ удирдлагын бүрэлдэхүүн байдаг. Байгууллагын зөвхөн ахлах удирдагч нь эрх мэдлээ сонгуулиар, доод дунд удирдлага нь өөрийн идэвх чармайлт, амжилт бүтээлээр олж авдаг. Харин жинхэнэ эрх мэдэл бүхий удирдлагын нэгж нь доорх үйл ажиллагааг эрхлэх чадвар бүхий албан хаагчдаас бүрддэг.

1. Тэд хувийн зүгээс албан тушаалдаа ханддаггүй бөгөөд үүргээ л биелүүлдэг байх ёстой.
2. Албан хаагчид нь уламжлалт удирдлагын доор ойлгомжтойгоор зохион байгуулагдсан байх ёстой.
3. Тухайн байгууллага бүр нь хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн эрэмбэ дараалалтай байх.
4. Байгууллага нь ямар нэгэн гэрээнд хавчигдахгүй байх, улмаар чөлөөт сонголттой байх.
5. Нэр дэвшигчид нь мэдлэг дээрээ үндэслэн сонгогдох. Нэг бол тодорхой сорил даалгаврыг давах эс бол ямар нэгэн диплом, баталгааг гаргах. Ингэснээр тэд албан тушаалд томилогдох болно. Энэ тохиолдолд сонгогдох гэж ярихгүй.
6. Тэдний цалингийн хэмжээ тогтмол бөгөөд ихэвчлэн тухайн байгууллагаас тэтгэвэрт гарах эрхтэй байдаг. Маш цөөхөн хэдэн онцгой тохиолдолд л, ялангуяа тухайн байгууллага хувийнх бол, тухайн ажил олгогч удирдлага нь гэрээг цуцлах эрхтэй байдаг бол харин албан тушаалтан нь хэзээ л бол хэзээ гэрээг цуцлах эрхтэй байдаг. Цалингийн хэмжээ нь албан тушаалийн эрэмбийн дагуу олгогддог нь тухайн албан тушаалтны ажлын үүрэг хариуцлага, албан хаагчийнх нь байр суурийг авч үзсэнтэй холбоотой.
7. Албан хаагч нь өөр бусад ажлыг хавсран хийхгүй байх, эсхүл түүний хувьд энэ ажил нь бусад бүх зүйлээс дээгүүр тавигдсан байх.
8. Энэ нь карьерийг чиглүүлж өгдөг. Мөн үүнд ажил эрхэлсэн хугацаа болон тэргүүлэлт эсхүл хоёулан дээр нь тулгуурласан албан тушаал дэвших тогтолцоо байдаг. Албан тушаал дэвших нь дарга нарын шүүлт шалгуураас л хамаардаг.
9. Албан хаагч нь удирдлагын нэгжээс огт хамааралгүйгээр мөн өөрийн байр сууриа ашиглан завшин шамшигдуулахгүйгээр ажилладаг.
10. Тэрээр байгууллагын үйл ажиллагаанд оролцохдоо нарийн чанд тогтолцоотой дэг журмыг нарийн чанд сахиж байх ёстой.

1. Энэ төрлийн зохион байгуулалт нь зарчмийн хувьд өөр салбарт өргөн хүрээтэй амархан хэрэглэгдэж болохоор юм. Энэ нь ашиг олдог бизнес, мөн халамжийн байгууламж, эсхүл үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулдаг хичнээн ч төрлийн хувийн компани, үйлдвэрүүдэд хэрэглэгдэж болох юм. Үүнийг мөн улс төрийн болон шашны байгууллагад ижилхэн хэрэглэж болно. Дор хаяж эдгээр бүх талбарт энэхүү зохион байгуулалт нь их бага хэмжээгээр байсаар ирсэн билээ. Жишээлбэл, энэ хэлбэрийн бюрократ нь хувийн клиникүүдэд,

тусламжийн эмнэлэгүүд болон шашны дэмжлэгтэй Эмнэлэгүүдэд байдаг болох нь илэрсэн. Мөн католик сүмд бюрократ зохион байгуулалт нь гол үүрэг гүйцэтгэсээр ирсэн. Өнөөгийн сүмийн хамба нарын удирдлагын эрх хэмжээ нь өнгөрсөн цаг үед хүрээгээ тэлж, хувийн эд хөрөнгө хурааж хувьдаа завшдаг байсан хуучин сүмийн хамба нарын өмч хөрөнгийг хураасан ажиллагаанаас тод харагдаж байна. Энэ нь бас шашин шүтлэгийн бүх талын зөв чадамжийг чиглүүлэн залж байгаа гэж боддог нийт лам нарын үзэл баримтлалаар тайлбарлагдсан. Мөн энэхүү үзэгдэл том хэмжээний капиталист үйлдвэрүүдэд байдаг, ба хэдий чинээ том байна төдий чинээ агуу тэдний үүрэг роль нь байдаг. Энэ нь бас тусдаа авч хэлэлцэгдэх улс төрийн намуудад үнэндээ бага байдаг зүйл бас биш юм. Эцэст нь орчин үеийн арми бол их содон, ховор төрлийн цэргийн "офицер" удирдлагатай бюрократ байгууламж юм.

2. Бюрократ эрх мэдэл нь хаана ямар л харилцан тохиролцсон зарчим байна, тэнд л яг бодит байдлаараа биелэгдэж байдаг. Тэнд томилогдсон албатуудын эрэмбэ дарааллын зохион байгуулалт шиг нь адил утга санаатай сонгогдсон албатын эрэмбэ дараа гэж байхгүй юм. Учир нь сонгууль нь дэг журмийн хатуу чанд, тодорхойлсон төрөлд ойртоход нь боломжгүй болгодог. Доогуур тушаалтай албан хаагчид, дарга нартайгаа зэрэгцэн аливаа шагнал, урамшуулалд нэр дэвших нь нээлттэй бөгөөд мөн түүний үзэл бодол нь дарга нараас хамааралгүй юм.

3. Орчин үеийн бюрократад чөлөөт сонгуулийг боломжтой болгодог чөлөөт гэрээ их чухал үүрэгтэй юм. Чадамжийн хүрээ нь хувийн биш албан тушаалын эрэмбээр байдаг боловч, тухайн бюрократын төрөлд ажиллах зарц нь хараат мэтээр чөлөөт бус албатуудаар ажилд сонгогдож ордог. Ингээд "үе дамжсан бюрократ" гэдэг нэр томъёог хэрэглэгддэг.

4. Бюрократын зохион байгуулалт дахь ерөнхий шалгаруулалтын төвшин өссөөр байна. Жирийн нэг намын албан тушаалтан эсхүл худалдааны нэгдлийн байгууллагын ажилтанд ч нэмэлт мэдлэг зайлшгүй шаардлагатай болдог бөгөөд хэдийгээр тэдний мэдлэг нь байнга аливаа дадлагаас хавьгүй илүү туршлагаар хөгжиж байдаг боловч, орчин үед шалгаруулалт шаарддаггүй албан тушаал нь зөвхөн сайдууд болон ерөнхийлөгчийн албан тушаал л байдаг. Энэ нь тэд зөвхөн албаны нүдээр харахад л мөн чанартаа албатууд мэт байдаг болохоос биш том корпорацийн ерөнхийлөгч эсхүл удирдах захирал гэдэгтэй адил нотлох баримтгүй байдаг байна. Үүнд ямарч асуулт байхгүй гэвч капиталист аж ахуй эрхлэгчийн байр суурь нь яг тодорхой язгууртан хаадын эд хөрөнгө хураахтай (завшихтай) адил юм. Тэгэхлээр бюрократ зохион байгуулалтын дээд шатанд ямар нэгэн чухал, гэхдээ яг цэвэр бус зохион байгуулалт бүхий элемент байхнээ. Бюрократын үндсэн төрөл бол захиргааны ажилчны тусгай төрлөөр хянагдаж байдаг дасгалыг зөвхөн хэрэглэх юм.

5. Бюрократ албан хаагчид тогтмол цалин авцгаадаг. Харин эсрэгээр нь хувиараа завшдаг орлогын эх үүсвэрийг "ашиг" хэмээн нэрлэдэг. Бюрократуудын цалин нь бэлнээр, буюу мөнгөн хэлбэрээр төлөгддөг. Энэ нь бюрократын үзэл баримтлалд тийм ч чухал биш боловч, энэхүү зохицуулалт нь яг жинхэнэ тогтолцоонд дөхөж очиж байгаа юм. Зарим төрлийн төлбөрүүд нь "ашиг" хэлбэрээр зохицсон байдаг ба ашгийн тооцоо баримт нь зүгээр л орлого олох болон байр суурьны ашигтай боломжуудын завшилтыг тодотгосон утга илэрхийлдэг. Гэсэн хэдий ч энэ талбарт олон зуучлагчид болон төвшний

шилжилтүүд байнга гарсаар байдаг. Түрээслэх эсхүл албан тушаалын худалдаа мөн албан тушаалтны цалингийн барьцаа зэрэг завших үйлдлүүд нь яг цэвэр хүнд суртлын төрөлд шинээр бий болж байгаа асуудал юм.

6. "Office" ууд, ялангуяа "honorary" office-ууд буюу албан тушаалтны мэргэжлийг өөртөө хамруулдаггүй нь өөр төрөлд хамаардаг..... Яг жинхэнэ бюрократ (хүнд сурталт) албат нь л мэргэжилтний хувьд тухайн "office" ийг эзэмшдэг.

7. Албат нь удирдлагын нэгжээс хамааралгүй байх энэхүү зарчим нь ялангуяа олон нийтийн удирдлага болон хувийн бюрократ байгууламжийн талбарт яг адилхан чухал юм.

8....Одоо үед "хамтын нөхөрлөл"-ийн утга агуулга эрс багасаж байгаа нь урьдын байсан шигээ хэн нэгний удирдлагад байгаагаас үүдэлтэй. Жишээ нь: Пруссийн хамтын засгийн газар нэг хүний засаглал руу буюу "ерөнхийлөгч"-ийн засаглалд шилжээд удаж байна. Энэ шийдвэрт нөлөөлсөн хүчин зүйл нь хурдан, бөгөөд ойлгомжтой шийдвэрийг өөр бусад санаанууд, олонхийн дайралтгүйгээр гаргахад анхаарсанд оршино.

9. Орчин үеийн армид алба хаагч офицерь бол хэд хэдэн төрлийн тодорхойлолттойгоор тусгайлан томилогддог албан тушаалтан юм.

Энэ ч утгаараа тэд зэвсэгт хүчний лидерүүдээс болон харизматик кондотери, шинэхэн офицер болон эдийн засгийн ашиг сонирхол бүхий байлдагчдаас, эцэст нь урьдчилан бэлтгэгдсэн албан хаагчдаас ялгаатай. Магадгүй эдгээрийн дунд шилжилт байж болох юм. Өөрийн дайчин баатарлаг чадварыг заан сургагч "trainer", эдийн засгийн ач холбогдол бүхий бэлтгэгдсэн армийн толгойлогч, болоод хувийн үйл ажиллагаа явуулагч аливаа этгээд орчин үеийн бюрократ засаглалын шинж чанарыг бүрдүүлэгчид билээ.³¹ Практикаас харахад нэг хүний засаглалын хэлбэрийг хэрэгжүүлэгч нь захиргааны байгууламжийн бюрократ төрөл бөгөөд түүний удирдагч хамгийн дээд цэгийн эрх мэдлийг өөртөө бий болгож, өөрийн захиргаанд бүхнийг атгах засаглалын нэг хэлбэр болох магадлал илүү байдаг. Гэхдээ бюрократ нь бусад засаглалын хэлбэрүүдээс өөрийн тогтвортой байдал, сахилгын хатуу чанд шаардлага болон найдаж болох итгэл төрүүлдэг талаараа илүү давуутай. Тийм ч болоод энэ байгууламжийн удирдлагуудад болон түүнд хамааралтай аль ч шатныханд маш өндөр хариуцлага тооцож байдаг. Энэ нь эцэстээ хүчирхэг удирдлага болон үйл ажиллагааны цар хүрээгээрээ юунаас ч хүчтэй бөгөөд бүх төрлийн удирдлагын үүрэгт ажиллагааг хэрэглэхийн хувьд бүрэн боломжтой юм.

Орчин үеийн ямар ч байгууллагын удирдлага, зохион байгуулалтын хэлбэрийг үнэн хэрэгтээ захиргааны бюрократын үргэлжилсэн хэлбэр гэж хэлж болох бөгөөд эд хоорондоо бараг ялгагддаггүй. Энэ нь сүм, муж улс, арми, улс төрийн намууд, эдийн засгийн үйлдвэрүүд, байгууламжууд, хувийн холбоонууд, клубууд болон өөр олон байгууллагын хувьд үйл ажиллагааны зарчим нь үндсэндээ адилхан. Үүний хөгжил нь либералуудын хувьд хамгийн аз туршсан хэрэг хийгээд хамгийн анхаарал татсан асуудал юм. Гэсэн хэдий ч энэ хэлбэрт

³¹ M.Weber The Essentials of Bureaucratic Organization: An Ideal-Type Construction. /Readin in Bureaucracy/ New York., 1968. The Free Press.

огтхон ч таарахгүй хэсэг бүлгүүд оршин тогтносоор байдаг бөгөөд тэдгээрээс дурьдвал, парламентын хороод, засгийн газрын танхим, потенциал элитүүд, бие даасан мэргэжлийн хуулийн зөвлөхүүд, өмгөөлөгчид зэрэг энэ хэлбэрт зохицохыг бодохгүй байгаа олон хүмүүс болон зохион байгуулалтууд үйл ажиллагаагаа явуулдаг аж. Тэд болон тэднээс өөр олон хүн хүнд суртлын "чөтгөрүүдийн" талаар байнга л гомдоллож байдаг. Хэрэв хэсэгхэн хугацаанд ч болов удирдлагыг албан хаагчдад биш хэн нэгэн өөр хүний гарт байгаагаар төсөөлөхөд бүх юм эмх замбараагаа алдах уу, яах бол. Орчин үеийн нийгмийн өдөр тутмын амьдралын бүхий л хэлбэр энэ тогтолцооны дэгд зохицохоор хийгдсэн байдаг онцлогтой. Бюрократ удирдлагын хүчин зүйлсээс авч үзэхэд, энэ нь хамгийн хэлбэртэй болохыг харж болно. Өнөөгийн нүсэр удирдлаганд энэ нь зайлшгүй чухал хэрэгцээтэй, буюу байх ёстой зүйл юм. Мөн аливаа удирдлагын талбарт хийх сонголт нь зөвхөн мэргэжилтэн түшмэл, өнгөц мэдлэгтэн (dilettantism) хоёрын хооронд л хийгддэг.

Бюрократ удирдлагын давуу байх эх сурвалж нь бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэлт дахь орчин үеийн технологийн дэвшил болон бизнесийн арга барилын хөгжлийг зайлшгүй бүрэн гүйцэд хүлээн авсан ерөнхий мэдлэгт тулгуурладаг. Ийм тохиолдолд эдийн засгийн тогтолцоо нь капиталист эсхүл социалист алин дээр нь ч зохион байгуулагдсан байсан ялгаа байхгүй юм. Харин хэрэв ерөнхий удирдах чадамжийг дээшлүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд зайлшгүй зохион байгуулалт бүхий бюрократ хэлбэрийг өсгөх хэрэгцээ гарна гэсэн үг. Тухайн оршин байгаа бюрократ аппаратын нөлөөг сулруулах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гагцхүү тухайн хүнд сурталжуулалтын нэгэн адил удирдлагыг өөрсдөө зохион байгуулах хэрэгтэй болно. Улмаар тухайн үйлчилж байгаа бюрократ аппарат нь материаллаг, объектив улмаар төгс хэлбэрийн сонирхол дээр л уламжлан зохион байгуулагдаж байдаг. Үүнгүйгээр дэг журам, ерөнхийдөө техникжсэн дадлаган дээр тулгуурласан албан хаагчид болон эрх бүхий этгээдүүд, албан хаагчид, ажилчдийн удирдлагын зохион байгуулалтын хуваарилалт нь энэ нийгэмд удаан ажиллаж чадахгүй. Ийм тохиолдолд байж болох ганцхан хувилбар нь жижиг фермерчид юм. Хүч хэрэглэсэн хувьсгал гарах эсхүл гадны улс орнуудад эзлэгдсэн тохиолдолд ч бюрократ машин нь яг урьдын хууль ёсны засгийн газартаа ажиллаж байсан шигээ цаашид ажиллаж чаддаг. Асуудлын гол нь хэн тухайн бюрократ машиныг ажиллуулж байгаад байдаг. Иймэрхүү эрх мэдэл нь мэргэжлийн бус этгээдэд төдийлөн олддоггүй. Нэг үгээр хэлбэл бэлтгэгдсэн буюу мэргэжлийн албан хаагч нь өөрийн албан тушаал дээрээ удаан хугацааны турш ажилласнаараа удахгүй өөрийн дарга болон хэн нэгэн мэргэжлийн биш этгээдийг явцдаа гүйцэж түрүүлэх хандлага их гардаг.

Яг үнэндээ капитализмийн эдийн засгийн нөхцөл байдал нь бюрократ удирдлагын хамгийн тохиромжтой хэлбэр юм. Учир нь энэ нь энэхүү удирдлагыг хамгийн оновчтой хэлбэрт хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгө мөнгөний эх үүсвэрийг тавьж өгдөг талтай. Хөрөнгийн тал дээрээс гадна харилцаа холбоо, тээвэрлэлтэнд чухал ач холбогдол өгөх хэрэгтэй байдаг. Эдгээрийн бодиттой байх нь төмөр зам, цахилгаан холбооны үйлчилгээнээс ихээхэн хамаардаг. Иймээс ч капиталист тогтолцоо бюрократын удирдлагын хөгжилд голлох үүрэг гүйцэтгэсэн нь ямар ч маргаангүй зүйл юм. Үнэндээ, бюрократ аппаратгүйгээр капитализмын цар хүрээ үргэлжилж чадахгүй байсан бөгөөд аль нэг үндэсний социалист төрүүд ч үүнийг хялбархан залгамжлан авч улмаар өөрийнхөө

нөлөөг өсгөх боломжтой болох байсан юм. Социалист зохион байгуулалт ч энэ бүхнийг орхигдуулдаггүй. Харин капиталист нөхцөлд нарийсан хөгждөг шиг, социалист нөхцөлд хөгжих болов уу гэдэг нь л эргэлзээтэй. Хэдийгээр нөхцөл байдал ийм байдаг ч социалист нийгэмд ч яг бүрэн дүүрэн зохион байгуулалтын энэ хэлбэр зайлшгүй шаардлагатай байдаг. Хэрэв энэ нь боломжгүй байх аваас, өөр нэг зохион байгуулалт шаардагдах бөгөөд мэдээж энэ нь хуучинтайгаа тодорхой хэмжээгээр зөрчилдөнө. Капиталистуудын шаардлагаар энэхүү зохион байгуулалтын хөгжил нь өөртөө яг таг, хүчирхэг, эрч хүч, бүхий захиргааны хэрэгцээг бий болгосон. Энэ л хэрэгцээгээр бюрократ нь бидний нийгэмд хүнд суртлын гэсэн шүүмжлэлтэй ч чухал байр суурийг эзэлдэг. Зөвхөн улс төрийн, шашны, эдийн засгийн, болон жижиг байгууллагын удирдлагад дахин шинэчлэл хийснээр үүний нөлөөнөөс холдож болох юм. Нэг үгээр хэлэхэд хэдийгээр өөр өөр түүхэн замналаар явж ирсэн ч орчин цагийн капитализмийн хөгжил нь бюрократизмын хөгжлийг илт давуутай дэмжиж байгаа билээ.

Бюрократ удирдлагын нэгж нь мэдлэг дээр суурилсан байдаг. Энэ нь л энэхүү удирдлагыг төгс болгож байгаа юм. Нэг талаар энэ нь мэдлэгийн цар хүрээгээрээ эрх мэдэл, албан тушаал олох боломжоор хангадаг. Мөн түүнчлэн мэдлэг, туршлага дээрээ үндэслэн аливаа байгууллага, эрх мэдэлтнүүд нь өөрсдийн нөлөөг өргөтгөж болдог аж. Байгууллагын хүрээнд тэдний зайлшгүй шаардлагад хэрэгцээтэй мэдээ мэдээллүүд нь зөвхөн тэдний гарын доор хуримтлагддаг. Мэдээж энэ бүхэн нь өндөр төвшний нууцлалтай байна. Хүнд сурталтан нь мэргэжлийнхээ хувьд ч, хувийн бизнес эрхлэгчийн хувьд ч өргөн цар хүрээ бүхий мэдлэг чадвартай хүн байна. Бидний нийгэмд байгаа хөрөнгөтөн, бизнес эрхлэгч нь л төгс хүнд сурталын нөлөөнөөс өөрийгөө зайлуулагч нь байж чаддаг. Бусад бүх этгээд нь аль нэг байгууллагын удирдлага, зохион байгуулалтад тодорхой хэмжээгээр хамаарагдан энэхүү удирдлагаас хараат байдаг.

Хүнд сурталт захиргааны үр дүнд гарч болох зарим өөрчлөлтийг дурьдвал:

1. Мэдлэгийн хүрээнд нь хамааруулан байгууллагыг хамгийн өргөн хүрээнд тодорхой төвшинд оруулах
2. Хамгийн урт хугацааны дадлагын явцад плутократ (plutocracy) тэлж томрох магадлалтай.
3. Хувийн зүгээс хандахгүй байх буюу аливаа үзэн ядалт, сэтгэл хөдлөлийг хаах бөгөөд, аливаа зүйлд "хөндий" хандах. Хамгийн төгс албан хаагч нь хүн бүхэнд адил тэгш хандах явдал юм.

Рационал бюрократыг Вебер легаль (хууль ёсны) засаглалын шинжилгээний явцад тодорхойлсон байдаг. Засаглалын энэ төрлийн ялгаатай онцлог нь удирдах ажилтнуудын үйл ажиллагааг зохицуулах албан ёсны дүрмийн тогтолцоо оршиж байдаг явдал юм. Эдгээр албан ёсны дүрмүүд нь тогтсон ёс журмыг даган өөрчлөгдөж байдаг. Уламжлалт засаглал нь шинээр гарч ирж буй хууль зүйн хэм хэмжээг ариун нандин уламжлалаар хязгаарлаж байдаг бол легаль засаглалын үед тохирсон ёс журам мөрдөгдөж л байвал хууль зүйн бүтээлд хязгаарлалт байдаггүй байна. Өөрөө өөрийнхөө байдлаараа

легаль засаглал нь өөртөө захирагдаж байгаа ард түмнийхээ өмнө хангалттай легитимтэй байж чаддаггүй . Ийм учраас Вебер энэ засаглал нь уламжлалт ба харизматик элементүүдээр баяжих ёстой гэж үзэж байсан. Үнэндээ легаль засаглал нь эмпирик бодит нөхцөлд цэвэр хэлбэрээрээ хэзээ ч байдаггүй бөгөөд аль нэг төрлийн хавсрага болж явдаг байна. Легаль засаглал нь онцлогдох хэд хэдэн шинж чанаруудтай бөгөөд Вебер тэдгээрээс доорх хэдийг онцолж үзсэн байдаг.

Үүнд :

А) Албан тушаалын үүргийг үндэслэлтэйгээр тасралтгүй гүйцэтгэдэг төдийгүй энэ нь дүрэм журмаар зохицуулагдаж байдаг;

Б) Эдгээр үүргүүд нь янз бүрийн үүргийн хүрээнд хуваарилагдсан байдаг бөгөөд нэг бүр нь шаардлагатай эрх мэдэл, санкц-аар хангагдсан байна;

В) Албан тушаалууд өгөгдсөн тушаалын хэрэгжилтийг хянах болон тэдгээрийг давж заалдах боломжийг хангасан иерархийг бүрдүүлдэг;

Г) Байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулж байдаг дүрэм журмууд нь цэвэр техникийн зааварчилгаа, эрх зүйн хэм хэмжээ гэж хуваагдаж байдаг ч аль алиныг нь хэрэгжүүлэхийн тулд тусгай бэлтгэгдсэн боловсон хүчин шаардлагатай байдаг;

Д) Байгууллагын нөөц баялаг нь түүний гишүүд (хувь хүний)- ийн өмчөөс салангид оршиж байдаг;

Е) Албан тушаалтан албан тушаалаа өмчлөх эрхгүй;

Ж) Удирдлагыг бичмэл баримт бичигт тулгуурлан явуулдаг бөгөөд энэ нь бичиг хэргийг орчин үеийн засаглалын байгууллагын төв болгож байдаг;

З) Легаль засаглал нь янз бүрийн хэлбэртэй байж болох ч энэ засаглалын идеаль төрөлд бюрократ удирдлагын боловсон хүчин ашиглагддаг байна. Бюрократ удирдлагын аппараттай легаль засаглалд зөвхөн байгууллагын толгойлогч (улс төрч) өөрийн байр сууриа сонгууль болон эзэмших буюу өвлөлийн (хувийн салбарт) үндсэн дээр олж авдаг байна. Түүний удирдлагад байгаа аппарат доорхи зарчмаар үйл ажиллагаа явуулж байдаг албан хаагчдаас бүрдэж байдаг .

Үүнд:

1. Тэд хувь хүний хувьд эрх чөлөөт иргэн бөгөөд эзэнгүй албан тушаалын үүргийн хувьд засаглалд захирагдаж байдаг;
2. Тэд тодорхой тогтсон албан тушаалын иерархийн дагуу зохион байгуулагддаг;
3. Албан тушаал болгон хатуу тогтсон тодорхой эрх мэдлийн хүрээнд үйлчилж байдаг;
4. Албан хаагч сайн дураар хийгдсэн гэрээний үндсэн дээр албан тушаалд ордог;
5. Албан тушаалд нарийн мэргэжлийг харгалзан шилж авдаг, гэхдээ тэднийг сонгон шалгаруулахгүй, харин томилж ажиллуулдаг;

6. Ажилласны төлөө тогтмол мөнгөн шагналаар, тэтгэвэрт гаргах эрхтэйгээр урамшуулдаг;
7. Албан тушаал нь түүнд томилогдон ажиллаж байгаа бие хүний ажлын цорын ганц буюу үндсэн төрөл нь байх ёстой;
8. Ажилласан жилээр буюу алдар гавъяаныхаа дагуу албан тушаал ахих систем оршиж байдаг;
9. Албан тушаалтан нь удирдлагын хэрэгслээс тусгаарлагдсан байдаг бөгөөд албан тушаалаа эзэмшиж, өөртөө ашиглах эрхгүй;
10. Тэдний үйл ажиллагаа хатуу сахилга бат болон хяналттай тогтолцоонд захирагдаж байдаг;

Веберийн үзэж байгаагаар бюрократыг легаль засаглалтай адилтгаж болохгүй. Нэг талаасаа легаль засаглал бюрократ бус тухайлбал, хамтын (коллегиаль) удирдлагаар явагдаж болно. Энэ нь эрх мэдэлтэй хэн нэгэнд биш харин зохиомол дүрэм журамд захирагдах нь зүйтэй гэж үздэг. Энэ тохиолдолд улс төрийн удирдагч мөн адил зохиомол эрх зүйн хэм хэмжээнд захирагдаж байх ёстой. Уламжлалт болон харизматик засаглалд гол ач холбогдолтой байдаг хувийн үнэнч зарчмыг халж, оронд нь биегүй дүрэм журмаар үйл ажиллагаа зохицуулагддаг.

Э.Гелнерийн тэмдэглэсэнээр бол либераль иргэний нийгмийн дурын гишүүн нь өөрөө өөрчлөхийг эрмэлзэж байсан ч гэсэн тогтсон хууль зүйг даган биелүүлж, түүнийг хамгаалах шаардлагатайг ухамсарладаг төдийгүй түүнд итгэлтэй байдаг. Гэхдээ тэрээр нийгмийн давхрагын шат дээгүүр байрлаж буй засаглалын бүтцийг тахин шүтдэггүй байна. Веберийн бичсэнээр легаль засаглал бол, захирагчийн нандин уламжлал, баатарлаг гавъяат харизм бүхий бие хүнд үнэнч байх, түүнд итгэх явдалд үндэслэн захирагдах бус, харин оновчтой тогтсон хэм хэмжээ (хууль дүрмийн тайлбар)-гээр дамжуулан тодорхойлогдсон засаглалын эрхтэй, хувийн шинж чанараа алдсан бодит албан тушаал бүхий тодорхой томъёологдсон зорилготой бодож боловсруулан нийтэд зарлагдсан хууль ёсны ерөнхий дүрмийн хүрээнд илэрч байдаг ажээ. Легаль засаглал нь ямар нэгэн үнэ цэнэтэй суурь фундаментийг агуулж байдаггүй бөгөөд цэвэр функциональ, өөрөөр хэлбэл ямар нэгэн удирдлагын төрлүүдийн үнэ цэнэтэй агууллагаас ямар нэгэн хамааралгүй байдаг ажээ. Нөгөө талаасаа бюрократ засаглалын аппарат нь удирдлагын легаль зарчмыг баримталдаггүй тохиолдолд ашиглагдаж болно.

М.Вебер ийнхүү бюрократын үзэгдлийн тодорхойлогч шинж чанаруудыг аль нэг байгууллагын захиргааны удирдлагын үндэс, хэв шинжийнх нь талаас нээн илрүүлжээ. Уламжлалт патриархаль, патримониаль удирдлагын хэлбэрүүдийн харилцааны онцлог болох хувийн засаглалын хэмжээгүй ноёрхол, “хүмүүсийн хоорондын харилцаанд бие биендээ ая тал засах, ивээлдээ авах зэрэг үзэгдлээс аль болох ангид “мэргэжлийн” шалгуурыг голлодог болсон нь”³² бюрократ удирдлагын хууль, дүрэм журамд тулгуурласан соёлын онцлог юм. Энэ утгаараа хууль зүйн дагуу төлөвшиж бий болсон прагматик бюрократуудын өмгөөлөгч гэж Веберийг үзсээр иржээ. Вебер бюрократ механизмгүйгээр орчин үеийн нийгэм нэг ч өдөр оршин тогтнохгүй гэж хэлсэн байдаг. Аристотелийн

³² Нигроу Ж, Нигроу Л. 1996. Орчин үеийн төрийн удирдлага. УБ., ТЗУХИ.

бичиж байснаар бол удирдлагын ямар ч зөв хэлбэр нь нөлөөт тольны тусгал мэт гажуудлыг бий болгодог.

Гэхдээ Вебер бюрократыг төгс төгөлдөр удирдлагын хэлбэр гэж үзээгүй бөгөөд харин ч, нийгэм, улс төрийн хувьд түүний үзүүлж болох сөрөг нөлөөллийг тооцож байсан билээ. Гэсэн ч тухайн цаг үед түүнээс өөр оновчтой удирдлагын хэлбэр загвар байхгүй гэж үзэж байсан. ХХ зууны туршид хандлага, аппаратын хөгжил дэвшил улс төрийн гол сэдэв болсоор ирсэн нь Веберийн таамаглал үнэн зөв байсныг баталсан билээ.³³

Рационал бюрократын онцлог

Бюрократ гэдэг бол захиргааны хүчинд тулгуурласан, маш нарийн зохион байгуулалт бүхий дэглэмтэй удирдлагын тогтолцооны тухай ерөнхий ойлголт юм. Рационал бюрократ тогтолцоо нь хувь хүнээс хамааралгүй, “бодит”, устгагдашгүй, зайлшгүй хэрэгцээт байдалтай байдаг бөгөөд нийгмийн давхраажилтыг бий болгож, рационализмыг түгээн сурталчилдаг байна. Орчин үеийн бүх улс орны газар нутаг дээр амьдардаг хүмүүсийн нийгэм, улс төр, эдийн засаг, соёл, оюун санааны болон байгал экологитой хүртэл харилцах харилцааны онцлог нь тухайн улсын хууль, захиргааны дүрэм журмуудаар зохицуулагдаж байдаг бөгөөд түүнийг албан ёсоор хэрэгжүүлэгчид нь бюрократууд юм.

Орчин үеийн улс орнууд дахь капиталист, социалист нийгмийн алинд нь ч бюрократ рационал хөгжлийг олох боломжтой. Учир нь бюрократ бол нэг талаар үйлдвэржилтийн зохион байгуулалтын үндэс юм. Нөгөө талаар орчин үеийн төрийн удирдлага, нийтийн захиргааны удирдлага зохион байгуулалтын суурь нь болж байдаг. Эдгээр удирдлагын элемент нь улсын хэмжээнд бюрократ бүлэглэлийг, хувийн эдийн засагт бюрократ пүүсийг бий болгоно.

Рационал бюрократ нь нэг хүний (Ерөнхий сайд гэх мэт гүйцэтгэх засаглалын тэргүүний) удирдлагад байна. Бюрократад дээд албан тушаалтнууд нь доод тушаалтнуудаа хянан захирдаг албан ёсны шатлан захирах систем бүрэлдэн тогтсон байдаг бөгөөд дээд тушаалтан нь доод тушаалын хүний үүрэгтэй хэзээ ч хутгалдахгүй. (энэ нь хүнд суртлыг багасгана) Харин доод тушаалтны албан газар сул ажлын орон тоо, зай гарвал тэнд үргэлж хүн нэмж авч байх хэрэгтэй болдог. (ингэснээр хүнд суртал улам ихэснэ)

Бюрократ тогтолцоонд дээд тушаалтны захирамж, тушаал шийдвэрийг доод тушаалтнууд биелүүлэх үүрэгтэй байдаг. Эдгээр үүргүүдийг биелүүлэхгүй байж болохгүй бөгөөд зарим үед албадлагын арга хэрэгсэл хэрэглэх боломжийг бий болгосон байна. Үүргүүдийг байнгын тогтмол биелүүлэх бололцоог зохион байгуулалттай аргаар хангаж байдаг. Удирдлага нь бичиг баримт болон бичээч, боловсруулагчдын багт тулгуурлан ажлаа явуулна. Албан тушаалтан дээр “бичиг баримт”-ыг нэмээд албан байгууллага бүрдэнэ. Зарчмын хувьд, ажил дээрх үйл ажиллагаа нь хувийн амьдралаас тусдаа зүйл юм. Албан байгууллагын удирдлагын үйл ажиллагаа нь нарийн, мэргэшсэн дадлагыг шаардана. Байгууллагын удирдлагын үйл ажиллагааг явуулах ерөнхий дүрмүүд байх бөгөөд тэдгээр нь тогтвортой, төвөгтэй, бас сурч болохуйц байдаг. Эдгээр дүрмийн мэдлэг нь онцгой туршлагыг бий болгоно.

³³ Ж.Нигроу Л.Нигроу. Орчин үеийн төрийн удирдлага. УБ., 1996. х 44.

Байгууллагыг удирдах нь мэргэжил мөн. Учир нь үүнд маш удаан хугацааны турш бүхий л хүчин чадлаа гаргахыг шаардах тусгай дадлага болон шалгуурууд байдаг. Албан тушаалтан нь байгууллагын ажилтан бус харин байгууллагын “хувийн бус, функционал зорилгууд”-ын төлөө тодорхой “үүрэг” хүлээж буй гэдгээрээ өөрийн оршин тогтнолыг баталгаажуулдаг байна. Бюрократ албан тушаалтнууд нь нийгэмд хүндэтгэлтэй байр суурьд хүрэхийг үргэлж хичээх бөгөөд үүндээ ч ихэнхдээ хүрч чаддаг. Хаана туршлагатай удирдлага хэрэгтэй байна, тэнд албан тушаалтнууд хамгийн өндөр нийгмийн статустай байх бөгөөд зэрэг дэвийн болон нийгмийн ялгаа маш хурц байдаг.

Бюрократад хамааралтай болон хамааралгүй албан тушаалтны ялгаа их байдаг. Сонгогдсон улс төрийн албан тушаалтнууд илүү тодорхой биеэ даасан (автономит) эрхтэй. Томилогдсон ажилчид нь сонгогдогсдоос илүү сайн ажилладаг. Учир нь тэд тухайн ажилд тохирох чадвартай байж чаддаг. Гэхдээ чадвар муутай сонгогдсон, томилогдсон удирдлага нь эргээд намдаа болон төрд муугаар нөлөөлнө. Дээд удирдах албан тушаал болон тэдгээрийн туслахуудыг бүрэн ардчиллын зарчмаар сонгох нь бюрократ систем болон албан тушаалын хяналтын тогтолцоог устгах аюултай байдаг. Мөн шүүхийн “насаараа эзэмших” хуулиар баталгаажсан эрх нь нийгмийн статусыг дээшлүүлэх шалтгаан болж чаддаггүй. Учир нь шүүхийн ийм эрх нь нийгмийн шударга ёс, засаглалын легитимээс хамаардаг.

Эрх мэдэл, албан тушаалаа хэрхэн яаж ашиглан мөнгө олох, хөрөнгө (зөвхөн бэлэн мөнгө бус капитал) шууд худалдан авах явдал яагаад гардаг тухай судлаачдын олон тайлбар бий. Энэхүү материаллаг бэлэг шагнал (цалин хөлснөөс тусдаа), эсвэл улс төрийн бусад эрх нь бюрократ механизмын эрх мэдэл, хүч чадлыг сулруулдаг байна. Харин албан тушаал ахих, статус, баталгаатай орлого, мэргэжлийн чөлөөт байдал зэрэг нь албадлагаас илүү зүйл бөгөөд энэ механизм нь бюрократ аппаратыг амжилтад хүргэх гол шалтгаан болдог. Бюрократ тогтолцоо нь түүний орших боломжийг олгож байдаг байнгын орлого, төсвөөс шууд хамааралтай. Тэрхүү орлого нь татвараар дамжин төсвөөс орж ирнэ. Татварын систем нь төсөв бүрдүүлэх байдлаар бюрократ тогтолцооны эдийн засгийн байнгын оршин тогтнох боломжийг нь хангаж байдаг учраас түүний оршин тогтнолд чухал дэмжлэг болж байдаг.

Бюрократ дэг журмын үндсэн шинжийн нэг нь захиргааны үүргийн тоо, хэмжээний өсөлт юм. Улс төрд нүсэр төр хийгээд том нам нь уг хөгжлийн тод жишээ болдог. Тодруулбал, орчин үеийн нүсэр төр нь бюрократ суурь дээр тогтоно. Төр хэдий чинээ том “хүчтэй” байна, төдий чинээ нийгэм, эдийн засгийн амьдрал төрөөс хамааралтай болдог. Орчин үед захиргааны үүргийн чанарын өөрчлөлт чухал болсон. Энэ хүрээнд бюрократын захиргааны үүргийн чанарын болон эрчимжилтийн өсөлт нь суурь шинжтэйгээр өөрчлөгдөж байна. Захиргааны үүрэг дэх удирдлага зохицуулалтаас илүүтэй үйлчилгээний хандлага чанарын суурь өөрчлөлтийн үндэс болж байдаг. Өөрөөр хэлбэл, захиргааны удирдах, зохицуулах үүрэг огт байхгүй болно гэсэн хэрэг биш бөгөөд захиргааны үйл ажиллагааны дийлэнх хэсгийг үйлчилгээний үүрэг эзлэх явдал чанарын суурь өөрчлөлтийн үндэс юм.

Бюрократ тогтолцоо нь өөрийн удирдлагаа үргэлж, тасралтгүй хэрэгжүүлж байхын тулд аль болох олон үүрэг даалгаврыг бий болгож байх явдал нь түүний эрчимжилтийн үндэс болдог. Бюрократ дэг журмын эрчимжилт нь байнгын арми, хууль хяналт, хүчний байгууллагуудад иргэншлийн төвөгтэй байдлыг даван туулахад эерэгээр нөлөөлж байжээ. Хэрэглэгчдийн эдийн засаг, соёлын хэрэглээний өсөлт болон амьдралын стандартын өөрчлөлт урьд нь байгаагүй

шинэ хүсэл хэрэгцээг байнга бий болгож байдаг. Хэрэглэгчдийн хүсэл хэрэгцээний хамаарал нь бюрократ тогтолцоонд эдийн засаг, соёлын шинэ нөлөөллийг бий болгож байдаг. Иргэдийн эмх журам, аюулгүй байдлыг хүсэх хүсэл нь бюрократын хөгжилд нөлөөлөл үзүүлнэ. Мөн орчин үеийн техник, технологийн хөгжил, мэдээлэл харилцааны хэрэгсэл нь төрийн хяналтыг улам шууд өсгөх бөгөөд удирдлагын хариу үйлдэлд шууд бусаар нөлөөлдөг байна.

Бюрократ байгууллагын өсөлтийн шалтгаан нь түүний бусад бүх төрлийн байгууллагуудаас давуу байдаг чанарт оршдог. Бюрократ дэг журам нь тодорхой болон тодорхойгүй байдал, хурд, баримтын мэдлэг, үйл ажиллагааны тасралтгүй шинж, ажлын нэгдэл, хатуу захирагдах ёс, маргааныг бууруулах, болгоомжлол, материаллаг зардал зэрэг бүгдийг зохицуулдаг. Бюрократ нь зэрэгцээ бус (тодорхой дүрмүүдийн дагуу, хэн гэдгээс нь үл хамааран ажлаас чөлөөлөх)-ийг ашиглана. Иймээс бюрократ хөгжих тусам “хүнийсэлт” өсөх болно. Олон талт, тусгайлсан дүгнэлт нь хараат бус “мэргэжилтэн”-ийг шаарддаг.

Бюрократ байгууллагын үйл ажиллагааны шинж чанарыг авч үзвэл кадийн, түгээмэл болон Ромын хуулийг илүү баримтлах хандлага ажиглагдана. Кадийн хууль нь “чанд хатуу ёс журам болон бусад албан бус үнэлэмж”-үүдээс бүрддэг. Харин эмпирик буюу түгээмэл хууль нь баттай болж өнгөрсөн үйл явдал дээр суурилсан бий болдог. Зөвхөн Ромын хууль нь дүгнэлт болон эргэцүүлэл, “шийдвэрийн дүрэм”-ээр тогтоогдох албан ёсны шийдвэрт суурилдаг. Герман болон Англи дахь хуулийн тогтолцооны ялгаа нь эдийн засаг бус улс төрийн хүчин зүйлээс бий болсон эрх мэдлийн хүчин зүйлүүдээс бүрдсэн байдаг. Хэдийгээр шүүх үйл ажиллагаа нь хуулийн хөгжилд хувь нэмэр оруулсан ч гэсэн Ромын хууль дахь бюрократ шинж чанар түүнийг албан ёсны шинжлэх ухаанч болгосон юм. “Мэргэжсэн” байдал өндрөөр үнэлэгддэг гэдэг нь ерөнхий болон абстракт дүрмүүд адил үйлчилнэ гэсэн үг биш юм. Хүн бүр “ямар ч цоорхойгүй хууль” бол боломжгүй зүйл гэж үздэг хэдий ч тэд Кадийн хуулийг бус харин захиргааны үйлдэл бүрийн ард ямар нэгэн “объектив оршихуйн шалтгаан” байх хуулийг хүсдэг байна. Ийм үзэл бодол нь өөрийн хүчийг хадгалах гэсэн бюрократ инстинктэй салшгүй холбоотой юм. Ардчиллыг шингээсэн зохимжтой хууль ч гэсэн заримдаа ардчиллыг хөгжүүлэх болон түрэмгийллийг зогсоход нэмэр болж чаддаггүй.

Бюрократ тогтолцоо нь нөөцийн төвлөрөлтэй салшгүй холбоотой бөгөөд өөрөөр хэлбэл, удирдагчийн гарт буй удирдлагын арга хэрэгслүүд засаглалын нөөц болдог. Хэдийгээр бюрократ дэглэм нь “дийлдэшгүй эрх мэдэл”-тэй боловч түүний хөгжлийн зам нь дардан байгаагүй. Түүхээс үзвэл, зэвсэгт хүчин бюрократаас хамааралтай болсон нь хөрөнгөтэйгээс хөрөнгөгүй болж шилжсэнтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, соёл болон эдийн засгийн хөгжлийг дагаж хөрөнгөтэй эрчүүд нь дайнд тохиромжгүй гэж үзэх болсон байдаг. Бюрократ тогтолцооны тусламжтайгаар зэвсэгт хүчин илүү том, мэргэжлийн, байнгын, үндэсний шинжтэй болсон байна. Төр болон их сургууль зэрэг бусад орчинд ч ялгаагүй бюрократ удирдлага нь бүхэлдээ төсвийг нь хянадаг болж, ингэснээр захирах захирагдах иерархи ёсыг бүрэн баталгаажуулсан юм. Удирдлагын арга хэрэгслийн төвлөрөл нь бюрократ тогтолцооны засаглалын гол нөөц болдог байна. Нийгмийн болон эдийн засгийн давхраажилт нь бюрократын хөгжилд тустай. Тухайлбал, орчин үеийн ардчилал дахь “хуулийн өмнө тэгш эрх”-тэй байх, “эрх дархаас” айх айдас, бизнесийг “алхам алхмаар” хийх үйл байдал нь дээд удирдлагын удирдах эрхийг халдашгүй байх боломжийг олгож байдаг. Учир нь эдгээр асуудлууд нь өөрөө бюрократ

зохицуулалтуудыг зайлшгүй шаарддаг байна. Бюрократ албан хаагчдын цалин хөлс нь ажилласан цагаас бус харин зэрэг дэв, ажилласан жилийн хугацаанаас хамаарна. Мөн тэдэнд тэтгэвэр олгогдоно. Албан хаагчид бюрократ системд “тушаал” дэвшсэнээр илүү чухал байр суурь, өндөр цалинтай болж, нийгмийн давхраажилтын шат ахидаг.

Ардчилал нь эцэстээ бюрократ дэг ёстой зайлшгүй сэргэлддөг бөгөөд үүний учир нь ардчилал иерархи автократыг тэвчихгүй. Ардчилал нь албан тушаалд байх хугацааг хамгийн бага байлгахыг зорих боловч зөвхөн мэргэжсэн хэн нэгнээс илүү янз бүрийн хүмүүс сонгогдох боломжийг олгодог. Гэвч бюрократ нь нийтээр хүлээн зөвшөөрөгдөж чадашгүй бүлэг хүмүүсийг томилох төдийгүй олон нийтийн үзэл бодлоос илүү өөрсдийн албархаг ёс журмыг хадгалахыг хичээдэг. Вебер “идэвхгүй ардчилал” гэдгээр “Аж ахуй ба нийгэм бүтээлдээ” захиргааны давхраажилтыг илэрхийлсэн. (985-986 хуудсыг харна уу) Ийм идэвхгүй ардчиллын хөдөлгөгч хүч нь эдийн засгийн аль эсвэл улс төрийн харилцаа байдаг.

Рационал бюрократ нь устгахад хамгийн хэцүү дэглэм юм. Бюрократ нь нийгмийн аливаа үйлдлийг зохион байгуулалттай үйлдэл болгон хөрвүүлэх хэрэгсэл учир “бюрократ аппаратыг удирдагчийн хүч чадлын эх сурвалж” мөн гэж Вебер үзсэн. Бюрократ дэг журам хүчтэй байдгийн учир нь “...бусад нөхцөл адил үед, зохион байгуулалттай, төлөвлөсөн үйлдэл нь бусад коллектив зан чанарын бүх хэлбэр болон нийгмийн эсрэг үйлдлээс нь илүү хүчтэй байна. Удирдлага нь бүрэн бюрократ болох үед, түүнийг дагалдах дээд эрх мэдлийн систем нь устгагдашгүй юм.”³⁴ Бюрократ дахь хувь хүмүүс нь “өөрийнхөө эдийн засгийн болон хийсвэр оршихуйтайгаа бүрэн хамааралтай” байдаг. Ихэнх тохиолдолд тэрхүү хувь хүн зогсошгүй хөдөлж буй механизм дахь том араануудын бяцхан шүд нь юм.”³⁵

Вебер бюрократ механизмын оройд нь байхгүй л бол юуг ч эхлүүлж, бас зогсоож чадахгүй. Удирдуулж буй хүмүүс бюрократ аппаратыг зогсоож чадахгүй, хэрэв тэгэх гэж оролдвол энэ нь нийтийн хямралд хүргэнэ. Олон нийт бюрократ байгууллагуудаас материаллаг хэрэгцээ нь бүрэн хамааралтай байдаг. Тэд үүнийг сольж чадахгүй бөгөөд бюрократ бол “тусгайлсан бэлтгэл, ажлын мэргэшсэн байдал болон нарийн төвөгтэй ажил үүргүүдийн нэгдэл” байдаг. Иймээс бюрократ нь устгагдашгүй төдийгүй хувь хүнээс хамааралгүй. Тийм учраас хэн нэгэн түүнийг гартаа оруулсан цагт хөдөлгөхөд маш амархан зүйл. Дайсан этгээд ч түүнийг атгасан бай, түүнийг зогсоохгүй байх нь хүн бүрийн хүсэлд нийцнэ. Бюрократ тогтолцоо ингэж “хувьсах” явцдаа эрх мэдлийн улам боловсронгуй тогтолцоог бий болгож, хэзээ ч устгагдашгүй болж ирнэ.³⁶ Эдгээр нь бюрократ тогтолцооны объектив болон субъектив үндэс юм.

Бюрократ системийн үр дагавар нь түүний эрх мэдлийг хэрхэн яаж хуваарилж буй аргаас шалтгаалах боловч, гол төлөв “нууц-язгууртны тогтолцоо”-нд хүрнэ. Түүний эдийн засгийн нөлөө нь эдийн засгийн бүтцээс шалтгаалан янз бүр байна. Гэхдээ нийгэм дэх үр дагавар нь давхраажилт юм.³⁷

³⁴ Max Weber. *Economy and Society*. 1978 by The Regents of the University of California Press, Berkeley and Los Angeles. Page 987.

³⁵ Max Weber. Мөн тэнд. Page 988.

³⁶ Max Weber. *Economy and Society*. 1978 by The Regents of the University of California Press, Berkeley and Los Angeles. Page 989.

³⁷ Max Weber. Мөн тэнд. Page 990.

Устгагдашгүй байна гэдэг нь бюрократад шууд маш их хүч чадлыг олгохгүй. Гэхдээ рационал бюрократын хүчний нөлөө нь үргэлж маш их бөгөөд жирийн нөхцөлд төрийн өндөрлөгөөс харахад бүх зүйл жижиг байна. Бюрократ нь угаас өөрсдийн мэдлэг болон зорилгоо нууцлана. Бүхнийг гартаа атгасан бюрократ өмнө абсолют монарх ч, ерөнхий сайд ч бай хүчгүй, учир нь түүний гарт хуулиар баталгаажсан бүхнийг удирдах монополь эрх бий. Зөвхөн бизнес дэх хувийн хөрөнгөтний бүлэг л бюрократыг илүүг мэдэж чадна, учир нь амьд үлдэхийн тулд үнэн мэдлэгийг чухалчлан авч үздэг.³⁸

Бюрократ нь “бодлоготой” амьдралын хэв маягийг дэмжиж, мэргэжсэн байх чанарын хөгжилд түлхэц үзүүлнэ. Бюрократ дахь мерит системийн шалгуур нь хувь хүний хөгжил, боловсролд чухал нөлөө үзүүлдэг. Гэхдээ ийм шалгалтын систем нь эрх мэдэлт “явцуу анги”-аас эмээх үзэгдлийг бий болгоно. Энэ тогтолцоо нь шалгалтаар олгогддог боловсролын зэрэг, цолны тусламжтайгаар хөгжих бөгөөд нэр нөлөөгөө эдийн засгийн ашиг болгох боломжтой гэсэн үг юм. Ийм үйлдлүүд нь бизнесийн болон нийтийн салбарт мөнхийн дархан эрхт давхрааг бүрдүүлнэ. Хуучны “соёлтой хүн” гэдэг ойлголтын оронд өнөөгийн бюрократад “мэргэжилтэн” гэдэг ойлголт гол үүрэг гүйцэтгэн тэд нийгмийг мэргэжлийн мэдлэгийн ноёрголоор удирдана.

Түүхэн хөгжлийн сүүлийн шатанд хүнд суртал буюу бюрократ нь хаа сайгүй болж ирсэн. Өнгөрсөн үе рүү улам холдох тусам хүнд суртал болон албархаг байдал бага байжээ. Хэдийгээр амьдралд яагаад захиргааны олон том институтийг зовоосон, хүнд суртлын байгууллага, хүнд сурталтан гэдэг эрх мэдэлгүй, битүү үг хэллэгтэй, зэмлэл дургүйцлийг агуулсан нэр томъёо олон нийтэд байнга хэрэглэгддэг нь иргэдийн тухайн өвөрмөц нөхцөл байдал бүхий хэрэг явдал, хүсэлтэд хандсан хатуу чанд дүрэм журамд тулгуурласан хүйтэн хандлага тэдний нарийн нягт нямбай, хичээл зүтгэлийг үгүйсгэх үндэс болдог. Бюрократ нь нэгэнт “оюун ухаант” чанартай учир хууль, төлөвлөгөө, эрх мэдэл гээд түүний бүх шинж нь хаа сайгүй өргөжин тэлж ямар нэгэн онцгой замаар “хувьсах” үр дүнг авчиран, ерөнхийдөө рационализмын хөгжлийг дагуулдаг байна.

Ашигласан ном:

1. Нигроу Ж, Нигроу Л. 1996. Орчин үеийн төрийн удирдлага. УБ., ТЗУХИ.
2. M.Weber The Essentials of Bureaucratic Organization: An Ideal-Type Construction. /Readin in Bureaucracy/ New York., 1968. The Free Press.
3. Max Weber. Economy and Society. 1978 by The Regents of the University of California Press, Berkeley and Los Angeles.

³⁸ Max Weber. Мөн тэнд. Page 994.

ИРГЭНИЙ НИЙГЭМ ГЭЖ ЮУ ВЭ?

И.Лхам

ХААИС-ийн нийгмийн ухааны тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор

Д.Болд-Эрдэнэ

ФСЭЗХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор

Түлхүүр үг: иргэн ба нийгэм, иргэний нийгэм, иргэний ниймийн парадигм, сонгодог философи парадигм, социологи-улс төрийн парадигм, нээлттэй нийгэм, иргэдийн эрх чөлөөг хэрэгжүүлэх чөлөөт орчин, төрийн бус байгууллага

Товч агуулга: иргэний нийгмийн асуудал философич болон улс төр судлаачдын анхаарлын төвд байдаг чухал тулгамдсан асуудал мөн. Иргэний нийгмийн асуудлыг улс төрийн философичд олон талаас нь янз бүрийн арга, хандлагаар авч үзсэн байдаг. Энэ удаа “иргэний нийгэм” хэмээх ойлголтын талаарх санаа бодлоо товчхон авч үзэхийг хичээв.

Иргэний нийгмийн асуудал нь орчин үеийн ардчиллын онолын судалгааны нэг томоохон бие даасан чиглэл болдог. Энэ нь иргэний нийгмийг орчин үеийн нээлттэй ардчиллын “дуу хоолой, нүд, чих” хэмээн үздэгтэй холбоотой. Иргэний нийгмийн асуудал нь үнэндээ саяханаас тавигдан, анхаарагдаж буй сэдэв биш, харин энэ нь хүн төрөлхтөний улс төрийн сэтгэлгээний хөгжлийн бүх цаг үед тавигдан судлагдаж ирсэн онол, үзэл баримтлалын түүхэн урт оюунлаг эх сурвалжтай юм.

Иргэний нийгэм нь хөгжлийн болон онол, сэтгэлгээний урт түүхэн замналыг тулжээ гэж үзэж болохоор байна. Иргэний нийгэм нь *түүхэн хөгжлийн хувьд* хүн төрөлхтөний иргэншсэн хөгжлийн замналтай холбоотой. Нийгэм, түүхийн үйл явцын хувьсал, өөрчлөлтийн явцад хүн төрөлхтөний иргэншсэн хөгжлийн ууган гурван голомт: Эртний Энэтхэг, Хятад, Грек, Римд үндсэндээ нэгэн зэрэг НТӨ VII зууны үеэс үүсэн хөгжсөн байна. Иргэншлийн энэ голомтуудаас хүн төрөлхтөний иргэншсэн хөгжлийн хоёр гол салаа зам эх үндсээ авчээ. Орон зайн хувьд бол Эртний Энэтхэг, Хятадын иргэншлээс *уламжлалт нийгмийн зам*, Эртний Грек, Римийн иргэншлийн хөгжлөөр *иргэний нийгмийн хөгжлийн зам* гараагаа авсан гэж ойлгож болно. Цаг хугацааны хувьд дундад зууны сүүл үе буюу XV-XVI зууны үе хүртэл иргэншлийн энэ хоёр салаа замаар хөгжиж байсан улс орнуудын хөгжлийн харилцан нөлөөлөл маш бага байснаа энэ үеэс (Сэргэн мандалтын үеэс Д.Б нар) эрчимжиж иргэний нийгмийн хөгжлийн загвар түгэн давамгайлах болжээ.³⁹

Хүн төрөлхтөний иргэншсэн хөгжлийн энэхүү түүхэн замналын онцлог иргэний нийгмийн талаарх *үзэл сэтгэлгээний хөгжилд* тод тусгалаа олсон гэхэд болох юм. Улс төрийн сэтгэлгээний хөгжлийн туулж ирсэн ерөнхий логикийг анзаарч үзэхэд XV-XVI зууны үе буюу сэргэн мандалтын үеэс иргэний

³⁹ Г.Чулуунбаатар. Иргэний нийгмийн төлөвшилийн онол, практикийн зарим асуудал. Шинэ толь №42, 50 дахь тал

нийгмийн талаарх улс төр, философи, социологийн шинжилгээ улам эрчээ авч хөгжиж байсан нь харагддаг. Чухам энэ үеэс иргэний нийгмийн талаарх уламжлалт сонгодог үзэл баримтлал орчин үеийн утга агуулгаараа төлжин хөгжиж, иргэний нийгмийн өнөөгийн үзэл санаа, онол, сэтгэлгээ эх ундаргаа авсан байдаг. Эндээс үзвэл орчин үеийн иргэний нийгмийн судалгааны эхлэх цэг нь Эртний Грек, Римийн оюунлаг уг сурвалжаас эхлэлтэй болох нь ойлгогдож байна. Харин иргэний нийгмийн прагматик судалгаа коммунизм, түүний утопи төсөөлөлийн сүйрэлтэй давхцан улам сэргэн идэвхжсэн байдаг.

Иргэний нийгмийн судалгааны явцад ерөнхийдөө үзэл баримтлалын хоёр *үндсэн парадигм* оршин үйлчилж байжээ. Үүний *эхнийх нь* нийгмийн тодорхой төлөв байдал, амьдралын бүхэл хүрээгээр тодорхойлогддог иргэн төвт нээлттэй нийгмийн тогтолцоо гэж үздэг *сонгодог философи парадигм* (Платон, Аристотель, Кант, Гегель, Маркс, Поппер); *нөгөө нь* нийгэм дэх төрийн биш бүх төрлийн харилцаа, иргэдийн төрөөс гадуур өөрийгөө илэрхийлэх болон *төрөөс хараат бус нийгмийн хүрээ* гэж үздэг орчин үеийн *социологи-улс төрийн парадигм* (Ж.Локк, Ш.Л. Монтескье А.Токвилл, Р.Дарендорф, Ю.Хебермас) зэрэг юм.

Иргэний нийгмийн талаарх сонгодог философи баримтлалыг орчин үеийн хэлбэрт “хөвөрүүлэн” үндэслэсэн философич бол Гегель юм. Гегель хэдийгээр иргэний нийгмийг тайлбарлалын өргөн агуулгын түвшинд авч үзэж, түүнийг амьдралын бүх хүрээгээр тодорхойлогддог нийгмийн хөгжлийн тодорхой төлөв байдал гэж үзэж байсан боловч энэ хүрээнд иргэнийг гол төвд нь тавьж, иргэний нийгмийг гэр бүл, төрийн хооронд тархсан, хувийн сонирхлынхоо дагуу харилцан уялдаж, хамтран үйлдэж буй хувь хүмүүсийн нэгдэл гэсэн агуулгаар ойлгон тайлбарлаж байв. Тэрээр “ Иргэний нийгэм нь төр, гэр бүлийн хоорондын ялгарал юм. Гэхдээ иргэний нийгмийн хөгжил нь төрийн хөгжлөөс хожимдож явагддаг. Учир нь иргэний нийгмийн ялгаралд төр тустай...”⁴⁰ Эндээс үзвэл Гегель иргэний нийгэм нь төр, гэр бүл хоёрын завсрын иргэний оршин үйлдэх орон зай, тэдний харилцааны хэлбэр гэсэн чухал дүгнэлтийг анх хийж байсан нь анзаарагддаг.

Иргэний нийгмийг нийгмийн хөгжлийн тодорхой төлөв байдал, иргэн бүрийн хувийн эрх чөлөөг бүх талаар дээдлэн эрхэмлэсэн нээлттэй нийгмийн тогтолцоо гэж ойлгох философи парадигмын хөгжилд К.Попперийн “Нээлттэй нийгэм ба түүнд дайсагнагчид” номондоо боловсруулан тавьсан үзэл санаа онцгой үүрэг гүйцэтгэсэн байна. Тэрээр иргэний нийгмийг “иргэдийн хувийн чөлөөт харилцаа, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлсэн тэдний нээлттэйгээр хамтран орших орчин”⁴¹ гэсэн агуулгаар ойлгон төсөөлж байсан нь ойлгогддог. Хөгжингүй иргэний нийгэм ардчиллыг бэхжүүлэхэд түлхэц болдог гэсэн ойлголт зөвхөн сүүлийн 20 гаруй жилд гарч ирсэн юм биш, харин хүн төрөлхтөний улс төрийн сэтгэлгээний хөгжлийн урт удаан хугацааны уламжлалтай юм. Энэ нь түүхийн шинэ цаг үеэс Ж.Локкоос эхлэн Ш.Л.Монтескье, А.Токвилл, Р.Дарендорф болон Ю.Хабермас нарын хөгжүүлсэн үзэл санааны үнэт зүйлстэй холбоотой. Тухайлбал энэ нь төрөөс хараат бус, улс төрөөс ангид *иргэдийн социал хүрээ* \ Ж.Локк, А.Смит \; эрх мэдлийг зохистой хуваарилаж, эрх чөлөөг баталгаажуулан, хуулийн дагуу засаглахад чиглэгдсэн *иргэдийн*

⁴⁰ Г.В.Ф. Гегель. Философия права. М., 1990, С. 228

⁴¹ К.Поппер. Нээлттэй нийгэм, түүний дайснууд”I, II –боть. Уб., 2006, 2009 үзнэ үү.

сайн дурын байгууллага, эвсэл, холбоодын хяналтын хэлбэр \ Ш.Л. Монтескье \; иргэдийн чөлөөт эвсэл холбооны цогц \ А.Токвилл \; хувь хүнд төрийн оролцоогүйгээр амьдралын боломж олгодог ертөнц \ Ральф Дарэндорф \; эрх ашиг институтчлэгдэхийн өмнөх үеийн албан бус олон ургальч эрх ашиг, сонирхлыг илрүүлэх, цэгцлэх хэлбэр \ Юрген Хебермас \ гэсэн баримтлалууд юм.

Иргэний нийгмийг тодруулж үзэхэд “иргэн”, “нийгэм” гэсэн ойлголтын утга учир тэдгээрийн харилцан хамаарлын тухай асуудлыг юуны түрүүнд анхааран үзэх учиртай. Тэдгээр ойлголтын утга чанар нь мэдлэгийн олон салбар болон тэдгээрийн зааг уулзвараас тайлбарлаж болох философи-социологийн өргөн багтаамжтай юм.* Иргэний нийгэм гэдэг нь энгийн агуулгаар “иргэн”, “нийгэм”-ийн харилцан хамаарлын бүхэл бүтэн орчин, нийгэм дэх иргэдийн оршин үйлдэх орон зай гэдэг нь ойлгогдож байна. Тэгэхдээ энэ орон зай, түүн дэх харилцааны шинж байдал, онцлог нь ямар байж болох вэ? гэдгээс түүний утга чанар тодрох учиртай.

Иргэнийн нийгмийг бодитой ойлгон баримжаалахад **нэгд** иргэн, нийгэм хоёрын харилцааны хэлбэр; **хоёрт** иргэдийн төр, гэр бүлийн хоорон дахь завсрын орон зай; **гуравт** иргэдийн сонирхлын чөлөөт сонголтонд суурилсан иргэнлэг чөлөөт бүтэц; **дөрөвт** иргэдийн хувийн сонирхолд суурилсан хамтын үйл ажиллагааны хэлбэр гэсэн суурь санааг анхааран үзэх хэрэгтэй болдог. Ингэхлээр иргэний нийгмийн утга агуулга нь олон хувилбартай болох нь ойлгогдож байна. Энэ тухай академич Г.Чулуунбаатар онцлон бичихдээ: “Иргэний нийгэм” гэдэг үгийн *явцуу утга* нь олон хувилбартай бөгөөд гол төлөв иргэний нийгмийн төлөвшлийн үндсэн шинж, бүрдэл хэсгүүдийг илэрхийлсэн агуулгатай болно. Тухайлбал, *төрөөс гадуурхи байгууллагуудын нийлбэр цогц; нийгэм дэх төрийн биш бүх төрлийн харилцаа; чөлөөт иргэдийн өөрийгөө илэрхийлэх хүрээ* гэх мэт. Иргэний нийгэм бол өөрөө хөгжих дотоод уг сурвалж бүхий тогтолцоо юм.⁴²

Орчин үед иргэний нийгмийг бодлогын прагматик агуулгаар бичиж тайлбарлах явдал түгээмэл болжээ. Улс төрийн толь бичиг, ном сурах бичгүүдэд: “Иргэдийн хувийн амьдралын болон төрийн үйл хөдлөлийн хүрээ хоёрын завсарын орон зай дахь хамтын амьдрал, нийтэд нээлттэй талбарыг иргэний нийгэм хэмээн нэрийддэг.”⁴³, “Иргэний нийгэм” нь хувь хүн ба төр засгийн хоорондох орон зайг нөхөж байдаг бөгөөд мэргэжлийн, шашны, соёлын гэх мэт төрөл бүрийн сайн дурын бүлэг, холбоодоос бүрддэг.”⁴⁴ “ Хүний амьдрал, үйл ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах, хувь хүн ба нийгмийн бүлгүүдийн янз бүрийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэх бүх талын боломж олгосон нийгмийн харилцаа, түүний хэлбэржсэн ба хэлбэржээгүй бүтцийн нийлбэр

* *Тайлбар*: энэ удаад тэдгээр ойлголтын агуулгыг тусгайлан тодруулж үзсэнгүй болно.

⁴² Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. Уб., 2009. 261-262 дахь тал.

⁴³ Ардчилсан засаглал, нээлттэй нийгмийн нэр томъёоны тайлбар толь. Уб., 2006. 61 дахь тал.

⁴⁴ Ц.Даваадулам. Засаглалын үзэл баримтлал, нэр томъёоны тайлбар толь бичиг. Уб., 2010. 22 дахь тал.

цогцос”⁴⁵гэх мэтээр тайлбарлаж байна. Иргэний оролцоог дэмжих дэлхийн холбооны Иргэний нийгмийн индекс \сивикусын индекс\ боловсруулахад баримталж буй тодорхойлолтоор иргэний нийгэм бол “ гэр бүл, төр, зах зээл зэргээс гадуур оршдог иргэдийн эвсэлдэн нэгдэж, нийтлэг эрх ашгийнхаа төлөө үйл ажиллагаа явуулдаг талбар мөн” гэсэн байдаг. Тэгвэл судлаач С.Соёлмаа “ Иргэний нийгэм бол төр ба гэр бүлийн институт хоорондын хувь хүн, нийгмийн бүлэг, холбоо, эвслийн үүрэг, үйл ажиллагаанд биелэлээ олсон; зөрчилт шинжтэй; техногений үед бий болсон иргэншлийн бүтэц, хэлбэрийн нэгдэл юм” гэсэн анхаарал татаж байна.⁴⁶

Энэ бүхнээс үзвэл иргэний нийгмийн гол агуулга нь дараах зүйлээр тодорхойлогдож байна. Үүнд:

- Иргэдийн үйл ажиллагааны төрийн гаднах буюу *төрийн бус хүрээ*
- Гэр бүл, төр, зах зээлээс гадуур оршдог иргэдийн эвсэлдэн нэгдэж, *нийтлэг эрх ашгийнхаа төлөө үйл ажиллагаа явуулдаг талбар*
- Нийгэм дэх *сонирхлыг илэрхийлэх арга, механизм*
- Бие даан зохион байгуулагдсан чөлөөт үндсэн дээр нэгдсэн олон тооны *иргэдийн сайн дурын байгууллага, холбоодын бүтэц, тэдний хараат бус үйл ажиллагааны хүрээ* юм.

Хэдийгээр ингэж иргэний нийгмийг янз бүрээр тодорхойлдог ч эцсийн дүндээ энэ нь *төр зах зээлээс тусдаа нийтлэг хэрэгцээ ашиг сонирхолтой, харилцан ойлголцол, оролцоо, хамтын ажиллагаа, тэгш байдал зэрэг үнэт зүйлсийг баримжаалдаг иргэдийн сайн дурын холбоодын бүтэц, тэдний аливаа гадны нөлөөллөөс хараат бус ажиллагааны хүрээ* юм.

Орчин үед иргэний нийгмийн үр ашигтай бодитой хяналт, үйл ажиллагаа ус агаар мэт хэрэгтэй байна. Үүнтэй холбоотой өнөөгийн нийгэмд иргэний нийгмийн үүрэг асар их өсч байгаа юм. Улс төрийн шинжлэх ухаанд иргэний нийгмийн үндсэн үүргийг **нэгд** бодлогын шинжилгээ хийх, сурталчилгаа явуулах; **хоёрт** төрийн байгууллагуудын ажлын үр дүн, төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, ёс суртахууны байдалд хяналт тавих; **гуравт** нийгмийн капитал бий болгох, иргэдэд тэдний үнэт зүйлс, итгэл үнэмшил, иргэний харилцааны хэм хэмжээ, ардчиллын практикийг таниж мэдрэх, илэрхийлэхэд туслах; **дөрөвт** нутгийн иргэдийн тодорхой бүлэг, ялангуяа хүн амын эмзэг, гадуурхагдсан хэсгийг зохион байгуулалтанд оруулж, улс төр, нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах; **тавд** гишүүдийнхээ болон бусад иргэдийн аж амьдралыг дээшлүүлэхэд чиглэсэн хөгжлийн үйл ажиллагаа явуулах замаар сайн засаглалыг гүнзгийрүүлэхэд хувь нэмрээ оруулах явдал гэж үзэж байна.⁴⁷ Эндээс үзвэл ардчилал дахь иргэний нийгмийн гол чиг үүрэг нь дараах байдлаар илэрч байна. Үүнд:

⁴⁵ Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. Уб., 2009. 263 дахь тал.

⁴⁶ С.Соёлмаа. “Иргэний нийгэм” хэмээх ойлголтын тухайд. Эрдмийн ертөнц. 2012 \2 (07) 54 дахь тал.

⁴⁷ Айша Гаус-Паша. Засаглалд иргэний нийгмийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг. Төрийн захиргаа ба ардчилсан засаглал: иргэддээ үйлчилдэг засгийн газар. Уб., 2008. 144 дэх тал.

- ❖ Төрөөс иргэдийн хувийн амьдрал, эрх чөлөөнд халдахаас хамгаалан баталгаажуулах
- ❖ Төрийн эрх мэдэлд ажиглалт хийн хяналт тавих
- ❖ Иргэдийг ардчилсан оролцооны чиглэлээр нийгэмшүүлэх
- ❖ Төрийн шийдвэр гаргах байгууллагуудад ардчилсан элитийг дайчлан оролцуулах
- ❖ Улс төрийн нам, парламентаас гаднах эрх ашгийн үнэт зүйлс, сонирхлын олон ургальч байдлыг илрүүлэх буюу сонирхлын артикуляци хийх
- ❖ Орон нутгийг ардчилах, нийгмийн зөрчлийг намжаах, нийгмийн зөвшөлцлийг бүрдүүлэх
- ❖ Иргэдийг нийгэмшүүлэх, гэгээрүүлэх, бодлогын шинжилгээ, сурталчилгаа хийх зэрэг юм.

Иргэний нийгмийг зөвхөн төрийн бус байгууллагууд \ ТББ \-тай адилтгах нь нийтлэг байдаг. Гэвч төрийн бус байгууллагууд нь дангаараа иргэний нийгмийг төлөөлөхгүй. Хэдийгээр ТББ нь иргэний нийгмийн нэг бүрдэл боловч нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд иргэдийн оролцоог идэвхжүүлэх, бодлогод нөлөөлөхөд чухал, заримдаа бүр онцгой үүрэг гүйцэтгэх нь байдаг. Энэ тухай Ю.Хабермас бичихдээ: “Иргэний нийгмийн байгууллагын гол цөм нь сайн дурын үндсэн дээр бий болсон төр ба эдийн засгийн бус нэгдэл байх ба тэдгээр нь сүм хийд, соёлын нэгдэл, академи, бие даасан зуучлалын хэрэгсэл, чөлөөт цаг, спортын нэгдэл, шүүмжлэл маргааны идэвх санаачлагыг өөртөө багтааж улмаар эдгээр нь цаашлаад мэргэжлийн нэгдэл, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл мөн альтернатив институт болж үргэлжилдэг”⁴⁸гэсэн байдаг. Ингэхлээр иргэний нийгмийн байгууллагын хүрээнд төрийн бус байгууллага, улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, хэвлэл мэдээллийн байгууллага, шашны бүлгүүд, худалдаа, үйлдвэрлэлийн танхим, сууц өмчлөгчдийн холбоо эрүүл мэнд, соёл урлаг, спорт, чөлөөт цаг гэх зэрэг чиглэлээр бий болсон иргэдийн сайн дурын албан бус бүлгүүд буюу төрийн бус статустай бүхнийг иргэний нийгмийн бүтцэд багтдаг байна.

Summary

Now the problem of civil society is in the center of attention of researchers. There are many concepts of civil society. In the article the author is dealing with issues around civil society.

⁴⁸ Habermas J. “Strukturwandel der Öffentlichkeit” Fr.a. M.,1990, С. 45 (дам ишлэв)

УЛС ТӨРИЙН ИМИЖ: ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**У.Батцэрэн***ШУА-ын ФСЭЗХ-ын Улс төрийн секторын ЭША, МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн докторант***Түлхүүр үг:** Имиж, улс төрийн имиж, имижийн хэв маяг, технологи

Товч утга: Image гэдэг үг нь шинж төрх, нэр хүнд гэсэн утгатай англи үг бөгөөд улс төрийн агуулгаараа зориудын реклам, сурталчилгаагаар бий болгосон улс төрийн зүтгэлтний нэр хүнд юм. Улс төрийн имиж нь улс төрийн зүтгэлнийг олон түмэнд тааламжтай эерэг харилцааг бий болгоход голлон нөлөөлнө. Имиж нь улс төрчийн ба сонгогчийн хоёулангийн ашиг сонирхолыг хангахын тулд үйлчилж, ашиг сонирхолуудыг нь нэгтгэхийг хичээдэг. Энэ нь сонгогчдын төрийн бодлогод өөрийн шаардлагаа хүргүүлж байх хүнтэй байх эрмэлзэл, түүнд нь нийцүүлэн эрх мэдэлтэ болох гэсэн улс төрчийн хүслээр илэрч байгаа юм. Ийм учраас тэдгээрийн хоорондын зүй зохистой харилцаа нь улс төрийн харилцааг зөв замаар хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм. Улс төрийн субъектэд өөрийн имижээ бүрдүүлэх асуудал нь туйлын чухал байдаг. Нийгэм, улс төрийн өдөр тутмын амьдрал, бүх шатны сонгуулийн үед нэр дэвшигчдийн имиж бүрдүүлэлтэнд төрөл бүрийн туслалцаа үзүүлэх, улс төрийн үйл ажиллагааг зохион байгуулах арга зүй, аргачлал, дадал туршлагыг өндөр түвшний зөвхөн улс төрийн имижмейкерүүд хийж гүйцэтгэдэг.

ИМИЖ

Улс төрийг, төрийг жолоодох урлаг болохынх нь хувьд хувь хүн, улс төрийн нам, улс төрийн хошуучлагчийн улс төрийн үйл явцыг өрнүүлэгчийн хувьд, сонгогч-сонгогдогч хоёрын хоорондын боломжит зохистой хэлхээ холбоог бүрдүүлэх болон улс төрийн үйл явцыг тавьсан зорилгодоо захируулах, улмаар үүнийхээ тусламжтайгаар гарах үр дүнг тодорхойлж чаддаг байх нийгэм-улс төрийн хэрэгцээ захиалгаар имиж судлалын шинжлэх ухаан үүссэн.

Image гэдэг үг нь шинж төрх, нэр хүнд гэсэн утгатай англи үг бөгөөд улс төрийн агуулгаараа зориудын реклам, сурталчилгаагаар бий болгосон улс төрийн зүтгэлтний нэр хүнд юм. Имиж нь бизнесийн салбарт бүтээгдэхүүнээ худалдан, борлуулах, үйлчлүүлэгчдээ нэмэгдүүлэхийг зорьдог. Имиж нь урт удаан хугацааны туршид бүрэлдэж, өсөж, унаж, сарниж, бүдгэрч, тодорч байдаг үйл явц юм.

Имиж нь нийгэм-улс төрийн /оюун санааны/ ба эдийн засгийн /материаллаг/ орчноос ханамж авах хэрэгцээ, түүнийгээ хангах хэрэгсэлтэй холбоотойгоор бүрэлдэн тогтдог. Имиж өнөөгийн нийгмийн бүх хүрээнд, улс төр, эдийн засаг, соёл урлаг, сонирхолын бүлэг, мэргэжлийн байгууллагад ч байдаг зүйл бөгөөд ямар имижтэй байгаа эсэх нь тэдний ажил үйлс, амжилт ихээхэн шалтгаалж байдаг. Ромын католик сүм хийдэд ч өөрийн гэсэн имиж байдаг. Ромын Папын дэргэд түүний имижийг бүрдүүлэх үүрэгтэй бүхэл бүтэн

алба ажилладаг байна. Хамгийн гол нь имижийг амжилттай, сайн бүрдүүлнэ гэдэг бол хэцүү, харин нэгэнт бүрдсэн имижийг үгүй болгох маш амархан, хэдхэн хормын асуудал гэдгийг ойлгох нь хувь хүн, байгууллага мөн имижийг бүрдүүлж буй мэргэжилтэн нарт хамгаас чухал зүйл юм.

Олон түмний харилцаа нь улс төрийн хүрээнд төлөөллийн ардчилалын механизмаар дамжуулан төр засгийн үйл ажиллагаанд оролцох, хүсэл эрмэлзлэлээ илэрхийлэх үйлдлүүд нь тодорхой “бие” хүнээр илэрдэг. Энэхүү харилцаа нь субъектив-объектив хэмээх хоёр хүчин зүйлийн хоорондох харилцан үйлчлэлийн үр дүнд үүсдэг. Иймд субъект тодорхой арга хэрэгслийн тусламжтайгаар объектоо хянах буюу объектдоо хянуулах болдог. Тэрхүү арга хэрэгслийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь тухайн субьектийн имиж мөн. Үүнийг маш олон арга хэрэгслээр бий болгодог.

Имиж нь хувь хүн, байгууллага, үйл явцын мөн чанарыг илэрхийлдэг хэлбэр юм. Бид өөрсдөө мэддэггүйч амьдралд тухайн хүнийхээ имижийг нь үндэслэн тухайн хүнтэй харилцаж, түүнийг дүгнэн хэлэлцэж мөн түүнд санал өгдөг.

Английн судлаач Элери Семпсон “Таны хувийн имиж бол таны зураг юм. Та имижгүй байж чадахгүй. Та хүссэн ч бай, хүсээгүй ч бай бусдад үзүүлэхээр өөрөө сонгож авсан тэр л зүйлийг хүмүүс харж байдаг.”⁴⁹ гэжээ. Имиж нь бидэнд ямар нэгэн хэлбэр агууллагаар дамжин илэрч буй үзэгдэл юм. Бид юмыг төсөөлөн бодохдоо имижээр нь ойлгон дүрсэлдэг. Жишээ нь: багш хүн гэхээр шил зүүсэн, хавтас барьсан, костюмтай, их мэдлэгтэй хүнээр харин, эмч хүн чагнуур зүүсэн, цагаан халаадтайгаар бидэнд тус тус төсөөлөгддөг.

Хэвлэл мэдээлэл, цуу яриа, хийж бүтээсэн зүйл, өөрийн баримтлан хэрэгжүүлж буй үзэл суртлын үр дүнд имиж нь тогтон төлөвшихдөө өөрийн гэсэн хэд хэдэн арга замаар бий болох боловч ерөнхийдөө хоёр үндсэн хандлагаар бүрэлдэнэ. Үүнд:

1. Жам ёсны үүсэл. Монголчуудын амьдардаг гэрийн хаалга намхан байдгийн учир нь гаднаас орж ирж буй хүн тухайн айлын гал голомтонд мөргөдөг. Энэ л монголчуудын зан заншил монголын имиж юм. Олон зуун жилийн түүхэн урт удаан хугацааны явцад бүрэлдэн бий болсон дүр төрх төсөөлөл нөгөө л имиж гэдэг зүйл.
2. Зохиомлоор үүсгэх буюу имиж бүрдүүлэх. Энэ нь тухайн объект /хувь хүн, улс төрийн хошуучлагч, улс төрийн нам, байгууллага, үйл явдал гэх мэт/-ыг нийгэмтэй, олон нийттэй харилцаа холбоо тогтоох замаар дамжуулан холбож уг объектын имижийг өсгөх зорилгоор ямар нэг субьект тухайн объектын имижийг хийж өгдөг. Уг субьектыг имижмейкер гэнэ.

Имижмейкер нь имижийг бүтээхдээ

1. Имиж өсгөх

⁴⁹ Ганхуяг.Д. “Хошуучлагчийн улс төрийн имиж түүнийг бүрдүүлэхүй”. УБ., 2004.

- Унасан имижийг өсгөх, сэргээх
 - Нэгэнт тогтворжсон имижийг илүү өсгөн нэмэгдүүлэх
2. Имижийг хадгалах гэсэн үндсэн хоёр хандлагаар имижийг бүтээдэг. Өөрөөр хэлбэл нэгэнт тогтвортой, өндөр имижийг унагачихгүй хадгалан барьж байх үйл ажиллагаа юм.

Имиж яагаад хэрэгтэй байдаг вэ? Хэн нэгэнд ямар нэгэн хүний тухай эсвэл ямар нэгэн объектын тухай тодорхой санаа бодол, сэтгэгдэл төрж байвал энэ нь тухайн объектын талаар шийдвэр гаргахад нөлөөлж байдаг. Хэрэв ямар нэгэн хүн, объект танд таалагдаж байвал танд эерэг сэтгэгдэл, эерэг имиж төрж байна гэсэн үг. Харин танд таалагдахгүй байвал сөрөг имиж төрж байна гэсэн үг. Аливаа хүн өөрт таалагдсан хүнтэй хамтран ажиллах, түүнийг дэмжин, сонгохыг хүсч байдаг. Ийм учраас улс төрийн зүтгэлтнүүд, улс төрийн намууд нь олон нийттэй харилцаа холбоо тогтоож тэдний санаа бодолд эерэгээр нөлөөлөхийг эрмэлздэг. Ийм учраас улс төрийн хошуучлагчид, сонгуульд нэр дэвшигчид, улс төрийн намууд өөрсдийн имижийг бүрдүүлэхэд онцгой анхаардаг.

Имиж бүрдүүлэх шаардлагатай хүмүүсийг ерөнхийд нь гурван бүлэгт хувааж болох юм. Үүнд:

- Нэгдүгээрт: дэлхий нийтийн хэмжээнд болон олон нийтэд алдартай (имижтэй) хүмүүс орох бөгөөд тэдэнд имиж бүрдүүлэх эсэх талаар зарим хүмүүс эргэлзэж байдаг. Нэгэнт тэд олон нийтэд нэр хүндтэй, өндөр имижтэй байдаг учраас тэдэнд имиж бүрдүүлэх шаардлагагүй гэж зарим хүмүүс үздэг. Гэхдээ тэд хэдийгээр олон түмэнд танил болсон, өндөр нэр хүндтэй хүмүүс ч гэсэн аливаа үйл явдалд тэр тусмаа улс төрийн үйл ажиллагаа, улс төрийн сонгуульд оролцох шаардлага тулгарвал тэдний уламжлалт имижээс гадна улс төрийн имижийг бий болгох, олон нийтийн дунд тэднийг улс төрийн байр суурь, мэдлэг чадварыг таниулах шаардлага шинээр гарч ирдэг.
- Хоёрдугаарт: тухайн албан тушаал, эзэлж байгаа байр сууриа хадгалахыг эрмэлзсэн, шинэ өрсөлдөгчдөөс эмээн болгоомжилсон, сэтгэл зүйн хувьд түгшсэн байдалтай хүмүүсийг хамааруулан үзэж, тэдэнд өөрсдийн имижийг өсгөн нэмэгдүүлэх, шинээр имиж нэмж бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тулгарч байдаг.
- Гуравдугаарт: имижийн талаар зохих мэдэгдэхүүн байхгүй буюу эсвэл тэдэнд имиж хэрэггүй, тэдэнд имижмейкер хэрэггүй гэж үздэг хүмүүс байдаг. Энэ бүлгийн хүмүүстэй ажиллахад дээрх хоёр бүлгийн хүмүүстэй ажиллахаас илүү хүндрэл тохиолдож болох юм. Энэхүү бүлгүүдийн имижийг бүрдүүлэх нь сэтгэл зүйн онцлог, нийгмийн байр суурь, өөрсдийнх нь сонирхол, идэвхи чармайлт, үнэлэмж нь өөр өөр байх учир имиж бүрдүүлэх технологи нь харилцан адилгүй байдаг.

Математикийн энгийн үйлдлүүдэд хэрэглэгддэг дөрвөн хууль байдгийн адил имижд ч гэсэн мөн дараахи хуулиуд үйлчилдэг. Үүнд:

- Нэмэх хууль: энэ нь имиж зохицлын үр дүнд хүчтэй имиж улам хүчирхэгжиж тэр ч бүү хэл өөрт байдаг сул талаараа ч гэсэн

имижээ нэмэгдүүлж байдаг. Өөрөөр хэлбэл хошуучлагчийн хүчтэй имижийг улам нэмэгдүүлж, сул талыг давуутай имижрүү нь татан оруулж байдаг. Практикт ямар ч хүчтэй имиж өөртөө тодорхой нэг хэмжээгээр сул талуудыг агуулж байдаг. Имиж нэмэгдэх шалтгаан гэвэл хошуучлагч хүн өөрийн имижийн эерэг дүгнэлтийг өсгөхийн тулд нийгмийн сөрөг байдлыг нээн илрүүлэхийг оролддог явдал юм.

- Хасах хууль: имиж дэх сөрөг шинжүүд дотоод, гадаад хүчин зүйлийн улмаас улам ихсэх үзэгдэл байдаг. Жишээлбэл имиж сарних үзэгдэл байна. Зарим хүмүүс өөрийн имижийг өсгөхийн тулд өөрийн талаархи эерэг гэж үзсэн болгоноо олон нийтэд хүргэж, өөрийн сайн гэж үзсэн болгоноо өөрийн имижийг нэмэгдүүлэх зорилгоор өөртөө имиж нэмж хийхийг оролддог. Гэвч ингэснээр уг хүний имиж түүний бодсоноор нэмэгдэхгүй харин ч тухайн хүний өндөрт байсан имиж сарниж, буурах үзэгдэл ажиглагддаг.
- Хуваах хууль: имижийг бүхэлд нь авч үзэхээс гадна имижийг хэсэгчилж, хувааж авч үзэх хэрэгтэй байдаг. Энэ нь аль нэг имижийг тусгайлан авч үзэхэд тустай. Жирийн иргэд татвар нэмэгдүүлэхийн эсрэг байр суурьтай, энэ талаар сөрөг имижтэй байх нь баян чинээлэг хүмүүсээс төрөөс авах татварыг нэмэгдүүлэхийг дэмжихэд улс төрийн шийдвэр гаргагчдад нөлөөлдөг.
- Үржүүлэх хууль: имиж нь тусгайгаас ерөнхийд, ерөнхийгөөс тусгайд шилждэг. Сонгогчид саналаа нэр дэвшигчдэд өгөхдөө намын имижийг харгалзан үздэг бөгөөд энэхүү зүй тогтол нь урьдчилан төлөвлөгдсөн найруулгын дагуу өрнөөгүй тохиолдолд түүнийг зайлшгүй засах шаардлагатай болно. Америкчууд ийм зорилгоор спиндоктор гэсэн нэртэй шинэ мэргэжилтнүүдийг ашигладаг. /Спиндоктор нь хүрэх зорилгодоо нийцүүлж өгөгдсөн боломжуудыг сайтар тооцож ажилладаг мэргэжилтнүүд юм. Имижийг бүтээх томоохон үүргийг олон нийтийн санаа бодлуудын өгөгдлүүдийг өөрчлөх “мэдээлэл” гүйцэтгэдэг. Энэ нь коммуникаци орох хамгийн чухал цэг юм. Поль Лазерсфельд коммуникатив судалгааны мөн чанарыг хэн, хэнд, юуг, ямар байдлаар хэлсэн гэсэн бүрдлээр тодорхойлон гаргасан. Үүнийхээ үндсэн дээр тэрээр өөрчлөлт нь огцом шууд бус, харин тодорхой хугацааны туршид явагддагийг тогтоон илрүүлсэн./

УЛС ТӨРИЙН ИМИЖ

Улс төрийн имиж бүрдүүлэлт нь өөрийн гэсэн онцлог шинж, чанар бүхий арга хэлбэрүүдийн үр дүнд бий болсон нарийн цогц улс төрийн ухамсарын ойлголт юм.

Улс төрийн имиж нь улс төрийн зүтгэлнийг олон түмэнд тааламжтай эерэг харилцааг бий болгоход голлог нөлөөлнө. Имиж нь улс төрчийн ба сонгогчийн хоёулангийн ашиг сонирхолыг хангахын тулд үйлчилж, ашиг сонирхолуудыг нь нэгтгэхийг хичээдэг. Энэ нь сонгогчдын төрийн бодлогод

өөрийн шаардлагаа хүргүүлж байх хүнтэй байх эрмэлзэл, түүнд нь нийцүүлэн эрх мэдэлтэ болох гэсэн улс төрчийн хүслээр илэрч байгаа юм. Ийм учраас тэдгээрийн хоорондын зүй зохистой харилцаа нь улс төрийн харилцааг зөв замаар хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Чухам үүнд имиж судлал үйлчилж, сонгогч буюу олон түмний сэтгэл зүйн болон үнэлэмжийн орчин, тэдгээрт хүрэхэд мэдээллийн ямар сувгийг ашиглах, үр дүнг урьдчилан тооцох, эргэх харилцаа хэрхэн байх зэрэг өргөн хүрээтэй асуудлыг судалж байдаг нь имижлогийн шинжлэх ухааны учир холбогдол нь харагдах билээ.

Америкийн судлаач Полли Берд “Имиж нь таны үзэгдэх байдал, яриа хөөрөө, хувцас хунар, үйлдэл мөн түүнчлэн таны байгаа аксессуар, хүрээлэл, компани зэргийг багтаана” гэжээ. Үүнийг дүгнэж үзэхэд имиж нь хэд хэдэн зүйлийн бүрдэл болох нь ажиглагдаж байгаа боловч дөрвөн үндсэн зүйлд хувааж болох юм.

1. Хүрээлэлийн хүчин зүйлс: Тухайн хүний унаа, байр, ажлын өрөө, хэрэглэж буй гар утас, үзэг зэрэг багтана. Энэ нь хувь хүний төдийгүй хамт олны, пүүс компани, албан байгууллагын имиж болдог. Жишээ нь Сургууль бүр өөр өөрийн гэсэн имиж, нэр хүндтэй. Зарим сургууль чанартай сургалттай, лидерүүдийн сургууль хэмээн өөрийн имижээ бүрдүүлдэг бол зарим нэг нь огт ондоо байдаг. Сургуулийн имижээс таны имиж бас шалтгаалж болно. Харвардын их сургуулийг төгсөөд ирсэн хүнийг бид өөр нүдээр харна. Тэр хүн ч ондоо имижийг түгээдэг.
2. Габитор буюу гадаад хүчин зүйлс: Хувцаслалт, гадаад үзэмж, царай төрхийг илэрхийлсэн ойлголт “Хувцасаар нь угтаад ухаанаар нь үддэг” байсан бол өнөө үед “хувцасаар нь угтаад хувцасаар нь үддэг” болсон байна. Монголчууд бид зиндаархах гэж ярьцгаадаг. Энэ нэг их буруу зүйл биш. Бизнесийн гэрээ хийх гэж байгаа бол нөгөө талаасаа дутахааргүй хувцаслах хэрэгтэй болно шүү дээ. Бизнес хийж буй хүндээ баян хүн, эргээд хэрэг болох ирээдүйтэй хүн гэсэн сэтгэгдлийг төрүүлэх хэрэгтэй. Хувцасаа цаг үедээ тохируулж өмсөх нь хүртэл нарийн, албан хэргийн хувцас, гоёлын хувцас, ёслолын хувцас, жирийн үед өмсөх хувцас гээд л... Албан хэргийн үед эрчүүд костюмны доод товчийг товчлохгүйгээр зангианы хавчаараа зангианы доод талаас таван хуруу зайд зүүх жишээтэй. Энэ хүчин зүйлд зөвхөн хувцаслалт биш арьсаа арчлах, үсээ тохируулж засуулах гээд л бүгд орно.
3. Вербаль буюу ярих чадвар: Тухайн хүний яриа, дуу хоолойны өнгө, харилцааны соёл, үгийн сонголт, илтгэх, бичих чадвар зэрэг нь имижийг бүрдүүлдэг. Гоё дэгжин хувцаслачихсан, олонд нэртэй хүн олны өмнө гараад ээрч муураад ярьж чадахгүй байвал хэн ч гэсэн сэтгэл дундуур байна. Цэгцтэй сэтгэж, цэгцтэй илэрхийлэх чадвар бол хүний хамгийн томоохон чадваруудын нэг. “Ярьж чаддаггүй хүн тушаал дэвшдэггүй” гэдэг шиг олны өмнө өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чаддаггүй бол та амжилтанд хүрэхгүй. Өөрийн имижээ амжилттай бүрдүүлж алдаршсаны үр дүн нь гэвэл уран үгэнд ухаан байр сууриа тавьж өгч байгаа явдал юм. Гэхдээ уран ярьсан болгоныг ухаантай гэж ойлгож бас болохгүй.

Уран илтгэл, яруу найраг хоёр ондоо гэдгийг ойлгох хэрэгтэй. Илтгэл тавих гурван дүрмийг танилцуулахад:

- Ритмийн зарчим: Дуу хоолойны өнгөө тохируулах:
 - Агуулгын зарчим: Сонирхолтой жишээ, тоо баримт, харьцуулсан судалгаа оруулах:
 - Сонсогчтой холбоо тогтоох зарчим: Энд таны дохио зангаа, харьцаа /сонсогчид дээр бүлэглэж тогтоох гэх мэт/
4. Кинетик хүчин зүйлс: Хүний алхаа гишгээ, зогсолт, гарын хөдөлгөөн нүүрний хувирал зэрэг багтдаг. Хошуучлагч хүн ямар ч тохиолдолд тайван, гараа савчихгүй алхах ёстой. Энэ нь тухайн хүн сэтгэлийн хөдөлгөөнөө барьж, аливаа асуудалд сэтгэл хөдлөлөөр бус оюун ухаанаар ханддагыг гэрчилдэг. Гар барих хүртэл өөрийн онцлогтой. Алгаа дээш нь харуулж гар барьж байгаа хүн нөгөө хүнээ хүндэлж байгааг гэрчилнэ. Алгаа доош нь харуулж гар барьж байгаа хүн харилцагчаа өөрөөсөө доогуур үнэлж байгаагийн илрэл. Дээш нь ч биш доош нь ч биш харуулж гар барьж байгаа бол ижил түвшинд харилцагчаа авч үзэж байна гэсэн үг.

Улс төрийн имижийг бүрдүүлэх нэгэн хүчин зүйл нь нэр хүнд юм. Их гүрнүүдийн улс төрчид өргөн мэдлэг, дадлага, туршлагаа олон түмэнд тусгайлан харуулах өөрийн арга хэрэгсэлтэй байдаг. Тэд хэвлэлийн бага хурал, олон түмэнтэй хийх уулзалт, албан ёсны арга хэмжээнд биеэ авч явах эзэмшсэн өвөрмөц тодорхой хэв маягтай байдаг. Жишээ нь: Францын ерөнхийлөгч Шарль де Голль гэхэд нэг ч асуултанд урьдчилан бэлтгэхгүйгээр хариулдаггүй байжээ.

Улс төрийн имижийн үндсэнд юу оршин байдаг вэ? имижийг зөв бүрдүүлнэ гэдэг бол маш нарийн асуудал юм. Дорнын хошуучлагчидийн баримталдаг зарчим бол тэд бидний өмнө яг бидэнтэй адилхан харагдахыг хичээдэг. Өрнөдийнхөн өөрийн ардчилсан дүр төрхөө олон нийтэд мэдэгдэх, түүгээрээ бусдад таалагдахыг хичээдэг онцлогтой.

Улс төрийн имиж нь улс төрийн хошуучлагчийг олон түмэнд тааламжтай, эерэг харилцааг бий болгоход голлон нөлөөлөхөд оршдог. Имиж нь улс төрийн хошуучлагч ба сонгогчдын хоёулангийнх нь ашиг сонирхлыг хангахын тулд үйлчилж, ашиг сонирхлуудыг нь нэгтгэхийг хичээдэг. Энэ нь сонгогчдын төр засгийн бодлогод хүсэл шаардлагаа тусгуулах өөрсдийн хүнтэй байх эрмэлзэл, нөгөө талаас үүнд нь өөрийгөө нийцүүлэн эрх мэдэлтэй болох гэсэн улс төрийн хошуучлагч, улс төрийн нам, бүлгүүдийн хүсэл сонирхолоор илэрнэ. Иймээс тэдгээрийн хоорондын зохистой харилцаа нь улс төрийн харилцааг зөв замаар хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой билээ.

Манай улсын өнөөгийн олонхи сонгогч сонгуульд саналаа өгөхдөө нэр дэвшигч аль нам, бүлгийг төлөөлж буйг бус хувийн шинж чанарыг илүүтэй харгалздаг болсон байна. Улс төрийн хошуучлагчийн имиж гэдэгт тухайн зүтгэлтний талаархи сонгогчдын таньж мэдсэн бүх зүйлийг багтаан ойлгодог. Үүнд тухайн хошуучлагчийн дүр зураг, бусдад ойлгогдсон төсөөлөл, нэр хүнд, бусдаас өгсөн үнэлгээ багтдаг. Сонгогч улс төрчдийг яг байгаагаар нь бүрэн таньж мэдсэн учраас бус, харин өөрийн ойлголт, төсөөллийг үндэслэн тухайн субъектэд саналаа өгдөг. Үнэндээ улс төрийн хошуучлагчийг зөвхөн имижээр нь

таньж, үнэлж дүгнэн сонгодог. Үүнд л улс төрийн шинжлэх ухааны нэгэн гол салбар болох имиж судлал үйлчилж сонгогч буюу олон түмний сэтгэл зүйн болон үнэлэмжийн орчин, тэдгээрт хүрэхэд олон нийтийн мэдээллийн ямар сувгийг ашиглах, дүнг урьдчилан тооцох, эргэх харилцаа хэрхэн байх зэрэг өргөн хүрээтэй асуудлыг судалж байдаг нь имиж судлалын шинжлэх ухаан хэрхэн ач холбогдолтой болохыг харуулж байна.

1980-аад оны сүүлээр имиж хэмээх ойлголтыг зөвхөн тухайн үеийн хошуучлагчдийн баримтлан явуулж буй үзэл суртал, улс төрийн бодлогын хэрэгжилтийн үйл ажиллагаа, уриа лоозонгоор ойлгож байсан. Харин 1990-ээд оны эхээр монголын нийгмийн хөгжилд өөрчлөлт шинэчлэлт /улс төрийн олон ургалч үзэл, санаа/ гарч ирсэнээр бид улс төрийн шинжлэх ухааныг өргөн утгаар нь төдийгүй салбар шинжлэх ухааныг нь ч судлан үзэх болсон билээ. Улс төрийн хошуучлагчид, улс төрийн намууд нь олон нийттэй харилцаа холбоо тогтоож тэдний санаа бодолд эерэгээр нөлөөлөхийг ихээхэн эрмэлздэг. Ийм учраас улс төрийн хошуучлагчид, сонгуульд нэр дэвшигчид, улс төрийн намууд өөрсдийн имижийг бүрдүүлэхэд онцгой анхаардаг болсон.

Сонгуульд нэр дэвшигчийн имиж, түүнд нөлөөлөх хүчин зүйлс нь нэр дэвшигчийн гадаад төрх байдал, хувцаслалт, оюун ухааны чадвар, хэл ярианы соёл, намын болон нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, амлалт, түүний хэрэгжих магадлал, нэр дэвшигчийн нэрийг дэвшүүлсэн нам ямар нам болох, нэр дэвшигчийн түүх намтар, нэр хүнд, мэдлэг боловсрол, ажил хэргийн болон мэргэжлийн ур чадвар, хувь хүний шинж чанар зэргийг илтгэн харуулж сонгууль буюу улс төрийн зах зээл дээр өрсөлдөж чадах эсэхийг харуулсан үзүүлэлт нь болж байдаг.

Улс төрийн имижтэй зайлшгүй холбоотой ойлголт бол **улс төрийн хошуучлал** юм. Энэ нь улс төр судлалын шинжлэх ухааны нэн чухал томоохон асуудлын нэг. Жишээлбэл олон нийтийн байгууллага, албан газар, шашин, гудамжны жагсаал цуглаан зэрэгт бүгдэд нь хошуучлагч байдаг. Хошуучлалын бүх хэлбэрүүдийн дотроос улс төрийн хошуучлал чухал байр суурийг эзэлдэг. Хошуучлалын тухай ойлголтыг тайлбарлах оролдлого эрт үеэс эхлэлтэй. “Эртний Грекийн гүн ухаантан Геродот, Плутарх нар түүхэн үйл явдлын гол баатрууд нь хаад, цэргийн жанжнууд гэж үзэж байсан бол, гүн ухаантан Перикл /одоогоос 2400 гаруй жилийн өмнө/ улс төрийн бодлогыг жинхэнэ ёсоор явуулж чаддаг хүн цөөхөн байдаг хэдий ч улс төрийн тухай иргэн бүр шүүн хэлэлцэж чаддаг.”⁵⁰ гэжээ.

Хошуучлагч сэтгэл татам арга барилтай байгаад зогсохгүй, тавьсан зорилгодоо хүрэхийн тулд бүлгийг нягтруулах, бүрдүүлэх чадвар чухал гэсэн үзэл санаа сэргэн мандлын үе, хөрөнгөтний хувьсгалын үед нэлээд дэлгэрчээ.

Хошуучлал гэдэг нь англиар leadership гэсэн үг юм. Судлаач Эдингер: “Хошуучлал гэдэг нь нөлөө, нэр хүнд, эрх мэдэл ба бусдыг хянах явдал юм”⁵¹ гэж тодорхойлжээ. Хошуучлагчид өндөр мэдлэг боловсрол, биеэ авч яваа

⁵⁰ Пүрэвсүрэн. Л. “Leadership”. Шинэ толь сэтгүүл. УБ., 1999. 157

⁵¹ Ганхуяг.Д. “Хошуучлагчийн улс төрийн имиж түүнийг бүрдүүлэхүй”. УБ., 2004.

байдал, илтгэх чадвар, зорилгод хүрэх хүсэл эрмэлзэл, ярианы соёл, хүнтэй харьцах эв дүйгээрээ буюу шинжээрээ хүмүүст нөлөөлж байдаг.

Улс төрийн нам-ын имиж гэж юу вэ? Энэ нь хэрхэн бүрэлддэг вэ? Энэхүү бүрэлдэн бий болсон имиж нь өсөж, буурч, сарниж өөрчлөгддөг үү? зэрэг олон асуудал улс төрчид, улс төр судлаачдын анхаарлыг татдаг.

Улс төрийн намын үүслийг XVII-XVIII зууны үеэс эхлэн тооцдог бөгөөд энэ нь язгууртны дугуйлан, жлс төрийн клуб, олон түмнийм гэсэн гурван үе шатыг дамжин хөгжиж иржээ. Дугуйлан, клубын үе шатыг улс төрийн намын ТҮҮХИЙН ӨМНӨХ ҮЕ гэж үздэг. Европод олон түмнийг хамарсан улс төрийн намууд XIX зууны сүүлийн хагаст бүрэлдэснээр орчин үеийн намын үүсэл тавигдсан юм.

Нам хэмээх нь *pars* - нэгэн зүйлийн хэсэг гэсэн латин үгнээс гаралтай ойлголт юм. Улс төрийн нам гэж юу вэ? гэдэг асуултанд олон янзын хандлага, тодорхойлолт байгаа ч эдгээрийг дүгнэвэл, нам гэдэг нь засгийн эрхийн төлөө эрмэлзэж, улс төрийн үйл ажиллагаа явуулдаг, тодорхой зохион байгуулалтай нийгмийн институт юм.

Орчин үеийн улс төрийн намуудад “засгийн эрхийг авах, түүнийгээ тогтоон барих” гэсэн үндсэн сонирхол давамгайлдаг. Өөрөөр хэлбэл үзэл суртлын гүн гүнзгий ялгаа байхгүй болсон гэсэн үг. Харин орчин үеийн улс төрийн намуудын хоорондоо ялгарах гол ялгаа нь тэдний имиж болж байна.

Улс төрийн намууд нөлөөллийн хамгийн их үр ашигтай гэсэн арга хэлбэр, сувгуудыг сонгон өөрийн мөрийн хөтөлбөрийг сонгогчдын хүсэн хүлээсэн тэр хэлбэрээр дэвшүүлэх хэрэгтэй. Улс төрийн нам бүхэн өөр өөрийн гэсэн тодорхой имижтэй байж, түүнийгээ хадгалах, мөн сонгогчдын сэтгэлд хүрэхүйц тийм имижийг бүрдүүлэхийг эрхэмлэдэг.

Америкийн судлаач Стив Хупер улс төрийн намын имижийг амжилттай бүрдүүлэх дөрвөн зарчмыг тэмдэглэсэн. Үүнд:

1. Нам гэдэг “ариун гэр бүл” дотор хагарал байх нь сонгогчдод сөрөг сэтгэгдэл төрүүлдэг;
2. Эдийн засгийн асуудлыг шийдэх чадвартай гэдгээ байнга давтах;
3. Ирээдүйг харах чадвартай гэдгээ үзүүлэхийн тулд хөгжлийн концепци боловсруулах хэрэгтэй;
4. Сөрөг хүчинд засгийн эрх шилжвэл ямар аймшигтай зүйл бий болохыг сурталчлах.

Хүмүүсийн хүсэл сонирхлыг өөрийн сэтгэл зүрхэнд тээж яваа гэдэгт итгэж буй тэр л улс төрийн хүчнийг олон түмэн дэмжих болно гэсэн нэгэн суурь зарчим улс төрийн хүрээнд үйлчилдэг.

Улс төрийн нам нь имижээ бүрдүүлэхдээ дотоодын эв нэгдэл, эдийн засгийн аливаа асуудлыг шийдэх чадвар, ирээдүйгээ харсан алсын хараатай байх сөрөг хүчнийхээ алдаан дээр тоглож чаддаг байх зэргийг гол зарчимаа болгох явдал юм.

Хүмүүсийн зарим хэсэг нь улс төр сонирхдоггүй /магадгүй бүр ч их сонирхдог байж ч болох юм/ мөн улс төрчид бидний төлөө ажилладаггүй гэж үздэг тул улс төрийн намын ухуулга сурталчилгаа нь сонгогчдын үзэл бодол, хүсэл сонирхолтой бүрэн нийцэж байх ёстой. Өөрөөр хэлбэл өөрийн үзэл

бодлоо олон түмэнд танилцуулахдаа хэрэглэх арга хэлбэр, тактикаа зөв сонгох учиртай. Улс төрийн намуудын сонгуулийн имиж үндсэндээ дараах дөрвөн зарчимд тулгуурладаг. Үүнд:

1. Сонгууль хүртэл аажмаар удаан хугацааны турш имиж бүрдүүлэх.
2. Өдөр тутмын тулгамдсан асуудалд өөрийн дуу хоолойг гаргах.
3. Намын бус шинжээчдийг өөртөө татах.
4. Имиж нь улс төрийн бодлогын орлогч биш харин түүнийг нөхөн гүйцээгч гэдэг талаас нь ажиллах зэрэг юм.

Энэ бүхнийг хэрхэн ашиглаж зохицуулж байна гэдгээс улс төрийн намын имиж, түүнд хандах олон түмний үнэлэлт ихээхэн шалтгаалдаг. Улс төрийн имиж гэдэг нь нийгэм улс төрийн өдөр тутмын болон тодорхой цаг хугацаанд оролцож буй субъектуудын оролцох оролцоо, түүнд хандах байр суурь, үйл ажиллагааны бодит хэлбэр, бусдын зүгээс өгч буй үнэлэлт дүгнэлт, ард түмэн болон нийгмийн бусад бүлгүүдийн хүлээн авч буй төсөөлөл түүний илэрхийлэл юм.

Өөрөөр хэлбэл бид өнөөгийн Ерөнхийлөгч, УИХ, УИХ-д суудалтай улс төрийн намууд, засгийн газар, улс төрчдийн хийж буй үйл ажиллагаа зэргийг мэдээллийн сувгаар дамжуулан хүлээн авч түүндээ өөрийн бодол санааны үүднээс дүгнэлт өгөх зэргээр улс төрийн имижийг илэрхийлж байдаг. Улс төрийн шинжлэх ухаан нь өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн нийгмийн үйл ажиллагааг судлан шинжилж улмаар ирээдүйрүүгээ тэмүүлсэн бодлогыг тодорхойлдог тул улс төрийн имиж судлалын салбарыг субъект тус бүрээр нь авч үзэж судлах нь улс төрийн шинжлэх ухаан болоод нийгмийн хөгжилд ихээхэн ач холбогдолтой юм.

ИМИЖ ТҮҮНИЙ ХЭВ МАЯГ

Имиж гэдэг нь гадаад болоод дотоод шинж байдал, мөн чанарыг илэрхийлсэн ухагдахуун юм.

Улс төрийн имижийг үндсэнд нь:

1. Идеальный /төсөөллийн/
2. Реальный /бодит/ гэж ангилна.

Идеальный имиж нь хүрэх зорилготойгоо нийцүүлэн тавигдсан төгс дүр төрх юм. Өөрөөр хэлбэл имижийн субъектууд нь өөрийн хүрээлэн буй орчин болон дотоод оюун санаандаа нийцүүлэн ирээдүйрүүгээ тэмүүлсэн буюу имижээ бүрдүүлэхээр төлөвлөсөн төсөөлөл юм.

Реальный имиж нь бодит нөхцөл байдалтай уялдуулан бий болгох зорилгоос үүсэлтэй байдаг шинж төрх юм. Өөрөөр хэлбэл амьдарч буй тухайн цаг үеийн нөхцөл байдлаас урган гарсан бодит зүйл. Бодит имижийг дотор нь:

- Бодит оршин буй имиж: гадаад байдал нь илүү түлхүү нөлөөлдөг. Үүнд гадны ямар нэгэн нөлөө орохгүй буюу мэргэжлийн имижейкерүүд улс төрчийн имижийг нь бүрдүүлдэггүй харин субъект нь зөвхөн байгаа байгаагаараа байх явдал юм.

- Зохиомлоор бий болсон имиж: имижмейкерүүд зориуд тухайн субъектынхээ имижийг бүрдүүлэн олон нийтийн анхаарлыг татах.
- Бүрдүүлэхээр төлөвлөж буй имиж: тухайн нөхцөл байдал, ирээдүйрүүгээ чиглэсэн имижийг мэргэжлийн хүмүүсийн үйл ажиллагааны үр дүнд бий болгон төлөвшүүлэх дүр төрх.
- Домогшин үлдсэн имиж: дэлхий дахинд монгол хэмээх нэрийг дурсган үлдээсэн агуу их удирдагч Чингис хаан, Д.Сүхбаатар зэрэг нийгэм, улс төр, цэргийн их удирдагчид.

“Таны дүр бол та хүрээлэн буй ертөнцөд харуулж буй таны хөрөг юм. Энэ хөрөг чинь таны эсрэг биш, харин таны төлөө үйлчилж байх ёстой” гэж судлаач Джеймс өөрийн бүтээлдээ тэмдэглэсэн байдаг.

Улс төрийн имижийг мөн функционал, хөндлөнгийн буюу хүрээлэн буй орчин, үйл ажиллагаа, зохион байгуулалтын хэлбэр зэрээс нь шалтгаалан дараахи байдлаар авч үзэж болох юм. Олонхи судлаачдын хүлээн зөвшөөрсөн имижийн хэв маягийг америкийн судлаач Элери Сетпсон тодорхойлсон байдаг. Түүний үзэж байгаагаар имижийг:

- Өөрийн имиж: бидний өнгөрсөн амьдрал, зан чанар, үнэлэмжтэй холбоотой мөн давж туулсан амьдрал, дурсамж зэргээс улбаатай бодит байдал дээр тулгуурласан имижийнхээ тухай өөрийнх нь төсөөлөл бөгөөд үүнийг жинхэнэ утгаар нь имиж хэмээн ойлгоход учир дутагдалтай.
- Ойлгогдсон имиж: олон нийтийн зүгээс өгч буй санал, дүгнэлт, тэдэнд төрүүлсэн сэтгэгдэл, дурсамж. Энэ нь тухайн улс төрчийн жинхэнэ имиж гэж ойлгож болох юм.
- Шаардагдах имиж: мэргэжлийн үйл ажиллагаатай уялдсан шинж бөгөөд мэргэжлийн онцлогтой тавигдаж буй дүр юм.

Судлаач Элери Сетпсоны имижийн ангилалыг мөн дараахи байдлаар тайлбарлаж болох юм. Үүнд:

- Объектив имиж гэдэг нь сонгогчдод төрсөн нэр дэвшигчийн талаархи сэтгэгдэл юм.
- Субъектив имиж гэдэг нь сонгогчдын нүдэнд би хэн бэ? гэсэн өөрийнхөө тухай нэр дэвшигчдийн төсөөлөл байдаг.
- Субъектийн болон загварчилсан имиж гэж мэргэжлийн имижмейкерүүд болон нэр дэвшигчийн командыг бүрдүүлэхийг оролдож буй төрх шинжийг хэлнэ.

Имижийг объектив, субъектив, субъектийн болон загварчилсан имиж гэж ангилах нь шинжлэх ухааны төвшинд нэлээд оновчтой байж болох юм.

Улс төрийн имиж гэдэг нь тухайн нэр дэвшигчээс үл хамаарах эсвэл шууд хамааралтайгаар олон түмэнд хүрэх түүний талаархи төсөөллүүд мөн. Сонгогчдын олонхи нь улс төрийн дотор руу өнгийж үзэх боломжгүй учраас олон нийтийн харилцаанд шууд ордог иймээс зөвхөн өөрийн олж харсан, сонссон зүйлээс өөрт нь төрсөн бодолдоо тулгуурлан имижд нь саналаа өгдөг.

Имижийн хэв маягийг тодорхойлон үзэхдээ дараах шинжийг нь харгалзан үзэх нь зүйтэй.

- Улс төрчийн гадаад төрх шинж: хувцаслалт, биеийн хөдөлгөөн, дохио зангаа, дуу авиа, биеэ авч явч буй байдлууд
- Улс төрчийн дотоод шинж чанар: шийдвэр гаргах үйл явц, түүнд хандах хандлага, хийж буй үйл ажиллагаа

Мөн имижийн хэв маягийг олон нийтийн бодол санаа, өгч буй үнэлэлт дүгнэлтийн үүднээс дараахи байдлаар авч үзэж болох юм. Үүнд:

- Оюун санааны: улс төрийн үйл ажиллагаа, харилцаанд оролцон өөрийн бодлогыг тодорхой хэмжээгээр гарган хэрэгжүүлж буй улс төрчийн шинж төрх юм.
- Үйл ажиллагааны: гаргасан шийдвэр дээрээ үндэслэн хийж хэрэгжүүлж буй зүйл юм.

Улс төрийн хошуучлагчийн имижийг олон нийтэд хүргэж буй байдлаар нь:

- Зэрэгцүүлсэн имиж: өрсөлдөгчийнхөө имижтэй зэрэгцүүлэн гарган ирж буй сурталчилгааг хэлнэ. Өөрөөр хэлвэл өөрийгөө бусадтай нэгэн зиндаанд тавьж, түүнээс илүү мэтээр харуулах, өрсөлдөгч ямар нэр хүндтэй байна өөрийгөө яг тийм байдлаар таниулах гэсэн зохион байгуулалтай хийж буй үйл ажиллагаа юм.
- Харьцуулсан имиж: өрсөлдөгчийнхөө юмуу эсвэл хэд хэдэн улс төрчдийн зарим нэгэн имижийг хооронд нь харьцуулж сайн талуудыг нь зохиомол хэлбэрээр авч өөрийн имижээ бүрдүүлэхийг хэлнэ.

Имиж бүрдүүлэлтийн үйл явцыг орчны, бүтээлийн, дүр төрхийн, үг яриа, бичгийн, хөдлөгөөний имиж гэж үндсэн хэв маягт авч үзэж болохоос гадна сэтгэл зүйн, зан төлөвийн хандлагууд нь имиж бүрэлдэн, төлөвшихөд чухал үүрэгтэй байдаг.

Орчны имиж: Таны эдэлж хэрэглэж байгаа машин, орон байр, ширээ сандал, тавилга, бусадтай харилцаж байгаа харьцаа зэрэг нь хамт олон, хувь хүмүүсийн хэмжээнд имижийн зөвхөн нэг талыг илэрхийлэн гаргахыг хэлнэ.

Дүр төрхийн имиж: Дүр төрхийн имиж нь аливаа хүний хувцас, хэрэглэл, /үс засалт, гоёл чимэглэлийн зүйл/ царай зүс, биеийн өндөр, нам... гэх мэт гадаад шинжээр илэрхээс гадна темперамент, зан төлөв, ёс зүй, ёс суртахуунаар тодорхойлогддог.

Бүтээлийн имиж: Уран зураг, дуу хөгжим, шүлэг, яруу найраг, тууж роман, ном зохиол, эрдэм шинжилгээний ажлын үр дүн гэх мэт оюуны болон биеийн хүчний хөдөлмөрөөр бүтсэн “бүтэл”-ээс таны талаархи мэдээллийг хүлээн авч дүн шинжилгээ хийж, имижийг тодорхойлон гаргах явдал юм. Таны бүтээл таны имижийг тодорхойлж бусдад нөлөөлж, таныг сурталчилж байдаг.

Үг яриа бичгийн имиж: Бичгийн хэв маяг, үг ярианы сонсгологтой байдал уран яруу хэллэгээр илрэн гардаг. Та амжилтанд хүрэхийг хүсч байгаа бол ярьж сур. Хэрэв ингэж чадахгүй бол хураасан бүх мөнгөө гоо сайхны мэс засалд зориул... мэдлэг эзэмш... гэж доктор Жерард Ниренберг зөвлөсөн байдаг. Имиж судлалд: Юу ярьж байгаа нь чухал биш, харин Яаж ярьж байгаа нь чухал байдаг. Алдар цуутай бүх хүмүүс амжилтыг өөрийн дуу хоолойтойгоо холбож тайлбарладаг. Таны бичгийн хэв маяг ямар байх нь нэг талаар сэтгэхүй, нөгөө

талаар зан төлөвтэй чинь холбоотой боловч цэвэрч нямбай, цэгцтэй гаргацтай бичиг таны имижийг чимэглэж байдаг.

Хөдөлгөөний имиж: Алхаа гишгээ, гарын дохио зангаа, нүүрний хувьсал өөрчлөлт, толгойны байрлал, суух маяг хэлбэр...зэргээр хөдөлгөөний имиж илрэн гардаг. Өөрт дургүй болон тааламжтай байгаа байдлаа царайны хувирал өөрчлөлт, нүдний харц, гарын байрлал, хөлийн тавилт, суусан байдал хөдөлгөөн өөрөө хүмүүс голчлон илэрхийлж байдаг тул эдгээрийг дотоод сэтгэлийн багаж хэрэгсэл гэж нэрлэдэг.

Баримт материал, мэдээлэлд тулгуурласан имиж бүрдүүлэх мэдээллийг шууд буюу хөндлөнгийн гэж хоёр хуваана.

1. Шууд имиж бүрдүүлэлтийн мэдээлэл: Таньтай болон имиж тогтоолгож буй этгээдтэй шууд харьцаж бий болсон, хүлээн авсан мэдээлэл төрсөн сэтгэгдэл юм. Үүнд:
 - Тухайн этгээдийн сэтгэл зүйн онцлог /зан төлөв, темперамент, үзэл бодол, боловсрол мэдлэг/
 - Гадаад төрх /биеийн өндөр нам, хувцас, хэрэглэж буй гоо сайхны зүйлс/
2. Хөндлөнгийн имиж бүрдүүлэлтийн мэдээлэл: Ямар нэг гадны нөлөөгөөр дамжин ирж байгаа мэдээлэл юм. Үүнд:
 - Гуравдагч хүний тусламжтайгаар,
 - Таны үйл ажиллагааны үр дүнгээр,
 - Таныг бүрдүүлсэн орчноор дамжуулан тус тус мэдээлэл авах.

Тухайн хүний талаар ямар нэгэн мэдээлэл хүлээн авч буй хүнийг реципиент /хүлээн авагч/, мэдээллийг өгч байгаа эх үүсвэрийг индуктор /өдөөгч/ гэнэ. Реципиент, индуктротойгоор харьцаж имиж бүрдүүлэлтийн мэдээллийг шууд буюу хөндлөнгийн замаар олж авч байна гэж үзвэл реципиентэд ямар сэтгэгдэл, бодол төрж бий болсныг хянан үзэхэд сэтгэл зүйн гурван хэв шинж ажиглагддаг.

1. Реципиент өөрт төрсөн бодол сэтгэгдэл нь бодит байдалтай нийцэж байгаа, яагаад ийм бодолтой болсноо мэддэг.
2. Реципиент хэдийгээр бодит байдалтай нийцэхгүй байгаа ч өөрт төрсөн бодол сэтгэгдэл нь үнэн юм шиг санагдаж байгааг өөрөө мэдэрч байдаг.
3. Реципиент яагаад түүнд ийм бодол сэтгэгдэл төрөх болсныгоо өөрөө ч мэддэггүй.

Шууд мэдээллийг ухамсарлагдсан буюу ухамсарлагдаагүй гэж хоёр ангилж үздэг. Ухамсарлагдсан мэдээлэл нь мэдээлэл бий болсон шалтгаанаа субъект мэдэж байдаг. Ухамсарлагдаагүй мэдээлэл нь:

- Төсөөлөл /мэдээлэл/ бий болж байгаа шалтгааныг субъект мэддэг
- Төсөөлөл бий болж байгаа шалтгааныг мэдэж байгаар мэтээр субъект бодож байх
- Төсөөлөл бий болж буй шалтгааныг мэддэггүй гэж ангилан авч үздэг

Имиж бүрдүүлэлтийн хөндлөнгийн мэдээллийг ухамсарын түвшин, үнэний байдал, эх үүсвэрээр нь мөн ангилан үздэг. Үүнд:

- Ухамсарын түвшингээр нь ухамсарлагдсан, ухамсарлагдаагүй
- Үнэний байдлаар нь үнэн, илт хуурамч, гуйвуулсан
- Эх үүсвэрээр нь хүмүүсээр дамжин авсан, эд зүйлсээр дамжиж авсан гэж ангилдаг

Тухайн хүн байгууллагын талаар буюу өөрөөр хэлбэл өдөөгчийн зүгээс ямар нэгэн мэдээлэлгүйгээр ч түүний имижийг тодорхойлон гаргах гэсэн үндсэн нэг хэлбэр нь хүлээн авагчийн ухамсартай үйл ажиллагаагаар таамаглал, бодомж төсөөллөөр бий болно.

Өөрийн бүрдүүлж бий болгосон имижийн хэв маягуудыг аль болох олон сувгаар хүмүүст дамжуулж хүргэх нь имиж бүрдүүлэхэд чухал нөлөөтэй.

ИМИЖ БҮРДҮҮЛЭЛТИЙН ТЕХНОЛОГИ

Таны имиж ямар байх ёстой вэ? Энэ бол гарцаагүй имиж бүрдүүлэх технологитой холбоотой асуудал юм.

Эрт үеэс улс төрийн аливаа үзэл санаа, бодлого, хөдөлгөөнийг тодорхой хүний нэртэй холбосоор ирсэн байдаг. Улс төрийг хувь хүнтэй холбох асуудалд өнөөдөр улам их ач холбогдол өгсөөр байна. Ялангуяа манай орны хувьд 1992-2012 оны УИХ, Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийн үйл ажиллагааг судлан үзэж, ажиглаж байх явцад намын бодлого хөтөлбөрөө нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн болон шилдэг улс төрчидийнхээ нэртэй холбох стратегийг өргөн хэрэглэж байна. Энэ стратеги нь зөвхөн нэг л зүйлээр хязгаарлагддаг. Тодруулбал сонгогчийн хувьд намын талаар баримталж буй байр суурь нь илүү чухал бөгөөд түүний сонголтын араншинг тодорхойлдог гэж олонхи судлаач үзэж байна. Гэвч өнөөгийн олонхи сонгогч сонгуульд саналаа өгөхдөө нэр дэвшигч аль нам, бүлгийг төлөөлж буйг төдийгүй түүний хувийн шинжийг бас харгалзаж байна. Мөн манипуляци, пр, мифологи, зар сурталчилгаа зэрэг имиж бүрдүүлэлтийн арга технологид өртөн сонголт хийдэг байна. Улс төрийн хошуучлагчийн имиж гэдэгт тухайн хошуучлагчийн талаар сонгогчийн олж мэдсэн бүх зүйлийг багтаан ойлгодог. Сонгогч улс төрчийг яг байгаагаар нь бүрэн таньж мэдсэн учраас бус харин өөрийн ойлголт төсөөллийг үндэслэн түүнд саналаа өгдөг. Улс төрийн хошуучлагч сонгогчдын хооронд холбоо харилцаа тогтоох, улс төрийг хувь хүнтэй холбон ойлгуулахад голлон хэвлэл мэдээллийн хэрэгслийг оновчтой ашиглах хэрэгтэй.

Сонгуульд нэр дэвшигчид нь өөрийн нэр алдар, байр суурийг хэтрүүлэн ойлгуулах, сурталчлах хандлагатай байдаг. Энэ нь ихэвчлэн “улс төржсөн” болон улс төрд анх удаа хөл тавьж байгаа шинэ хүмүүст түгээмэл ажиглагддаг. Сонгуулийн дүн гарсны дараа энэ нь тэднийг сэтгэл зүйн томоохон хүндрэлд хүргэх нь бий.

Сонгуулийн кампани нь “нэр дэвшигчгүй” схемээр ажиллах тохиолдол байдаг. Энэ нь тухайн үед нэр дэвшигчийн имижийг бүрэн тодруулж гаргаж ирж чадаагүй байдагтай шууд холбоотой. Ийм тохиолдолд имиж бүрдүүлэлтийн багийн зүгээс илүү их хүчин чармайлт шаардах боловч боломжтой зүйл юм. Гэвч энэ схемээр ажиллах үед тухайн үедээ тодорхойгүй байгаа нэр дэвшигчийн имиж бүрдэлт дутагддаг ба сонгуулийн кампанийн багийн

төлөвлөгөөнөөс гадна тэр нэр дэвшигч нь сонгуульд ялахын тулд бие даан олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, реклам сурталчилгаанд ажиллах хэрэгтэй болдог. Жинхэнэ улс төрч хүн бол өөрийн дүр төрхийг байнга бий болгож, хадгалж явах нь зүйтэй гэдгийг санаж явдаг.

Сонгуульд нэр дэвшигчийн имиж бүрдүүлэх стратеги нь хэд хэдэн хэлбэртэй байна. Үүнд:

1. Улс төрийн намын сонголтын гол асуудал бол чухамхүү нэр дэвшигчидтэй холбоотой гэж харуулахыг оролдоно. Намаас нэр дэвшигч нь улс орны хөгжлийн талаархи улс төрийн бодлогын нэгэн хувилбарыг төлөөлөн илэрхийлнэ. Нэр дэвшигч бол ямар нэгэн шинэ зүйлийг нэвтрүүлэгч мөн гэдгийг харуулахуйцаар кампанийг зохион байгуулна. Нэр дэвшигч улс төрийн цуцашгүй зүтгэлтэн мөн гэсэн ойлголтыг сонгогчдод өгөх бүхий л боломжийг ашигладаг. Намаас нэр дэвшигч нь намын үзэл санаа, зорилгыг төлөөлж буй хамгийн шилдэг бөгөөд нийтлэг төлөөлөгч мөн гэсэн сэтгэгдлийг сонгогчдод төрүүлэхийг эрмэлздэг. Энэ нь намд талтай байх мэдрэмжийг хүчтэй болгоход нөлөөлдөг гэж үздэг. Илүү нарийн стратеги бол намын нилээд хэдэн тэргүүлэх улс төрчийг нэг баг, команд гэсэн утгаар олон нийтэд танилцуулдаг.
2. Сонгуулийн өмнөх кампанит үед нэр дэвшигчийн сонгогдвол юу хийхээ амлах амлалт гэж байдаг. Түүний амлаж буй программ өрсөлдөгчийнхөөсөө илүү, тод байх ёстой. Имижийг бүтээгчдийн гол зорилго бол улс төрийн харилцааны янз бүрийн хэрэгслийг ашиглан олон түмний сэтгэлд богино хугацаанд хүрэх явдлыг бий болгох асуудал юм. Сонгуулийн кампанийг удирдах явдал улам бүр мэргэжлийн шинж чанартай болж байна. Кампанийг удирдаж буй хүн нам болон нэр дэвшигчээс сонгогчдод санал болгож буй хөтөлбөр, бодлогыг боловсруулан бэлтгэхэд хувь нэмэр оруулахаас гадна түүнийг сонгогчдод хүргэж, тэдэнтэй харилцах арга зам, сувгийг тогтооно. Мөн сонгуулийн кампанийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулдаг. Иймээс улс төрийн бодлого, стратеги боловсруулахад оролцох, улс төрийн коммуникаци тогтоох, зохион байгуулах гэсэн гурван гол үүргийг хэрэгжүүлдэг байна. Эдгээр үүргийг хэрэгжүүлэх нь амар хялбар ажил биш, учир нь гурван өөр төрлийн мэдлэг чадварыг төгс эзэмшсэн байхыг кампанийн менежерээс шаарддаг.
3. Улс төрийн бодлого тодорхойлох стратегич, дээд зэргийн зохион байгуулагч бөгөөд харилцааны урлаг, арга хэрэгслийг нэгэн зэрэг эзэмшсэн хүн ховор байдаг. Иймээс кампанийн менежерийн ажил, үүргийг мэргэшсэн хүмүүсийн баг хийж гүйцэтгэдэг. Багийн гишүүн бүр дээр дурьдсан салбарын аль нэгэнд шинжээчийн түвшинд ажиллах мэдлэг, чадвар эзэмшсэн чадвартай байх ёстой.

Асуудалд улс төрийн үүднээс хандах шаардлага гарах үед улс төрчид шийдвэрлэх үгийг хэлэх хэрэгтэй байдаг. Иймээс кампанийн менежерийн гол үүрэг бол онцгой чадвартай байхаас гадна дээрхи гурван хүрээний ажлыг уялдуулан зохицуулахад оршдог. Энэ утгаараа сонгуулийн кампани орчин үеийн менежментийг зайлшгүй шаарддаг.

Нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэхийн тулд нэр дэвшигчийн имижемейкер нь сонгуулийн кампанийн менежерийн үүргийг гүйцэтгэж сонгуулийн кампанит ажиллыг хослуулан удирдан явуулах зайлшгүй шаардлага гардаг. Ингэхдээ дор дурьдсан ажлуудыг зохион байгуулах болдог. Үүнд: сонгуулийн тойргийг оновчтой сонгох, социологийн судалгаа авах, сонгуулийн кампанийн стратеги, тактикийг боловсруулах, кампанийн шуурхай төлөвлөгөөг зохиох, нэр дэвшигчийн имижийг бүрдүүлэх, дэмжигчдийн гарын үсэг цуглуулах, сонгуулийн зардлыг тооцоолж төсөвлөх, нэр дэвшигчийн багийг бүрдүүлж, бүтцийг тогтоох, сонгуулийн кампанид хэрэглэгдэх техник хангамжийг бэлэн болгох, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан ажиллах, нэр дэвшигчийн уулзалт, ярилцлага, аялалыг зохион байгуулах, хаягийн хүргэлт хийх, зар сурталчилгааны хэвлэмэл материал захиалан тараах, телефон утсаар сонгогчидтой ганцаарчлан ярилцах, мэдээлэл цуглуулах, аюулгүй байдлыг хангах, сонгуулийн явцыг хянах зэрэг бусад олон ажлыг зохион явуулдаг.

Сонгуулийн стратеги бол амжилт, ялалтанд хүрэх түлхүүр юм. Сонгуулийн кампанийн стратеги зөв боловсруулагдсан эсэхийг сонгуулийн дараа л хэлж болдог онцлогтой. Сонгуулийн стратегийг зөв боловсруулж, нэр дэвшигчийн имижийг өргөхөд анхнаасаа нэгэн зүйлд анхаарлаа хандуулах хэрэгтэй. Сонгуульд өрсөлдөгчдийн дотор анхнаасаа өөр зорилготой орж ирсэн хүмүүс нилээд хэмжээгээр байдаг. Зарим нэр дэвшигч албан тушаалаасаа чимээ шуугиан тарилгүй шилжих, зарим нь өөрийн компаниа сурталчилж хэрэглэгчдийн анхаарлыг татах, өрсөлдөгчдийн саналыг хуваах зорилгоор гол өрсөлдөгчид туслах /үүнийг клонирование гэх бөгөөд 1990-ээд оноос манайд их дэлгэрч байгаа үзэгдэл/, өөрийн социаль байр сууриа өсгөж засаглалын болон үйлдвэрлэл, бизнесийн байгууллагын сонирхлыг татах, өөрийгөө лоббидох далд санаа зэрэг олон зорилгоор сонгуульд оролцдог. Сонгуулийн кампанийн стратеги бол сонгуулийн кампанийн үндсэн зорилго, үзэл санааны багц юм. Сонгуулийн кампанийн хүрээнд нэр дэвшигчийн дүр төрх, имижийг “хайрцаглан” сонгуулийн кампанийн тактик, төлөвлөгөөг хэрэгжүүлдэг. Сонгуульд өрсөлдөгч улс төрийн нам, нэр дэвшигчдийн имиж тэдний улс төрийн амьдралд оролцох явцад, урт удаан хугацааны явцад, нэр их хөдөлмөр зүтгэлийн үр дүнд бүрэлдэж байдаг. Харин сонгуулийн кампанийн хэдхэн хоногт хэн нэгэн “цоо шинэ” хүн, хэн ч үл мэдэх улс төрийн нам өөрийн имижийг хийн ялалт байгуулах магадлал тун бага юм. Иймд сонгуулийн кампанийн гол зорилго бол нэгэнт буй болсон имижийг зөв “хайрцаглах”, түүндээ тохирсон стратеги, тактик боловсруулан ажиллах явдал юм.

Америкийн сэтгэл судлаачид: “Сонгуульд оролцогчид өөрийн дэмжигчийн төлөө саналаа өгөхдөө 80 хувь нь өөрийн дотоод мэдрэмжээр авсан мэдээлэлдээ тулгуурладаг. Харин 20 хувь нь нэр дэвшигчийн бий болгосон зорилготой бодлого үйлдлээр өгсөн мэдээлэлд тулгуурладаг гэж тогтоосон байна. Хүмүүс өөрсдийн мэдрэх эрхтнүүдийн тусламжтайгаар орчин тойрондоо харьцаж буй объектоос мэдээллийг байнга санаатай бус зорилгогүйгээр хүлээн авч байдаг.”⁵²

⁵² Sampson. E. “The image factor”. London., 1994.

Хүмүүсийн өдөр тутмын үйлдэл хөдөлгөөн, хэв маяг, төрх байдал нь тэдний ажлын арга барил, заншил, зуршилаар илрэн гарч бусдын оюун санаанд байнга тусгагдаж чиглэсэн зорилготой биш ч ямар нэгэн мэдрэмж дохиолол болон үлдэж тодорхой хугацаагаар хадгалагдаж байдаг. Хүний сэтгэл зүйн орчинг дотоод мэдрэмж, дотоод ухамсар гэж авч үздэг. Жишээ нь: Лекц уншсан багшийн зүүсэн зангиаг хэдийгээр бүгд харж байгаа боловч зарим хэсэг нь анхаараагүйгээс өнгө хэлбэрийг нь санахгүй байж болно. Тухайн хэсэг хүнийг гипнозод оруулаад зангианы талаар асуухад бүгд зөв хариулт өгч байдгийг харуулна.

Тодорхой зорилгод чиглэсэн үйл ажиллагаа болон дотоод мэдрэмжинд тулгуурлан зохион бий болгосон таны имижийн хэв маягууд нь хүмүүст нөлөөлж бусдыг өөртөө татаж чадсанаар амжилтанд хүрдэг имижийн гол онцлог юм.

Иймд өөрийн бүрдүүлж бий болгосон имижийн хэв маягуудыг бусдад хүргэж нөлөөлөхийн тулд имижд нөлөөлөх, нөлөөллийн зарчмууд гарч ирдэг. Үүнд:

- Давтагдах зарчим.
- Нөлөөллийг тасралтгүй хүчтэй байлгах зарчим.
- Давхар нөлөөллийн зарчим.

Давтагдах зарчим: Хүний ой тогтоолт дээр үндэслэгдэж хүмүүст ухамсарлагдсан мэдээлэл давтагддаг. Давтагдсан мэдээллүүд нь илүү сайн тогтоогддог боловч хүмүүст ойлгуулах, ухамсарлуулахын тулд нилээд цаг сэтгэцийг тухайн байдалд дасгадаг гэдэгт үндэслэгдсэн.

Нөлөөллийг тасралтгүй хүчтэй байлгах зарчим: нь сэтгэл хөдөлгөсөн харилцаа, имижийн хэв маягуудын тоог аажмаар нэмэгдүүлэх явдал дээр үндэслэгддэг. Имижийн хэв маягаар дамжуулан өгч буй мэдээлэл нь олон удаагийн давталтын нөлөөллөөр хүлээн авагчийн сонирхлыг төрүүлж түүнийг эзэмших сэтгэгдлийг бий болгодог.

Давхар нөлөөллийн зарчим: Мэдээлэл нь зөвхөн оюун ухааны хэмжээгээр хүлээн авдаггүй, хүний сэтгэл хөдлөлийн хүрээ, дотоод ухамсар, сэтгэцийн процессууд ч оролцож байдаг. Иймд хүнийг ямарваа нэгэн нөлөөлөлд оруулахын тулд түүнд давхар дуудлага хийх хэрэгтэй. Өөрөөр хэлбэл ухамсар болон дотоод ухамсарт нь хандах хэрэгтэй. Энэ нь имижийн үйлчлэлийн нууц нь рекламтай адилаар дотоод ухамсар уруу хандсан байдгаар тайлбарлагдана.

Сэтгэхүй нь зан төлөвийг имижийн тусламжтайгаар шат дараалан удирдах схем болж өгдөг. Хүмүүсийн анхаарлыг татаж сонирхлыг төрүүлж хэрэгцээг нь бий болгож чадсанаар өөрийн имижээр уриалан дуудах, өдөөхөд имиж нөлөөллийн томъёолол чиглэгдэж байдаг. Үүнийг тооцоолон Стокгольмын их дэлгүүрийн захиргаа нь нэг хүн өдөрт хичнээн удаа ОК /ямар гоё юм бэ?/үгийг хэлсний төлөө түүнд нэмэгдэл урамшуулал олгодог систем тогтоож байжээ. Учир нь худалдан авагч шинэ пальтотойгоо гадагш гаран ок хэмээх үгийг хэлсэнээр сониуч, атаач зантай эмэгтэйчүүдийн шохоорхолыг хөдөлгөн улмаар тэдгээр эмэгтэйчүүдийг шинэ пальто худалдан авахад хүргэдэг байжээ.

Өөрийн имижийг бүтээн бий болгож бусдад хүргэхэд зан төлөвийн /ёс суртахуун, ёс зүйн/ зөв хэлбэрийг сонгон авахад зайлшгүйд хүрдэг. Олонхи тохиолдолд хошуучлагчийн имиж нь тухайн тохиолдолд зүг чигээ зөв олсны үр дүн байдаг. Энэ нь зан төлөвийн зөв хэлбэрийг сонгон авсантай холбоотой бөгөөд эндээс имиж бүрдүүлэлтийн зан төлөвийн нөлөөлөл чухал болох нь харагддаг.

Судлаач Гёте “Зан төлөв гэдэг бол өөрийгөө харуулах толь”⁵³ гэж хэлсэн байдаг. Зөвхөн харуулах ч биш энэ толинд харах, өөрийгөө хүрээлэгчдийн харилцааг соргогоор барьж авах, мэдрэх нэг төрлийн авьяас байдагт имижийн нэг нууц оршино. Хүн бүр амжилт авчирах зан төлөвийн зөв хэм хэмжээ чадварыг эзэмших ёстой. Хүн хэдий чинээ хүмүүсийн үйлдэлд үндэслэн өөрийн зан төлөвийг бодитойгоор төсөөлөн гаргаж чадна төдий чинээ стратеги, тактик нь тодорхой болно. Зан төлөвийн илрэл нь гадаад нөхцөл байдал, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг хэрхэн ойлгож харьцаж байгаагаар харагддаг.

Зан төлөвийн хандлагууд нь олон нөхцөл байдлын нөлөөлөлд оршдог боловч энэ нь биднийг өөрийн зан авирын төлөө хариуцлага хүлээх явдлаас чөлөөлдөггүй. Энэ хариуцлагыг ухамсарлах хэмжээ бидний оюун ухаан боловсролын түвшингээс шууд хамааралтай байдаг. Зан төлөвийн хандлагууд нь имиж бүрдүүлэлтийн харилцааны нэг хүчин зүйл болж өгдөг.

Дээр өгүүлсэн имиж бүрдүүлэлтийн зарчмыг ерөнхийд нь нэгтгэн авч үзвэл:

- Имижийн идэвхитэй хэв загварыг бий болгож нөлөөлөхийн зэрэгцээ дотоод ухамсар, дотоод мэдрэмжинд тулгуурлах зарчим
- Дотоод мэдрэмжинд тулгуурлах зарчим
- Имижийн хэв загварын давтагдах зарчим
- Нөлөөллийг тасралтгүй хүчтэй байлгах зарчим
- Давхар нөлөөллийн зарчим гэх мэт болно.

Мөн зан төлөвийн хандлагууд, боловсрол мэдлэг мэргэжлийн өргөн цар хүрээтэй байх зэрэг нь имиж бүрэлдэн тогтоход чухал нөлөөтэй юм.

Имиж бүрдүүлэлтийн үйл явц: Хүмүүс өөрийнхөө имиж бүрдүүлэлтийн мэдээллийг бусдад хэрхэн илгээдэг, өөрийнхөө тухай бодлыг ямар хэлбэрээр бий болгодог өөрийн имижийг яаж бүрдүүлдэг, өөрөөр хэлбэл имиж бүрдүүлэлтийн үйл явц, үндсэн хэлбэрүүдийг авч үзье. Имиж бүрдүүлэлтэнд мэдээлэл нь санаатай (зорилготой) болон санаандгүй (зорилгогүй) дамжуулагддагийг бид мэднэ.

Имиж бүрдүүлэлтийн ач холбогдол: Ажил хэрэгч харилцааны соёлын нэгэн хэсэг нь бусдад нөлөөлөхүйц имижийг бүрдүүлэх явдал юм. Үүнгүйгээр нийгэмд байр суурь, нэр алдарыг эзлэх гэвэл гэнэн хэрэг болно.

⁵³ Ганди.Т. “Улс төрийн сэтгэл зүй, мэдээлэл, шүтэлцээ”. УБ., 2000.

Имиж хэмээх ойлголт нь бидний амьдрал хэл ярианд баттайгаар байр сууриа олж хэвлэлд бичигдэх боллоо. Ер нь амжилтанд хүрэхийг хүссэн хүн бүхний үсний засалт, хөдөлгөөн, донж маяг, татдаг тамхи, байнга хэлдэг үгсээс авхуулаад хувцаслах хэв маяг, дуртай унаа, яриа хөөрөө зэрэг нь өөрийн дүр төрхийг илэрхийлэхэд түлхэц өгч чадах зэвсэг байх ёстой. Дур хүслээрээ юуг ч бүү сонго, ямар нэгэн зүйлийг илэрхийлж зохицуулахын тулд л сонго, таны хөлөөс толгой хүртэл бүх зүйл чинь бусдад нөлөөлөх имиж юм. Найрал хөгжмийг эгшиглэн дуграх тэрхүү цогц бүрдэлийг бүрдүүлэх хөгжмийн зэмсэгүүд болж чадсан үед л та ялалтанд хүрнэ. Хүн бүхэн дуртай хөгжмөө үзэж оролдоод байвал ямар найрал хөгжим болох вэ? Харин бүх хүн тоглох ёстой хөгжмөөрөө нэгэн гайхамшигт аялгууг цогцлон бүтээвэл сая биширсэн үзэгчид хүндэтгэл үзүүлж алга таших билээ. Таны гутал хувцас, донж маяг, хэв загвар, сэтгэл зүй бүхэн чинь цогцлон бүтээх зэмсэг болох ёстой. Ингэсэн цагт л биднийг хаана ч баяртай угтах болно.

Имижээ зөв бүрдүүлэх нь тэр чигээрээ амжилт ялалтын алтан зам. Иймээс ч “Амьдралаа өөрчлөө гэвэл имижээ өөрчил” гэсэн хосгүй үгийг хүн бүхэн мэдэх хэрэгтэй. Хүн бүхэн биднийг гаднах байдлаар нь угтан авдаг. 2012 оны 6 сард хийсэн УИХ-ын сонгуулийн судалгааны урьдчилсан дүнгээс үзэхэд сонгогчид гурван хүн тутмын хоёрыг нь гаднах шинжээр нь тодорхойлж дүгнэсэн байдаг. Биднийг гүн гүнзгий таньж мэдсэн хойно ч дүр төрхөөх нь үлдсэн анхны сэтгэгдэл дүгнэлт нь оршоор байдаг байна.

Тиймээс ч бидний “Имиж ямар үнэтэй байна, бид яг тийм үнэтэй гэсэн үг” хууль болон үлдсэн байдаг байна. Гэхдээ энэ нь мэдээж дүр төрхөө илэрхийлж чадаж байгаа эсэхийг нь л дүгнэсэнээс биш шууд мөнгөн илэрхийлэлээр хэмжсэн хэрэг ердөө ч биш юм. Дэлхийд нэр нөлөө бүхий улс төрчид, урлаг, спортынхоны тоолж барашгүй хөрөнгө тэдний имижийг тодорхойлдоггүй байна. Хэдхэн төгрөгийн үнэтэй тамхи, хийц муутай хувцас, хямдхан эд зүйлс тэдний имижийг мөн л сайн тодорхойлж өгдөггүй байна. Харин улс төрийн болон өндөр мэдлэг боловсрол л тэдний имижийг бүтээдэг. Тэр бүгд нь эзнийхээ байр суурь, дүр төрхийг илэрхийлсэн хамгийн зөв сонголт байдаг ажээ. Заавал домог болон мөнхрөх нь гол биш өөрийн хүрээндээ бусдын гайхал бишрэлийг төрүүлж амжилт ялалтаа ахиулж байхын тулд имижийн идэвхтэй хэв загварыг өөртөө бүтээх хэрэгтэй юм. Таны нэр хүнд ахих, буурч мөхөхийг таны имиж шийддэг тул үүнийг савангийн хөөс шиг тэр дор нь мартаж орхлгүй өдөр бүр ахиулж байх хэрэгтэй.

Таны гадаад төрхөөр таныг дүгнэдэг гашуун үнэн хуулийн дагуу дүр төрх чинь хувирахад хувь заяа дагаж өөрчлөгддөг. Хэний имиж хүчтэй байна, түүний нөлөөнд хүмүүс илүү автдаг. Өөрөөр хэлбэл хэн имиж бүрдүүлэлтийн технологийг сайн ашиглана тэр бусдад илүү нөлөөлдөг байна.

ABSTRACT

Image means a character or reputation in English language and is a reputation of a political figure created by intentional advertising through the political content. A political image is the key to creating a positive relationship for political figures to public and drawing support for the candidates. Image serves to ensure the interest of

both politicians and voters and associate their interests. This becomes apparent through the aspiration of voters to have someone who delivers their requirements to the political policy and through the desire of a politician to have a power in conformity with voters' aspiration. Accordingly, the proper relationship between them is significant to develop political relations through the right way and right message. An issue to form its image in the political subject is absolutely important. Only high level political image-makers have developed the methodology, practice and experience for organizing political activities and providing various supports to image making of candidates during the all stages of election process and social and political everyday life.

НОМ ЗҮЙ

1. Алехин.А.Я. Имидж. идтикет делового человека. Москва. 1996г.
2. Ганди.Т. “Улс төрийн сэтгэл зүй, мэдээлэл, шүтэлцээ”. УБ., 2000.
3. Ганхуяг.Д. “Хошуучлагчийн улс төрийн имиж түүнийг бүрдүүлэхүй”. УБ., 2004.
4. Дейвис.Ф. “Вам абсолютный имидж”. Москва. 1997г.
5. Пүрэвсүрэн. Л. “Leadership”. Шинэ толь сэтгүүл. УБ., 1999. 157
6. Почепцов.Г.Г. Профессия:имиджмейкер. Киев. 2000г.
7. УТБА-ийн лекцийн эмхтгэл. “Улс төрийн имиж бүрдүүлэх нь”. УБ., 1999, № 3.
8. Sampson. E. “The image factor”. London., 1994.

УЛС ТӨРИЙН МАРКЕТИНГИЙН ЗАРИМ АСУУДЛУУД

Д.Оюунчимэг

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн ахлах багш

Нийгмийн улс төрийн салбарт ардчилсан өөрчлөлт шинэчлэл хийгдэж чадаж байна уу гэдэгт жирийн иргэдээс эхлээд улс төрчид, улс төр судлаачид хүртэлхи бүхий л хүмүүсийн нэг хэсэг нь “хангалтгүй” гэсэн үнэлгээ өгч байхад нөгөө хэсэг нь “хангалттай” гэсэн үнэлгээг өгдөг. Бодит байдал дээр улс төрийн амьдралд олон намын тогтолцоо, засаглал хуваах зарчим хэрэгжиж, ардчилсан сонгууль явагдаж байгаа ч улс төрийн амьдралын салаа мөчир бүрт ардчилал бүрэн утгаараа хэрэгжиж хараахан чадаагүй, “сонгуулийн ардчилал”-ын хэлбэрээс хэтрэхгүй байна гэдгийг зарим судлаачид хүлээн зөвшөөрдөг.

Хэрэг дээрээ улс төрийн амьдралын салаа мөчир бүрт маркетинг цогц утгаараа хэрэгжиж байна уу, үгүй юу гэдэг тэнд ардчилал биелэлээ олж буй эсэхийн үндсэн шалгуур юм.

“Монголчууд маркетингийн ертөнцөд амьдрах боллоо. Өөрөөр хэлбэл, нийгмийн амьдралын бүхий л хүрээнд солилцооны зарчим үйлчилж байна. Маркетингийг худалдаа, арилжаа, бизнесийн хүрээгээр хязгаарладаг цаг үе өнгөрч одов. Улс төр, шашин, урлаг, соёл, боловсрол, төрийн үйлчилгээ гээд маркетингийн ухааны хамрахгүй хүрээ гэж байхгүй болж байна.

Улс төрч хүн олон түмэнд хэн болохоо таниулахаас эхлээд маркетингийн ухаанд дөрөөлж улс төрийн амьдралд орох гараагаа эхэлдэг юм. Эхлээд хамт олондоо, өөрийн намынхандаа, улмаар ард олондоо танигдаж байж улс төрч болно. Улс төрийн өндөрлөгт гарна, тухайлбал парламентын гишүүн боллоо гэдэг бол сонгогч олон өгөх зүйлээ тэр хүнд өгчихлөө гэсэн үг. Харин солилцооны нөгөө тал болох ард олныхоо, төрийнхөө төлөө үнэнч шудрага зүтгэх үүрэг улс төрчид ноогдоно. Ард түмнийхээ итгэж хүлээлгэсэн үүрэг хариуцлагыг зөв ухаарч төр түмнийхээ төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэдэг улстөрчдөд сонгогч олон дахин итгэл хүлээлгэдэгийг манай парламентын түүх харуулж байна. Гэхдээ тэр үүргээ умартан хувийн эрх ашгаа урьдал болгосон улс төрч гэгдэж буй зарим хүмүүс өөрийнхөө төдийгүй парламентынхаа нэр хүндийг ч олон түмний дунд илэрхий унагаж байгааг бид бас харж байна. Энэ бол зарим талаар улс төрийн хүрээнд тэнцүү солилцооны зарчим хэрэгжихгүй байна гэсэн үг юм.

Харин олон түмний итгэл хүлээлгэсэн хэмжээнд ажилладаг тийм улстөрчдөөр парламент бүрдсэн цагт төр цэвэршиж маркетингийн үзэл баримтлал хаа сайгүй хэрэгжих нөхцөл бүрдэх болно. Өнөөдөр Монголын нийгэм маркетингийн зарчим газар сайгүй үйлчилдэг эрүүл саруул нийгэм болох чиглэл рүү явж байна гэж дүгнэж болно. Тэгвэл Улс төрийн маркетинг гэж юу вэ?

Засаглалын төлөөх тэмцэл нь онцгой үйлдэл бөгөөд ихэнхидээ хатуу ширүүн, харилцан үл буулт хийх шинжтэй бөгөөд энэхүү үзэгдэлд шинжлэх ухааны болон уран сайхны олон бүтээл зориулагдсан байдаг. Улс төрийн социологи, политологи, конфликтологи үндсэндээ засаглалын төлөөх тэмцлийг судалдаг. Улс төрийн маркетингийн хүрээнд судлан гаргаж ирдэг гол сэдэв бол хүн төрөлхтөний соёл иргэншлийн хөгжлийн дагуу засаглалын эрхэнд олон түмний хүсэл зоригийн нөлөөлөл ихсэх хандлага юм.

Улс төрийн маркетинг гэдэг ойлголтыг авч үзэхээс өмнө “улс төрийн социологи”, “улс төр судлал” гэдэг нэр томъёотой хэрхэн хамааралтайг шинжье. Улс төрийн социологи нийгмийн том бүлгүүдийн улс төрийн үйл байдлыг судалдаг бол улс төр судлал сонгодог утгаараа засаглагч хийгээд эдийн засгийн элитийн улс төрийн үйл байдлыг судалдаг. Харин улс төрийн маркетинг нь явцуу утгаараа элитүүдэд хэрэгтэйгээр олон түмний улс төрийн үйл байдлыг зохицуулах, удирдах үйл ажиллагаа бүхий агуулгатай салбар шинжлэх ухаан гэж тодорхойлж болох юм. Гэвч одоогоор нэгдсэн нэг саналд хүрээгүй учир үндсэн ерөнхий ойлголтыг тодорхойлохоос эхлэе.

Маркетинг гэдэг үг нь монгол хэлэнд “зах зээл судлал” гэж орчуулагдаж, их, дээд сургуулиудад зааж буй хичээл ингэж нэрлэгдэж байна. Тухайн нэр томъёоны утгыг ойлгоход уг урьдчилсан тайлбар туслана. Эдийн засгийн маркетингийг “зах зээлийг судлахад үндэслэгдсэн, фирмийн үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх зорилго бүхий, түүнд үнэ, таваар, мэдээллийн нөлөө үзүүлэх систем”-Барааны маркетинг бол зах зээлийг судлахад үндэслэгдэгдсэн, тухайн барааны борлуулалтыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн, түүнд үнийн болон мэдээллийн нөлөө үзүүлэх систем” хэмээн тодорхойлсон байдаг бол улс төрийн маркетингийн хувьд бол фирмийн оронд “нам”, барааны оронд сайн хөтөлбөр бүхий “нэр дэвшигч” байх бөгөөд ялах шаардлагатай саналыг тоог сонгогчдоос авах явдал юм.

Улс төр гэдэг хүмүүс болон нийгмийн бүлгүүдийн төрийн засаглалтай холбоо бүхий харилцаа бөгөөд харин улс төрийн нам бол нийгмийн зарим нийтлэгийн хүсэл сонирхолд нийцүүлж засаглалыг олж авах, тогтооход чиглэгдсэн үйл ажиллагаа гэж тодорхойлж болох хэдий ч улс төрийн маркетингийн талаар нийтээр хүлээн зөвшөөрсөн тодорхойлолт одоохондоо бий болоогүй байна гэж хэлж болохоор байна. Тухайлбал улс төрийн маркетингийг “иргэдийн үйл байдалд нөлөөлөх, улс төрийн нэгдлийг бий болгох зорилго бүхий онол, арга хэрэгслийн цогц” (Кудинов О.П) хэмээн дүрслэн бичсэн байдаг. Уг тодорхойлолт нь хэдийгээр мөн чанарыг тусган харуулж байгаа хэдий ч дутагдалтай юм. 1-рт: улс төрийн нэгдэлтэй байх нь засаглалыг олж авахын тулд урьд нь харьцангуй шийдвэрлэгдсэн байдаг. 2-рт: ямар хэлбэрээр, ямар зорилгоор “иргэдэд нөлөөлөх вэ?” гэдэг талаар энд дурьдагдсангүй. Судлаачид улс төрийн болон барааны маркетингийн ойлголтын талаар “зарчмын” ялгаа байхгүй гэж үздэг. “Саванг жижиглэнгээр худалдах, нэр дэвшигчийг худалдах” хоёрын хооронд асар их ялгаа байдаг боловч худалдааны рекламны зарим онцлог зүйлүүд улс төрийн үйл явцын эргэлтэнд бат бэхээр оржээ” (Ф.Котлер) хэмээн тэмдэглэсэн байдаг. Энэ бүхнээс үндэслэвэл улс төрийн маркетинг бол улс төрийн зах зээл - сонгогчдыг судлах, засаглалыг олж авахын тулд сонгогчдод нэр дэвшигчийг дэвшүүлэх, үзэл суртал-үзэл баримтлалын хийгээд бодлогын хөтөлбөр программ боловсруулах, улс төрийн зах зээлд мэдээллийн нөлөө үзүүлэх /реклам, PR/ цогц үйл ажиллагаа гэж дүгнэж болох юм.

Улс төрийн маркетинг нь улс төрийн зөвлөхүүд, улс төр судлаачид, социологичид, сэтгэл зүйчид, рекламистууд, олон нийттэй холбоо харилцаа тогтоогч мэргэжилтнүүд “пиарщики” /Англ. PR/ сэтгүүлчид, копирайтерууд /уриа лозун, илтгэл зэргийн үг найруулгыг томъёологчид/, зохиолчид, креаторууд /янз бүрийн рекламны схем, агуулгыг зохиогчид/, найруулагчид, зураглаачид, фотозурагчид, зураачид, дизайнарууд, үгийн найруулга зүйчид, визажистууд,

тайзны урлагийн мэргэжилтнүүд, жүжиглэл, үгийн урлагийн болон шошгын мэргэжилтнүүд зэрэг төрөл бүрийн мэргэжилтнүүд оролцсон онцгой социол технологи.

Улс төрийн зах зээлийн тухай ойлголт эцсийн эцэст “Улс төрийн маркетинг”-д зайлшгүй хүргэдэг. Улс төрийн маркетинг нь хувь хүнээс улс төрийн зах зээлтэй харилцах үйл ажиллагаа. Өөрөөр хэлбэл улс төрийн маркетингийг хүмүүсийн улс төрийн хэрэгцээ, сонирхлыг хангах зорилгоор сонголт, солилцоо хийх замаар улс төрийн зах зээлтэй харилцах үйл ажиллагаа хэмээн тодорхойлж болох юм.

Улс төрийн маркетинг гэдэг ойлголтын цаана ямар утга агуулагдаж байна вэ? Улс төрийн маркетингийг ихэнхи хүмүүс улс төрийн нам, нэр дэвшигчийг “борлуулах” өрсөлдөөнд ялуулахтай адилтгадаг. Үүнд гайхах юмгүй. Сонгуулийн үеэр явагдаж буй телевизийн реклам, сурталчилгаа, сонины нийтлэлүүд, нэр дэвшигчдийн уулзалт, шоу хөтөлбөрүүд сонгогчдыг багагүй сандраадаг. Улс төрийн маркетингийн хамгийн чухал зүйл нь “борлуулалт” буюу сонгуульд ялах явдал биш гэж энд гаргахыг оролдсон маань зарим хүнийг гайхахад хүргэж болох юм. Улс төрийн зах зээлийн өрсөлдөөнд ялах, сонгуульд ялах явдал нь улс төрийн маркетингийг мөсөн уултай зүйрлэвэл тэрхүү мөсөн уулын уснаас цухуйн харагдаж буй зөвхөн оргил хэсэг бөгөөд энэ нь түүний үүргийн нэг мөн боловч ихэнхидээ хамгийн чухал нь биш юм гэсэн санааг энд дэвшүүлэхийг хүссэн юм. Хэрэв улс төрийн намууд болон улс төрийн зах зээлийг судлаач мэргэжилтнүүдийн зүгээс нийгмийн бүлгүүдийн улс төрийн хэрэгцээ, хүсэл сонирхлыг олж илрүүлэн түүнд тохирсон бодлого, хөтөлбөр программ боловсруулан, хүсэн хүлээсэн нэр дэвшигчийг нь санал болгож сонгогч олон түмэнтэй зөв буюу эерэг холбоо харилцаа тогтоох аваас тийм улс төрийн нам, нэр дэвшигч сонгуульд хялбархан ялах, амжилтанд хүрэх нь ойлгомжтой. Өөрөөр хэлбэл улс төрийн маркетингийн энэхүү “улс төрийн зах зээлийг судлах” хэсэг дээр сайн ажиллаваас тийм улс төрийн нам, хөтөлбөр, нэр дэвшигч улс төрийн зах зээл дээрх өрсөлдөөнд ялах боломж бүрдэнэ. Сонгогчдын хүсэн хүлээсэн улс төрийн хөтөлбөр, улс төрийн лидер гэж хэнийг хэлэх вэ? Энэ нь хоосон амласан амлалт, гадаад дүр төрх жүжиглэл төдий бус жинхэнэ бодит ур чадвартай улс төрийн лидер, хэрэгжих боломж бүхий сайн хөтөлбөр байж улс төрийн зах зээлийн өрсөлдөөнд ялж, сонгогчдынхоо хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагыг хангана. Нөгөөтэйгүүр нийгэм улс төрийн цаашдын хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлагын чиг хандлагыг зөв гольдролд хандуулах болно. Энэ нь улс төрийн хөгжил, ардчилал, нийгмийн сайн сайхныг төлөвшүүлэхэд онцгой ач холбогдолтой. Удирдлагын онолчдын нэг Петер Друккер “Маркетингийн зорилго нь худалдаа, борлуулалтанд их чармайлт гаргуулахгүйд оршино”. Бараа буюу үйлчилгээ нь худалдан авагчийн сэтгэлд таалагдаж борлогдоно гэдгийг сайн мэдэж ойлгосноор маркетинг зорилгоо биелүүлнэ” гэж хэлсэн байдаг. Иймээс улс төрийн маркетингийн зорилго нь нэр дэвшигчийг сонгуульд ялуулахад их хүч чармайлт гаргахгүйд л оршино. Хэрэгжүүлэх гэж буй улс төрийн бодлого, хөтөлбөр, нэр дэвшигч нь сонгогчдын сэтгэлд нийцэж сонгогдоно гэдгийг сайн мэдэж ойлгосноор маркетинг гол зорилгоо биелүүллээ гэж үзэж болно. Гэвч энэ нь улс төрийн зах зээл дэхь борлуулалтын өрсөлдөөнд хүч чармайлт гаргах огт шаардлагагүй гэсэн үг хараахан биш юм. Харин энэ нь (илүү өргөн хүрээтэй “Улс төрийн маркетингийн иж бүрдэл” буюу тухайлбал, улс төрийн зах зээлд дээд зэргээр нөлөөлж

чадахын тулд бие биетэйгээ нягт уялдаатай байх шаардлагатай) маркетингийн цогц арга хэрэгслийн нэгээхэн хэсэг гэсэн үг юм. Иймээс улс төрийн маркетингийн утга санааг тодорхойлохдоо: иргэд, сонгогчид, нийгмийн бүлгүүдийн улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагыг хангахад чиглэгдсэн улс төрийн үйл ажиллагааны нэгэн төрөл мөн хэмээн томъёолж болох юм. Энэхүү товч тодорхойлолтын агуулга улс төрийн бодлого, үзэл баримтлал, хөтөлбөр, нэр дэвшигч, улс төрийн хэрэгцээ, шаардлага, улс төрийн хүсэл сонирхол, солилцоо, улс төрийн сонголт, улс төрийн зах зээл зэрэг ойлголтуудыг нарийвчлан авч үзсэнээр илүү тодорхой болно.

Улс төрийн маркетинг хэдийд үүссэн вэ? Улс төрийн маркетинг хэмээх энэхүү хавсарга ухааны түүхэн сэтгэлгээний байдлыг авч үзнэ гэдэг бол угтаа ардчилал, түүний түүхэн хөгжил, нөхцөл байдлыг авч үзэх явдал юм. Энэ үүднээс авч үзвэл улс төрийн маркетингийг ардчилсан сэтгэлгээний хөгжилт, “өрсөлдөөнт элитийн ардчилал”-ын загварын асуудал гэж үзэж болох юм. Үүний баталгаа болгож Шумпетерийн “Ардчилсан арга гэдэг бол хувь хүмүүс сонгогчдын саналын төлөө өрсөлдөөний замаар оролцон шийдвэр гаргах эрх мэдлийг олж авдаг тийм улс төрийн шийдвэр гаргах институциональ байгууламж” гэсэн тодорхойлолтыг өгүүлэх нь зүйтэй. /Шумпетер.И, Капитализм, социализм ба ардчилал/ Ж.Локк төрийн засаглалыг эрх мэдлийн салаа мөчрүүдэд хуваах саналыг дэвшүүлэхдээ хууль тогтоох байгууллага нь ямар нэгэн байдлаар төлөөллийн ардчилал дээр тулгуурлах ёстойг дурьдсан байдаг. Ж.Локкын дэвшүүлсэн энэхүү санаа нь засаглалын эх сурвалж нь иргэд буюу ард түмэн гэдэг санааг тодруулж өгсөнд түүний ач холбогдол оршиж байна. Ардчилсан нийгмийн улс төрийн хүрээ нь цэвэр чөлөөт өрсөлдөөн байдаг гэсэн санааг М.Вебер өөрийн бүтээлдээ тод гаргасан байдаг.

Аж үйлдвэржилтийн нийгэм нь өөрийнхөө цаг үед масс буюу иргэдийн нийлбэр цогцийг улс төрийн үйл ажиллагааны субъект болгон хувиргасан. Иргэд сонгох эрх эдлэх болж энэ хүрээнд улс төрийн маркетинг буй болон үүний үндсэн дээр нийгмийн хөдөлгөөнүүдийн удирдагчид болон гишүүд, гудамжны жагсаал цуглаанд оролцогсод бий болсон юм. Өөрөөр хэлбэл энэ үеэс эрх баригчдын зүгээс олон түмэнд хандах хандлага өөрчлөгдөж эхэлжээ. Г.Лебонь тэмдэглэсэнээр улс төрийн талбар дээр хүчний харьцаа өөрчлөгдсөн. Тэрээр энэ санаагаа “Массын эрх нь вангуудын эрхийг өөрчлөх ёстой” хэмээн томъёолжээ. /Лебон.Г. Психология народов и масс, 1995/ Олон түмний үйл байдалд өөрчлөлт орсноор рациональ удирдлагын асуудал ч дэвшигдэж, түүнийг зөвтгөж эхэлсэн юм. И.Шумпетерын тодорхойлсноор сакральний (шашны ёслолд холбогдох ойлголт, ёсорхол, ёс горимыг чанд баримтлах /Словарь иностранных слов М., 1980/) удирдагчийг сольсноор биеэ даасан “ард түмэн” гэсэн ойлголт үүссэн бөгөөд энэ үеэс ард түмэн улс төрийн түүхэн хөгжлийн түлхэц нь болсон /И.Шумпетер. 1995. С-328/ Энэ үеийн нийгэм улс төрийн байдал нь төлөөллийн ардчиллын урьдач нөхцөл байдлыг төлөвшүүлсэн. Олон түмний үйл байдал өөрийн төлөөллөө бий болгосон. Тэрхүү төлөөлөл нь нийгмийн болон үзэл суртлын гүн гүнзгий хурцадмал зөрчилдөөнт сегментүүд байлаа.

Аж үйлдвэржилтийн дараах үе тулж ирэхэд бие хүмүүс аажимдаа дээрхи нийгмийн болоод ангийн, үзэл суртлын нэгдмэл томоохон нэгдлүүдээс харьцангуй чөлөөлөгдөж иржээ. Төлөөллийн ардчиллын хэв шинж дээрхийг батладаг. Эхлээд нийгэм ангийн болон үзэл суртлын нэгдэл дээр тулгуурлаж

байсан бол аажим хувьссаар плюраль нийгмийн болон улс төрийн байгууллага болж шилжсэн. Аж үйлдвэржилтийн дараах нийгмийн иргэн айсны үндсэн дээр захирагдах мэрдэмжээсээ төдийгүй, улс төрийн үйл байдлынх нь гол тохируулагч болох үзэл суртлын хатуу тогтсон нэгдлээсээ харьцангуй чөлөөлөгдсөөр байна. Ийнхүү урьдны нийгмийн холбоо нь суларч байхгүй болсон хэдий ч бие хүмүүс цэвэр хэрэгцээн дээр үндэслэсэн нийгмийн бүлгүүдэд хамаарагдаж байх ёстой гэдгээ ухамсарлаж байдаг. Энэхүү хувьсгалд төлөөллийн төрийн ойлголт хэвээр үлдсэн юм.

Өмнөх үед засаглалын үндсэн хэрэгсэлд авъяас, зөн билэг зэрэг нь ашиглагдаж байсан бол харин өнөө үед шинжлэх ухаан ашиглагдах болсон байна. Энэ байдал нь И.Шумпетерийн “ардчилал гэдэг бол хошуучлалын шудрага өрсөлдөөн” гэсэн ойлголтын баталгаа болдог.

Хүний түүхийн бүр эхэн үед хүмүүс удирдагчиддаа зүгээр л физически захирагддаг байсан. Гэвч нийгэм ангиудад хуваагдсанаар өөрийн сонирхлын нийтлэг байдлыг ойлгосны үндсэн дээр өөрсдийн шинэ удирдагчдыг сайн дураар сонгох болжээ. Жишээлбэл боолчуудын, тариачдын бослогууд ийм байсан. Энэ үед удирдагчийг сонгох учир шалтгааны үндсэн хүчин зүйлүүд бүрэлдэн бий болсон нь сонирхол татаж байна. Тухайлбал дараахи нөхцөл байдлууд нөлөөлж байжээ. Үүнд -олон түмний амьдралын хүнд байдал буюу тэдний амьдралын нөхцөл байдалдаа сэтгэл ханамжгүй байдал, -удирдагчийн зөн төлөв, хүмүүсийн өмнө, олон нийтийн өмнө өөрийгөө авч явах, ярих чадвар, -өөрийгөө дагалдсан олон түмэнд “эрх чөлөөг” олгоно, тэдний амьдралыг сайжруулна гэж амлах зэрэг юм. Тухайн утгаараа Спартакийн бослогын үеэс өнөөгийн ерөнхийлөгчийн сонгууль хүртэл олон түмний энэхүү улс төрийн үйл байдал эрс өөрчлөгдөөгүйг хялбархан олж харж болно.

Гэвч бодит эрх чөлөө хийгээд амьдралыг үндсээр нь сайжруулах тухай зөвхөн шинэхэн түүхийн үед л ярьж болох юм. Ялангуяа түүний гайхалтай үзэгдэл болох бүх нийтийн ардчилсан сонгуулийн үйл явц үүнийг тод харуулдаг. Ийм нөхцөлд удирдагчийн хувь заяанд нөлөөлөх олон түмний нөлөөлөл өөрийн дээд цэгтээ хүрдэг. Засаглагчид үүнийг ойлгож өөрийн талд саналын олонхийг авахын тулд “сонгогчдын” сэтгэл санаа, талархалд нөлөөлөхөд хүчин чармайлт гаргадаг. Нийгмийн хөгжилтэй холбоотойгоор олон түмэнд нөлөөлөх технологи улам нарийн боловсронгуй болсоор өнөө үед судлаачид, мэргэжилтнүүдийн гарт нэгэнт шилжжээ.

Өнөө үеийн улс төрийн амьдралын өрсөлдөөний нөхцөлд оршин тогтнохын төлөө, засаглал болон сонгогчдын талархлыг олж авах хийгээд нөөцийн төлөөх өрсөлдөөн нь улс төрийн ямар ч байгууламжийн оршин тогтнох, улс төр, нийгмийн болон санхүүгийн нөөцөө өсгөн нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болж байгаа учир уг асуудлыг цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай тулгарч байна. Цогцоор нь шийдвэрлэнэ гэдэг маань энэхүү зорилтыг шийдвэрлэх арга хэрэгсэл нь цогц байна гэсэн үг юм.

Улс төрийн маркетингийн талаар гаргасан номын гар бичмэлтэй танилцаад судлаач В.А.Попов “хаана сонгуулийн технологи эхэлнэ, тэнд ардчилал дуусдаг” гэж дүгнэсэн нь нилээд сонирхол татдаг бөгөөд энд хоёр үндсэн санааг агуулж байна. Үүнд сонгуулийн технологи гэдэг бол “арга хэрэгсэл, арга механизм, арга заль байдгийг тодруулж хэлсэн, нөгөөтэйгүүр улс

төрийн маркетинг хөгжлийн эхэн үедээ /судалгааг голлосон бус сурталчилгааг голлосон/ явж байгааг илэрхийлжээ гэж дүгнэж болох юм.

Улс төрийн маркетинг, реклам хийгээд PR (public relations) нь цаг хугацаагаар шалгагдан, дэлхийн практикт өргөн хэрэглэгдэж байгаа гадаад ертөнцтэй холбоо харилцаа тогтоох арга хэрэгсэл юм. Тавьсан зорилтдоо хүрэх, амжилт олох үр ашигтай коммуникацийг бий болгохын тулд эдгээр хандлагуудыг зайлшгүй нэгтгэх цаг нэгэнт болжээ. Зах зээлийн зүй тогтлын хойшлуулушгүй, зайлшгүй шаардлага нь энэ юм. Жишээ нь: Оросын “ИМА групп холдинг” гэхэд л өөртөө маркетингийн коммуникаци гэж нэрлэгддэг, үйлчилгээний бүх хүрээнд өөрийн үйлчлүүлэгчиддээ санал оруулдаг компаниудыг нэгтгэн ажилладаг бөгөөд эдгээр нь сонгуулийн технологи, PR, реклам, зөвлөгөө, интернет технологи болон бусад үйл ажиллагааг явуулдаг байна. Үүнгүйгээр нийгэмтэй үр бүтээлтэй, ашигтай, эерэг харилцаа тогтооно гэдэг хэцүү. Шинэ мянган гарснаар нийгмийн аятай нөхцөл байдал техникийн урьдчилсан нөхцөл байдлаас шууд хамаарах болсон байна. Өөрөөр хэлбэл хүмүүсийн үйл байдал, ухамсрын нарийн төвөгтэй үйлдлийг техникийн тусламжтай өргөн далайцаар гүйцэтгэх боллоо. Орчин үеийн телекоммуникатив технологи нь бүх ертөнцийн зорилгыг “маш амархан” биелүүлэх болов. Өнөө үед нийгмийн орон зайг эзлэхийн тулд бүхэл томоор нь бус үлэмж жижиг жижиг сегментээр нь авч үзэх хэрэгтэй болж байна.

Улс төрийн коммуникаци зайлшгүй болсноор удирдах болон хянах зорилгууд нэгэн бүхэллэг систем болов. Ингэснээр хэрэгцээ, ашиг сонирхлоороо нэгдсэн хүмүүст нэгэн зэрэг нөлөөлөх, итгүүлэх боломж бий болж байгаа бөгөөд шууд бус байдлаар нийгмийн тухайлсан гишүүнд хүрэх боломж ч нээгдэж байна. Мэдээллийн технологийн хөгжил нь хүмүүсийн хоорондын холбоо харилцааг өөрчлөхөд хүргэж байна. Бие хүн хийгээд олон түмний улс төрийн үйл байдалд (намын цуглаанд, парламентад, үйлдвэрчний эвлэлийн цуглаанд) ач холбогдол өгөх болсон нь эргээд олон түмний улс төрийн үйл байдлыг тодорхойлох хүчин зүйл болов. Өөрөөр хэлбэл олон түмэн улс төрийн коммуникацид оролцогчдын илэрхийлэл болж байна. Нийгэм болон техникийн хөгжлийн үр дүнд хошуучлагч болон иргэдийн хоорондын харилцаа шууд байдлаар явагдах болов. Улс төрийн лидерийн маркетинг гэдэг бол нэр дэвшигчийн онцлог, давуу чанарыг (түүний хөтөлбөр, гадаад төрх, биеэ авч явах байдал, олон нийттэй холбоо харилцаа тогтоох арга, шийдвэр гаргах хэв маяг г. м.) тодорхойлох хийгээд сонгогчдыг судлахад тулгуурласан, тухайн лидерт сонгогчдын илүү олон санал өгүүлэх зорилгоор олон нийтэд мэдээллийн нөлөө үзүүлэх систем юм.

Улс төрийн маркетинг хөгжөөгүй орон зайд зах зээлийн бус /шударга өрсөлдөөний бус/ элементүүд биежин хэрэгждэг, тухайлбал манай улсад УИХ-ын нөхөн сонгуулийн нэг бус тойрогт улс төрийн намууд үр хүүхэд, эхнэр нөхөр, ах дүүг нь дэвшүүлж байсан явдал нь улс төрийн зах зээлийн элемент биш юм. Өөрөөр хэлбэл энэ тохиолдолд улс төрийн зах зээл үйлчлэхгүй болно.

Өнөө үед улс төрийн амьдралын зах зээлийн хандлага улам бүр өсөн нэмэгдэж тэр хэмжээгээрээ судлаачдын анхаарлыг татаж байна. Тухайлбал судлаач П.Бурдые эрэлтийн логикоор улс төрийн амьдралыг тайлбарлан бичсэн байдаг. Түүнийхээр улс төрийн талбар гэдэг бол – агентуудын хоорондын тэмцэл өрсөлдөөний орон зай. Энэ ч чанараараа түүн дээр улс төрийн үйл

явдал, үзэл баримтлал, /асуудал, хөтөлбөр, задлан шинжилгээ, тайлбарлал, үйл явдал, үзэл баримтлал болж/ үүсэж байдаг бөгөөд тэдгээрээс жирийн сонгогч зайлшгүй сонгох шаардлагатай байдаг. Хэрэглэгч хэрэгцээ хангасныг хэрэглэж, үл хангасныг шахан зайлуулдаг /П.Бурдые. Социология политики, М/

Улс төрийн маркетинг хэмээх шинжлэх ухаанд ямар ямар ойлголт категориуд хэрэглэгддэг вэ? Улс төрийн маркетингийн үзэл санааг тодорхойлохдоо улс төрийн маркетинг гэдэг нь иргэд сонгогчид, нийгмийн бүлгүүдийн улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагыг ханагахад чиглэгдсэн улс төрийн үйл ажиллагааны нэгэн төрөл мөн хэмээн томъёолох нь түүнд задлан шинжилгээ хийхэд хялбар болгоно. Энэхүү тодорхойлолтыг тайлбарлахын тулд шаардлага, хэрэгцээ, хүсэл сонирхол, солилцоо, сонголт, арилжаа, зах зээл гэсэн ойлголтуудыг авч үзэх шаардлага тулгарч байна.

Шаардлага гэдэг бол хүн ямар нэгэн юмаар дутагдаж байгаагаа мэдрэхийг хэлдэг. Хүний шаардлага олон янз бөгөөд нарийн төвөгтэй зүйл. Үүнд хоол унд, хувцас хунар, орон байр, аюулгүй байдлаа хангах зэрэг физиологийн үндсэн шаардлагууд, сэтгэл санааны хувьд ойр байх, нөлөөлөх, хайрлах, мэдлэг эзэмших, өөрийгөө илэрхийлэх, үзэл бодолтой байх, мэдээлэл авах, сонгох, сонгогдох зэрэг нийгмийн үндсэн шаардлага зэрэг олон янз байна. Хүний хангагдаагүй шаардлагууд нь түүнийг ихээхэн шаналгаж байдаг.

Улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлагаа хангаагүй хүн уг шаардлагаа хангах боломжтой зүйлийг эрж олох буюу эсвэл тэр шаардлагаа намжааж номхотгох гэсэн хоёр замын аль нэгийг сонгож авна.

Нийгмийн хөгжлийн сул төвшин, улс төрийн ардчилал үгүй нөхцөлд олон түмэн улс төрийн хэрэгцээ, шаардлагаа хангах боломжгүй учир намжааж, номхотгодог бол улс төрийн ардчилсан дэглэмийн нөхцөлд иргэд улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагаа илүү мэдэрч түүнийгээ хангах боломжийг эрж хайдаг, нөгөө талаас ардчилсан нийгмийн зүгээс боломжоор харьцангуй хангагдаж байдаг.

Улс төрийн маркетингийг сонгогчдын буюу иргэний байр сууринаас харж чадах аваас улс төрийн маркетинг сонгогчдод улс төрийн ухаалаг сонголт хийхэд нь туслах болно.

Тухайн хувь хүн, нийгмийн бүлгийн улс төрийн соёлын төвшинтэй уялдаж өвөрмөц хэлбэрээр илрэн гарч ирж буй улс төрийн шаардлага бол улс төрийн хэрэгцээ юм. Хувь хүн, нийгмийн бүлэг бүрийн улс төрийн хэрэгцээ өөр өөрийн өвөрмөц онцлогтой. Афганы, Швейдийн, Монголын сонгогчдын улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлага өөр хоорондоо адилгүй. Түүнчлэн нэг улс орон доторхи нийгмийн бүлгүүдийн улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага өөр өөр. Улс төрийн хэрэгцээ нь тухайн нийгмийнхээ соёл иргэншилд зохицсон аргаар, улс төрийн шаардлагыг хангаж чадах зүйлээр илэрдэг байна.

Имижмейкерүүд нилээд тохиолдолд улс төрийн хэрэгцээг шаардлагатай хольж хутгадаг. Улс төрийн либерал үзлийг баримтлагч өөрийн үзлийг нийгэмд шаардлагатай гэж үзэж байхад харин сонгогчдын тухайн үеийн улс төрийн хүсэл сонирхол, эрх ашигт консерватив үзэл илүү нийцэн, таалагдаж (эрх ашигт нь бүрэн нийцээгүй ч гол нь таалагдаж байх явдал) байж болно. Ийм үед

шаардлага хуучин хэвээр байлаа ч гэсэн шинэ үзэл баримтлалыг сонгох шинэ хэрэгцээ төлөвших тохиолдол байж болно. Хүмүүсийн улс төрийн хэрэгцээ, сонирхол харьцангуй хязгааргүй гэж үзэж болно. Харин түүнийг хангах нөөц хязгаарлагдмал байдаг. (Өөрөөр хэлбэл сонгогчид юу хүссэнээ бус, тухайн үед байгаа хувилбаруудаас илүү гэж үзсэнээ сонгодог гэсэн үг юм).

Эдийн засгийн шинжлэх ухаанд “эрэлт” гэдэг худалдан авах чадвараар баталгаажсан “хэрэгцээ” байдаг улс төрд тэрхүү “эрэлт”-тэй дүйцэхүйц ойлголт бол сонгогч олон түмний “улс төрийн хүсэл сонирхол” гэсэн ойлголт бөгөөд энэ нь тэдний хэрэгцээ шаардлагаас төдийгүй улс төрийн ухамсар, соёлын төвшингөөс хамааралтай “сонголт” байдаг онцлогтой.

Тодорхой цаг үед нийгмийн тодорхой хэсгүүдийн улс төрийн хэрэгцээг тооцоолж, танин мэдэж болно. Үүнд тодорхой цаг үед Монголын сонгогч олон түмэн улс төрийн ямар үзэл баримтлал, улс төрийн хүчин, лидерийг хэрхэн үнэлж байна гэдгийг судлан гаргаж болно. Гэхдээ улс төрийн хүсэл сонирхол бол тийм ч найдвартай тогтвортой зүйл биш юм. Хүмүүс удаан хугацаанд баримталсан улс төрийн бодлого, дахин сонгогдсон улс төрийн хүчин, лидерүүдээс “уйдаж” шинэлэг үзэл бодол, улс төрийн сөрөг хүчин, шинэ лидерийг “эрж” эхэлдэг тал бий. Мөн улс орны эдийн засаг, улс төрийн байдал, олон улсын байдлаас болоод улс төрийн хүсэл сонирхол, сонголт өөрчлөгдөх талтай.

Олон түмний улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлага нь түүнийг хангах улс төрийн үзэл баримтлал, хөтөлбөр, улс төрийн хүчин, лидерийг улс төрийн зах зээлд нийлүүлэх хэрэгцээг төрүүлдэг.

Сонгогч олон түмний улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлагыг хангаж чадах, анхаарал, сонирхлыг нь татах, тэдний олонхи нь “зохистой” гэж үзэж улс төрийн зах зээлд сонгон гаргаж ирж буй “улс төрийн үзэл баримтлал, хөтөлбөр, улс төрийн хүчин, лидер”-ийг улс төрийн зах зээлд ялан гарч ирж сонгогдох боломжтой /борлогдох бараа/ гэж үзэх боломжтой.

Тодорхой нэг улс төрийн нам, лидер сонгуульд ялах хүсэл сонирхолтой байна гэж бодъё. Энэ хүсэл сонирхлыг хангаж чадах бүх хүчин зүйлийг сонголтын хүчин зүйлийн нэр төрөл гэж нэрлэж болно. Энэ нэр төрөлд сонгогч олон түмний хүсэл таашаалд нийцсэн улс төрийн үзэл баримтлал, улс орны хөгжил, цэцэглэлтийг хангахуйц стратеги, тактик, энэ бүхнийг хэрэгжүүлэх чадвартай улс төрийн хүчин, лидер зэрэг багтана.

Эдгээр нь нэгэн зэрэг бүгдээрээ сонгогчдын хүсэл сонирхлыг бүрэн төгс хангахгүй нь ойлгомжтой, зарим нь /А/ сонгогч олон түмний хүсэл сонирхлыг бүрэн хангаж байхад зарим нь /В/ хагас дутуу, нөгөө хэсэг нь /С/ огт хангахгүй байдаг. Үүнийг улс төрийн хүсэл сонирхол хангалтын нийцэх гурван төвшин гэж үзэж болно. Тодорхой улс төрийн үзэл баримтлал, хөтөлбөр, улс төрийн хүчин, лидерийн нийгэм дэхь улс төрийн хэрэгцээ хангах чадварыг түүнийг сонгосон сонгогчдын давхардлын хэмжээгээр дүрсэлж болно. Дээрхи нөхцөлд: “А” хүчин зүйл нь сонгогч олон түмний хүсэмжилсэн зүйлс, “В” хүчин зүйлс нь тэдний хэрэгцээг хагас дутуу хангах зүйлс, “С” хүчин зүйлс нь тэдний хүсэмжлээгүй зүйлс юм.

Сонгогч олон түмний хүсэл сонирхолд тухайн улс төрийн хүчний үзэл баримтлал, дэвшүүлсэн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга механизм, гардан хэрэгжүүлэх нэр дэвшигчид нь хэдий чинээ бүрэн нийцвэл төдий чинээ амжилт олно. Улс төрийн зах зээлд өрсөлдөж буй нам, хүчнүүд өөрсдийнхөө үзэл баримтлал, хөтөлбөр, нэр дэвшигчийг нь сонгох хүсэлтэй сонгогчдоо олох, тэдний хүсэл сонирхол, шаардлагыг судалж, үүндээ үндэслэн тэдний улс төрийн хэрэгцээ, шаардлагыг бүрэн хангаж чадахуйц тийм үзэл баримтлал, хөтөлбөр боловсруулж, нэр дэвшигчдийг бэлтгэхэд оршино.

Хүмүүс улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлагаа солилцоо, сонголтын тусламжтайгаар хангахаар шийдсэн нөхцөлд л улс төрийн маркетинг учир утгаа олдог.

Хүмүүс төр засаггүйгээр, улс төрийн бүлэггүйгээр өөрөө өөрийнхөө улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлагаа хангах боломжгүй юм. Иймд үзэл бодол, ашиг сонирхлоороо бүлэглэл үүсгэх, төлөөллийн ардчиллыг ашиглах зэрэг олон хэлбэрээр улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагаа хангадаг. Хэрэв солилцоо, сонголт нь улс төрийн маркетингийн шинжлэх ухааны үндсэн ойлголт байдаг бол маркетингийн хүрээний үндсэн хэмжих нэгж нь арилжаа юм.

Арилжааг жирийн өгч, авахаас ялгах хэрэгтэй. Өгч авалцах гэдэгт бэлэг, мөнгөн тусламж, өргөлийн үйлдэл хамаарах бөгөөд энэ нь солилцооны нэг хэлбэр болно. Бэлэг өгөхдөө өөртөө аятай талтай хандуулах, буруугаа цагаатгах, нөгөө талдаа хариу барих хүсэл бий болгох зэрэг ямар нэг үр ашгийг бодолцдог. Янз бүрийн санд хандив цуглуулдаг мэргэжлийн хүмүүс өргөл баригчийн сэтгэлгээний үндэс болж байгаа “хариу барих” шалтгааныг хурцаар мэдэрч, түүний сонирхлыг хангахыг эрмэлздэг. Хэрэв өргөл баригчийг зүгээр л мартаж буюу тэдэнд талархал илэрхийлэхгүй бол уг сан удалгүй дэмжлэг авахаа болино. Үүнээс үүдэн сүүлийн үед зах зээлийн мэргэжилтнүүд арилжааны явцад үүсэх сэтгэлгээг судлаад зогсохгүй, өгч, авалцах явцад бий болох сэтгэлгээг маркетингийн хүрээнд хамааруулан маркетингийн үзэл номлолыг өргөнөөр тайлбарлах болов.

Өгч авалцах үйл ажиллагааны үед улс төрийн зах зээлийн ажилтан ямар нэг тодорхой нийлүүлэлтэнд хариу үйлдэл бий болгохыг эрмэлздэг. Энэ үйлдэл нь “худалдан авах” буюу худалдаж солилцох-той адилгүй юм. Нэрээ дэвшүүлсэн улс төрийн зүтгэлтэн сонгогчдынхоо саналыг авах, сүм хийд сүсэгтнүүдийнхээ тоог ахиулах, нийгмийн бүлгүүд “үзэл санааны дэмжигчид”-ээ олшруулахыг хүсч байдаг. Маркетинг ямар нэг зүйл, үйлчилгээ буюу үзэл санаатай харилцахдаа ямар ч хэлбэрээр байсан зохих хариу үйлдэл хийх, чиглэсэн зорилго бүхий нөхцөл байдлыг бий болгох үүднээс үйл ажиллагаагаа явуулна. Улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлага, солилцоо, сонголт, арилжаа зэрэг ойлголтууд нь “улс төрийн зах зээл” гэсэн ойлголт өөд шууд хөтөлж байна.

Улс төрийн зах зээл гэдэг нь нэгэнт өнөөдөр оршин байгаа ухамсар, чадвар бүхий сонгогчдын цогц юм.

Монголд улс төрийн зах зээл байна уу? Зах зээл гэдгийг эдийн засагт эрэлт хийгээд нийлүүлэлт, худалдагч хийгээд худалдан авагчдын уулзварыг хэлдэг бол улс төрийн зах зээл гэдэг нь ухамсартай сонголт бүхий сонгогч олон түмний

хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлага нөгөө талаас тэдний хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагад нийцсэн улс төрийн үзэл баримтлал, хөтөлбөр, нэр дэвшигчдийн уулзвар юм. Зах зээлийн тухай ойлголт “Маркетинг”-д зайлшгүй хүргэдэг. Ийнхүү солилцоо, сонголтоор дамжуулан улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагыг хангадаг, улс төрийн үйл ажиллагааны нэгэн төрлийг улс төрийн маркетинг мөн гэж тодорхойлж болох юм.

Улс төрийн зах зээлийг “улс төрийн хүчнүүдийн зах зээл”, “сонгогчдын зах зээл” гэж ангилах нь зүйтэй юм. “Улс төрийн хүчнүүдийн зах зээл” гэдэг нь түүнд улс төрийн намуудын, улс төрийн үзэл суртлын томоохон засаглал тогтсон байх бөгөөд тухайн улс төрийн зах зээлд хамгийн идэвхитэй хүчин чармайлт гаргах ёстой хүмүүс нь сонгогч олон түмэн байдаг. Тэд өөрсдөө хүчин чармайлт гаргаж улс төрийн намуудын үйл ажиллагаа, үзэл баримтлал, хөтөлбөр зэрэг холбогдох баримт материалууд цуглуулан үзэж, идэвхи, санаачлага гарган сонгуульд оролцож, тэдний төлөө саналаа өгцгөөдөг. Харин “сонгогчдын зах зээл”-д үүнээс арай өөр тогтолцоо бүрэлдэх бөгөөд үүнд “худалдан авагч” буюу сонгогч олон түмэн илүү засаглалтай байж, уг зах зээлийн хамгийн идэвхитэй хүчин чармайлт гаргагчид нь улс төрийн намууд болдог. Өнөөгийн ардчиллын нөхцөлд ийм зах зээл байх учиртай.

Улс төрийн зах зээл байна гэдэг улс төрийн сонголт байна гэсэн үг. Монгол оронд өрнөсөн нийгэм-улс төрийн өөрчлөлт, шинэчлэлтийн үр дүнд нэг намын тогтолцооноос олон намын тогтолцоонд шилжсэнээр улс төрийн сонголт, улс төрийн зах зээл эхлэлээ тавьсан. Гэвч өнөөдөр улс төрд “улс төрийн хүчнүүдийн зах зээл” бүрэлдэн үйлчилж байна гэж дүгнэж болох юм. Мэдээж үүнд “сонгогчдын зах зээл”-ийн зарим элемент, үйлчлэл байгааг үгүйсгэхгүй бөгөөд энэ шинж чанар сонгуулийн үед тодорч гарч ирдэг. Гэвч бүхэлдээ “сонгогчдын зах зээл” бүрэлдэж хараахан чадаагүй байна. Эндээс өнөөдрийн Монгол дахь улс төрийн зах зээл нь “улс төрийн хүчнүүдийн зах зээл” юм гэсэн дүгнэлтийг хийж болох юм. Үүнийг олон баримтаар нотолж болох боловч өнөөдөр үйлчилж байгаа улс төрийн маркетингийн хөгжлийн үе шат, хэлбэр, шинж чанар, үйлчлэх чиг хандлагыг авч үзэхэд хангалттай танигдана. Улс төрийн зах зээл “сонгогчдын зах зээл”-ийн төлөвт шилжин орох нь нийгэм улс төрийн амьдралд ардчилал жинхэнэ бодит зүйл болон хэрэгжих үндсэн нөхцөл юм. Ингэснээр сонгогч олон түмэн улс төрийн зах зээлийн “хаан” гэсэн хандлага үйлчилнэ. Улс төрийн зах зээл “сонгогчдын зах зээл” болоход дараахь нөхцлүүд зайлшгүй шаардагдана. Тухайлбал: Сонгогч олон түмэн улс төрийн үзэгдэл үйл явцын талаар үнэн бодит, өргөн мэдээлэл авах боломжтой байх, улс төрийн сонголт хийх, улс төрийн үзэгдэл, үйл явцад үнэлэлт, дүгнэлт өгөх чадвартай байх, сонголт хийх боломжоор хангагдсан байх буюу тэдний өмнө “сонголтууд байх”, улс төрийн шийдвэрт нөлөөлөх боломжтой, хүсэл сонирхолтой байх зэрэг нөхцлүүд бүрэлдэж байж “иргэд сонгогчид хаан” гэсэн зарчим хэрэгжих болно.

Нийгмийн амьдрал зах зээлийн зүй тогтлоор хөгжиж буй өнөө үед нийгмийн аль ч салбар маркетингийн ач тусыг ойлгон мэдэрч сонирхох болжээ.

“Сонгогч олон түмний” улс төрийн зах зээлийн үед маркетингийн гол зорилго улс төрийн нам, нэр дэвшигчийг “борлуулах” буюу улс төрийн зах зээлд ялуулах зорилгоосоо сонгогч олон түмний хэрэгцээ, шаардлага, хүсэл сонирхлыг судлах зорилго руу шилжинэ.

Улс төрийн маркетингийг сонгуулийн ялалт, эсвэл ухуулга сурталчилгаатай адилтгаж болохгүй. Энэ бол улс төрийн институт болон иргэд сонгогчдын /шинэ ба байнгын/ харилцааг сайжруулах арга зам юм. Ихэнхи улс төрчид маркетинг амжилтын үндэс болохыг батлах жишээ гаргаж чадна. Харин зарим нэг үед үр дүнд хүрэхгүй байх тохиолдол гардаг. Маркетингийг үр дүнгүй ашиглах нь хэд хэдэн алдаанаас болно. Тухайлбал: Маркетингийн удирдлагын эхний зарчмыг ойлгохгүй буюу ойшоохгүй байхаас болдог. Энэ зарчим нь “Өөрийн гишүүд, дэмжигчдийн хүсэл сонирхол, үйл байдлыг сайн мэдэх ёстой” гэсэн зарчим юм. Улс төрийн маркетинг иргэд сонгогчид, нийгмийн бүлгүүдийн улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлагыг судлахаас ажлаа эхэлдэг. Зарим үед маркетингийн тухай мэдлэггүйгээр улс төрд амжилт олох тохиолдол байдаг ч энэ нь тохиолдлын чанартай бөгөөд цаг хугацааны шалгуурт бүдэрдэг.

“Улс төрийн маркетингийг удирддаг уу? удирддаг бол хэрхэн удирддаг вэ? Улс төрийн маркетингийн удирдлага гэдэг нь улс төрийн лидер болон институтын зорилгыг хангахуйц солилцоо бий болгохын тулд үзэл баримтлал, бодлого хөтөлбөр, шинэ санааг бий болгох, үнэлэх, идэвхижүүлэх, түгээн дэлгэрүүлэх явцыг төлөвлөн гүйцэтгэх үйл ажилагаа юм, “Улс төрийн маркетингийн шийдвэр гаргагчид улс төр судлал, сэтгэл судлал, эдийн засгийн онол, гүн ухаан, математик, статистикийн мэдлэгтэй байх шаардлага гардаг.” /С.Түвшинзаяа, “Маркетингийн удирдлага” УБ., 1999, /

Улс төрийн маркетингийг удирдах гэдэг нь сонгогч олон түмний саналыг авах, дэмжигчдээ өргөжүүлэх гэсэн тухайн улс төрийн хүчний тодорхой зорилтыг хэрэгжүүлэх үүднээс сонгогч олон түмэнтэй зөв холбоо харилцаа тогтооход чиглэгдсэн арга хэмжээ шинжлэн судлах, төлөвлөх, амьдралд хэрэгжүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих явдал. Улс төрийн маркетингийг удирдах зорилго нь тухайн улс төрийн хүчний /байгууллагын/ зорилтыг хэрэгжүүлж чадахуйц улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ, шаардлагын төвшин, цаг хугацаа, шинж чанар, үйл явцад нөлөөлөхөд оршино. Энгийнээр хэлбэл улс төрийн маркетингийг удирдах гэдэг нь улс төрийн хүсэл сонирхол, хэрэгцээ шаардлагыг удирдана гэсэн үг. Улс төрийн маркетингийн удирдагчид гэдэг бол маркетингийн байдалд судалгаа хийж, зохиосон төлөвлөгөөгөө амьдралд хэрэгжүүлэн хяналт тавих үүрэг бүхий улс төрийн албан тушаалтнууд, мэргэжилтнүүд юм. Үүнд сурталчилгааны албаны удирдах ажилтнууд, маркетингийн судлаачид, имижмейкерүүд, санхүү хариуцсан мэргэжилтнүүд, тухайн улс төрийн байгууллагын удирдлагууд хамаарна.

Улс төрийн хүсэл сонирхлыг ялган тодорхойлж түүнд тохирсон зорилтыг улс төрийн маркетинг дэвшүүлдэг. Улс төрийн зах зээл дээрхи сонгогч олон түмний улс төрийн хүсэл сонирхлыг шинж чанараар нь ангилж судалж чадвал асуудлын эрэмбэ дараалал, авах арга хэмжээний хэлбэр, хэм хэмжээ зэрэг олон зүйл тодорхой болж, амар хядбар болно. Тухайлбал иргэд сонгогчид, нийгмийн бүлгүүдийн улс төрийн хүсэл сонирхлыг: “Улс төрийн сөрөг хүсэл сонирхол”, “Улс төрийн хүсэл сонирхолгүй болох”, “Улс төрийн далд хүсэл сонирхол”, “Улс төрийн буурч байгаа хүсэл сонирхол”, “Улс төрийн байнгын бус хүсэл сонирхол”, “Улс төрийн бүрэн төгс хүсэл сонирхол”, “Улс төрийн хэт хүсэл сонирхол”, “Улс төрийн зохисгүй хүсэл сонирхол” гэх зэргээр ангилж судлах нь тун чухал ач холбогдолтой.

Ийнхүү иргэд сонгогчид, улс төрийн бүлэглэлүүд, тэдгээрийг төлөөлсөн институтуудын улс төрийн хүсэл сонирхлыг ялган тодорхойлсноор түүнд тохирсон зорилтыг улс төрийн маркетинг сонгон хэрэгжүүлдэг.

Улс төрийн маркетингийн судалгааны хэрэгцээ шаардлага, арга, технологийг алдагдуулах, хэлбэрдэх хандлага ажиглагдсаар байна. Аливаа улс төрийн шийдвэрийг шинжлэх ухааны үндэстэй гаргана гэдэг бол маркетингийн судалгааг ашиглаж байна гэсэн үг юм. Нийгмийн харилцаа өөрчлөгдсөн 20 гаруй жилийн хугацаанд эдийн засгийн хүрээнд олон мянган аж ахуйн нэгж байгуулагдаж хөгжсөний хамт мөн хэдэн зуугаараа татан буугджээ. Тэд бүгд л ихийг бүтээх, амжилтанд хүрэхийг эрмэлзэж байсан нь тодорхой. Үүн лугаа улс төрийн хүрээнд олон арван улс төрийн намууд үүсэн байгуулагдаж, нэгдэж, задарч, төрийн эрхийг барихын төлөө тэмцсээр иржээ. Гэвч тэдний дийлэнхи олонхи нь энэ он жилүүдэд улс төрийн амьдралд идэвхитэй оролцож чадсангүй.

Харин нийгмийн эрэлт хэрэгцээг буюу иргэдийнхээ улс төрийн хүсэл сонирхлыг судалж, шинэ санаа олж, шинэлэг арга барилаар ажиллаж буй улс төрийн намууд, нэр дэвшигчдийн хөдөлмөрийн үр дүнг ямар нэг хэмжээгээр олж харж болно.

Маркетингийн судалгаа гэж юу вэ? Энэ бол маркетингийн өвөрмөц асуудлуудыг шийдвэрлэх болон зах, зээлд өрсөлдөөний давуу тал олж авахад хэрэглэгдэх мэдээллийг нарийн дэс дараалалтайгаар төлөвлөн цуглуулах, шинжилгээ, боловсруулалт хийх, шийдвэр гаргагчдад тайлагнах эрэмбэ дараатай үйл явц. Товчоор хэлбэл хүрээлэн буй орчиндоо үйл ажиллагаагаа зөв чиглүүлж сонгогч хийгээд зах зээлээ нарийвчлан мэдэх үйл явцыг маркетингийн судалгаа гэж ойлгож болно. Сонгогч болон улс төрийн зах зээлийн бодит байдлын тухай мэдээллүүдийг илрүүлэн олж авч, шийдвэр гаргахад хэдийчинээ хүрэлцэхүйц сайн мэдээлэлтэй байна, төдий чинээ үндэслэлтэй бөгөөд үр ашигтай шийдвэр гаргаж чадна.

Манай улс төрийн намууд, улс төрчид улс төрийн зах зээлд ухаалгаар ажиллая, үр ашиггүй шийдвэрт цаг хугацаагаа зарцуулахгүй байя, үр ашигтай зүйлийг төр, олон нийтээр дэмжүүлэе л гэж байгаа бол маркетингийн судалгааны арга зүйд суралцах, түүний үр ашгийг ашиглаж сурах нь зүй ёсны хэрэг юм.

Улс төрийн маркетингийн үр ашигтай стратеги боловсруулж хэрэгжүүлэх тулгуур нь маркетингийн судалгаа. Сонгогчдын оюун бодолд улс төрийн үнэт зүйлс, үнэлэмж, оновчтой бодлого, хөтөлбөрийг хоногшуулах, тодорхой асуудлын шийдвэрлэх хувилбаруудыг боловсруулж түүнийгээ олон нийтэд хүргэх арга, хэрэгслээ “идэвхижүүлэх”, “хэрэгжүүлэх” талаар оновчтой шийдвэр гаргахад тал талаас нь нарийн нягт бодож төлөвлөн гүйцэтгэсэн маркетингийн судалгаа нэн чухал.

Улс төрийн маркетингийн судалгааны дэс дараалал оновчтой байх нь судалгааны үр дүнг шийдвэрлэнэ. Маркетингийн судалгаа эн тэргүүнд “судлах асуудлаа тодорхойлох, судалгааны төлөвлөгөө боловсруулах, мэдээлэл цуглуулах эх сурвалж, хэлбэрээ сонгох, түүврийн болон асуулгын төлөвлөгөөгөө гаргахаас эхэлнэ. Улмаар судалгаа авагчдыг зааварлаж бэлтгэж, судалгаа явуулах цагийн хуваарийг гаргаж ажиллана. Дараагийн үе

шат бол мэдээллүүддээ хяналт хийх, кодлох, хүснэгтлэх зэргээр боловсруулалт хийсний үндсэн дээр судалгааны тайланг стандартын дагуу бичих гэсэн ерөнхий дарааллаар хэрэгждэг.

Маркетингийн судалгаа бол нэг нь нөгөөгөөсөө урган гарсан нарийн төвөгтэй, дэс дараат үйл явц бөгөөд судлах зүйл, түүний шинж төлөв, удирдлагад тулгарсан шийдвэрлэх асуудлын байдлаас хамааран эдгээр дарааллыг хэрхэн хэрэгжүүлэх, судалгааг яаж төгсгөх арга хэлбэрийг шийддэг. Зарим асуудлыг судлахад хэд хэдэн үе шатыг дараалуулсан байдлаар биш зэрэг зэрэг хийж гүйцэтгэх тохиолдол ч байж болно. Энэ нь судлаачдын мэдлэг, туршлага, чадвар зэрэг олон зүйлээс шалтгаална.

Маркетингийн мэдээлэл судалгааны тогтолцоо нь маркетингийн менежер, судалгааны зохистой арга зүй, судалгааны техник хэрэгсэл гэсэн гурван хүчин зүйлийн хослолоос бүрэлдэнэ.

Маркетингийн судалгаа ямар ямар чиглэлүүдээр явагддаг вэ? Маркетингийн судалгаа дараахи 3 үндсэн асуудалд чиглэгддэг. Үүнд: 1-рт Хийж буй ажлаа /УТ нам хийж буй, хийхээр төлөвлөж буй ажлаа/ зохистой төлөвлөхөд, 2-рт Өнөөгийн ба хэтийн төлөвийн асуудлаар оновчтой шийдвэр гаргахад, 3-рт Үнэт зүйлс үзэл баримтлал, бодлого хөтөлбөр зэргээ зах зээлийн буюу сонгогчдын шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянахад тус тус чиглэгддэг.

Маркетингийн судалгааны талаар зарим нэг ташаа ойлголтууд байдаг. Тухайлбал, “Маркетингийн судалгаа бол сонгогчдоос асуулга авах төдий зүйл юм”, “Маркетингийн судалгаа өндөр өртөгтэй, зөвхөн улс төрийн том намууд л явуулах блонжтой”, “Маркетингийн судалгаанууд хөдөлмөр зарцуулалт ихтэй учир төвөгтэй, зөвхөн маш туршлагатай мэргэжилтнүүд л хийж чадна”, “Нилээд тохиолдолд судалгааны үр дүн урьдаас тодорхой байдаг” гэх зэрэг ойлголтууд нь ташаа ойлголтууд юм. Ямар нэгэн байгууллага, институтыг маркетингийн судалгаанд хэр ойр байгааг маркетингийн менежер хүн “төлөвлөлт”, “асуудал шийдвэрлэх”, “хяналт” гэсэн чиглэлүүдэр дараахи зүйлээс харж болно. Жишээ нь улс төрийн нам дээр гэхэд л, “Төлөвлөлт”-ийн чиглэлээр: а. Намын үзэл баримтлал, бодлого хөтөлбөрийг хэн дагаж байна? Тэд хаана байна? /тэдний улс төрийн сонирхол ямар байна зэргийг тодорхойлох/ б. Намын үзэл баримтлал, бодлого хөтөлбөрийг талархан хүлээн авагчид өсөж бна уу? эсвэл багасаж бна уу? Хараахан эзэлж амжаагүй боловч эзлэх боломжтой шинэ зах зээл байна уу? в. Намын үзэл баримтлал, бодлого хөтөлбөрийг танилцуулах сувгууд өөрчлөгдөж байна уу? Маркетингийн шинэ зохион байгуулалтыг шаардаж байна уу? зэргийг тодорхойлох бол харин “Асуудал шийдвэрлэх” чиглэлээр: а. Ямар үзэл санаа, бодлого хөтөлбөр нийгмийн дэмжлэгийг хүлээх бололцоотой байна? б. Ухуулга, сурталчилгааны ямар хэлбэр илүү зохимжтой болох? в. Намын үзэл баримтлал, бодлого хөтөлбөрийг хэн, хэзээ, хаана, хэрхэн олон нийтэд танилцуулах нь илүү зохистой? Уг үйл ажиллагааг хэрхэн урамшуулах? г. Мэдээллийн ямар хэрэгслийг ашиглан идэвхижүүлэлт хэрхэн хийх вэ? Идэвхижүүлэлтэнд ямар хэмжээний зардал гаргах вэ? зэргийг судлана. Харин “Хяналт”-ын чиглэлээр: а. тухайн намын үзэл санаа, бодлого, хөтөлбөрийг дэмжигчдийн хамрах хүрээ ямар? Намын зүгээс сонгогч олон нийтийн зөв сегмент дээр ажиллаж байна уу? б. Сонгогчид манай “үзэл санаа, үнэт зүйлс, бодлого, хөтөлбөрийг үзэж танилцах боломжоор бүрэн хангагдсан уу? Гишүүд, дэмжигчид, олон нийттэй хэрхэн харилцаж байна вэ? в. Манай

намын талаархи, намын үзэл санаа, бодлого хөтөлбөрийн талаархи сонгогчдийн үнэлгээ ямар байна вэ? Өөрөөр хэлбэл бусад намуудтай харьцуулахад манай намын нэр хүнд ямар байна вэ? г.Намын “идэвхижүүлэлтийн талаар гаргасан зардал ямар үр дүнд хүрч байна? гэдгийг тус тус системтэйгээр судлан гаргасны үндсэн дээр тухайн улс төрийн нам бага зардлаар их үр дүнд хүрэх үүд нээгдэнэ..

Ийнхүү маркетингийн судалгааг 1-рт, Улс төрийн зах зээлд явуулах үйл ажиллагаагаа зохистой төлөвлөхөд, 2-рт тухайн үед тулгарсан асуудлуудаа шийдвэрлэх хамгийн оновчтой арга замыг олоход, 3-рт маркетингийн талаар гаргасан аливаа шийдвэрийнхээ үр дүнг хянаж залруулахад тус тус чиглүүлдэг гэж үзэж болно.

Нэг удаагийн маркетингийн судалгаанд дээрхи зорилтуудын алийг нь гол болгохоо судлаач ,судалгааг хийлгэж буй байгууллага хоёр тогтоох бөгөөд санхүүгийн нөөц боломжтой байгууллагууд өргөн цар хүрээтэй судалгаа явуулахдаа дээрхи зорилтуудын аль алиныг хамруулсан сонирхолтой үр дүнд хүрэх судалгаа хийж болох юм.

Харин томоохон хэмжээний судалгаа хийх боломжгүй /санхүүгийн/ нөхцөлд дараахи алхмуудыг хийж болно. Үүнд: 1-рт Тогтвортой дэмжигчдийнхээ дунд асуулга судалгаа явуулж, олдсон боломжийг ашиглан өөрсдийн санал бодлоо илэн далангүй илэрхийлэхийг хүсэх, 2-рт Оюутнуудын дадлага зэргийг ашиглан хямд төсөр судалгаа хийлгэх, 3-рт Хамтран ажилладаг байгууллага, гишүүд, дэмжигчидтэйгээ утас, интернет зэргийг ашиглан судалгаа хийх, 4-рт Бусад судалгааны байгууллага, УТ намуудын судалгааг ашиглах зэрэг алхмуудыг хийж болно.

Монгол дахь улс төрийн маркетингийн хөгжлийн өнөөгийн байдал ямар төвшинд явж байна вэ? Монголын маркетингийн холбоо байгуулагдсанаасаа хойш 20 дахь жилдээ идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Маркетингийн сургалт, эрдэм шинжилгээний ажлын хүрээ, далайц өргөжиж үндэсний төдийгүй олон улсын хэмжээнд сургалт судалгаа явуулж, гадаадын эрдэмтэдтэй хамтран ажиллаж байна. Гэвч улс төрийн салбарт маркетингийн хөгжил харьцангуй хоцрогдмол байгааг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.

Маркетинг аль ч байгууллага, институтын анхаарлын төвд улам бүр тавигдах боллоо. Шийдвэр гаргах бүрдээ зах зээл, өрсөлдөх чадварын судалгаанд тулгуурладаг болох чиг хандлага ажиглагдаж байна. Энэ утгаараа шийдвэр гаргах үйл явцад маркетингийн мэргэжилтний гүйцэтгэх үүрэг роль улам өсөн нэмэгдэх хандлагатай байна.Маркетингийн судалгаа, зөвлөгөө өгөх компаниудын тоо, зах зээлд эзлэх байр суурь улам бүр өсөн нэмэгдэж байна. Цаашид тэдний хийх судалгааны чанар, өгөөж ч дээшилж, эрэлт хэрэгцээ нь өсөн нэмэгдэх болно. Мэдээллийн технологийн дэвшил монголын маркетингийн хөгжилд шинэ үеийг нээж байна. Интернетийн сүлжээ, гар утас хөдөө орон нутгийн хэрэглэгчдийг ч хамарч байгаа нь маркетингийн хэлхээ холбооны шинэ боломж, шинэ үе шат - “интернет маркетинг”-ийн үе эхэлж байна.

Орчин үед “Алсын харааны цогц маркетинг”-ийн ач холбогдол улам бүр өсөн нэмэгдэнэ. Гадаад дотоод орчноос олон талаар хамааралтай улс төрийн зах зээлийн хэтийн хандлагад суурилахын хамт хүрээлэн буй орчин, хүний

хөгжил, эдийн засгийн өсөлтийг хамтад нь тооцсон, алс хэтийг харсан, нийгмийн чиглэлтэй маркетингийн үзэл баримтлалыг алсын харааны цогц маркетинг хэмээн тодорхойлж болно.

Эдийн засгийн салбарт 1970-аад оны дунд үед Америк Японы алсын хараатай бизнесменүүд “нийгмийн чиглэлтэй маркетинг”-ийг стратеги бодлогынхоо үндэс болгож эхлэн хүн төрөлхтөний ирээдүйг бодсон бизнес рүү хошуурч эхэлсэн бол 1990-ээд оны эхнээс дэлхийн улс төрийн манлайлах зүтгэлтнүүд байгаль, нийгэм, эдийн засгийн асуудлыг цогцоор нь хөгжүүлэх даян дэлхийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг улс орон болгоны хөгжлийн үндэс болгох улс төрийн түүхэн шийдвэр гаргаж эхэлсэн байна.

Улс төрийн маркетинг хөгжлийн дараа дараагийн шатандаа дэвшин хөгжиж чадах аваас улс төрийн шинжлэх ухаан - шинжлэх ухаанч шинж чанараа улам олох юм.

Улс төрийн аливаа институт маркетингийн үзэл баримтлалд тулгуурлан ажиллахын гол агуулга нь зөвхөн нэг удаагийн харилцаа холбоогоор хязгаарлагддаггүй бөгөөд харилцан бие биенийгээ дэмжсэн байнгын найдвартай харилцаа холбоо тогтоон ажиллахад оршдог. Монголын улс төр судлаачид ч энэ зарчмын дагуу ажиллаж их дээд сургуулийн мэргэжлийн эрдэмтэн судлаачид, янз бүрийн шатанд ажиллаж буй улс төрийн маркетеруудаас бүрдсэн, маркетингийн үзэл санаагаар нэгдсэн монголын улс төрийн маркетингийн хамтлаг (marketing community) –ийг цаашид улам бэхжүүлж, үйл ажиллагааг нь идэвхижүүлэх аваас монгол дахь улс төрийн харилцааг эрүүлжүүлж, улс орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулж чадна. Монгол хүнд нэг үеэ бодвол менежер гэдэг үг удирдах арга ухааны нарийн мэргэжилтэн гэдэг утгаар илүү ойлгомжтой болжээ. Харин одоо маркетер гэж хэн болохыг бизнесийнхэн л мэдэж эхэлж байна Маркетерийг бизнесийн байгууллагуудад “борлуулалтын менежер”, “маркетинг судлаач”, “бүтээгдэхүүний менежер”, “сурталчилгааны менежер”, “маркетингийн менежер” зэрэг янз бүрийн албан тушаалд ажиллуулж байна. Зарим үйлчилгээний салбарт “орон тооны бус маркетер”-ийг өргөнөөр ажиллуулах болсон байна.

Харин улс төрийн хүрээнд, тухайлбал улс төрийн намуудад маркетингийн мэргэжилтнүүд ажилладаг уу? тэдний хүрэлцээ хэр вэ? - Улс төрийн намуудын ихэнхи нь маркетингийн мэдлэгийг ашиглах ашиглалт тун хомс, нөгөө талаас энэ чиглэлийн мэргэжилтнүүдийн хүрэлцээ хангалтгүй байгаа өнөөгийн нөхцөлд их, дээд сургуулийн багш нар, бусад байгууллагуудад ажиллаж буй маркетингийн мэргэжилтнүүдийг “орон тооны бус маркетер”-аар ажиллуулах зэргээр улс төрийн зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх бодит боломж байгааг манай улс төрийн намууд, тэдний удирдлагууд олж харж ухаалгаар ашиглах зайлшгүй шаардлагатай. Улс төрийн маркетинг үргэлж хэрэгцээтэй байдаггүй. Тухайн цаг үе, нөхцөл байдал нь хэрэв “шудрага өрсөлдөөн байхгүй бол, сонгогчдын саналыг луйвардах боломжтой бол, стандарт бус үйлдлүүдийг хүлээн зөвшөөрч байвал, авилга оршин үйлчилж байвал ...тэнд “улс төрийн маркетинг” хэрэгцээгүй болдог. Тиймээс улс төрийн маркетинг бол улс төрийн ардчиллын таних тэмдэг төдийгүй шалгуур юм.

XXI ЗУУН ДАХЬ ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫН ОНОЛЫН АСУУДЛУУД

Л.Сарангэрэл

МУБИС-ийн УТССТ-ийн багш, докторант

Түлхүүр үг: Хүний эрхийг боловсрол, энх тайвны боловсрол, мөргөлдөөнийг зохицуулах, олон талт соёлын боловсрол, хүний эрхийг албан, албан бус боловсрол, аюулгүй байдал, хүмүүнлэг ёс, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалт, ардчилал, тэгш эрх гэх зэрэг болно.

XXI зуун дах хүний эрхийн боловсролын талаарх эрдэмтэн судлаачдын онолын үзэл баримтлал дараах байдалтай байна.

Хүйтэн дайны дараах үеийн хүний эрхийн боловсролын талаар Ж.Андреополус (**J.Andreopoulos**) авч үзэхдээ хүйтэн дайн дууссанаар оюун санааны амьдралд бага ч гэсэн тайтгарал бий болсон бөгөөд хүмүүнлэгийн асуудлуудад илүү их анхаарал хандуулах нөхцөл бололцоог⁵⁴ бий болсон гэжээ. НҮБ байгуулагдснаас хойш анх удаа олон улсын энх тайван, аюулгүй байдлыг бүрэн дүүрэн хангах, НҮБ-ийн дүрмийн нэгдүгээр зүйлийн гуравдугаар хэсэгт заасан байдаг эдийн засаг, нийгэм, соёл болон хүмүүнлэгийн шинж чанартай олон улсын асуудлыг шийдвэрлэх, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэгээр үл ялган хүний эрх, хэн бүхний үндсэн эрх чөлөөг хүндэтгэх явдлыг хөхиүлэн дэмжиж, хөгжүүлэх талаар олон улсын хамтын ажиллагааг хэрэгжүүлэх гэсэн зорилтууд гарч ирсэн байна.

Улмаар Вений тунхаглал болон Үйл ажиллагааны хөтөлбөрийн нэгдүгээр хэсгийн дөрөвдүгээр бүлэгт (Хүний эрхийн дэлхийн конференцийн сүүлийн баримт) “хүний эрх болон суурь эрхүүдийг хамгаалах хөхиүлэн дэмжих явдал нь НҮБ-ийн зарчим, зорилготой тэр дундаа олон улсын хамтын ажиллагаанд нийцсэн нэн тэргүүний зорилт байх ёстой” талаар тусгасан байна. Эдгээр зорилго, зарчмуудын хүрээнд хүний эрхийг хамгаалах, хөхиүлэн дэмжих явдал нь олон улсын хамтын нийгэмлэгийн зүй ёсны ажил гэсэн санааг анхлан дэвшүүлжээ.

Судлаач Ричард Фолк (**Richard Folk**) аюулгүй байдал болон хүмүүнлэг ёсыг тэнцвэртэйгээр хангах явдлыг судалсан бөгөөд нэг талаас дотоодын хагарал бутрал, удирдлагагүй байдлын улмаас бий болсон дайны нөхцөл, хэрээс хэтэрсэн хүмүүнлэгийн хямрал, иргэдийн шаардлагын үр дагавар нь “сул дорой улсын даван туулах шалгуур”⁵⁵ болдгийг тэмдэглэжээ.

Орчин үед мөргөлдөөний цаад гүн гүнзгий эх сурвалж нь эдийн засгийн хямрал, нийгмийн шудрага бус байдал, улс төрийн дарангуйлал, хавчлага болоод байна. Энэ нь хүний нийтлэг хэрэгцээнүүд хангагдаж чадахгүй байгаатай мөн холбоотой юм.

⁵⁴ J.Andreopoulos and Richard Pierre Claude. Edited by George. Human Rights Education for the Twenty-First Century. 2006.,page 10-20

⁵⁵ J.Andreopoulos and Richard Pierre Claude. Edited by George. Human Rights Education for the Twenty-First Century. 2006.,page 10-20

Ийнхүү өөрчлөгдөж буй нөхцөл байдалтай холбоотойгоор хүний эрхийн боловсрол ямар гол зорилтуудыг тавьж байгаа талаар авч үзэхдээ нэгдүгээрт, хүний аюулгүй байдлын асуудал, хоёрдугаарт, хүний аюулгүй байдлын тухай сургалтын стратеги, гуравдугаарт, боловсролын стратеги, дөрөвдүгээрт, бүх талыг хамарсан хүний эрхийн боловсрол нь мөргөлдөөний дараах энх тайван байдлыг бий болгоход гол үүргийг гүйцэтгэх ёстой гэсэн үзэл санааг дэвшүүлсэн байна.

Хүний эрх нь энх тайвны боловсролтой холбогдох талаар судлаач Бетти Реердон (**Betty A. Reardon**) энх тайвны боловсрол нь өөрчлөгдөн буй дэлхийн нийгэмд хариу үзүүлэх замаар байнгын тасралтгүй явагддаг дэлхийн нийтийг хамарсан хөдөлгөөн⁵⁶ гэж үзжээ. Энх тайвны боловсрол нь бага, дунд анги, их сургуулийн хөтөлбөрт “мөргөлдөөнийг зохицуулах нь”, “олон талт соёлын боловсрол”, “хөгжлийн боловсрол” гэх зэргээр нэрлэгдэж байгаа бөгөөд сүүлийн үед “хүрээлэн буй орчны боловсрол” гэсэн нэрээр явж байна. Энх тайвны боловсрол нь нийгмийн шудрага бус байдал, дайн, мөргөлдөөний асуудлыг судлахаас гадна иргэдийн энх тайвнаар амьдрахад сургадаг юм. Хүний эрхийн боловсрол нь энх тайвны боловсролтой адил хурдацтайгаар дэлхий дахиныг хамарсан боловсролын феномен болж нэгэн зэрэг хөгжиж байна.

Энх тайвны боловсролын үзэл баримтлалын цөм нь хүчирхийлэл, түүнийг хянах, бууруулах бүрэн устгах бол хүний эрхийн боловсролын хувьд хүний эрхэм сайн чанар, түүнийг хүлээн зөвшөөрүүлэх, бүрэн дүүрэн хангах, жигдлэх явдал юм.

Мөргөлдөөнийг зохицуулах нь. Энэ нь Америкийн бага дунд сургуулиудад хамгийн өргөн тархсан энх тайвны боловсролын нэг чиглэл юм. Жижиг бүлгийн болон хувь хүмүүс хоорондын мөргөлдөөнийг шийдвэрлэх арга техник, үйл явцад илүү анхаардаг байна. Багш нарын хувьд ангийн дэг журмыг хадгалах, сургуулийн орчин дах зодоон зэрэг боловсролын тогтолцоонд оршиж байгаа илүү хүнд хэлбэрийн хүчирхийллийг даван туулах, шударга зан чанар, хүчирхийлэл үл хэрэглэсэн зан үйлийн үр нөлөөг харуулахыг зорьдог.

Энэ чиглэлийн сургалт нь гурав дах хүчний оролцоотой, эсвэл хоёр тал зөвшилцөн асуудлыг шийдэх чадварыг суулгахад чиглэдэг. Ийм сургалт явагдсан сургуулиудад эерэг үр нөлөө их ажиглагдсан байна.

Олон талт соёлын боловсрол. Олон талт соёлын боловсрол нь янз бүрийн соёл хооронд дах ижил төстэй болон ялгаатай талуудыг хүндэтгэх, ойлгох, тодруулах зорилготой юм. Хүний эрхийн зарчим, үзэл баримтлалууд нь олон талт соёлын боловсролын зорилгыг илүү тодотгож өгдөг. Соёл хоорондын зөрчил мөргөлдөөнийг зохицуулах, шийдвэрлэхэд уг боловсрол чухал үүрэгтэй ажээ. Соёл бүр өөр өөрийн онцлог, хүрээлэн буй орчиндоо хариу үйлдэл үзүүлэн дасан зохицдог. Ийм нөхцөлд хүний эрхийн түгээмэл зарчим дээр тулгуурласан хэм хэмжээ нь соёлыг өөрчлөхөд гол чиг баримжаа болж өгдөг гэсэн санааг дэвшүүлсэн байна. Хүмүүс ч өөрсдөө өөрчлөгдөхөд бэлэн байх ёстой бөгөөд тэр өөрчлөлт нь гагцхүү боловсролоор дамжин явагддаг.

Нэгдсэн үндэсний байгууллагын энх тайвныг хангах үйл ажиллагаан дах хүний эрхийн боловсрол онолоос бодит амьдралд хэрэгжсэн тухай Стефан Маркс (**Stefan Marks**), Жеймс Бенкс (**James Banks**) нар авч үзэхдээ НҮБ-ын “энх тайвныг хангах” үйл ажиллагаа нь хүний эрхийн боловсролд өөрөөр хандах, хөгжүүлэх, бодит хөрсөн дээр

⁵⁶ *Betty A. Reardon. Chapter 2 Human rights as Education for peace. 1997., page 22-34*

буулгах шинэ боломж бололцоог олгосон⁵⁷ гэж үзжээ. Үүний нэг тод жишээ нь Камбож дахь нэгдсэн үндэсний байгууллагын түр захиргааны (КНҮБТЗ) хүний эрхийн боловсрол, мэдээлэл сургалтын хөтөлбөр юм. Уг хөтөлбөрийн хүрээнд 1992-1993 оны хооронд хүний эрхийн боловсролын бүх хэлбэрийг бүх түвшинд зааж сургажээ. Камбожоос гадна Эл Сальвадор, Гаити улсад энэхүү төсөл хэрэгжсэн байна.

1991 оны Парисын энх тайвны гэрээ болон 1992 оны НҮБ-ийн ЕНБ-ийн даргын илтгэлийн үр дүнд Камбожид хүний эрхийн боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай шийдвэр гарсан байна. Хөтөлбөрийг 6 үе шаттай стратеги төлөвлөгөөний дагуу явуулахаар болжээ.

Нэг дэх үе шат нь боловсролын үйл ажиллагаа чиглэгдэх зорилтод бүлгийг тодорхойлох явдал байсан бөгөөд тэдгээр бүлэгт КНҮБТЗ-аас төлөөлөл болж цагдаа, багш, их сургуулийн оюутнууд, төрийн албан хаагчид, улс төрийн намын төлөөлөл, шүүгч, прокурор, иргэний нийгмийн байгууллагаас хүний эрхийн холбоо, эмэгтэйчүүдийн байгууллага, сэтгүүлч, лам, эрүүл мэндийн ажилтнууд орсон байна. Хоёр дах үе шатанд хөтөлбөрийн төгсгөлд эдгээр бүлгүүдийн хүрэх үр дүн, хүлээлтийг тооцоолох явдал байв. Хөтөлбөрийн гол зорилго нь хүний эрхийн талаарх үзэл баримтлалууд, олон улсын стандартыг ойлгох, тэдгээрийг улс орондоо болон өөрсдийн ахуй амьдралд буулгах чадварыг суулгах явдал байлаа. Гурав дах үе шат нь сургалт, боловсрол, мэдээлэл олгоход шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх байсан юм. Дөрөв болон тав дах үе шат нь төслийг хэрэгжүүлэх цаг хугацааг тодорхой тогтоох явдал байв. Зургаа дах сүүлийн үе шат нь оролцогчидоос санал асуух хэлбэрээр төслийг үнэлэх явдал байв. Энэхүү 6 үе шатад стратеги төлөвлөгөө нь албан ба бус боловсролын хэлбэрээр хэрэгжсэн байна⁵⁸.

Албан боловсрол. Төсөл хэрэгжиж эхлэх үед Камбожийн байдал хүнд байв. Багш нарын 75 хувь, бага дунд сургуулийн сурагчдын 67 хувь, ахлах ангийн сурагчдын 80 хувь нь нэг бол амь насаа алдаж эсвэл улс орноосоо дүрвэн гарсан байв. Ихэнх сургуулиуд хаалгаа барьсан байлаа. Гэсэн хэдий ч төслийн хүрээнд хичээлийн хөтөлбөр боловсрогдон гарч, шаардлагатай ном материал, гарын авлагуудыг хэвлэн явуулын багууд орон нутгаар ажиллан сургалтыг явуулсан байна.

Их сургуулийн оюутнууд илүү идэвхтэйгээр хүний эрхийн боловсролын сургалтыг хүлээн авсан бөгөөд 3 сарын хугацаатай долоо хоногийн дөрвөн цагийн хичээлийг 242 оюутнуудад орсон байна. Оюутнууд 1) бодит байдлыг үнэлэх 2) хүний эрх зөрчигдөж байгаа асуудлуудыг тогтоох 3) тэдгээр асуудлуудад анализ хийх 4) бодлогын зөвлөмж боловсруулах үйл ажиллагааг сургалтын явцад хийсэн байна.

Албан бус боловсрол. Албан бус боловсролын цөм нь иргэд рүү чиглэж байв. Иргэдэд хүрэхийн тулд иргэний нийгмийг ашиглахыг зорьжээ. Камбожийн хувьд иргэний нийгмийн гол хүч нь хүний эрх, эмэгтэйчүүд, хөгжлийн асуудалд төвлөрөн үйл ажиллагаагаа явуулдаг сүм хийд, чөлөөт хэвлэл, ТББ байв.

⁵⁷ James Banks, *Multiethnic Education: Theory and Practice*. Boston: Allyn and Bacon, 1988., page 25-34

⁵⁸ UNTAC's *Human Rights Education Mandate and Strategy* J. Andreopoulos and Richard Pierre Claude. Edited by George. *Human Rights Education for the Twenty-First Century*. 2006., page 36-46

Сүм хийдүүдийн хувьд алслагдмал бүс нутагт хүний эрхийн боловсролыг түгээхэд тус дөхөм болж байсан бол сэтгүүлчдийн хувьд хамгийн гол нь хүний эрхийн мэдээг хэрхэн нийтлэх вэ гэдэгт суралцаж байлаа. Төрийн албан хаагчдад зориулсан хоёр долоо хоногийн сургалтыг явуулын багууд зохион байгуулсан байна.

Судлаач Кларенс Диаз ядуурал, сул дорой байдал нь тасралтгүй гарах хүний эрхийн зөрчлийг тэжээсээр байдаг. Хөгжил дэвшил нь энэхүү эргүүлэгийг зогсоож чадах бөгөөд учир нь хөгжил дэвшил ядуурлыг бүрэн устгаж чадна. Тэгвэл хүний эрхийн боловсрол нь хөгжлийн мөн чанар, үндэс суурийг бэхжүүлж түүнийг гардан явуулж байгаа субъектийг илүү үүрэг хариуцлагатай болгож өгдөг. Хүний эрхийн боловсрол нь бодит хөгжлийг бий болгоход маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Улмаар хөгжил нь эргээд хүний эрхийг баталгаажуулах, хэрэгжүүлэхэд сайнаар нөлөөлдөг. Эцэст нь ядуурал, сул дорой байдлын тамын эргүүлэг нь хөгжил дэвшлийн эргүүлэгээр солигдоно⁵⁹ гэж үзжээ. Хүний эрхийн боловсрол нь хөгжилд хэд хэдэн арга замаар нөлөөлдөг.

- ✓ Нэгдүгээрт, оршин байгаа хөгжлийн үйл явц нь хүний эрхэд хэрхэн нөлөөлж байна вэ гэдэгт илүү үр дүнтэй *мониторинг* хийх бололцоо олгоно. Энэ нь хүний эрхийг хангахаас илүү зөрчиж байгаа гажууд хөгжлийг зогсооно.
- ✓ Хоёрдугаарт, хүний эрхийн боловсрол нь олон нийтийг хохирсон нэгний ард зогсох тэдэнд дахин хөл дээрээ босох, тэднийг дэмжих үйл явцад нэгдэхэд тусладаг.
- ✓ Гуравдугаарт, хүний эрхийн боловсрол нь илүү хүмүүнлэг орчинд аж төрөх хөгжлийн загварыг ойлгоход *тусладаг*. Энэ нь иргэдийн үүсгэл санаачилгатай хөгжлийг эрчимжүүлдэг.
- ✓ Дөрөвдүгээрт, хүний эрхийн боловсрол нь төсөл санаачлах, загвар гаргах, хэрэгжүүлэх, хянах, үнэлэх, дахин эмхлэх зэрэг хөгжлийн үйл явцад илүү үр дүнтэй *оролцоход* тусладаг.
- ✓ Тавдугаарт, хүний эрхийн боловсрол нь оролцогчдыг хөгжлийн төсөл, хөтөлбөр, төсөв, санхүү, үйл явцад илүү *хариуцлагатай* ханддаг болгоход туслана.
- ✓ Зургаадугаарт, хүний эрхийн боловсрол нь хөгжлийн төсөл, бодлого, үйл ажиллагаанд оршин байгаа алдаа дутагдалыг засахад тусладаг байна.

Дүгнэж хэлбэл хөгжлийн тухай хүний эрхийн боловсрол нь хүний эрхийг илүү эрчимтэйгээр хангах, хөгжлийн явцад хүний эрхийг зөрчигдөхөөс сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаанд тус нэмэр болдог байна.

Хөгжлийн тухай хүний эрхийн боловсрол нь үзэл баримтлалын болон практик үйл ажиллагааны гэсэн хоёр талтай. Үзэл баримтлалын түвшин нь дараах гурван асуудалд анхаардаг. Нэгд, хөгжих эрх нь өөрөө хүний эрх юм. Хоёрт, хүний эрх нь хөгжлийн загвар хийгээд түүний оролцогчдын хариуцлага тооцох шалгуурыг бий болгодог. Гуравт, хөгжлийн явцад хүний бүх эрх хамгаалагдсан байх ёстой.

⁵⁹ UNTAC's Human Rights Education Mandate and Strategy J.Andreopoulos and Richard Pierre Claude. Edited by George. Human Rights Education for the Twenty-First Century. 2006.,page 36-46

Үйл ажиллагааны түвшинд хүний эрхийн боловсрол нь нэн тэргүүнд доорх хоёр асуудалд анхаарлаа хандуулдаг. Нэгд, тодорхой хөгжлийн төслүүд нь араасаа хохирогчдыг дагуулдаг явдал. Хоёрт, хүний нийгэм, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн үнэлгээний асуудал байдаг.

Судлаач Гарф Ментжес (**Garth Meintges**) хүний эрхийн боловсролын эрхийг олгох тухай санаа хоёр өөр төлөв байдлаас үүдэлтэй гэж үзсэн. Эхнийх нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг боловсрол, сургалтын үйл ажиллагааны замаар хүмүүст хүргэх бол нөгөө нь бодит амьдрал дээрх туршлага дээр суурилан хүний эрхийн ач холбогдол, үнэ цэнийг хүмүүст харуулах⁶⁰ явдал юм.

Эрхийг олгоно гэдэг нь хүмүүс болон нийтлэгүүд өөрсдийн амьдрал, түүнд нь нөлөөлж болох шийдвэрүүдийн эзэн болох эсвэл өөрсдөө хянах үйл явц юм. Европын зөвлөлөөс эрхийг олгохтой холбоотой хүний эрхийн боловсролын сургалтын дараах зорилгуудыг дэвшүүлэн⁶¹ тавьсан байдаг.

Үүнд: Хүний эрхийн түүхэн хөгжлийн гол үйл явдлуудын тухай мэдлэг, орчин үеийн хүний эрхтэй холбоотой тунхаглал, гэрээ, конвенций тухай мэдлэг, хүний эрхийн гол зөрчлүүдийн тухай мэдлэг, хүний эрхийн суурь үзэл баримтлалуудыг ойлгох, улс төрийн, эрх зүйн, нийгэм-эдийн засгийн эрхүүдийн хооронд дох ялгааг ойлгох, хувь хүн, бүлэг, үндэстний эрхийн хооронд дох харилцааг ойлгох, хүлээцтэй хандах, хэн нэгний эчнээ итгэл үнэмшлийг хүлээн зөвшөөрөх, бусдын эрхийг хүлээн зөвшөөрөх, эрх нь хязгаарлагдсан нэгнийг өрөвдөн хайрлах, мэдээлэл цуглуулах, задлан шинжилгээ хийх чадвартай болох, үйл ажиллагааны ур чадвартай болох (зан үйлээ өөрчлөхийн тулд суралцах) зэрэг болно.

Эдгээр зорилгуудад хүрэх зорилтууд нь 1) хандлагыг өөрчлөх оролдлогууд 2) үнэт зүйлсийг тодруулахад чиглэсэн харилцан яриа болон дүрд тоглох дасгалууд 3) Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын баримт бичгүүдийн гол мөн чанарыг ойлгох судлах 4) нийтлэг эрх ашиг бүхий хандлагыг хөхиүлэн дэмжих 5) хүмүүст эрхийг олгоход чиглэсэн хөтөлбөр, арга зүйг зааж сургах. Энэхүү хүний эрхийн боловсролын зорилтууд нь мэдээж бүрэн төгс биш юм.

Эрхийг олгоход чиглэсэн боловсролыг *албан* (бага, дунд, дээд), *албан бус* (албан боловсролын тогтолцооноос гаднах хүн амын дэд бүлгүүдэд чиглэсэн зохион байгуулалттай сургалт), *өдөр тутмын* (соёлын бэлэг тэмдэг, хэвлэл мэдээлэл, ажлын байр зэрэг газарт олж авах боломжтой системчлэгдээгүй боловсрол) боловсролоор дамжуулж олгох боломжтой.

Албан боловсролын хувьд хүний эрхийн боловсролыг албан ёсны боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх нь тийм ч тохиромжтой биш гэдэг санааг судлаачид гаргадаг байна.

Тухайлбал Чарльз Хенри “Сургуулиуд нь оюутан сурагчдыг оршин буй нийгмийн тогтолцоонд нийгэмшүүлэхэд чиглэгдсэн байдаг билээ. Бүр бага ангиасаа сурагчдыг тухайн дэглэм, улс төрийн тогтолцоог хүндэтгэхэд сургадаг явдал нь эрхийн тухай сургалттай зөрчилдөх болно” гэжээ. Гэхдээ албан боловсролын бүх хүрээ салбар нь

⁶⁰ Garth Meintges. Chapter 5. Human Rights Education as Empowerment: Reflections on Pedagogy. 2000., page 65-75.

⁶¹ J.Andreopoulos and Richard Pierre Claude. Edited by George. Human Rights Education for the Twenty-First Century. 2006.,page 70-80.

эрхийг олгоход чиглэсэн хүний эрхийн боловсролын хөтөлбөрт тохирохгүй гэсэн үг бас биш юм.

Хүний эрхийн боловсролыг албан бус замаар олгох нь олон давуу талтай бөгөөд эрхийг олгоход чиглэсэн хөтөлбөрүүдэд илүү түгээмэл хэрэглэгддэг. Давуу тал нь: 1) сургагч багш нарын хувьд өөрсдийн сургалтын арга зүйгээ урьдчилан тогтоосон албан боловсролын зорилго, аргад нийцүүлэх бэрхшээлтэй тулгарахгүй; 2) сургалтанд түүх, философи, социологи, эрх зүй, улс төр, эдийн засаг, антропологи зэрэг мэдлэгийн олон салбараас сургалтын материалыг боловсруулах бололцоог олгодог; 3) зорилтод бүлгүүдийг тэдний хэрэгцээ, ашиг сонирхолд нь тулгуурлан ялган тогтоож, зохион байгуулж болдог; 4) албан бус боловсролын уян хатан байдал нь сургагч багш нарт хичээлийн хөтөлбөрөө илүү бүтээлч, шинийг санаачилсан хэлбэртэйгээр боловсруулах боломжийг олгодог.

Албан бус боловсролын гол сул тал нь хүлээн зөвшөөрөгдөх байдал болон нөөц боломжийн асуудал юм. Зохион байгуулагчдын хувьд өөрсдийн оролцогчдын хүрээлээс гадна олон нийтийн дунд хүлээн зөвшөөрөгдөхөд бэрхшээлтэй тулгардаг бөгөөд сайн дурын болон хандивын санхүүжилт, нөөц дээр тулгуурлаж үйл ажиллагаагаа явуулах хэрэгтэй болдог.

Өдөр тутмын мэдээллийн эх сурвалжууд нь хамгийн өргөн тархсан боловсрол, харилцаа холбооны арга хэрэгсэл байж болох юм. Тогтолцоот бус шинж чанар нь энэ хэлбэрийн боловсролын сурган хүмүүжүүлэх ухааны ашиг тусыг хязгаарладаг. Гэхдээ албан ёсны боловсролтой холбож туршилтын боловсролын хөтөлбөртэй нэгтгэж өгсөнөөр илүү амжилтанд хүрэх боломжтой.

Хамгийн үр бүтээмжтэй сургалтын орчин, нөхцөлийг бий болгохын тулд нэгдүгээрт, нэг талаас багш суралцагч хоёр, нөгөө талаас суралцагч болон мэдлэгийн хооронд дох уламжлалт харилцааг өөрчлөх хэрэгтэй, хоёрдугаарт, шатлан захирах ёс нь харилцан ярианы хэвтээ, хөндлөн харилцаагаар солигдож, сургагч багш нар нь сайн сонсогч болж хувирах хэрэгтэй юм. Энэ нь суралцагчдыг мэдлэг олж авах тасралтгүй үйл явцад үр бүтээлтэй, шууд оролцох нөхцөлийг хангана, гуравдугаарт, энэхүү харилцан яриа хэлбэрийн сургалтыг цааш хөгжүүлэхийн тулд суралцах орчинг ардчилсан, тайван байх нөхцөл боломжоор хангаж зохион байгуулах нь чухал юм. Ямар нэг байдлаар захирагдсан, баригдсан сургалтын орчинд байгаа суралцагч сурах үйл явцад тайван чөлөөтэй, идэвхтэй оролцож чадахгүй, дөрөвдүгээрт, суралцагч болон мэдлэгийн хооронд дох харилцааг өөрчлөхийн тулд сургалтанд хүмүүсийн амьдралд тохиолдсон бодит үйл явдал, жишээ, нөхцөл байдлыг илүү ашиглах нь оновчтой.

Хэдийгээр ерөнхий үзэл санаа, үзэл баримтлалууд чухал боловч түүнийг суралцагчийн өөрийнх нь хувь хүний туршлагаар баяжуулж дэлгэрүүлэх хэрэгтэй.

Эцэст нь хүний эрхийн боловсролын сургалтын ач холбогдол, үр дүнг хэмжих, үнэлэх явдал бөгөөд үнэлгээ нь суралцагчидын хүний эрхийн зарчмуудын мөн чанар, түүхийн талаар амжилттай суралцсан, тэдний үйл байдалд өөрчлөлт гарсан эсэхийг хэмждэг. Үнэлгээ нь дараах шалгууруудыг тавьсан байвал зохино: 1) Суралцагсадын хүний эрхийн багтаамжийг таньж мэдэх, дасгал ажлууд дээр ажиллах чадвар; 2) эдгээр эрхүүдийг хамгаалах, дэмжихэд оруулах хувь нэмрээ ухамсарладаг, өөрийгөө илэрхийлж чаддаг байх; 3) гарч ирэх хариултуудад үнэлэлт өгөх; 4) шинэлэг, бүтээлч хариултуудыг олж тогтоохыг оролдох; 5) аль сонголт нь илүү тохирохыг шийдэх, эрэгцүүлэх; 6) шийдвэр гаргаж хариуцлагын хүлээх өөртөө итгэх итгэлтэй байх, түүний үр дүнгийн нөлөөллийг танин мэдэх эдгээр орно.

ЮНЕСКО-гийн 1974 онд гаргасан хүний эрхийн боловсролтой холбоотой зөвлөмж нь хүний эрхийн талаархи үзэл санаа, төсөөллийг өргөжүүлээд зогсохгүй мөн

хязгаарлаж өгсөн байна. Энэ зөвлөмжид “боловсрол” хэмээх ойлголтыг хүний хувийн чадавхи, чиг хандлага, авъяас чадвар, мэдлэгт нөлөөлж байдаг “нийгмийн амьдралын бүхэл бүтэн үйл явц” гэж тодорхойлжээ. Хүний эрхийн боловсролын зорилгыг “олон улсын харилцан ойлголцол”, “хамтын ажиллагаа”, хүмүүс болон засгийн газар хоорондын нөхөрсөг харилцааг нэгтгэсэн “энх тайван”, “хүний эрх болон суурь эрх чөлөөг хүндэтгэх” явдлыг хөхиүлэн дэмжих юм гэж заажээ.

Зөвлөмжид хүний эрхийн боловсрол нь доорх асуудлуудыг хөндөн гарч ирж байна гэж үзсэн. Энэхүү зөвлөмж нь хүний эрхийн боловсролыг түгээмэл тунхаглалаас илүү өргөн хүрээнд дүрслэн гаргасан байна.

Abstract

Purpose of the article is to study scholar's concept about human rights education for the XXI century, including human rights education in the post cold context, human rights as education for peace, conflict resolution and providing human rights through formal and non-formal education.

Ашигласан материал, баримт бичгүүд

1. J.Andreopoulos and Richard Pierre Claude. Edited by George. Human Rights Education for the Twenty-First Century. 2006.
2. Betty A. Reardon.Chapter 2 Human rights as Education for peace. 1997.
3. James Banks, Multiethnic Education: Theory and Practice.Boston: Allyn and Bacon, 1988.
4. UNTAC's Human Rights Education Mandate and Strategy.
5. Garth Meintges. Chapter 5. Human Rights Education as Empowerment: Reflections on Pedagogy. 2000.
6. Бүх нийтийн боловсрол дахь хүний эрхэд суурилсан хандлага. НҮБХС, НҮБ, БСШУЯ. 2007
7. Nancy Flowers, Human Rights Educator's Network, Amnesty International USA
8. Raising one voice8 A Training Manual for Advocates on the Rights of Child Domestic Workers8 Child Workers in Asia, 2005
9. UNICEF (2005) A Campaign in East Asia and the Pacific to Stop Violence against children. Bangkok, Thailand
10. Willms, J. D. (2000). Standards of care: Investments to improve children's educational outcomes in Latin America. Paper presented at the "Year 2000 Conference of Early Childhood Development" sponsored by the World Bank, Washington, D.C., April, 2000.

МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН СЭТГЭЛГЭЭ БА ОРЧИН ҮЕ**“АРВАН БУЯНТ НОМЫН ЦАГААН ТҮҮХ” БА МОНГОЛ ТӨРТ ЁСНЫ ХӨГЖИЛ
Л.Идэр***МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн докторант*

Түлхүүр үг: Хубилай хааны төрийн бодлого, Хоёр ёс, номын засаг, хааны засаг

Товч хураангуй: Монгол туургатны өвөг дээдэс бүр МЭӨ III зууны орчим, Хүннү гүрний цагаас тулгар төрөө байгуулсан билээ. Монгол төрт ёсны энэхүү үүсэл хөгжлийг дагалдан, түүний хэрэгцээ шаардлагыг тусгаж төрт ёсны сэтгэлгээ нь ч гүнзгийрэн хөгжсөөр иржээ. Монголын шашин төрийн харилцааг зохицуулах хоёр ёс нь Нирун улсын үеэс үүдэлтэй бөгөөд ХХ зууны эхэн хүртэл Монголын төрт ёсны сэтгэлгээний зонхилогч чиг хандлагыг тодорхойлсоор ирсэн. “Цагаан түүх” дэх “хоёр ёс” гэдэг нь иргэний засаг, номын засаг хоёрыг эн чацуухан хослуулж, төрийн хууль зарлиг цэргийн дэг журмаар ард олныг удирдахын зэрэгцээ энэ болоод хойт насны өмнө гүйцэтгэж буй ариун үйлс гэж байлгах ёстой хэм хэмжээг дээд тэнгэр бурхны зарлиг болгон номлодгоороо олон түмний эрхийн ухамсарт хүчтэй тусаж байсан ажээ. “Цагаан түүх” дэх “хоёр ёс” аль нэг нь тэгш хэмээс гажвал төр нийгмийн хямрал болдог тул өөр өөрийн жинхэнэ жам ёс горим журмаар нь эн чацуу зэрэгцүүлэн хөгжүүлэх шаардлагатай гэдэг.

Монголчууд нь эртний төр ёсны уламжлал мэдлэгтэй ард түмэн билээ. Монголын төрийн сэргэн мандалтын оргил үе болох XIII-XIV зууны үеийн Монголын гүн ухаан, нийгэм улс төрийн сэтгэлгээн дэх шашин төрийн харилцааны онцлог гэвэл төр шашныг хослох тухай “Цагаан түүх” дэх хоёр ёсны онол цэгцрэн боловсорч нийгэм улс төрийн салбарт бодитойгоор хэрэгжих болсон явдал юм. Монголын төрт ёсны сэтгэлгээнд өөр өөрийн өвөрмөц өнгө аяс, дүр төрх бүхий олон янзын үзэл онол үүсэн гарч халагдан солигдож ирсэн хэдий ч нийт дундад зууны туршид Монголын төрт ёсны сэтгэлгээний зонхилох чиг хандлагыг тодорхойлж байсан. Монголын төрт ёсны сэтгэлгээний өдгөө бидэнд мэдэгдэж байгаа хамгийн анхны дурсгал дурсгал бичгүүдийн нэг нь “Арван буянт номын цагаан түүх” хэмээх алдарт зохиол даруй мөн болно. Монголын их бага хаад тэдний үе үеийн хууль цаазын дурсгал бичгүүдэд нэг талаас эзлэгдсэн харъяат орнуудын хүн амыг өөр өөрийн шашин суртлаа шүтэн бишрэхийг зөвшөөрч хүндэтгэх нөгөө талаас уламжлалт бурхан шашныг төрийн шашин болгож тууштай явуулж ирснийг Юан гүрний төрийн байгууллагыг бүрдүүлэн тогтоох чиглэлээр Хубилай хааны буулгасан удаа дараагийн зарлиг цаазын эмхтгэл энэхүү “арван буянт номын цагаан түүх” хэмээх сурвалж бичигт тод томруун тусгажээ. Уг сурвалж бичигт шашин төрийн харилцааг журамлан цэгцэлсэн хоёр ёсны тухай онол хамгийн тодорхой бөгөөд Монголчуудын түүхэнд тодорхой нөхцөл төр ёсны болон шашин, гүн ухааны сэтгэлгээний өвөрмөц онцлогийг тусгасан байдлаар бүрэн боловсорсон гэж үзэж болно. Монголын шашин төр нь хоорондоо нягт уялдаатай байж, өвөрмөц байдлаар хосолж ирсэн түүхэн уламжлалтай. Энэхүү уламжлал нь өнөө үед ч цаг үеийнхээ шинэ нөхцөл байдлыг тусган шинэчлэгдэн өөрчлөгдсөөр байгаа билээ. Эртний Монголчуудын төр ба шашны ухамсар үүсэх түүхэн нөхцөл нь нийгэмд хувийн өмч үүсэж, хөдөлмөрийн ялгаа бий болсон тэр цаг үе, тухайлбал анхны төрт улс болох Хүннү гүрэнтэй холбоотой билээ. Хүннү улс нь

бурхны шашныг төрийн байгууллагыг бэхжүүлж, нийгмийг нэгдэлтэй байлгахад ач холбогдолтой гэж үзэж, төрт ёсны үзэл суртлын үндэс болгохыг эрмэлзэж байсан бололтой. Сяньби улс нь Хүннү нартай гарал угсаа нэгтэй Монгол угсааны улс бөгөөд Сяньби нарын түүхэн баримтаас үзэхэд Табгач аймгийнхан шүтэх бодлогыг явуулдаг байжээ. Монголчууд бүр Хүннүгийн үеэс төвлөрсөн хүчирхэг төр засагтай явж ирсэн уламжлалтай. XIII зуунд энэ уламжлалаа алдаагүй харин түүнийг өвлөн авч шинэ шинэ зүйлээр баяжуулсан учир Монголчууд дахин асар хүчирхэгжиж чаджээ. Энэ үеийн хаад бол тохиолдлоор төр засгийн тэргүүнд гарч ирэгсэд бус, харин улс үндэстнийхээ тусгаар тогтнол, хөгжил цэцэглэлтийн төлөө цогтой тэмцэгчид, ард олныхоо итгэл найдварыг бүрнээ хүлээсэн гавъяат үйлснүүд байсан юм. Тэднийг түүх дэвшүүлэн гаргаж ирсэн бөлгөө. Энэ учир шалгаран гарч ирсэн тэр хүнээ цөөнхийн сонгуулиар сонгож байжээ. Энэ нь бас нарийн утга учиртай юм. Төр засгийг удирдах энэ ажлыг зөвөөр шийдвэрлэхийн тулд зөвхөн мэргэшсэн хүмүүс шаардагдана. Цөөнх гэдэг бол чухамдаа тэрхүү мэргэшсэн боловсорсон хүмүүс мөн. XIII зууны Монголын их хуралдай бол мэргэшсэн, боловсорсон хүмүүсийн чуулга байсан юм. Их Монгол улс дэлхийн соёл иргэншлийн төв болон мандаж байсан нь төр улсынхаа тэргүүнийг зөв, онож тавьдаг, улс төрийн холч, мэргэн бодлого явуулж ирсэнтэй ямар нэг хэмжээгээр холбоотой. Хүн амаа хэд хэдэн шат бүхий зэрэг дэв болгон хуваан захирч ирсэн нь Монголын төрийн нэг онцлог болой. "...Хүн амын ихэнх нь болох доод зэрэг дэвтэй ард иргэд, аравт, зуутын захирагч хүмүүсийг төрийн чухал асуудал хэлэлцэхэд оролцуулахгүй, уг асуудлыг дээд зэрэг дэвтэй цөөнх хэсгээр нь шийдвэрлүүлж"⁶² байжээ. "Хүмүүс зэрэг дэвийн хирээр нийгэмд гүйцэтгэх өөр өөрийн үүрэгтэй байх ёстой. Нэгийг нь нөгөөгөөр нь сольж үл болно"⁶³. Дорно дахины нэг л хүн эрх чөлөөг эдэлнэ, тэр нь төрийг тэргүүлж буй захирагч, дорно дахины хүмүүс захирагч хэмээх төвөө тойрон хүрээлсэн байна. Тэрхүү Ромын эзэнт гүрний захирагч шиг дарангуйлагч биш, овгийн ахлагч лугаа адил хүндэтгэлтэй хүн юм"⁶⁴. Монголчууд үеийн үед төрийн тэргүүнээ дээдлэн хүндэлж, дээд тэнгэр язгууртан хэмээн шүтэж, тэрхүү шүтлэгээ дагаж захирах захирагдах ёсыг чанд сахиж иржээ. Ард олон эзэн хаанаа тэнгэр гаралтай хэмээн түүнд шүтэн захирагдаж, эзэн хаан ч өөрийнхөө зарлигийг тэнгэрийн зарлиг хэмээн үзэж байжээ. Төрийн тэргүүний нэр хүндийг өндөрт өргөж явах нь нийгэм, улс гүрэн эмх цэгцтэй, хэвийн байдлаар хөгжих нэг баталгаа болно. Шүтэн захирагдах ёс нь хүмүүсийн харилцаа бүх салбарт нэвтэрч, Монгол түмний оршин тогтнох үндэс болж хувирчээ. Залуучууд ахмад үеэ, үр хүүхэд нь эцэг эхээ, эхнэр нь эр нөхрөө, шавь нар нь багш нараа, харц ард нь хаад ноёдоо шүтэж, түүнд захирагдана гэдэг нь оюун ухаанаа дээдлэн хүндэлж, шүтэж түүндээ захирагдана гэсэн үг мөн. Тиймээс ч Монголчууд хаад ноёдын нийгэмд эзлэх байр суурийг хуульчлан тогтоож байжээ. Энэ бол ихэс дээдсийн шүтэн тэдэнд захирагдах сэтгэл зүйг ард олонд бий болгох нэг нөхцөл байжээ. XIII зуунд эцэг эхээ хүндэтгэж шүтэх ёсыг төрийн түвшинд тавьж хэрэгжүүлж байжээ. Монголчууд тэнгэр эцэг, газар эх хэмээн бишрэн шүтдэгт Мөнх хөх тэнгэр л манай амьдралын хувь заяаг шийдвэрлэдэг аж. III-IV зууны үед хаанаар өргөмжлөхдөө хааны удам угсааны 7 хүн хаанаа хар эсгий дээр суулган баруун зүг харуулж сар, од, тэнгэрт мөргүүлж хаан ширээнд залж байсан гэж бичсэн

⁶² Н.Хавх "Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан" УБ., 1995 он, 87 дахь тал.

⁶³ Л.Цэенбазар "Их Монгол улс" УБ., 2000 он, 38 дахь тал.

⁶⁴ Дээрх бүтээлийн 39 дэх тал

байна. Сяньби улсыг үндэслэн байгуулагч нь Тяншихуай. Тэд бөө мөргөл бурхны шашныг өөрсдийнхөө эрх ашигт тааруулан төр, улс төрийнхөө үзэл сурталд ашиглаж байжээ. Монголын эртний төрт улсууд болох Хүннү, Сяньби улсын дараагийн халааг авч гарч ирсэн Монгол угсааны улс болох Жужан буюу Их Нирун улс юм. Нирун улс манай эриний 330-550 оны хооронд оршин тогтносон хийгээд "... Нирун улсын төрийн багшаар Дхармаприя буюу Фа ай гэдэг ламыг шашны судар, шашдир, зурхай сайн мэддэгийн тул 420-460 оны үед өргөмжилжээ. Хаан түүнд 3000 өрх тэргүүтнийг соёрхсон байна. Үүнээс үзвэл 1 талаар Нирун улсын үед язгууртан ноёдын зэрэгцээгээр жирийн олон түмэн, жишээлбэл Дхармаприяд соёрхсон хүмүүс бурхны шашныг шүтэж эхэлсэн, нөгөө талаар Энэтхэгийн Ашока, Кушаны Канишка нарын төрийн бодлогоос үндэс болж байсан. "Эртний Энэтхэгийн төр ба номын ёсыг ёслох 2 зарчим нь нүүдэлчдийн улсад ийнхүү анх хэрэглэгдэж ирсэн бололтой"⁶⁵. Чингис хаан насан турш бөөгийн шүтлэгтэй явж ирсэн бөгөөд түүний төрийн үйл хэрэгт төрийн Бэхи Үсүн өвгөн, төрийн зайрангийн хэмжээнд залагдахуйц Хөхөчү Түв тэнгэр зайран бөө, Чингис хааны итгэлийг олж, бусад бөө удганаас илүүтэй хүндлэгдэж байжээ. Үсүн өвгөн "...Тэнгэр шинжиж он, сар, өдрийг тодорхойлон цаг улирлын тооны бичиг зохиож, нар сар хиртэхийг урьдаас мэдэн хаанд айлтгах, ан авд мордох өлзийтэй өдөр, цагийг зааж өгөх зэргээр үүргээ гүйцэтгэж байжээ"⁶⁶. Чингис хаан төрийн зайран болон төрийн төрийн бэхитэй байв. Бусад шашнуудын тал дээр тэр бээр нилээд төвийг сахисан байр суурьтай байсан гэхэд болох хийгээд төрийн багштай байсан эсэх талаарх мэдээ нэн ч тодорхойгүй байна. Их Монгол улсын үед шашин төрийн харилцаанд өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой байсан. Чингис хаан эзэлж авсан янз бүрийн сүсэг бишрэлтэй олон үндэстэн ястныг их гүрний захиргаанд барьж байхын тулд шашны тал дээр уян хатан бодлогоо баримталж, хүн бүхэн өөрийн дуртай шашныг шүтэх бодлогыг явуулдаг байжээ. Чингис хааны энэ бодлого нь шашны хоорондын мөргөлдөөн үүсэхээс сэргэмжилсэн улс төрийн ухаалаг бодлого юм. Чингис хаан тархай бутархай олон овог аймгуудыг нэгтгэж улсыг байгуулж их засаг хэмээх Монголын анхны бичигдмэл хуулийг баталж гаргасан. Их засаг хуулиараа тухайн үеийн нийгмийн харилцааны бүхий л асуудлыг зохицуулж байсан бөгөөд түүнд нь шашин төрийн харилцааны асуудал ч мөн багтаж байсан. Монгол их хаад бурхны шашныг тэтгэн өөрийн төрийн шашин болгохын хамт Энэтхэг, Төвдийн соёлын өвийг сонирхон таалах болсон байна. Ер нь Монголын их хаан Чингис түүний залгамжлагчид болох Өгэдэй, Гүюг, Мөнх хаадын үед Монголчуудын голлох шашин нь язгуурын бөөгийн шашинд байсан бөгөөд ялангуяа Чингис хааны үед төрийн шашны хэмжээнд байсан гэх бүрэн үндэстэй. Хубилай хааны умард Хятадыг эзлэн сууж байхдаа Хятад түшмэдийн тусламжтайгаар тэдний эртний хуулийг орчуулан сонирхон судалж тэр дундаа Хятадын эртний Тан улсын хуулийг анхааран үзэж байжээ. Энэ нь нүүдэлчний ахуй, зан заншил, төрийн хэв маягт тохируулан байгуулсан. Их засгийн агуулгаар эртний соёлт Хятадыг барьж болохгүйг ойлгуулж байсантай холбоотой, Хубилай хаан тухайн үеийн Хятад түшмэд нилээд зөвөлгөө өгч ятган Хятад улсыг эзлэе гэвэл заавал Хятад улсын хуулиар явах хэрэгтэй, Хятад улсын хууль хэрэглэвэл сая удаан тогтож чадна гэж хэлж байв"⁶⁷. Мөн

⁶⁵ Н.Хавх "Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан" УБ., 1995 он, 87 дахь тал

⁶⁶ Ч.Далай "Их Монгол Улс" УБ., 2006 он, 231 дахь тал

⁶⁷ Б.Баярсайхан "Монгол улсын арван буянт номын цагаан түүх" УБ., 2002 он, 18 дахь тал

Хубилай хааны бичгийн түшмэл Сюи хэн Монгол улсын говь хязгаарын чанад үүссэн учир эдүгээ тэдний уг ёс Хятад газарт таарахгүй болсон тул Хятад ёс хууль ба хэрэглэхээс өөр аргагүй болсон гэж бичсэн байна⁶⁸. Арван буянт номын цагаан түүх төрийн бодлогын үндэс төр их хаан, төрийн албан хаагч, шашны мяндагтны эрдэм чадал, тэдгээрийг баримталбал зохих албан ёс зүйн хэм хэмжээ, тэдгээр албан тушаалтнуудын үйлдсэн аливаа гэмт үйлдэлд ноогдуулах ял шийтгэлийн хэлбэр зэргийг тусгасан эрх зүйн гол эх сурвалж юм. Зарим судлаач хуулийн эмхэтгэл тэр тусмаа захиргаа ба хууль цааз, мөн нөгөө нэг утга нь төр ёсны сургаалийг.....агуулсан хоёрдмол шинжтэй бүтээл гэж үзсэн байна⁶⁹. Арван буянт номын цагаан түүхийн сурвалж бичигт Монгол улсын дөрвөн төрийн арван буянт номын цагаан түүх гэж тэмдэглэсэн байдаг бөгөөд зарим нэг судлаачийн бүтээлд XIII-XIV зууны Монголын төрт ёсны сэтгэлгээн дэх цоо шинэ чиглэлийн үзэл санаа гарч ирсэн гэж дүгнэсэн нь учир дутагдалтай байна. Учир юун гэвэл энэхүү төрт ёсны сэтгэлгээ МЭӨ III зууны үед буюу Хүннү үеийн үед гарч иржээ. Хубилай хааны төр ёсны шинэтгэл бол Монголын нийгмийн сэтгэлгээний түүхэнд энэ зууны эхэн хүртэл уламжилсан ертөнцийн засаг хийгээд номын засгийн тэгшид явуулах зорилго бүхий хоёр ёсны номлол юм⁷⁰. XIII зууны 60-аад оны дунд үеэс Монголын эзэнт гүрний төрийн байгууламжийн бүтцэд өөрчлөлт орж эрх мэдэл төвлөрсөн дорно зүгт шилжих Хятад маягийн хэв загвар бүхий гүрэн байгуулагдсанаар Монгол төрийн язгуур ашиг сонирхол, Чингисийн бодлогын залгамж шинж алдагдаагүй гэх үзэлтэй. Хубилай эртний Төвд, Энэтхэгийн хаадын үзлээр шашин төрийн тэгш явуулах хоёр ёсны харилцааг зөв тогтоож улсыг номын ёсоор засаж энх амгалан болгох мөн төрийн ёсоор засаж жаргалын дээдийг эдлүүлэх үндсэн санааг баримтлан төр ёсыг тогтоосон байна. Энэ тухай "Цагаан түүхэнд" дээд шашны үндэс номын эзэн лам ба их төрийн эрхэм ертөнцийн эрхэт хаан хийгээд үнэн номын засаг хэвийн зангаа мэт алдаршгүй, хийд хааны засаг алтын буулга мэт эвдэршгүй⁷¹ гэжээ. Төрийн суу билэгт хаан, төрийн их сайд, түшмэлийн эрдэм боловсрол, бие сэтгэлийн ёс жудагийг 3 их үйл, 4 их төр, 6 их үлгэр, 7 их бин, 9 их бэлэгээр тэгштгэн тогтоожээ⁷². Энэ нь төрийг улам хүчтэй болгох гэсэн санааг агуулж байна. Ер нь төр хүчтэй, түвшин амгалан байхын эрхэм уг санаа нь зөвхөн хааны хүч, эрдмээс хамааралтай байдаггүй түүнийг хүрээлсэн ард түмэн, түшмэд буюу төрийн аппарат гэсэн гурвал хэлбэрээр оршиж төр, улс хүчтэй байх тухай сургасан номлол юм. Ард иргэнийг амгалан тайван байлгах нь төрийн үүрэг хэдий ч иргэдэд сургасан номлол, сургаал цөөнгүй байна. Хубилай нь төрийг үзэх үзэлд хоёр ёсны эрхэмлэн тэгш явуулахыг сургаж төрд эрдэм чадал ихт төрийн сайд түшмэлийн дагах ёстой ёс журмыг чухал үзэж төрөөс тогтоосон хэм хэмжээг дагахаас гадна сэтгэлийн буюу номын засгийг чухалчлан үзэж түүний ёсыг хатуу номлон сургаж байжээ. Хубилайн хоёр ёсыг тэгш явуулж байхыг эрхэмд үзэж төрийн албан ёсны тэмдэглэлт өдрүүдийг түмэн олон тэмдэглэн өнгөрүүлж байх тухай "Цагаан

⁶⁸ Дээрх бүтээлийн мөн тэнд

⁶⁹ Монголын философийн түүх УБ., 2002 он, 280 дахь тал

⁷⁰ Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил УБ., 1995 он, тэргүүн боть, 63 дахь тал

⁷¹ Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал УБ., 2002 он, 63-64 дэх тал

⁷² Ч.Жүгдэр "Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ" УБ., 2002 он, 147-148 дахь тал

түүхэнд” нарийн зааж өгсөн байна. Энэ нь түмэн олныг эмх журамтай байлгах гэсэн гол үзэл баримтлал байсан байх гэлтэй⁷³.

Ном зүй

- А. Амар “Монголын товч түүх” УБ., 1989 он
 Т.Алтангэрэл “Монгол-Ойрадын их цааз төр эрх зүйн түүхэн эх сурвалж болох нь” УБ., 2001 он
 Б.Баярсайхан “Монгол улсын арван буянт номын цагаан түүх” УБ., 2002 он
 Буддын судлал №1 УБ., 1989 он
 Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан “Монголын төр эрх зүйн түүхэн уламжлал” УБ., 1997 он
 Д.Гонгор “Халх товчоон” УБ., 1970 он
 Ч.Далай “Их Монгол Улс” УБ., 2006 он
 Д.Дагвадорж “Бурхны шашин, Монгол уламжлал” УБ., 2002 он
 С.Жалнаажав “Цагаан түүхийн тухай”
 Ч.Жүгдэр “Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ” УБ., 2002 он
 Н.Ишжамц “Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь” УБ., 2002 он
 Монголын философийн түүх УБ., 2002 он
 Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжил УБ., 1995 он, тэргүүн боть
 Монгол улсын түүх тэргүүн боть УБ., 2003 он
 Н.Хавх “Монголчуудын соёл иргэншлийн гүн ухаан” УБ., 1995 он
 Л.Цэенбазар “Их Монгол улс” УБ., 2000 он

⁷³ Монголын төр ёс, эрх зүйн сэтгэлгээний зарим асуудал УБ., 2002 он, 64 дэх тал

МОНГОЛ ТӨРИЙН ЗАСАГЛАЛЫН ЭРХ МЭДЛИЙН ХУВААРИЛАЛТ, ТЭНЦВЭРЖИЛТ

Д.Болд-Эрдэнэ

ФСЭЗХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор

Товч агуулга: Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх зарчим бол ардчилсан засаглалын сонгодог суурь үзэл санаа юм. Энэ үзэл санаа ардчилсан улс орон бүхэнд өөрийн онцлогтой илэрч үйлчилж байдаг. Тиймээс тухайн асуудлыг онол, эрх зүйн талаас нь харьцуулан шинжлэх хэрэгтэй болдог. Энэ бүхэнд хамаарах онол, практикийн зарим тулгамдсан асуудлыг Монголын жишээн дээр эл өгүүлэлд дэлгэрэнгүй авч үзсэн болно.

Түлхүүр үг: Төр, төрийн эрх мэдэл, төрийн засаглал, төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онол, зарчим, хууль тогтоох эрх мэдэл, гүйцэтгэх эрх мэдэл, шүүх эрх мэдэл, эрх мэдлийг хуваарилах, эрх мэдлийг хянах, эрх мэдлийг тэнцвэржүүлэх

* * * * *

Онол, үзэл санааны товч тойм

Үндсэн хуулийн тулгуур үндэс, амин сүнс нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санаа юм. Тиймээс ч төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилаагүй, тэдгээрийн хоорондын харилцааг тэнцвэржүүлээгүй нийгмийг ардчилсан Үндсэн хуультай нийгэм хэмээн ойлгох аргагүй. Энэ агуулгаар авч үзвэл төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан, тэнцвэржүүлэх нь Үндсэн хууль бодитой оршин үйлчлэх баталгаа болдог байна.

Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санаа нь улс төрийн шинжлэх ухаан, төрийн онол, үндсэн хуулийн эрх зүй зэрэг олон шинжлэх ухааны мэдлэгийн зааг уулзвар дээр судлагдах онолын болон практикийн өргөн агуулга бүхий цогц судлагдахуун юм.

Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санааны тухай авч үзэхийн өмнө түүнтэй холбоотой зарим ойлголт, нэр томъёог жигдлэн нэг мөр тайлбарлах шаардлага зүй ёсоор гарч ирдэг. Энэ асуудлыг авч үзэх явцад “засаглалыг хуваах”, “засаглалын гурван өндөрлөг”, “гурван засгийн онол”, “засаглалын салаа мөчир” гэх зэрэг олон ойлголт нэр томъёог судлаачид хэрэглэж иржээ. “Засаглалыг хуваах”, “засаглалын гурван өндөрлөг”, “гурван засгийн онол” гэх зэрэг нэр томъёо нь асуудлыг будлиантуулан буруу тайлбарлан ойлгоход нэрмээс болж мэдэх оноогүй, зөв биш нэр томъёо болох нь илэрхий. Харин “засаглалын салаа мөчир” гэдэг нь ердийн ухамсарын түвшинд ойлгомжтой мэт боловч шинжлэх ухааны судлагааны хүрээнд төдий л ончтой үг хэллэг бас биш юм.

Түүнчлэн “төрийн эрх мэдэл”, “төрийн засаглалын эрх мэдэл” гэсэн нэр томъёо нилээдгүй дайралддаг. Үүнтэй холбоотой улс төр, эрх зүйч судлаачид маргах нь цөөнгүй. Эрх зүйч судлаачид “төрийн эрх мэдэл” хэмээх ойлголтыг

түлхүү хэрэглэдэг бол улс төр судлаачид “төрийн засаглалын эрх мэдэл” гэсэн нэр томъёог өргөн хэрэглэж хэвшсэн нь ажиглагддаг. Энэ нь тухайн салбар шинжлэлийн онцлогтой холбоотой байж болохоор байна. Гэхдээ “засаглал”, “эрх мэдэл” хэмээх нэр томъёо хоорондоо утга зүйн нарийн шүтэлцээтэй, бие биенээ харилцан нөхцөлдүүлсэн ойлголт юм. “Эрх мэдэл” хэмээх нь төрийн ажил хэргийг явуулах эрх зүйн байдал \статус\ гэсэн агуулгаар ойлгогддог бол “төрийн засаглал” хэмээх нь эрх мэдлийн тусламжтай улс төрийг явуулах, шийдвэр гаргах харилцан хамааралт үйл ажиллагаа түүнийг хэрэгжүүлэх чадвар юм.⁷⁴ Энэ тохиолдолд “төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан, тэнцвэржүүлэх” хэмээн ярьж, бичиж хэвших нь авч үзэж буй асуудлын утга чанарыг бүрэн илэрхийлсэн оновчтой томъёолол байж болох юм.

Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санааны эх сурвалж нь эртний соёлт Грек, Ромын оюунлаг ертөнцөөс үндэс улбаатай. Эхэн үедээ энэ үзэл санаа төрийн чиг үүрэг тодорхой нэг байгууллага дээр бусдаас илүү байдлаар төвлөрөх ёсгүй, төрийн эрх мэдлийг “зөвлөх”, “засаглах”, “шүүх” гэсэн эрх мэдлүүдэд хуваарилах⁷⁵ гэсэн агуулгаар ойлгогдож байжээ. Харин төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах Грек, Ромын сэтгэгчдийн үзэл, сургаалыг нарийвчлан гүнзгийрүүлж орчин үеийн үзэл баримтлалын үнэт зүйлс болгоход Английн улс төрийн гүн ухаантан Ж.Локк /1632-1704/, Францын сэтгэгч, эрх зүйн онолч Ш.Л.Монтескье /1689-1755/ нар жинтэй хувь нэмэр оруулжээ.

Ж.Локк “Төрийн тухай хоёр шастир” хэмээх сонгодог бүтээлдээ төрийн засаглалыг хууль тогтоох, гүйцэтгэх, холбооны гэж ангилан тэдгээрийн хоорондын үүргийн хуваарилалт, эрх мэдлийн харьцаа, зохицол, зааг хязгаарын зарчмын талаарх цэгцтэй үзэл санааг дэвшүүлэн, Засгийн газрын буюу гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй дээд байгууллагын зүгээс парламентын эрх мэдэлд халдаж болзошгүйг анхааруулаж байсан нь санамсаргүй хэрэг биш юм. Ингэхдээ тэрээр парламентын эрх хэмжээний хүрээ хязгаар нь хувь хүний амь нас, эрх чөлөө, өмч хөрөнгө гэдгийг онцолж байжээ.⁷⁶

Францын сэтгэгч Ш.Л.Монтескье “Хуулийн амин сүнс” хэмээх бүтээлдээ Ж.Локкийн үзэл санааг улам баяжуулан тодорхой болгож, төрийн засаглалын салаа мөчрүүдийн хооронд үүргийн зохистой хуваарилалтыг хэрэгжүүлэх үндсэн дээр тэдгээрийн эрх мэдлийн хяналт тэнцвэрийг хангаж болох тухай үзэл санааг дэвшүүлэн тавьсан байдаг.

Засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санаа нь нэг талаас ардчилсан нийгэм, Үндсэн хуулийг бүтээх үзэл баримтлалын цэгцтэй тулгуур онол, нөгөө талаас ардчилсан төрийн байгуулалыг зохион байгуулах Үндсэн хуулийн зайлшгүй мөрдлөг болгох суурь шаардлага, норматив болж байдаг үндсэн зарчим юм. Тиймээс түүнийг судлаачид **онол** төдийгүй **зарчим** хэмээн үздэг нь санамсаргүй хэрэг бишээ. Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвүүлсэнээр төрийн аль нэг институт, албан тушаалтанд хэт их

⁷⁴ Д.Болд-Эрдэнэ. Монголын нийгмийн улс төр ба нам. (Улс төрийн шинжлэх ухааны доктор \Sc.D\ зэрэг горилж бичсэн нэг сэдэвт бүтээл) УБ.,2013, 13 дахь тал

⁷⁵ Д.Лүндээжанцан. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001. 3 дахь тал.

⁷⁶ Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007, 181 дахь тал.

эрх мэдэл төвлөрөх, дураар авирлах явдлыг хязгаарлах, эрх мэдэл илүү болон дутуу хуваарилагдахаас сэрэмжлэх, ард түмний нийтлэг язгуур ашиг сонирхол хуулийн хүрээнд хангагдах, хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хэрэгжүүлэх бодитой нөхцөл баталгаа бүрддэг.

Орчин үед төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онол, зарчмын амин сүнс, гол цөм нь **нэгдүгээрт**, эрх мэдлийг зааглан хуваарилах, **хоёрдугаарт**, эрх мэдлийг харилцан тэнцвэржүүлэх, **гурвдугаарт**, эрх мэдлийг харилцан хянах гэсэн гурван гол зүйлээр тодорхойлогддог. Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санааны дээрх харилцан хамаарал бүхий гурван гол тулгуур зарчмыг нарийвчлан авч үзвэл дараах үндсэн утга чанар тодордог. Үүнд:

Төрийн засаглалын эрх мэдлүүд

- ✓ Хоорондоо нягт уялдаа хамааралтай байх,
- ✓ Чиг үүргээ нягт нарийн харилцан хуваарилсан байх,
- ✓ Засаглалын эрх мэдэл тус бүрдээ харьцангуй бие даасан байх,
- ✓ Засаглалын аль нэг нь нөгөөгөөсөө илүү болон дутуу эрх эдлэхгүй байх,
- ✓ Эрх мэдлээ харилцан тэнцвэржүүлсэн байх,
- ✓ Засаглалын эрх мэдлүүд бие биедээ харилцан хяналт тавьсан байх зэрэг юм.

Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онол зарчим нь орчин үед 1787 оны АНУ-ын, 1791 оны Францын Үндсэн хууль болон 1789 оны “Хүний болон иргэний эрхийн тунхаглал”-ын суурь баримтлал болсон билээ. Тухайлбал 1789 оны Францын “Хүний болон иргэний эрхийн тунхаглал”-ын 16 дугаар зүйлд “Эрх хэрэгжүүлэх нөхцөл хангагдаагүй, төрийн эрх мэдлийг хуваарилаагүй аливаа нийгэмд Үндсэн хууль оршдоггүй” хэмээн тодорхой заасан байдаг. Эндээс үзвэл төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үзэл санаа, ардчилсан Үндсэн хууль хоёрын хооронд салшгүй амин шүтэлцээ байдаг нь харагдаж байна.

Монгол төрийн эрх мэдлийн хуваарилалт

тэнцвэржилтийн хэрэгжилт

Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онол нь утга чанарын хувьд сонгодог шинжтэй. Харин энэхүү сонгодог онолыг хэрэгжүүлэх тогтсон нэг “жор” загвар, стандарт гэж байдаггүй. Тиймээс уг онол хаана ч бүрэн төгс хэрэгжиж байгаагүй гагцхүү энэ тохиолдолд тодорхой улс орны онцлогоор дамжин өвөрмөц байдлаар л хэрэгжиж ирсэн. Энэ агуулгаар авч үзвэл төрийн засаглалыг хуваарилан тэнцвэржүүлэх онол нь зарчим болох талаасаа улс орон бүхэнд харилцан адилгүй байдлаар хэрэгжиж байдаг. Харин түүнийг хэрэгжүүлэх хатуу болон зөөлөн гэсэн хоёр хувилбар байдаг. Улс төрийн амьдралын нийтлэг жишгээс үзвэл төрийн засаглалын Ерөнхийлөгчийн хэлбэр

оршин үйлчилж буй нөхцөлд хатуу, харин парламентын хэлбэрийн үед зөөлөн нь голлон хэрэглэгддэг байна.*

Монгол Улсын 1992 онд батлагдан мөрдөгдсөн шинэ Үндсэн хуульд төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онолыг зарчмын хувьд нь ямар нэг хэмжээгээр тусган хэрэглэсэн байдаг. Тэгэхдээ манайд хэрэгжиж буйг нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах зөөлөн хэлбэр хэмээн үзэх үндэстэй. Үндсэн хуульд “эрх мэдэл” хуваарилах гэдэг нэр томъёогоор орсон эл зарчим нь зарим судлаачдын үздэгээр Монгол орон “гурван засаг” буюу “засаглал”-тай болчихоод байна гэсэн утгатай бус, харин Парламентын Бүгд найрамдах засагтай нэгдмэл төрийн эрх мэдлийг, өөрөөр хэлбэл төрийн эрхэлж хэрэгжүүлдэг ажил /”чиг үүрэг”, “хэм хэмжээ” улмаар түүний гол агуулга болсон бүрэн эрх”/ -ыг төрийн харьцангуй бие даан салаалсан гурван төрлийн байгууллагад* хуваарилан хариуцуулж, хооронд нь харилцан хамаарал, хяналт, тэнцэлтэй болгох гэсэнд гол зорилго оршино.⁷⁷

Гэвч манай судлаачид төрийн засаглалын эрх мэдлийн хуваарилалтын өнөөгийн үйл явцыг үнэлэх үнэлэмж нэг мөр болж чадаагүй байна. Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах, тэнцвэржүүлэх үйл явцыг тойрсон маргааны явцад ялгаа бүхий дараах үзэл байр суурь тодорч байгаа юм. Энэ нь **нэгд** эрс өөрчлөх байр суурь. /хатуу хэлбэрээр эрс өөрчлөх: М.Энхсайхан ба бусад/, **хоёрт** шүүмжлэгч шинэчлэгч байр суурь. /гажуудлыг засч залруулах. Н.Лүндэндорж ба бусад/, **гуравт** төвч байр суурь. /төгс биш боловч хэрэгжиж буй, цагийг нь олж засч залруулах. Г.Чулуунбаатар, А.Цанжид, Б.Дэлгэрмаа ба бусад/, **дөрөвт** болгоомжилсон байр суурь. /Үндсэн хуулийг өөрчлөх, шинэчлэх цаг нь болоогүй. Б.Чимид ба бусад/ зэрэг юм. Тэдгээрийн дотроос шүүмжлэгч шинэчлэгч байр суурийн тухайд зарим зүйлийг тодруулахад сонирхолтой байна. Тэд Монгол Улсын Үндсэн хуулинд төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх зарчим нилээд хэмжээгээр гажсаны уршгаар эрх мэдлийн хуваарилалт үндсэндээ хэрэгжиж чадаагүй гэж үздэг. Тухайлбал доктор Н.Лүндэндорж бичихдээ: “...Монгол Улсад төрийн эрх мэдлийн хуваарилалт гажсан болохыг харж болно. ...Үндсэн хууль бодитой оршихын шалгуур нь хууль тогтоох журмаар баталсан ямар нэг хууль зүйн бичвэр байхын нэр огт биш. Харин хяналт тэнцвэрийн зарчмын дагуу төрийн эрх мэдлийг хуваарилж, хүний эрхийн баталгааг жинхэнэ ёсоор хангасан байх явдал юм. Энэ бол баталгаа үл шаардах илт үнэн. Энэ шалгуураар харвал одоогийн Үндсэн хууль бүрэн амилаагүй, зөвхөн бараа сүрийг үзүүлж байгаа, ардчилал, хүний эрхийн давалгаагаар амьдарч яваа баримт бичиг юм. Одоо

* *Тайлбар:* “Хатуу” хувилбараар эрх мэдэл хуваарилах үед гүйцэтгэх эрх мэдлийн гол институт болох Засгийн газар нь парламентаас хамаарал багатай байдаг бөгөөд төрийн тэргүүний институттэй холбогдсон байдаг. Харин төрийн эрх мэдэл хуваарилах “зөөлөн” хувилбарын нөхцөлд Засгийн газар нь парламентаас харьцангуй илүү хамаардаг, эсхүл шууд хамаарч байдаг.

* *Тайлбар:* Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах нэг үндсэн шаардлага нь эрх мэдлийг хэрэгжүүлж буй байгууллага нь гагцхүү хуулиар легитимт байдлаа хангасан байх явдал юм.

⁷⁷ Б.Чимид. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. УБ., 1996. 15 дахь тал.

түүнийг жинхэнэ ёсоор амлуулах, бодит үйлчлэл бүхий гэрээ болгох явдал монголын нийгмийн өмнө зүй ёсоор тулгарч байна” гэсэн байна.⁷⁸

Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үндсэн нөхцөл нь тэдгээрийн хоорондын харилцаа, харилцан хамаарал, нөлөөлөл юм. Францын судлаач М.Дюверже “Улс төрийн байгууламж” хэмээх бүтээлдээ засаглалын институцуудын хоорондын харилцааны төрөл хэлбэр, онцлогийг нарийвчлан судлаад сонирхолтой санааг дэвшүүлсэн байдаг. Тэрээр бичихдээ: “Засаглалыг бүрдүүлж буй төрөл бүрийн байгууллагууд бие биеээсээ салангид тусгай оршдоггүй. Тэдгээр байгууллага тусгаарлагдмал маягаар үйл ажиллагаа явуулдаггүй. Тэдгээрийн дунд заавал ямар нэгэн хэмжээнд хамтын ажиллагаа байх ёстой. Энэхүү хамтын ажиллагаа нь засаглалын нэг байгууллага нөгөөдөө, тухайлбал засгийн газар парламентад, парламент засгийн газарт төрөл бүрийн аргаар нөлөөлж буйгаар илэрдэг.”⁷⁹ гэсэн нь анхаарал татаж байна. Энэхүү харилцан хамааралаас төрийн эрх мэдлийн хоорондын “check and balances” /хяналт, тэнцвэр/-ын зарчим хэрэгжих үйл явц эхэлдэг.

Монгол Улсын Үндсэн хуулинд төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах, тэнцвэржүүлэхдээ хууль тогтоох эрх мэдлийг УИХ-д, гүйцэтгэх эрх мэдлийг Ерөнхийлөгч, Засгийн газар түүний байгууллагуудад, шүүх эрх мэдлийг шүүх, Үндсэн хуулийн Цэцэд тараан хуваарилсан байдаг. Ингээд тэдгээрийн хэрэгжүүлэх чиг үүрэг, үйл ажиллагааны зарчим, харилцан хамаарал, тэнцэл зохицлыг нь тодорхой зааж өгсөн. Энэ агуулгаараа Монгол Улсын Үндсэн хууль нь нийгэм, төрийн байгууллын тулгуур үндсийг эрх зүйн талаас нь нэгтгэн томъёолсон суурь баримт бичиг юм.

Монголд өнөөдөр төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилалтыг Үндсэн хуулиар ямар нэг хэмжээгээр баталгаажуулан хэрэгжүүлж байгаа нь маргаангүй. Харин энэ хугацаанд дутуу дулимаг бодож, шийдсэн болон зайлшгүй засч залруулбал зохих олон асуудал байгаа нь ойлгомжтой. Ингэхлээр Монгол Улсын Үндсэн хуульд төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онол, зарчим хэрхэн тусч, тэр нь одоо яаж хэрэгжиж буй асуудлыг тодруулан үзэх нь сонирхолтой байна.

Хууль тогтоох эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилт

Эрх мэдлийн хуваарилалт. Монгол Улсын Үндсэн хуулинд “...хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их хуралд хадгалана.” /20 зүйл/ хэмээн заасан байдаг. Энэ дагуу хууль тогтоох эрхийг УИХ-аас өөр ямар нэг засаглалын институцд биш харин зөвхөн УИХ-д оногдуулан хуваарилсан. Энэ нь нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах онолын сонгодог жишигтэй нийцэж байгаа юм.

Гэвч манай зарим судлаачид дээрх заалттай холбогдуулан шүүмжлэлт санаа бодлоо илэрхийлсэн нь байдаг. Тухайлбал хуульч, доктор Б.Дэлгэрмаа хуулиар хязгаарласан эрх мэдлийн үзэл санаа нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах зарчмын маш чухал тал мөн бөгөөд энэ тохиолдолд парламент хууль тогтоох эрх мэдлийг ерөнхийд нь хэрэгжүүлэх бус, харин

⁷⁸ Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2010. 9-10 дахь тал.

⁷⁹ М.Дюверже. Улс төрийн байгууламж: үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007. 136-137 дахь тал.

Үндсэн хуулиар тогтоосон хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд л түүнийгээ эдлэх учиртай гэж үзээд АНУ-ын Конгресстэй харьцуулан бичихдээ: “...Үндсэн хуулинд эрх мэдлийг нь заагаагүй Конгрессын аливаа эрх зүйн акт хуулийн хүчин төгөлдөр болох үндэсгүй юм. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх заалтаас Улсын Их Хурал нь хэмжээ хязгааргүй хууль тогтоох эрх мэдэлтэй гэж ойлгогдож байна. Нөгөө талаас гүйцэтгэх засаглалын дээд байгууллагаас батлан гаргадаг эрх зүйн хэм хэмжээ тогтоосон акт нь хуулийн шинжийг агуулах, энэ тохиолдолд Конгресс хууль тогтоох эрх мэдлээ түүнд төлөөлүүлэн олгосон гэж үзэж захиргааны дээрх акт нь хуулийн нэгэн адил үйлчилдэг явдал АНУ-ын эрх зүйн практикт тогтжээ. Гэтэл манай Үндсэн хуулинд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ-д хадгалуулж байгаа нь төрийн захиргааны төв байгууллагын ажиллагааг удаашруулах, гүйцэтгэх засаглалын уян хатан шинж, шуурхай байдлыг алдагдуулахад хүргэх уршигтай” гэсэн байдаг.⁸⁰

Дээрх судлаачын байр суурийг анхааран хүндэтгэх нь зүйн хэрэг боловч төрийн засаглалын эрх мэдлийн хуваарилах онолын үүднээс хүлээн авахад эргэлзээтэй санагдана. Хэрвээ парламент хууль тогтоох эрх мэдлээ засаглалын өөр нэг институцд найр тавих эсвэл хуваалцах, шилжүүлэх нь эрх мэдлийг хуваарилан зааглах нийтлэг шаардлагатай нийцэхгүй юм. Энэ тухай судлаач, академич Г.Чулуунбаатар бичихдээ: “Хууль тогтоох онцгой эрх мэдлийг зөвхөн УИХ өөртөө хадгалж байх ёстойг Үндсэн хуульд тодорхойлсон. Гэтэл энэ онцгой бүрэн эрхийг УИХ маань хуваан хэрэгжүүлж байна уу даа гэж үзэж болохоор байдал бий болж болзошгүй. УИХ нэг хууль гаргаад ийм асуудлыг Засгийн газар, тийм журмыг тэр яам, өөр нэгийг нь тэр сайд гаргана гэх нь холгүй байна. Энд тодорхой зааг ялгаа гаргаж, эмх цэгц тогтоохгүй бол гүйцэтгэх эрх мэдэлтнүүд хууль тогтоох эрхийг хуваалцан хэрэгжүүлдэг зохисгүй байдал бий болох талтай. Ингэж хууль хэрэгжүүлэх үйл ажиллагаа өөрөө хууль тогтоох шинжтэй болчихож таарахгүй”⁸¹ гэсэн нь анхаарал татаж байна.

Эрх мэдлийн хяналт. Төрийн засаглалын эрх мэдлийн харилцан тэнцэлийг хангах үндсэн механизм нь тэдгээрийн хоорондын бие биедээ тавих харилцан хяналт юм. Бодитой хууль ёсны хяналт нь эрх мэдлийг тэнцвэржүүлэх суурь нөхцөл болдог. Ер нь төрийн засаглалын субъектын харилцан хамаарал, тэнцэл, бие биенээ нөхөн сэлбэх чадвар, шаардлагатай үед бие биедээ “тээг тавих” эрх нь хуулиар тогтоогдсон хяналтаар дамжин хэрэгждэг.

Үндсэн хуулиар УИХ-д тавигдах хууль ёсны хяналтын механизм сул томъёологдсон. Өнөөдөр Үндсэн хуульд зааснаар УИХ-ын үйл ажиллагааг бодитой хянах тоотой хэдхэн механизм л байгаа юм. Энэ нь **нэгдүгээрт** УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс хориг тавих тухай Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, **хоёрдугаарт** УИХ-ын шийдвэрийн талаарх Үндсэн хуулийн Цэцийн гаргасан дүгнэлт, шийдвэр /66 дугаар зүйлийн 2.4 дэх заалт/, **гуравдугаарт**, УИХ-ыг тараахтай холбоотой Үндсэн хуулийн 22 дугаар зүйлийн 2 заалт зэрэг юм. Тэгэхдээ УИХ-ыг тараах үйл явцад их өндөр босго тавьж өгсөн. Тухайлбал УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний

⁸⁰ Б.Дэлгэрмаа. Үндсэн хуульд ёс, харьцуулалт, анализ. Шинэ толь. 1994 № 2, 24 дахь тал.

⁸¹ Г.Чулуунбаатар. XX, XXI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. УБ., 2009, 101-102 дахь тал.

гуравны хоёроос доошгүй нь санал гаргаснаар УИХ өөрөө тарах тухай асуудал тавигдахаар байгаа. /22.2/

Харамсалтай нь УИХ-ын үйл ажиллагаанд тавих хяналт хариуцлагын дээрх механизм нь хүчтэй үйлчилж чадахгүй байна гэж хэлж болохоор байгаа юм. Учир нь УИХ-ын шийдвэрт тавих Ерөнхийлөгчийн хоригийг УИХ хэлэлцэн шийдвэрлэх ч хоригийг УИХ-ын чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлддэг. /33.1.1/ Харин УИХ-ын гаргасан шийдвэрийн талаарх Үндсэн хуулийн Цэцийн гаргасан дүгнэлт нь Цэцэд Үндсэн хуулиар олгогдсон УИХ-ын үйл ажиллагаанд тавих нилээд хүчтэй хяналтын механизм мөн боловч практикаас үзэхэд УИХ Үндсэн хуулийн Цэцийн гаргасан дүгнэлтийг үл оошоох, хуульд заасан хугацаанд нь хэлэлцэхгүй удаах, замхаруулах, хэрэгжүүлэхгүй байх зохисгүй үзэгдэл газар авсан нь уг хяналтын механизмын хүчин чадлын үйлчлэлийг саармагжуулахад хүргэдэг нь нууц биш юм.

Парламентын үйл ажиллагаанд тавих хяналтын хамгийн хүчтэй механизм нь түүнийг тараах асуудал юм. Монгол Улсын Үндсэн хуульд УИХ-ыг тараах механизм бүдэг бөгөөд их сул томъёологдсон. Энэ нь УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр УИХ өөрөө тарах, Засгийн газрын Ерөнхий сайдыг томилох саналыг өргөн мэдүүлсэнээс 45 хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй бол тарахаар хуульчлагдсан. /22.2/ Гэвч Үндсэн хуулийн энэ заалт амьдрал дээр тэр бүр хэрэгжих магадлал муутай юм. Учир нь улс төрийн практикт парламент өөрөө өөрийгөө тараах тохиолдол бараг гардаггүй байна.

Ингэхлээр Үндсэн хуулиар УИХ-ыг тараах механизмыг нарийвчлан тодорхой болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Тэгэхдээ энд гол нь УИХ өөрөө тарах тухай эрх зүйн сонин зохицуулалтыг өөрчлөх, УИХ-ыг тараах нөхцөл үндэслэлийг тодорхой болгох шаардлагатай байна. Тухайлбал УИХ-ыг тараах хэд хэдэн нөхцөл шаардлага байж болохоор байна. Үүнд тодорхой хугацааны дотор улсын төсвийг баталж чадаагүй мөн хугацаанд чуулганаа эхлүүлэх буюу явуулж чадаагүй, хэд хэдэн удаа Засгийн газарт итгэл үзүүлээгүй (жишээ нь Унгарт нэг жилийн дотор 4 удаа) тохиолдолд УИХ тарж байхаар хуульчилж болох юм. Үүнээс гадна парламентыг тараах нь мөн хэд хэдэн нөхцөлөөр хязгаарлагдсан байж болно. Үүнд: дайны болон онц байдал зарласан тохиолдолд, бүрэн эрхийнх нь хугацаа дуусахаас хэдэн сарын өмнө (тухайлбал, 6 сарын өмнө) буюу шинээр сонгогдсон парламент ажлаа эхэлсэнээс хойш тодорхой хугацааны дотор, хэрэв Ерөнхийлөгч парламентыг тараах санал гаргасан бол энэ нь түүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас хэдэн сарын өмнө байж болохгүй гэх мэт тодорхой нөхцөлүүд байж болох юм.⁸²

Өнөөдөр УИХ-ын гишүүдэд тавих ёс зүйн болон сонгогчдын зүгээс тавих хяналт, хариуцлагын механизм хэрэг дээрээ байхгүй байгаагийн дээр харин ч эсрэгээр тэднийг УИХ-ын гишүүний халдашгүй байдал гэдгээр халхавчилсан хариуцлагаас мултлах, бултан зайлуулах гажиг механизм үйлчилж байгаа нь хачирхалтай. Түүнчлэн УИХ-ын жам ёсны дотоод хяналт ч үгүй болсон гэхэд

⁸² А.Пагма. Монгол Улсын Үндсэн хууль, эрх мэдэл хуваарилалтын онолын асуудалд. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. / Товхимол III / УБ., 2000. 23 дахь тал.

хэтрүүлэл болохгүй. Учир нь парламентын олонхид тавих цөөнхийн хяналтын хүчтэй механизм, түүнийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн тодорхой орчин өнөөдөр үгүйлэгдэж байна. Манай практикаас үзэхэд парламентын цөөнх хүчин мөхөсдөх эсвэл “стандарт бус” гэсэн халхавчтайгаар олонхи, цөөнх нь хамтраад парламентад улс төрийн нэг нэгдмэл субъект болж орхидог, үйл ажиллагааны эрх зүйн хангалттай орчин, чадамж хүрэлцэдгүй зэрэг шалтгаан, хүчин зүйлийн улмаас энэ механизм бодитой ажиллаж чаддаггүй байдал харагддаг. Ингэхлээр хангалттай хүч нөлөөтэй цөөнхийн хяналтгүй парламентыг эрх мэдэл тэнцэржсэн, хяналттай парламент гэж ойлгоход төвөгтэй. Түүнчлэн парламентын доторх хяналтын байгууллага маш сул ажилладаг. Үүнийг хяналтын үүрэг гүйцэтгэх ажлын хэсэг зарим үед оролдог ч түүний ажил хэрэгч чанар, үр дүн хангалтгүй байна. Энэ бүхнээс дүгнэж үзвэл өнөөдөр УИХ-ын үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагын механизм хангалттай үйлчлэхгүй байгаа нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онол, зарчим манайд бодит агуулгаараа оршин үйлчлэхгүй байна гэж үзэхээс өөр аргагүй юм.

Эрх мэдлийн тэнцвэр. Монгол Улсын Үндсэн хуулийн 20 дугаар зүйлд “Монгол Улсын Их хурал төрийн эрх барих дээд байгууллага мөн...” гэж заасан байдаг. Үндсэн хуулийн энэ заалт нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онол, зарчмын үндсэн жишиг шаардлагатай нийцэхгүй байна гэж үзэх үндэстэй юм. Энэ тухай манай нилээд олон судлаачид байх сууриа илэрхийлсэн байдаг. Тухайлбал хуульч судлаач, доктор Н.Лүндэндорж Үндсэн хуулийн дээрх заалт нь “..хяналт, тэнцвэрийн зарчмыг алдагдуулж, хууль тогтоох эрх мэдэлд давуу эрх олгосон заалт юм. Энд байгаа “төрийн эрх барих” гэдэг гуравхан үг бол техникийн алдаа эсвэл орчуулгын буруу онолт төдий зүйл биш юм. Аль ч утгаар авч үзсэн “төрийн эрхийг барина” гэдэг нь УИХ бусад эрх мэдлээс өргөн бөгөөд давуу эрх мэдэлтэй байна гэсэн утгыг шууд илэрхийлж,....”⁸³ байна гэсэн үнэн юм.

Парламент нь төрийн эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх үйл явцад онцгой үүрэгтэй оролцдог ноён нуруутай институт мөн. Учир нь парламентаас төрийн эрх мэдэл эхэлдэг тэр дундаа парламентын засаглалтай орны хувьд парламентын эрх мэдэл хуваарилагдсан байдал нь засаглалын бусад институтын үйл ажиллагаанд чухал нөлөөтэй байдаг. Хэдий тийм боловч энэ нь парламент бусад институтээс илүү, давуу эрх мэдэлтэй байна гэсэн үг ерөөсөө биш. Хаана ч, ямар улс орны Үндсэн хуульд парламент “төрийн эрх барих дээд байгууллага” гэсэн заалт байхгүй. Дэлхийн зарим улс орны Үндсэн хуульд /АНУ/ парламентыг “хууль тогтоох дээд байгууллага” л гэж заасан байдаг.⁸⁴

Парламент ёсны жишгээр улс орнуудын парламентыг хууль тогтоох эрх мэдлээр нь **нэгдүгээрт** өргөн эрх мэдэлтэй, **хоёрдугаарт** хязгаарлагдмал эрх мэдэлтэй, **гуравдугаарт** зөвлөх гэсэн гурван төрөлд хуваадаг.⁸⁵ Харин Монгол Улсын парламентыг “хууль тогтоох өргөн эрх мэдэл бүхий парламент”-ын төрөлд хамруулан үзэж болохоор байдаг. Гэвч энэ нь түүнд засаглалын бусад институтээс давуу эрх олгох үндэслэл болохгүй юм. Гэтэл манай зарим судлаачид парламентын засаглалтай орны хувьд парламентат бусдаасаа арай

⁸³ Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2010. 8 дахь тал

⁸⁴ АНУ-ын Үндсэн хууль. 1 дүгээр зүйл.

⁸⁵ Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан. Парламентат ёс. УБ., 2005. 162 дахь тал.

давуу эрх нөлөөтэй байж болно гэж үздэг. Доктор Д.Лүндээжанцан энэ тухай бичихдээ: "...хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад түүхэн тодорхой нөхцөлд ард түмний язгуур эрх ашиг, сонирхолын үүднээс аль нэг эрх мэдэл тэргүүлэх, давамгайлах үүрэг хүлээхийг нийгмийн амьдрал заавал шаарддаг. Энэ шаардлагыг соргог мэдэрч хэрэгжүүлэхгүй аваас төрийн эрх мэдлийн тэнцвэрт байдал алдагдаж, илүү эрх мэдлийн төлөө тэмцэл газар авч эцэстээ нийгмийг бүхэлд нь хямруулах аюултай. Эрх зүйт төрийг төлөвшүүлж буй өнөөгийн нөхцөлд төрийн эрх мэдлийн тэнцвэрт байдлыг ханган, төрийн ноён нуруу болж байх байгууллага нь Парламент юм" гэжээ.⁸⁶ Түүний энэ санааг хуваалцаж болох хэдий ч төрийн эрх мэдлийг бодитой хуваарилж буй нөхцөлд аль нэг нэгэнд нь тэргүүлэх, давуу эрх олгох нь зохистой биш юм. Харин байгалийн гамшиг болон онцгой болон дайны байдалтай нөхцөлд дээрх судлаачийн санаа үндэстэй байж болох юм.

УИХ-д олгогдсон хууль тогтоох эрх мэдлийг Үндсэн хуульд түүний "бүрэн эрх"-ээр нэгтгэн баталгаажуулсан байдаг. Парламентын "бүрэн эрх" нь түүний чиг үүргийнх легитимт илэрхийлэл болдог. Хууль тогтоох, биелэлтэнд нь хяналт тавих, төлөөлөх нь парламентын үндсэн чиг үүрэг нь юм. Бүрэн эрхгүйгээр чиг үүрэг хэрэгжих ямар ч боломжгүй. Бүрэн эрх бол дан ганц эрхүүд бус, харин эрх, үүрэг, үйл ажиллагаа, эрхлэх асуудал зэргийг багтаасан цогц ойлголт юм. Парламентын бүрэн эрхийг үндсэн бүрэн эрх, тодорхой бүрэн эрх, онцгой бүрэн эрх гэж гурав ангилж болно.⁸⁷ Тэгвэл М.Дюверже парламентын бүрэн эрхийг шийдвэр гаргах бүрэн эрх, Засгийн газартай харилцах бүрэн эрх гэж хоёр ангилсан байна.⁸⁸ Харин бүрэн эрхийн хүрээ хязгаарыг "эрх хэмжээ" хэмээдэг.⁸⁹ ОХУ-ын судлаач Ю.Н. Жданов эрх хэмжээ нь чиг үүрэг, бүрэн эрхийн цогц мөн гэсэн байна.⁹⁰

УИХ-ын онцгой бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1-д 18 зүйлээр заасан байдаг. УИХ-ын энэ онцгой бүрэн эрхийн зармыг нь манай нэг хэсэг судлаачид алив парламентад байх бүрэн эрхийн хэм хэмжээнээс хальсан, парламентад хэтэрхий эрх мэдэл төвлөрсөний илрэл гэж үздэг. Үүнтэй холбогдуулан хуульч, доктор Н.Лүндэндорж манай УИХ-д "...зөвхөн монголдоо хамаатай, бусад улсын парламент хэрэгжүүлдэггүй дараах давуу эрхүүдтэй байгаа юм" гээд энэ хүрээндээ "төрийн гадаад, дотоод бодлогын үндсийг тодорхойлох /25.2/, төрийн гадаад, дотоод бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх /25.1/, УИХ-д ажлаа шууд тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах, /25.6/, УИХ зөвхөн өөрөө өөртөө хариуцлага хүлээлгэдэг /22.2/, нийт ард түмнээс сонгосон ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль гаргах /25.5/ бүрэн эрхийг багтаан үзсэн байна.⁹¹ Үүнийгээ тэрээр одоогийн Үндсэн хуулийн гажиг согог, хоосон орон зайг ашиглах явдал аяндаа гарна. Тухайлбал УИХ-төрийн

⁸⁶ Д.Лүндээжанцан. Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001, 17-18

⁸⁷ Т.Сэнгэдорж. Үндсэн хуулийн эрх зүй дэх Парламентын засаглалын онолын зарим асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. / Товхимол III / УБ., 2000. 41 дэх тал.

⁸⁸ Морис Дюверже. Улс төрийн байгууламж: үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007, 474 дахь тал.

⁸⁹ Д.Лүндээжанцан, Л.Өлзийсайхан. Парламентат ёс. УБ., 2005, 77 дахь тал.

⁹⁰ Конституционное право. М., 1997, СТР. 311

⁹¹ Н.Лүндэндорж. Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал. УБ., 2010. 9 дахь тал

эрхийг барьж буй субъектын хувьд, Үндсэн хуулийн 25.1–д заасны дагуу шүүн таслах ажиллагааны нэгдсэн бодлогын асуудлыг ямар нэг шалтаг, шалтгаанаар хэлэлцэхэд гайхах зүйлгүй гэсэн байна.⁹²

Дээрх судлаачын байр суурийг зарим талаар хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Учир нь Үндсэн хуулийн 25.1-д заасан төрийн гадаад, дотоод бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх тухай заалтын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэх гэсэн нь, мөн 22.2 заалт болох УИХ-өөрөө өөртөө хариуцлага хүлээлгэх тухай заалтууд нь төрийн эрх мэдлийн тэнцвэржилтийн зарчимтай нийцэхгүй байгаа юм. Түүнчлэн нийт ард түмнээс сонгосон Ерөнхийлөгчийг сонгосон гэж үзэж хууль гаргах тухай 25.5 заалт УИХ-д хэт их эрх мэдэл төвлөрсөний илрэл гэж үзэж байна. Энэ бүхнээс үзвэл УИХ-д засаглалын бусад институттэй харьцуулахад Үндсэн хуулиар нилээд өргөн хэт их эрх мэдлийг олгосон нь харагдаж байгаа бөгөөд энэ байдал нь төрийн засаглалын эрх мэдлийг тэнцвэржүүлэх зарчимтай ямар нэг байдлаар зөрчилдөж байна гэж үзэх үндэстэй. Түүнчлэн засаглал хуваарилах зарчмыг бодитой хэрэгжүүлэх шаардлагын үүднээс Монгол Улсын Үндсэн хуульд заасан УИХ-ын онцгой бүрэн эрх, түүнийг хэрэгжүүлэх зарим тодорхой механизмыг УИХ-ын үйл ажиллагааг зохицуулдаг хуульд нарийвчлан тодотгож өгөх шаардлага гарч байна. Ийм нарийвчлал дутмагаас шалтгаалж, УИХ-ын онцгой бүрэн эрхэд хамаарах зарим асуудал Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, Үндэсний аюулгүй ыайдлын зөвлөлзэрэг засаглалын харилцааны бусад субъектүүдийн эрх мэдэл, эрхлэх ажлын хүрээнд давхар харьяалагдах, улмаар тэдгээрийн үүрэг функцийн ялгаа бүдгэрэх зэрэг үзэгдэл гарсаар байгааг⁹³ анхааран засамжлах нь хэрэгтэй байгаа юм.

Ингэхлээр хууль тогтоох эрх мэдлийг зохистой хуваарилан тэнцвэржүүлэх шаардлагын үүднээс цаашид дараах зүйлсийг анхааран хэрэгжүүлэх хэрэгтэй байгаа юм. Тухайлбал хууль тогтоох эрх мэдлийн зарим элементийг гүйцэтгэх засаглалд шилжүүлэх; Ерөнхийлөгчийн хоригийн үйлчлэлийн эрх зүйн чадамжийг нэмэгдүүлэх; Үндсэн хууль дахь төрийн эрх барих дээд байгууллага гэсэн заалтыг өөрчлөх /харамсалтай нь энэ заалтыг өөрчлөхийг хуулиар хориглосон байгаа/; УИХ-ын бүрэн эрхийн системд өөрчлөлт, зохицуулалт хийх /өөрөө тарах механизмыг өөрчлөх гэх мэт/; Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг ёсчлон хүлээн зөвшөөрч, хэрэгжүүлж хэвшүүлэх; УИХ-ын онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлэх зарим тодорхой механизмыг УИХ-тай холбоотой хуульд нарийвчлан тодотгох шаардлагатай байна.

Гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилт

Эрх мэдлийн хуваарилалт. Төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх онолын үүднээс гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газар эсвэл төрийн тэргүүнд хуваарилдаг. Үндсэн хуульд “Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн” /38.1/ гэж заасан байдаг. Эндээс үзвэл манай нөхцөлд Засгийн газар гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд зонхилох байр суурь эзэлдэг нь харагдаж байна. Харин Ерөнхийлөгчийн институтын хувьд түүнийг төрийн засаглалын аль салбарт хамааруулсан нь тодорхой биш байдаг.

⁹² Мөн тэнд. 10 дахь тал.

⁹³ Г.Чулуунбаатар. ХХ, ХХI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. УБ., 2009, 100 дахь тал.

Энэ нь үнэн хэрэгтэй манай Үндсэн хуульд гүйцэтгэх эрх мэдлийг бүрэн дүүрэн хуваарилаагүйг харуулж байна. Гэтэл Ерөнхийлөгчийн институтын хувьд улс төрийн тогтолцоо, төрийн засаглалын институтын хоорондын харилцаа, тэдгээрийн эрх мэдлийг хуваарилан тэнцвэржүүлэх явцад өвөрмөц байр суурь эзлэн, үүрэг гүйцэтгэдэг. Энэ агуулгаараа гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэх явцад ч зохих үүрэгтэй оролцдог билээ. Эндээс үүдэн Монгол Улсын Ерөнхийлөгчийг манай нөхцөлд төрийн засаглалын аль салбарт хамааруулах эсэх асуудлыг тодруулах нь төрийн эрх мэдлийг хуваариалах үйл явцыг бодитой ойлгон баримжаалахад чухал ач холбогдолтой байна.

Төрийн тэргүүний асуудлыг бодитой авч үзэхэд төрийн засаглалын хэлбэрийн асуудал чухал учир холбогдолтой байдаг. Олон улсын улс төрийн амьдралын нийтлэг жишгээр Парламентын засаглалтай улс орнуудыг “хүчтэй Ерөнхийлөгчтэй”, номиналь буюу эрх багатай Ерөнхийлөгчтэй, бас бэлэгдлийн тэргүүнтэй гэж нарийвчлахын хамт сүүлийн үед “хүчтэй” гэх Ерөнхийлөгчтэй улсыг “хагас парламентын” гэх буюу холимог /парламент-ерөнхийлөгч хосолсон/ улс гэж ангилах болсон юм. “Төрийн тэргүүн” гэдэг бол олон улсын жишиг маягийн хэллэг бөгөөд Парламентын БНУ-ын Үндсэн хуульд Ерөнхийлөгчөө гол төлөв Төрийн тэргүүн мөн гэж томъёолсон байдаг.⁹⁴ Энэ жишгийн дагуу ч манай Үндсэн хуульд “Монгол улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн...”⁹⁵ гээд шууд заачихсан учраас төрийн тэргүүн гэж хэн бэ? гэдэг асуудал тодорхой юм.⁹⁶ Хэдий тийм боловч төрийн тэргүүн засаглалын эрх мэдлийн аль бүтцэд хамаарах, энэ нь эрх мэдэл бүхий хувь хүн, албан тушаалтан эсвэл засаглалын бүхэл бүтэн институт мөн эсэх асуудал дээр манай судлаачдын дотор янз бүрийн санаа бодол байсаар байдаг. Манай зарим судлаачид “төрийн тэргүүн бол Ерөнхийлөгч”, “төрийн тамгыг Монгол Улсын Ерөнхийлөгч барина” гэсэн Үндсэн хуулийн зарим заалтыг үндэс болгон төрийн тэргүүн бол байгууллага /институт/ биш, харин албан тушаалтан юм гэсэн байр суурийг илэрхийлэх нь байдаг.⁹⁷ Гэвч төрийн тэргүүн нь ард түмний сонголтоор сонгогдож гарч ирдэг, тэдний нийтлэг эрх ашиг, сонирхолыг илэрхийлэгч гэдэг талаасаа тодорхой албан тушаалтан, хувь хүн мөн боловч засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох оролцоо, эрх мэдлийн хуваарилалтанд гүйцэтгэж байгаа үүрэг, нөлөөллийн хувьд түүнийг засаглалын онцгой нэгэн субъект, институт гэж үзэхээс аргагүй.

Төрийн тэргүүнийг засаглалын эрх мэдлийн аль бүтцэд хамааруулах асуудал дээр өнөө хэр маргаан гарсаар байдаг. Манайд ч энэ маргаан байсаар байна. Үүний гол шалтгаан нь нэг талаас манай Ерөнхийлөгч төрийн эрх мэдлийн аль ч байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй нөлөө үзүүлэх эрх зүйн статустай субъект болж байдаг, нөгөө талаас Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийн институт төрийн эрх мэдлийн аль салбарт хамаарахыг тодорхой зохицуулж

⁹⁴ Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь” /онол практикийн бага хурал/ УБ., 2003. 27 дахь тал.

⁹⁵ Монгол Улсын Үндсэн хууль. 30 дугаар зүйл 1 заалт.

⁹⁶ *Тайлбар*: Хэдийгээр парламентын засаглалтай улс орнуудын Үндсэн хуульд Ерөнхийлөгчөө их төлөв төрийн тэргүүн гэдэг ч зарим улс орнуудад энэ нь хуулиар нарийвчлан зохицуулагдаагүй байдаг. Энэ тохиолдолд төрийн тэргүүн хэн бэ? гэдэг дээр маргаан гарах нь байдаг.

⁹⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. Товхимол- I, УБ., 1999, 92 дахь тал.

өгөлгүй нээлттэй орхисон зэрэгтэй холбоотой юм. Улс төрийн практикаас үзвэл төрийн тэргүүнийг **нэгд** засаглалын эрх мэдлийн аль ч салаа мөчирт хамруулдаггүй, **хоёрт** хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн аль алинд нь хамруулан үздэг, **гуравт** зөвхөн гүйцэтгэх эрх мэдэлд багтаан үздэг зэрэг янз бүрийн жишиг тогтсон байдаг. Энэ нь мөн л манай судлаачдын дотор илэрдэг. Тухайлбал манай судлаачдын нэг хэсэг нь Ерөнхийлөгчийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн аль алинд нь хамаатуулах нь байна. Тэд энэ байр сууриа илэрхийлэхдээ манайх засаглалын хэлбэрийн хувьд парламентын засаглалыг сонгосон хэдий ч тухайн хэлбэрт нь зохицоогүй өргөн хэмжээний бүрэн эрхийг төрийн тэргүүнд Үндсэн хуулиараа олгосон. Түүнчлэн төрийн тэргүүний хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдэлтэй харилцах харилцаа тэдгээрийн хүрээнд эдэлдэг эрх хэмжээг авч үзвэл ганцхан гүйцэтгэх эрх мэдэлд түүнийг хамруулж болохгүй гэж үзэж байна⁹⁸ гэцгээдэг. Хэрвээ Ерөнхийлөгчийн институтыг төрийн засаглалын хууль тогтоох хийгээд гүйцэтгэх эрх мэдлийн аль алинд нь хамруулж үзсэн тохиолдолд Ерөнхийлөгчийн төрийн засаглалын системд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэгтэй холбоотой маргаантай гэж хэлж болох олон ээдрээтэй асуудал бий болохоос гадна засаглалын дээд “оргил”, онцгой институт гэж ойлгоход хүрч болзошгүй. Хэрвээ ингэхэд хүрвэл засаглалын хэлбэрийн асуудал тэр дундаа манай парламентын засаглалын статус, онцлог бүрхэгдэхэд хүрч болохоор байгаа юм.

Тэгэхдээ манай ихэнх судлаачид Ерөнхийлөгчийг төрийн засаглалын гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд хамруулан үздэг. Тухайлбал доктор, профессор П.Очирбат “Ерөнхийлөгч нь эрх зүйн байдлаараа гүйцэтгэх эрх мэдлийн тогтолцоонд хамаардаг. Иймд засгийн газартайгаа зохистой харилцах нь төрийн эрх мэдэл хуваарилах зарчмаас үүдэлтэй”⁹⁹ гэсэн бол доктор, профессор Б.Чимид “...Ерөнхийлөгчийн статусыг гүйцэтгэх эрх мэдлийн чиглэлээр голчлон тодруулах нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд илүү нийцнэ гэсэн дүгнэлт хийж болмоор”¹⁰⁰ гэсэн байна. Тэгвэл судлаач доктор Ц.Ганболд, С.Мөнхбат нар “.....Монгол Улсын Үндсэн хууль хийгээд бусад хууль, дүрмийн хүрээнд авч үзвэл Ерөнхийлөгчийн институцийг засаглалын эрх мэдэл хуваарилах салаа мөчрийн гүйцэтгэх эрх мэдэлд хамруулан авч үзэх нь нилээд дөхөмтэй санагдана”¹⁰¹ гэж үзжээ. Монгол Улсын Үндсэн хуулинд Ерөнхийлөгчийг засаглалын аль салаа мөчирт хамаарахыг тодорхой зохицуулаагүй нээлттэй орхисон байдаг ч түүний Ерөнхийлөгчтэй холбогдох заалтуудыг нягтлан үзвээс засаглалын гүйцэтгэх эрх мэдэлтэй илүү ойр байж болохоор томъёолсон нь ойлгогдохоор байдаг.

Ингэхлээр Монгол Улсын Ерөнхийлөгч нь төрийн засаглалын хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явцад Үндсэн хуулиар олгогдсон өөрийн эрх хэмжээний дагуу идэвхтэй оролцон нөлөөлж байдаг

⁹⁸ Д.Лүндээжанцан. Монгол Улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт. УБ., 2001.,171 дахь тал.

⁹⁹ П.Очирбат. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх, анхны зам мөр. УБ., 2001.31 дахь тал.

¹⁰⁰ Б.Чимид. Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал. /Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь: онол практикийн бага хурал. УБ., 2003.34 дахь тал.

¹⁰¹ Ц.Ганболд, С.Мөнхбат. Төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн институт. Политологи. 2005 № 246 III 63 дахь тал

хэдий ч түүний статусыг засаглалын гүйцэтгэх эрх мэдэлтэй илүү холбогдуулан үзэх нь зүйд нийцэх юм. Энэ нь **нэгдүгээрт**, Үндсэн хуулиар хууль тогтоох эрх мэдэл гагцхүү УИХ буюу парламентад хадгалагдана гэж заасан нь хууль тогтоох эрхийг УИХ-аас өөр засаглалын ямар ч субъект эдлэхгүй гэдэг нь ойлгогдож байна, **хоёрдугаарт** Ерөнхийлөгчийн УИХ-тай харилцах харилцааны шинж байдлаас харж болно. Тухайлбал түүний бүрэн эрхийг УИХ хүлээн зөвшөөрдөг, тэр нь УИХ-д ажлаа хариуцдаг, Ерөнхийлөгчийн гаргасан зарлиг ба бусад аливаа шийдвэр нь хуулинд харшилбал түүнийг нь УИХ хүчингүй болгодог, Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах эрхийг УИХ өөрийн эрх хэмжээний хүрээнд багтаадаг, **гуравдугаарт** Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгогдсон бүрэн эрхийн шинж байдлаас үзвэл түүний бүрэн эрхийн системийг гүйцэтгэх эрх мэдэлд илүү хамаарах эрх үүргүүд үндсэндээ бүрдүүлдэг. Харин зарлиг, захирамж, илгээлт зэргийг эс тооцвол хууль тогтоох шинжтэй эрх түүнд бараг байдаггүй, **дөрөвдүгээрт** олон улсын улс төрийн амьдралын практикт ч Ерөнхийлөгчийг их төлөв төрийн засаглалын гүйцэтгэх эрх мэдэлд хамаатуулан үздэг нь нийтлэг шинжтэй зүйл юм. Үүнтэй холбогдуулан Оросын судлаач А.А.Мишин бичихдээ: “төрийн тэргүүн ихэвчлэн гүйцэтгэх эрх мэдлийг агуулагч гэж үзэгддэг”¹⁰² гэсэн байдаг зэрэгтэй холбоотой.

Эрх мэдлийн хяналт. Ерөнхийлөгчийн засаглалтай улс орны хувьд гүйцэтгэх эрх мэдлийн хяналт, тэнцвэржилт нь Ерөнхийлөгч, Засгийн газрын хоорондын харилцаагаар их төлөв тодорхойлогддог бол парламентын засаглалын үед парламент, гүйцэтгэх эрх мэдлийн хоорондын харилцан хамаарал чухал учир холбогдолтой байдаг.

Гүйцэтгэх эрх мэдлийн хяналтын хүрээнд парламентын зүгээс гүйцэтгэх заасаглалыг хянах хяналтын асуудал чухал байр суурь эзэлдэг. Үндсэн хуульд гүйцэтгэх засаглал буюу Засгийн газар, Ерөнхийлөгч нь парламентаас нилээд хэмжээгээр хамаарч байхаар тусган томьёолсон байдаг. Энэ нь парламентын засаглалын онцлогтой холбоотой. Төрийн удирдлагын парламентын системийн онцлог нь Засгийн газрыг бүрдүүлэх, түүний бүтэц бүрэлдэхүүнийг батлах, үйл ажиллагааг нь хянах, итгэл үзүүлэх, огцруулах зэрэгт парламентын оролцоо нөлөөлөл их байдагт оршдог. Энэ нийтлэг жишиг манайд ч тодорхой байдлаар хэрэгждэг. Түүнчлэн Засгийн газрын Ерөнхий сайдыг нэр дэвшүүлэх /33.2/, Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүний тухай саналыг УИХ-д оруулах /39.2/ явцад Ерөнхийлөгчийн оролцоо тодорхой хэмжээгээр байдаг. Гэвч Үндсэн хуулийн 2000 оны нэмэлт өөрчлөлтөөр Ерөнхийлөгчийн институтын энэ үүргийг нилээд хэмжээгээр хязгаарласан юм. Энэ тохиолдолд Засгийн газрын Ерөнхий сайд, гишүүдийг томилох, өөрчлөх, огцруулах явцад парламентын оролцоо нэмэгдэж байна. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Засгийн газрын Ерөнхий сайдыг УИХ томилдог /25.1.6/ бөгөөд Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлсэнээр УИХ хүн бүрээр хэлэлцэж мөн томилдог. /39.3/ Түүнчлэн Засгийн газрын огцруулах асуудлыг УИХ- хэлэцэн шийдвэрлэдэг. /43.3, 44 дүгээр зүйл/ Үндсэн хуульд зааснаар Засгийн газрын Ерөнхий сайд УИХ-ын өмнө хариуцлага хүлээдэг/41.1/ бөгөөд Засгийн газар үйл ажиллагаагаа УИХ-д тайлагнана. /41.2/ Үүнээс гадна гүйцэтгэх эрх мэдлийн нэг

¹⁰² А.А.Мишин. Конституционное государственное право зарубежных стран. М., 1998. С. 178.

чухал бүрдэл болох “Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах” /25.1.5/ зэрэгт УИХ-ын оролцоо нөлөөлөл шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг байна. Энэ бүхнээс үзвэл гүйцэтгэх эрх мэдлийн хэрэгжилтэнд УИХ шийдвэрлэх нөлөөтэй, гүйцэтгэх эрх мэдэл ч парламентаас шууд хамааралтай байдаг нь харагдаж байна.

Хэдий тийм боловч УИХ Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ тун хангалтгүй биелүүлдэг нь ажиглагддаг. Энэ нь гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаа, түүний үр дүн, хариуцлага тооцох механизмын үйлчлэлийг сулруулах уршиг дагавартай байдаг. Өнгөрсөн практикаас дүгнэхэд парламент ба Засгийн газрын хоорондын хамтын ажиллагааны оновчтой хэлбэр бүрэн төлөвшиж амьжаагүй байна. Засгийн газар парламенттай, парламент засгийн газартай харилцах, эрх мэдлийг хуваарилах чиглэлээр Монгол Улсын Үндсэн хуульд чамгүй зохицуулсан зүйл бий. Тухайлбал Монгол Улсын Үндсэн хуульд “Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана.” /41.2/ гэж заасан. Тэгвэл өнгөрсөн хугацаанд ингэж тайлагнадаг хэвшиж тогтсон байнгын үр ашигтай механизм үндсэндээ бүрэлдэж чадаагүй, хааяа Засгийн газрын үйл ажиллагааг хэлэлцсэн нэр зүүдэг ч энэ нь ерөнхий яриа болж өнгөрөөд зогсохгүй тодорхой төслүүдийн биелэлтэнд нарийвчлан хяналт тавьдаггүй, ингэж хянах механизм ч байдаггүй нь харагддаг. Харин энэ тохиолдолд Засгийн газар нь болохоор УИХ-ын гаргасан тогтоолыг “мартаж” орхих юмуу эсвэл уг шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд тусгагдаж хэрэгжихдээ удаашралтай байдаг. Ер нь УИХ-ын зүгээс Засгийн газрын үйл ажиллагааны тайланг хэлэлцэн шийдвэрлэх, Засгийн газарт итгэл үзүүлэх болон итгэл үл үзүүлэх практик хэрэг дээрээ үгүй болсон гэхэд хэтрүүлэл болохгүй юм.

Парламент ёсны нийтлэг жишгээр парламентаас засгийн газрыг хянах олон төрлийн арга механизм байдаг. Энэ нь асуулга тавих, онцгой хэлэлцүүлэг, хороодын шалгалт зэрэг юм. Манайд тэдгээр механизм бүрэн утгаараа хэрэгждэггүй, эн бүхэн нь засгийн газрын мэдээлэл сонсох, парламентын гишүүдээс асуулга тавих төдийнөөр хязгаарлагдаж байна. Засгийн газрын хувьд ч дээрх хяналтын механизмд төдийлөн ач холбогдол өгдөггүй, ор нэр төдий ханддаг, ноцтой ээдрээтэй асуудлыг намын олонхиор түрж, хаацайлан мөлийлгөдөг муу зуршил газар авчээ. Энэ нь парламент, гүйцэтгэх засаглалын хоорондын хяналт хариуцлагын зарчим гажуудсаны бодитой баримт мөн билээ.

Гүйцэтгэх эрх мэдлийн хяналтын нэг чухал бүрдэл нь Засгийн газрын зүгээс парламентайгаа харилцах, түүний үйл ажиллагааг хянах тухай асуудал байдаг. Францын судлаач М.Дюверже гүйцэтгэх засаглал парламентад нөлөөлөх аргыг төрөл хэлбэрийнх нь хувьд **нэгд** парламентын гишүүдийг томилоход оролцох, **хоёрт** парламентын зохион байгуулалтанд оролцох, **гуравт** парламентын үйл ажиллагаанд оролцох, **дөрөвт** парламентыг татан буулгах зэрэгтэй холбон үзсэн байдаг.

Засгийн газар, гүйцэтгэх байгууллага болохын хувьд УИХ-ын өмнө **нэгдүгээрт**, хуулийн төсөл өргөн барьж, УИХ-ын баталсан хуулийг хэрэгжүүлэх, **хоёрдугаарт**, төвлөрсөн төсвийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн барьж, батлагдсан төсвийг хуваарилан хэрэгжүүлэх, **гуравдугаарт**, засгийн газар ажлаа Их хуралд тогтмол тайлагнах, мэдээлэх, **дөрөвдүгээрт**, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, захиргааны байгууллагын бүдүүвч, үйл ажиллагааны

хөтөлбөрөө батлуулах, **тавдугаарт**, УИХ-аас даалгасан ажил үүрэг, гүйцэтгэх чиглэлээр харилцаж, Засгийн газар, Улсын Их хурлын өмнө ажил төрлийн талаар хамтын хариуцлага хүлээж, кабинетаараа огцроно.¹⁰³

Үндсэн хууль судлаач доктор Ж.Төртогтох бичихдээ: “Гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох засаглалдаа бүрэн харъяалагдаж, харин эргээд түүнд ямар нэгэн байдлаар нөлөөлөх механизм Үндсэн хуулийн хүрээнд тодорхойлогдоогүй боловч энэ асуудлыг практикт Засгийн газар нь нэгэнт УИХ-д олонхи суудал авсан нам, хүчнээс байгуулагдах учир тэрхүү олонхиор дамжуулан УИХ-д нөлөөлөх байдлаар шийдвэрлэж болох юм. Гэхдээ энэ механизм нэгэнт Үндсэн хуульд тусгагдаагүй тул сөрөг үр дагаварт ч хүргэж болох талтай. Тухайлбал ийм байдал үүсэх нэг томоохон хүчин зүйл нь парламентат олонхи суудал авсан намын дарга Засгийн газраа байгуулж, тэргүүлэх, нөгөө нэг хүчин зүйл нь Засгийн газрын бүрэлдэхүүн бүхэлдээ буюу тодорхой хэсэг нь парламентын гишүүдээс бүрдэх явдал байж болно. УИХ-ын зүгээс засгийн газарт хяналт тавьж байх зарчим Үндсэн хуулиар тодорхойлогдсон ч практикт засгийн газрын тэргүүн нь парламентын олонхийг намын тэргүүнийхээ хувьд удирдах бололцоотой. Тэр тусмаа засгийн газрын бүрэлдэхүүний тодорхой хэсэг парламентаасаа бүрдэж байгаа тохиолдолд парламент дахь Засгийн газрын нөлөөлөл харьцангуй нэмэгдэнэ гэсэн үг”¹⁰⁴ гэсэн нь сонирхолтой дүгнэлт юм.

Ийм нөхцөл байдал манайд хэдийнээ бүрдсэн гэж болно. Үүнтэй холбоотой өнөөдөр парламент дахь Засгийн газрын нөлөө, оролцоо түүний зүгээс парламентыг үнэн хэрэг дээрээ хяналтандаа байлгах нь бодитой зүйл болжээ. Энэ нь **нэгдүгээрт** Монгол Улсын Ерөнхий сайд парламентын олонхи болсон намын дарга байгаа, **хоёрдугаарт** парламентад олонхи болсон нам, түүний нөлөө бүхий гишүүд /парламентын гишүүд/ засгийн газрын бүрэлдэхүүнд багтсан, **гуравдугаарт** Засгийн газрыг парламентад олонхийн намын сахилга батын зарчим ямар нэг байдлаар хэрэгжиж байгаатай, **дөрөвдүгээрт** УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүний албыг хавсран гүйцэтгэж болох Үндсэн хуулиар олгогдсон боломж /29.1/ зэрэгтэй холбоотой байна.

Үүнтэй холбогдуулан УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн байж болох тухай Үндсэн хуулийн 29.1 заалтын тухайд зарим зүйлийг бага зэрэг тодруулж үзье. 1992 онд баталсан Үндсэн хуулийн анхны эхэд дээрхийн эсрэг заалт байсан. Харин үүнийг 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр батлагдсан нэмэлт өөрчлөлтөөр өөрчлөлт хийж найруулсан байдаг. Тухайн үедээ Үндсэн хуулийн Цэцийн 2000 оны 02 дугаар тогтоолоор уг нэмэлт өөрчлөлтийг хүчингүй болгосон боловч мөн оны 12 дугаар сарын 14-ний өдрийн Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр дахин нэмж оруулсан юм. Энэ нэмэлт өөрчлөлт нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хоорон дахь хяналт, тэнцвэрийн зарчмыг алдагдуулан, УИХ-ын зүгээс Засгийн газрын үйл ажиллагаанд бодитой хяналт тавих боломжийг сулруулж, Засгийн газрын эрх хэмжээг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.

¹⁰³ Б.Шаравсамбуу. УИХ ба Засгийн газар хоорондын харилцаа, Засгийн газрын бүрэн эрхийн зарим асуудал. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. Товхимол-III, УБ., 2000. 106 дахь тал.

¹⁰⁴ Ж.Төртогтох. Үндсэн хуулийн политологийн шинжилгээ. УБ., 2010. 71 дахь тал.

Сүүлийн үед УИХ-ын гаргасан бодлого, чиглэлийг Засгийн газар дур мэдэн төдий л хангалттай хэрэгжүүлэхгүй байх, түүнд нь УИХ-ын зүгээс цаг тухайд нь хяналт тавьж, хариуцлага тооцож чадахгүй байх дутагдал ажиглагдаж байна. Энэ нь угтаа хууль тогтоох эрх мэдэл болон гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлэгч институтын хоорондын үүргийн хуваарилалт, эрх мэдлийн тэнцэл зохицол, харилцан хяналттай байдал алдагдан, хоорондоо үйл ажиллагааны хувьд хэт их хутгалдах болсоны уршиг мөн билээ. Иймд Үндсэн хуулийн хүрээний энэ гажуудлыг засамжлах шаардлага зайлшгүй тавигдаж байна.

Парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байж болдог жишиг нилээдгүй улс орнуудад (Австрали, Шинэ Зеланд, Индонез, Япон, Герман, Ирланд, Сингапур /2 сайд/ гэх зэрэг) хэрэгждэг. Харин Франц, АНУ, Израиль, Энэтхэг, Турк, Австри, Орос, Дани гэх зэрэг бусад улс орнуудад тэдгээрийн хоорондын ялгаа, бие даасан байдал хадгаллагддаг.* Эндээс үзвэл хууль тогтоох хийгээд гүйцэтгэх эрх мэдлийн харилцаа, үүргийн хуваарилалт, түүний үр дагаварын асуудал нь тухайн улс орны улс төрийн амьдралын өвөрмөц нөхцөл байдал, ардчилсан улс төрийн институтын төлөвшил, нийгмийн улс төрийн соёл, боловсрол, мэдлэгийн онцлогтой шууд холбоотой байдаг нь харагдаж байна.

Харин Монгол орны хувьд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн давхцалт байдал нь тус орны өнөөгийн улс төрийн амьдралын өвөрмөц байдал, улс төрийн институтын төлөвшлийн хүрсэн түвшин, улс төрийн ухамсар, соёлын онцлогтой тэр бүр таарч нийцэхгүй, гарах үр дагавар нь ч хүссэн үр дүнг авчирч чадахгүй байгаа юм. Үндсэн хуульд Засгийн газрыг бүрдүүлэн байгуулах болон түүний үйл ажиллагаа нь УИХ-д хамааралтай байхаар хуульчлагдсан хэдий ч Засгийн газрын бүрэлдэхүүний тодорхой хэсэг парламентаас бүрдэж байгаа тохиолдолд парламент дахь Засгийн газрын хүч нөлөө нэмэгдэж, тэр хэрээр Засгийн газарт тавих парламентын хяналт харьцангуй сулрах магадлал өндөр байгаа юм.

Сүүлийн үед Засгийн газрын бүрэлдэхүүний гуравны нэгээс дээшгүй хувь нь УИХ-ын гишүүн байж болно. Тухайлбал бодлогын чиглэлийн гол яамд буюу Гадаад харилцаа, Сангийн яам болон Ерөнхий сайдыг парламентын гишүүдээс сонгож болох юм гэсэн санаа гарч ирэх болсон. Энэ чиглэлээр хуулийн төсөл ч боловсрогдон, саналын түвшинд яригдаж байгаа байх. Тэд энэ санаагаа тайлбарлахдаа УИХ-ын гишүүн Засгийн газрын гишүүн байж болохгүй гээд шууд шийдчихээр 1996-2000 оных шиг тогтворгүй нөхцөл байдал үүсэх магадлалтай гэдгийг иш үндэс болгож байна. Гэвч энэ нь үнэндээ хангалттай үндэслэлтэй тайлбар биш юм. Учир нь ийм нөхцөл байдал үүсэхгүй байх нөхцөлийг 2000 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр тухайлбал Ерөнхийлөгч, Засгийн газрын хоорондын харилцааг зохицуулсан зарим нэмэлт өөрчлөлт оруулсан заалтаар хангалттай хааж өгсөн гэж үзэж байна. Үүнтэй холбогдуулан Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг онцолж болох байна.

* *Тайлбар:* Засгийн газар нь парламентын гишүүнээс бүрдсэн 34 орон, хориглосон 24, дундаж байр суурь барьдаг 24 орон байдаг . /Д.Лүндээжанцан, Л. Өлзийсайхан. Парламентат ёс. УБ., 2005, 129 дахь тал. /

Гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс парламенттай харилцах, хянах нэг суваг нь Ерөнхийлөгчийн зүгээс парламенттай харилцах харилцаа юм. Монгол Улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгч, парламентын хоорондын харилцааг зохицуулсан нилээд заалт Үндсэн хуульд байдаг.¹⁰⁵ Тэр дундаас УИХ-ын шийдвэрт тавих Ерөнхийлөгчийн хориг, УИХ-ыг тараахтай холбоотой харилцааг зохицуулсан заалт анхаарал татаж байна. УИХ-ын шийдвэрт тавих Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс УИХ-ыг хянах хяналтын сул, хүчгүй механизм болохыг нэгэнтээ өмнө тодорхой тайлбарласан. Харин УИХ-ыг Ерөнхийлөгч тараахтай холбогдсон механизмыг тусгаж өгсөн Үндсэн хуулийн 22.2 заалтыг тодорхой болгох шаардлага байгаа юм. Учир нь парламент өөрөө тарах механизмтай улс оронд түүнийг засаглалын өөр субъект тараах эрхгүй буюу хориглодог байна. Иймд парламентыг Ерөнхийлөгч тараах тухай Үндсэн хуулийн одоогийн заалт хэрэгжих үндэсгүй хэлбэрийн төдий заалт болох нь илэрхий.

Эрх мэдлийн тэнцвэр. Парламентын засаглалын нөхцөлд гүйцэтгэх эрх мэдэл парламенттай бүрэн хамааралтай байдаг ч эргээд төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлэх шаардалагын үүднээс гүйцэтгэх эрх мэдлийн хяналт, тэнцвэрийн механизмыг Үндсэн хуульд тодорхой суулгаж өгөх нь үнэхээр ач холбогдолтой. Үүнтэй холбогдуулан дараах гурван зүйлийг онцлон үзье. Үүний нэг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгож гаргаж ирэх механизм, нөгөө нь УИХ-ыг тараахтай холбогдсон Ерөнхийлөгчийн эрх хэмжээний асуудал, гурав дахь нь Засгийн газарт УИХ өөрийн зарим эрх хэмжээг шилжүүлэх тухай асуудал юм.

Үндсэн хуулийн 31 дүгээр зүйлийн 1 хэсэгт Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгож гаргаж ирэх механизм хоёр үндсэн үе шаттай байхаар заасан байдаг. Энэ нь 31.3-т зааснаар эхлээд Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгож гаргаж ирнэ. Дараа нь 31.4-д зааснаар ард түмнээс сонгогдсон Ерөнхийлөгчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь зөвшөөрсөн хууль гаргана. Ингэснээр Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн хоёр дахь үе шат дуусч, Ерөнхийлөгчийн бүрэн эрх баталгаажиг байгаа юм.

Гэтэл энд дараах логик зөрчил ажиглагдаж байна. Үүнд **нэгд** Монгол улсын Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгож гаргаж ирсэн хэрнээ парламентаас бүрэн эрхийг нь зөвшөөрүүлж байгаа нь ойлгомжгүй байна, **хоёрт** УИХ-аас Ерөнхийлөгчийг батламжилж байгааг сонгуулийн хоёр дахь үе шат гэж үзэхэд эргэлзээтэй байна, **гуравт** бүх ард түмнээс тэр байтугай парламентаар баталгаажиг гарч ирсэн Ерөнхийлөгчид олгогдсон бүрэн эрхийн механизм нь түүний сонгогдож гарч ирсэн хэлбэртэй нийцэхгүй байгаа зэрэг юм. Энэ нь төрийн засаглалын эрх мэдлийг тэнцвэржүүлэх зарчимд огтоос тохирохгүй байгаа юм. Энэ тохиолдолд асуудлыг шийдэх хамгийн үр ашигтай гарц нь Монгол Улсын Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс биш харин парламентад ёсны нийтлэг жишгийн дагуу түүнийг парламентаас сонгож гаргаж ирэх механизмыг Үндсэн хуульд суулгаж өгөх явдал юм. Төрийн тэргүүнийг парламентаас сонгож гаргаж ирдэг хэлбэр парламентын засаглалтай олон оронд хэвшиж тогтсон шинжтэй болсон байдаг. Тухайлбал Итали, Герман,

¹⁰⁵ Энэ тухай Б.Дэлгэрмаа. “УИХ болон Ерөнхийлөгч хоорондын харилцаа”. /Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. УБ., УБ., 2000/ өгүүлэлээс тодорхой үзнэ үү.

Энэтхэг гэх зэрэг олон улс орнуудыг онцлон үзэж болно. Хэрвээ Монгол Улсын Ерөнхийлөгчийг ингэж парламентаас сонгож гаргаж ирдэг болох нь наад зах нь нүсэр сонгууль явуулж зардал чирэгдэл гаргахгүйгээс гадна төрийн засаглалын эрх мэдлийг тэнцвэржүүлэх үйл явцад бүрнээ нийцсэн хэрэг болохсон билээ.

Төрийн засаглалын эрх мэдлийн тэнцвэрийг бодитой хангах нөгөө нэг механизм нь Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ыг тараахтай холбогдсон Үндсэн хуулийн зохицуулалт юм. УИХ үйл ажиллагаагаа явуулж чадахгүй нь илэрхий болсон нөхцөлд /өмнө тодорхой дурьдсан/ Ерөнхийлөгчийн УИХ-ыг тараах механизмын үйлчлэлийг хүчтэй болгож өгөх нь гүйцэтгэх засаглалын зүгээс парламентат тавих нэгэн хамгийн доривтой хяналтын механизм бүрдэх учиртай юм. Харин энэ тохиолдолд Ерөнхийлөгч парламентыг тарааж болохгүй байх хязгаарлалтыг ч давхар хуульчилж өгөх нь зүйтэй байх. Тухайлбал энэ бүхэн нь Ерөнхийлөгчийн сонгогдсоны дараах хугацаа болон бүрэн эрх нь дуусахын өмнөх хугацаа, Ерөнхийлөгч тараах шийдвэрийг гаргах ээлж, энэ шийдвэрийг дахин гаргахыг хориглох түүнчлэн парламентын бүрэн эрх нь эхэлсэний дараах болон дуусахын өмнөх хугацаа зэрэгтэй холбоотой байж болох юм. Парламентын засаглалтай улс орнуудад төрийн тэргүүн /Ерөнхийлөгч, Эзэн хаан/ нь парламентаа тараах шийдвэр гаргадаг жишиг түгээмэл байдаг. (Жишээ нь, Австралт, Австри, Бельги /эзэн хаан/, Итали, Энэтхэг, Франц, Герман, Чех, Япон /эзэн хаан/)

Парламентат ёсны жишгээр зарим улс орнуудад /Герман, Франц, АНУ/ Засгийн газрын гаргаж буй зарим акт, шийдвэрийг хуулийн хүрээнд хүлээн зөвшөөрсөн байдаг. Харин энэ тохиолдолд гүйцэтгэх засаглалаас гаргаж буй эрх зүйн акт шийдвэрийн чухам аль акт шийдвэрийг нь хуулийн хүрээнд зөвшөөрч болохыг нарийн зааглаж, зохицуулсан байдаг. Үүнтэй холбоотой манай зарим судлаачид УИХ-д хууль тогтоох эрх мэдлийг яс оноох нь Засгийн газрын үйл ажиллагааны шуурхай байдал, эрчим, идэвхийг сулруулах уршигтай гэгцгээдэг. Иймд зарим нөхцөлд Засгийн газрын гаргасан шийдвэр, акт, эрх зүйн баримт бичгийг хуулийн хүчинтэйд тооцож, хүлээн зөвшөөрүүлж байх нь чухал байна гэж тэд үздэг юм. Тухайлбал энэ тухай доктор С. Зүльфикар бичихдээ: “Засгийн газарт хязгаарлагдмал эрх олгож, түүний чиг үүргийг бусад төрийн институтууд хатуу чанд хязгаарлах нь улс төрийн гацаа үүсгэж болох аюултай. Засгийн газар нь бие даан үйл ажиллагаа явуулж, парламентыг хянах боломжгүй бол гүйцэтгэх эрх мэдэл нь нийгмийн өмнө тулгамдаад байгаа асуудлыг бие даан шийдвэрлэх бололцоогүй болж байгаа хэрэг юм” гэсэн байна.¹⁰⁶ Энэ байр суурийг анхаарч үзэж, түүнийг хэрэгжүүлэх зохистой, оновчтой арга замыг эрэлхийлэх нь буруу зүйл биш боловч энэ нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах зарчимтай ямар нэг байдлаар харшилж болохыг давхар бодолцох нь зүйтэй юм.

Ингэхлээр төрийн гүйцэтгэх эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилтийн зарчмыг бодитой ханган хэрэгжүүлэхийн тулд цаашид дараах зүйлсийг анхааралдаа ваха хэрэгтэй байгаа юм. Тухайлбал гүйцэтгэх эрх мэдэл дэх Ерөнхийлөгчийн институтын статус, байр суурь, үүргийг тодорхой болгох; парламентаас гүйцэтгэх эрх мэдэлд тавих хяналтыг хүчтэй болгох, үр дүнг дээшлүүлэх; парламентын гишүүн Засгийн газрын гишүүн байх явдлыг

¹⁰⁶ С.Зүльфикар. Засаглал хуваах онолын хөгжил, хандлага. Политологи. 2011 № 348 /61/, 32 дахь тал.

хязгаарлах, эсвэл бүр болиулах; Ерөнхийлөгчийн хоригийн үйлчлэлийн эрх зүйн чадамжийг нэмэгдүүлэх; парламент өөрөө тарах механизмыг зогсоож, үүнд ерөнхийлөгчийн оролцоо, нөлөөллийг нэмэгдүүлэх; Ерөнхийлөгчийг парламентаас сонгож, гаргаж ирдэг болох зэрэг юм.

Шүүх эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэржилт

Эрх мэдлийн хуваарилалт. Шүүх эрх мэдэл нь төрийн засаглалын эрх мэдлийг хуваарилах, тэнцвэржүүлэх үйл явцад онцгой үүрэг гүйцэтгэдэг. Энэ нь хууль тогтоох байгууллага шиг нийтээр дагаж мөрдөх хуулийн хэм хэмжээ тогтоодоггүй, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага шиг төрийн удирдлагын хэргийг эрхэлдэггүй харин хуулийг хэрэглэн, засаглалын бусад эрх мэдлийн байгууллагын үйл ажиллагаанд хуулийн хяналт тавьж, эрх мэдлийн тэнцвэрийг хангаж байдаг.

Монгол улсын Үндсэн хуульд шүүх эрх мэдлийг нарийн хуваарилан зохицуулсан байдаг. Тухайлбал Үндсэн хуульд “Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ” /47.1/, “Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” /47.2/ хэмээн заасан байдаг нь шүүхийг төрийн бусад эрх мэдлийн институтээс нарийн хуваарилан заагласаныг харуулж байна. Олон улсын жишгээр шүүх эрх мэдэл нь өөрийн бүрэн эрхээр дамжуулан чиг үүргээ хэрэгжүүлдэг бөгөөд энэ нь хуульд захирагдах ёс, хараат бус байх, бие даасан байх, бусдын эрхийг хангах, шударга, ил тод байх гэсэн үндсэн зарчимд суурилдаг. Шүүхийн бүрэн эрхийн хүрээнд:

- Маргааны үндсэн дээр бие даан, алагчлалгүй асуудлыг шийдэх
- Шүүн таслах эрх
- Хараат бус байх эрх
- Зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх эрх
- Гэм буруутайг тооцох эрх
- Шийдвэрлэж буй асуудлаар эцсийн шийдвэр гаргах
- Гаргасан шийдвэр нь заавал биелэгдэх хүчинтэй байх эрхүүд багтдаг.¹⁰⁷

Үндсэн хуулинд Монгол Улсын “Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх...” /48.1/ болохыг зааж тэдгээрийн бүрэн эрх , чиг үүргийг тодорхой томъёолсон байдаг. Харин тэдгээрийг хэрэгжүүлэх арга зарчмыг “Шүүхийн тухай” –хуульд нарийвчлан тодорхойлсон. Түүнчлэн Үндсэн хуульд шүүх тогтолцооны дээр дурдсан бүрдлийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах чиг үүрэг бүхий хамтын удирдлагын орон тооны бус байгууллага болох Шүүхийн Ерөнхий зөвлөлийн бүрэн эрх, үүрэг бүрэлдэхүүнийг тусгайлан зохицуулж өгсөн байдаг. /49.3.4/ Үндсэн хуульд зааснаар “Шүүхийн ерөнхий зөвлөл нь шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү

¹⁰⁷ В.Удвал. Шүүх бүрэн эрх. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. Товхимол №1, УБ.,1999, 124 дахь тал.

хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ” /49. 4/

Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1-т “ Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн...” гэж заагаад түүний бүрэн эрхийг нийт 5 зүйлээр тодорхойлон авч үзсэн байдаг. Харин “Шүүхийн тухай хууль”-д шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх тусгай зарчмыг хуульчилсан байдаг бөгөөд тэдгээр зарчим нь: шүүгч гагцхүү хуульд захирагдах; мэтгэлцэх; хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч оролцох зарчим; гэм буруутайд тооцож үл бол зарчим; хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх зарчим; шүүхээс хууль хэрэглэх зарчим; өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхээр хангах зарчим; шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулах зарчим; шүүх хуралдааныг нээлттэй явуулах зарчим зэрэг юм. Эндээс үзвэл Монгол Улсад шүүх эрх мэдлийг хуулийн хүрээнд олон улсын нийтлэг жишгийн дагуу зөв зохистой хуваарилсан нь харагдаж байна. Харин гагцхүү шүүх эрх мэдлийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх арга механизмыг нийгмийн хөгжлийн дагуу улс төр, эрх зүйн талаас нь улам бүр төгөлдөржүүлэх шаардлага ямагт тавигдах нь зүйн хэрэг билээ.

Шүүх эрх мэдлийн хуваарилалтийн асуудлын хүрээнд тавигдаж, өнөө хэр ойлголтын зөрөөтэй байгаа нэг үндсэн асуудал нь Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийг шүүх эрх мэдлийн бүрдэл хэсэг мөн эсэх тухай асуудал юм. Манайд өдгөө Үндсэн хуулийн Цэц шүүх мөн үү, биш үү гэсэн маргаан байнга явагддаг байдаг нь үнэхээр хачирхалтай. Өнөөдөр яагаад түүнийг шүүх мөн, биш хэмээн маргаад байгаагийн үндсэн шалтгаан нь Үндсэн хуульд Цэцийг Монгол улсын шүүх тогтолцоонд хамруулан баталгаажуулж өгөлгүй зөнд нь орхисонтой холбоотой. Гэтэл Үндсэн хуулийн Цэц нь Үндсэн хуулийн хяналтыг хэрэгжүүлж байдаг шүүх мөн гэдэгт эргэлзэх хэрэг ерөөсөө байхгүй юм. Энэ тохиолдолд Үндсэн хуулийн Цэцийг Монгол Улсын шүүх эрх мэдлийн тогтолцоонд эргэлзээгүйгээр багтаан үзэх нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуульд Цэцийг бие даасан байдлаар тусгайлан зохицуулсаныг манай зарим судлаачид зөвтгөн тайлбарлахдаа: “ Бидний үзэж буйгаар 1992 оныхоо Үндсэн хуулиар тогтоосон төрийн байгууллын тогтолцоо маань эх газрын эрх зүйн тогтолцоонд голлон тулгуурласан учир Үндсэн хуулийн Цэцийг бие даалгаж, ердийн шүүхийн тогтолцоонд оруулаагүйн зэрэгцээ Үндсэн хуулийг сахиулах баталгаа болгон бэхжүүлж өгчээ. Гэхдээ энэ нь Үндсэн хуулийн Цэцийг шүүх эрх мэдлийн гадна орхисон хэрэг биш юм”¹⁰⁸ гэсэн байна. Энэ судлаачийн тайлбарыг ойлгон хүлээн авч болох ч тэртэй тэргүй шүүх институт болох Цэцийг нийгмийн харилцааны суурь хууль-Үндсэн хуульд бие даасан байдлаар оруулж, зохицуулсанаар Цэцийн талаар буруу зөрүү ойлголт бий болох, асуудлыг хоёрдмол агуулгаар бүрхэгдүүлэх нөхцөл болж буйг шууд хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Иймээс Цэцийг шүүх тогтолцооны үндсэн бүтцэд оруулан Үндсэн хуулинд нэмэлт өөрчлөлт хийх нь зохимжтой байгаа юм.

Эрх мэдлийн хяналт. Шүүх эрх мэдэл нь Үндсэн хуульд заагдсан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ нийгэмд хууль ёсыг сахиулах баталгаа болж, түүгээр

¹⁰⁸ Д. Лүндээжанцан. Шүүх эрх мэдэл, түүний чиг үүргээ гүйцэтгэх эрх зүйн орчин. Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын асуудал. Товхимол-III, 130 дахь тал.

дамжуулан хянах чиг үүргээ биелүүлдэг. Хуулийн ноёрхол бол ардчилсан нийгмийн амин сүнс юм. “Хууль анхдагч” байх тухай үзэл санааг хүн төрлөхтөний сод сэтгэгчид бүр эртнээс үндэслэн сануулж байсан нь санамсаргүй хэрэг биш юм. Платон “хаана хуулийн хүчин чадал сул байна, тэнд төр сүйрэлд хүрнэ. Эрх мэдлийн дээр хууль орших нь төрийг ч, үнэ цэнэтэй бүхнийг ч аврах болно” гэсэн бол Ж.Руссо “төр хүчтэй байна гэдэг нь дарангуйлахад биш, бусдын өмнө үүрэгтэйг хуулиар зохицуулахад оршино” гэсэн байдаг нь шүүх нь хууль хэрэглэх явцад төрийн засаглалын эрх мэдлийн тогтолцоонд хяналтын хүчирхэг механизм болдогийг хүлээн зөвшөөрсөн хэрэг юм. Шүүх эрх мэдлийн хяналтын чиг үүрэг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэлтэй харилцах шүүх эрх мэдлийн харилцаагаар тодорхойлогддог.

УИХ-аас баталсан хууль тогтоомж, Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн тохиолдолд Цэц тэдгээрийг хүчингүй болгох хэлбэр нь шүүх эрх мэдлийн зүгээс хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдэлд тавьж буй хяналтын чухал механизм болдог. Үндсэн хуульд зааснаар “Хууль зарлиг, Улсын Их хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно” /66.4/, “Үндсэн хуулийн цэцийн шийдвэр гармагцаа хүчин төгөлдөр болно.” /67/ гэсэн байдаг. Энэ заалт Үндсэн хуулийн Цэцийн их суудлын хуралдааны шийдвэр эцсийн бөгөөд түүнийг УИХ шүүхгүй, хэлэлцэхгүй, зөвхөн хэрэгжүүлэх үүрэгтэй гэсэн хууль зүйн утга, логик гарч байгаа юм. Гэтэл УИХ Цэцийн шийдвэрийг хэрэгжүүлэхийн оронд Үндсэн хуулиас хууль зүйн хүчин чадлын хувьд доогуур хуулийг баримтлан хэлэлцэж, зарим тохиолдолд түүний шийдвэрийг үл тоомсорлодог буруу практикийг заавал залруулах ёстой. Хэрвээ үүнийг засахгүй бол Үндсэн хуулийн шүүхийн шийдвэрийг биелүүлдэг арга механизмгүй болгож, УИХ-ын үзэмжээс хамаардаг жишиг тогтоно. Үүний уршгаар Үндсэн хуулийн Цэцийн их суудлын шийдвэр эцсийн байхаа больж, түүнийг дахин хянадаг нэг байгууллагыг энэ буруу практикаар тогтооно. Түүний дараа Монгол Улсыг Үндсэн хуультай гэж ярихын ч аргагүй болно.

Харин парламентын зүгээс шүүх эрх мэдэлтэй харилцах харилцааны нэг үндсэн хэлбэр нь шүүгч нарыг томилоход оролцох парламентын оролцоо юм. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Үндсэн хуулийн Цэцийн 9 гишүүнээс гурвыг нь УИХ санал болгох бөгөөд тэдгээр 9 гишүүнийг УИХ томилдог. Энэ нь УИХ өөрийг нь хянадаг институтын бүрэлдэхүүнд нөлөөлөх боломжтой болж байгаа хэрэг юм. Гэхдээ энэ нь шүүхийг УИХ шууд хянах үндэс болохгүй.

Эрх мэдлийн тэнцвэр. Шүүх эрх мэдэл нь төрийн засаглалын тогтолцоонд эрх мэдлийн тэнцвэрийг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг. Ингэж тэнцвэржүүлэхдээ төрийн засаглалын бусад институт, байгууллагад тавих хяналтаар дамжуулан тэнцвэржүүлэх чиг үүргээ хангаж байдаг. Үндсэн хуулиар шүүх эрх мэдэл нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хэрэгжилтийн хэм хэмжээг хангаж, түүнд шаардлагатай бол хязгаарлах хүртэл нөлөө үзүүлдэг. Үүний зэрэгцээ хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын зүгээс ч шүүх засаглалд ямар нэг байдлаар нөлөөлөх эрх зүйн боломж байдаг. Тухайлбал Үндсэн хуулийн Цэцийн дүгнэлтийг УИХ хүлээж авах эс хүлээж авах эсэхээ хэлэлцэн шийдвэрлэх, Улсын дээд шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөл УИХ-д танилцуулах болон Цэцийн гишүүдийг УИХ томилох,

Ерөнхийлөгч Цэцийн 3 гишүүнийг нэр дэвшүүлэх, Дээд шүүхийн болон бусад шатны шүүхийн шүүгчдийг томилох зэрэг нь засаглалын бусад институтын зүгээс шүүх засаглалд ямар нэг хэмжээгээр нөлөөлж, тэдгээрийн хоорондын харилцааны тэнцвэрийг хангаж буй хэлбэр болдог.

Хэдийн тийм боловч шүүхийн бие даасан, хараат бус, зөвхөн хуульд захирагдах зарчим нь түүний төрийн засаглалын эрх мэдлийн тогтолцоонд тэнцвэрийг найдвартай хангах баталгаа нь болдог. Харамсалтай нь шүүхийн энэ жам ёсны зарчимд ил далд халдах, төрийн өндөр албан тушаалтан, нам, хүчний зүгээс шүүхийн шийдвэрт нөлөөлөх гэж оролдох оролдлого тойруу далд боловч байсаар байгаа нь төрийн эрх мэдлийн хүрээнд байх ёстой тэнцвэржүүлэлтийн зарчимд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж буйг цаашид анхааран засамжлах учиртай юм. Үүнтэй холбоотойгоор шүүх эрх мэдлийн хувьд ч өнөөдөр хараат бус байх зарчим дээрээ хатуу зогсож, зоригтой, шийдэмгий байж, шийдвэрийнхээ үндэслэл нотолгоо, тайлбарын онолын түвшинг дээшлүүлэн, улс төрийн нам, хүчин, албан тушаалтны элдэв шахалт, шаардлага, ятгалагт автахгүйгээр үндсэн чиг үүргээ шударгаар хэрэгжүүлэх нь туйлын чухал болж байгаа юм.

Энэ бүхнээс үзвэл цаашдаа шүүх эрх мэдлийн хүрээнд эрх мэдлийн хуваарилалт, хяналт, тэнцвэржилтийн үйл явцыг зохистой хангахын тулд юуны өмнө Үндсэн хуулийн Цэцийг шүүхийн тогтолцооны бүтцэд оруулах; шүүхийн хараат бус бие даасан байдлыг бодитой хангах; шүүхийг чадваржуулах; шүүх эрх мэдлийн эрх зүйн орчинг сайжруулах; шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэсэн Үндсэн хуулийн заалтыг чанд мөрдөн хэрэгжүүлэх; Үндсэн хуулийг тайлбарладаг субъект нь Үндсэн хуулийн Цэц байдаг жишгийг эрх зүйн хувьд баталгаажуулах шаардлагатай байгаа юм.

Summary

The concept of power distribution is a basic principle of democratic government. This idea is put in practice in all democratic countries, depending on national specifics. In our country this concept is reproduced in Constitution and is implementing in real life. In the article the author is analyzing this process.

УЛС ТӨРИЙН ДЭГЛЭМИЙН ШИЛЖИЛТ БА МОНГОЛЫН УЛС ТӨРИЙН ЭЛИТ

Ч.Өлзийсайхан

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор

Ц.Өлзийжаргал

Улс төр судлалын магистр

Түлхүүр үг: засаглал, эрх баригч элитүүд, улс төрийн дэглэмийн шилжилт, намын тогтолцоо, олон ургальч дэглэм, ардчилал

Засаглал бол үзэл санаа, итгэл үнэмшил, нийгмийн төлөөлөл, эрх зүйн зохицуулалттай нарийн учир холбогдолтой зүйл юм. Улс төрийн дэглэмүүдийн өөр хоорондоо ялгаатай байдал нь эрх мэдлийн хэм хэмжээний асуудлыг тодруулах, төрийн эрх баригчид, нийгмийн бүлгийн удирдагчдыг үйл байдлыг харьцуулан үзэх боломжтой болгож байна. Улс оронд оршин тогтнож байгаа засаглал нь хууль эрх зүйн зохицуулалтын хэлбэрээр хэрэгждэг тул дэглэмүүдийг харьцуулан үзэхийн тулд юуны өмнө нийгэм, төрийн үйл ажиллагааг зохицуулж байдаг эрх зүйн байдлыг харьцуулан үзэх зайлшгүй шаардлага гарч ирнэ. Профессор С.Хантингтон ардчиллын гурав дахь давалгааны үеийн ардчилалд шилжсэн улсуудын шилжилтийг харьцуулсан байдлыг авч үзэхэд монголын энэхүү шилжилтийн үйл явц нь шинээр бий болсон сөрөг хүчнийхний хүчтэй шахалтаар хуучин эрх баригчид буулт хийснээр ардчилал тогтож эхэлсэн хэв маягт Монгол улс хамаарах юм¹⁰⁹. Харин сөрөг хүчний хүчтэй шахалтаар хуучин эрх баригчид буулт хийснээр ардчилсан дэглэмийн шалгуур үзүүлэлтүүд шууд хэрэгждэггүй харин удаан хугацааны олон янзын хувилбар, сонголтуудыг дамжин хөгждөг болох нь харагдаж байгаа юм.

1960 оны БНМАУ-ын Үндсэн Хуульд “Социалист эх орноо социализмын дайснаас ариунаар хамгаалах”-ыг¹¹⁰ иргэн бүрт үүрэг болгож, “Социалист төр нь нийгмийн социалист өмчийг хамгаалж бэхжүүлэх, аж ахуй соёлын байгуулалтанд нийгмийн бүх гишүүдийг идэвхитэй оролцуулах, хөдөлмөрийн социалист сахилгыг бүх аргаар бэхжүүлэх, улс орныг империалист түрэмгийллээс батлан хамгаалах явдлыг зохион байгуулна”¹¹¹ гэж заасан нь социализмын үеийн улс төрийн элитүүд өөрийн эрх дархыг ямар нэг сөргөлдөөнгүйгээр урт удаан хугацаагаар хадгалж байх хууль эрх зүйн үндэс нь болж байсан билээ. Энэ үед улс төрийн өөр намууд оршин байх, эрх баригч элитүүдийн үйл ажиллагаа, бодлогыг шүүмжлэн хэлэх боломжгүй хатуу чанга нэг намтай дэглэм оршин байв.

1980-аад оны дунд үе хүртэл оршин байсан энэхүү нэг намтай хатуу тогтолцоо бүхий улс төрийн дэглэм нь нэг үзэлт дэглэмийн энэ хувилбарт байдаг бүх онцлог шинжүүд бодит зүйл болгосон байв. 1990 оноос өмнөх төрийн эрх барих нэгдмэл тогтолцоо нь тухайн үедээ Монгол Улсын хөгжлийн төвшин, нийгэм-эдийн засаг, газар зүй, хүн амын онцлогт тохирч байсан боловч төрийн эрх барих дээд байгууллагыг хуульд заасан эрхийг нь бүрэн эдлүүлж,

¹⁰⁹ Монголын ардчиллын төлөвшил” ФСЭХ., УБ. 2011 он, 28 дахь тал

¹¹⁰ БНМАУ-ын Үндсэн хууль. УБ., 1960, 8-р бүлэг, 89-р зүйл

¹¹¹ БНМАУ-ын Үндсэн хууль. УБ., 1960, 2-р бүлэг, 14-р зүйл

үйл ажиллагааг нь жинхэнэ ёсоор нь явуулах боломжгүй байлгасан юм. Захиран тушаах хүнд сурталт дэглэмийн уршгаар төрийн эрх барих байгууллагын ардчилсан чиглэл, ард түмнийг төлөөлөн ажилладаг шинжийг нь хязгаарлаж, дээрээс бодлого болгон тулгаж, захиргаадах аргаар ажилладаг хүнд суртлын механизм болгон хувиргаж байв. Төрийн эрх барих дээд байгууллага нь гүйцэтгэн захирах байгууллагын нөлөөнд автах явдал их байлаа. Үндсэн хуульд заагаагүй албан тушаал бий болгох, улс төрийн нэг намд төрийн дээд эрх мэдлийг төвлөрүүлэх замаар нам төр хоёрын зааг ялгааг алдагдуулах, иргэдийн хүсэл зорилгыг илэрхийлсэн хууль гаргахын оронд аппаратын эрх, ашиг сонирхлыг хамгаалсан акт гаргах, түүнийгээ заавал намын дээд удирдлагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр батлах явдал хэвшил болсон байсан билээ. Өөрөөр хэлбэл бодит эрх мэдэл засгийн газарт байж, засгийн газарт нь нам ноёрхож байв. Иймээс намын элитүүд засаглалын бүх эрхийг атгаж улс төрийн хөдөлгөгч хүч нь засгийн газар биш харин нэг намын улс төрийн товчоо, намын төв хороо байв. Хэлбэрийн төдий парламент нь үйл ажиллагаагаа явуулах цаг хугацаа, арга механизм, бүрэлдхүүний хувьд хууль тогтоох үндсэн гол үүргээ гүйцэтгэх бодит боломжгүй байлаа.

Сонгууль болдоггүй, сонгууль нь харин санал асуулгын хэлбэрээр явагдаж хоосон тунхагын шинжтэй засаглалын хуваарийг тогтоож, ард түмэн өөрсдөө мэдэж сонгох ёстой, тэдний бүрэн эрхт төлөөлөгчдийг дээрээс урьдчилан нэр зааж өрсөлдөөнгүйгээр сонгуулах, зөвхөн тэр намын удирдлагаас сонгогдсон хүмүүс л депутат байх ёстой болж, тэдэнд намын эрх ашгаас зөрчилдөөгүй хэмжээ хязгаарын дотор бүрэн эрх дархыг бий болгох зэрэг гажуудал гарч байв. Төрийн эрх барих дээд байгууллагын ажиллагаанд гарч байсан энэхүү зөрчил нь нийгэм, улс төрийн тогтолцоонд бий болсон гажуудал байсан юм.

М.Дюверже нэг намтай дэглэмүүд нь шилжилтийн үеийн хэлбэрээр дамжин олон намтай дэглэм болж хувирдаг гэж үзсэн ба энэ үзлийг баримтлан дэглэмийн шилжилт эрх баригч элитүүдэд хэрхэн нөлөөлсөн бэ гэдгийг гаргаж болох юм.

1980-аад оны дунд үеэс энэхүү хатуу нэг намын тогтолцоо нь **уян хатан нэг намын тогтолцоо** бүхий дэглэмд шилжиж ирсэн. Ингэснээр маш хатуу сахилга баттай, цул нэгдэлтэй, намын дотор ямар нэг хандлага огт байдаггүй, сөрөг хүчингүй, нийгмийн бүх гишүүд нэг л номлолыг ягштал дагадаг хатуу нэг намын тогтолцоо бүхий дэглэмд өөрчлөлт орж эхэлжээ. М.Дюверже уян хатан нэг намын тогтолцоо нь онолын хувьд л боломжтой гэж үзэж байсан бөгөөд үүнийг амьдрал дээр бараг боломжгүй, учир нь нэг нам ноёрхож байгаа үед нам нь эв нэгдэлтэй. Гадаад эв нэгдэл нь дотоод эв нэгдлийн илэрхийлэл болж байдаг гэж үзсэн. Гэхдээ М.Дюверже уян хатан нэг намтай дэглэмийг Кемалистийн үеийн Туркийн “Ард түмний БНН”, Лениний үеийн ЗХУКН-ын үед байсан гэж үзсэн байдаг. Харин манай орны хувьд уян хатан нэг намын тогтолцоо бүхий дэглэм 1980-аад оны үеэс бий болсныг харуулах онцлог шинжүүд ажиглагдаж эхэлсэн байдаг.

“ЗХУ-д эхэлсэн өөрчлөн байгуулалт манайд нөлөөлсөн тэр үеэс эхлээд ямар нэг байдлаар түүнийг туршиж үзэх хүсэл залуучуудад төрсөн. Шинэ сэтгэлгээ, ил тод байдал, олон ургальч үзэл гэх мэт шинэ ойлголтууд хэр бөх бат болохыг шалгаж, урьд нь хаалттай байсан хаалганы цаагуур өнгийж, хаа хүртэл хөтлөхыг нь үзэх оролдлого олон

гарч байлаа. УБДС дээр Дарь.Сүхбаатарын гаргаж байсан “Цагийн толь” сонин, МҮЭСТО-ы дэргэдэх улс төр сонирхогчдын клуб, “Шинэ үе” нэрээр Э.Бат-Үүл нарын наасан ухуулах хуудас, Ховдын багшийн дээд сургуулийн багш, оюутнуудын хийсэн цуглаан зэрэг нь үүний жишээ юм. Залуучууд “өөрчлөн байгуулалт”-ын нээлттэй хаалгаар сад тавьж ороогүй, хамгийн зоригтойнууд нь тэргүүлэн ихээхэн болгоомжтойгоор, тэмтэрч, гэтэж орж эхэлсэн... Тухайн үеийн эрх баригчид ч өөрсдийн нээсэн хаалгаар чухам хэнийг оруулах вэ, хаа хүртэл явуулаад, үзүүлээд буцаах вэ гэдэг зөвшөөрлийг өгч, хяналттайгаар нэвтрүүлэх хүсэлтэй байсан нь мэдээж, энэ нь ч харагддаг байлаа. Жишээ нь мөнөөх алдарт “Шинэ үе”-ийнхнийг зөвшөөрсөн заагаас илүү гарахыг оролдлоо гэж НАХЯ-нд дуудаж, нөхөрсгөөр зэмлэж, даврахгүй байхыг сануулан ам өчгийг нь аваад явуулсан зүйл байх”¹¹²

гэж 1990 оны ардчилсан хөдөлгөөнд анхнаас нь оролцож явсан Чимидийн Энхээ “Ардчилсан хөдөлгөөн. Хөшигний арын нууц” хэмээх дурсамжиндаа тэмдэглэсэн байна. Мөн БНМАУ-ын батлан хамгаалах зөвлөлийн нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөлийн референт, МАХН-ын төв шалган байцаах комиссын гишүүнээр ажиллаж байсан Ж.Хүрэлжанцан “Ардчиллын халуун өдрүүд” хэмээх дурдатгал бүтээлдээ:

“Манай орны нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт ажиллагсадын шилдэг тэргүүний хэсэг нь МАХН-ын эгнээнд байсан нь хэзээний уламжлал байлаа. Тэр хүмүүсийн дуу хоолой өөрчлөлт шинэчлэлийг дэмжин цуурайтаж байсан юм.

Чухам яаж өөрчлөлт хийх вэ гэдэгт МАХН-ын удирдлага шийдвэртэй хариулт өгч чадаагүй, алгуурлаж байхад “перестройка”-гийн нөлөөнд манай орны тэргүүний сэхээтэн залуусын үзэл бодолд тэсрэлт болж 1987-1988 оны зурвас үед төвийн тогтмол хэвлэл “Үнэн”, “Улаан Од” болон бусад сонин хэвлэлүүдэд, улс ардын аж ахуйн бүх салбаруудын доголдол дутагдлыг илчилсэн хүчтэй нийтлэлүүд шил шилээ харан дугаар алгасахгүй хөвөрсөөр байлаа”¹¹³

гэж бичжээ. Нэг намын тогтолцоо бүхий дэглэм хэвээр байсан боловч хязгаарлагдам хүрээнд ч гэсэн олон ургалч үзэл нилээд өргөн дэлгэр болж байсныг харуулах энэ мэт олон баримтыг олж болно. Харин энэ үеийг ардчилсан дэглэм рүү оруулж тооцож болохгүй учир шалтгаан нь 1990 он хүртэл хэн нь ч улс төрийн тогтолцоог бүхэлд нь өөрчилье, удирдагч ганц нам болох МАХН-ыг үгүйсгэе гээгүй, харин социализмыг улам боловсронгуй болгоё, МАХН-ын бодлогыг улам боловсронгуй болгоё гэсэн чиглэлээр л асуудлыг тавьж байсан билээ. Энэ үеийн улс төрийн элитүүд нь олон ургальч үзлийг тодорхой хязгаарын дотор хүлээн зөвшөөрч, өөрсдийн эрх мэдлийг хэрэгжүүлэх боломжтой хэвээр байсан үе юм.

¹¹² Чимидийн Энхээ. Ардчилсан хөдөлгөөн. Хөшигний арын нууц. Улаанбаатар. 2010. 22 дахь тал

¹¹³ Ж.Хүрэлжанцан. Ардчиллын халуун өдрүүд. Дурдатгал. Улаанбаатар, 2004, 21 дэх тал

Харин үйл явдлын өрнөл, олон улсын улс төрийн нөхцөл байдал нь социализмыг боловсронгуй болгож байдлыг сайжруулья гэдэг үзэл баримтлалыг удаан хугацаанд хэвээр нь баримтлах боломжгүй болгосон ба ялангуяа зүүн европын орнуудад эрчимтэй өрнөсөн улс төрийн тэмцлүүд нь манай орны хувьд ч улс төрийн системийг бүхэлд нь өөрчлөх чиглэл рүү хөтлөсөн билээ. 1990 оноос өмнөх гажуудлыг засахын тулд өөрчлөлт шинэчлэлтийн эхлэл болгож, төрийн эрх барих байгууллагын тогтолцоог шинээр бүрдүүлэх үзэл баримтлалыг боловсруулж түүнийгээ хэрэгжүүлэх эхлэл бий болсон. Төрийн эрх барих байгууллагыг шинэчлэхдээ нам, төрийн үүргийг зааглах, улс төрийн тогтолцооны гол цөм нь төр байх, түүнийг чиг үүргийг бүх талаар өндөржүүлж, эрх хэмжээг нь өргөтгөх, хуулийг үүргийг хүчтэй болгох, парламентын нэгдмэл тогтолцоог бүрдүүлэн төлөвшүүлэх, ардчиллыг хөгжүүлэх чиглэлийг баримталсан байна.

1990 оны ардчилсан хувьсгал өрнөснөөр дэглэмийн шилжилт хэвээр хадгалагдаж **шилжилтийн үеийн уян хатан нэг намын тогтолцоо** бүхий дэглэмээс шилжилтийн үеийн өөр нэг шат болох **ноёрхогч нэг нам бүхий дэглэмд** шилжсэн юм. М.Дюверже ноёрхогч нэг нам бүхий дэглэмийн онцлог шинжийг

- Харахад олон ургальч юм шиг харагддаг
- Гэхдээ хэд хэдэн намууд оршин тогтож байдаг
- Гэхдээ нэг нам нь бусад намуудтай харьцуулашгүй том
- Нэг нам засгийн эрхийг барьж парламентад дийлэнхи олонхи нь болж байдаг
- Иймээс нэг намын гарт эрх мэдэл төвлөрч байдаг
- Нэг үзэлт дэглэмд байгаатай адил эрх баригч нам нь ялагдал гэдгийг мэддэггүй
- Гэхдээ сөрөг хүчин нь сонгуульд оролцоно
- Сөрөг хүчин нь парламентад бага хэмжээний суудалтай ч байж болно
- Сөрөг хүчин нь зарим нэг нийтийн эрх чөлөө эдэлнэ.
- Буурай хөгжилтэй орнуудад энэ онцлог бүхий дэглэм их ажиглагдана.
- Хандлага нь нэг намын тогтолцоо руу явж байдаг

гэж тоочсон байна.

Эдгээр онцлог байдлууд манай улсад хэрхэн ажиглагдаж байсан бэ, эрх баригч элитүүд болон сөрөг хүчний үйл байдал хэрхэн өөрчлөгдсөн бэ?

1990-8-26-нд болсон АИХ-ын сонгуулийн үйл явц, сонгуулийн үр дүн нь ноёрхогч нэг намтай дэглэм байсныг тодорхой харуулдаг. 1990-5 сард батлагдсан “Улс төрийн намуудын тухай хууль”-ийн дагуу Монголын Үндэсний Дэвшлийн нам, Чөлөөт хөдөлмөрийн нам, Монголын Ардчилсан Нам, Монголын Социал Демократ Нам, Монголын Ногоонтны Намууд улсын Дээд Шүүхэд албан ёсоор бүртгүүлсэн. Энэ нь олон намын тогтолцоотой ардчилсан дэглэмийн шинжийг өнгөц харахад сайтар бүрдүүлж байсан.

Харин МАХН 1960 онд Үндсэн Хуулиар баталгаажуулсан удирдан чиглүүлэх үүргээсээ татгалзаж, хуучинсаг үзэл, хүнд суртал, захиргаадалтын эдийн засгаасаа салж байгаагаа илэрхийлж байсан боловч монголын хэвлэл мэдээллийн салбарт монополь эрхтэй байсан давуу байдлаа сайн ашиглаж байв. Мөн шинэ улс төрийн элитүүд ч “Ардын эрх” зэрэг анхны хэвлэлүүдээр

дамжуулан үгээ хэлэх боломж олгож байсан нь МАХН үнэхээр ардчилсан болж өөрчлөгдсөн гэсэн сэтгэгдлийг олон түмэнд хүргэхэд ихээхэн үүрэг гүйцэтгэжээ. 1990-7-22-нд болсон орон нутгийн сонгуульд МАХН 53,4%, АИХ-ын сонгуульд 84,4%-ийн саналыг авч ялалт байгуулж байсан юм. Өөрөөр хэлбэл АИХ-ын 422 суудлаас 357 нь МАХН-д очжээ.

Хүснэгт №1

Намууд	МАХН	МҮДН	МЧХН	МАН	МСДН	МНН
Авсан санал хувь	61,74%	5,95%	1,22%	24,33%	5,52%	1,24%
Авсан суудал	357	5	-	16	4	-

Дээрхи улс төрийн үйл явдлууд, сонгуулийн үр дүн, баримтууд нь Монгол оронд үнэхээр олон ургальч харилцаа нэгэнт тогтсон мэт харагдаж, улс төрийн олон намууд оршин тогтож, үйл ажиллагаагаа явуулах боломжтой болсон мэт харагдуулж байна. Гэхдээ бодит байдлыг анхааралтай нягтлан үзвэл МАХН бусад намуудтай харьцуулашгүй том, мөн парламентад үнэмлэхүй ялагч болж байгаа бөгөөд энэ намын элитүүдэд засаглалын эрх мэдэл төвлөрчээ. Энэ үеийн эрх баригч элитүүд нь нэг үзэлт дэглэмд байснаасаа нэг их ялгарах юмгүйгээр засгийн эрхийг барьж ялагдах гэдгийг мэдэхгүй олон жилийг ардаа орхисон билээ. Нэг үзэлт дэглэмээс ялгагдах онцлог нь сөрөг хүчин нь сонгуульд оролцсон, бас парламентад бага ч гэсэн суудлыг авч чадсан билээ. Сөрөг хүчин нь нийтийн эрх чөлөөг эдлэж үгээ чөлөөтэй хэлэх, үзэл бодлоо илэрхийлэх зэрэг эрх эдэлж байсан.

М.Дюверже ийм нөхцөл байдал нь нэг намын тогтолцоо руу явж байдаг гэж үзэж байсан юм. Харин манай улсын хувьд урт удаан хугацааны туршид нэг намын дарангуйлал дор байсан, түүнээсээ нөр их хичээл зүтгэл, ард олны дэмжлэгээр салж гарсан, олон улсын нөхцөл байдал ч ардчиллын зам руу нэгэнт хандсан байсан зэрэг нь эргээд нэг намын тогтолцоо руу орох боломжгүй болгосон юм.

Ийнхүү 1980-аад оны дунд үеээс өөрчлөн байгуулалттай хамт бий болсон шилжилтийн үеийн уян хатан нэг намын тогтолцоо нь 1990 оны ардчилсан хувьсгалын өрнөлттэй зэрэгцэн шилжилтийн үеийн өөр нэг үе шат болох ноёрхогч нэг нам бүхий дэглэмд шилжсэн байна.

Хэдийгээр ноёрхогч нэг нам бүхий дэглэмтэй болсон боловч улс төрийн тогтолцоонд томоохон өөрчлөлтүүд гарч эрх мэдлийг хуваарилах тал дээр дэвшил гарсаар байв. Тухайлбал, БНМАУ-ын Ардын их хурлаас гадна байнгын ажиллагаатай анхны парламент болох БНМАУ-ын Бага хурал болоод төрийн тэргүүн-Ерөнхийлөгчийн институтийг бий болгож, тэдгээрийн хооронд эрх мэдлийг харилцан хамааралтай, тэнцвэртэй хуваарилах чиглэлд томоохон алхам хийгджээ. 1990 оны V сард болсон АИХ-ын Чуулганаар, бүх нийтийн ардчилсан сонгууль явуулах, төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд

байгууллага нь Ардын их хурал, хууль тогтоох дээд байгууллага нь Улсын бага хурал, төрийн тэргүүн-Ерөнхийлөгч, гүйцэтгэх засаглалын дээд байгууллага-засгийн газрыг эмхлэн байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлэв¹¹⁴. Улсын Бага хурлын дарга нь БНМАУ-ын Дэд ерөнхийлөгч нэгэн зэрэг байхаар тогтоосон бөгөөд Улсын Ерөнхийлөгч нь төрийн дээд эрх барих ёсыг хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй үндсэн хуулийн нэг институт болж гарчээ.

Гэхдээ ардчилсан хувьсгал ялснаас хойшхи хорь гаруй жилийн хугацаанд байсан монголын улс төрийн тогтолцоог хоёр намын тогтолцоотой гэж нэрлэхээсээ илүүтэйгээр ноёрхогч нэг намтай тогтолцоо байсан гэж үзэх гээд байгаагийн учир шалтгааныг дараахь нөхцөл байдалтай холбон тайлбарлаж болмоор байна.

- Юуны өмнө монгол улсын төрийн тогтолцоог бүрдүүлж байгаа механизм нь бүрэн тогтсон шинжгүй, янз бүрийн хувилбаруудыг туршиж үзсэн шинжтэй байна.

- Эрх барьж, олонхийг бүрдүүлж байсан элитүүд нь үндсэндээ нэг намаас гарч ирж тасралтгүй олон жил халаагүй ноёрхож байсан учраас өөрсдийн байр суурийг бэхжүүлсэн олон хууль ёсны болон хууль бус үйлдлүүдийг хийж гаршсан.

- Сөрөг хүчний санаа бодол нь төрийн тогтолцоог боловсронгуй болгоход төдийлөн үүрэг гүйцэтгэж чадаагүй. Иймээс тогтсон нэг дэглэмийн шинжийг олж удаан хугацаагаар, цаг хугацааны шалгуурыг давж хэлбэршин тогтох үйл явц нь одоо ч үргэлжилсээр байгаа

- Дэглэмийн шинжид томоохон нөлөө үзүүлж байдаг Үндсэн хууль, сонгуулийн хуулиуд нь шүүмжлэлд нилээд өртөж, өөрчлөгдөх магадлал тодорхой хэмжээнд байгаа. Энэ бүхэн нь хоёр нам ээлжлэн засгийн эрхийг барьсан гэхээсээ урьдаар нэг нам түлхүү ноёрхсон нөхцөлтэй байсан гэж үзэж Их Британийн төрийн тогтолцоотой яг адил гэхээсээ түүнтэй ихээхэн төстэй боловч шилжилтийн үедээ яваа ноёрхогч нэг намтай дэглэм байна гэж үзэж болмоор байгаа юм.

2006 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 28-р зүйлийн 1-д “нам эвсэл нь олон мандаттай тойрогт тухайн тойрогт ноогдох мандатын тооноос илүүгүй хүний нэрийг дэвшүүлнэ” гэж заасан нь “ялагч бүхнийг авдаг” өмнөх тогтолцоог өөрчилж чадаагүй бөгөөд МАХН дангаараа ноёрхогч байх нөхцөл байдалд төдийлөн өөрчлөлт оруулж чадаагүй юм.

Харин ноёрхогч нэг намтай дэглэмээс М.Дювержегийн тодорхойлсон олон ургальч дэглэм рүү шилжихэд нилээд удаан хугацаа шаардагджээ. 2012 оны сонгуулиар 1996-2000 оны хооронд Ардчилсан хүчнийхэн ялалт байгуулснаас бусад бүх үед ноёрхогч нам байсан МАН ялагдал хүлээсэн нь шилжилтийн үеийн дэглэмийн нөхцөл байдлыг нилээд өөрчлөх боломж олгож байна. Энэ нь юуны өмнө сонгуулийн хуулийн өөрчлөлтөөс үүдэлтэй. Тухайлбал, 2011 оны 12 сарын 15-нд батлагдсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 4.9. "... нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр

¹¹⁴ Х.Гүндсамбуу “Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага”, УБ. 2002 он. 392 дахь тал

дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан сонгуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг улс төрийн нам буюу улс төрийн намуудын сонгуулийн эвсэл /цаашид “нам, эвсэл” гэх/-ийн жагсаалтаас тус тус сонгоно¹¹⁵ гэсэн заалт оруулсан нь эрх баригч элитүүдийн бүтэцэд томоохон өөрчлөлт ороход нөлөөлсөн.

М.Дюверже Их Британийн улс төрийн тогтолцоог хоёр намын тогтолцоотой парламентын дэглэм гэж нэрлэсэн байдаг бөгөөд энэ нь манай улсын төрийн тогтолцоотой ихээхэн төстэй юм. 1990 оноос хойш бараг тасралтгүй үргэлжилж байсан эрх баригч намын элитүүд нь цул нэгдэлтэй улс төрийн чухал асуудлууд дээр парламентын гишүүд нь нэг ижил санал өгдөг, гүйцэтгэх засаглалын элитүүд нь унах айдасгүй, олонхийн намын лидер нь хичнээн сул хүн байсан ч итгэл төгс байдаг, намын олонхи элитүүдээсээ өөр санаа бодолтой нэгнийгээ гадуурхаж, дэмжлэг байхгүй болгодог зэрэг шинжүүд нь “хоёр намын хатуу тогтолцоо бүхий дэглэм” гэж М.Дювержегийн нэрлэж байсан тэр дэглэмийн шинжүүдтэй яв цав нийлж байсан билээ. Хэдийгээр Их Британий улс төрийн тогтолцоо нь Монгол Улсын төрийн тогтолцоотой олон талаар адил боловч бид энэ дэглэмийг ноёрхогч нэг намын тогтолцоо бүхий дэглэм гээд байгаагийн учир нь МАХН удаан хугацаанд дангаараа улс төрийн бодлогын гол тоглогч хэвээрээ байсанд оршино. МАХН хэдийгээр 1996-2000 оны хооронд ялагдал хүлээсэн боловч тухайн үеийн Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтууд нь энэ намыг эрх баригч хүчнээс нэг их дутахааргүй үйл ажиллагаа явуулах боломж олгож байсан нь МАХН-ын ноёрхлыг хэвээр хадгалахад хүргэж 1990-1996 оны хооронд тогтсон парламентын хүчний харьцаа нь байдлыг төдийлөн өөрчилж чадаагүй юм. Өөрөөр хэлбэл М.Дюверже олон ургальч дэглэмийг олон намтай, хоёр намтай гэж хувааж үзсэн ангиллаар өмнөх сонгуулийн ялагч бүхнийг авах боломжтой хувилбар нь МАН ба бусад намууд гэсэн хувилбар руу илүү түлхэж МАН-ын элитүүд нь улам нягт нэгдэлтэй, өөрийгөө хянаж цэвэршүүлэх тал дээр хангалтгүй, талсжсан, гаднаас шинэ хүчнээр өөрийгөө сэлбэдэггүй хэсэг болон хувирахад хүргэжээ.

Харин 2012 оны УИХ-ын сонгуулийн тухай хуулинд улс төрийн намуудын авсан саналын тоонд хувь тэнцүүлэн суудал хуваарилах хувилбарыг оруулж өгсөн болон улс төрийн намуудын зүгээс сонгуулийн явцад хяналт тавих тал дээр илүү анхаарсан нь олон намын тогтолцоо бүхий дэглэм болж төлөвших анхны томоохон үйл явдал болсон юм. Нэг нам улс төрийн шийдвэрт голлох үүргийг гүйцэтгэж гүйцэтгэх засаглалын элитүүд нь хууль тогтоох засаглалын элитүүдтэй нягт харилцаа холбоотой бие биенээ хамгаалж хаацархай байдалтай байсан өмнөх байдал нь улс төрийн хүчний харьцааг зөв тооцоолох, гуравдахь ч хүчний санаа бодлыг харгалзан үзэх байдал руу эрх баригч элитүүдийг шахаж байна. Сонгуулийн хуулинд өөрчлөлт оруулсан өнөөгийн байдал нь хоёр нам голлох гэхээсээ голлох хоёр намын аль нэг нь, улс төрийн гуравдахь ч хүчинтэй тохиролцсоноор нөгөө улс төрийн намыг шахах бодлого ихээхэн ажиглагдаж олон намтай олон ургальч дэглэмийн шинж төлөвийг түлхүү харуулж байна.

¹¹⁵ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. Шинэчилсэн найруулга. 2011-12-15, Улаанбаатар хот

Олон нам бүхий олон ургалч хэлбэржин тогтож байгаа нь өмнөх ноёлогч нэг намтай улс төрийн тогтолцооны үеийн эрх баригчдаас нилээд өөр элитүүд гарч ирэхэд нөлөөлж байна. Юуны өмнө эрх баригч элитүүд хэзээ ч унахгүй дархлагдсан байдал үндсэндээ алга болж бусад улс төрийн намын элитүүдээс тодорхой хэмжээнд хараат болж ирж байна. Шинэчлэлийн засгийн газарт орж хамтран ажиллаж байгаа улс төрийн намууд хэдийгээр засгийн газрыг унагаах аюулд хүргэж чадахгүй боловч хууль тогтоох байгууллагаар дамжуулан олонхи болж засгийн эрх мэдэлд давуу байдлыг олж авсан элитүүдэд хяналт тавих боломж олж авсан юм. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль 39 дүгээр зүйлд сонгуулийн хандивын талаар “Нам, эвсэл, нэр дэвшигчид өгөх хандивын дээд хэмжээ хувь хүнээс нэг сая төгрөг хүртэл, хуулийн этгээдээс гурван сая төгрөг хүртэл байж болно”¹¹⁶ гэж хязгаарлаж өгсөн боловч энэ нь улс төрийн эрх баригч элитүүд эдийн засгийн нөлөө бүхий хүмүүс, компаниас хараат байх явдлыг таслан зогсоож чадахгүй байгаа юм.

Дэглэмийн өөрчлөлт нь удирдагчид олон түмэнд аз жаргалыг өгч байгаа гэж итгэж тэдний засаглалыг хүлээн зөвшөөрөх байдалд ч өөрчлөлт оруулж байна. Ф.Фукуяма ардчиллын гол агуулга бол ард түмэн өөрөө засаглах эрхийг бодитой хянах бүх талын бололцоог хангах явдал бөгөөд ардчиллын үзэл санааг хүлээн авч тунхагласнаар ардчилал бий болдоггүй. Тэрээр ардчилсан үйл явц бодитой хэрэгжихдээ:

- Ардчиллын үзэл санааг хүлээн авч дэлгэрүүлэх
- Улс төрийн шинэ ардчилсан бүтцийг бий болгох
- Ардчиллыг хөгжүүлэх эдийн засгийн таатай нөхцөл бүрдүүлэх
- Иргэдийн оролцоо, иргэний нийгмийн зохистой төлөвшлийг хангах
- Иргэдийн улс төрийн боловсрол, соёлыг төлөвшүүлэх зэрэг цогц үйл ажиллагааг шаарддаг.¹¹⁷

Ард түмний эрх ашгийг бусдаас дээгүүр авч үзнэ хэмээн иргэдийн саналыг авсан төрийн түшээд ард түмний ашиг тусаас илүү намын эрх ашигаа илүүд үзэж байвал юуны ёс суртахуунтай байх билээ¹¹⁸. Ардчилал, ардчилсан засаглалын тухай асуудлыг хүн төрөлхтний мөнхийн сэдэв гэж үзэж болох бөгөөд эртний грекийн их сэтгэгч Платон, Аристотель нараас эхлээд үе үеийн томоохон сэтгэгчид энэ асуудлыг янз бүрээр хөндөн судалж ирсэн бөгөөд сүүлийн жилүүдэд ардчилал, ардчилсан засаглалын тухай сэдвийг мэргэжлийн эрдэмтэн судлаачид төдийгүй дагнан судалдаг олон улсын төрөлжсөн байгууллагууд бий болсон. Жишээлбэл: Шведийн Ардчилал болон сонгуульд туслах олон улсын хүрээлэн, АНУ-ын Олон улсын хөгжлийн байгууллага, НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн банк, Мянганы хөгжлийн 9 дэх зорилгыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх төслийн Засаглалын судалгааны баг зэрэг олон байгууллагууд тодорхой зорилго, чиглэлээр олон төрлийн бие даасан илтгэл, тайлангуудыг нийтийн хүртээл болгосон.

Улс төрийн боловсролын академиас явуулдаг “Зүүн Азийн барометр”-ын ардчиллын талаарх судалгааны дүнгээс

¹¹⁶ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. 2011, 39 дүгээр зүйл

¹¹⁷ “Монголын ардчиллын төлөвшил” ФСЭХ., УБ. 2011 он, 27 дахь тал

¹¹⁸ Мөн тэнд 42 дахь талд

Манай оронд ардчилал хэр хөгжиж байна вэ?
2005, 2008, 2010

Хариулт	Хувь		
	2005 он	2008 он	2010 он
Маш сайн	4,4	2,9	2,6
Сайн	28,4	21,7	23,2
Дунд зэрэг	52,9	54,7	54,3
Муу	10,9	13,2	11,2
Маш муу	3,4	2,5	4,2
Үнэлж мэдэхгүй	0,0	5,0	4,6
Нийт	100,0	100,0	100,0

2004 оны сонгуулийн өмнө хийсэн судалгаагаар сонгогчдын 60% нь ямар нэг намыг хатуу дэмжигчид, 30 орчим хувь нь хаашаа ч хөлбөрч болох “хөвдөг” сонгогчид, 10% нь сонгуульд огт оролцдоггүй “идэвхигүй” иргэд байсан бол 2008 онд Сант Марал судалгааны төвөөс намуудад итгэж буй эсэх асуудлаар иргэдийн дунд судалгаа хийсэн байна. Судалгаагаар судалгаанд хамрагдагсадын 16,6% нь намуудад итгэдэг, 40,2% нь итгэдэггүй, 43,2% итгэж буй эсэхээ мэдэхгүй гэж хариулжээ. Мөн монгол дахь улс төрийн намуудын санхүүжилтын өнөөгийн нөхцөл байдал нь төр ард иргэдэд үйлчлэх үүргээ умартахад хүргэж, улс төр, эдийн засгийн явцуу бүлэглэлийн эрх ашгийг төлөөлөхөд хүргэж байна. Сонгуульд ялсан намын бодлого тухайн намыг сонгуульд нэр дэвшихэд хөрөнгө мөнгөөр дэмжиж байсан хандивлагчдад ямар нэгэн байдлаар ашигтай байдаг эл үзэгдэл зөвхөн манай оронд ч бус бусад олон оронд түгээмэл ажиглагддаг болжээ.

Эдийн засгийн байдал үе үе доройтох, төр засгийн мөнгө санхүүгийн бодлого нь хүнд сорилтуудыг давж чадахгүй байна гэсэн бодол иргэдэд бий болох, ядуурал, ажилгүйдлыг бууруулж чадахгүй, төрийн үйлчилгээг түвэг чирэгдэл ихтэй байлгадаг зэрэг нь эрх баригчдад итгэх итгэлийг бууруулж байна. Ялангуяа иргэд эдийн засгийг сөргөөр үнэлж эдийн засгийн хүнд сорилтуудыг давах төр засгийн чадварт сөрөг бодолтой байх, глобалчлалтай холбоотой өрсөлдөөний шахалт дарамт болон эдийн засгийн тэгш бус байдал нэмэгдэх болсон, эдгээр асуудлыг шийдэх арга хэмжээнүүдийг авч ажиллах төр засгийн эрмэлзлэл, чадварт итгэл алдрах явдал нь эрх баригч элитүүдийн засаглалд итгэх байдалд өөрчлөлт оруулж байна.

Улс төрийн дэглэмээс хамаарч эрх баригч элитүүдийн нэр хүндийн асуудал өөр өөр дүр төрхтэй байна. Улс төрийн дарангуйлал нь заримдаа засаглалыг хэвийн ёсоор дэмждэг олон түмний итгэл суларсны дүнд үүсдэг

засаглалын өвчин юм¹¹⁹. Улс төрийн дэглэмийн хөгжлийн энэ хувьсал өөрчлөлт нь ард түмний аж байдлыг бодитойгоор дээшлүүлсэн эдийн засгийн зөв бодлоготой уялдаатай зөв хосолж байж ард түмний итгэлийг хүлээсэн тэр хэв шинжээрээ бүрэлдэн тогтох билээ.

Abstract

There are different pictures of governing elites' reputation due to political regime. Political dictatorship is an authority illness (authority syndrome) that occurs where normal public trust and support for authority is loosened. This type of political regime evolution can be abolished when public support is gained for the state where public living is increased in accordance to proper economic policy.

Ном зүй

1. Х.Гүндсамбуу “Монголын нийгмийн давхраажил: хөгжил хандлага”, УБ., 2002
2. М.Дюверже “Улс төрийн байгууламж: Үндсэн хуулийн эрх зүй” УБ., 2007
3. Ж.Хүрэлжанцан “Ардчиллын халуун өдрүүд” /Дурдатгал/ УБ., 2004
4. Ч.Энхээ “Ардчилсан хөдөлгөөн. Хөшигний арын нууц” УБ., 2010
5. ФСЭХ “Монголын ардчиллын төлөвшил” УБ., 2011 он
6. БНМАУ-ын Үндсэн хууль. УБ., 1960
7. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ УБ., 2011-12-15
8. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль. 2011

¹¹⁹ Морис Дюверже. Улс төрийн байгууламж. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007, 35-р тал

МОНГОЛ ДАХЬ АРДЧИЛЛЫН БЭХЖИЛТ, ХӨГЖЛИЙН ХАНДЛАГА**Ц.Ганболд***МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, профессор***Б.Батдэлгэр***МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн магистрант*

Түлхүүр үг: ардчиллын бэхжилт, эрхзүйт төр, оролцоо, өрсөлдөөн, ардчиллын чанар, нийгэм-эдийн засгийн нөхцөл, ардчиллын гуравдахь давалгаа, Зүүн Азийн Барометр, улс төрийн боловсрол

Товч хураангуй: Монгол дахь ардчиллын бэхжилт хийгээд чанарын асуудлыг ардчиллын онолчидын үзэл баримтлал дээр тулгуурлан ардчиллын хүрсэн төвшин болон цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлохыг зорилго.

Дэлхийн хэмжээний ардчиллын шинэ давалгаа 1974 оноос эхэлсэн гэж үздэг. Уг давалгааны хүчээ авах шалтгаан нь эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө хөдөлгөөн тоталитаризмыг дэглэмийнх нь хувьд эсэргүүцэх сэтгэл зүй олон улсын хэмжээнд тархаж, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдал, арьсны өнгө, хүйсээр ялгаварлан гадуурхахыг эсэргүүцсэн нийгмийн шинэ хөдөлгөөн, шинэ үзэл санаа гарсантай холбож тайлбарлаж болох юм.

Ардчилал ийнхүү олон улсын хэмжээний хөгжлийг тодорхойлогч хүчин зүйл болох тусам ардчиллын чанар, хэлбэр, загвар, хөгжлийн түвшний ялгаа зэрэг асуудлыг судлах ажил эрчимжсээр байна. Ардчилсан шилжилт хийгээд багагүй хугацааг ардаа орхисон манай улсын хувьд ардчилал ямар шатандаа, ардчиллын бэхжилт хэрхэн явагдаж байгааг судлах нь ач холбогдолтой юм. Монгол дахь ардчиллах үйл явцын нэг чухал үр дүн нь Монгол улсын Үндсэн хууль мөн бөгөөд тэрээр өмнөх авторитар дэглэмийн институцийн бүтэц, процедур, хэм хэмжээг үндсээр нь өөрчлөх суурь нөхцлийг бүрдүүлсэн билээ. 1992 оны шинэ үндсэн хуулинд “хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм” цогцлоон хөгжүүлэхийг зааж өгснөөр ардчилсан улс болохоо тунхагласан төдийгүй Монголын ардчиллын ирээдүйд томоохон хувь нэмэр оруулсан.

Олон намын, өрсөлдөөнт, чөлөөт сонгуулийг ардчиллыг хэмжих эцсийн хэмжүүр гэж үздэггүй ч өдгөө ардчиллыг хэмжих нийтлэг хэмжүүр болоод байна. Монгол улсын хувьд бүрэн либерал ардчилсан улс уу, эсвэл гарааны /минималист/ ардчилсан улс уу гэдгийг тодруулах нь зүйтэй. 1990 оны ардчилсан шилжилт нь Монгол улсын ардчиллын хөгжилд томоохон амжилт болсон бөгөөд ардчиллын талаар эргэцүүлэн бодож, үнэлэх өнөөгийн түвшин, ардчилсан тогтолцоо, ардчилсан үйл явцад өгөх иргэдийн үнэлгээ нь ардчиллын цаашдын ирээдүйг тодорхойлох юм.

Олон улсад ардчиллын судалгаа, мониторинг хийдэг бие даасан байгууллага болох “Freedom House¹²⁰”-ийн 2012 оны судалгаагаар нийт 197 улс хамрагдсан байдаг. Уг судалгаанд улс орнуудыг улс төрийн эрх болон иргэний эрх гэсэн 2 үндсэн категорийг ашиглан эрх чөлөөт, хагас эрх чөлөөт, эрх чөлөөгүй гэсэн ангилалд /хүснэгт-1/ ялгасан байна.

Хүснэгт-1. *Freedom in the World*, Freedom House’s flagship publication /2012/

	Улс орнуудын тоо	Эзлэх хувь
Эрх чөлөөт	66	33,5
Хагас эрх чөлөөт	72	36,5
Эрх чөлөөгүй	59	30
Нийт	197	100

Уг судалгаагаар манай улсыг хагас эрх чөлөөт гэсэн ангилалд багтаан оруулсан нь монголд ардчилал сайтар нутагшаагүй, алдаа зөрүү байгааг илэрхийлж байгаа гэж дүгнээд ардчиллын цаашдын хөгжилд саад учруулж байгаа хүчин зүйлсийг илрүүлж, засах нь зүйтэй гэж үзэж байна. Гэхдээ Монгол улс сүүлийн наая орчим жил коммунист үзэл суртлаар явж ирсэн боловч эрх чөлөө, чөлөөт байдлын үнэлэмж хамгийн өндөр үнэлгээтэй байгаа нь Монголчуудын онцлог гэж хэлж болох юм. Иймд энэ давуу талаа ашиглан ардчиллын үзэл санааг илүү чанарын төвшинд хүргэх боломж байна.

Р.Далийн санал болгодог “Полиарх” ардчиллын загвар нь ардчиллыг үнэлэхэд ач холбогдол өндөртэй байдаг. Тэрээр ардчиллыг үнэлэхдээ иргэдийн улс төрийн оролцоо болон улс төрийн намуудын өрсөлдөөн гэсэн үндсэн шалгуурыг гаргаж ирсэн.

Үүнээс гадна ардчиллын чанарын талаар Ларри Даймондын үзэл санаа, хэмжүүрийг энд зайлшгүй дурдах нь зүйтэй. Ларри Дайманд ардчиллын чанарын тухай асуудлыг хөндөхдөө юуны өмнө “ардчилал”, “чанар” гэсэн ойлголтуудын тодорхойлолтыг шинжилж үзсэн байдаг. Ардчилал нь хамгийн багадаа дараах дөрвөн элементийг шаардана.

1. Бүх нийтийн, насанд хүрэгчдийн сонгуульд оролцох эрх
2. Давтамжит, чөлөөт, өрсөлдөөн бүхий шударга сонгууль
3. Нэгээс илүү улс төрийн нам
4. Мэдээллийн олон тооны эх үүсвэр

Харин чанар нь эрх зүйт ёс, оролцоо, өрсөлдөөн, хөндлөн ба босоо хариуцлага гэсэн хэмжүүртэй. Мөн агуулгын хувьд чанар нь иргэний ба улс төрийн эрх чөлөөг хүндэтгэх байдал, улс төрийн илүү тэгш байдлын дэвшилт, хэрэгжилт гэсэн хоёр хэмжүүртэй. Харин үр дүнгийн хувьд чанар нь улс төрийн үйл явцаар

¹²⁰ Freedom house- 1941 онд АНУ-д үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бөгөөд дэлхийн ардчиллын хөгжилд хяналт тавьдаг бие даасан байгууллага юм. Freedom in the World нэртэй сэтгүүлээ 1972 оноос хойш хэвлүүлэх болсон бөгөөд уг байгууллагаас гаргадаг томоохон хэвлэл юм.

нэгтгэгддэг иргэдийн эрэлт, шаардлагад төрийн бодлого нь хэрхэн нийцэж буйг хэмжих хариуцлагатай байдал гэсэн ганц хэмжүүртэй. ¹²¹Манай улсын хувьд ч гэсэн эдгээр хэмжүүрээр үнэлэгдсэн судалгааг /хүснэгт-2/ “Зүүн Азийн Барометр” судалгаанаас харж болно.

Хүснэгт-2. Монголчуудын ардчиллын төсөөллийн хамаарал¹²²
(Азийн бусад улсуудтай харьцуулсан байдлаар)

Ардчиллын төсөөллийн хамаарал

	Сэтгэл ханамж		Дэмжлэг		Итгэл	
	Монгол	Ази	Монгол	Ази	Монгол	Ази
Эрх зүйт төр	0,136**	0,281**	-0,015	0,134**	-	-
					0,245**	0,189**
Авлига	0,138**	0,360**	-0,014	0,175**	-	-
					0,119**	0,126**
Өрсөлдөөн	0,074**	0,336**	-	0,186**	-	-
			0,109**		0,240**	0,251**
Сонгуулийн оролцоо	0,008	0,092**	0,034	0,109**	-0,009	-
						0,128**
Улс төрийн сонирхол	-0,003	0,085**	0,130**	0,235**	-0,004	-
						0,037**
Улс төрийн үр ашиг	0,157**	0,159**	0,570**	0,659**	0,022	-
						0,069**
Босоо хариуцлага	0,047	0,135**	-0,046	0,106**	-0,075*	-
						0,060**
Хөндлөн хариуцлага	0,099**	0,260**	-0,022	0,140**	-	-
					0,089**	0,045**
Эрх чөлөө	0,065*	0,140**	0,029	0,089**	-	-
					0,203**	0,217**
Тэгш байдал	0,099**	0,283**	-0,016	0,116**	-	-
					0,129**	0,251**
Хариуцан тайлагнал	0,165**	0,383**	0,004	0,200**	-	-
					0,153**	0,245**

** хамаарал нь 0,01 төвшинд зөвшөөрөгдөнө

* хамаарал нь 0,05 төвшинд зөвшөөрөгдөнө

¹²¹ УТБА. Зүүн Азийн Барометр. УБ., 2005.20, 41 дэх тал

¹²² Монголын Ардчиллын төлөвшил УБ., 2011 ФСЭХ

Судалгааны дүнгээс үндэслээд доктор Д.Ганбат тэмдэглэхдээ "...Монгол Улсын хувьд Азийн нэгтгэсэн коэффициентээс доогуур үзүүлэлт ажиглагдаж байна. Ардчиллын талаарх монголчуудын төсөөлөл нь ардчилалд хандах хандлагад тийм ч их нөлөөтэй байж чадахгүй дүр зураг ажиглагдаж байгаа бөгөөд энэ нь юуны түрүүнд монголчууд ардчиллын чанарын талаар нилэнхүйдээ доогуур үнэлгээ өгсөнтэй холбоотой. Одоогийн байдалд сэтгэл ханамжгүй байгаа нь бүхэлдээ, монголчуудын хувьд хариуцан тайлагнах, авилгыг хянах, хууль сахидаг байх зэрэг нь ардчилалд сэтгэл ханамжтай байх байдлыг, харин улс төрийн үр ашигт байдал, улс төрийг сонирхох түвшин ардчиллыг дэмжих дэмжлэгтэй тус тус хамааралтай"¹²³ хэмээн тайлбарласан байна.

2012 оны 8-р сард Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн урилгаар Монголд ирсэн Стэнфордын их сургуулийн эрдэмтэн, судлаач Ларри Даймонд "Ардчиллын чанар чансаа, түүний оршихуйн увидас" илтгэлдээ эдийн засаг талаас авлига байгаа тохиолдолд улс төр бохир, хууль дээдлэх ёс байхгүй бол ардчилал саатна. Ардчиллын чанар иргэдийн орлого багатай орнуудад тааруу байдаг. Мөн нийгэм дэх иргэдийн оролцоо, иргэний нийгмийн хүч чадал, ил тод байдал зэргээс бас ардчиллын чанар хамаарна хэмээсэн юм.

Эндээс монголын ардчилалын өмнө тулгарч буй томоохон сорилт нь эдийн засгийн бие даасан байдал, монгол улсын мөнгөний бодлого, экспортоос хэт хамааралтай байдал юм. Эдийн засгийн хувьд сул дорой байснаас хүн амын дунд ажилгүйчүүдийн эзлэх хувь, нийгмийн ядуурлын түвшин өсөх нь уг дэглэмдээ итгэх итгэлийг багасгаж, дэглэмийн легитимийг сулруулсанаар цаашдын хөгжилд томоохон бэрхшээл учруулна. Иймд эдийн засгийн хувьд бие даасан, иргэд амьжиргааны хувьд илүү дээр байх нь ардчиллын хөгжилд асар үнэтэй хувь нэмэр болох юм.

Ингээд Ларри Даймондын ардчиллын чанарын хэмжүүрээс эрх зүйт төр, оролцоо, өрсөлдөөн гэсэн хэмжүүрүүдийг сонгон авч монголын нөхцөлд ямар байгааг тодрууллаа.

Эрх зүйт төр

Ардчиллын чанарын гол хэмжүүр болох эрх зүйт төрийн үндэс нь иргэд хуулийн өмнө тэгш ба бие даасан, хараат бус шүүхийн тогтолцоо юм. Ардчиллын чанарыг хэмжих үндсэн хэмжүүр болсон эл үзүүлэлт Монголд ямар түвшинд явж байна вэ? Иргэдийн дунд шүүх байгууллага нэг талыг барин ажиллаж байна гэсэн сэтгэл зүй бүрдээд байгааг их бага санал асуулгаас харж болохоор байна. Шүүх бүх шатандаа дундыг баримтлан аливаа улс төрийн нөлөөллөөс хараат бус байх гэсэн зарчим чанарын энэ хэмжүүрт багтаж байна. Шүүхийн хараат бус байдал монголд байгаа эсэх нь эргэлзээ төрүүлмээр байна.

"Монголчуудын ардчиллын төсөөллийн хамаарал" судалгаанаас харахад ч эрхзүйт төр, авлига гэсэн хэмжүүр нь ардчилалд сэтгэл ханамжтай байдлыг илэрхийлэх бөгөөд Азийн дунджаас доогуур байгаа нь монгол дахь шүүхийн хараат бус байдал алдагдсан, авлига хээл хахуульд автсан байгааг гэрчилж байна. Тиймээс авлигад илүү их өртөх магадлалтай, төрийн байгууллагуудын шийдвэр, үйл ажиллагаанд тавих төрийн болон иргэний хяналтыг хүчтэй болгож, тэдгээр байгууллагын удирдах албан тушаалтнуудыг байнга сэлгэн

¹²³ ФСЭХ. Монголын Ардчиллын төлөвшил. УБ.,2011 32-33 дахь тал

ажиллуулах, мөн иргэдийн авлигын эсрэг ухамсрыг төлөвшүүлэх зорилгоор авлигын эсрэг шат дараалсан арга хэмжээг зохион байгуулах хэрэгтэй.

Оролцоо

Ардчиллын чанарын бас нэг чухал хэмжүүр бол оролцоо юм. Сонгуульд санал өгч оролцсон хувь нь оролцоог илэрхийлэх нийтлэг хэмжүүр болдог боловч энэ нь оролцооны зөвхөн нэг талыг илэрхийлнэ. Үүнээс гадна улс төрийн нам, нийгмийн хөдөлгөөн, төрийн бус байгууллага дахь гишүүнчлэл, идэвхи оролцоо чухал үзүүлэлт юм. Ардчиллын чанарын сул дорой байдлын (авлига, эрх мэдлийг урвуулан ашиглах, засаг төрийн сул мэргэшил) үр дагаварт ардчиллын үйл явцаас хүнийсэх эсвэл ардчилсан механизмын үр нөлөөтэй чанарт эргэлзэн залхах хандлага нь оролцоонд саад болох нийтлэг сөрөг үзэгдэл юм.¹²⁴ Уг хэмжүүрийн хувьд монголд харьцангуй гаагүй гэж үнэлж болохоор байдаг. Харин сүүлийн үед сонгуульд оролцох оролцоо харьцангуйгаар буурч байгааг /хүснэгт-3/ аас харж болохоор байна.

Хүснэгт-3. УИХ-ын болон Орон Нутгийн Хурлын сонгуулийн ирц: /1996-2012 он/

	УИХ-ын сонгууль	ОНХ-ын сонгууль
1996	92,1	72,1
2000	82,4	65,9
2004	81,8	67,2
2008	74,31	47,0
2012	67,29	52,17

Сонгуулийн ирц нь сонгогчдын улс төрийн идэвхийг харуулах нэг үзүүлэлт болдгийнхоо хувьд ардчиллын чанарын гол хэмжүүрт ордог. Монголын сонгогчдын хувьд сонгуулийн идэвхи, оролцоо сонгуулиас сонгуулийн хооронд буурч байгаа нь ажиглагдаж байна. Сонгуулийн ирц буурч байгааг дараах хэдэн зүйлээр тайлбарлах боломжтой гэж бодож байна.

Нэгдүгээрт, Улс төрийн намуудаас залхсан, үл итгэсэн байдал нөлөөлсөн. 2004 оны сонгуулиас эхлэн МАХН, АН хоёуланд итгэх итгэл ихээхэн буурсан юм. Өөрөөр хэлбэл энэ хоёр намыг дэмжигчдийн эзлэх хувь нийлээд нийслэлд 50% -ийг хүрэхгүй байна. Тиймээс сонгуулийн ирц ч мөн хангалттай байсангүй гэж болно. Сонгогчид намуудад итгэх итгэл буураад зогсохгүй улс төрчдөд ч итгэх итгэл ихээхэн суларсан бөгөөд аль нь ч гарсан ялгаагүй гэх хандлага сонгогчдын дийлэнх олонхыг хамарч байна.

Хоёрдугаарт, орон нутгийн сонгуульд ирц үргэлж бага хувьтай байдаг. 1996 оны УИХ-ын сонгуулиас 2008 оны УИХ-ын сонгууль хүртэл сонгуулийн оролцоо 20 шахам хувиар буурсан байна. Орон нутгийн сонгуулийн хувьд ирц харьцангуй доогуур хувьтай байдаг нь нэг талаас орон нутгийн сонгууль нь УИХ-ын сонгуулийн дараахан болдог учраас сонгогчид залхсан байдаг, аль аль талаас ач холбогдол бага өгдөг, түүнчлэн цаг хугацааны хувьд оновчгүй, намрын ид ажлын үетэй давхацдагтай холбоотой билээ. 2008 оны орон нутгийн сонгуулиар

¹²⁴ УТБА. Зүүн Азийн Барометр. УБ., 2005 он 26 дахь тал

нийслэлд анх удаа сонгуулийн ирц хүчинтэй байх хэмжээнд ч хүрэлгүй дутсан бол 2012 оны орон нутгийн сонгуулиар мөн нийслэлийн хэд хэдэн дүүргийн хэсгийн хороодод сонгуулийн ирц 50 хувьд хүрээгүй тул дахин санал хураалт явуулахад хүрсэн. Сонгогчдын оролцоо жил ирэх тутам буурч байгаа нь санхүү эдийн засгийн хувьд ч тэр, ардчиллын чанарын хувьд ч тэр шийдвэрлэх асуудал болоод байна.

Гуравдугаарт, сонгуулийн луйвар, санал худалдаж авах явдал нь нийцтэй оролцоог багасгаж байна. Сонгогчийн өгсөн санал үнэн бодитоор үнэлэгдэхгүй, саналыг худалдаж авах зэрэг хууль бус үйлдэл нь иргэд сонгогчдийн дунд сонгууль шударга явагдаж байгаад үл итгэсэн байдал үүсгэж байна.

Өрсөлдөөн

Тогтсон хугацаанд улс төрийн намуудын хооронд чөлөөт, шударга өрсөлдөөнтэй сонгууль явуулдаг улс төрийн системийг ардчилалтай гэнэ.¹²⁵ Ингэхдээ шинэ улс төрийн хүчнийхэнд сонгуульд өрсөлдөх нээлттэй боломж, ОНХМХ-ээр өрсөлдөгч намууд тэгш илэрхийлэгдэх боломж зэргийг харгалзах хэрэгтэй.

Сонгууль шударга явагдаж байгаа эсэхэд эргэлзсэн маргаан 2008 оны сонгуулиас хойш яригдаж байгаа бөгөөд уг асуудал социал хүрээнд ч эмзэг сэдэв болоод байна. Иймээс 2012 оны сонгуулийг шударга явуулахад төр засгийн газраас ихээхэн анхаарч хувь тэнцүүлэн төлөөлүүлэх зарчимд тулгуурласан сонгуулийн системийг сонгосон.

Уг тогтолцоо нь, УИХ-ын нийт 76 суудлын 11.2.Энэ хуулийн 4.9-д заасан Улсын Их Хурлын 48 гишүүнийг сонгох сонгуулийн нутаг дэвсгэр нь энэ хуулийн 12.1, 12.2-т заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойрог /цаашид “тойрог” гэх/-т хуваагдана. 48 суудлыг 26 тойргоос мажоритар сонгуулийн тогтолцооны олон мандаттай плюраль системээр, үлдсэн 28 суудлыг намын нэрсийн жагсаалтаар (list system)¹²⁶ пропорциональ төлөөллийн системийг ашиглан сонгож байгааг /49.1.4.“Б” жагсаалтад орсон нам, эвсэл тус бүрийн энэ хуулийн 49.1.2-т заасан саналын хувийг энэ хуулийн 49.1.3-т заасан нэг суудалд ногдох хувьд хувааж Улсын Их Хурлын гишүүний 28 суудлыг их үлдээгдлийн зарчмаар хувь тэнцүүлэн хуваарилах; / УИХ-ын сонгуулийн тухай хуулиар хуульчилж өгсөн байна.

48 суудлын хувьд олон мандаттай плюраль системээр сонгуулийн тойрог бүр нэгээс илүү нэр дэвшигчийг хууль тогтоох хуралд илгээж болно. Сонгогчид саналын хуудсан дээр хичнээн суудал байгаагаар нэр дэвшигчийг тэмдэглэж, хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг сонгогдсонд тооцдог.¹²⁷ Уг сонгуулийн систем нь олон нам сонгуулийн тавцанд гарч парламентад орох

¹²⁵ Мөн тэнд. 26 дахь тал

¹²⁶ Намын нэрийн жагсаалтын системээр сонгуульд өрсөлдөгч намуудын нэр дэвшигчдийн жагсаалтаас сонголт хийнэ. Санал тооллогын дүнд нам бүр бүх саналын хувийн дагуу авсан суудалдаа зохих тооны гишүүдээ жагсаалтаасаа нэрлэнэ. Суудал хувиарлахдаа хамгийн их үлдээгдлийн системийг (largestremained) ашигласан.

өрсөлдөөний нэг үзүүлэлтээр давуу боловч өөр нэг үзүүлэлт болох эрх мэдэл дэх альтернатив хувилбарын боломжийг багасгадаг.

Улс төрийн шударга өрсөлдөөнийг үндсэн хууль болон бусад хуулиар зохицуулсан хэдий ч хуулийн хэрэгжилт хангалтгүй, ардчилсан зарчмуудыг зөрчих явдал түгээмэл гарч, сонгуулиар сонгогчдын санал бодлыг төөрөгдүүлэх, сонгуулийн бохир технологи хэрэглэх зэргээр сонгуулийн үр дүнд нөлөөлөхүйц шударга бус өрсөлдөөн байсаар байгаа нь ардчиллын цаашдын хөгжилд саад учруулж байна. Иймд зүй зохистой хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, юуны өмнө улс төрийн намын тухай хууль болон сонгуулийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай.

Дүгнэлт

Монголын ардчиллын өнөөгийн төлөв байдлыг дүгнэвэл ардчиллын байгууллагдажсан бүтэц хэлбэрүүд зохион байгуулалтын хувьд бий болсон боловч энэ нь нийгэм ардчилсан болсныг илэрхийлэхгүй, эдгээр байгууллагуудын оршин байх арга нь, явуулж буй бодлого, үйл ажиллагаа нь ардчилсан болж чадсан нөхцөлд нийгэм ардчилсан болно гэсэн чанарын талын шалгуураар бол манай ардчилсан хөгжилд томоохон сорилт тулгараад байна. Эрх зүйт төр болон оролцоо, өрсөлдөөн гэсэн ардчиллын чанарын хэмжүүрээр манай улс хангалттай түвшинд байж чадахгүй байна.

Харин Зүүн Азийн барометрийн судалгаанд “Монгол улс сүүлийн наяд жил коммунист үзэл суртал, тэгшитгэлийн бодлогыг хүчтэй хэрэгжүүлж ирсэн боловч эрх чөлөө, чөлөөт байдлын үнэлэмж хамгийн өндөр үнэлгээтэй байгаа нь монголчуудын онцлог юм” гэжээ. Уг судалгааны дүнгээр монголчуудын эрх, эрх чөлөө, хувь хүний эрхийг сонгосон хувь өндөр байгаа нь монгол дахь ардчиллын цаашдын хөгжил, чанарын асуудалд томоохон боломж гэж харж болохоор байна.

Монголын ардчиллын хүрсэн төвшинг зүй зохистойгоор үнэлэх хийгээд цаашид улам боловсронгуй болгоход иргэн бүрийн оролцоо, улс төрийн боловсрол чухал нөлөөтэй болохыг онцлож байна. Мөн төр засгийн үйл ажиллагаа авлигаас ангид байж, иргэндээ үйлчилдэг сайн засаглалыг бий болгох зорилго тавигдаж байна.

Abstract:

It depends on the type of political regime we study and on the type of regime we want to avoid or to attain. Applying this double distinction of empirical viewpoints and normative horizons – on the basis of a four-fold typology of political regimes (authoritarianism, semidemocracy, liberal democracy, and advanced democracy) – leads to five concepts of democratic consolidation: avoiding democratic breakdown, avoiding democratic erosion, institutionalizing democracy, completing democracy, and deepening democracy. At the moment, Mongolian democracy is minimal and semidemocracy.

АРДЧИЛЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЫН НИЙГМИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Г.Цэнд-Аюуш

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, доктор

Ө.Лувсанренчин

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн магистрант

Түлхүүр үг: Ардчилал, ардчиллын үнэт зүйлс, улс төрийн ба хариуцлагын ухамсар

Ардчилал” хэмээх ойлголт ХХ, ХХI зуунд хамгийн өргөн хэрэглэгдэх болсон, нөлөөлөх цар хүрээгээрээ улс төрийн шинжлэх ухааны гол сэдэв болж ирсэн билээ. Ардчилал нь А.Линкольны хэлснээр “ард түмнээс байгуулагдсан, ард түмний төлөө, ард түмний засаглал”-ыг илэрхийлдэг гэсэн сонгодог утгаараа ардчилсан орнуудад тохирох тодорхойлолт гэхээсээ илүүтэй хүн төрөлхтний дийлэнх хэсэг зорин тэмүүлж буй идеал хэвээр байна. Мөн ардчилал хүн төрөлхтний дийлэнх олонхийн хүсэл зоригт хэлбэрийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн даяарчлагдаж буй үйл явц болжээ. 2011 онд дэлхийн 167 улсыг сонгон таван гол хэмжүүрээр (сонгуулийн үйл явц ба олон ургальч байдал, засгийн газрын үйл ажиллагаа, улс төрийн оролцоо, улс төрийн соёл, иргэний эрх чөлөө) авч үзэхэд 50 гаруй улс орныг ардчилсан төр улс мөн хэмээн нэрийджээ. Монгол улс мөн адил ардчилсан өөрчлөлтийн замаар 23 жил замнаж нийгмийн амьдралын бүхий л хүрээнд ардчиллын үнэт зүйлсийн үндсийг тавиад байна.

Ардчилал нь “эдүгээг хүртлэх оршин буй улс төрийн байгууллын дотроос хамгийн шилдэг нь”¹²⁸ хэдий ч ардчиллын нөхцөлд улс орны өмнө тулгамдаж буй эдийн засаг, улс төр, нийгэм-соёлын асуудлуудыг шийдвэрлэхэд хүндрэл бэрхшээл тулгарсаар байна. Энэ ч учраас ардчиллын онолын асуудлаар мэргэшсэн эрдэмтэд тухайлбал, Р.Даль “Ардчилал ба түүнийг шүүмжлэгчид” номондоо ардчиллын үйл явц даяарчлагдаж байгаа нөхцөлд ардчилсан институтуудийн бүтцийг боловсронгуй болгох, ардчиллын онол, практикийн нэгдлийг хангаж ардчиллын үнэт зүйлсийг нийгмийн бодит амьдрал дээр хэвшүүлж хэлбэржүүлэх тухай өгүүлжээ. Энэ утгаар авч үзвэл өнөөгийн монголын нийгэмд ардчиллын үнэт зүйлс хэлбэрийн төдий л тогтож байгаагийн зэрэгцээ тэдгээрийг хэлбэршүүлэх үйл ажиллагаанд өдий төдий гажуудал гарсныг манай зарим судлаачид “урвуу ардчилал”¹²⁹ хэмээн шүүмжлэн бичсэн байдаг. Тухайлбал, улс төрийн хүрээнд: иргэн хүн, улс төрийн засаглалын хооронд иргэдийн оролцоог хангасан эргэх холбоо бүхий шууд ардчилал хэрэгжихгүй байна. Хоёрт, засаглалын тэнцвэрт хуувиарлалт алдагдсан УИХ-ын эрхэм гишүүдийн нэлээгүй нь засгийн газрын гишүүнээр хавсран ажиллаж

¹²⁸ У.Черчиллийн хэлсэн үг. УТБА-ийн лекцийн эмхтгэл. УБ., 1999, 3-р тал

¹²⁹ Д. Ганхуяг. Судльдаатай төр. “Өнөөдөр”2001-10-18, С. Дашдаваа. Монголын нийгэм системийн хямралаас сүйрэл рүү. Социологи.2005.№5, Б. Даш-Ёндон. Сэтгэлгээгээ шинэчлэх нь хямралаас гарч дэвжихийн үндэс. Бодрол бясалгал.1993.№1,2,Б. Чимид. Өнөөгийн улстөр хуульчийн нүдээр.УУБ.,2006, Г. Сайнхишиг. Урвуу ардчилал. Философи, эрх зүйн судлал.2007.ХХII боть.

байгаагаас улбаалан төрийн ачаалал нүсэрдсэн, бие хүний болон нийгмийн сонирхлын зөрчил хадгалагдсаар байгаа. Мөнөөх намын харьяаллаар засаглалын бүтэц, бүрэлдүүнийг тодорхойлж, томилдог гаж систем хэвээр үйлчилсээр байна.

Гуравт, улс төрийн аливаа шийдвэрүүдийг улс төрийн институтууд гаргадаг байдал хэвээр байгаа учир тэдгээр шийдвэрүүдийн иргэдэд нууцлагдмал байдал хэвээр, үр дүн нь олон түмэнд хүртээлгүйг оюутолгой, таван толгойн гэрээ хэлцлүүд бэлхнээ харууллаа.

Дөрөвт, олон нийтийн санаа бодол, хүсэл зориг, дуу хоолой эрх баригчдад хүртээлгүй хэвээр, хүрсэн ч гаргах шийдвэрт нь тооцогдож тусгагддаггүй. Ажилгүйдэл, ядуурлын түвшин өндөр, авилга, хээл хахууль газар авсан, түүнээс улбаатай ард олны дургүйцэл, бухимдал ихсэж байна. НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн судалгаагаар Монгол Улсын ядуурлын түвшин 2010 оны байдлаар ойролцоогоор 36 хувьтай байна. Хүний хөгжлийн индексээр Монгол Улс дэлхийн 182 орноос 115-т эрэмбэлэгдэн бичигдсэн¹³⁰. Нөгөө талаар “явал ядуурлаас гарах вэ?” гэсэн социологийн судалгааны асуултанд ядуу болон эмзэг бүлгийн 43 хувь нь хөдөлмөр эрхлэх, 37 хувь нь мэргэжлийн болон мэргэшүүлэх сургалтанд хамрагдах, 20 хувь нь тэтгэмж авах гэж хариулснаас үзэхэд ядуус ажил хийдэггүй, залхуу гэдэг ойлголт зарим талаар буруу ташаа болохыг нотолж, ажил хийх, хөдөлмөрлөх нөхцлийг бүрдүүлэхийн чухлыг харуулж байна¹³¹. Ядуурал хүмүүсийг хүн чанар, эх орноо бодох чадваргүй болгодог. Энэ бол мэргэшсэн байгууллагуудын судалгааны дүн.

Тавд, монголын сонгуулийн кампани шударга бус явагддаг, сонгууль болсны маргаашнаас “луйврын” гэгдэх хэрүүл маргаан тасардаггүй.

Эдийн засгийн хүрээнд: Ардчилал, зах зээл жам ёсны ая зөнгөөрөө учраа олох ёстой гээд зөнд нь орхидог тэр цаг нэгэнт өнгөрчээ. Зах зээл, ардчиллын хөгжил тодорхой үзэл баримтлал бүхий улс төрийн бодлогод суурилах учиртай. Учир нь энэ бүгд хүн бүрийн, нийгмийн бүлэг бүрийн амьдрал ахуйд тусдаг. Ардчиллын үнэт зүйлсийг хөгжилтэй эдийн засаг тэтгэдэг тиймээс зах зээлийн харилцааг зөв гольдрилоор нь хөтлөх нь зүйн хэрэг. Гэтэл манайд иргэн хүн хувийн өмчтэй болж үндэсний олон арван кампани бий болсон хэдий ч гол төлөв гаднын бэлэн бүтээгдэхүүнийг зуучлан борлуулах үүрэг хүлээж, үйл ажиллагаа нь мөнгө хүүлсэн шинжтэй байгаа нь нууц биш. Дээрээс нь үнэ ханш ямар байхыг төр, зах зээлийн аль нь ч биш, харин “ченжүүд” хэмээх паразит давхрага шийдэх болсоор удаж байна.

Нийгэм-соёлын хүрээнд: Манай зарим хүмүүс ардчилал гэхээр юу санаснаа ямар ч аргаар хамаагүй хийж хэрэгжүүлж болох, дур зоргоороо авирлах, зохион байгуулалт, дэг журам, хяналтгүй орчин мэтээр төсөөлөх явдал байна. Энэ бол ардчиллыг анархизмаар сольж буй төөрөгдөл. Бас нэг хэсэг нь хаалгаар нь яваад орчихвол бүх зүйл бүтэж бүрэлдэх “хүслийн диваажин” гэж ойлгоно. Энэ бол ардчиллын тухай үл гүйцэлдэх мөрөөдөл. Бүх

¹³⁰ Монголын улс төрийн ууган байгууллага МАХН ба улс төрийн үзэл баримтлал.УБ., 2010, 79-р тал

¹³¹ Монгол Улс: Ардчилсан өөрчлөлтийн 20 жил, цаашдын зорилт /Онол-практикийн бага хурал /. УБ., 2010, 111-р тал.

юмыг улс төржүүлээд байвал ардчилал болох нь тэр гэх явцуу төсөөлөл ч газар авсан. Мөн ардчиллыг үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдсөн “туйлын” эрх чөлөө гэж андуурах явдал ч байна. Энэ бол ардчиллыг буруугаар ухамсарлаж байгаагийн бас нэгэн баримт. Энэ бүхэн олон түмний санаа бодлын толинд ил харагдаж буй зураглал. Ардчилал бол нийгмээс өөрөөс нь хариуцлагын ухамсар шаарддаг нийгмийн харилцааны арга¹³² гэсэн баримтлал байдаг. Энэ утгаар ардчилал бол: а) эрх, үүрэг, хариуцлагын нэгдэл, б) сахилга, дэг журам, зохион байгуулалтын хэлбэр, в) хууль эрх зүйн дээдлэл, ёс зүйтэй байхын зохицол, г) ард түмний улс төрийн уламжлал, ухамсар, соёлын эрхэмлэл, д) төрийн засаглалын бүтэц, хэлбэр ба улс төрийн нам, иргэний байгуулагуудын уялдаа зохицолын цогцолбор болж хөгжих учиртай.

Дээр дурдсан ардчилал, зах зээлийн давалгаанаар манайд орж ирсэн таагүй үзэгдлүүдийг дагаж монголын нийгмийн ухамсарт, түүний дотор олон түмний оюун санаанд улс төрийн буруу ухамсарлалын олон шинэ гэмээр элементүүдийг өөртөө шингээсэн хувьсал өөрчлөлтүүд гарсаар байна. Ингэхлээр улс төрийг тогтвортой байлгаж дэмжих эдийн засгийн хөгжилт, өсөлтийн хүчин зүйл улс төрийн системийн хувьд дэд систем болох олон түмний улс төрийн ухамсрын өсөлт, төлөвшилтөд тэргүүн зэргийн нөлөөтэй болох нь тодорхой байна. Америкийн улс төрийн онолч Ж.Роулс ардчиллыг хэрэгжүүлэхэд ардчиллын институтыг бий болгох нь хангалтгүй тухай өгүүлэхдээ “эдгээр ардчилсан институтууд нь төлөөллийн ардчиллын “техник хангамж” төдийг л бүрдүүлж байгаа”¹³³ гэжээ. Өөрөөр хэлбэл, эдгээр ардчилсан системийн бүрдлүүдийг бий болгосноор л ардчилал өөрөө бэхжиж, төлөвшихгүй гэдгийг өгүүлсэн болой. Учир иймд монгол орны хувьд өмчийн болон аж ахуйн ямар хэлбэр, хэвшлүүд оршин тогтнож хөгжих нь хамаагүй гагцхүү хөрөнгө баялагтай байж хүн ардынхаа аж амьдралыг сайжруулах, соёл боловсрол, нийгэм хангамжийн бүхий л асуудлыг шийдвэрлэх төрийн зөв бодлого, шударга ёс, ил тод байдал хэвшсэн нөхцөлд ардчилсан соёл, ухамсар, хүмүүжил зүгширч төлөвших болно.

Америкийн эрдэмтэн С.Хантингтон: ардчиллыг хөгжүүлж бэхжүүлэхэд хоёр хүчин зүйл нэн чухал болохыг тэмдэглээд эдийн засгийн тогтвортой хөгжил ардчиллыг тэтгэдэг бол улс төрийн удирдлагын чадамжийн хэр хэмжээ, ардчиллыг зөв гольдролоор нь залж хөгжүүлдэг гэж хэлсэн байдаг.

Резюме

Страны различных регионов мира встали на путь демократизации, имея перед собой опыт передовых западных государств в качестве ориентира развития. Однако практика показала, что переходные общества трансформировались в далекие от первоначального идеала и малосравнимые политические системы. В каждой стране демократия реализовывалась с характерной национально-исторической спецификой.

¹³² “ Ил товчоо” 1993, №4.

¹³³ Мөн тэнд.

В посткоммунистической стране, в которой в начале XX в. был осуществлен форсированный переход из феодального состояния к социализму, в конце XX в западные демократические идеи не встретили особых преград и быстро прижились на местной почве.

Данная статья посвящена необходимостью всестороннего анализа природы демократии в Монголии в плане политического развития страны и в контексте глобальных тенденций демократического развития.

Ашигласан материал

1. УТБА-ийн лекцийн эмхтгэл. УБ., 1999
2. С.Дашдаваа. Монголын нийгэм системийн хямралаас сүйрэл рүү. Социологи. 2005. №5,
3. Б.Даш-Ёндон. Сэтгэлгээгээ шинэчлэх нь хямралаас гарч дэвжихийн үндэс. Бодрол бясалгал. 1993. №1, 2
4. Б.Чимид. Өнөөгийн улстөр хуульчийн нүдээр. УБ., 2006,
5. Г.Сайнхишиг. Урвуу ардчилал. Философи, эрх зүйн судлал. 2007. XXII боть.
6. Монголын улс төрийн ууган байгууллага МАХН ба улс төрийн үзэл баримтлал. УБ., 2010
7. Монгол Улс: Ардчилсан өөрчлөлтийн 20 жил, цаашдын зорилт /Онол-практикийн бага хурал /. УБ., 2010
8. “Ил товчоо” 1993, №4.

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН УЛС ТӨРИЙН ОРОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

Я.Төгөлдөр

ШУТИС-ийн НТС-ийн ОНХА, Улс төр судлалын профессорын баг

Хураангуй: 1990-ээд оны дунд үеэс эхэлсэн феминизмийн шинэ давалгаа Зүүн Европ, Ази, Номхон далайн бүсэд өрнөж, уг нөлөөгөөр Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны талаарх судалгаа шинжилгээний ажил идэвхжиж байна. Энэ үйл явц нь аливаа улс орны улс төрийн систем, сонгуулийн хэлбэр, соёл, уламжлал, эдийн засаг болон техник технологийн дэвшил, олон нийтийн хэвлэл мэдээлэл, иргэд сонгогчдын зан үйл гэх мэт олон хүчин зүйлээс хамааран явагддаг. Иймд Монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны өнөөгийн байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг нийгмийн шинжлэх ухааны фактар анализын аргаар дүн шинжилгээ хийж тулгамдаж буй асуудлыг хөндөн гаргахыг хичээлээ.

Түлхүүр үг: эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо, нөлөөлөх хүчин зүйлс, шалтгаан үр дагавар

Оршил

Ардчиллын онолд төрийн бодлого, шийдвэрт иргэдийн улс төрийн оролцооныг холбогдлын талаар судалж, нийгмийн төлөөллийг шийдвэр гаргах үйл явцад жинхэнэ утгаар нь оролцуулж ардчиллын мөн чанарыг хангах арга замыг эрэлхийлж байна. Иймд иргэдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх асуудалд улс төрийн тэгш байдлын тухай хөндөгдөж, улмаар хүйсийн хандлагатай судалгаа шинжилгээ улс төрийн шинжлэх ухаанд анхаарал татаж байна.

Монгол улсад ч иргэдийн улс төрийн оролцооны асуудалд эмэгтэйчүүдийн төлөөлөл, байр суурийг дээшлүүлэхэд нэг талаас төр засгийн тогтвортой бодлого нөлөөлөх боловч нөгөө талаас нийт сонгогч эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хэлбэр, түвшин, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тандан судлах хэрэгтэй юм.

Судалгааны ажлын зорилго:

- Онолын суурь ойлголтод тулгуурлан эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд нөлөөлөх хүчин зүйлсийн хамаарлын схем боловсруулах
- Судалгаанд Монголын эмэгтэйчүүдийн улс төрд хандах хандлага, байр суурийг тодруулж, шийдвэр гаргах түвшиний оролцоог дээшлүүлэх талаарсанал, зөвлөмжийг боловсруулах болно.

Судалгааны арга:

1. Судалгааны асуулга боловсруулахдаа (Likert, Bardis) үнэлгээний загварыг ашигласан.
2. Судалгааны нийт 88 асуулга нь дараах бүрдэл хэсгүүдээр боловсруулагдсан.

Үүнд:

- I. Эмэгтэй сонгогчдын ерөнхий мэдээлэл
- II. Эмэгтэй сонгогчдын улс төрийн оролцооны хэлбэр
- III. Эмэгтэй сонгогчдын улс төрийн талаарх ойлголт, хандлага

IV. Эмэгтэй сонгогчдын улс төр, эдийн засаг, соёлтой холбоотой хэсэг гэсэн 4 дэд хэсэгт хуваасан.

Уг судалгааг SPSS11.5 судалгааны программаар хүчин зүйлийн шинжилгээг ашиглан судалгааны үр дүнг гаргасан. Судалгааны асуулгыг хувь хүний, соёлын, улс төрийн хүчин зүйлээр нь ангилж, хүчин зүйлийн шинжилгээг хийхдээ 88 асуултаа 4 хэсэгт хуваан, Бартлетийн загварын нэгээс их үзүүлэлтүүдийг сонгон авсан.

Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэн гэж арван найман нас хүрсэн, Иргэний хуулийн¹³⁴ 15.1-д заасан эрх зүйн бүрэн чадамжтай иргэнийг сонгуулийн эрхтэй сонгогч гэж үздэг. 2012 оны байдлаар нийт сонгогчдын 50,3 хувь буюу 985194 мянга нь эмэгтэй сонгогчид эзэлж байна. Иймд нийт сонгогч эмэгтэйчүүдээс судалгааны түүврийн олонлог болгож 662 эмэгтэй сонгогчдоос асуулгын анкетаар судалгаа авсан. Судалгаа санамсаргүй түүврийн аргыг хэрэглэхдээ нийт эмэгтэй сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн насны үзүүлэлтэд тулгуурлаж түүврээ сонгон авсан. Насны бүтцээр нь авч үзвэл 18-29 насны эмэгтэй сонгогчид 24,9 хувьтай, 30-49 насны эмэгтэйчүүд 51,1 хувьтай, 50-59 насны эмэгтэйчүүд 19,7 хувь, 60-аас дээш насных нь 4,3 хувийг эзэлж байна.

Судалгааны таамаглал нь:

Судлаач Вики Рендалын үзсэнээр улс төрд оролцох гэдэг нь хувь хүний улс төрийн идэвх, ухамсартай холбоотой тиймээс эрчүүд давамгайлсан улс төрийн намын бүтэц, бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийн оролцоо, нөлөөллийг дээшлүүлэхэд тэдний улс төрийн талаарх төсөөлөл, итгэл үнэмшил, үнэлэмжийг тодруулах нь зайлшгүй хэрэгтэй гэж үзсэн¹³⁵. Иймд монголын эмэгтэйчүүдийн улс төрийн хандлага, зан байдлыг судалж улс төрд оролцох эмэгтэйчүүдийн өнөөгийн төлөв, боломжийг авч үзэх нь судалгааны ажлын ач холбогдлыг нэмэгдүүлэх болно гэж үзсэн.

Эмэгтэйчүүдийн улс төрд оролцох сэдлийг идэвхжүүлэхэд Нордик орнуудын улс төрийн загварт эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд нөлөөлөх хүчин зүйлсийг үндсэн гурван хүчин зүйлийн хамаарал, шалгуураар авч үздэг. Энэ нь улс төрийн институцийн хүчин зүйл, эдийн засгийн хүчин зүйл, соёлын хүчин зүйлүүдийн шалгуурууд, мөн тодорхой арга замуудыг /квот, нөөц суудал, хуулийн зохицуулалт гэх зэрэг/ хэрэглэдэг¹³⁶. Үүнээс гадна хувь хүний хүчин зүйл нь улс төрийн оролцоонд чухал нөлөөтэй гэх судлаачдын дүгнэлтийг¹³⁷ дөрөв дэх гол нөлөөлөх хүчин зүйл хэмээн авч үзэж дараах таамаглал бүхий загварчлалыг гаргасан.


¹³⁴Иргэний хууль. 15.1. Иргэний эрх зүйн бүрэн чадамж буюу иргэн өөрийн үйлдлээр өөртөө эрх олж авах, үүрэг бий болгох чадвар насанд хүрснээр буюу 18 наснаас бий болно” гэж заажээ.

¹³⁵David Marsh and Gerry Stoker. *Theory and Methods in Political Science*. 3rd ed. NY. 2010. p 122

¹³⁶Nordic Gender Institute Gender and power in the Nordic countries- with focus politics and business. 2011:1. p86

¹³⁷*Contemporary Issues and Ideas in Social Sciences*, Journal. 2007. p15

Таамаглаж буй эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны загвар



Дээрх загварчлалд үндэслэн дараах таамаглалуудыг дэвшүүлсэн болно.

Үүнд:

- Таамаглал1 (T1).Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны Нордик загвар нь эмэгтэйчүүдийн улс төрийн шийдвэр гаргах түвшний оролцоонд шууд эерэг нөлөөтэй;
- Таамаглал2 (T2).Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хүчин зүйлийн загвар нь улс төрийн институцийн хүчин зүйлд эерэг нөлөөтэй
- Таамаглал3 (T3).Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хүчин зүйлийн загвар нь нийгэм эдийн засгийн хүчин зүйлд эерэг нөлөөтэй
- Таамаглал4 (T4).Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны Нордик загвар нь нийгэм соёлын хүчин зүйлд эерэг нөлөөтэй
- Таамаглал 5 (T5). Институцийн хүчин зүйлийн эерэг нөлөө нь хувь хүчин зүйлд харилцан эерэг нөлөөтэй
- Таамаглал6 (T6). Эдийн засгийн хүчин зүйлийн хандлага нь хувь хүний улс төрд хандах хандлагыг улс төрийн шийдвэр гаргах түвшний оролцоонд хүргэх нөлөөтэй
- Таамаглал7 (T7).Соёлыг хүчин зүйлийн эерэг нөлөө нь хувь хүний улс төрд хандах хандлагыг улс төрийн шийдвэр гаргах түвшний оролцоонд хүргэхээрэг нөлөөтэй
- Таамаглал8(T8).Хувь хүний хандлагыг идэвхжүүлснээр улс төрийн шийдвэр гаргах түвшний оролцоонд эерэг нөлөөтэй

Дээрх таамаглалуудыг дэвшүүлэн судалгааны ажлын үр дүнд шинжилгээ хийснээр Монголын сонгогч эмэгтэйчүүдийн улс төрд хандах хандлага, оролцооны хэлбэр, түвшинд хүйсийн тэнцвэрт байдлыг бий болгоход гол

нөлөөлөх хүчин зүйлсийг тодруулж, улмаар улс төрийн салбарт жендэрийн тэгш байдлын талаархи бодлого, төлөвлөлтийг сайжруулах боломжтой юм.

Судалгааны үр дүн

Нийт судалгаанд оролцогчдыг статистикийн мэдээлэл дэх сонгогчдын насны бүтцийн дагуу түүврийг сонгосон бөгөөд улс төрийн оролцоонд хувь хүний хүчин зүйл болох нас, боловсрол, хөдөлмөр эрхлэлт чухал хүчин зүйл гэж судлаач Конвэй, С.Верба, Н.Ний, А.Сен нарын онцлон дурдсаныг авч үзэж судалгаанд харьцуулалт хийхийг зорьсон. Судалгаанд оролцогчдын насны бүтэц, ерөнхий мэдээллийг дараах хүснэгтэд хураангуйлан харууллаа.

Хүснэгт №.2

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл		Хувь	Судалгаанд оролцогчдын мэдээлэл		Хувь
Хүйс	Эмэгтэй	Нийт хүн амын 50,3	Хүүхдийн тоо	1 хүүхэдтэй	18,4 %
	18-25			18,1%	2 хүүхэдтэй
Нас	26-30	18,7%		3 хүүхэдтэй	9,4%
	31-40	28,1%		4 хүүхэдтэй	2,4%
	41-50	23,9%		5 хүүхэдтэй	1,5%
	51-60	7,3%		Албан тушаал	Удирдах албан тушаал
	61 дээш	3,9%	Дунд түвшний удирдах албан тушаал		21,8 %
		Үйлчилгээний албанд	5,1%		
Гэрлэлтийн байдал	Ганц бие	26,9%	Боловсролын түвшин	Бүрэн дунд	21,1 %
	Гэр бүлтэй	64,4%		Дипломын зэрэг	10,9 %
	Салсан	3,6%		Бакалавр	46,8 %
	Бэлэвсэн	2,1%		Магистр	16,6 %
	Нийт	97,3%		Доктор	3,9%
				Шинжлэх ухааны доктор	3%

Судалгааны эхний хэсэгт Монголын эмэгтэйчүүд дунд хүйсийн тэгш бус ялгаварлан гадуурхах асуудлыг хөндөж гэр бүл, ажлын байр, нийгмийн харилцаа, өмчийн харилцаа, уламжлал, соёлын харилцаанд, аливаа өрсөлдөөнд эмэгтэй та хүйсийнхээ үүднээс ямар нэг дарамт, гадуурхагдах тохиолдол мэдэрч байсан уу? гэж асуухад дараах үр дүн гарсан.

Хүснэгт № 3.

Эмэгтэй хүн гэдэг үүднээс ялгаварлан гадуурхагдах тохиолдол байсан уу?

Хариултууд	Хувь
Тохиолддог	3,3 %
Хаяа тохиолддог	12,4 %
Тохиолдоггүй	78,5 %

Энэ асуултыг нийт санал өгсөн эмэгтэйчүүдийн дийлэнх нь буюу 78,5хувиас дээш тохиолддоггүй гэсэн хариулт өгсөн байна. Үүнээс үзэхэд Монголын эмэгтэйчүүд ямар нэг илт дарамт шахалтгүй, ялгаварлан гадуурхах тохиолдол бага байгаа нь манай орныг эмэгтэйчүүдэд ээлтэй орон гэсэн дүгнэлттэй давхцаж болохоор байна¹³⁸. Харин эдгээр асуулгад тодруулах анализ хийж үзэхэд нийгмийн харилцаа, өрсөлдөөн, уралдаан тэмцээнд эмэгтэй хүйсийнхээ үүднээс гадуурхагдаж үзээгүй, харин гэр бүлийн хүрээнд, ажлын байранд хааяа, мөн шууд дарамт шахалт үзэх тохиолдол байдаг гэж нийт судалгаанд оролцогчдын 15,7 хувь нь үзжээ. Хэдий тийм ч эмэгтэйчүүдийн олонх нь өөрсдийгөө бие даасан иргэн хүн гэдэг статусыг шууд илэрхийлж, 80 хүртэлх хувь нь огт гадуурхагдах, дарамт шахалт үзэх тохиолдол байхгүй гэж үзсэн нь ардчилсан улс төрийн дэглэмийн үр дүн гэж үзэж болохоор байна.

Судалгаанд эмэгтэйчүүдийн улс төрд хандах хандлага, улс төрийн талаарх мэдлэг, үнэлэмжийг авч үзсэн.

Хүснэгт №4.

Хүчин зүйл 1. Хувьхүнийулс төрд хандах хандлагыгилэрхийлсэнбайдал

д/д	Хүчин зүйлийн хариултууд	Eigenvalues	Extraction
1	Улстөрдэмэгтэйчүүдихсонгогдсоноорээрэгүрдүнгарна	1	21,865
2	Эмэгтэйнэрдэвшигчидэрчүүдээсдутахааргүйбайсанболохоорн ьдэмжсэн	1	17,732
3	Эмэгтэйчүүдийнболовсролнэмэгдэжбиедаасан, хэнээс ч хамааралгүйбайххүсэлтэйхолбоотой.	1	11,449
4	Эмэгтэйулс төрчийгдэмжиж, санал өгч байсан	1	9,550
5	Ажлынамжилтсайтайболовсролөндөртэйхүүхнүүдулстөрдордо г	1	7,344
6	Улстөрднайзхүүхнүүдээ, ойр дотны эмэгтэйчүүдийгдэмжихньбага байсан	1	6,749
7	Эмэгтэйчүүдэрчүүдийнадилнөхцөлтэйулстөрдоролцохньзөв	1	5,933
8	Улстөрийгбагазэрэг л сонирхдог	1	5,346

¹³⁸“Жендерийн мэдрэмжтэй төсөв” сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаа. НҮБХХ. 2002 он

Үүнээс үзэхэд эмэгтэйчүүдийн олонх нь улс төрд хандах хандлага нь идэвхтэй биш, улс төрийг сонирхох нь бага, улс төрд оролцож буй бусад эмэгтэйчүүдийг хөндлөнгийн байр сууринаас ажигласан өөрөөсөө хол хөндий мэт хандлага харагдаж байна. Гэсэн хэдий ч улс төрд орсон эмэгтэйчүүдийн тухай төсөөлөл нь эерэг үнэлэмжтэй, эмэгтэйчүүд бие биенээ дэмжих хандлага харагдаж байна. Үүнийг тоон анализаар тодруулан үзэхэд эмэгтэй нэр дэвшигчийг дэмжиж байсан гэжнийт судалгаанд оролцогчдын 69,7% хариулсан, эрчүүдээс дутахааргүй чадалтай эмэгтэйчүүд байсан учраас дэмжсэн гэж 49,7 % нь үзжээ. Энэ дүн 2011 оны 3 сарын ЖТБҮХорооны захиалгат судалгаанд эмэгтэйчүүдийн бие биенээ дэмжих хандлага нь 70%-тай байсантай давхцаж байна¹³⁹. Түүнчлэн эмэгтэйчүүд улс төрд ороход ямар нэг дэмжсэн хөшүүрэг гэхээсээ илүү эрчүүдтэй адил тэнцүү өрсөлдөж улс төрд орох нь зөв гэж 68,6% үзэж, улс төрд ажлын амжилт сайтай боловсрол өндөртэй эмэгтэйчүүд ордог гэсэн хандлагыг 28,4 % нь илэрхийлж байна. Үүнээс эмэгтэйчүүдийн улс төрийн хандлага эерэгээр өөрчлөгдөж байгаа ч нөгөө талаасаа ихэнх эмэгтэйчүүд улс төрийн амьдралд хөндлөнгийн үзэгч, ажиглагч мэт хандаж буй нь нийт эмэгтэйчүүдийн улс төрийн боловсрол, улс төрд ойрхон байх сэдлийг дээшлүүлэх кампанит ажлуудыг өргөн хүрээтэй хийх хэрэгтэй гэж харагдаж байна.

Судалгаанд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хэлбэрүүдийг нийт 20 асуултаар оролцогчдоос асуухад хүчин зүйлийн шинжилгээний нэгээс их дараах хэлбэрүүд гарсан.

Хүснэгт №5

Хүчин зүйл 2. Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцооны хэлбэрүүд

д/д	Хүчин зүйлүүд	Eigenvalues	Varimax	Cumulative explained proportion
1	УИХ-ын сонгуулийн оролцож байсан	3,792	18,060	18,060
2	Өлсгөлөнд оролцож байсан	2,093	9,968	28,027
3	Эсэргүүцлийн жагсаал цуглааны үйл ажиллагааг дэмжиж хандив өгч байсан	1,986	9,456	37,483
4	Орон нутгийн сонгуульд оролцдог	1,333	6,346	43,829
5	Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр үзэл бодлоо илэрхийлж байсан	1,119	5,327	49,156
6	Хороо, дүүрэгт улс төрийн албан тушаал эрхэлж байсан	1,103	5,250	54,407

¹³⁹Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцооны талаархи олон нийтийн санаа бодол” судалгааны үрдүн. 2011 оны 3 сарын 4-ны тайланд

Эндээс *varimax* коэффициентийн хэмжээ нь 18,06 буюу хүчин зүйлсийн дотроос тоон үзүүлэлт нь хамгийн өндөр хувьтай УИХ-ын сонгуулийн оролцоо, мөн коэффициентийн хэмжээ нь 6,34 буюу орон нутгийн сонгуулийн оролцоо өндөр байгаа нь эмэгтэйчүүдийн улс төрийн идэвх нь сонгуулийн оролцоогоор хамгийн их идэвхжиж байна. Энэ хоёр үзүүлэлтийн тоон утга нь бусад үзүүлэлтээс нэг дахин их байгаа нь эмэгтэйчүүдэд уламжлалт улс төрийн оролцооны хэлбэр зонхилж байна. Нэг талаар эмэгтэйчүүдийн сонгуулийн оролцоо өндөр байгаа нь сайн талтай ч, нөгөө талаас эмэгтэйчүүдийн олонхи нь сонгуулиас өөр оролцооны хэлбэрийг илүүд үзэхгүй, эсвэл оролцох бололцоо сул байна гэж үзэж болохоор байна.

Харин дараагийн хүчин зүйлийн коэффициентийн хэмжээ нь 9,96-тай улс төрийн өлсгөлөнд оролцож байсан үр дүн нэлээд сонирхол татаж, бусад оролцооны хэлбэрээс бага байх гэсэн таамаглал алдаа байлаа. Эмэгтэйчүүд улс төрийн оролцооны илүү хурц хэлбэрт өөрсдийгөө золиосолж чадахаар тэмцэгч байж үзэл бодлоо хамгаалагч, тууштай гэдгийг харуулсан үр дүн гарсан. Өлсгөлөнд оролцож байсан хүчин зүйлийг насны бүтцээр нь авч үзэхэд бүрэн дунд боловсролтой 31-40 насны эмэгтэйчүүдийн 66,7% нь өлсгөлөнд оролцож байсан дүн гарсан.

Мөн эсэргүүцлийн жагсаал цуглааны үйл ажиллагааг дэмжиж хандив өгч байсан нь гэж коэффициентийн хэмжээ 9,45-тай хүчин зүйл нь эмэгтэйчүүдийн эдийн засгийн хараат бус байдал сайжирсан гэхээсээ илүүтэд зөвхөн гэр бүлээс гадна зөв гэж үзсэн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлдэг нь харагдаж байна. Мөн тавд 5,32 коэффициентийн хэмжээ нь эмэгтэйчүүдийн өөрийн гэсэн үзэл бодлоо илэрхийлдэг идэвхтэй хандлага илэрч байна, мөн аливаадажил хэрэгч, шүүмжлэлтэй хандаж асуудлыг шударгаар илэрхийлж чаддаг нь харагдаж байна.

Үүнээс дүгнэхэд төр засгаас гарч буй шийдвэр эмэгтэйчүүдийг улс төрийн үйл явцад сэтгэл хангалуун бус, улс төрд татан оруулж буй сэдэл нь эсэргүүцсэн, үл хүлээн зөвшөөрсөн хэлбэрүүд зонхилж байгаагаас харахад Монголын улс төрд дийлэнх олонх нь эрчүүд давамгайлсан бүрэлдэхүүнээс улс төрийн шийдвэр оновчгүй, үр дүн нь хүртээмжгүй байгаагийн илрэл гэж үзэж болохоор байна. Мөн өнөөдрийн Монголын нийгэмд үүссэн эмэгтэйчүүд, хүүхэд, гэр бүлийг дэмжсэн нийгмийн хамгааллын бодлого, түүний хэрэгжилт хангалтгүй байна. Үүнээс шалтгаалан эмэгтэйчүүд улс төрийн амьдралд оролцохоос илүү гэр бүлийн ачаалал их, ажил үүргийн уламжлалтхуваарилалтаас шалтгаалан эмэгтэйчүүдийн хувьд завгүй байх нөхцөл бүрдсэн байна.

Мөн судалгаанд хороо, дүүрэг зэрэгт улс төрийн албан тушаал эрхэлж байсан гэсэн 5,25 коэффициентийн хэмжээ нь эмэгтэйчүүд улс төрийн анхан шатны нэгжид хамгийн их хувийг эзэлдэг бусад судалгааны дүнтэй таарч байна. Судлаач Л.Милбрэдийн үзсэнээр улс төр бол өөрөө шаталсан бүтэцтэй бөгөөд түүнийг дамжиж түвшин ахидаг гэвэл монголын эмэгтэйчүүд анханшатны түвшинд хүрээд зогсонги байдалд ороод байна уу гэсэн дүгнэлтэнд хүрэхээр байна. Мөн нөгөө талаас улс төрийн албан тушаал эрхэлж буй энэ тоо шууд утгаараа улс төрийн намын гишүүнчлэлийг илэрхийлдэг. Үүнийг тодруулан үзэхэд нийт судалгаанд оролцогчдын 71,9% нь аль нэг намын гишүүн байна. Иймд Монголын эмэгтэйчүүд улс төрийн амьдралаас хол хөндий байна гэж үзэх үндэслэл харагдахгүй байна. Гэвч улс төрийн намын гишүүнчлэлээс дээш оролцооны түвшин нэмэгдэж чадахгүй байгаа нь улс төрийн намын дотоод

ардчилал, нөгөө талаас эмэгтэйчүүдийн манлайллын асуудалтай холбоотой гэж үзэж болох юм.

Эцэст ньдээрх хүчин зүйлийн шинжилгээг нэгтгэн үзвэл эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд сонгуулийн оролцоо илт давамгайлсан, улс төрийн оролцооны “шилжилтийн түвшин” зонхилсон гэж үзэж болохоор байна. Түүнчлэн хүчин зүйлийн шинжилгээнд эмэгтэйчүүд үзэл бодлоо илэрхийлж төр засгийн шийдвэр оновчтой байхыг шаардаж байна. Улс төрийн шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийн орон зай үгүйлэгдэж улс төрийн намд эмэгтэйчүүдийн талаар баримтлах бодлого, шийдвэрт шинэчлэл хэрэгтэй байгааг уг шинжилгээ харууллаа.

Судалгаанд оролцож буй эмэгтэйчүүдээс нийгэм соёлын уламжлал хүйсийн тэгш бус байдалд нөлөөлж буй эсэхийг тандсан нийт 10 асуултаас хүчин зүйлийн шинжилгээний үр дүнддараах 5 хүчин зүйл гарсан.

Хүснэгт №6

Хүчин зүйл 3. Соёлын хүчин зүйлийн хандлага

д/д	Хүчин зүйлийн хариулт	Eigenvalues	Varimax	Cumulative explained proportion
1	Эмэгтэйхүнууловооны тахилгазэрэгт оролцожболдоггүйгсайнмэдэхгүй ч дагажмөрддөг	1,478	14,784	14,784
2	Буддыншашнызанүйлэмэгтэйчүүдэд тэгшбусханддаггэдэгтээсаналнийлэхгүйбайсан	1,396	13,962	28,746
3	Ууловоонытахилгазэрэгтэмэгтэйчүүдоролцохгүйбайхуламжлалзөв гэж үзсэн	1,265	12,649	41,395
4	Гэр бүл, ажлын амжилт альальньминийхувьдсайнбайгаа	1,185	11,846	53,241
5	Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд бага байгаа нь уламжлал, соёлын ялгаатай холбоотой гэдэгтээ санал нийлсэн	1,047	10,473	63,714

Хүчин зүйлсийн дотроос хамгийн өндөр хувьтай гарсан “Эмэгтэйхүнууловооны тахилгазэрэгт оролцожболдоггүйгсайнмэдэхгүй ч дагажмөрддөггэсэн хандлагыг тоон анализаар нарийвчлан үзэхэд 39,3% нь ер нь дагаж мөрддөг гэж үзсэн, мөн 3-т байгаа “Ууловооны тахилгазэрэгтэмэгтэйхүн оролцохгүйбайхуламжлал”зөв гэж тоон анализаар 53,5% үзсэн нь эмэгтэйчүүдийн ихэнхи энэ соёлын зан үйлийг дагаж мөрдөх нь хүйсийн тэгш бус хандлага гэж огтхон ч үзэхгүй байна. Энэ хандлагыг шашны зан үйлтэй холбож асуухад буддын шашин эмэгтэйчүүдэд тэгш бус ханддаг гэсэн асуултыг хүлээн зөвшөөрөхгүй, санал нийлэхгүй байна гэж 61,6% нь үзжээ. Үүнээс үзэхэд эмэгтэйчүүд уламжлалт соёлоо хүндэтгэн дагадаг үүнийг ямар нэг тэгш бус хандлага гэж үзэхгүй байгаа нь харагдаж

байна. Гэхдээ дараагийн хүчин зүйлийн агуулга эндээс шууд дүгнэлт хийж болохгүйг харуулна.

Энэ хэсгийн хүчин зүйлийн шинжилгээнд эмэгтэйчүүдийн өөрсдийнх нь хандлагыг тандсан бодомж оруулсан. Асуулгын дүнгээс дээрх уламжлалт зан үйлийг дагадагхэсэг нь либераль бие даасан эмэгтэйчүүд гэдгийг илтгэсэн асуулга орсон нь сонирхол татаж байсан. Тухайлбал, Бодитамьдралдээртаалийгнхилүүхэрэгжүүлдэгвэ?” гэсэн бодомжоос эмэгтэйчүүдийн 63,1 хувь нь гэр бүл, ажлын амжилтаа хамтад ньавчявахыгхичээдэгбаальальньминийхувьдсайнбайгаа гэж өөрсдийгөө дүгнэн үзсэн байна. Мөн үүний дараа “Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүд бага байгаа нь уламжлал, соёлын ялгаатай холбоотой гэдэгтээ санал нийлж байна гэж тоон анализаар 57,1 хувь нь үзснээр улс төр дэх хүйсийн тэгш бус харьцааг хүлээн зөвшөөрч нийгэмд тогтсон ойлголтыг өөрчлөх хандлага илэрч байсан.Эндээс дүгнэхэд нийгэмд тогтсон жендэрийн тэгш бус байдлын технологи ньтухайн нийгмийн зан үйл, шашны уламжлалаар дамжин нийгмийн ухамсартбат бөх болдог гэсэн жендэрийн соёлын онолын агуулга манай эмэгтэйчүүдийн дунд ч хэвшсэн, бат бэх ойлголт болсон нь харагдаж байна. Судалгаанд оролцож буй эмэгтэйчүүдийн өөрийнх нь хувьд улс төрд идэвхтэй оролцоотой байхад юу нөлөөлөхийг мэдэх зорилгоор асуухад дараах 3 хүчин зүйл гарсан.

Хүснэгт №7

Хэрвээтаулстөрдорохыгхүсвэл нөлөөлөх гол хүчин зүйлсийн талаар

д/д	Хүчин зүйлийн хариулт	Eigenvalues	Varimax	Cumulative explained proportion
1	Мөнгө	1,795	29,92	29,92
2	Гэрбүлийндэмжлэг	1,228	20,466	50,386
3	Намынхаръяалал	1,122	18,696	69,081
4	<i>Найзнөхөдхамтолныдэмжлэг</i>	<i>0,868</i>	<i>14,468</i>	<i>83,549</i>
5	<i>Боловсрол</i>	<i>0,81</i>	<i>13,496</i>	<i>97,044</i>
6	Улстөрийнтуршлага	0,177	2,956	100

Энд “Мөнгө” эмэгтэйчүүдийн улс төрд ороход нөлөөлөх гол хүчин зүйл гэж үзсэн ньорчин үеийн улс төр арилжааны шинж чанартай болж, мөнгө асар их нөлөөтэй болох нь харагдаж байна. Иймд монголын эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог шийдвэр гаргах түвшинд хүргэхэд эдийн засгийн хөшүүрэг чухал гэдгийг харууллаа. Энэ хэсэгт хүчин зүйлийн шинжилгээний асуулгуудыг нас, боловсролоос хамаарах хүчин зүйлээр нь харьцуулан анализ хийж үзэхэд сонирхолтой дүгнэлтүүд гарсан. Судалгаанаас харахад эмэгтэйчүүдийн боловсрол ахих тусам нийгмийн харилцаа, шийдвэр гаргах үйл явц, шийдвэр оновчтой байх зэрэгт анхаарах, нөлөөлөх боломжоо илүү мэдэрч, бусад эмэгтэйчүүдээ дэмжих хандлага илэрч байна. Нөгөө талаар эмэгтэйчүүдийн боловсрол, нас ахих тусам нийгмийн харилцаанд иргэн хүний статустай, оролцоотой байх ёстой субъект гэж өөрсдийгөө илүү үнэлж байгаа нь харагдаж байна.

Хүснэгт №8

Эмэгтэйчүүдийн улс төрийн оролцообагабайгааг та юутай холбож үзэж байна вэ?

Хүчин зүйлийн хариулт	Eigenvalues	Varimax	Cumulative explained proportion
Гэрбүлийндэмжлэгтааруу	3,082	61,641	61,641
Эмэгтэйчүүдөөрсдөөулстөрийгсонирхдоггүй	1,036	20,728	82,370
Эмэгтэйчүүд амбиц бага	0,520	10,403	92,773
Улс төрд мөнгө хэрэгтэй	0,214	4,286	97,059
Бие биенээ дэмжихгүй байна	0,147	2,941	100,000

Судалгаанаас үзэхэд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд хамгийн чухал нөлөөлөх хүчин зүйл нь юуны өмнө эмэгтэйчүүд улс төрд сонгогчын байр сууринаас биш, төлөөлөх чадвартай сонгогдогч байх төлөвшлийг олгох нь чухал байна. Нөгөө талаас улс төрийн засаглалд эмэгтэйчүүдийн төлөөлөл бага байгаа нь нийгэмд сөрөг үр дагавартай байгааг эмэгтэйчүүдийн олонх хүлээн зөвшөөрч байна. Учир нь өнөөгийн Монголын эрчүүд давамгайлсан төр засгийн шийдвэрээс ардчилсан иргэний нийгмийн энэрэнгүй шинж буурсан, өөрийнхөө хүчинд итгэж амьдрах хатуу нөхцөлүүд тулгарч байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Дүгнэлт

Монголын эмэгтэйчүүд улс төрийн эрх мэдэл, засаглалыг хуваалцах эрх зүйн чадамжтай боловч бодит амьдрал дээр тэдний нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, байр сууринд уламжлалт патриархийн шинж давамгайлсан хандлага хүчтэй хэвээр байна. Нэг талаас эмэгтэйчүүдийн улс төрд оролцох хувь хүний хандлага, улс төрийн талаарх үнэлэмж, мэдлэг нь сайн биш байна, нөгөө талаас нийгмийн сэтгэл зүй ч үүнд бэлэн биш байна.

Судалгаанд эмэгтэйчүүд улс төрийг бага сонирхдог гэсэн үр дүн гарсан нь олон зуун жилийн турш нийгмийн сэтгэл зүйд хэвшсэн эмэгтэйчүүд улс төрөөс хол байсан зан үйл, улс төрийн соёлтой холбоотой гэж үзэж болмоор байна. Мөн Монголын эмэгтэйчүүдийн нуруун дээрх гэр бүлийн ачааллаас төрийн хуваалцах чадамж сул, нийгмийн хамгааллын систем хангалтгүй байгаагийн илрэл гэж үзэж байна. Социализмын үеийн эмэгтэйчүүдийн талаарх бодлого, үр дүнгээс улбаалсан эмэгтэйчүүд гэр бүл, ажил албаа хамтад нь авч явахыг хичээдэг хэв маяг одоо ч харагдаж байна. Энэ хандлагыг феминизмийн онолчид үеэ өнгөрөөсөн хэв маяг гэж шүүмжлэлтэй хандаж, шинэ зууны хөгжил, техник технологийн дэвшил эмэгтэйчүүдийн сонголтыг өөрчилж шинэ дүр төрх, шинэ зан үйл эмэгтэйчүүдийн сонголтыг улам ихээр нэмэгдүүлж буйг А.Хахимын сонголтын онолд онцолсон байдаг. Тиймээс Монголын эмэгтэйчүүдийн хувьд гэр бүл, ажлын ачааллаа хамтад нь авч явна гэдэг нь эмэгтэйчүүд зав багатай учраас улс төрийн оролцоог дээшлүүлэх тухай ярихад саад болж байна. Өөрөөр хэлбэл эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоонд макро түвшиний хүчин зүйл болох нийгмийн хамгаалал, эдийн засгийн хүчин зүйл

зэрэг нь саад болсоор байна. Үүнийг өөрчлөхөд гэр бүлийн ачааллыг хөнгөлөх нийгмийн хамгааллын тогтолцоог төрөөс тууштай, тогтвортой сайжруулснаар эмэгтэйчүүд ямар нэг нөхцөлийг шаардаж биш, нөлөөлж хэрэгжүүлж чаддаг нийгмийн томоохон төлөөлөл болох зайлшгүй нөхцөл үгүйлэгдэж байна.

Эмэгтэйчүүд улс төрд оролцох чадамжаараа эрчүүдээс дутуугүй гэж үзэж байгаа учраас квот зэрэг тодорхой арга замыг хөшүүрэг болгон улс төрд төлөөллөө нэмэх нь оновчтой биш гэж ихэнх эмэгтэйчүүд үзжээ. Үүнийг чанарын судалгаагаар улс төрийн намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллагын удирдах албан тушаалтан, идэвхтэн, гишүүд нартай уулзаж тодруулахад судалгаанд оролцсон эмэгтэйчүүдээс өөр хандлагатай байсан. Тэд үзэхдээ эмэгтэйчүүд улс төрд оролцоход тусгай механизмыг ашиглахгүйгээр хүссэн үр дүнд хүрч чадахгүйгээс гадна, дараагийн эмэгтэйчүүддээ урам зориг өгөх гарцыг гаргаж чадахгүй юм. Улс төрд эмэгтэйчүүдийн төлөөллийг дээшлүүлэхэд квот нь хамгийн гол шийдвэрлэх нөлөөтэй арга зам гэж үзэж байсан. Үүнээс харахад жирийн эмэгтэй, улс төрд оролцож буй эмэгтэй нарын хооронд үзэл бодлын зөрүү байгаа нь квотын ач холбогдолын тухай таниулах, мөн эдгээр субъектүүдийн цаашдын хамтын ажиллагааг сайжруулах хэрэгтэй нь ажиглагдаж байна. Түүнчлэн Монголын эмэгтэйчүүд бие биенээ дэмжих хандлага улс төрд тод илэрч байгаа ч цаашдын чиг хандлагыг тогтвортой болгоход феминизмийн онол арга зүйд тулгуурласан танин мэдэхүйн болоод гэгээрүүлэх ач холбогдолтой үйл ажиллагаа дутагдаж байна. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдийн нас, боловсролын түвшин ахих тусам улс төрийн талаарх төсөөлөл, үнэлэмж, чиг баримжаанд эерэгээр нөлөөлж улс төрийн оролцоог идэвхжүүлэх хүчин зүйл болж байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Ерөнхийд нь дүгнэхэд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоог шилжилтийн шатнаас шийдвэр гаргах түвшиний оролцоонд хүргэхэд нийгэм, соёлын, эдийн засгийн хүчин зүйл нь саад болж буй нь харагдаж байна. Иймд макро түвшинд эмэгтэйчүүдийн талаарх уламжлалт соёлын хандлага, хөдөлмөр эрхлэлт дэх жендэрийн тусгаарлалтыг онцлон авч үзэж олон нийт, хувь хүний үзэл бодолд сэтгэлгээний өөрчлөлт хийх хэрэгтэй нь харагдаж байна. Ингэснээр эмэгтэйчүүдийн улс төрд хандах хандлагыг идэвхжүүлж, шийдвэр гаргах түвшний оролцоонд эмэгтэйчүүдийн байр суурь, нөлөөллийг нэмэгдүүлэх боломж байна.

Түүнчлэн судалгааны үр дүнд эмэгтэйчүүдийн улс төрийн оролцоо нь улс төрийн намын түвшинд хүрээд оролцоо, төлөөлөл нь багасаж байгаа нь институцийн хүчин зүйлийг нарийвчлан авч үзэх шаардлага гарч байна. Хэдийгээр Монголын төрөөс жендэрийн тэгш байдлын талаарх бодлого эрх зүйн орчин сайжирч байгаа ч улс төрийн оролцооны дундаас дээш түвшинд эмэгтэйчүүдийн төлөөлөл харилцан тэнцвэргүй байгаа нь микро түвшний судалгааг илүү тодорхой хийх нөхцөл харагдаж байна. Иймд цаашид улс төрийн намын бүтэц, бүрэлдэхүүнд эмэгтэйчүүдийг дэмжих арга замуудыг эрэлхийлж, томоохон кампанит ажлуудыг тогтвортой, шат дараалалтай хэрэгжүүлэх нь шийдвэр гаргах түвшний эмэгтэйчүүдийн оролцоог бодит хэрэгжилт болгож, улмаарнийт иргэдийн улс төрийн оролцоог дээшлүүлэх нэг алхам болно.

Ашигласан материал

1. David Marsh and Gerry Stoker.2010.*Theory and Methods in Political Science*.3rd ed.NY
2. Nordic Gender Institute.2011:1.Gender and power in the Nordic countries-with focus politics and business.
3. *Contemporary Issues and Ideas in Social Sciences*,2007.Journal
4. Randall, Vicky. 1982*Women and Politics*. London. Macmillan Press
5. Shelley Budgeon. 2011.*Third Wave of Politics of Gender in late Modernity*. 1th ed., London
6. Norden statistic year book . 2011
7. Laura Laubeova. 2002.*Gender and Political Equality in the Nordic Countries*.
8. Olesen,V.1994. *Feminisms and models of qualitative research*. In N.K.Denzin (Eds)Handbook of Qualitative Research. Thousand Oaks, CA:Sage.
9. “Жендерийн мэдрэмжтэй төсөв” сэдвийн хүрээнд хийгдсэн судалгаа. НҮБХХ. 2002 он
10. Шийдвэргаргахтүвшиндэхэмэгтэйчүүдийноролцооньталаархиолоннийтийнсанаабодол” судалгааныүрдүн. 2011оны 3сарын 4-ны тайланд
- 11.УИХ-ын сонгуулийн тухай хууль. 2011
- 12.Иргэний хууль. 2002

Б.Одгэрэл

Отгонтэнгэр Их Сургуулийн багш, МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн докторант

Хураангуй: Шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог тодорхойлох харьцууллын аргыг түлхүү хэрэглэсэн энэхүү судалгааны өгүүлэлдээ дэлхий дахины хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн төлөөллийн тоо, эзлэх хувийг харьцуулан, улс орнуудын хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөллийг оруулж буй арга механизмыг судлаж, Монголын эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшний оролцооны цаашдын чиг хандлагыг тогтоохыг зорьсон билээ.

Түлхүүр үг: Феминизм, эмэгтэйчүүдийн улс төрийн эрх, хууль тогтоох байгууллага, квот, сонгох, сонгогдох эрх

Үндсэн хэсэг

Нийгмийн улс төрийн амьдралын хүрээнд эмэгтэйчүүдийн нөлөөлж эхэлсэн байдлыг түүхийн цаг хугацааны хувьд авч үзвэл МТӨ 3000 жилийн тэртээ эртний Египетийн хатад улс орноо захирч байсан тухай түүхийн баримт үлдсэн байх бөгөөд хамгийн анх түүхэнд нэрийг нь дурдсан эмэгтэй удирдагч бол Урукын дайны дараах тусгаар тогтносон Месопотамын хот улсыг МТӨ 2500 жилийн тэртээ захирч байсан Ку Бабаг гэж тэмдэглэжээ¹⁴⁰.

Эмэгтэйчүүдийн эрхийн тухай асуудал харьцангуй хожуу үед буюу XIX зууны эхэн үеэс үүсэлтэй юм. Чухам тэр үеэс эмэгтэйчүүд улс төр нийгмийн амьдралд татагдан орох эхлэл тавигдсан гэж үздэг билээ. Энэ үед эрэгтэй эмэгтэй хүйсийн тэгш байдлын тухай нийгмийн шинэ онол Феминизмийн /Feminism/ үзэл санаа бий болж эмэгтэйчүүд эдийн засаг, нийгмийн салбарт орж амжилт гаргах боломжтой болжээ. Феминизм нь нийгэмд эмэгтэйчүүдийн тэгш байр суурийг илэрхийлж, ярьж, ойлгож, эрхийг нь хамгаалах үзэл санаа юм. Феминист үзэл санаа, феминистүүд 1872 оноос Голланд, Франц 1890 оноос Их Британид, 1910 оноос Америкт би болж үүсчээ. Оксфордын англи хэлний толь бичигт 1894 онд анх феминист гэж өөрсдийгөө нэрлэгсэд гарч ирсэн гэж тэмдэглээд 1895 онд Их Британийн “Дэйли Ньюс” сонинд анх Феминист нэр томъёо Францууд шууд хэрэглэжээ. Феминизм үзэл санааны хувьд хэд хэдэн үе шатыг дамжсан бөгөөд эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэх, өмч эзэмших эрхийг бүрдүүлж өгөхийг шаардаж эхэлсэн тэмцэл өнөөдөр шийдвэр гаргах түвшинд төлөөлөлтэй байх, нийгмийн тэгш эрхийн төлөөх тэмцэл болон өөрчлөгджээ.¹⁴¹

XX зуунд эмэгтэйчүүдийн эрхийн асуудлыг дэвшүүлэн, нийгэм улс төр, эдийн засгийн салбарт тэгш эрхтэй оролцуулах шинэ хандлага гарч зарим үр дүнд хүрсэн байна. Тухайлбал эмэгтэйчүүд боловсрол олж авах, ажил эрхлэх, улс төрд оролцох зэрэг асуудалд ихээхэн өөрчлөлт гарч ардчилсан институцууд бодлого боловсруулж шийдвэр гаргах түвшинд хүйсийн тэгш оролцоог хангах

¹⁴⁰ <http://www.guide2womenleaders.com/>

¹⁴¹ Marie-Jean-Antoine-Nicolas Caritat, Marquis de Condorcet, On the Admission of Women to the Rights of Citizenship (1790), The First Essay on the Political Rights of Women. A Translation of Condorcet's Essay "Sur l'admission des femmes aux droits de Citoy" (On the Admission of Women to the Rights of Citizenship). By Dr. Alice Drysdale Vickery (with preface and remarks) (Letchworth: Garden City Press, 1912).

шинэ зорилтыг тунхагласан юм. XX зууны сүүлийн хагаст эмэгтэйчүүдийн талаархи тогтсон ойлголтуудад огцом өөрчлөгдсөн байна. Эмэгтэйчүүд зөвхөн гэр бүлийн хүрээнд гол байр суурьтай байна гэсэн энгийн хэвшмэл ойлголт эвдэрч, дэлхийн II-р дайны үеэс эмэгтэйчүүдийн ажил хөдөлмөр эрхлэлт харьцангуй өссөн байна. Эмэгтэйчүүдийн мэргэжлийн ажил хөдөлмөр эрхлэх, боловсрол эзэмших, олон нийтийн үйл ажиллагаанд оролцох чадвар ихээхэн дээшлэв. Нийгмийн амьдралын ихэнх салбарт нарийн мэргэжил эзэмшсэн эмэгтэйчүүдийн тоо өсч эмэгтэйчүүдийн чадавхи боломж нэмэгдлээ.

Ардчилсан болон ардчилсан бус аль ч нийгэмд эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийн хоорондын харилцааны асуудлыг хөндөөгүй нийгмийн ямар нэг өөрчлөлт түүхэнд байхгүй гэж болно. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгийн анх ардчилсан орнууд хүлээн зөвшөөрч баталгаажуулсан боловч олон орон эхний жилүүдэд тодорхой алхам хийхээс цааргалж байлаа. Жишээ нь АНУ, Нэгдсэн Вант Улсын эмэгтэйчүүд санал өгөх эрхээ 1920, 1930-аад онуудад олж авсан байдаг.¹⁴²

Шинэ Зеланд анх 1893 онд эмэгтэйчүүдэд сонгох эрхийг бүрэн олгосон анхны орон болсон бол Финланд 1906 онд эмэгтэйчүүдийнхээ сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулжээ. XXI зууны эхэн гэхэд дэлхийн улс орнуудын 95 хувь нь эмэгтэйчүүдийн улс төрийн эрх, тухайлбал сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулаад байна.

Ардчилсан засаглалын нэг гол зарчим нь хүний эрхийг хүндэтгэх явдал бөгөөд түүний дотор эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн улс төрийн тэгш эрхийг бүрэн хангах явдал багтдаг. Олон зууны туршид эмэгтэйчүүдийн эрхийн тухай яригдаж тодорхой өөрчлөлтүүд гарч байгаа ч эмэгтэйчүүдийн улс төр, эдийн засаг, нийгмийн эрх эрх чөлөөг хангах нь бодит байдал дээр хангалттай биш байсаар байна. Эрчүүд, эмэгтэйчүүдийн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох тэгш төлөөлөл нь 1979 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас баталгаажуулж 1981 оноос хүчин төгөлдөр хэрэгжих болсон Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн хүчирхийллийг устгах тунхаглалын гол агуулга билээ. Энэхүү тунхаглалд улс орнууд гарын үсэг зураад 30 гаруй жил өнгөрч, энэ хугацаанд 179 орон энэхүү конвенцид нэгдэн эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшин дэх төлөөллийг нэмэгдүүлэхийг идэвхийлэн дэмжиж байна.

1995 онд НҮБ-ын дэлхийн эмэгтэйчүүдийн IV дүгээр их хурал Бээжин хотод болж “Бээжингийн үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж нэрлэгдсэн баримт бичиг гаргасан бөгөөд түүнд дурдснаар “Шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцооны түвшин ялгаатай байна”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих механизм бүх түвшиндээ хангалттай бус байна” гэж заасан нь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг чиглүүлж өгсөн гол заалтуудын үндэс нь болжээ¹⁴³. Эдгээр заалтууд нь 1995 он гэхэд дэлхийн хэмжээнд Парламентад эмэгтэйчүүдийн эзлэх хувь буурч доод танхимд 1985 онд 12%, дээд танхимд 12,7% байснаа арван жилийн дараа доод танхим дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл 11,6% болж, дээд танхим дахь эмэгтэйчүүдийн хувь 9,4% болжээ.

Сүүлийн 15 жилийн дотор улс үндэстнүүдийн парламентад эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэхэд ихээхэн дэвшил гарсан. 1995 онд

¹⁴²Anna Coote“New gender agenda: Why women still want more” 2000, UK p-86

¹⁴³Парламент дахь эмэгтэйчүүд Тоо ба агуулга, 16-р тал

дэлхийн хэмжээнд эмэгтэйчүүд нийт парламентын гишүүдийн 11,3%-ийг эзэлж байсан бол 2005 онд энэ тоо 16% болж өсчээ.¹⁴⁴ Харин 2012 оны 10 сарын 31-ний байдлаар дэлхийн хэмжээнд хууль тогтоох хурлын 20,4%-ийг эмэгтэйчүүд эзлэх болсон байна.¹⁴⁵

Дэлхийн Парламентын бүх танхимын дунджаар авч үзвэл	
Нийт Парламентын гишүүдийн тоо	45908
Эрэгтэй гишүүдийн тоо	36553
Эмэгтэй гишүүдийн тоо	9355
Эмэгтэйчүүдийн дэлхийн парламентын бүх танхимд дунджаар эзэлж буй хувь	20.40%

Дэлхийн хэмжээнд хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг бүсчлэн авч үзвэл Скандинавын улс орнууд хамгийн өндөр буюу бүсийн хэмжээнд 42,0% үзүүлэлттэй тэргүүлж байна.

	Нэг танхимтай парламент болон парламентын доод танхимуудад	Сенат болон парламентын дээд танхимуудад	Хоёр танхимыг нэгтгэж авч үзвэл
Скандинавын улсуудад	42.0%	---	---
Хойд ба Өмнөд Америк	23.8%	24.6%	24.0%
Европ /Скандинавын орнуудын оролцуулаад/	23.6%	21.1%	23.1%
Европ /Скандинавын орнуудын оролцуулахгүйгээр/	21.9%	21.1%	21.7%
Африк	20.8%	17.4%	20.4%
Ази	18.5%	14.2%	18.0%
Араб	14.9%	6.4%	13.2%
Номхон далайн орнууд	12.7%	34.8%	15.2%

Эх сурвалж : <http://www.ipu.org/wmn-e/world.htm>

Онолын хувьд сонгогдох буюу нэрээ дэвшүүлэн сонгуульд өрсөлдөх эрх нь сонгох эрх дээр суурилдаг. Харин бодит байдал дээр нэр дэвшигчдийн ихэнх нь эрэгтэйчүүд байдгаас эмэгтэйчүүд хууль тогтоох байгууллагад сонгогдож ажиллах нь тодорхой хязгаартай байсаар байна. Эмэгтэйчүүд

¹⁴⁴<http://www.ipu.org> 2005оны 1 дүгээрсарын 31 статистикмэдээ.

¹⁴⁵ <http://www.ipu.org/wmn-e/world.htm>

сонгуульд нэр дэвшихэд зориулан квот¹⁴⁶ тогтоох нь хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэхэд хамгийн үр дүнтэй механизм юм. Үндсэн хуулиар болон сонгуулийн хуулиараа квотыг зохицуулсан нь гадаад улс орнуудын хувьд 1990 оны үеэс хэрэгжиж эхэлсэн байна. Тухайлбал, Балба /1990 онд Парламентын суудлын 5%/ Аргентина /1991онд Парламентын суудлын 30%/ зэрэг улсуудыг нэрлэж болно. 2005 онд 90 гаруй улс ямар нэг хэмжээгээр намынхаа дүрмэнд буюу албан ёсоор хуулиндаа квотын тухай заасан байна. Эдгээрээс 50 гаруй улс оронд улс төрийн намууд сайн дураараа өөрийн дүрэмдээ эмэгтэйчүүдийн квотыг тусгасан байна.

Парламент дахь эмэгтэйчүүдийн суудлын тоогоор эхний 10-т эрэмбэлэгдэж байгаа улс орнуудыг авч үзвэл:

	Улс	Нэг танхимтай парламент болон парламентын доод танхимууд				Дээд танхимууд			
		Сүүлийн сонгууь болсон хугацаа	Нийт суудлын тоо	Эмэгтэй гишүүдийн тоо	Эмэгтэй гишүүдийн эзлэх хувь	Сүүлийн сонгууль болсон хугацаа	Нийт суудлын тоо	Эмэгтэй гишүүдийн тоо	Эмэгтэй гишүүдийн эзлэх хувь
1	Руанда	2008	80	45	56.30%	2011	26	10	38.50%
2	Андорра	2011	28	14	50.00%	---	---	---	---
3	Куба	2008	586	265	45.20%	---	---	---	---
4	Швед	2010	349	156	44.70%	---	---	---	---
5	Сечиллэс	2011	32	14	43.80%	---	---	---	---
6	Сенегал	2012	150	64	42.70%	---	---	---	---
7	Финланд	2011	200	85	42.50%	---	---	---	---
8	Өмнөд Африк	2009	400	169	42.30%	2009	53	17	32.10%
9	Никрагуа	2011	92	37	40.20%	---	---	---	---
10	Исланд	2009	63	25	39.70%	---	---	---	---

Руанда улс нь эмэгтэйчүүдийн квотыг амжилттай хэрэглэсэн шинэхэн жишээ болж байна. Дэлхийн улсуудын парламентууд дотроо Руанда улс эмэгтэйчүүд давамгайлсан парламентаар анх удаагаа тодроод байгаа билээ. Руандад эмэгтэйчүүдийн парламентад эзлэх хувь хэмжээ Скандинавын орнуудын үзүүлэлтээс давж гарсан шалтгаан нь парламентын доод танхимын 80 суудлын 24, дээд танхим буюу Үндэсний Ассамблейн нийт суудлын 30%-ийг шууд эмэгтэйчүүдэд олгосон 2003 онд батлагдсан үндсэн хуулийн заалт юм. Мөн эмэгтэйчүүдийн парламентад эзлэх хувь өндөр байгаа нь хувь тэнцүүлэх сонгуулийн системтэй шууд холбоотой болох нь харагдаж байна. Сүүлийн

¹⁴⁶Эмэгтэйчүүдийн квот гэдэг нь ямар нэг байгууллага, эсвэл нэр дэвшигчдийн жагсаалтын, хууль тогтоох хурал, байнгын хороодын болон засгийн газрын гэх зэрэг олон түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх тодорхой хувийг баталгаажуулах аргачлал юм.

арван жилийн дотор Руанда улсын парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөлөл бараг 36 орчин хувиар нэмэгдсэн нь тухайн улсад болсон эмгэнэлт цуст хядлагын дараах шинэ үндсэн хуулийн заалт бодит амьдралд хэрхэн нөлөөлсний жишээ болжээ.

Скандинавын улсууд нь парламент дахь эмэгтэйчүүдийн төлөөллөөрөө дэлхийн бусад улс орнуудыг байнга тэргүүлж ирсэн байна. Одоо ч эдгээр орнууд Парламент дахь эмэгтэйчүүдийн хувь нь хамгийн өндөр байдаг 20 орны тоонд багтаж байна.

	Скандинавын орнууд	Парламентын Нийт суудал	Парламент дахь Эмэгтэйчүүдийн суудал	Парламентад Эмэгтэйчүүдийн хувь
1	Швед	349	156	44.7%
2	Финланд	200	85	42.5%
3	Дани	179	70	39.1%
4	Норвеги	169	67	39.6%
5	Исланд	63	25	39.7%

<http://www.ipu.org/wmn-e/classif.htm> Situation as of **31 October 2012**

Гэхдээ Скандинавын эдгээр улсуудад эмэгтэйчүүдийн парламент дахь төлөөллийг баталгаажуулсан үндсэн хуулийн ямар нэг заалт болон бусад хуулиуд байдаггүй. Эмэгтэйчүүд улс төрийн тавцанд хүчтэй гарч ирсэн үе нь 1970 аад он бөгөөд энэ үед эдгээр орнуудад улс төрийн намуудын дүрэм ч эмэгтэйчүүдийн хувь хэмжээг зааж оруулаагүй байсан юм. Эмэгтэйчүүдийн байгууллага, иргэний нийгмийн шахалт нь Скандинавын орнуудад улс төрийн намуудынх нь хувьд хүчтэй нөлөөлсөн байна. Зүүн болон Төвийн үзэл баримтлалтай улс төрийн намууд сайн дураараа намын дүрэмдээ квот оруулж ирснээр бусад улс төрийн намуудад ч нөлөөгөө үзүүлсэн байна. 1993 онд Шведэд хоёр нэр дэвшигч бүрийн нэг нь эмэгтэй байна гэсэн зарчим дэвшүүлсэн байдаг. Өмнөд Африк болон Мозамбикт улс төрийн намууд квотын механизмыг нэвтрүүлсэн. Бүс нутгийн хэмжээнд Өмнөд Африкийн Хөгжлийн холбооны гишүүн орнууд 2005 он гэхэд Парламент дахь эмэгтэйчүүдийн эзлэх хувийг 30% хүргэх зорилт тавин ажилалсан бөгөөд үүний үр дүнд дээрх холбооны 14 гишүүн орноос дөрвөн орны Хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн төлөөлөл сүүлийн сонгуулийн дараа 30 хувиас дээш өссөн дүн гарчээ. Эдгээр орнуудын хамгийн өндөр үзүүлэлт нь Свазиландын 40 хувийн үзүүлэлт билээ.

Шийдвэр гаргах түвшин дэх эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлдэг том хөшүүрэг нь эмэгтэйчүүдийн квот болсон хэвээрээ байгааг жишээнээс харж болно.

Эмэгтэйчүүдийн квот гэдэг нь ямар нэгэн байгууллагын, эсвэл нэр дэвшигчийн жагсаалтын, хууль тогтоох байгууллагын байнгын хорооны болон засгийн газрын гэх мэт олон түвшинд эмэгтэйчүүдийн эзлэх тодорхой хувийг баталгаажуулах арга хэрэгсэл юм. Засгийн газар, парламент болон орон

нутгийн удирдлагын байгууллага гэх мэт сонгогдох болон томилогдон ажилладаг байгууллагууд дахь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх нь квотын гол зорилго болдог. Өргөн хэрэглэгддэг квотын хоёр гол төрөл бол нэр дэвшигчийн тоонд квот тавих болон тодорхой тооны суудлыг эмэгтэйчүүдэд зориулан хуваах гэсэн хоёр төрөл байдаг.

Нэр дэвшигчийн тоонд квот тогтоох нь: тодорхой нэг сонгуульд оролцож байгаа нэр дэвшигчийн дотор эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жингийн доод хязгаарыг тогтоож, улс төрийн намаас гарах нэр дэвшигчийн жагсаалтад тусгадаг.

Улс төрийн намуудын квот: Улс төрийн намууд сайн дураараа эмэгтэйчүүдийн квотыг дүрмэндээ тусгаж өгч төлөөллийг нь нэмэгдүүлэхэд чиглэдэг.

Зарим улс орнууд эмэгтэйчүүдэд хууль тогтоох байгууллагадаа тусгай суудал хуваарилдаг. Үүнийг үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор зохицуулдаг. Уганда улсад сонгуулийн тойрог бүрийн 1 суудал буюу нийт суудлын 56 нь эмэгтэйчүүдэд хуваарилагдсан байдаг байна.¹⁴⁷ Руанда улсад нийт суудлын 30 хувьд эмэгтэйчүүд тусгай горимын дагуу сонгогддог бөгөөд энэ суудлыг зөвхөн эмэгтэйчүүдэд зориулан хадгалахаар үндсэн хуулиндаа заасан байдаг. Танзани улсад нийт суудлын 20% нь эмэгтэйчүүдийн суудалд шууд хадгалагддаг бол Кени болон Арабын зарим орнуудад сонгохгүйгээр эмэгтэйчүүдийг шууд томилдог туршлага ч байна¹⁴⁸. Филиппиний эмэгтэйчүүдийн нам 100% эмэгтэйчүүдийг нэр дэвшүүлэн өрсөлддөг.

Дэлхийн улсууд эмэгтэйчүүдийн квотыг хэрэглэсэн жишээг харьцуулбал:

	Улс орнууд	Улс төрийн намуудын сайн дурын квот	Парламентын квот	
			Нэг танхимтай болон доод танхимууд	Дээд танхимууд
1	МОНГОЛ	25 % хүртэл	Нэр дэвшигчдийн 20%	-
2	Австрали	40%	-	-
3	Австри	33.3-50%	-	-
4	Канад	25-40%	-	-
5	Македони	-	Нэр дэвшигчдийн 33%	-
6	Франц	50%	19%	22%
7	ХБНГУ	40-50%	-	-
8	Итали	50%	-	-
9	Норвеги	40-50%	-	-
10	Португал	-	Нэр дэвшигчдийн 33%/27	-
11	Швед	50%	-	-
12	ИхБритани	50%	-	-
13	БуркинаФасо	-	Нэр дэвшигчдийн 15%	-

¹⁴⁷ Constitution of Republic of Rwanda, ChapterII . Legislature


¹⁴⁸Парламент дахь эмэгтэйчүүд, тоо ба агуулга. УБ. 2008

14	Брунди	-	Шууд хуваарилсан суудал 32%	Шууд хуваарилсан суудал 46%
15	Жибути	-	Шууд хуваарилсан суудал 14%	-
16	Руанда	-	Шууд хуваарилсан суудал 56%	Шуудхуваарилсансууд ал 35%
17	Сомали	-	Шууд хуваарилсан суудал 7%	-
18	Сенегал	-	Нэр дэвшигчдийн 22%	Шууд хуваарилсан суудал 40%
19	Танзани	-	Шууд хуваарилсан суудал 30%	-
20	Уганда	-	Шууд хуваарилсан суудал 31%	-
21	Израйль	10-40%	-	-
22	Энэтхэг	-	-	Шууд хуваарилсан суудал 31%
23	Индонейз	-	Нэрдэвшигчийн 18%	-
24	Флиппин	25-100%	-	-

Монгол улс 2012 оноос эхлэн Жендэрийн Эрх Тэгш Байдлыг Хангах тухай хуулийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2012 онд батлагдсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд эмэгтэйчүүдийн хувь аливаа нам эвслээс нэр дэвшигчдийн 20-иос доошгүй байна гэсэн хуулийн заалтыг оруулж ирсэн нь улс төрийн намуудын сайн дурын квотыг намын дүрмэндээ тусгасанаас илүү бодитой нөлөө үзүүлж чадсан юм. 2012 оны УИХ-ын сонгуульд нийт 11 эмэгтэй гишүүн сонгогдсон нь ардчилсан үндсэн хууль батлагдсанаас хойш хамгийн том амжилт болж байна. 1992 оны анхны ардчилсан үндсэн хууль батлагдахаас өмнө эмэгтэйчүүд Ардын Их Хуралд 20-оос доошгүй хувийг эзэлж байсан бөгөөд 1950 онд 22,4%, 1972 онд 22,9% тус тус эзлэж байсан юм.¹⁴⁹

Ардчилсан үндсэн хууль хэдийгээр эмэгтэйчүүдэд сонгох сонгогдох суурь эрхийг нь нээж өгсөн ч эмэгтэйчүүдийн төлөөлөл шийдвэр гаргах түвшинд огцом буурсан нь сонгуулийн системийн мажоритар тогтолцоо, мөн эмэгтэйчүүдийн улс төрийн намын удирдлагад эзлэх сайн дурын квот намуудын дүрэмд тусаагүй байсантай холбоотой юм. Нийгмийн шаардлага, ардчиллын бэхжилтийн үр дүнг хангах зайлшгүй шаардлагын улмаас улс төрийн нам тус бүр намын дүрэмдээ сайн дурын эмэгтэйчүүдийн квотын заалт оруулсан ч хууль тогтоох байгууллага дахь эмэгтэйчүүдийн тоо 2012 он хүртэл нэмэгдэх биш харин ч буурч байлаа.

¹⁴⁹ Цэдэнгийн Цэцэгжаргал “Монголын эмэгтэйчүүд” ХХ зуунд Хувьсал өөрчлөлт, УБ, 2005 он



2011 онд батлагдсан Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль 2012 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэгжсэн, 2012 оны УИХ-ын тухай хууль батлагдаж сонгуулийн системийг холимог тогтолцоотой болгосон, тэрчлэн аливаа нам эвслээс нэр дэвшигчдийн 20 хувиас доошгүй нь эмэгтэйчүүд байна гэсэн квотын заалтыг хуульд тусгаж хэрэгжүүлэх болсон нь Улсын Их Хуралд эмэгтэйчүүдийн төлөөлөл нэмэгдэх үндэс суурь нь болсон байна.

Хэдийгээр хуулийн заалт мөрдөгдсөн ч улс төрийн намуудын хувь тэнцүүлэх хувилбарт нэрсийн жагсаалтаар эмэгтэйчүүдийг байршуулах асуудалд жагсаалтын боломжтой хэсэгт эмэгтэйчүүдийн нэрсийг жагсаахгүй үлдээх асуудал үүссэн нь дараа дараагийн сонгуульд давтагдах магадлал мөн өндөр байгаа билээ. 2012 оны сонгуульд нийт 544 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 174 эмэгтэй нэр дэвшигч өрсөлдсөн байна.

2012 оны УИХ-ын сонгуульд өрсөлдсөн нийт 11 нам 2 эвслээс жагсаалтаар нэр дэвшигчийг харвал эхний 10-т нийт 36 эмэгтэй эрэмбэлэгджээ. Эхний арвын эрэмбэнд 3 ба гурваас дээш эмэгтэй эрэмбэлсэн 2, 2 эмэгтэй эрэмбэлсэн 7, зөвхөн 1 эмэгтэй эрэмбэлсэн 4 нам эвсэл байсан нь сонгогдох боломжтой жагсаалтад эмэгтэйчүүдийг эрэмбэлэх хандлага бага байгааг харуулж байна. Тиймээс эмэгтэйчүүдийг хувь тэнцүүлэх зарчмаар сонгогддог намын жагсаалтад эрэгтэй нэр дэвшигчидтэй тэнцүү байр суурьтай эрэмбэлэгдэхэд нам доторх эмэгтэйчүүдийн нөлөөлөл чадварыг нэмэгдүүлэх, боловсон хүчний бодлогыг сайжруулах шаардлага тулгарч байна.

Дүгнэлт

Эмэгтэйчүүд нийгэм улс төрийн эрх чөлөөгөө олж авахын тулд түүхийн урт удаан замыг туулсан юм. Дөнгөж XIX зуунд эмэгтэйчүүдийн эрхийн тухай яригдаж, XX зуунд улс төрийн эрхийн тухай тэмцэл өрнөж, XXI зуунд эмэгтэйчүүдийг улс төрийн эрхийг хангах зайлшгүй шаардлагыг хүлээн зөвшөөрчээ.

Дэлхийн олон улс хийгэд Монголын эмэгтэйчүүдийн хууль тогтоох байгууллага дахь оролцооны хөгжлийн түүхийг товчоолон дүгнэвэл:

1. 1995 онд НҮБ-ын дэлхийн эмэгтэйчүүдийн 4 дүгээр их хурал Бээжин хотод болж “Бээжингийн үйл ажиллагааны төлөвлөгөө” гэж нэрлэгдсэн баримт бичиг гаргасан бөгөөд үүнд дурдсанаар “Шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн оролцооны түвшин ялгаатай байна”, “Эмэгтэйчүүдийн хөгжлийг дэмжих механизм бүх

түвшиндээ хангалттай бус байна” гэж заасан нь эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх үйл ажиллагааг чиглүүлж өгсөн гол заалтуудын үндэс нь болжээ. Сүүлийн 18 жилийн турш ихээхэн өөрчлөлт орсон бөгөөд өнөөдөр дэлхийн хууль тогтоох байгууллагуудад эмэгтэйчүүдийн эзлэх дундаж хувь 22,4 болсон нь 1995 оны үзүүлэлтээс даруй 10%-аар илүү байгаа юм.

2. 1990 оноос квотын механизм хэрэгжиж эхэлсэн байна. 2005 он гэхэд 90 гаруй улс ямар нэг хэмжээгээр намынхаа дүрэмд буюу албан ёсоор хуулиндаа квотын тухай заасан байна. Эдгээрээс 50 гаруй улс оронд улс төрийн намууд сайн дураараа өөрийн дүрэмдээ эмэгтэйчүүдийн квотыг зарлан мэдүүлжээ.
3. Тухайн улсын сонгуулийн тогтолцоо болон квотыг хэрэгжүүлж буй механизм нь шийдвэр гаргах, хууль тогтоох түвшинд эмэгтэйчүүдийн төлөөллийг нэмэгдүүлэх гол хөшүүрэг болдогийн жишээ нь Руанда улс бөгөөд эмэгтэйчүүдийн төлөөлөл хууль тогтоох байгууллагад хамгийн өндөр буюу 56,3 % байна.
4. Монгол улс 1992 оноос хойшх эмэгтэйчүүдийн Улсын Их Хуралд эмэгтэйчүүдийн эзэлсэн хамгийн бага төлөөлөл нь 3 эмэгтэй гишүүн буюу 3,9 хувь хамгийн их нь 11 эмэгтэй гишүүн буюу 14,5 хувь байна.

Ерөнхийлөн дүгнэвэл:

Монгол улсад хууль тогтоох байгууллагад эмэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэхэд улс төрийн намуудын дүрэм дэх эмэгтэйчүүдийн квотын заалт, сонгуулийн хувь тэнцүүлсэн тогтолцоо, сонгуулийн хуулинд тусгаж өгсөн эмэгтэйчүүдийн квот мэдэгдэхүйц нөлөөлсөн гэж үзэж болно. Гэсэн хэдий ч эмэгтэйчүүдэд улс төрийн намын жагсаалтад боломжтой хувилбараар эрэмбэлэгдэх боломж төдийлөн хангалттай биш байгаа нь улс төрийн намуудад эмэгтэйчүүдийн нөлөөлөл бага, хүний нөөцийн бодлого алдагдсан байгаатай холбоотой гэж үзэж байна.

Abstract:

First Democratic states face up to women's political rights in nineteenth century. Therefore women's [representation](#) is increased in Legislatures around the world. Today, there are 20.4% of legislature houses, are women. In order to improve women's representation in the legislature is to have a woman quotation mechanism. In 2012, Mongolian Great State Khural passes new law about Election. According new election law, more than 20% of candidates are must be woman from all political parties. By [consequence of the law](#), first time in democratic election history of Mongolia, woman members became 14.5% of Great State Khural. However, We need to increase women's representation in legislature in Mongolia. In order to so, we have to change the human resource policy and raise women representation in decision making of all political parties.

Номзүй

1. Парламент дахь эмэгтэйчүүд, тоо ба агуулга. УБ., 2008
2. Цэцэгжаргал Ц. Монголын эмэгтэйчүүд ХХ зуунд: хувьсал, өөрчлөлт. УБ., 2009
3. Constitution of Republic of Rwanda, Chapter II. Legislature

4. Anna Coote "New gender agenda: Why women still want more" UK., 2000. p-86
5. Marie-Jean-Antoine-Nicolas Caritat, Marquis de Condorcet, On the Admission of Women to the Rights of Citizenship (1790), The First Essay on the Political Rights of Women. A Translation of Condorcet's Essay "Sur l'admission des femmes aux droits de Citй" (On the Admission of Women to the Rights of Citizenship). By Dr. Alice Drysdale Vickery (with preface and remarks) (Letchworth: Garden City Press, 1912).
6. <http://www.guide2womenleaders.com/>
7. <http://www.ipu.org/wmn-e/world.htm>

УЛС ТӨРД НӨӨЦ БАЯЛГИЙН ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ**Д.Мягмарсүрэн***ШУТИС-НТС ОНХА, УТС-ын профессорын багийн багш, докторант***Түлхүүр үг:** Рантье улс, неопатримониалист төр, баялгийн национализм**Оршил**

Монгол улс сүүлийн жилүүдэд ашигт малтмал, уул уурхайн салбарын тэлэлтээс шалтгаалж, нийгэм, эдийн засгийн өсөлтөөрөө дэлхий дахинд дээгүүрт бичигдэн, бүс нутгийн төдийгүй дэлхийн хүчирхэг улс гүрнүүд, үндэстэн дамнасан корпорациудын анхаарлыг ихээр татсан улс орны нэг болсон. Энэхүү хөгжил дэвшлийн эерэг үзүүлэлтийг дагалдан хүрээлэн буй орчны бохирдол, баялгийн оновчгүй хуваарилалт, баян ядуугийн ялгаа улам бүр холдож буй зэрэг сөрөг үзэгдлүүд тулгарах болов. Ялангуяа эрдэс баялгийн арвин нөөцтэй холбоотойгоор нийгмийн үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөө, ардчилсан засаглал, тогтвортой хөгжлийн хандлага зэрэг нийгэм-улс төрийн төлөвшилд эерэг сөрөгнэз бүрийн үйл явц өрнөж буйг эрдэмтэн судлаачид хийгээд олон нийт янз бүрээр илэрхийлж байна.

Нийгэм, улс төрийн тогтолцоонд байгалийн нөөц баялаг, түүний үзүүлэх үр нөлөөний тухай асуудал орчин үед онолын хийгээд практик чухал учир холбогдолтой сэдэв юм. Хорь гаран жил замнаж ирсэн ардчиллын тогтолцоонд байгалийн баялгийн үзүүлэх нөлөөнөөс шалтгаалж, эрүүл хандлагыг эвдэж, урхаг үр дагавартай, эргэж засагдах аргагүй “эмгэгтэй” улс төрийн тогтолцоо бүрэлдэх вий гэсэн болгоомжлол нэг бус ажиглагдах болов. Сүүлийн жилүүдэд ОНМХ болон судалгаа шинжилгээний өгүүлэл нийтлэлүүдэд “олигархи төр”, “улс төрийн хүчнүүдийн бэлэн мөнгөний амлалт”, “баялгийн хараал”, “гадныхантай хуйвалдсан эрх баригчид” гэх популист маягийн ойлголтууд нилээн гарах болсон. Нөөц баялгийг эрх баригч бүлэгт багтагсдын хувийн сэдэл сонирхлоор зарцуулах, “нөөц баялаг”-т гадныхны оролцоог хязгаарлах үзэл өргөжих, баялгийн оновчгүй хуваарилалтын улмаас нийгмийн хөгжил саатах зэрэг үзэгдэл, үйл явцын учир шалтгааныг гадны судлаачид хэдийнээс судалж тодорхойлж ирсэн байдаг.

Байгалийн баялаг болон ардчилсан тогтолцоо, улс төр эдийн засгийн модернизацийн хоорондын хамаарлын талаар тодорхой онол, үзэл баримтлалууд бий. Тухайлбал, нөөц баялгийн нөлөөгөөр нийгэм-улс төрийн тогтолцоо, олон нийтийн санаа бодолд гарч буй өөрчлөлтийг тодорхойлсон “неопатримониалист” болон “рантье төр”, “нөөц баялгийн үндэсний үзэл” зэрэг сөрөг үр дагавар бүхий асуудлыг тодорхойлсон ойлголт, онол хандлагууд байдаг. Эдгээр онолын хүрээнд хөндсөн улс төрийн үйл явц, хөгжлийн загвар, шинж тэмдэг Монголын өнөөгийн нийгэмд илэрхий ажиглагдах болжээ. Иймээс онолын түвшинд томьёолсон асуудлыг авч үзэх замаар Монголын улс төрийн тогтолцоонд гарч буй сорилт бэрхшээл, тулгамдсан асуудлыг тодорхойлохыг зорьлоо.

Неопатримониалист төрийн дэглэм (хувь эзэмшлийн төр)-ийн тухай ойлголт

Патримониализм (patrimonium-эзэн захирагчийн хувийн сан хөмрөг) хэмээх нэр томъёог анх германы судлаач М.Вебер болхи бүдүүлэг эдийн засагтай жижиг, тусгаарлагдмал хүй нэгдэл, нийтлэг ялангуяа колонийн үеэс өмнөх африкийн овог аймгуудын улс төрийн тогтолцоог нэрлэх зорилгоор хэрэглэсэн байна. Патримониализмын гол онцлог бол хувийн нэр хүнд, эрх мэдлээр захирдаг “том хүн” гэх ойлголт юм. Эгэл ард бол “том хүний ивгээл”-д нь багтах этгээд төдий юм.Төрийн эрх мэдэл бол хувь хүний шинж чанартай байх бөгөөд нийтийн аливаа асуудлыг хууль журмаар бус захирагчийн хүсэл сонирхлоор шийдвэрлэдэг байдгаараа онцлог.Ийм засаглалын шинж чанарыг Ромын эзэнт улс болон дундад зууны Ойрхи Дорнод дахь султаны дэглэм, ХХ зууны сталинизм, фашист болон маоист дэглэм, орчин цагийн Африкийн зарим улсаас харж болох аж.

Неопатримониализм нь уламжлалт патримониал ноёрхлын элементийг өөртөө шингээсэн нийтийн засаглалын хэв маягт хамаарах ойлголт юм. Өрнөдийн улс төрийн шинжлэх ухаанд неопатримониализмын үзэл хандлага модернизацийн сонгодог онолын хүрээнд боловсорч гарч иржээ. Судлаач Ш.Эйзенштадт“неопатримониализм”-ыг уламжлалт болон орчин үеийн дэглэмийн өвөрмөц “синтез” байдлаар Ази, Африк, Латин америкийн хөгжиж буй нийгэм дэх улс төрийн тогтолцоо, төрийн институцийн хөгжлийн загварт нийтлэг ажиглагдаж буй хэв маяг гэж тодорхойлжээ. Өргөн утгаараа неопатримониалист дэглэм бол бусармаг эсвэл алаг цоог шинжтэй модернизаци үйл ажиллагааг хэлнэ.

Украины улс төр судлаачА.А.Фисун неопатримониалист тогтолцоон дахь үйл ажиллагааны үндсэн 3 зарчмыг тэмдэглэсэн байна. Үүнд:

1. Зах хязгаараас хараат бус, тусгаарлагдмал, улс төр, эдийн засгийн болон бэлэгдэл зэрэг бүхий л нөөцийг төвлөрүүлсэн улс төрийн төвтэй. Тэрхүү нөөц, байр суурийг бусад нийгмийн давхрага, бүлгүүд ашиглахыг хаан боогдуулж, тэдгээрт хяналт тавихыг эрмэлздэг.
2. Эрх баригч бүлгийнхэн хувийн эзэмшил өмч (патримониум) адилаар төрийг удирдан залж,нийгмийн янз бүрийн институци, үүргийг төр засгийн эзэд хувьчилж, төрийг хувийн ашиг орлогын эх үүсвэрээ болгож байдаг.
3. Угсаатан, отог омог, шашин, гэр бүл төрөл төрөгсдийн хэлхээ холбоо арилддаггүй төдийгүй орчин үеийн улс төр, эдийн засгийн харилцаанд төрөл арилжуулан сэргээж, тэдгээрийн үйл ажиллагааны зарчим, арга замыг тодорхойлж байдаг.[2]

Францийн судлаач Ж.Ф.Медарнеопатримониалист тогтолцоо бий болох гол хүчин зүйлийг “гүйцэд хөгжөөгүй төр улс” (underdeveloped state) гэж томъёолсон байна. Өөрөөр хэлбэл, шилжилтийн эсвэл хөгжиж буй улс төрийн тогтолцооны загвар бус харин хэвшмэл нөхцөл болчихсон улс төрийн тогтолцооны хэлбэр юм. Ийм улс үндэсний эрх баригчдын гол зорилго бол хөгжил гэхээсээ улс төр дэх хувийн оршин тогтнолоо хангах, дэг журмыг тогтооход л чиглэж байдаг. Неопатримониалист дэглэмийн үндсэн шинж чанар бол улс төрийн хүрээгбизнесийн салбар төдий зүйл болгон хувиргах явдал юм. Ийнхүү бүх нийтийн улс төрийн салбар хүрээ хувийн мэдэлд очсноор улс төрийн нөөц нь эдийн засгийн нөөцийг олж авах арга хэрэгсэл болж, улмаар баялаг улс төрийн засаглалын эх сурвалж биш, эсрэгээр улс төрийн эрх мэдэл баяжихын уг сурвалж гэж тооцогдож эхэлдэг аж.

Монголын улс төрийн тогтолцоо “хувьчилагдсан” уу

1990-ээд оноос нийгмийн шилжилт хийсэн посткоммунист орнуудад неопатримониалист дэглэмийн хэв шинж ажиглагдаж байгаа талаар судлаачид авч үзсэн байна¹⁵⁰.

Монголд төрөл садны хэлхээ холбоо, улс төрийн нам дамнасан бизнес ашиг сонирхлын бүлэглэл, “нутгийн зөвлөл” дагасан төрийн албаны тогтолцоо, ашигт малтмал, нөөцийн ордууд дахь улс төрчдийн ил далд хэлхээ холбооны талаар нэр бүхий улс төрч, сэтгүүлч, судлаачид ярилцлага, нийтлэлээр дамжуулан асуудал хөндөх болов.¹⁵¹ Тэдний үзэж буйгаар улс төр, эдийн засгийн томоохон бодлого шийдвэр хувь хүмүүсийн явцуу эрх ашгаар тодорхойлогдох явдал илт ажиглагдах болжээ. ОНМХ дэх “олигархит төр” гэх ойлголтоор шийдвэр гаргах түвшинд улс төр-бизнесийн бүлэглэлүүдийн тохиролцоогоор үндэсний стратегийн шинжтэй нөөц баялгийг өөрсөддөө ашиглах бололцоог хангахад чиглэсэн тогтолцоог тэмдэглэсэн гэж хэлж болно. Өмнөговь аймгийн Тавантолгой, Нарийн сухайтын орд, Ховд дахь Хөшөөтийн уурхай, Сэлэнгэ аймаг дахь “Болд төмөр ерөө гол”, Сүхбаатар аймгийн “Цайрт минерал” компаниудын эзэмшиж буй стратегийн шинжтэй ордуудыг цөөн хэдэн улс төрчийн ивгээл хамгаалалт дор, хуулиас давсан гэрээний нөхцлөөр ашигладаг тухай яриа хэл цөөнгүй гардаг.

Төрийн бодлогыг явцуу сонирхлоор залах үзэгдэлд монголчуудын төрөлсөг, нутгархаг уламжлалт хандлага багагүй нөлөөлдөг. Нийгмийн хөгжлийн явцад энэхүү чанар сулрах бус харин ч өргөжих төлөвтэй болжээ. Улс төрийн тавцан дахь Увс, Ховдын бүлэглэл, Хотын фракцын ил далд нөлөөгөөр албан тушаалын хуваарилалт оногддог нь нууц биш юм. Ялангуяа улс төрийн сонгуулийн дараагаар аль нэг нутаг орныхон яам агентлаг, төрийн өмчит компаниудыг тэр чигт нь “эзэмших” явдал анзаарагддаг. 2012 оны сонгуулийн үр дүнд бүрэлдсэн засгийн газрын тэргүүн болон эрх баригч намын фракциудын нөлөөллөөр өөрсдийн хүн, төрөл төрөгсдөө зохих албанд томилох нь ердийн үзэгдэл болжээ.

Нийгэмд хувь эзэмшлийн шинжтэй төрийн үүрэг роль ихэсч, төрийн алба данхайхад нөөц баялгийн нөлөө ч багагүй үүрэг гүйцэтгэж байна. Улс орнуудын улс төрийн тогтолцооны төлөвшилд байгалийн нөөц, эрдэс баялгийн үзүүлэх сөрөг нөлөөллийн талаар америкийн улс төр судлаач Майкл Росс авч үзжээ. Тэрээр газрын тос, ашигт малтмалын экспортод тулгуурласан эдийн засаг

¹⁵⁰*А.А. Фисунк *переосмыслению постсоветской политики: неопатримониальная интерпретация*// Политическая концептология № 4, 2010. * дэлгэрүүлэн уншина уу.

¹⁵¹Доор эх сурвалжаас дэлгэрүүлэн харна уу. <http://politics.news.mn/content/137502.shtml> М.Батчимэг: “АН-д хуучин МАХН-ын Улс төрийн товчоо бий болсон байна”, <http://www.mongolianminingjournal.com/content/45487.shtml>

Л.Пүрэвбаатар: “Уул уурхайн төмөр замыг өөр категориор баривал зохистой”, <http://ganchimeg.niitlech.mn/content/4931.shtml> Б.Ганчимэг “Эрх ашгийн эрэмбээ эвхээд тавьчихсан гишүүд”, <http://baatarhuyag.niitlech.mn/content/4110.shtml> А.Баатархуяг “Үндэсний хөрөнгөтнүүдийн үндсийг таслаж болохгүй”, “Зөөлөн хүчирхийлэл”, <http://jargalsaikhan.niitlech.mn/content/4852.shtml> Д.Жаргалсайхан “Тавантолгой ба таван сорил”, <http://www.president.mn/mongolian/node/3033> “Хууль зүйн салбарын шинэчлэл” сэдэвт уулзалт чуулганыг нээж Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн хэлсэн үг, <http://www.24tsag.mn/content/10684.shtml> Х.Тэмүүжин: “Н.Энхбаяр маш том аалзны торны сүлжээг задлах гэрч болж байгаа. Тиймээс хорлогдох вий гэж айж байна.”, <http://otgonbayar.niitlech.mn/content/4731.shtml> Б.Чимид: “Энэ бүгдийг хэлэх цаг нь болжээ”

тухайн орнуудын ардчилсан хөгжлийг саармагжуулахад хүргэдэггэж дүгнээд, ардчилах үйл явцад газрын тос, байгалийн баялгаас олж буй орлогын нөлөөлөл саад учруулдаг болохыг дараах хүчин зүйлстэй холбон тайлбарласан байна. Үүнд:

1. “Татварын нөлөө эффект” багтана. Байгалийн нөөц баялагтай орнуудын засгийн газар нийгмийн хурцдмал байдлыг арилгахын тулд мөнгө санхүүг ихээр зарцуулах бөгөөд эсрэг тохиолдолд ард түмэн, нийгмийн зүгээс хариуцлага хүлээх шаардлагад дарагдах юм. Нөөц баялагтай орны эрх баригч дэглэм иргэддээ татвар оногдуулах нь “зохисгүй хэрэг”. Иймд тус улсын оршин тогтнолыг хангахын тулд экспортын орлогоо ашиглахад хүрдэг. “Татвар төлөхгүй бол төлөөлөл байхгүй” гэх сонгодог зарчмын дагуу эрх баригчид ард олны санаа бодлыг сонсож хүлээж авах, тэдний эрх ашгийн төлөөлөл шаардлагагүй болдог байна.
2. “Төрийн зарлагын нөлөө эффект”. Нөөц баялгийн орлого нь “төрийн зарлагын нөлөө”-г өсгөдөг. Энэ нь төрөөс нийгмийн “тэтгэмжийн” зардлыг өсгөх хэдий ч ардчилсан үйл явцад сөргөөр нөлөөлж эхэлдэг.
3. “Социал бүлгийн нөлөө эффект”. Нөөц баялгийн мөнгөөр хахсан эрх баригчдын дэглэм, түүнийг ашиглан бие даасан нийгмийн бүлгүүдийн төлөвшилд саад хийхийг эрмэлздэг.
4. “Залхаан цээрлүүлэлтийн нөлөө эффект” буюу нөөцийн орлогоо эрх баригч дэглэмийг хамгаалах, ардчилсан хөдөлгөөнийг дарах зорилготой цагдаа, тусгай албанд үрж эхэлдэг.
5. “Модернизацийн эсрэг нөлөө эффект”. Газрын тосны орлогын урсгал хотжилт, боловсролын түвшин, мэргэжлийн боловсон хүчний хангамжийг бууруулах нөлөөтэй юм. Өөрөөр хэлбэл, эдийн засгийн дэвшлийг хангах, иргэдийн ухамсар, өөрийгөө удирдах чадварыг дээшлүүлэх, хамтын шаардлага, үйл ажиллагааны зохицуулалтыг төлөвшүүлэх, төр засгаас хараат бусиргэний нийгмийг хөгжүүлэхэд саад учруулдаг гэсэн үг. Ийнхүү нөөц баялгийн салбарын эзэрхэл нь хөгжлийн хэвийн явцыг гуйвуулж, нийгэм улс төрийн харилцаанд хүчтэй нөлөө үзүүлдэг гэж дүгнэсэн байна.[3]

Монголын төр засаг ч нөөц баялгийн орлогоос үүдэн аяндаа данхайхад хүрч байна. Хэдийгээр нэг хүний дангаар ноёрхол шууд тогтох боломжгүй ч “хүч нөлөө”-тэй нэгний гар хөл болсон улс төрийн хүчин, бүлэглэлүүд улс төрийн тоглоомын дүрмийг тодорхойлох бололцоо бүрэлдэж байгааг үгүйсгэх аргагүй. Байгалийн нөөц баялгийн хүчин зүйл нь жижиг орны улс, эдийн засгийн шинэчлэлд сөргөөр нөлөөлсөн тохиолдол нэг бус байна. Улмаар “эрлийз” буюу хуурамч ардчилал бүрэлдсэн гашуун туршлагын талаар судлаачдын олон зохиол бүтээлд өгүүлсэн байдаг.¹⁵²

¹⁵²Дурьдсан сэдвээр гарсан зохиол бүтээл, нийтлэл өгүүллүүд: Sandbrook R. “Patrons, Clients, and Factions: New Dimensions of Conflict Analysis in Africa,” *Canadian Journal of Political Science*, Vol. 5, No. 1 (1972): 104–119; Willame J.–C. *Patrimonialism and Political Change in the Congo*. Stanford: Stanford University Press, 1972; Le Vine V. T. “African Patrimonial Regimes in Comparative Perspective,” *Journal of Modern African Studies*, Vol. 18, No. 4 (1980): 657–673; Callaghy T. M. *The State–Society Struggle. Zaire in Comparative Perspective*. New York: Columbia University Press, 1984; Joseph R. A. *Democracy and Prebendal Politics in Nigeria: The Rise and Fall of the Second Republic*. Cambridge: Cambridge University Press, 1987; Rothchild D., Chazan N. *The Precarious Balance. State and Society in Africa*. Boulder: Westview Press, 1988; Bratton M. and N. van de Walle. “Neopatrimonial Regimes and Political Transitions in Africa,” *World Politics*, Vol. 46, No. 4 (1994): 453–489; Bratton M., and N. van de Walle. *Democratic Experiments in Africa: Regime*

Дээрх хандлагын хүрээнд Монголын улс төрийн амьдралд ажиглагдаж буй үзэлдлийг нэгтгэн томъёолж болно. Үүнд:

1. Байгалийн баялаг (rent)-т баримжаалсан “улс төрийн бизнес” хандлага газар авч, улс төрийн албан тушаал, эрх мэдэл нь хувийн эдийн засгийн эрх чөлөөнд хүрэх хэрэгсэл гэж тооцох хандлага ажиглагдах болсон.
2. Төр захиргааны алба, аппарат нь улс төр эдийн засгийн өрсөлдөөний талбар болж, сөрөг бүлэглэлийнхээ хүч нөлөөг хязгаарлахад ашигладаг зэмсэг болсон.
3. Улс төр, бизнесийн салбар нь нэг цул болон бүтэцлэгдэж, улс төрийн сонгуулиар бүрэлдэх институци нь төрөл садан, нутаг усныхан, намд гавъяа зүтгэлт нэгнээ тэтгэн дэмжих (tribalism) шат дамжлага болж хувирч байна.

Тэрчлэн “хүнд сурталт неопатримониализм” буюу төрийн хүнд суртлаар бизнесийн салбарыг хянах, түүнийг ашиглан эдийн засгийн ашиг хонжоо олох сонирхол бүхий улс төрийн бүлэглэлүүдийн үйл ажиллагаа идэвхижих болов. Үүнд нам хүчнүүд доторх хийгээд нам дамнасан бүлэглэл, фракциудыг тооцож болох талтай. Жишээлбэл, Алтангадас, Хотын фракц болон бусад нэр нөлөө бүхий хувь улс төрчөөр толгойлуулсан бүлэглэлүүдийг нэрлэх байна.

Мөн “олигархийн неопатримониализм” буюу байгалийн баялагт чиглэсэн бизнес-улс төрийн бүлгүүдийн төр, хувийн хэвшлийг дамнасан сүлжээ нь төрийн шийдвэр гаргах механизмыг өөрийн ашиг сонирхолд захируулах сонирхолтой үйл ажиллагаа тодорхой хэмжээгээр ажиглагддаг. “MCS”, “Шунхлай”, “Женко”, “Ажнай”, “МАК” зэрэг томоохон компаниудын эзэд ашиг орлогын эх үүсвэрээ хамгаалах, шинэ эх үүсвэр эзэмших ил далд сонирхлын улмаас бизнесээс улс төр лүү орсныг ажиглагчидилэрхийлж байна. Ялангуяа ашигт малтмалын томоохон орд газруудад хяналт тогтоох, төрийн бодлого шийдвэрээр өөрсдийн хувь эзэмшлийн орд газруудаа хамгаалуулах эрх ашиг явж байгааг ОНМХ-ээр явж буй хэлэлцүүлэг сэдвээс бэлээхэн харж болно.

Рантье улсын (Байгалийн баялгийн рентээс хамааралт төр улс) тухай үзэл санаа

Улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцааны онолд “рантье-төр улс” (rentier state) нэр томъёогоор байгалийн нөөц баялгийн экспортын рент

Transitions in a Comparative Perspective. Cambridge: Cambridge University Press, 1997; Lindberg S. I. “Forms of States, Governance, and Regimes: Reconceptualizing the Prospects for Democratic Consolidation in Africa,” *International Political Science Review*, Vol. 22, No. 2 (2001): 173–199. Crouch H. “Patrimonialism and Military Rule in Indonesia,” *World Politics*, Vol. 31, No. 4. (1979): 571–587; Hutchcroft P. D. “Oligarchs and Cronies in the Philippine State: The Politics of Patrimonial Plunder,” *World Politics*, Vol. 43, No. 3 (1991): 414–450. Roett R. *Brazil: Politics in a Patrimonial Society*. New York: Praeger, 1984; Uricoechea F. *The Patrimonial Foundations of the Brazilian Bureaucratic State*. Berkeley: University of California Press, 1980; Zabludovsky G. “The Reception and Utility of Max Weber’s Concept of Patrimonialism in Latin America,” *International Sociology*, Vol. 4, No. 1 (1989): 51–66; Remmer K. L. “Neopatrimonialism: The Politics of Military Rule in Chile, 1973–1987,” *Comparative Politics*. Vol. 21, No. 2 (1989): 149–170; Hartlyn J. “Crisis–Ridden Elections (Again) in the Dominican Republic: Neopatrimonialism, Presidentialism, and Weak Electoral Oversight,” *Journal of Interamerican and World Affairs*, Vol. 34, No. 4 (1994): 91–144. Bratton M., and N. van de Walle. *Democratic Experiments in Africa: Regime Transitions in a Comparative Perspective*. Cambridge: Cambridge University Press, 1997

орлогоос (rent) улс үндэсний бүх болон зонхилох орлого бүрддэг улс орныг нэрлэж ирсэн. Уг онолыг 1970 онд Ираны судлаач Хуссейн Махдави (Hossein Mahdavy) анх томъёолжээ.[4] Мөн газрын тос, хий гэх мэт байгалийн нөөц арвинтай улс орнуудын зэрэгцээ валютын нөөц зэрэг санхүүгийн арга хэрэгслээр баян, тэрчлэн өөрийн стратегийн нөөц бололцоогоо (жишээлбэл, нутаг дэвсгэр дээрх томоохон цэргийн бааз) ашиглан ашиг хонжоо олдог улс үндэстнийг тодорхойлох нь бий.[5]

Египетийн эдийн засагч Хазем Беблауи (Hazem Beblawi) рантье улсыг тодорхойлох нөхцөл байдал гэдэгт:

1. Рент буюу байгалийн нөөц баялгийн нөхцөл байдал давамгайлсан,
2. Эдийн засаг гадаад рент орлогоос ихээр хамааралтай, үүнээс шалтгаалаад дотоодын аж үйлдвэрийн салбар хөгжөөгүй,
3. Хүн амын багахан хэсэг байгалийн баялгийн ихэнхийг ашиглах, хуваарилах эрх мэдлийг гартаа авсан байдаг,
4. Засгийн газар нь гадаад рент орлогын гол “эзэн” байж, хүн амд хувь хишгийг нь хүртээх гол үүрэг ролийг гүйцэтгэж байдаг гэсэн 4 шинж чанарыг онцлон тэмдэглэсэн байна.

Эдгээр орнуудын орлогын эх үүсвэр гадны хамааралтай байх агаад дотоодын аж үйлдвэр, ХАА-н эдийн засагт эзлэх хувь хэмжээ бага байдаг. Нөөцөд тулгуурласан рантье улсын хувьд ардчилал, иргэний нийгмийн хөгжүүлэхэд багагүй сорилт бэрхшээлтэй тулгардаг аж. Беблауигийн үзэж буйгаар рантье улсынуг чанараас шалтгаалаад нөөц баялагтай орнууд авторитар дэглэмтэй байх нь түгээмэл ажиглагддаг байна. Өөрөөр хэлбэл, ашигт малтмал, эрчим хүчний нөөц арвинтай улс орнуудын улс төрийн тогтолцоог бүхэлдээ “рантье” чанар тодорхойлдог ажээ. Судлаач Махдавигийн үзснээр хүн амын зонхилох хэсэг буюу масс төртэй харилцах үйл явцад ач холбогдол өгдөг болохоос эдийн засгийн урт хугацааны өсөлтийн хүчин зүйлд багахан анхаардаг буюу эсвэл ор анхаарал хандуулдаггүй байна.

“Рантье төр улс”-ын талаар үзэл баримтлалыг Ойрхи дорнод, Өмнөд америкийн судлаачид дэлгэрэнгүй судалсаны зэрэгцээ сүүлийн үед Дундад ази, Оросын эрдэмтэн судлаачид идэвхтэй анхаарал хандуулж байна.[6]

Монгол “рантье улс” мөн үү

Монголын эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувь хэмжээ жилээс жилд өсч байна. 2012 оны байдлаар Монголын ашигт малтмалын бүтээгдэхүүний экспорт нийт экспортын 96 хувийг (үүнээс 43.7% нь нүүрс, 22% нь зэсийн баяжмал, 13.7%-ийг төмрийн хүдэр, 8.7%-ийг газрын тос эзэлдэг. Цаашдаа 98%-ийг эзлэх төлөвтэй).[7] Улсын төсвийн орлогын 1/3, ДНБ-ын 25%-ийг (2016 онд 40% болох төлөвтэй), аж үйлдвэрийн бүтээгдэхүүнд уул уурхайн бүтээгдэхүүний эзлэх хувь 70 гаран хувийг тус тус эзлэх болжээ.[8] Монгол улсын эдийн засгийн үзүүлэлт үндсэндээ алт, нүүрс, төмрийн хүдрээс олох орлогоос хамаарч буй бөгөөд эдийн засгийн макро түвшин, эдийн засгийн өсөлт, инфляци, хөрөнгө оруулалт, аж үйлдвэрийн салбарын хөгжил бүхэлдээ ашигт малтмал, уул уурхайн салбараас хамаарч байна. Тэрчлэн хамгийн баян хүмүүсийн жагсаалтад уул уурхай, ашигт малтмалын үйл ажиллагаа эрхэлдэг компаний эзэд зонхилохын зэрэгцээ УИХ, засгийн газар зэрэг шийдвэр гаргах институцид ашигт малтмалын бизнес эрхэлдэг улс төрчдийн тоо улам бүр өсөх болов.

Уул уурхайн салбарын хөгжил нь нэг талаас байгалийн нөөц баялагт суурилан аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэх нөхцөл бололцоог илтгэж буй

хэдий ч ажиллах хүчний нөөц хомс, гадны хөрөнгө оруулалтын эмзэг мэдрэмтгий чанар, газар зүйн түгжигдмэл нөхцөл, дэд бүтэц, техник технологийн хоцрогдол, төрийн бодлогын тогтворгүй байдал зэрэг олон сөрөг хүчин зүйлийн улмаас тэр бүр ахицтай хөгжихгүй байна. Монгол улс эдийн засгийн девирсификацид анхаарал хандуулж, голланд өвчин, баялгийн хараат байдлаас сэргийлэх бодлого баримтлахыг эрмэлздэг. Гэвч ашиг малтмалын экспортын хязгаарлагдмал нөхцөл (нийт экспортын 93% нь БНХАУ-тай хийгдэж байна), геополитикийн эмзэг байдлаас шалтгаалаад эдийн засгийн либералчлал тэр бүр амжилттай явагдахгүй байна. Дэд бүтцийн альтернатив гарцгүйн (одоогийн ашиглагдаж буй төмөр зам нь оросын өмч) улмаас хараат эдийн засгийн тогтолцоотой болоход хүрдэг. Энэ нөхцөл байдал нь аяндаа “бүрэн рантье улс” болох төлөв рүү түлхэж буй хэрэг. Өөрөөр хэлбэл, Африк, Дундад Ази, Латин америк, Ойрхи дорнодын “түүхий эд”-д суурилсан эдийн засагтай, нөөц баялгийн экспортоос бүрэн харааторнуудтай нэг түвшинд ангилагдаж байна гэсэн үг.

Баялгийн национализм (Resource nationalism)-ын зорилго, арга хэлбэр

“Нөөцийн үндэсний үзэл” буюу баялгийн национализм нь өөрийн нутаг дэвсгэр дээрх байгалийн нөөц баялагт хяналт тавих зорилготой нийгмийн болон төр засгийн үзэл хандлагыг илэрхийлсэн ойлголт юм. Өөрөөр хэлбэл, эрдэс баялгийн салбар дахь гадны оролцоонд тааламжгүй хандах олон нийтийн уур амьсгал хийгээд төр засгийн бодлогын илрэл юм.

Эдийн засаг, улс төрийн шалтгаанаар стратегийн болон бусад ашигт малтмалыг олборлох, ашиглах асуудлаар засгийн газар хариуцлагыг өөртөө авах байдлаар асуудлыг зохицуулах янз бүрийн оролдлого хийдэг. Уг салбар дахь гадны компаниуд хийгээд улс гүрнүүдэд “мөлжүүлэхгүй” байх, тэдний оролцоог шахахын тулд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлдэг ажээ. Үүнд, гадны хөрөнгө оруулагчдын хувь хэмжээг хязгаарлах, татвар, роялтийг өсгөх, гадаадын эзэмшлийн компаниудыг үндэсний эзэмшлээр зарлах, хөрөнгийг нь шууд албадан хураах зэрэг аядуу ба хатуу янз бүрийн бодлого, арга явууллагаар илэрдэг[9]. Үүнд, 2006 онд Боливийн газрын тос, хий олборлолтын салбарыг улсын мэдэлд авах үйл ажиллагаа, Венесуэлын 2007, 2011 онд гадныхөрөнгө оруулалттай газрын тос, алт олборлогч компаниудыг шахах бодлого, Аргентины газрын тосны компанийг үндэсний мэдэлд шилжүүлэх үйл явцыг нэрлэж болно.

Байгалийн баялагтай холбоотой үндэсний үзэл түүхий эд, бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн ханш өсч буй үед өргөжих хандлагатай нь ажиглагддаг. Тухайлбал, алт, зэсний дэлхий зах зээлийн үнэ ханш өсөх хандлагатай байсан 2007 онд УИХ-ын хэсэг гишүүдээс 68%-ийн гэнэтийн ашгийн татварыг санаачлан батлуулж байсан. Өөрөөр хэлбэл, улс орны эдийн засгийн салбар уул уурхайн экспортын орлогоос хамааралт байдал буюу рантье улсын байр суурь нь ийнхүү улс төржих нөхцөл байдал руу түлхэхэд хүрдэг ажээ. Энэ нь нөөц баялгийн экспорт нь тухай орны хүн хийгээд улс төрчдийн хувьд гадныханд “ашиглуулаад” байгаа мэдрэмж байнга төрж байдагтай холбоотой. Ялангуяа колони байсан орнууд болон бүс нутагт геостратегийн өрсөлдөгч олонтой жижиг орнуудын хувьд уг асуудалд эмзэг мэдрэмтгий байх нь ажиглагддаг. Уг үзэгдэл, Дундад азийн болон Латин америкийн орнуудын иргэд төдийгүй эрх баригчдын түвшинд хурцаар илэрдэг.[10]

Зөвхөн хөгжиж буй орнууд төдийгүй хөгжингүй улс гүрнүүдийн хувьд гадны өрсөлдөгч улс үндэсний эсрэг хориг хязгаар тавих нь олшрох болжээ.

Ялангуяа дэлхий дахинд улс төр, эдийн засгийн байр суурьнь улам бүр тэлж буй Хятадын оролцоог хязгаарлах оролдлого дэлхийн өнцөг булан бүрт илэрч байна. Тухайлбал, 2005 онд Тайландын эрх баригчид хятадын “CITIC Resources Holdings” компаниас “ThaiPetrochemical Industry PLC” корпорацийг 900 сая ам.доллараар авах үйл ажиллагааг таслан зогсоож байсан. Мөн онд АНУ-ын конгрессоос Хятадын “CNOOC” нефтийн компаниас Америкийн газрын тосны “Unocal” компанийг 18.5 сая ам.доллороор авах гэснийг хязгаарласан тогтоол баталсан. Үүнийгээ үндэсний эрх ашиг, эрчим хүчний аюулгүй байдалд эрс хохиролтой зүйл болох байсны улмаас гэж тайлбарласан аж. Мөн 2008 онд “China Oilfield Services” компани Оросын газрын тосны “ТНК-ВР” хязгаарлагдмал хариуцлагатай нийгэмлэгийн охин компанийг 65-70 сая ам.доллороор худалдаж авах гэснийг Холбооны монополийн эсрэг албанаас ямар нэг тайлбаргүйгээр болиулсан зэрэг жишээ баримтыг дурьдаж болно.

Монгол дахь ашигт малтмал тойрсон үндэсний үзэл

Эрдэс баялгийн эрэл хайгуул, олборлох, ашиглахтай холбоотойгоор үүссэн асуудлаар орон нутгийн иргэд болон компаниудын хооронд маргаан мэтгэлцээнээс аваад зөрчил тэмцэл үүсэх явдал улам бүр олшрох болов. Гадны хөрөнгө оруулагчдад сэжигтэй хандах, томоохон орд газруудыг төрийг мэдэлд үлдээх зэрэг сүүлийн жилүүдэд уул уурхайн хөгжил дагасан нийгэм, улс төрийн асуудлууд цөөнгүй гарсан. Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаад дотоодын компаниудыг хянах, үйл ажиллагааг нь хязгаарлах зорилгоор байгуулагдсан орон нутгийн шинжтэй хийгээд үндэсний хэмжээний иргэний хөдөлгөөн, ТББ-ууд олноор үйл ажиллагаа явуулж байна. Тэдгээрийн зарим нь илэрхий эрүүгийн шинжтэй үйлдэл хийж, буу зэвсэг ашигласан явдал нь асуудал нилээн хурцдмал түвшинд хүрсний илрэл юм. Тухайлбал, 2010 онд “Гал үндэстэн холбоо” ТББ-ын гишүүд гадны хөрөнгө оруулалттай “Сентерра Гоулд” компанийн техник хэрэгсэл рүү буудсан хэргийн улмаас эрүүгийн хэрэг үүсгэж байсан.[11] Эдгээр иргэний хөдөлгөөнүүд нь уул уурхайн улмаас байгаль орчинд учруулж буй уршиг, үр дагаврын эсрэг тэмцэж буй нэртэй ч хэрэг дээрээ илэрхий гадныхныг гадуурхах, шахах үйлдлийг янз бүрийн байдлаар илэрхийлж байдаг.

Улс төрчид, нам хүчнүүдийн хувьд нөөц баялгийн үндэсний үзэл нь олон нийтийн дунд нэр хүндээс өсгөх, легетим чанараа хангах хэрэгсэл төдийгөөр ашиглах нь олонтаа. Улс төрийн сонгуульд өрсөлдөж буй нам хүчин, нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөрт байгалийн нөөц баялагт төрийн оролцоо болон иргэдийн хяналтыг сайжруулах асуудал цөөнгүй хөндөгдсөн байдаг. Тухайлбал, МАХН-МҮАН-ын “Шударга ёс эвсэл” 2012 оны УИХ-ын сонгуулийн хөтөлбөртөө “...ард түмний баялаг болох Оюутолгой, Тавантолгой, бусад стратегийн орд, байгалийн баялгийг гадныхантай хуйвалдаж, үнэгүйдүүлэн гадагш нь урсгаж өнөө ба ирээдүйн үндэсний эрх ашиг ноцтой хохирч байгаа”-г дурьдаад, “Монгол Улс байгалийн баялагаа захиран зарцуулахыг баталгаажуулсан эрх зүй, зохион байгуулалт, хяналт, шалгалтын иж бүрэн тогтолцоог бий болгох. Баялгийн хуваарилалтийг хүртээмжтэй, шударга болгон өөрчилж, баялагтаа ард иргэд нь эзэн суух нөхцөлийг хангах, Монголчууд баялагтаа эзэн суух...” зэрэг үндсэрхэг популист амлалтуудыг өгсөн байна.

Дэлхийн хэмжээний алт зэсийн том орд тооцогдож буй Оюутолгойн гэрээтэй холбоотой хэлэлцүүлэг өрнөсөөр байна. Тус ордод хөрөнгө оруулсан гадны компанийн хувь оролцоог хязгаарлах, гэрээний зүйл заалтыг эргэж харах

асуудал нь олон нийтийн дунд төдийгүй шийдвэр гаргагчид, судлаач шинжээчдийн дунд томоохон маргааны сэдэв юм.

Монголын төр засаг, шийдвэр гаргах түвшинд гадны хөрөнгө оруулалтыг хязгаарлах, хумих бодлого үйл ажиллагаа нэг бус явуулж иржээ. Жишээлбэл, 2007 онд УИХ-аас баталсан “Монголын стратегийн ач холбогдолтой орд газрын жагсаалт” хэмээх баримт бичгийн гол зорилго нь эдгээр ордуудад гадны хөрөнгө оруулалтын хувь хэмжээг бага түвшинд байлгахад чиглэсэн бодлого юм. Монголын засгийн газраас стратегийн ордын тоог цаашдаа улам бүр нэмэх байр сууриа илэрхийлсэн. Олон улсын жишгээр бол “стратегийн орд газар” гэдэг нь гадны хөрөнгө оруулалтыг аль болох ихээр татах, үр өгөөж өндөртэй гэдгийг итгүүлэх, хамтран ажиллах сонирхолтойгоо дэлхий дахинд нээлттэй зарлахад чиглэсэн ойлголт юм.

Эрдэс баялаг тойрсон дээрх үндсэрхэг үзэл нь нэг талаас ашиг малтмал, уул уурхайн салбар улс төржилтөд хамгийн түрүүн өртдөгөөс үүдэлтэй. Хоёр том хөршөөр хүрээлэгдсэн жижиг улсын хувьд хятадад дургүйцэх уламжлалт үзэл, дотоод гадаад бодлогод оросын хүч нөлөө орохоос сэрэмжлэх хандлага нь “баялгийн национализм” тэлэхэд багагүй нөлөөлөл үзүүлдэг.

Нөгөө талаар баялгийн национализм нь ашигт малтмалын үйл ажиллагаанаас үүдсэн хүрээлэн буй орчин, нийгэм соёл, ахуйн хувьд учруулж буй уршиг, үндэсний бүрэн эрхэт байдалд гадны хүч нөлөөлөл орохын эсрэг зүй ёсны хариу үйлдэл, “дархлаа” юм. Гэсэн хэдий ч гадны хөрөнгө оруулалтыг үргээх, тухайн орны олон улсын нэр хүндэд тааламжгүйгээр нөлөөлж, улмаар эдийн засгийн өрсөлдөөн, либерал хандлагад сөрөг нөлөө үзүүлдэг эрүүл бус үзэгдэл болохыг хэлэх хэрэгтэй.

Дүгнэлт

Байгалийн нөөц баялаг нь нийгэм эдийн засаг, аж үйлдвэрийн салбарын хөгжилд чухал хүчин зүйл болдог хэдий ч улс төрийн ардчилсан тогтолцооны төлөвшилд нэг бус тааламжгүй нөлөө үзүүлдэг болохыг тодорхой онол, үзэл баримтлалын хүрээнд тайлбарлан авч үзжээ. Өөрөөр хэлбэл, төр улсын рантье хэв маяг, неопатримониалист улс төрийн тогтолцоо, нөөцийн баялгийн националист хандлагын “хоршил” нь улс орны тогтворт байдалд сөргөөр нөлөөлж, улс төрийн эрүүл бус хандлага газар авах, ардчилал, иргэний нийгмийн хөгжлийг сулруулан, нийгэм эдийн засгийн хувьд эмзэг мэдрэмтгий болоход хүргэдэг. Энэ нь өргөн утгаараа улс үндэсний аюулгүй, бүрэн эрхэт байдалд аюул занал учруулах эрсдэлтэй гэсэн үг юм.

Дээрх онол хандлагын хүрээнд дэлхийн улс орнуудын туршлага, учирсан саадбэрхшээлийг даван туулах бодлого, үйл ажиллагааг судлан тодорхойлж, Монгол улсын хувьд ардчилсан нийгэм, улс төрийн тогтолцоо, зах зээлийн эдийн засагт шинэ тутам тулгарч буй сорилт бэрхшээлийг даван туулах арга замыг дэвшүүлэх шаардлага хэрэгцээ тулгамдаж буй хэмээн үзэж байна.

Монгол Улсын Үндсэн Хуулиар тодорхойлсон хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилгын хүрээнд улс төр, эдийн засгийн модернизацийг гүнзгийрүүлж, нийгэм, улс төрийн тогтолцоонд рационал, эрүүл хандлагыг төлөвшүүлж, төрийн бодлого, үйл ажиллагаанд ул суурьтай, судалгаатай хандах явдлыг өргөжүүлэх зэрэг концептуаль асуудлуудыг хэрэгжүүлэх нь нэн чухал юм. Тэрчлэн эдийн засаг нэг салбараас хамааралтай байдлыг хязгаарлахын тулд диверсификацийг тэлэх, нийтийн албаны хуулийн үзэл санаандтусгагдсан ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах ажлыг тууштай хэрэгжүүлэх, уул уурхайн салбар ил тод байдлыг сайжруулах, эрдэс баялгийн

салбарын бодлого үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зэрэг практик зорилго зорилтуудыг цогцоор нь шийдвэрлэх шаардлага өнөөгийн нөхцөл байдлаас урган гараад байна.

Annotation

Many modern theories prove that natural resources significantly affect socio-economic and industrial development meanwhile negatively affects democratic political establishment. Theories such as “state rentier”, “neopatrimonialism”, “resource nationalism” are socio political synthesis which negatively affects political sustainability and leads to unhealthy/unsound political trend, weakening democracy and civil society which increases sensitivity of socio-economic conditions. Above mentioned feature, phenomenon and process are often met of today’s Monoglian socio-political system which author tried to emphasize in this Article.

Ашигласан ном, материал

- [1] W. Ostrowski, “Comparative Politics of Energy and Minerals: Concepts, Debates and Gaps,” POLINARES working paper n., vol. 8, p. 19, 2010.
- [2] А. Фисун, “К переосмыслению постсоветской политики: Неопатримониальная интерпретация,” Политическая концептология, vol. № 4, pp. стр-165, 2010.
- [3] Т.Фридман, “Первый закон петрополитики: Уровень демократии обратно пропорционален уровню цен на нефть,” [Online]. Available: <http://www.inosmi.ru/world/20060503/227213.html>.
- [4] R. Dannreuther, “International Relations Theories: Energy, Minerals and Conflict,” POLINARES working paper , vol. 8, p. 13, 2010.
- [5] К. Я. и. д. В.С. Лисин, Институциональные ограничения современного экономического роста, vol. — 640 с, — М.: Издательский дом «Дело» РАНХиГС, 2011, pp. Стр-225.
- [6] W. Ostrowski, “Rentierism, Dependency and Sovereignty in Central Asia,” in 61st Political Studies Association Annual Conference, Novotel London West, 2011.
- [7] СЭЗЯ Монгол улсын 2012 оны төсвийн орлогын мэдэгдэл, УБ. 2013.
- [8] Монгол улсын 2013 оны төсвийн танилцуулга МУЗГ УБ, 2012.
- [9] P. Leon, “The rise of resource nationalism and what it means for foreign investors,” in Second International Congress on Mining Law, Salvador, Bahia, Brazil, 2012.
- [10] E. Stoddard, “The Resource Curse - Resource Nationalism Nexus: Implications for Foreign Markets,” Journal of energy security, November 2012.
- [11] Duulin, “Монгол яллаа!!!” 2011. [Online]. http://gal-undesten.blogspot.com/2012/06/blog-post_14.html.

УЛС ТӨРИЙН НАМЫН ВЭБ САЙТАД ¹⁵³ХИЙСЭН АНАЛИЗ**Т. Туяачимэг***МУБИС-ийн Улс төр судлал, социологийн тэнхмийн багш, докторант*

1992 онд батлагдсан шинэ үндсэн хуульд зааснаар Монгол улс олон намын үйл ажиллагааг хүлээн зөвшөөрдөг. Улс төрийн намууд сонгогчидтой харилцахад вэб сайт ашиглах нь бүрэн нээлттэй бөгөөд өрсөлдөөнт үйл ажиллагаа болж байна. 2012 оны УИХ-ын сонгуулийн тухай хуульд орсон сонгуулийн системийн өөрчлөлт нь улс төрийн намуудыг иргэд, сонгогчдод нээлттэй бөгөөд идэвхитэй үйл ажиллагаа явуулахыг шаардсан гэлтэй. Өөрөөр хэлбэл парламентын 28 суудалд сонгогчдоос намуудад өгсөн саналын хувиар намын нэрсийн жагсаалтаас гишүүд сонгогдохоор болсон. Улс төрийн намууд өөрсдийн зорилго, үйл ажиллагааг сонгогчдод сурталчилж тэдний дэмжлэгийг олж авахад идэвхийлэх боллоо.

Улс төрийн коммуникацийн практикт интернэтэд суурилсан харилцааны янз бүрийн суваг ашиглах болсоны нэг илрэл нь дэлхийн улс төрийн намууд коммуникацийн шинэ суваг болох улс төрийн намын вэб сайт ашиглах нь түгээмэл боллоо. Энэхүү өгүүлэл нь “Интернэт улс төрийн коммуникацийн шинэ суваг болох нь”¹⁵⁴ сэдэвт өгүүллийн үргэлжлэл бөгөөд улс төрийн намын вэб сайтад анализ хийсэн эмпирик судалгаанд үндэслэсэн юм.

Улс төрийн нам олон нийт, сонгогчтой харилцах хэрэгсэл болсон вэб сайтыг судлах нь ямар ач холбогдолтой вэ?

Нэг. Улс төрийн намын вэб сайтыг судлах арга зүйн тухайд

Улс төрийн намын вэб сайтын талаарх судалгааны ажлуудыг ерөнхий байдлаар тоймлож үзвэл уг ойлголтыг судлагдахууны талаас нь ялгаатайгаар судалсан байна. Үүнд:

Нэгд. Улс төрийн намын вэб сайтын тоон өсөлтийг хэмжсэн статистик судалгаа. Энэ нь судалгааны эхэн үед хийгдсэн бөгөөд арга зүйн анхдагч хувилбар гэж хэлж болно. Улс төрийн намууд яагаад интернэт орон зайд шилжиж байна вэ? Энэхүү шилжилт ямар тоон давтамжтай явагдаж байгааг судалдаг. Аргагүйн хувьд олон улс орныг судалгаанд хамруулдаг учраас харьцуулсан судалгааны онол, арга зүйн загварт тулгуурладаг. 2007 онд дэлхийн өндөр хөгжилтэй болон хөгжиж буй 196 оронд хийсэн судалгаагаар¹⁵⁵ 3084 улс төрийн намыг хамруулсан бөгөөд тэдгээрийн 48% нь үйл ажиллагаандаа вэб сайт ашиглаж байсан байна. Энэ тоо 2000 онд 1284 улс төрийн намын 39%, 2005 онд 1668 улс төрийн намын 46% нь вэб сайт ашиглаж

¹⁵³ Тайлбар: “Вэб сайт” хэмээх холбоо үг нь Монгол хэлээр “Сүлжээний байрлал” гэж орчуулагдах хэдий ч энэхүү орчуулсан утгаар хэрэглэх нь ойлголтын зөрүү үүсгэх вий хэмээн таамаглаж нийтэд орчуулагагүй хэрэглэж заншсан вэб сайт гэсэн хэлбэрээр нь өгүүлэлдээ хэрэглэв. Цаашид хэл шинжлэл талаас болоод орчуулгын хувьд Монгол хэлнээ хэрхэн хэлж, хэрэглэж занших талаар нягтлууштай болохыг судлаачын зүгээс цохон тэмдэглэж байна.

¹⁵⁴ “Улс төр судлал, социологийн асуудал”. Эрдэм шинжилгээний бичиг. МУБИС, Улс төр судлал, социологийн тэнхим. УБ., 2012 №1 хуудас 86-96

¹⁵⁵ Routledge Handbook of Internet Politics. Andrew Chadwick, N. Howard. Copyright. USA., 2009

байсан гэсэн харьцуулсан судалгааны дүн гарчээ. Үүнээс үзэхэд дэлхийн улс орнуудад улс төрийн намууд улс төрийн коммуникацийн практикт вэб сайт ашиглах байдал тооны хувьд жил ирэх бүр өсөж буй дүр зураг харагдлаа.

Хоёрт. Улс төрийн намын вэб сайт нь сонгуулийн кампанит ажлын хэрэгсэл болох талаас нь судалсан улс төрийн коммуникацийн судалгаа. Улс төрийн намууд болон нэр дэвшигчид сонгуулийн үед сонгогчидтой идэвхитэй байнгын харилцаа тогтоох нэгэн хэрэгсэл нь интернэт дахь вэб сайт болж байдаг. Интернэт сүлжээний давуу талыг ашиглан сонгуулийн сурталчилгаа хийх, сонгогчидтой харилцахад ашиглаж байгаа улс төрийн нам болон нэр дэвшигчийн зүгээс хийдэг цогц үйл ажиллагааг вэб кампанит ажил (web campaigning, e-campaigning) гэж нэрлэх нь бий. Вэб кампанит ажил гэдэг нь сонгуулийн үед ашиглаж байгаа улс төрийн нам, нэр дэвшигчийн интернэт дахь вэб сайтын бүтэц, хэлбэр, агуулга дизайн нь сонгогчид шийдвэр гаргахад нь нөлөөлөх зорилготой хийгддэг олон төрлийн улс төрийн сурталчилгаа, улс төрийн маркетинг, олон нийт рүү чиглэсэн PR-ийн үйл ажиллагааны нэгдэл байна.

Улс төрийн намын вэб сайтыг сонгуулийн кампаний коммуникацийн хэрэгсэл болох талаас нь судалсан судалгааны үр дүнгээс харахад намын вэб сайт нь сонгуулийн үед өөрийн хэлбэр, бүтэц, мэдээллийн агуулгаа өөрчилж байдаг байна. Тухайлбал, мэдээлэл нь эмэгтэйчүүд, залуу сонгогчид, улс төрийн намыг тойрон хүрээлэгчдэд зориулсан агуулгатай байх бөгөөд уламжлалт, хуурмаг шинжтэй мэдээллээс бүрддэг¹⁵⁶ ажээ.

Гуравт. Улс төрийн намын систем талаас нь судалсан судалгаа. Намууд хоорондын шударга өрсөлдөөнийг нөхцөлдүүлэх орчин нь мэдээллийн чөлөөт орон зай интернэт болж байна. Бодит улс төрийн практикт улс төрийн намын систем хатуу тогтсон байхын дээр улс төрийн амьдралд тус системд ноёлох байр суурьтай улс төрийн намууд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байдаг. Харин интернэт сүлжээ бол энэхүү бодит ертөнц дэх улс төрийн намын системийг эвддэг. Интернэт бол иерархи бус орон зай юм.

Дөрөвт. Улс төрийн намын вэб сайт ардчилах үйл явцад үзүүлэх нөлөөг тодорхойлох судалгаа. Улс төрийн үйл явц цахим сүлжээнд шилжсэн нь дэлхийн улс түмэн төр засгаа сонгон бүрдүүлэх, улс төрийн эрхээ эдлэх болон цахим сүлжээ ардчилах үйл явцад хэрхэн нөлөөлж байгааг судлах дижитал ардчилал¹⁵⁷, электрон ардчила¹⁵⁸ зэрэг судлагдахууны шинэ аспект хэдийнээ бий болжээ. Тэгвэл тус өгүүлэлд судлан тодорхойлох гэж буй улс төрийн намын вэб сайт нь электрон ардчилалыг хөгжүүлэх хөдөлгүүр болохыг судлаачид¹⁵⁹ тэмдэглэжээ. Улс төрийн намын вэб сайтыг судалсан судалгааны ажлуудаас тоо хэмжээ, цар хүрээгээрээ түүний ардчилах үйл явцад үзүүлэх нөлөөллийг асуудлыг хөндсөн байдаг. Тухайлбал, орчин үед улс төрийн институци интернэтэд шилжилт хийгээд зогсохгүй ардчилах үйл явц мөн ийнхүү шилжиж байна. Иргэдийн улс төрийн оролцоо, нийгмийн харилцан үйлчлэл өсөн

¹⁵⁶ Political Parties and the Internet: Net Gain. R. K. Gibson, Paul Nixon, Stephen Ward. Copyright. London., 2003

¹⁵⁷ The Myth of Digital Democracy. Matthew Hindman. Copyright. New Jersey., 2009

¹⁵⁸ Social Informatics: An Information Society for All: In Remembrance of Rob Kling. Jacques Berleur, Markku I. Nurminen, John Impagliazzo. Copyright. USA., 2006




¹⁵⁹ Democratic Governance and New Technology: Technologically Mediated innovations in political practice in western Europe. Jens Hoff, Ivan horrocks, Pieter Tops. Copyright. USA., 2005

нэмэгдэх, эрчимжих, идэвхижихэд интернэт сүлжээ эерэг нөлөө үзүүлж байна хэмээх “кибр оптимистууд” үздэг.

Эдгээр өөр хоорондоо ялгаатай аргагүйн асуудал нь улс төрийн намын вэб сайтыг судлах ач холбогдлыг бага боловч тодорхойлж чадсан болов уу. Харин миний хувьд аль хандлагыг судалгаандаа сонгон баримтлах вэ? гэсэн асуулт урган гарсан. Монголын улс төрийн намуудын вэб сайтыг судлахад өсөлтийг хэмжсэн тоон судалгаа хийх боломжгүй бөгөөд судалгааны энэ чиглэл нь нэгж улс орны намуудыг биш харин холбооны улс эсвэл тив, бүс нутгийн хэмжээнд хийгддэг онцлогтой. Улс төрийн системийн талаас нь судална гэж үзвэл Монгол дахь улс төрийн гурав ба түүнээс олон улс төрийн намын сүүлийн 5 жил тасралтгүй ажилласан вэб сайт бидэнд хэрэгтэй болно. Энэ шаардлагыг хангах улс төрийн намын вэб сайт байхгүй байна.


Улс төрийн коммуникацийн судалгаанд улс төрийн намууд интернэт сүлжээг ашиглах нь улс төрийн үйл явцад эерэг нөлөө үзүүлдэг болохыг А.Колеман (2003), П.Норрис (2008), Д.Лилкер (2009) нарын судлаачид тэмдэглэсэн. Тус судалгаа нь аргагүйн дээрх чиглэлүүдээс улс төрийн намын вэб сайтыг улс төрийн коммуникацийн хэрэгсэл болох талаас нь анализ хийх “Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар¹⁶⁰” –т тулгуурласан болно. Америкийн “Рочестер технологийн хүрээлэн”-ийн судлаач П.Фербер, Ф.Флотц нар судлаач Мак Милланы¹⁶¹ интернэт сүлжээн дэх хүмүүс хоорондын харилцан үйлчлэлийн дөрвөн талт загварыг илүү нарийвчлан улс төрийн институт, улс төрийн нам нь өөрийн вэб сайтаар олон нийтэд мэдээлэл түгээгээд зогсохгүй интернэт орчин дахь хүмүүс хоорондын улс төрийн аливаа асуудлаарх хэлэлцүүлэгийг удирдан чиглүүлэх, өдөөх, тэрхүү хэлэлцүүлэг явуулах боломж бүрдүүлэх үүргийг гүйцэтгэх нь зүйтэй хэмээн үзжээ. Иймийн тул “Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар”-г томьёолжээ.

Хүснэгт. 1 Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар

		Коммуникацийн чиглэл		
Хүлээн авагчын хяналт		Нэг чиглэлтэй	Хоёр чиглэлтэй	Гурван чиглэлтэй
		Хариу үйлдэлт	Олон талын оролцоот дискурс	Олон нийтийн оролцоот дискурс
Дээд түвшинд				

¹⁶⁰ Cyberdemocracy and Online Politics: A New Model of Interactivity. Paul Ferber, Franz Foltz, Rudy Pugliese. “Bulletin of Science, Technology & Society”. Vol. 27, No. 5, October 2007., p. 391-400

¹⁶¹ A four-part model of cyber-interactivity. McMillan, S. J. New Media & Society. Copyright., 2002. № 4(2), p. 271-291




Тайлбар: S- Sender Илгээгч, R-Receiver Хүлээн авагч, P-Participant Оролцогч


Дээрх “Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар”-ыг Швейцарийн Бернийн их сургуулийн М.Фарефел, С.Нокс нарын судлаачид¹⁶² Швейцарийн улс төрийн намын вэб сайтад анализ хийхдээ туршжээ. Тухайлбал, зургаан талт харилцан үйлчлэлийн загвар нь улс төрийн намын сонгуулийн кампанид ашиглаж байгаа вэб сайт болон улс төрийн намын өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж байгаа вэб сайтын аль алинд нь анализ хийж болдогоороо давуу талтай юм.

Монголын улс төрийн намын вэб сайтад анализ хийхэд түүнийг сонгуулийг кампаний хэрэгсэл гэж үзэх нь цаг хугацааны хувьд саад бэрхшээл байсан учраас улс төрийн намууд өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглаж буй вэб сайтад анализ хийлээ. Ингэхдээ Монголын улс төрийн системд ноёлогч байртай түүнчлэн сүүлийн нэг жилд вэб сайт нь тогтмол ажиллагаатай МАН-ын www.nam.mn, АН-ын www.demparty.mn зэрэг вэб сайтыг судалгааны объектоор сонгосон.

Зураг. 1 Монгол ардын намын вэб сайтын нүүр хуудас \ www.nam.mn \



Зураг. 2 Ардчилсан намын вэб сайтын нүүр хуудас \ www.demparty.mn \




¹⁶² Proceedings of the 10th European Conference on E-Government: National Center for taxation studies and university of Limerick, Ireland. Dave O'Donnell. Copyright. UK., 2010. p. 511-520

Хоёр. Судалгааны дүн

Монголын улс төрийн намуудын вэб сайтад намаас сонгогч, олон нийтэд мэдээлэл түгээх 10 үзүүлэлт, намын дотоод сүлжээг шалгах 1 үзүүлэлт, намын нөөц, дэмжигчдийг өөртөө элсүүлэх боломжтой эсэхийг хэмжсэн 6 үзүүлэлт, сонгогчид намын вэб сайтаар дамжуулан намтай харилцах бололцоог хангасан эсэхийг хэмжих 20 үзүүлэлт, вэб сайтыг мэргэжлийн дизайнчлалыг шалгах 6 үзүүлэлт тус бүрээр нийт 43 үзүүлэлтийг анализ хийхэд ашигласан. Ерөнхий дүнг үзүүлбэл:


Диаграмм. 1 МАН, АН-ын вэб сайтын анализийн дүн



МАН ба АН интернэтийн вэб сайтыг иргэд, сонгогч дэмжигчидтэй харилцах улс төрийн коммуникацийн хэрэгсэл болгон ашиглаж байна уу гэдэг асуултад нийт 43 шалгуур үзүүлэлтээс МАН 18, АН 19 үзүүлэлтийг хангажээ. Ерөнхий байдлаар дээрх хоёр намын вэб сайт ойролцоо тоон үзүүлэлттэй харагдаж байгаа хэдий ч үзүүлэлт тус бүрээр авч үзвэл ялгаатай байдал ажиглагдсан.

Намын вэб дизайныг хэмжсэн 6 үзүүлэлтээс АН-ын сайт 4-г, МАН-ын сайт 5-г хангасан байсан нь Монголын улс төрийн намын сайтын вэб дизайн мэргэжлийн түвшинд байгааг илтгэж байна. Харин улс төрийн намуудын вэб сайт иргэд, сонгогчдод мэдээлэл түгээх хэрэгсэл болж байгаа эсэхийг хэмжих 10 үзүүлэлтээр анализ хийж үзвэл дараах дүн гарсан. Үүнд:

Диаграмм. 2 Улс төрийн намууд вэб сайтаар дамжуулан мэдээлэл түгээж буй байдал




Монголын улс төрийн намын вэб сайт нь иргэдэд улс төрийн боловсрол олгох, тэдний улс төрийн оролцоог хангах боломж олгох, улс төрийн аливаа асуудлаарх нээлттэй хэлэлцүүлэг өрнүүлэх бололцоог бүрдүүлсэн байх зэрэг шалгуурыг хангасан гэхээсээ илүүтэй олон нийт намын вэб сайтыг мэдээлэл түгээх оновчтой хэрэгсэл болж байна гэж дүгнэдэг. Гэтэл анализийн дүн чамлахаар үзүүлэлттэй гарч байна. Нам тус бүрээр харвал АН, МАН-ыг бодвол вэб сайтдаа иргэдэд зориулсан мэдээллийн “Хайлтын цонх”-той байгаагаараа давуу талтай байв. Тэгвэл намын дотоод сүлжээг хэмжсэн үзүүлэлтийг тус хоёр нам хангасан бөгөөд иргэд олон нийт, залууст нээлттэй Facebook холболтыг вэб сайтдаа хийжээ.

АН, МАН нь вэб сайтдаа гишүүнчлэл, хандивийн талаарх ерөнхий мэдээлэл багтаасан боловч гишүүнчлэл болон намд хандив өгөхтэй холбоотой иргэдийн санал, хүсэлт, шууд асуултыг авах онлайн хуудас байгаагүйн дээр намд өгсөн хандивийн талаарх мэдээлэл олж авах боломжгүй байдлаар дизайн хийжээ. Харин АН онлайнаар гишүүн элсүүлэх тохиргоотой байснаараа МАН-аас ялгарч байсан.

Улс төрийн намын вэб сайт нь коммуникацийн хэрэгсэл болохынхоо хувьд зөвхөн сонгуулийн кампанит ажлын үед гэлтгүй сонгуулиас бусад үед ч улс төрийн намын үйл ажиллагааг иргэд, сонгогчидод таниулж байх учиртай. Түүнчлэн “Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар”-т вэб сайт нь иргэдийн улс төрийн оролцоог хангах боломжтой эсэх нь коммуникацийн гурван чиглэлтэй, дээд түвшний харилцааг илтгэх чухал үзүүлэлт болох юм. Иймээс анализ хийсэн 43 үзүүлэлтийн 20 нь иргэд намын үйл ажиллагаанд идэвхитэй оролцох боломжоор хангасан эсэхийг хэмжих үзүүлэлт байлаа.

Диаграмм. 3 МАН, АН-ын вэб сайт иргэдийн улс төрийн оролцоог хангаж буй эсэхийг хэмжсэн анализийн дүн



Дээрх диаграммаас харахад намууд ижил хувьтай үзүүлэлтийг хангасан хэдий ч зөвхөн нам тус бүрт ялгаатай байсан үзүүлэлтийг авч үзье.

Хүснэгт. 2 Иргэдийн улс төрийн оролцоог хангасан эсэхийг хэмжих зарим үзүүлэлт

Иргэдийг оролцоог хангасан эсэхийг хэмжих зарим үзүүлэлт	МАН	АН
Намын парламентад сонгогдсон гишүүдтэй холбогдох ерөнхий мэдээлэл бий эсэх	1	0
Намын парламентад сонгогдсон гишүүдтэй холбогдох онлайн холбоос \application \ бий эсэх	1	0
Намын парламентад сонгогдсон гишүүдтэй утсаар холбогдох боломжтой эсэх	1	0
Намтай шууд холбогдох телефон утасны дугаар бий эсэх	0	1
Намын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий санал асуулга явуулж байгаа эсэх	0	1
Намын вэб сайт рүү нэвтрэх тусгай хаалга бий эсэх \Login\	0	1

Улс төрийн нам бол ард түмний олонхийн саналаар сонгогдсон төлөөллийг иргэд сонгогчидтой холбох үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үүргээ намын вэб сайтаар дамжуулан гүйцэтгэж болох аж. Намуудыг харьцуулан авч үзвэл МАН вэб сайтаар тус намаас сонгогдсон УИХ-ын гишүүдтэй холбогдох [холбоос\линк](#) хийсэн байснаараа онцлог байв. Мөн сонгогч намаас сонгогдсон гишүүнд хандсан санал хүсэлт, захиа даалгавар өгөх онлайн холболттой байхын сацуу УИХ-ын гишүүдтэй холбогдох утасны дугаарыг байрлуулжээ. Харин АН-ын хувьд МАН-ын адил тус намын УИХ-д сонгогдсон гишүүдтэй холбогдох [холбоос\линк](#) байгаагүй. Улс төрийн намын дотоод хяналтын механизм нь намаа төлөөлөн парламентад ажиллаж байгаа гишүүдийн талаарх иргэдийн санал, хүсэлтэд тулгуурладаг нь зүй. Мөн ээлжит парламентын сонгуульд УИХ-д намаа төлөөлөн ажилласан гишүүний үйл ажиллагааг сурталчилах, сонгогчдоос дэмжлэг авах гэдэг утгаар гишүүнтэй холбогдох бүхий л мэдээллийг намын вэб сайтаас авах боломжтой байх учиртай.

Хоёр нам вэб сайтаар намтай шууд холбогдох утасны дугаар¹⁶³ байрлуулсан хэдий ч дуудлага хийж үзвэл МАН-ын утас ашиглалтад байхгүй гэсэн хариу өгч байсан бол АН-ын шууд утас хэвийн ажиллаж байлаа. Ийнхүү намууд иргэдийн улс төрийн оролцоог хангах, сэдэлжүүлэх байдал нь 40% тай бөгөөд өөр хоорондоо зарим үзүүлэлтээр ялгаатай байна.

Монголын улс төрийн намуудын ашиглаж буй вэб сайтад хийсэн анализийн дүнгээс үзвэл улс төрийн намууд сонгогчидтой харилцахад вэб

¹⁶³ МАН-тай холбогдох утас 50067805 www.nam.mn сайтад 2013 оны 02 сарын 28 ны өдрийн байдлаар, АН-тай холбогдох утас 1206 www.demparty.mn сайтад 2013 оны 02 сарын 28 ны өдрийн байдлаар

сайтыг 40%-тай ашиглаж байгаа нь тогтоогдлоо. Цаашид сонгогчидтой идэвхитэй, ашигтай улс төрийн харилцаа тогтооход нөлөөлөх хэд хэдэн асуудал байна. Үүнд:

- Цахим орон зай дахь улс төрийн нам ба сонгогч хоорондын харилцааг тодорхойлсон “Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар”-аас дээд түвшний, гурван талтай идэвхитэй улс төрийн харилцааг бий болгоход чиглэсэн вэб сайт ажиллуулахад анхаарах нь зүйтэй.
- Намын вэб сайт сонгогчдод мэдээлэл түгээх үүргээ хангалттай биелүүлж чадахгүй байгаа нь анализийн дүнгээс харагдсан тул зөвхөн НАМААС-СОНГОГЧ руу чиглэсэн нэг талтай харилцааг өөрчлөх. Үүний тулд бүх төрлийн мэдээлэл татах зориулалттай DOWNLOAD хэрэгсэл байрлуулах шаардлагатай.
- Онлайнаар гишүүн элсүүлэх бүх боломжийг хангах. Ингэхдээ гишүүнчлэлтэй холбоотой нарийвчилсан мэдээлэл хүсэх, саналаа хэлэх бололцоог хангасан онлайн асуулгын хуудас \online application\ вэб сайтдаа байрлуулах нь зүйтэй.
- Намуудын вэб сайтын алинд нь байгаагүй намын хандивтай холбоотой мэдээлэл олж авах, санал хүсэлт өгөх бололцоог хангасан онлайн захиалгын хуудас ажиллуулах.
- Намын вэб сайтад шинээр нэмэгдсэн мэдээллийг харуулдаг RSS хэрэгсэл байрлуулах.
- Ажиллуулж буй вэб сайтын талаарх нээлттэй санал асуулга явуулах зэрэг багтана.

Өрнөдийн улс төрийн намын вэб сайт нь сонгогчдод мэдээлэл түгээх НАМ-СОНГОГЧ гэсэн харилцаанаас илүүтэй СОНГОГЧ-ОРОЛЦОГЧ-НАМ гэсэн гурван талт харилцааг төлөвшүүлэхэд чиглэж байна. Тэд аль болох намын вэб сайт руу хандах сонгогчдын тоог өсгөх, тэдгээр сонгогчдын утасны дугаар, мэйл хаяг зэргийг цуглуулан дэмжигчдын бааз бүрдүүлэхэд анхаарч, олон төрлийн сонирхолтой хэлэлцүүлэг зохиох, арга хэмжээнд уриалах замаар тэдний дэмжлэгийг олж авдаг байна.

ДҮГНЭЛТ

Улс төрийн үйл явц интернэт сүлжээнд шилжиж байгааг илрэл нь улс төрийн институт нь олон нийттэй улс төрийн харилцаа тогтооход интернэт сүлжээ түүний хэрэгслүүд болох вэб сайт, блог, нийгмийн сүлжээ ашиглах болсон байна. Улс төрийн бодит байдал өөрчлөгдөж байгаатай холбоотой анхаарал татахуйц олон асуудлыг судлаачид сонирхон судалж байгааг нэг нь энэхүү өгүүллийн үндсэн судлагдахуун болох улс төрийн намын вэб сайт юм.

Улс төрийн намын вэб сайтыг судлах судалгааны хэд хэдэн хандлага байгаагаас энэ удаагийн эмпирик судалгаанд улс төрийн коммуникацийн хэрэгсэл болох талаас нь улс төрийн намын вэб сайтад анализ хийлээ. “Зургаан талт кибр харилцан үйлчлэлийн загвар” –ыг ашиглан хийсэн эмпирик судалгааны дүнд Монголын улс төрийн намууд вэб сайтыг улс төрийн коммуникацийн практикт ашиглахдаа зөвхөн мэдээлэл түгээх НАМ-СОНГОГЧ гэсэн нэг талтай харилцааны чиглэлтэй байгааг тодорхойлсон. Ижил төстэй судалгааны дүнгээс харахад өрнөдийн улс төрийн намууд СОНГОГЧ-

ОРОЛЦОГЧ-НАМ гэсэн гурван талтай, иргэний оролцоонд тулгуурласан харилцааг ач холбогдолтойд тооцон, зорилго чиглэлээ өөрчилж байна. Тиймээс Монголын улс төрийн намууд цаашид сонгогчидтой идэвхитэй, олон талт харилцаа тогтооход өөрийн вэб сайтаа шинэчлэн сайжруулах шаардлага нэгэнт бий болсоныг судалгааны дүн бидэнд харууллаа.

ABSTRACT

I have analyze some opinion relating with political communication instrument as party`s web site and methodological issues studying political party`s website. The content of the article have been concluded as a following:

What is political party`s website?, how we study and analyze political party`s website?, how political party`s use this communication instrument as party`s website in Mongolia?. Also, there was the methodological issues studying at political party`s website. This article focuses on the Mongolian political parties` use of website in their political communication with the party base and party politics in general.

НОМ ЗҮЙ

Нэг сэдэвт бүтээл

1. Democratic Governance and New Technology: Technologically Mediated innovations in political practice in western Europe. Jens Hoff, Ivan horrocks, Pieter Tops. Copyright. USA., 2005
2. Political Parties and the Internet: Net Gain. R. K. Gibson, Paul Nixon, Stephen Ward. Copyright. London., 2003
3. Proceedings of the 10th European Conference on E-Government: National Center for taxation studies and university of Limerick, Ireland. Dave O'Donnell. Copyright. UK., 2010.
4. Routledge Handbook of Internet Politics. Andrew Chadwick, N. Howard. Copyright. USA., 2009
5. Social Informatics: An Information Society for All? In Remembrance of Rob Kling. Jacques Berleur, Markku I. Nurminen, John Impagliazzo. Copyright. 2006., USA
6. The Internet election: perspectives on the web in campaign 2004. Andrew P.Williams, John C. Tedesco. Rowman & Littlefield Publishing group. Inc. Copyright. USA., 2006.
7. The Myth of Digital Democracy. Matthew Hindman. Copyright. New Jersey., 2009,

Өгүүлэл

1. “Улс төр судлал, социологийн асуудал” Эрдэм шинжилгээний бичиг. МУБИС, Улс төр судлал, социологийн тэнхим. УБ., 2012 №1 86-96
2. A four-part model of cyber-interactivity. McMillan, S. J. New Media & Society. Copyright., 2002. № 4(2)
3. Cyberdemocracy and Online Politics: A New Model of Interactivity. Paul Ferber, Franz Foltz, Rudy Pugliese. “Bulletin of Science, Technology & Society”. Vol. 27, No. 5, October 2007

Интернэт сайт

1. www.demparty.mn
2. www.nam.mn

ХАРЬЦУУЛСАН УЛС ТӨР**Хүннү ба өмнөд, өрнөд хөршийн харилцаа холбоо****3. Батсайхан***МУИС-ийн Археологи-антропологиин тэнхмийн профессор***Түлхүүр үг:** Хүннү, Хан улс, Баруун хязгаар, харилцаа, Урт хэрэм

Хүннү улс нь өмнөд этгээдээрээ Зүүн Ази дахь эртний суурин иргэншлийн нэгэн том голомт Хятадын Хан улстай, баруун ба баруун өмнөд талаараа Баруун хязгаарын хэмээн түүх сударт тэмдэглэсэн нүүдэлчин болон хагас суурьшмал олон жижиг улс, овог, аймагтай хил залган оршиж байжээ. Энэхүү хоёр хөрш нь нийгэм-эдийн засгийн хөгжлийн түвшин, хэл соёл, угсаа гарвалын хувьд хүннүгээс эрс ялгаатай ард түмнүүд байсан бөгөөд өөрөөр хэлбэл Алтайн хэлт нүүдэлчин Хүннү, газар тариалан эрхлэгч суурин амьдралтай хятад болон эртний индоираны хэл аялгуугаар ярилцагч хагас нүүдэлчин, хагас суурьшмал үсүн, юэжи зэрэг дорнод ираны салбар овог аймгууд гэх мэт гурван өөр угсаатан, хэл соёлын уулзвар байсан юм.

Гурван хөршийн харилцаа нэн эртний угшилтай бөгөөд ялангуяа, МЭӨ II мянганы эцэс I мянганы эхнээс эхлэн умардын гуйфан хэмээх хүчирхэг овог аймгууд Шар мөрний хөндий саваар нутаглах Инь, Жоу улстай дайтаж байсан тухай хүрэл сав суулга болон мэргэ төлөгний ясны бичээст тэмдэглэсэн байдаг бол баруун хязгаарын юэжи нарын тухай анхны мэдээ МЭӨ V-IV зууны Гуаньзы бичигт юйши, юйжи хэлбэрээр гардаг ажээ. Харин Умардын болон Баруун хязгаарын ард түмнүүдийн харилцаа энеолит ба хүрлийн эхэн үеэс эхтэй.

1. МЭӨ IV-III зууны үед Евразийн түүхэн хөгжилд түлхэц үзүүлэх тус тивийг дамнасан анхны зам харгуй түүгээр дамжин Дорно дахин ба нүүдэлчдийн соёлын ололт, амжилт төдийгүй цэрэг дайны урлаг баруун зүгт нэвтрэх угтвар нөхцөл бүрдсэн юм. Мянга гаруй жил хятадын вант улсууд болон умардын нүүдэлчдийн хооронд үргэлжилсэн дайн дажны эцэст ойролцоо цаг хугацаанд хятадад анхны нэгдсэн төр Цинь, Хан улсууд байгуулагдсан бол умардад нүүдэлчдийн тулгар төр улс Хүннү гүрэн байгуулагдсан билээ. Энэ нь умард, өмнөдийн хоорондын олон зууныг гэтэлсэн холбоо харилцааны хариу үйлдлүүд, зайлшгүй гарах үр дүн байсан гэж үзэлтэй. Ази тивийн хоёр их хөрш улсын гадаад бодлогын чиг шугам нь аль нэг талаа хараат улс байлгахад чиглэгдсэн улс төр, цэрэг дайны бодлого **баримталж байсан ажээ**. Хан улс оршин тогтнож ирсэн бүхий л хугацааны турш хүннү нарыг хазаарлан барих боломжтой гэж үзсэн цэрэг дайны болон дипломатын бүхий л аргуудыг хэрэглэсэн боловч тэр нь хүсэн хүлээж байсан тэр үр дүнд хүрээгүй бөгөөд хүннүг номхотгоход хамаг амьдралаа зориулсан У ди хаан үүнийг хүлээн зөвшөөрсөн байдаг билээ. Гэсэн хэдий ч хоёр улс түүхийн эгзэгтэй мөчүүдэд төрт ёсны хэм хэмжээ, гэрээ хэлцлийг аль аль тал нь баримталж байсан төдийгүй Хан улсын хааны сэнтийг ёс бусаар эзлэн авсан Ван Маний бослогыг дарахад хүннү нар цэргийн хүчээр тусалж байсан зэрэг цөөнгүй тохиолдлууд сурвалж бичгийн мэдээнд тэмдэглэгдэн үлджээ (Таскин 1968, 1973, 1984).

Хүннү улс нь Хятадын Хан улсын хүн амаас хэдэн арав дахин цөөн байсан боловч өргөн уудам газар нутаг, сайн зохион байгуулалттай хурдан

шаламгай морин цэрэг, тусгал сайтай нум, хил хамгаалах тогтолцоо, өртөө маягийн холбоо зэрэг давуу талууд дээрээ түшиглэн Төв болон Дорнод Азийн хүчний харилцааг тэцвэржүүлж байсан гэж үзэлтэй. Гэхдээ хүннү нар үр тарианы ургамал, бөс бараа гэх мэт суурин орны зарим бараагаар байнга гачигдаж, дутагдаж байсан бол хятадууд нүүдэлчдийн адуу мал, арьс ширээр арилжаа наймаа хийх сонирхолтой байсан боловч Хан улсын зүгээс нүүдэлчдэд үзүүлэх улс төрийн дарамт шахалтын улмаас боомтын арилжаа зогсоход хүрч байжээ. Ийм тохиолдолд Хүннү нар хятадын боомт хотуудыг довтлон хэлмэгдүүлэх шалтаг болж цаашид өргөжин хоёр талаас олон арван мянган цэрэг оролцсон томоохон хэмжээний дайн гарахад хүргэж, эцэст нь нэгэн адил асар их хэмжээний хохирол амсдаг байжээ. Дайны эцэст хэрэв хүннү нар ялагдал хүлээсэн бол эр цэрэг өсөн торинож, насанд хүрч, агт морь үржин олширтол хэсэг хугацаанд намжмал байдал зонхилж байсан бол Хан улс ялагдсан тохиолдолд ургийн явдалд тулгуурласан энхийн гэрээг дахин байгуулж бэлэг сэлт маягаар их хэмжээний бөс бараа, үр тариа зэргээр жил бүр татвар төлөх болдог байлаа. Үүнийг нөгөө талаас нь авч үзвэл Хан улс байнгын цэрэг дайны аюул дор хараат байдалтай байсан бол хүннү нар бөс бараа болон үр тарианы гачигдал дор харилцан хараат оршиж байжээ. Чухам энэхүү шалтгаан нөхцөл нь эрс тэрс шинжтэй хоёр иргэншил зэрэгцэн орших үндэс суурь нь болж байсан гэлтэй.

2. Аливаа хөрш улсуудын дотоодын зөрчил тэмцэл нь нөгөө талдаа ашигтайгаар эргэдэгийн адил Хан ба Хүннү улсад ч ажиглагдаж байсан юм. Тухайлбал, Цинь, Хан улсын хооронд үүссэн дайн тулааны улмаас олон хятад иргэд дүрвэн Хүннүгийн нутагт ирж суурьшсанаас гадна олон тооны олзлогсод, дагаар орогсод байсан бөгөөд зарим судлаачдын тооцоогоор Хүннүгийн газар тариаланд 100 000 орчим хятад иргэд ажиллаж байжээ (Ганбаатар 2008:279). Үүнээс гадна худаг ус гаргах, үр тариа хадгалах амбаар сав барих, гүүр тавих зэрэг ажил хийж байсан тухай цухас мэдээ сурвалжид гарч байгаагаас үзвэл анхын хот маягийн суурин газрууд, хэрэм бэхлэлт босгоход хятад иргэд шууд оролцож байсан гэж үзэх хэрэгтэй. **Гэхдээ нүүдэлчин ард түмний анхны хот суурин маягийн газрууд нь газар тариалан эрхлэгч суурин оронд анхны хот маягийн төвүүд үүссэн зүй тогтолоос эсрэгээр төр улс үүсэн байгуулагдсаны дараагаар болсон үйл явц байсан нь ажиглагдаж байна. Үүний нэгэн адил Хүннүгийн суурин газрууд нь улс төр, засаг захиргааны төвийн үүрэгтэй байгаагүй, зөвхөн эдийн засгийн ач холбогдлоор тодорхойлогдож байсан бололтой** (Батсайхан 2011:396).

3. Хятад болон хүннү иргэдийн хооронд гэр бүлийн өргөн холбоо харилцаа байсан тухай бичгийн сурвалжийн мэдээ гарахгүй байгаа бөгөөд археологийн сурвалжид бас илрэхгүй байна. Харин хүннүд олзлогдсон болон дагаар орсон хятад цэргийн түшмэл, элч төлөөлөгчид хүннү эхнэр авсан тухай цөөвөр мэдээ бий. Үүнээс үзвэл хятад иргэд уламжлалт зан заншил, аж төрөх ёсондоо баригдан өөр хоорондоо гэр бүл үүсгэж байсан бололтой.

Шаньюй нарын дэргэд Чунхан Юэ, Вэй Лю, Жао Синь мэт хятад боловсролтой хүннү нараас гадна хятад түшмэл зөвлөх байсан тухай сурвалжид огт дурдахгүй байна.

4. Энэхүү харилцаагаар дамжин хятадын газар тариалангийн багаж хүрээ, анжис, зээтүү мөн арвай, буудай зэрэг үр тарианы ургамал ахуйн соёлын зарим

элемент будаа агшаах ёроолдоо нүхтэй ваар, шавар зуух, зарим нэг хэв шинжийн дэнгийн цөгц зэрэг эд зүйл хүннү нарын дунд өргөн нэвтэрсэнээс гадна хоолны ясан савх олонтаа олдож байгаагаас үзвэл хятад маягийн хоол дэлгэрсэн байсан бололтой. Түүнчлэн ширдмэл аяга, тагш, нарийн нэхээстэй торго, цагаан хүрэл толь, хаш гоёл чимэглэл зэрэг хятадын тансаг хэрэглээний эд зүйлийг хүннү нар ихээхэн таашаадаг байсан бололтой. Мөн хоёрын зэрэг булшнаас хар бэхний үлдэцтэй хавтгай чулуун янтай (Эрдэнэбаатар нар 1999:65. Зур.4) гарснаас үзвэл хятадын бичгийн соёлын нөлөө нэвтрэхийн хамт бичиг үсэгт тайлагдсан боловсролтой хүмүүс цөөнгүй байсан гэлтэй.

Хүннү нартай хил залган оршин суух хятад иргэдийн дунд нүүдэлчдийн мал маллагааны арга ухаан, адуу малын уналга эдэлгээ, тоног хэрэглэл, хувцас хунар дэлгэрч байснаас гадна хил орчмын хятад залуус нүүдэлчдийн нөлөөгөөр моринд гарамгай, харваж намнахдаа нутгийн гүнд оршин суух хятад иргэдээс хавьгүй илүү тул тэднээс бүрдсэн тусгай цэрэг анги хүртэл зохион байгуулж байсан тухай сурвалжид өгүүлжээ. Үүнээс гадна нүүдэлчдийн зарим төрлийн хоол, гамбир, мах борцлон хатаах зэрэг арга ухаан зэр зэвсэг, байлдах урлаг нэвтрэн оржээ. Түүнчлэн, Хүннүгийн дотоод гарсан зөрчил тэмцлийн уршигаар овгийн ахлагчаар удирдуулсан олон овог аймгууд Хан улсад дагаар орж хил хамгаалах болон Умард Хүннүгийн эсрэг хийх аян дайнд цэргийнхээ хамт оролцож байлаа. Үүнийхээ төлөө Хан улсаас өндөр шан харамж, цол хэргэм хүртэж хятадын төрд зүтгэж байжээ. **Хүннү гүрэн задарч хоёр хуваагдсанаар Өмнөд хүннү нар Ордосын Бор тохойд эргэн суурьшсанаар яваандаа суурин ба нүүдлийн иргэншлийг хослуулсан завсарын соёл төрөн гарсан нь хятадын иргэншлийн хөгжилд зэрэг нөлөө үзүүлснийг онцлон дурдах нь зүйтэй.**

Нүүдэлчидтэй харилцах харилцааны явцад төр, засаг захиргааны шинэ албан нэгжүүд хүртэл байгуулагдаж нүүдэлчдийн талаар явуулах гадаад бодлогын үндэс суурь тавигдаж хятадын төр улс улам бэхжсэн ажээ.

5. Хүннү улсаас Баруун хязгаарын аймаг улстай харилцаж байсан харилцаа холбоо нь судалгааны тусгай сэдэв мөн. Юуны өмнө энэ харилцаа нь Хан улстай харилцаж байсан харилцаанаас эрс өөр зарчмын ялгаатай юм. Учир юу гэвээс Хүннү гүрний эсрэг Хан улс, Баруун хязгаарын хооронд аливаа эвсэл холбоо байгуулагдахаас урьдчилан сэргийлэх бодлого баримталж өөрийн хараа, хяналт тогтоох, нөлөөгөө хадгалж байхын тулд цэргийн хүчээр туслах, ургийн холбоо тогтоох, хүчээр эзлэн номхотгох зэрэг цэрэг, улс төрийн боломжтой бүхий л аргыг хэрэгжүүлж байсан бөгөөд тодорхой амжилтанд хүрч байсан билээ. Энэхүү холбоо харилцаа тогтоход аж ахуй, соёлын зарим ижил төстэй тал тухайлбал, нүүдлийн мал аж ахуй, түүнд тохирсон аж төрөх ёс, зарим зан заншлын адил тал сайнаар нөлөөлсөн байж таарна. Түүнчлэн, хүннүгийн хүн амын доторх монгол, европ завсарын төрхөн бүлгүүд болон Баруун хязгаарын ард түмний хоорондох эртний угсаа гарвалын холбоо сүлбээний дам нөлөөллийг үгүйсгэх аргагүй юм.

Сурвалжид өгүүлснээр МЭӨ 138 онд хятад түшмэл Жан Цянь Баруун хязгаарын улс орнуудаар аялан явж хожим нь Торгон зам хэмээн нэрлэх болсон өрнө, дорныг холбосон их замыг нээсэн гэж үздэг. Гэтэл хүннү нар үүнээс өмнө Баруун хязгаарын хүчирхэг том аймаг Юэжитэй юу ч атугай Түмэн

шаньюй харилцаатай байсан бөгөөд тус бүс нутаг дахь хүннүтэй сөргөлдөх томоохон хүч байсан боловч Модун шаньюйд цохигдон нэг хэсэг нь баруун тийш зайлан одсоноор Баруун хязгаарт хяналтаа тогтоожээ. Яагаад гэвэл өрнө зүгт нэвтрэх гол зам харгуйн уулзвар газар тул Хан улс мөн нэгэн адил анхаарч Баруун хязгаарыг эзлэн авахад чиглэсэн улс төрийн идэвхитэй бодлого явуулж асар их хэмжээний хүн хүч, хөрөнгө мөнгө зарж байсан боловч төдийлөн амжилтанд хүрч чадаагүй ажээ.

6. Нүүдэлчдийн улс төр, нийгэм, эдийн засгийн салбарт асар сөрөг нөлөө үзүүлдэг нэгэн үзэгдэл бол урт хэрмийг чиглэсэн нүүдэл, шилжилт хөдөлгөөн юм. Энэ нь нүүдэлчдийн дунд үүсэн бий болсон хаан ширээний төлөөх тэмцэл, түүнээс болсон үймээн, бужигнаан, улс төрийн шалтгаантай урвалт, байгаль, цаг агаарын гамшигт үзэгдэл ган, зуд, царцааны нүүдэл, түүнээс улбаатай өлсгөлөн, өвчин тахал дэгдэх зэрэг дотоодод өрнөсөн улс төр болон гадны нөлөөллөөс ангид болдог үйл явцын үр дүн болон илэрдэг үзэгдэл юм. Дурдсан шалтгаануудын улмаас тухайн овог, аймгийн ахлагч, тэргүүлэгч нараар удирдуулан хэдэн мянгаас хэдэн арван мянга зарим тохиолдолд 100-200 гаруй мянган хүн Хан улсад дагаар орж, Урт хэрмийн гадна эсвэл дотор орж сууж байсан тухай мэдээ хятад сурвалжид олонтаа давтагдан гардаг. Дагаар орогсодыг хятадын дипломат бодлогын үзэл баримтлал ёсоор “энхрийлэн” хүлээн авч овог, аймгийн ахлагч нарт цол хэргэм олгож бөс бараа, үр тариа, дарс сэлтээр бэлэх барих бөгөөд түүний хариуд элэг нэгтнээс Хан улсын хил хязгаарыг хамгаалах, хүннүгийн эсрэг аян дайнд харьяат иргэдээ удирдан оролцох зэрэг үүрэг хүлээдэг байлаа. Зарим тохиолдолд тэдгээр нүүдэлчид хятад хэл соёлыг хүлээн авч аажмаар суурин амьдралд шилжин орж байсан бол зарим хэсэг нь умар зүгт нам тайван байдал тогтмогц эргэж тал нутгийн зүг нүүн ордог байжээ.

Энэ байдал нүүдэлчдийн төр улс доройтох тохиолдол бүрт байнга давтагдаж ирсэн хүн хүч болон эдийн засагт сөргөөр нөлөөлдөг уршигт үзэгдэл байсан төдийгүй нүүдэлчдийн төр улсыг улмаар мөхөлд хүргэж байсан гол шалтгаануудын нэг мөн.

Үүнд нүүдэлчдийн төр улсын язгуурын бүтэц зохион байгуулалтын онцлогийг дурдах хэрэгтэй. Тухайлбал, нүүдэлчдийн хаад аян дайныг удирдан зохион байгуулж газар, бэлчээрийг өргөтгөх дайны олз, бэлэг сэлт болон хараат орноос авах алба татварыг дахин хуваарилахаар хязгаарлагдах бөгөөд харьяат овог аймгуудыг бүрэн хянан барих боломжгүй байдаг. Учир юу гэвээс тухайн төр улсыг бүрдүүлж байгаа овог аймаг бүр өөрийн ахлагч удирдагчтайгаас гадна гишүүн эрчүүд бүгд зэвсэглэсэн малчин цэргүүд байх тул дээрээс улс төрийн дарамт үзүүлэх тэр бүр боломж байдаггүй ажээ. Үүнээс гадна өөр нэгэн чухал зүйл тэд бүгд тодорхой хэмжээний мал сүрэгтэй байх тул эдийн засгийн дарамт шахалтад автахгүй.

Иймээс хот айл буюу түүнтэй төстэй бүтэц зохион байгуулалт дээр суурилсан нүүдэлчдийн овог, овог аймгийн нэгдлийн шилжилт хөдөлгөөнийг хянан хязгаарлах боломжгүй байсан бөгөөд энэ нь дайсагнагч хөрш оронд ашигтай харин нүүдэлчдийн төрийг доройтуулагч хүчин зүйлийн нэг байлаа.

7. Зарим эх сурвалжаас үзвэл нүүдэлчид болон Баруун хязгаар хооронд скифийн үеэс эхлэн аж ахуй, соёл, угсаатны өргөн холбоо харилцаа тогтож

ирсэн бөгөөд түүгээр дамжин индоираны шүтлэг, домог үлгэр гэх мэт оюуны соёлын элементүүд нүүдэлчдийн дунд нэвтрэн орсоноос гадна, малыг нас шүдээр нэрлэх нэр томъёо, цагаан идээ, эсгийн гэрийн зарим хэсгийг нэрлэх нэр гэх мэт олон зүйлс харилцан нэвтрэлцэж алтай язгуурын хэл, соёлыг илүү баялаг болгожээ. Гэхдээ үүнийг зөвхөн индоираны соёлын тэргүүлэгч нөлөөгөөр тайлбарлах учир дутагдалтай бөгөөд Хангай нуруу, Орхон, Сэлэнгийн савд Карасукийн соёлтой ижил төстэй “Хиргисүүр, буган хөшөө”-ний соёл хэмээх хөгжингүй соёлын голомт төв байсан ба эдгээр соёл хэлбэрийн тогтоход монгол төрхтөн алтайн хэлт ард түмэн тодорхой үүрэг гүйцэтгэсэн юм. Сүүлийн үеийн судалгааны урьчилан үр дүнгээс үзвэл хөгжингүй хүрлийн үеийн бие даасан өвөрмөц иргэншил үүссэн нэг төв байсан бөгөөд дараачийн шинэ түүхэн эрин үеийн хөрс суурь болсон гэж үзэлтэй. Хүннүгийн оршуулгын зан үйлд мянга гаруй жилийн өмнөх хиргисүүр, буган хөшөөний соёлын зарим содон шинж тэмдэг уламжлагдан ирсэн байдаг нь хүннүгийн бие даасан соёлын нийтлэг бүрэлдэн тогтоход нэгэн гол тодорхойлогч элемент болон уламжлагдсан байна.

8. Хүннү болон Баруун хязгаарын улс орнуудын хооронд тогтож байсан харилцааны нэгэн гол ач холбогдол нь түүгээр дамжин өрнө зүгийн Грек, Бактри зэрэг улстай соёлын холбоо харилцаа үүсгэж байсанд оршино. Энэ харилцааны үрээр анх Монгол, Дундад Ази болон Ойрхи Дорнод, Балканы хойг хүртэлх анх зам харгуй тавигдаж эхэлсэн бөгөөд хятад түшмэл Жан Цянь санаандгүй учралаар Таныи Фу хэмээх хүннү хүнийг дагуулж аянд гараагүй бололтой бөгөөд тэрбээр орчуулагч, газарч, бие хамгаалагчийн үүрэгтэй явсан байж болох юм. Хожим нь Торгоны зам хэмээн нэрлэх болсон тэрхүү зам нүүдэлчдийн их нүүдлийн зам байсан ба хятадын бөс бараа анх хүннү нараар дамжин Баруун хязгаарт хүрч улмаар цааш баруун зүгт түгэн дэлгэрсэн бололтой.

9. Энеолитийн үеэс эхлэн хэдэн зууныг дамнан үргэлжилсэн харилцааны эцэст хүннү хүн амын дотор монгол, европ завсарын хэв шинжтэй томоохон бүлэг бий болсон бөгөөд Архангай аймгийн Тамирын Улаан хошуу, Худагийн ам, Наймаа толгой гэх мэт хүннүгийн оршуулгын газруудыг дурдаж болох юм. Энэ нь хүннү болон Баруун хязгаарын аймаг улсуудын хооронд улс төрийн харилцаанаас гадна энгийн иргэдийн хооронд гэр бүлийн харилцаа ихээхэн үүрэгтэй байсныг харуулж байна. Гэр бүлийн сайн харилцаагаар дамжин соёлын олон элемент дамжин орсон нь ойлгомжтой бөгөөд хүннү нар угсаатны хувьд төдийгүй соёлын талаараа ч гетероген нүүдэлчид байжээ. Иймээс Хүннүгийн угсаатны бүрэлдэхүүн болон соёлын үүсэл гарвалыг бүс нутгийн хүрээнд судлаж, аж ахуй-соёл, угсаатны оролцоог тодорхойлох нь судалгааны цаашдын чиг хандлага байх болов уу.

10. Баруун хязгаарт Умард Хүннүгээс дайжин очсон шаньюй тэргүүтэй цөөнгүй тооны нүүдэлчид МЭ 153 он хүртэл нөлөөтэй хэвээр байсан бөгөөд 155 онд Умард хүннү сяньбийн Танишихуайд бүрэн цохигдсоноор хүннү нарын нэг хэсэг нь баруун зүгт дүрвэн одож, үлдсэн хэсэг нь юэбань нэрийн дор түүх сударт тэмдэглэгдэх болжээ. Ийнхүү өргөн уудам газар нутгийг эзлэн оршиж байсан Хүннү гүрэн улс 350 гаруй жил оршин тогтносоны эцэст мөхсөн боловч тал нутагт их гүрэн байгуулж болох тухай аугаа их үзэл санаа мөхөөгүй бөгөөд зөвхөн нүүдэлчид төдийгүй суурин иргэншилт ард түмэнд хүртэл нөлөөлжээ. Нүүдэлчин хүннү нарын нөлөөгөөр өргөн уудам газар нутаг, улс орныг

эрхшээлдээ оруулан захирч их гүрэн байгуулж болох санааг ханчууд чухам тэр үед ухааран ойлгосон гэлтэй.

Эцэст нь тэмдэглэхэд тус тивд хүннү нарын явуулж байсан дипломат бодлогын хамгийн томоохон ололт амжилтын нэг нь Хүннү, Хан улсын хил хязгаарыг Цагаан хэрмээр тогтоож, газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хадгалахад чиглэсэн хоёр улсын хооронд байгуулсан анхны гэрээ болох нь эргэлзээгүй. МЭӨ 117 оны гэрээгээр Цагаан хэрмийн умард дахь нум, сум агсагчид шаньюйн зарлигийг дагаж хэрмээс урагш түшмэдийн бүс, малгай өмсөгчид Хан улсад захирагдах бөгөөд Хан, Хүннү хоёр улс бол мөр зэрэгцэх хүчирхэг улс болохыг дипломатын түвшинд Хан улсаар хүлээлгэн зөвшөөрүүлсэн түүхэн чухал ач холбогдолтой гэрээ болсон. Нөгөө талаас хятадыг дипломатынхаа уламжлалт бодлогоосоо ухран буулт хийхэд хүргэсэн том цохилт байжээ. Нүүдэлчид, Хүннүгээс эхлээд бүс нутгийн асуудлыг цэрэг зэвсгийн хүчээр гэхээсээ илүү дипломат замаар, тэрсэлдэн тэмцэх гэхээсээ илүү эвлэрэн зохицох зэрэг маш нарийн бодож төлөвлөсөн, улс төрийн уян хатан бодлого баримталсаар байсан энэ мэт олон жишээг дурдаж болох билээ. Гэхдээ нүүдэлчдийн дипломат бодлого нь өрсөлдөгч этгээддээ ямагт учир битүүлэг, үйл хөдлөлийнх нь дэс дарааллыг тааварлахад бэрхшээлтэй байхууцаар журамлан явуулахыг эрмэлздэг байсан нь тал нутгийн нүүдэлчдийн сэтгэн бодох өвөрмөц арга, гэнэтийн цохилт өгөх хурдан хөдөлгөөнт морин цэргийн хүч, өргөн уудам нутаг зэрэг давуу тал дээрээ суурилсан байжээ. Судлаачдын онцлон тэмдэглэснээр Модун-ы гадаад бодлогын номлол, түүнийхээ төлөөх улс төр, дипломатын тэмцэл нь үнэн хэрэг дээрээ Дорнод Азид Рах Хунница гэж зүй ёсоор нэрлэж болох энхийн дэг журмыг тогтоосон (Бор 2001:58) бага бүс нутгийн хүрээний дипломат бодлогын чиг шугамын зарчим байсан бөгөөд дэлхийн иргэншилд оруулсан хувь нэмэр гэж үзэж болох билээ.

Тухайн үед ази тивийн зүүн хэсгийн улс төрийн харилцаанд зонхилох үүрэг гүйцэтгэж асан хоёр их гүрэн нэгэн цаг хугацаанд сэргэн мандсантай адил мөн л ойролцоо цагт мөхөх тавилантай байжээ. Гэхдээ 400 гаруй жил үргэлжилсэн хоёр улсын харилцааны эцсийн үр дүнд хятадын гадаад бодлого буюу умардын нүүдэлчидтэй харилцах харилцаа бүрэн тавигдсан бөгөөд хожмын хятадын төр улсуудын уламжлалт гадаад харилцааны үндэс суурь болсон тухай сурвалжид олонтаа тэмдэглэсэн байна.

Хүннү улс мөхсөний дараагаар говийн өмнөд ба умардад хүннүгийн үлдэгдэл хэдэн зуугаас мянга хүртэлх тооны олон том жижиг овог аймгууд тал нутаг даяар нааш цааш нүүдэллэн оршиж байсан бол Умард хятадын нутагт хэдийнэ суурьшиж амжсан хүннү, сяньби нар Тоба Вэй улс, Умар Лян улс болон Умардын таван бүдүүлэгийн Арван зургаан улс хэмээн нэрлэсэн олон төр улсыг удаа дараалан байгуулж байсан боловч яваандаа тэдгээр нүүдэлчид хэл, соёлын хувьд бүрэн уусан шингэж хятадчилагджээ.

Хөшөө Цайдамд VII зууны 30-аад оны дунд үеэр босгосон Түрэгийн Билгэ хааны гэрэлт хөшөөнд Түрэг улсыг түрэгийн ухвар мөчид бек ноёд хятадын уран үг, үнэт эд баялагт мэхлэгдэн төр улсыг мөхөөсөн тухай харамсан дурдаад эцэст нь ийнхүү бичжээ. “Хятадын амтат уран үг, үнэт эд баялагт хууртагдавас түрэг ард түмэн, чи мөхнө. Хэрэв нэг хүн алдваас түүний харьяат бүх хүн ард манцуйтай нялх балчир хүртэл хэлмэгдэх болно” гэх мэтээр хятадын аюул

заналыг дахин анхааруулахын хамт “миний үг эндүүрэл үгүй бус уу? Ай, түрэгийн бек хийгээд ард түмэн мину, намайг сонсохтун. Түрэг түмнийг хурааж, төрөө түвшитгэсэн тухай энд сийлэв. Бас төөрөн будлих аваас задран бутрах тухай энэ чулуунаа сийлэв. Би бэр сэтгэсэн бүхнээ энэхүү мөнх орших чулуунаа сийлэв” (Мырзатай Ж. нар 2006:264) гэсэн нь өнөөдөр ч ач холбогдолтой хэвээр байна.

Abstract

In this article we tried to define Xiongnu and Han dynasty, Xiongnu and Western countries political relations. The studies reveal that The Xiongnu's relationship with the two neighboring countries mentioned above was based on entirely different approaches. The Xiongnu foreign policy regarding its 2 neighbors was to make them dependent states. Chinese Hans relations with Xiongnu and Western countries helped to shape Chinese foreign policy principles with northern nomads

Ашигласан сурвалж ба судалгааны бүтээлүүд

1. Батсайхан З. Хүннү түүх соёл. Хамтын бүтээл УБ, 2011
2. Бор Ж. Монголын хийгээд Евразийн дипломат шастир. I боть. УБ, 2001
3. Ганбаатар Я. Хүннүгийн түүх соёл. УБ, 2008
4. Мырзатай Ж, Каржаубай С. Атлас Орхонских памятников. Астана, 2006
5. Эрдэнэбаатар Д, Төрбат Ц, Эрдэнэбат У. Хүннүгийн үеийн шинэ олдворууд. АС. т.ХІХ, 1999
6. Таскин В.С. Материалы по истории древних кочевых народов группы дунху. М.1984
7. Таскин В.С. Материалы по истории сюннү. М. 1968
8. Таскин В.С. Материалы по истории сюннү. М. 1973

ҮНДЭСНИЙ УХАМСАР БОЛОН ҮНДЭСНИЙ ҮЗЭЛ СУРТЛЫН ХЯМРАЛ

М.Мөнхзул

ХААИС-ийн Нийгмийн ухааны тэнхмийн багш, докторант

Түлхүүр үг: Үндэстэн, үндэсний ухамсар, үндэсний үзэл суртал, улс төрийн ухамсар.

Товч хураангуй: Үндэсний ухамсрын судалгаа нь гол төлөв тухайн улсын түүхийн баримт нотолгоон дээр суурилан хийгддэг байна Учир нь үндэсний ухамсрыг судлах асуудал нь бусад улс үндэстнүүдийн түүхэн туршлагыг авч үзэх асуудлуудыг тойрон өнгөрөх ёсгүй. үзэл суртлыг албан байдлаар үгүйсгэж байгаа нь либерализм нь өөрөө албан бус “идеологи” болж байгаа юм. Энэ нөхцөл байдал маань эргээд төрийн үзэл суртлын асуудлыг илүү нарийн авч үзэх байдлаар хөндөх болж байна. Үзэл суртлын тодорхойгүй байдлын хоёр дахь туйл нь үндэсний ухамсрын асуудал юм. Үзэл суртал ба үндэсний ухамсрыг нэг талаасаа хоорондоо ижил ойлголт мэт хүлээн авах аль эсвэл тэр өөр эсрэг тэсрэг категори хэмээн ойлгож байгаагаас дээрх тодорхойгүй байдал даамжирч, үзэл суртал ба үндэсний ухамсрын нийгмийн статусыг тодорхойлох, мөн улс төрийн холбогдох арга барилуудыг боловсруулахад нэмэлт ээдрээг үүсгэж байгаа юм.

Барууны судлаачид дэлхийн түүхэн дэх соёлыг судлах болсон үеэс эхлэн үндэсний ухамсар хэмээх асуудалд анхаарлаа хандуулах болжээ. Үндэсний ухамсрын асуудал хүчээ авсан нь улс үндэстэн бүрийн түүхэн үндэс угсаанд өөрийн гэсэн соёлын өв тогтож байдгийг олж харсантай холбоотой билээ. Тусгаар улс үндэстнүүдийн оюун санааны үнэт зүйлсийг бүх хүнд нэгдмэл байх нийгмийн ой санамжийн механизм болгон уялдуулах боломжийг хайсаар ирсэн¹⁶⁴. Энэ асуудлын хүрээнд судлаачид XIX зууны дунд үеэс эхлэн үндэсний ухамсрын онолын шаардлагуудыг хурцаар авч хэлэлцэж эхэлсэн боловч зарим асуудлуудыг өдий хүртэл бүрэн шийдвэрлэж нэгдсэн дүгнэлтэнд хүрч чадаагүй байна. Мөн өнөө үед ч гэсэн монголын үндэсний ухамсрын онцлог шинжийг олж харах сонирхол хүчээ авч байгаа нь глобальчлалын үйл явц дахь үндэсний ухамсрын модернизацийн үр дүн гэж ойлгож болно. Аливаа улсын соёлын мөн чанар оюун санааны орчин тойрны хил дээр оршдог гэж үзэж болно. Нөгөөтэйгүүр Н.Бердяевийн хэлснээр “Орос улс түүхэн цаг хугацаандаа цуглуулсан олон үндэстний бөгөөд олон шашинт соёлын ачаа тээшээс хамааран дотоод үндэсний соёлыг ойлгох байдал нь харилцан адилгүй байсан”¹⁶⁵ гэжээ. Түүнээс гадна иргэний нийгмийг бүрэлдүүлэн бий болгох зайлшгүй шаардлагаас урган гарч ирж байна гэж үздэг. Гэхдээ глобальчлалын үйл явцын хэтийн төлөв тодорхойгүй байгаа бөгөөд үндэсний ухамсрын онцлог шинж, мөн чанар ба зүй тогтлуудын талаарх маргаан мэтгэлцээн үргэлжилсээр байгаа нь үндэсний ухамсрыг судлах асуудал нь илүү их ач холбогдолтойг харуулж байна. Ер нь үндэсний ухамсрын судалгаа нь гол төлөв тухайн улсын түүхийн баримт нотолгоон дээр суурилан хийгддэг байна¹⁶⁶. Ийм хязгаарлалт

¹⁶⁴ Кормер В.Ф. Двойное сознание интеллигенции и псевдокультура // Вопр. философии. 1989. № 9. х 65–79.

¹⁶⁵ Андерсон Б. Нация и национализм. М. 2003. х 65

¹⁶⁶ Бахтин М.М. Творчество Франсуа Рабле и народная культура средневековья и Ренессанса. М., 1965. х 7

нь үндэсний ухамсар гэдэг ойлголттой холбоотой асуудлуудын нарийн төвөгтэй тотентуудыг тототгох мөн хэд хэдэн байр сууриудын эвристик талуудыг гаргаж ирэх зорилгоор бий болжээ. Учир нь үндэсний ухамсрыг судлах асуудал нь бусад улс үндэстнүүдийн түүхэн туршлагыг авч үзэх асуудлуудыг тойрон өнгөрөх ёсгүй. Түүхэн асуудлуудыг авч үзэхдээ онолын судалгааны юунд анхаарах хэрэгтэй вэ гэвэл үндэсний ухамсрын түүхэн хөгжил болон функциональ байдлыг харгалзан авч үзэхээс гадна нийгмийн түүхэн ухамсрын тодорхой нэгэн хэлбэр нь болж байгаа эсэхийг нарийвчлан авч үзэх ёстой. Өнөөдрийн хувьд түүхэн ухамсар өөрийг нь бүрдүүлж буй хамгийн гол хүчин зүйл бол сайн муу аль алин бүхий үндэсний ухамсар болж байна. Тиймээс орчин үеийн нийгмийн шинжлэх ухааны гол асуудлын нэгт түүхэн ухамсрыг бүрдүүлэгч үндэсний ухамсрыг тодорхойлох асуудал тавигдаж байна.

Өнгөц харвал түүхэн ухамсар нь улс төрийн соёлын нэгээхэн хэсэг мэт харагдах боловч илүү нарийвчлан авч үзэхэд түүхэн ухамсар нь улс төрийн соёлын зүгээр нэг бүрэлдэхүүн хэсэг байгаад зогсохгүй соёлын өв уламжлалын бүхий л өгөгдлүүдийг нэгд нэгэнгүй хөндөж тэдгээргийг төрөлх шинж чанаруудыг тодорхойлж байдаг¹⁶⁷.

“Үзэл суртал”-ийн асуудал нийгмийн оюун ухаанд бараг хоцрогдсон хэллэг болоод байна. Албан хэллэгт бараг хэрэглэхээ больсон ба хэрэв хэрэглэвэл зөвхөн өнгөрсөн “тоталитар” дэглэмийн үеийн тодотгол байдлаар ашигладаг. Магадгүй хэн нэгэн “монгол улсад үзэл суртал байхгүй” хэмээн хэлээд үүнийгээ иргэний нийгэм болон ардчилалд хүрэх замд гарсан агуу том ололт амжилт хэмээн үзэх байх. Үзэл сурталын асуудал төр засаг болон нийгэм дэх соёлын элитүүдийн хэлэлцэх сэдвүүдээс бараг хасагдсан. Ерөнхийдөө төр болон нийгэм нь үзэл сурталын зохиомол дөрөө хэрэггүй гэж үзэх нь төр нийгэм нь өөрөө цэвэр зах зээлийн эдийн засгийн механизмууд дээр суурилан, аливаа үзэл суртал нь эдийн засаг, соёл, улс төрийн аль ч түвшин дахь зах зээлийн субъектийн чөлөөт үйл ажиллагаанд саад болно гэж үздэг. Энэхүү либераль ухамсрын хэв болсон зарчим нь өөрөө хоёрдмол бөгөөд зальжин шинж чанартай байгаа нь өнөөгийн өнхцөл байдлаас харагдаж байна. Өөрөөр хэлбэл, үзэл сурталыг албан байдлаар үгүйсгэж байгаа нь либерализм нь өөрөө албан бус “идеологи” болж байгаа юм. Энэ нөхцөл байдал маань эргээд төрийн үзэл сурталын асуудлыг илүү нарийн авч үзэх байдлаар хөндөх болж байна.

Төрийн үзэл суртал нь нийгмийн амьдралын хувьд хэр чухал асуудал вэ? Үзэл сурталын бүрэлдэхүүн нь юу вэ? гэсэн асуултууд улс төрийн үүднээс дахин нэг ухааран авч үзэх шаардлагатай болоод байна. Туршлагаас харахад нийгмийн хувьд “үзэл сурталын либерализм”-ын зарчмуудыг ухамсаргүйгээр хүлээн авах нь 1990-ээд оны эхэн үеийн “эдийн засгийн либерализм”-аас дутахгүйгээр сүйрэлтэй байгаа юм. Энэ хүрээнд зөвхөн төр засгийн гадаад хэлбэрээс гадна түүний иргэншсэн дотоод суурь нь нуран унадаг. Нийгэм нь өөрийн үндэсний-ертөнцийг үзэх үзлийн үнэт зүйлсүүд устан үгүй болоход өвдөг сөхөрч эхэлснийг, аливаа уламжлалт үндэсний сүр хүчийг “хувь хүмүүс”-ийн түвшинд хадгалан хамгаалж чадахгүй байгаагаа мэдэрч эхэлсэн¹⁶⁸. Нийгэм нь өөрийн үндэсний-ертөнцийг үзэх үзлийн үнэт зүйлсүүд устан үгүй болоход өвдөг

¹⁶⁷ Астафьева О. Н. Многообразие моделей этнокультурной идентичности в современном информационно-коммуникативном пространстве // Глобализация и перспективы современной цивилизации. - М.2005. х.123.

¹⁶⁸ Арин О.А. Россия в стратегическом капкане. - М., 1997. х 34

сөхөрч эхэлнийг аливаа уламжлалт үндэсний сүр хүчийг “хувь хүмүүс”-ийн түвшинд хадгалан хамгаалж чадахгүй байгаагаа мэдэрч эхэлсэн. Нийгэм нь өөрөөр хэлбэл үзэл суртлын эмх замбараагүй байдлын нурангинд дарагдах болсон. “Саяхны” гэгдэх өнгөрсөн үеийн үзэл суртлаас айх айдас нь нийгэм үзэл суртлын эрүүл зохион байгуулалтанд хүрэхэд цаашлаад үндэсний төр-улсын ахуйн агуулгыг бүхлээр нь төсөөлөн ойлгоход саад болсоор байна. Төрийн чухал асуудлын нэг болох үзэл суртлыг ийм нөхцөл байдалд сэргээх асуудал нь үндэсний сэргэн мандалтын зам дахь хамгийн түрүүнд шийдвэрлэх нь улс төрийн даалгавар болж байгаа юм¹⁶⁹.

Үзэл суртлын тодорхойгүй байдлын хоёр дахь туйл нь үндэсний ухамсрын асуудал юм. Үзэл суртал ба үндэсний ухамсрыг нэг талаасаа хоорондоо ижил ойлголт мэт хүлээн авах аль эсвэл тэр өөр эсрэг тэсрэг категори хэмээн ойлгож байгаагаас дээрх тодорхойгүй байдал даамжирч, үзэл суртал ба үндэсний ухамсрын нийгмийн статусыг тодорхойлох, мөн улс төрийн холбогдох арга барилуудыг боловсруулахад нэмэлт ээдрээг үүсгэж байгаа юм. Тухайлбал, үндэсний ухамсрын асуудлыг шинэ нөхцөл байдал дахь үндэсний - төр засгийн өөрийгөө тодорхойлох хэрэгцээ болохынх нь хувьд нэлээн түгээмэл авч үздэг. Харин үзэл суртлын асуудал хэлэлцэх асуудлын тооноос тэр чигээрээ хасагдсан тул үндэсний ухамсрыг тэр бүр хэлэлцэх шаардлагагүй ч юм шиг хүлээн авах болсон. Улмаар үзэл суртлын асуудал үүсэх нөхцлийн бүхий л спектрууд улс төрийн хариуцлагагүй үзэл баримтлал, мөрөөдөл, популяцийн бай болсоор ирсэн. “Орон бүхний пролетар нар нэгдэгтүн”, “Чанар манай зорилт”, гэх мэт популист лоозонгоос өөр юу ч санал болгоогүй.

Үзэл суртлыг хүлээн авахгүй байгаа нь нэг талаасаа нийгмийн үзэл суртлын хүрэн дэх хувийн зохион байгуулалт бүрэн дүүрэн хэрэгжих объектив нөхцөл бүрэлдээгүйтэй холбоотой. Нөгөө талаас үзэл суртлын хандлага нь нийгэмд хиймлээр тулган хүлээлгэсэн өнөөгийн үзэл баримтлал болох либерализмтай шууд эсрэгцэх байдлаар оршиж байгаатай холбоотой юм. Либерализм нь тэр тусмаа үзэл суртлын ямар нэгэн хэмжээнд нийгмийн ухамсарт давамгайлах эрхийг нь үгүйсгэж байдаг¹⁷⁰. Нарийвчлавал лебирализмын хувьд үзэл сурталт засаглалын тоталитар байдал нь түүний гол үнэт зүйлсүүд болох “хувь хүний эрх чөлөө” ба “хүний эрх”-ийн эсрэг шууд аюул занал гэж үздэг. Тэр бүү хэл неолиберализм нь үзэл суртлын хажуугаар төр засгийг өөрийг нь үгүйсгэж, засрашгүй тоталитар бүтэц хэмээн үздэг¹⁷¹. Ийм нөхцөл байдалд үндэсний сэргэн мандалтын цогц алгоритм болох төрийн үзэл суртал бүрэлдэн тогтох нь маш их асуудалтай тулгарах юм.

Нийгэм үзэл суртлыг шинээр тодорхойлох явцад хоёр төрлийн асуудалтай тулгарч байна. нэгдүгээрт, 1980-аад оны сүүлээс өнөөдрийг хүртэл үргэлжилж буй үзэл суртлын дотоод хямрал нь 1980-аад оны сүүл үеийг хүртэл хаагдмал байсан бөгөөд социализм, коммунизмын зарчмуудтай диалектик маргаанд оршсоор ирсэн үндэсний ухамсрын томъёолуудыг бидний ахуй амьдралд оруулж ирсэн асуудал. Хоёрдугаарт үндэсний үзэл суртлын уламжлалт эх сурвалжуудын нийлбэр ба үзэл суртлын цар хүрээг глобаль хэмжээнд эрчимтэй хэрэгжүүлж буй өрнөдийн либерализм хоёрын хоорондох үзэл суртлын эсрэгцэл цоо шинэ түвшинд гарч ирж буй асуудал. Үзэл суртлын иймэрхүү тогтолцоо нь үндэсний үзэл суртлын цогц томъёог олж тогтоох

¹⁶⁹ Севастьянов А.Н. Ты – для нации, нация – для тебя. - М., 2002. х.10

¹⁷⁰ Аксючиц В.В. Под сенью креста. - М., 1997. х.408.

¹⁷¹ Аксючиц В.В. Под сенью креста. - М., 1997. С.408.

боломжийг хязгаарлаж байгаа учраас холбогдох асуудлын бүхий л бүрэлдэхүүн хэсгүүд тэр дундаа түүхэн, улс төрийн, шашны, ертөнцийг үзэх үзлийн өнцгөөс асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай. Хэрэв үндэсний ухамсрын бүхэллэг байдлыг сэргээх зорилготой бол үүнээс өөр арга зам байхгүй. Юуны өмнө үзэл суртлын илэрч болох бүхий л түвшин дэх түүний эсрэгцлийн үндсэн логикийг олж гаргах хэрэгтэй.

Ер нь үзэл суртал гэж юу вэ? Либерализмын өнцгөөс харвал: үзэл суртал гэдэг нь нийгмийн ухамсрын авторитар хэлбэр бөгөөд хувь хүнийг ертөнцийг үзэх үзлээрээ ялгарах болон иргэний хувьд өөрийгөө тодорхойлох түүний эрх чөлөөг бүрэн хязгаарласан байдал юм. Тиймээс “хүний эрх”-ийг зөрчдөг. Харин социаль бүхэллэг гэдэг утгаараа нийгмийн байр сууринаас харвал: үзэл суртлын талаарх хариулт тэс өөр байна. Өөрөөр хэлбэл, үзэл суртал нь нийгмийг түүхэн хөгжлийн бие даасан бүхэллэг субъектээр хадгалдаг (төр улсын нэгэн адил) хамгаалдагчир энэ байр сууринаас үзэл суртлыг асуудалгүйгээр сайн зүйл хэмээн үздэг¹⁷². Түүнчлэн Үзэл суртал нь төр улсын ахуй, оршихуйн объектив хүчин зүйлсийг төлөөлдөг. Үзэл суртлаар нийгэм-түүхийн үнэт зүйлсүүд бүрэн цогцлож, тухайн түүхэн үеийн үе шатан дахь үндэсний дүр төрхийг тусгасан төрийн ижил төстэй байдлын бүхэллэг тогтолцоонд нэгддэг. О.Арины үзэж буйгаар үзэл суртал нь ард түмэн үндэстэн болж хувирах тэрхүү мөчид үүсэн гарч ирдэг. Үзэл суртал нь төр улсын зайлшгүй шаардлагатай шинж чанар билээ¹⁷³. Үзэл суртал нь төрийн үндэсний ухамсрын нэгэн хэлбэр болохынхоо хувьд нэг талаас үргэлж тодорхой, нөгөө талаас нэгэн хэвийн байдаггүй харин ч улс төр, эдийн засгийн тусгал дахь түүхэн үйл явцтай холбоотой байдаг. Энэ утгаараа үзэл суртал нь түүхийн давалгаанд үндэстэнг живүүлэхгүй барьж үндэстний түүхэн оршихуй дахь зохистой байдлыг тодорхойлдог. Үндэсний ухамсрыг үндэсний үзэл суртлын ариун нандин агуулга хэмээн ойлгож болох ба үндэсний ухамсар нь үндэсний түүхэнд императив байдлаар түүхэн замналын зуун зуун эринийг дамжин явдаг. Үндэсний түүхийн императив нь түүхэн дэх үндэстний оршихуйн утга учрыг улмаар тодоройлдог.

Үзэл суртал нь үндэсний утга санаануудыг нэгэн бүхэлд албаар татан оруулдаг утилатир улс төрийн ямар нэгэн матрикс биш, илүү гүн гүнзгий метафизик агуулгыг өөртөө багтаасан байдаг¹⁷⁴. Үндэсний ухамсрыг ертөнцийг үзэх үзлийн хий үзэгдэл мэтээр хүлээн авах нь багассан тул үндэсний ухамсрын ойлголт нь өнөөгийн үндэсний түүхийн оршихуйн тогтолцоонд фундаменталь байр суурийг эзлэх болжээ. Түүнчлэн төрийн үзэл суртлын динамик нь түүхэн нөхцөл байдлын санамсаргүй тусгал байхаа больжээ. Хэрэв үндэсний ухамсрыг үндэсний ижил төстэй байдлын шалгуур хэмээн авч үзээд, үзэл суртлыг үндэсний ухамсрын хэлбэр хэмээн тооцвол үзэл суртлын үүрэг роль нь үндэсний ухамсрын ижил төстэй байдлын түүхэн нөхцлийн өөрчлөлтийн суурин дээр хадгалан хамгаалахад оршиж байгаа юм¹⁷⁵.

Тиймээс улс төрийн үзэл суртал нь тодорхой нэгэн түүхийн үйл явцад үндэсний ухамсрын шугамын хазайлтыг тусгадаг гэж ойлгон хүлээн авбал үзэл суртал нь түүхэн маш чухал үүрэг ролийг гүйцэтгэдэг. Үзэл суртлын уг түүхэн

¹⁷²Осипова Е.В. Общественный идеал как составная компонента мировоззрения. // Духовное измерение современной политики. М., 2003. х.97

¹⁷³ Арин О.А. Россия в стратегическом капкане. - М., 1997. х 34

¹⁷⁴ Шмаков В. Закон синархии. - Киев, 1994. х 265.

¹⁷⁵ Аксючиц В.В. Под сенью креста. - М., 1997. х 307

үүрэг нь үндэсний төрийн ижил төстэй байдлын суурь нь болж үндэсний-түүхийн оршихуйн залгамж холбоог өөрөөрөө хамгаалахад оршино.

Тиймээс үзэл суртал нь тухайн түүхэн нөхцөл байдалд үндэстний нүүр царай болдог. Тухайн түүхэн үе шатанд үндэсний ухамсрыг тодорхойлдог үндэсний үзлийн бүхэллэг тогтолцоо болохынхоо хувьд үзэл суртал нь “орчин үе”-ийн ертөнцийг үзэх үзлийн зарчмуудын санамсаргүй иж бүрдэл биш харин тухайн үндэстний өөрийнхөө өнгөрсөн, одоо, ирээдүйг бүхэлд нь ухамсарлан ойлгохын илэрхийлэл байсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, үндэсний үзэл суртал үндэсний-түүхийн хувь заяаны нэгдмэл байдал буюу хамт туулсан өнгөрсөн үеийн нэгдмэл байдал, одоогийн нэгдэл, ирээдүйн нэгдлүүдийн нийлмэл тусгал юм. Дахин хэлэхэд үндэсний үзэл суртал нь үндэстэнд бүрмөсөн зааж өгсөн үндэсний-түүхийн тогтвортой үзүүлэлт биш бөгөөд харин эсрэгээрээ үндэсний түүхэн үйл явцад нээж илрүүлэх, үржүүлэх шаардлагатай тухайн үндэстний ур чадвар гэж үзэж болно. Тиймээс үндэстэн бүр өөрийн түүхэн зорилтынхоо төлөө түүхэн цаг хугацааны турш үүрэг хариуцлага хүлээж өөрийн үндэсний-түүхийн зорилго зорилтоосоо ухарч болохгүй. Энэхүү амьдралын зорилгыг нь үндэсний ухамсар агуулах ёстой бөгөөд түүхэн туршлагаудыг даван туулах болон ард түмний идеал зорилтыг биелүүлэх зам харгуй дахь үндэсний сүр сүлдийг сэргээх асуудал тэрхүү үндэсний ухамсарт шингэсэн байх ёстой.

Нөгөө талаар бодит түүхэн үйл явцад үндэсний үзэл суртал нь төрийн үзэл суртал хэлбэрээр оршиж ирсэн тул энэ утгаараа үзэл суртал нь улс төрийн хувьд зөв зүйтэй байдаг. Хэрэв үндэсний ухамсар нь үндэстний өнгөрсөн цаг үед тухайн цаг үед холобгдолгүй аливаа нэг тусгалыг илэрхийлдэг бол, үндэсний үзэл суртал нь үндэсний ухамсрын цаг хугацааны аянд хугарч, эрч хүчээ авч одоо үеийн бодит байдлаас түүхэн ирээдүй рүү дамжин өнгөрдөг төвлөрлийн цэг юм¹⁷⁶. Өөрөөр хэлбэл, төрийн үзэл суртал нь тухайн түүхэн үед үндэстний төр-түүхийн ухамсрыг тусгагч үндэсний ухамсрын цаг хугацаанд объективжсэн хэлбэр юм. Энэ мөчид идеал нөхцөл байдал төгсөж, үндэсний сүр сүлд жинхэнэ улс төрийн тавцан дээр гарч ирдэг.

Мэдээжээр улс төр нь хүн төрөлхтний оршихуйн тийм ч төгс төгөлдөр салбар биш. Ерөнхийдөө санамсаргүй байдал, хүний хүчин зүйлс, улс төрийн хүчнүүдийн төрөл бүрийн урьдаас таашгүй зохицуулалт зэрэг олон зүйлээс шалтгаална. Тиймээс улс төрийн үзэл суртал нь улс төрийн тогтолцооны нэгэн хэсэг болохынхоо хүрээнд дотоод агуулга буюу үндэсний ухамсрын харьцангуй хэлбэрийн үнэн байдал, зохистой байдал, жинхэнэ байдал зэргийн өөр өөр түвшнүүдийг илэрхийлдэг¹⁷⁷. Үндэсний үзэл суртал нь бүтцийн хувьд эмпирик байдаг бол үндэсний ухамсар нь метафизик шинж чанартай байдаг тул энэ байдал нь гүн гүнзгий бөгөөд эцэс төгсгөл хүртлээ тодорхой бус эсрэгцлийг агуулдаг¹⁷⁸. Үзэл суртал нь өөрийг нь үгүйсгэх нь төр улсыг өөрийн зохион байгуулалт бүхий нийгмийн үндэсний-түүхийн хэлбэр гэдэг утгаар нь үгүйсгэдэг байна. энэ байр суурийг либерализмын цар хүрээнд эсвэл “тоталитар дэглэм”-ийг нураан унагаах контекстээр илэрхийлж болох боловч¹⁷⁹ үндэсний сэргэн мандалтын төлөөх зорилго зорилтуудаа хамааруулж болохгүй.

¹⁷⁶ Шмаков В. Закон синархии. - Киев, 1994. х.232

¹⁷⁷ Путилов С.В. Русская идея как национальная идея: процесс концептуализации // Русская этнополитология и национальная идея. - М., 2006. х.94.

¹⁷⁸Осипова Е.В. Общественный идеал как составная компонента мировоззрения. // Духовное измерение современной политики. - М., 2003. х.105.

¹⁷⁹ Аксютин В.В. Под сенью креста. - М., 1997. х 397

Үзэл суртлын ийм “эмгэг”-шилтийн асуудал нь үзэл суртлын өөрийнх нь проблем биш, харин хүний ухамсрын дорой байдлын нөлөө илүүтэйгээр холбоотой. Өөрийн ухамсрыг нэгдмэл байлгах нийгмийн тэмүүлэл нь объектив социаль шаардлага хэрэгцээ мөн хэдий ч аливаа хэрэгцээ шаардлагын нэгэн адил гажилт хазайлт, хэт хэрэглээ, завхралаас хамгаалагдсан байж чаддаггүй. Үүн дээр үндэслэн уг хэрэгцээ өөрийг нь эмгэгжсэн асуудал мэтээр үгүйсгэх нь хүний нийгмийн эх сурвалж байгалийн ба социаль эхлэлүүдийг үгүйсгэж байгаа гэсэн утгатай.

Өнөөгийн манай нийгмийн нөхцөл байдлыг төр улсын бүхий л илэрлээр буюу улс төр, нийгэм, эдийн засаг, түүхэн зэрэг бүхий л чиглэлээр хямралтай байна гэж хэлж болно. Энэ хямрал нь “шинэчлэл” биш, “тоталитаризмаас чөлөөлөгдөх” үйл явц ч биш, илүү ул суурьтай, түүхэн зайлшгүй хямрал гэдгийг хүн бүр ойлгож байгаа байх. Энэ үйл явц улам даамжрах тусам, “Монголын үндэстний сэргэн мандалт”-ын тухай улс төрийн мөрөөдөл ор хоосон зүйл рүү холдох тусам, дээрх ухамсарлалт илүү гүнзгий болно. Сүүлийн 10-аад жилийн үндэсний итгэл найдвар өөрийн чадавхгүй байдлын өмнө бууж өгөх янзтай байна. Үнэндээ хямрал гэдэг нь дан ганц гадаад буюу эдийн засаг юмуу улс төрийн шинж чанарыг агуулдаггүй. Түүнчлэн өнөөгийн бодит амьдралын хамгийн гүн гүнзгий дотоод салбарууд тэр дундаа үндэсний үзэл суртлын уламжлалт хэлбэр, ухамсар, үндэсний ижил төстэй байдлыг багтаасан шинж чанарыг агуулдаг¹⁸⁰. Эдгээр эхлэлүүдийн аль нь ч бие дааж төрийн шинэ эхлэлийг дэмжих үндэсний хэмжээний нэгдлийн суурь нь болж чадахгүй. Дээрх хямралыг 70 жил ноёрхсон коммунист дэглэмийн деструктив үр дагавараас үүдэлтэй бөгөөд үндэсний ахуй ба ард түмний архитеп устахад буруутай гэж үзэж байна. Гэхдээ асуудлыг ингэж тайлбарлах нь хэт өнгөц бөгөөд өөрийгөө хий хоосон зүйлсээр тайвшруулах, хаацайлах хандлагыг баримтлагчидад хамааралтай. Харин энэхүү асуудлыг түүхэн иргэншлийн илүү гүнзгий хямрал талаас нь илүү бодитоор үнэлэн дүгнэх юм бол төр-түүхийн шинэ үзэл баримтлалыг олж тогтоох шаардлагатай. Ийм байдлаар асуудлыг ойлгон ухаарах нөхцөлд үндэсний сэргэн мандалтын уламжлалт жороос эхлүүлээд бүх үр дүн муутай арга барилуудыг тайлбарлаж болно.

Цаашдаа хүн төрөлхтний хувь заяаны өмнө бүтэлгүйтсэн коммунизмын туршилтын дараах глобаль, аж үйлдвэржилтийн дараах, капиталист ертөнц гэх ганцхан арга зам үлдсэн үү? гэсэн асуултууд тавигдаж байна. Бодит түүхэн явцад эдгээрийн хариултыг сэдвийн хүрээнд буюу үзэл суртлын хүрээнд өгөх нь илүү зохимжтой. Энэ зорилт нь бидний эрин үед үндэсний гол зарчмын асуудал болоод байна. Энэ тохиолдолд өнөөгийн үзэл суртлын хямралыг энэ тэр гэсэн уламжлалт үзэл суртлуудын тэмцэл байдлаар харах хэрэггүй, харин үзэл суртлын ерөнхий үр дүнг дүгнэх цаг үе гэж ойлгох хэрэгтэй. Энэ нь илүү шинэлэг бөгөөд үр өгөөж бүхий үзэл баримтлал гэдэг нь үзэл суртлын асуудлыг үр бүтээлт гольдрол руу оруулж байгаа байдалтай холбон тайлбарлаж болно. Үзэл суртлын талбарт үндэсний ухамсрын түүхэн субъектүүд буюу эртний сүсэг бишрэлээс коммунизм хүртэлх асуудлууд гарч ирж байгаа нь санамсаргүй хэрэг бус, энэ нь жинхэнэ онцгой үзэгдэл бөгөөд иргэншлийн хагаралыг илэрхийлж байгаа бөгөөд улмаар үндэсний түүхийн утга санаанууд бүгд нээгдэж байгаа учраас үндэсний сүр хүчний түвшинд эдгээр утга санаануудын нэгдлийг ухамсарлан ойлгох шаардлагатай байна.

¹⁸⁰ Панарин А.С. Стратегическая нестабильность в XXI веке. - М., 2003. х.183.

Коммунизмын задрал нь дэлхий нийтэд эдийн засаг, геополитикийн өөрчлөлт байгаад зогсоогүй билээ. Энэ нь үндэсний үзэл суртлын дэд бүтцийн өөрчлөлт байсан¹⁸¹. Үндэсний ухамсар нь өөрийн уг гарлынхаа хувьд метафизик шинж чанартай тул түүнийг эрж хайх нь оюун санааны үйл явц хэмээн ойлгож болно. Тиймээс үзэл суртлын өнөөгийн хямрал нь үндэсний ухамсрыг шинээр тодорхойлохтой холбоотой ертөнцийг үзэх үзлийн хямрал гэж нэрлэж болно. Энэ асуудал нь улмаар өнөөгийн үндэсний-түүхийн сонголтын хамгийн хэцүү бөгөөд таамаглашгүй хүчин зүйл болж байна¹⁸². Аль хэдийнээ улиг болон яригдсаар ирсэн үзэл суртлын уламжлалт хэлбэрүүдийг шинэ төр засгийг бий болгох суурь болгон дэвшүүлэх замаар энэ үйл явцыг хурдасгах оролдлого нь нийгмийн ухамсарт ямарваа нэгэн өөрчлөлт хийхэд дөхөм болж чадахгүй байгаа юм¹⁸³. Механик арга барил энд зохихгүй гэсэн үг. Тухайлбал хаант засаглал ардчилалтай холбоогүйн адилаар нийгмийн эрх тэгш байдлыг ухуулах социалист дадал зуршил нийгмийг ангилан хуваахтай нийцэхгүй. Нөгөөтэйгүүр энэ хямралын нөхцөл байдлыг нэг газраа удаан хүлээж чадахгүй өнөөгийн түүхэн цаг үе өөрөө хурцатгаж байна. Бүрэн төлөвшөөгүй, төөрөгдсөн үндэсний ухамсарт барууны ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлс, холбогдох үзэл суртлын томъёолууд бас нэгэн шинэ асуудлын урсгал болж байна. Энэ асуудал нь объектив үйл явц учраас үндэсний ухамсрын дасан зохицлыг өөрийн эрхгүй шаардаж байна. Гэхдээ эдгээр шинэ үнэт зүйлс нь тухайн үндэсний архитеп, уламжлалт ёс суртахууны зарчимтай хир зохицох нь бас нэгэн асуудал болон гарч ирж байгаа юм. Үндэсний ухамсрын нэгэн цагт барууны хувилбарт тухайлбал, Т.Гоббсын “Бүгд бүгдийн эсрэг дайн”-ны хэлбэрт хөрвүүлэх боломжтой юу? Мөнөөх л баян ядуугийн ялгааны асуудлыг хэрхэх билээ? Иймээс өнөөгийн төрүүдийн хямрал нь үзэл суртлын хямрал байгаад зогсохгүй түүхийн шинэ нөхцөл байдал дахь үндэсний ухамсрыг тодорхойлохтой холбоотой илүү гүн гүнзгий асуудал болоод байна¹⁸⁴. Үүнтэй холбоотойгоор нэгэн зүйлийг тодруулах нь зүйтэй. Цаг хугацааны утга агуулгын метафизик нэгэн хэсэг болсон үндэсний үзэл ба бодит түүхийн талбар дээрх утга агуулгын эмпирик тусгал болсон үзэл суртлын хооронд харьцангуй чөлөөт үзэл санааны маш өргөн талбар оршиж байгаа бөгөөд эл талбарыг үндэсний ухамсрын идэвхтэй гарч ирэх талбайгаар төсөөлж болно. Энэхүү үндэсний соёлын амьд орчинд үндэсний сүр сүлд болон үндэсний ухамсрын утга санаанууд үндэсний үзэл суртлын томъёолол болох үг өгүүлбэр болон хувирдаг. Тиймээс нийгэм дэх үндэсний соёлын ухамсар дотоод нэгдэлгүй байсан цагт дотоод сөргөлдөөн эсрэгцэлтэй байсан цагт төрийн үзэл суртал бүхэллэг байдлаар үүсэн хөгжихгүй¹⁸⁵. Өөрөөр хэлбэл ерөнхий байдлаар бүрэлдэн тогтноогүй ертөнцийг үзэх үзэл тодорхой хэлбэр дүрс бүхий үзэл суртал болж хувьсаж чадахгүй гэсэн үг.

Нэг талаас үндэсний ухамсрыг үндэсний сүр сүлд (өөрөөр хэлбэл үндэсний итгэл найдвар) бүрэлдүүлдэг бол нөгөө талаас үзэл суртлыг үндэсний оюун ухаан бий болгодог¹⁸⁶. Энэ байдал нь үндэсний түүхийн үзэл суртлын эргэлтүүдийн контекстийн хүрээнд ухан ойлгоход маш чухал. Хамгийн ноцтой

¹⁸¹Катасонов В.Н. Национально-государственная идея России. - Пермь, 1998. х.9.

¹⁸² Панарин А.С. Стратегическая нестабильность в XXI веке. - М., 2003. х.183.

¹⁸³ Межуев В.М. Идеология обновления есть идеология свободы / . Освобождение духа. – М., 1991.х. 41.

¹⁸⁴ Севастьянов А.Н. Ты – для нации, нация – для тебя. - М., 2002. х 25.

¹⁸⁵ Панарин А.С. Стратегическая нестабильность в XXI веке. - М., 2003. х.77.

¹⁸⁶ Мөн тэнд

гэх үндэсний хямралууд нь (XVI зууны харийн түрэмгийлэл, XX зууны шинэчлэл, 90-ээд оны хямрал зэрэг) нь тухайн үедээ үндэсний ухамсрыг зүй зохистой илэрхийлэх үзэл суртлын шинэ хэлбэрийг эрж хайж байсан интеллигенцээс (үндэсний оюун санаа) шууд хамааралтай өрнөн гарч байсан. Үүний хажуугаар үндэсний итгэл найдвар ба гадны (ихэвчлэн барууныг дагасан) ухамсар хоёрын хоорондох салалтын үр дүнд тухайн үеийн үзэл суртал нь үндэсний түүхийн холимог бөгөөд нураан сүйтгэх утга санааг олж авч байсан.

Цаг хугацаандаа нийцэх, оюун санаагаа дэлхий нийтийн баримжаатай авч явах нь үндэсний-түүхийн хөгжлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл байдаг. Өөрөөр хэлбэл, түүхэн цаг хугацааны гадуур буюу ази тивийн нэг хэсэг болж үлдэх боломжгүй ч байж болно. (Жишээ нь буддын шашинт улс учраас түүхэнд буддын контекстэнд хамааралтай байсан бөгөөд дорнын салшгүй нэг хэсэг байсаар ирсэн) Энэ бүх хүчин зүйлсийн нөлөөгөөр бүхэлдээ үзэл суртлын хямрал нь үндэсний ухамсрын байнгын үзэгдэл болсон. Үндэсний оюун ухаан ба үндэсний итгэл найдварын хоорондох тэнцвэргүй байдал түүхийг хөдөлгөгч субъектив хүчин зүйл болдог байна. Хэрэв үндэсний ухамсрыг үндэсний итгэл найдварын үр дүнд, харин үзэл суртлыг үндэсний оюун санааны үр дагавар хэмээн үзвэл үндэсний соёлын болоод төр улсын хэмжээнд итгэл найдвар ба оюун санааны тэнцвэр нь үндэсний оюун санааг үндэсний итгэл найдварын эх сурвалжид хандуулах хэрэгсэл, үндэсний ухамсрыг үндэсний үзэл суртлын гол утга санааны баталгаа хэмээн ойлгогдох юм.

Үндэсний ухамсар болон үндэсний үзэл суртлын хоорондох зарчмын хэмжээтэй орон зай нийгэмд эмпирик эсрэгцэл байдлаар бойжих явцдаа үзэл суртлын шинэ хэлбэрүүдийг олж гаргаж ирэхийг шаарддаг¹⁸⁷. Үзэл суртлын хэлбэрийн өөрчлөлт нь өөрөө үзэл суртлын хямрал юм. Үзэл суртлын хэлбэрийн өөрчлөлт нь өнөөгийн үйл явц тодорхой хэмжээгээр нэлээд удаашран сунжраад байна. Үндэсний итгэл найдвар ба оюун санаа хоёр бие биенээ нэг л олж харахгүй байгаагаас гадна хамтран орших нэгэн талбар, нэгэн цаг хугацаа, иргэншлийн талсжилтийн дундын цэгийг олж мэдрэхгүй байна¹⁸⁸. Үндэсний ахуй нь үндэсний түүхийн мянга мянган хэлтэрхий, үндэсний төрийн болон үндэсний ухамсрын олон хэлбэрийн олон жижиг тасархай болж бутран унасан мэт болсон. Үзэл суртлын төөрөгдөл дунд оршиж буй үндэсний оюун санаа нь ямар нэгэн зүйл ойлгохоо ч больж, үндэсний үзэл суртлын тодорхойлолтыг боловсруулан гаргах түүхэн үүрэг хариуцлагаасаа ухрахад бэлэн болсон байна¹⁸⁹. Үүний хажуугаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр үзэл сурталд хандах нийгмийн хандлагыг сулруулж иргэний нийгмийн зүгээс үзэл суртлыг шинэчлэн зохион байгуулах эерэг хандлагыг угаар нь устгаж байна. Үүний үр дүнд үндэсний ухамсар нь цогц утга санаа болон нэгдсэн түүхэн логик агуулаагүй эрээвэр хураавар үзэл суртлын нийлбэр болж хувирсан.

Ийм нөхцөл байдал бүрэлдэн бий болох хэд хэдэн шалтгааныг нэрлэж болно. Нийгэмд үзэл суртлын тогтворгүй байдал бий болох хүчин зүйлийг коммунист үзэл суртлын тогтолцоо гэнэт нурсан мөн өмнөх бүхий л зүйлээ алдаагаар булах сэтгэлгээтэй шууд холбоотой. Өөрийн түүхэнд ингэж сөрөгөөр хандах байдал нь үндэсний үзэл суртлын дахин тодорхойлолтыг олж авах шинэ

¹⁸⁷Осипова Е.В. Общественный идеал как составная компонента мировоззрения. // Духовное измерение современной политики. - М., 2003. х.105.

¹⁸⁸ Катасонов В.Н. Национально-государственная идея России. - Пермь, 1998. х.9.

¹⁸⁹ Мөн тэнд

оролдлогыг үр дүнгүй болгож байна. Үндэсний ухамсарт үндэсний түүхийн өмнөх үе шат байхгүй болсон нөхцөлд өөрийн үндэсний ижил төстэй байдлыг сэргээх боломжгүй. Түүх өөрөө залгамж холбоо бүхий тасралтгүй үйл явц билээ. Бид номны нэг хуудсыг тасдан авч хаявал дараагийн хуудсыг ойлгохгүйтээ адилхан.

Энэ асуудлын хүрээнд үндэсний ухамсрын эсрэгцлийн хамгийн эмзэг сэдвүүдийг ил гаргадаг. Үндэсний-түүхийн залгамжит үргэлжилсэн байдлын ач холбогдлыг үзэл суртлын гурван субъектээр гаргаж ирж болно. Энэ нь нэгдүгээрт, шарын шашны үнэт зүйлс дээр суурилсан ХХ зууны эхэн үеийн хувьсгалын өмнөх үеийн төр засаглал, хоёрдугаарт коммунист үзэл суртлын суурь бүхий ХХ зууны 2-р хагасын социализмын төр засгийн тогтолцоо, гуравдугаарт, ил тод өрнөдийг дагасан үзэл суртлын дүр төрх бүхий өнөөгийн шинэ капиталист төр засаглал. Өнөөгийн түүхийн бодит талбараас дээрх гурвын дундах социалист хэлбэрийг бүх нийтээрээ амжилттай түлхэн гаргаснаар өнөөгийн нөхцөл байдлыг зарчмын хувьд шийдвэрлэх боломжгүй буюу абсурд шинжтэй гэж хэлж болно¹⁹⁰. Өөрөөр хэлбэл, ХХ зууны эхэн үеийн шарын шашин бүхий төл улс болон ХХI зууны эхэн үеийн аж үйлдвэржилтийн дараах үеийн нийгэм хоёрын хооронд ямар ч үзэл суртлын уялдаа холбоо байхгүй. Энэ хоёр үеийг түүхийн залгамж хэлхээсээр шууд холбох нь ямар ч утгагүй болж байна. Үүний үр дүнд үндэсний уналтын цэг, өөрийн ижил төстэй байдлыг алдах мөч, үндэсний оршихуйн ач холбогдлыг алдах эрсдэлд хүрээд байна. Түүхийн тодорхой бус байдал болон үзэл суртлын тулгамдсан эсрэгцэл эмгэнэлтэйгээр удаан үргэлжилж байгаа болон үндэсний ухамсар өөрийн ижил төстэй байдлын хүрээнд тодорхойлогдохгүй байгаагаас харахад өнөө үеийн хямрал нь “бэршээл хүндрэлийн дээд категори”-ийг агуулж байгаа буюу үзэл суртлын тэнцвэргүй байдал болж хувирч байна.

Дүгнэлт

Монголын үндэсний ухамсрын онцлог шинжийг олж харах сонирхол хүчээ авч байгаа нь глобальчлалын үйл явц дахь үндэсний ухамсрын модернизацийн үр дүн гэж ойлгож байна. үндэсний ухамсрыг хэрэгжүүлэх хамгийн чухал зүйл бол үндэсний үзэл суртал юм. Сүүлийн үед үзэл суртлын асуудал төр засаг, соёлын сэдвүүдээс бараг хасагдсан байна. Гэтэл энэхүү либераль ухамсрын хэв маяг нь өөрөө хоёрдмол шинж чанартай. Төрийн чухал асуудлуудын нэг болох үзэл суртлыг өнөөгийн нөхцөлд сэргээх нь үндэсний сэргэн мандалтын зам дахь хамгийн түрүүнд шийдвэрлэх улс төрийн даалгавар болж байх ёстой. Учир нь үзэл суртал ба үндэсний ухамсрыг нэг талаасаа хоорондоо ижил ойлголт мэт хүлээн авах эсвэл төр өөр эсрэг тэсрэг категори хэмээн байгаагаас улс төрийн холбогдох арга барилуудыг боловсруулахад нэмэлт ээдрээг үүсгэж байгаа юм. Үзэл суртал нь төрийн үндэсний ухамсрын нэгэн хэлбэр болохын хувьд нэг талаас үргэлж тодорхой, нөгөө талаас нэгэн хэвийн байдаггүй, харин ч улс төр, эдийн засгийн тусгал дахь хамгийн түүхэн үйл явцтай холбоотой байдаг. Энэ утгаараа үзэл суртал нь түүхийн давалгаанд үндэстэнг живүүлэхгүй барьж үндэстний түүхэн оршихуй дахь зохистой байдлыг тодорхойлдог.

¹⁹⁰ Соловьев В.С. Русская идея // Соч.: в 2 т. - М., 1988. х.220.

Резюме

Однако нынешняя смена идеологических форм очевидным образом затянулась. Национальные вера и разум никак не могут найти друг друга, не могут нащупать общую платформу, общее актуальное время, общие точки новой цивилизационной кристаллизации. Национальное бытие словно распалось на множество фрагментов из разных отрезков национальной истории, разных форм национальной государственности и национально-исторического самосознания. Национальный разум, находясь в полной идеологической растерянности, кажется, уже вообще перестал что-либо понимать и готов снять с себя всякую историческую ответственность за идеологическое самоопределение нации, подчинившись идеологическому хаосу как объективно неизбежному и естественному состоянию общества постмодерна. При этом политика деидеологизации, целенаправленно осуществляемая через СМИ, многократно усиливает идеологическую апатию общества, на корню уничтожая всякие положительные тенденции к его гражданской самоорганизации. В итоге национальное самосознание превратилось в пеструю идеологическую эклектику, лишенную целостного смысла и единой исторической логики.

Ном зүй

1. Андерсон Б. Нация и национализм. М. 2003.
2. Астафьева О. Н. Многообразие моделей этнокультурной идентичности в современном информационно-коммуникативном пространстве // Глобализация и перспективы современной цивилизации. - М. 2005.
3. Арин О.А. Россия в стратегическом капкане. - М., 1997.
4. Аксючиц В.В. Под сенью креста. - М., 1997.
5. Бахтин М.М. Творчество Франсуа Рабле и народная культура средневековья и Ренессанса. М., 1965.
6. Кормер В.Ф. Двойное сознание интеллигенции и псевдокультура // Вопр. философии. 1989. № 9.
7. Севастьянов А.Н. Ты – для нации, нация – для тебя. - М., 2002.
8. Осипова Е.В. Общественный идеал как составная компонента мировоззрения. // Духовное измерение современной политики. М., 2003.
9. Шмаков В. Закон синархии. - Киев, 1994.
10. Путилов С.В. Русская идея как национальная идея: процесс концептуализации // Русская этнополитология и национальная идея. - М., 2006.
11. Панарин А.С. Стратегическая нестабильность в XXI веке. - М., 2003.
12. Катасонов В.Н. Национально-государственная идея России. - Пермь, 1998.
13. Межуев В.М. Идеология обновления есть идеология свободы / Освобождение духа. – М., 1991.
14. Соловьев В.С. Русская идея // Соч.: в 2 т. - М., 1988.

Түүх бол өнгөрөөсөн улс төрийн бодлого

Улс төрийн бодлого бол өнөөдрийн түүх

Э.Фримен

ХААНТ ОРОС УЛСЫН САНХҮҮГИЙН ЗӨВЛӨХ ТҮШМЭЛТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ТУХАЙД

Г. Цэнджав

ШУТИС-ийн Нийгмийн Технологийн Сургуулийн багш, доктор

Хураангуй: Хаант Оросын гадаад бодлого нь ХХ зууны эхэн үеэс Алс дорнодод хандах үйл ажиллагаагаа улам идэвхжүүлж, улмаар Ар Монголд нөлөөлөх талаар бодиттой ажлуудыг хийж эхэлсэн билээ. Тухайн цаг үед Монгол нь туурга тусгаар улсаа тунхаглаж, Хаант Орос улсыг өөрийн өмөг түшгээ хэмээн үзэж, мөнгө санхүүгийн болон зэр зэвсгийн тусламжийг удаа дараа хүсэх болсон.

Хаант Орос улсын зүгээс Монгол дахь өөрийн ашиг сонирхолоо тогтоох гэсэн бодлогод нийцтэй байсан тул монголын талын хүсэлтийг биелүүлэхэд нааштай хандсан юм. Мөн өөрийн эрх ашигт нийцүүлж Монголыг эдийн засгийн протекторат улс болгон хувиргах, монгол дахь хятадын болон бусад улс орнуудын зах зээлийг аажмаар шахан зайлуулах, байгалийн баялгийг тандан мэдэх зэрэг олон ажлуудыг зөвлөх түшмэлээрээ дамжуулан хэрэгжүүлсэн юм

Одоогоос 100 жилийн тэртээ “Монгол улсын Богд эзэн хааны засгийн хэрэг шийтгэх газраас Орос улсын харъяат Сергей Андреевич Козинтой хэлэлцэн тогтоосон гэрээ бичгийн зүйл”¹ хэмээх 12 зүйл заалттай гэрээг 1913 оны 12-р сарын 25-ны өдөр Оросын Петербург хотод байгуулсан юм. Үүнийг Монгол улсын хаан эзний зарлигаар Орос улсад зарагдсан бүрэн эрх барих элчин сайд, сайн ноён хан Намнансүрэн төлөөлж гэрээг байгуулав. Уг гэрээ бичгийн Монголын түүхэнд гүйцэтгэсэн үүрэг зорилтын талаар архивын баримт болон судлаачдын зохиол бүтээл дээр тулгуурлан энэхүү өгүүллийг бичсэн болно.

Хаант Оросын талаас ХХ зууны эхэн үеэр улс төр, эдийн засгийн бодлого үйл ажиллагаагаа алс дорнодод улам идэвхжүүлэх, ялангуяа ар Монголд өөрийн ашиг сонирхолоо нэмэгдүүлэх үйл явц зайлшгүй болсон.

Монголын талаас Хаант Оросыг өөрийн өмөг түшгээ болгож, найрсгаар хандах, улмаар улс орныхоо цаашдын хөгжилд тус нэмэр болох мөнгө санхүүгийн зээл тусламжийг удаа дараа хүссэн явдал нь оросын ашиг сонирхолд илүү нийцтэй болж өгсөн. Тиймээс Оросын тал өөрийн бодлогоо хэрэгжүүлэхийн тулд төлөөний түшмэлийг тавих асуудлыг Монголын талд санал болгож, тулгасан юм. Үүнийг Монголын засгийн газраас аргагүй хүлээн зөвшөөрч, цаашид хоёр талаас гэрээ бичиг үйлдсэн юм. Уг гэрээ бичгийн мөн чанар нь их гүрний бодлого үйл ажиллагаагаар жижиг буурай улсыг эдийн засгийн протекторат улс болгох, монгол дахь хятадын болон бусад улс орнуудын зах зээлийг аажмаар шахан зайлуулах, монголын байгалийн баялгийг

тандан мэдэх, оросын үйлдвэрлэгчид, худалдаачдын эрх ашгийг эрх зүйн хувьд баталгаажуулах, мөнгө санхүүгийн зээлийн эргэн төлөлтийг хянаж байхад оршино.

Олноо Өргөгдсөн Монгол улс байгуулагдсан цаг мөчөөс эхлэн улс орны гадаад, дотоод амьдралд олон чухал шийдвэрлэх асуудлууд тулгамдаж, эдгээрийг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын засгийн газраас ихээхэн зүйлийг сэдэж хийж эхэлсэн аж. Тухайн цаг үед Монгол улс олон зуун жилийн манж, хятадын эрхшээлийн бодлогоор нийгэм эдийн засгийн хоцрогдолд орж, ядууран доройтсон байлаа¹⁹¹. Тулгар төрийнхөө тусгаар тогтнол бүрэн эрхт байдлыг баталгаатай болгох, тусгаар тогтнолоо гадаад улс орнуудаар хүлээн зөвшөөрүүлэх болон эдийн засгийн дотоод амьдралын олон чухал үйл хэргийг амжилттай хэрэгжүүлэхэд тус оронд мөнгө, зэр зэвсэг ихээхэн хэрэгцээтэй байлаа. Тиймээс Хаант Оросоос удаа дараа зээл тусламж хүссэн юм. Хаант Оросын засгийн газар ч хатуухан болзолтой зээл олгож, түүнийхээ эргэн төлөгдөх нөхцөлд анхаарал хүчин чармайлт тавьж байсны нэгэн илрэл нь Монголын засгийн газарт зөвлөх түшмэл С.А.Козинг илгээсэн явдал байв.

Зөвлөх түшмэл илгээх асуудлыг анх Орос улс сэдсэн байна. 1912 онд Монголын засгийн газар Оросоос 2 сая рублийн зээл хүсэхэд Оросын тал санхүүгийн зөвлөх аваач гэсэн саналыг тавихад монголын тал татгалзсан боловч төдөлгүй 1913 онд Оросоос дахин 3 сая рублийн зээл хүсэхэд уг зээлийг олгох асуудлыг дагалдуулан санхүүгийн зөвлөхийг илгээхээр болжээ. Хэдийгээр тийнхүү харь зөвлөх авах асуудал дээр анхандаа Монгол улсын засгийн газар татгалзаж байсан ч хэрэг явдлын өрнөлт нь санхүүгийн зөвлөх авахаас өөр аргагүй байдалд хүргэжээ. Эл үед Монголын хил хязгаар нэн түгшүүртэй болж мөнгө санхүүгийн хувьд төрийн данс “улайссан” байсан учраас арга буюу Оросын шаардлагыг хүлээн авсан байна.

Зөвлөх түшмэл илгээх асуудлаар хоёр улсын хооронд гэрээ хэлцэл байгуулагдсангүй, гагцхүү Монгол улсын ерөнхий сайд Т.Намансүрэн С.А. Козин хэмээх хувь хүнтэй гэрээ байгуулжээ. Анхлан санхүүгийн зөвлөх хэмээн яригдаж, илгээгдсэн С.А.Козин нь “Монгол улсын засгийн газрын зөвлөх түшмэл”¹⁹² гэсэн том нэртэйгээр хүрэлцэн ирж тус орны эдийн засгийн аливаа хэргийг зохион байгуулах ба улсын хөрөнгийг арвижуулах, улсын хэргийг шинэтгэн засах дүрэм хэмжээг зохиох үүрэгтэйгээс гадна Хаант Оросоос зээлсэн мөнгөний зарцуулалтанд хяналт тавих мөн зарим талаар тэдгээр мөнгийг захиран зарцуулах эрхтэй нэгэн болон иржээ.

Нөгөөтэйгүүр зээлсэн мөнгөний эргэн төлөлтийг хэрхэн барагдуулах талаар Монголд нилээд бодиттой, бүтээлч ажлуудыг санаачлан хийлгэх, бусад мөнгө хөрөнгөний эх үүсвэрүүдийг нэхэн гаргах зэрэг үүрэг гүйцэтгэнэ. Үүнийг нотлох баримт бол тухайн үедээ нууц гэсэн ангилалтай байсан өдгөө нууцлалын хугацаа нь дуусч нийтэд нээлттэй болсон ОХУ-ын Архивын баримтууд юм. Эдгээр баримтуудыг ашиглах боломжтой болсон явдал Хаант Оросоос илгээсэн С.А.Козин болон түүний хөдөө аж ахуй хариуцсан зөвлөх барон Витте нарын Монголын засгийн газарт зөвлөх түшмэлээр хэрхэн ажилласныг бүх талаас нь судлах боломж олгосон билээ.

¹⁹¹ УТА.ФА, Д.1,ХН-673.

¹⁹² АВПРИ.ф.Китайский стол.Оп.491,Д.3090, л.11-13

Зөвлөх түшмэлийн бүхий л үйл ажиллагааны тайлан, мэдээлэл болон түүний ажил төрлийн талаарх консулын мэдээлэл зэрэг баримтууд өдгөө Оросын архивуудад хадгалагдаж байна

Тэдгээр баримтууд болон өөрийн орны архивын баримтуудыг үндэслэн Орос улсаас Монгол улсын сангийн хэргийг зөвлөх түшмэлээр ирсэн С.А.Козиноос 1913 оны 12 сарын 25-нд гэрээ бичиг хэлэлцэн тогтоосноос эхлэн зөвлөхийн алба татан буугдсан Олноо Өргөгдсөний 7 дугаар оны цагаан сар хүртэл үйлдсэн албаны хэргүүдийн үр дүнг нэгтгэн дүгнэвээс зөвлөх түшмэлийн хийж гүйцэтгэсэн нэр бүхий 18 ажил болон төлөвлөн бэлтгэсэн боловч хэрэгжүүлж амжаагүй таван ажил нь Монголын талд ихээхэн ач тустай зүйл байсан боловч асар их хэмжээний мөнгө зарцуулж, тэдгээрээс гарсан үр дүн нь чамлахуйц бага байна. Гэхдээ энд бид зөвхөн зарцуулсан мөнгө, улсад орсон орлогыг баримтлан үнэлэлт дүгнэлт өгөх нь бас учир дутагдалтай юм. Тиймээс түүний ажлын дэвшилт талыг онцлон дурьдах хэрэгтэй болов уу.

Улс орны эдийн засгийн амьдралтай холбоотой 10 дүрэм боловсруулан хэрэгжүүлж эхлэсний ачаар Олноо өргөгдсөний анхны жилүүдээс гаалиас олох орлого 1/4 хувьтай байсан бол 1915 он гэхэд улсын орлогын 2/3 хувийг гаалиас хураах болж гааль албан татварын бодлогыг нилээд цэгцэлжээ¹⁹³. Монгол орныг судлах 2 удаагийн экспедиц зохион байгуулан шинээр орлого оруулж болохуйц эх сурвалжуудыг тогтоосон нь чухал зүйл байлаа. Харин дээрх шинжилгээний ангиудын цуглуулсан олон баримт сурвалжуудын хуулбарыг ОХУ-ын архивуудаас авч Монголдоо авчирвал ХХ зууны эхний 10 жилийн тус орны нийгэм-эдийн засаг, соёлын хөгжилтийн түүхийг судлахад нэн чухал сурвалжууд учир монголын түүх судлалд ихээхэн тустай хэрэг болно.

Монголын тал зөвлөх түшмэл урих асуудлыг Хаант Оросын шахалт доор хүлээн зөвшөөрсөн бөгөөд Оросын Засгийн газраас томилсон С.А.Козинтэй (хувь хүнтэй) гэрээ бичиг солилцжээ.

Гэрээнд, зөвлөх нь:

- Монгол улсын аливаа хэргийг зохион байгуулах ба улсын хөрөнгийг захирах хэрэгт зөвлөх түшмэл болгохоос гадна, бас улсын засгийн хэргийг шинэтгэн засах дүрэм хэмжээг зохиолгоно.

- Улсын хөрөнгө ба орлогыг эрхлэн захирах хороо ба бас Улсын санхүүгийн зүйлийг хадгалах ба хянан байцаах хэргийг эрхлэн захирах хороог Сангийн яаманд хавсарган байгуулж, орон нутагт салбаруудыг байгуулах ажлыг энэхүү зөвлөх түшмэлээр эрхлэн шийтгүүлнэ.

Дүрэм журмыг нь боловсруулан сайдуудын хуралд өргөн мэдүүлж батлуулна.

- Аливаа татварыг авах зүйлийг тогтоох ба бас улсын хөрөнгөнөөс шинэ орлого олоход тус болгохыг бодож мөнхүү зөвлөх түшмэл, улсын харъяат газар, аж ахуй зэргийг байцаан тоолох ба дэлхийн хөрөнгийг шинжлэх явдлыг цөм үүсгэн үйлдүүлнэ.

- Эдийн засгийн хэргийг сайжруулан засахыг бодож, хууль дүрэм зохиогоод, сайдуудын чуулганд өргөн барьж, шүүмжлүүлэн батлуулахаас гадна, бас

¹⁹³ Ж.Урангуа. ХХ зууны эхэн үеийн Монгол улс.УБ.,2010,т.130

Монгол улсын засгийн хэрэг шийтгэх газраас тусгайлан тушаасан хууль дүрмийг зохионо.

Харин Монгол улсын засгийн хэрэг шийтгэх газар нь:

- мөнхүү зөвлөх түшмэлийн хэрэглэлд сар бүр нэгэн мянган /цельков нь нэг рублийн мөнгөн зоос /цаас олгохоос гадна Монгол газарт одох ба Орост буцахын замын хэрэглэлд тус бүр нэгэн мянган гурван зуун цаасыг нэгмөсөн гаргаж өгнө.

- Оросоос урин авчирах эрдэмд боловсорсон хүн нарын хэрэглэлд жил бүр дөрвөн түмэн цаас гаргаж, чухамхүү хэрэглэх тухайг үзэж, сар бүр мөнхүү зөвлөх түшмэлд өгнө.

- Энэхүү гэрээг баталсан өдрөөс эхлэн, гурван жилийн хугацаагаар дагаж явуулна гэжээ.

Ерөнхий сайдын дээрх айлчлалаар монголын тал Хаант Орос улсаас 3 сая рублийн зээл хүссэн бөгөөд энэ байдлыг Оросын тал маш чадамгай ашиглан монголчуудын дунд нэвтрэн орж, бүхий л салбарт нь хяналт тавих, хойш нь мэдээлж байх үүрэг бүхий төлөөлөгчийг¹⁹⁴ илгээж чадсан аж. Монголд туслах нэрийн дор өгч буй зээлийнхээ эргэн төлөгдөх нөхцлийг ч буй болгоход чиглэж байв.

Монгол улсын хувьд бол мөнгө санхүүгийн гачигдалтай байдлынхаа улмаас тийнхүү Хаант Оросоос зөвлөх түшмэл авах байдалд хүрчээ.

Оросын талд С.А. Козинд нарийн зөвлөмж өгсөн байдаг¹⁹⁵. Чингэхдээ Зөвлөх нь 1912 оны намар байгуулсан Орос-Монголын найрамдлын гэрээнд заасан зүйлтэй үйл ажиллагаагаа нарийн уялдуулах бөгөөд Оросын ерөнхий консулын зөвлөмжийг дагах ёстой. Авч хэрэгжүүлэх санхүүгийн болон захиргааны арга хэмжээнүүд өндөр хөгжилтэй нүүдэлчин улс түмнүүдийн жишигт хүрсэн байх ёстой.

Үйл ажиллагааны эцсийн үр дүнд:

- Орон нутгийн орлого болон зээлээс олж буй бүх мөнгө улсын сан хөмрөгт орж байх
- Засаг захиргаа, шүүх, санхүү, нийгмийн болон бусад байгууллагуудыг Орос улсын маягаар зохион байгуулж эрх зүйн соёлыг нэвтрүүлэх
- Ноёд алба татвар авдаг явдлыг зогсоож, алба татвар авах эрхийг улсын онцгой эрх болгох
- Тус орныг эдийн засаг-статистик болон хүн ам зүйн хувьд судлан шинжлэх

¹⁹⁴ АВПРИ. Ф.Китайский стол. Оп.491,Д.3090, л.16-17 “Заметка по поводу назначения Финансового Советника в Монголии”, л.283 “Главнейшие указания Советнику Монгольского правительства”

¹⁹⁵ АВПРИ. Мөн тэнд, л.283

- Газар ашиглах болон эзэмших явдлыг нарийн зохион байгуулах явдлыг эхлүүлж, үүнээс олох орлогыг улсын санд оруулах болон орлогын шинэ эх сурвалжуудыг эрэн олох
- Орон нутгийн засаг захиргаа, шүүхийн байгууллага болон шүүх хууль тогтоомжийг эмхлэн цэгцлэх
- Хүн эмнэлэг болон мал эмнэлгийн ажлыг буй болгох
- Ардын сургууль байгуулах зэрэг ажлууд хийгдсэн байх ёстой гэжээ.

Боловсруулсан бүх дүрэм журам Монголын талд танилцуулхаас өмнө ерөнхий консулд үзүүлж танилцуулж Хаант Оросын эрх ашигт нийцэж байгаа эсэхийг хянуулах үүрэгтэй байв.

Эл үед Хүрээнд Оросын ерөнхий консулын алба, цэргийн зөвлөх, худалдааны төлөөлөгч, санхүүгийн зөвлөх гэсэн албан тушаалтнууд ажиллаж Хаант Оросын гадаад бодлогыг Монголд хэрэгжүүлж байлаа. Чингэхдээ санхүүгийн зөвлөхийн үүрэг нилээд өвөрмөц байв. Учир нь тэрбээр Ерөнхий консулаас нууцаар удирдамж авахын зэрэгцээгээр, хэрэг дээрээ Монголын засгийн газрын зааврын дагуу ажиллаж буй бие даасан этгээд мэтээр харагдаж, монголчуудын итгэл найдварыг олж авах ёстой байжээ. Санхүүгийн зөвлөхийн үйл ажиллагааны улс төрийн талыг авч үзвэл тэрээр түүнд удирдамжийг Гадаад хэргийн яам нь өгч, санхүү болон засаг захиргааны үйл ажиллагаанд нь Сангийн яаманд нь хамаарч байжээ. Эцэст нь дүгнэхэд С.А.Козинтой байгуулсан гэрээ нь Монголд эдийн засгийн олон салбарын ажлуудыг тодорхой зааг ялгаатай болгохын зэрэгцээ явуулах үйл ажиллагааг удирдлага санхүүгээр хангахад чиглэгджээ. Мөн санхүү эдийн засгийн бодлого зорилтыг төлөвлөж, ашиг орлогыг нэмэгдүүлэх, хөрөнгө санхүүг арвижуулахын тулд дотоод нөөц бололцоог дайчлан ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад өргөн мэдүүлсэн гэрээ болсон байна. Гэхдээ гэрээ байгуулагч хоёр талын үүрэг хариуцлагын талыг үзвэл, оросын талын гэрээний хариуцлагын эргэн тооцох асуудлыг огт дурдаагүй байсан. Ийм ч үүднээс С.А.Козин хийсэн ажлын баримтаа хаана, хэнд үлдээсэн нь тодорхойгүй, мөнгө санхүүгийн тайлан тооцоогоо бүрэн гүйцэд тайлагнаагүй гэнэт нутаг буцсан явдал юм. Удалгүй Орос оронд Октябрийн хувьсгал гарч, хуучин засгийн үйл ажиллагаа зогсож, шинээр байгуулагдсан Зөвлөлт засаг Монголд төлөх дутуу 2 сая рублийг хүчингүй болгосон юм

Abstract

The beginning of XX century, the Russian foreign policy to became active in the Far East such as Outer Mongolia. In that time, Outer Mongolia declared own independence from Qing Dynasty and some aids had been supported by the Russia, which was encouraged by concept of the Russian foreign policy. Therefore, the Russian government implemented the action of the economic protectorate program in Mongolia, was searching natural recourse and was forcing out the Chinese traders from the country by the Russian consuler.

Ашигласан материал:

1. Үндэсний Төв Архив фонд А-4 хн 673
2. РГИА фонд-1276. дело 463, стр.413
3. АВПРИ фонд Китайский стол. опись 491, дело 3090
4. Урангуа.Ж . ХХ зууны эхэн үеийн Монгол улс (1911-1919). УБ., 2010

АНУ-ЫН УЛС ТӨРИЙН СИСТЕМ

Ё.Довчин

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн эрхлэгч, профессор

АНУ нутаг дэвсгэрийн хэмжээгээрээ Орос, Канад, Хятадын дараа дэлхийд дөрөвдүгээрт ордог. Америк зүүн, баруун талаараа хоёр их далайгаар хүрээлүүлж, хойгуур урдуураа төдийлөн “цэрэг дайнч” гэхээргүй хоёр улстай хиллэдэг нь нутаг дээрээ дайн тулаан хийлгүй, гадаадад энх тайванч бодлого баримтлах таатай боломж олгож иржээ. Гэвч тив алгасдаг пуужин, өвч зэвсэглэсэн усан доогуур шумбагчг завь гарч ирсэн нь энэхүү газар зүйн байршил АНУ-ыг дэлхийн улс төрийн үйл явцаас тэр бүр хол тасархай байлгаж чадахгүй гэдэг нь тодорхой болсон бөлгөө.

АНУ хүн амаараа (2011 оны байдлаар 311 сая хүнтэй) Хятад, Энэтхэгийн дараа дэлхийд гуравт ордог. Энэ нь АНУ оршин тогтносон 215 жилд хүн ам нь 679 хувиар өссөн гэсэн үг ажээ. Дэлхийн өнцөг булан бүрээс 50 сая хүн цагаачлан ирсэн нь өрнөдийн соёл иргэншлийн түүхэнд томоохонд тооцогдох шилжилт хөдөлгөөн байв. Иймээс Америкийг цагаачдын эх орон гэж нэрлэх нь зүй ёсны хэрэг. Тухайлбал, уугуул иргэд нь хүн амынхаа 2,6 хувийг, үлдсэн хэсгийг гадаадаас ирж суурьшигчид, тэдний үр сад эзэлдэг ажээ.

АНУ дэлхийн хамгийн хүчирхэг эдийн засагтай орон. Түүний үндэсний нийт бүтээгдхүүн 1995 онд 7,5 тэрбум доллар байсан 2011 оны байдлаар 15097 тэрбум долларт хүрчээ. Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдхүүн 48442 доллар байна. Америк доллар олон улсын валютын харилцааны үндсэн нэгж хэвээр байна. Гэхдээ зарим эдийн засагчид америкийн эдийн засгийн өсөлтийн хурд саарсан, олон жилийн турш том зээлдүүлэгч орон байснаа өртэй (зөвхөн 1997 он гэхэд үндэсний дотоод өр 5,2 миллиард долларт хүрсэн) улс болсон, төсвийн алдагдал өссөөр байгаа зэргээс үүдэн түүний эдийн засгийн ноёрхол ард үлдсэн гэж тайлбарлах нь бий. Гэвч тухайлбал, төсвийн алдагдлыг багасгах талаар ерөнхийлөгч Клинтон үеэс шийдвэрлэх алхам хийж чадсан байна. Гэхдээ \$40 тэрбумын хохирол учруулсан 2001.09.11-ний террорист халдлага, \$522 тэрбумыг залгисан Иракийн дайны хор уршиг өнөөдөр ч америкийн эдийн засагт туссаар байгааг мэргэжилтнүүд сануулсаар буй. Одоо дэлхийн санхүү-эдийн засгийн хямралын нөхцөлд эдийн засгийн өсөлтөө хадгалах, ажилгүйдлийг бууруулах нь АНУ-ын төрийн бодлогын үндсэн чиглэл болж байна.

Америкийг хүмүүс капиталист үзэл санаа, чөлөөт зах зээлийн өрөсөлдөөн, чөлөөт бизнесийн сонгодог жишээ гэж ойлгодог. Америкчууд ч индивидуаль соёлоороо, хүний эрхээрээ бахархдаг. Иймээс тэр ойлголтыг буруу гэх аргагүй. Гэвч америкийн төр чөлөөт эдийн засгаа тэр чигт нь зах зээлд даатгадаг гэвэл дэгсдүүлсэн болно гэж судлаачид бичдэг. Жишээлбэл, америкийн засгийн газар америкийн бизнестээ тусалдаг. Засаглалын байгууллагууд эдийн засгийн маш өндөр өртөгтэй шинжилгээ судалгаа хийж, үр дүнг нь хувийн компаниудад үнэ төлбөргүй өгдөг. Конгресс америкийн үйлдвэрлэгчдийг хамгаалж аж үйлдвэрийн тодорхой нэрийн бараа таваарын импортод тоо хэмжээ тогтоодог. Жинхэнэ чөлөөт зах зээл ямар хөлс олгохоос үл хамааран хөдөлмөр эрхлэж буй хүн бүрт тогтоосон хэмжээнээс доош цалин хөлс олгохгүй байхыг холбооны хуулиар баталгаажуулсан байдаг. Америкчууд хэдийгээр чөлөөт бизнесийн давуу талыг мэддэг ч төрд даатгалтай бизнес эрхлэхийг эрхэмлэдэг байна.

АНУ эдүгээ дэлхийн улс төрийн бодлого, олон улсын тавцан дээрх гол тоглогчдын нэг юм. XIX зууны сүүл хүртэл АНУ-ын гадаад бодлого дэлхий дахинаас тусгаарлагдмал байсан гэж болно. Гагцхүү Испани-Америкийн дайн (1898), Орос-Японы хоорондын энхийн гэрээнд (1905) Теодор Рузвельт зуучилсан, дэлхийн I дүгээр дайны төгсгөлд (1917) АНУ оролцсон тэр цагаас гадаад бодлогод нь эргэлт гарчээ.

1945-1989 онд дэлхийн улс төрийн бодлогыг “Хүйтэн дайн” тодорхойлж байсан бөгөөд эсрэг хоёр талыг АНУ, ЗХУ гэсэн хоёр хэт их гүрэн толгойлж байв. 90-ээд оны эхээр “хүйтэн дайн” дууссан ч АНУ-ын гадаад бодлого олон улсын өнөөгийн нөхцөлд “хүйтэн дайн”-ы үеийнхээс ч дутахааргүй нарийн төвөгтэй сорилтуудтай тулгарч байна. АНУ нь Их Британи, Франц, Хятад, ОХУ-ын хамт “цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн клуб”-ын гишүүнд багтдаг. “Хүйтэн дайн”-ы дараа ч цөмийн зэвсэгтэй орнуудын тоо нэмэгдэж 8-9 болсон нь цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх, зэвсэглэлийг хязгаарлах асуудлуудыг хурцаар тавих болов. Энэ мэтийн олон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн төлөө НАТО-гийн бүрэлдхүүнд, НҮБ-ын ивээл дор АНУ гадаад бодлогын үйл ажиллагаагаа явуулж байна.

АНУ-д улс төрийн бодлогыг хэрэгжүүлэх тухайд нэг биш, харин олон засгийн газруудын үйл ажиллагааны талаар ярина гэсэн үг. 1997 оны байлаар АНУ-д Холбооны засгийн газрыг оруулаад 87000 гаруй засаглалын бүтэц, тухайлбал, 50 муж, 3043 тойрог, 19372 хот, 16629 дүүрэг, 13726 орон нутгийн сургуулийн хэсгүүд, 34683 тусгай тойргууд байна. Эдгээр засаг захиргааны нэгж бүр өөрийн бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хуулийн болон зиндаа зэрэглэлийн тодорхой эрх мэдэлтэй байдаг. Энэхүү 87453 бүтцээс холбооны засгийн газар өөрийн орлогын хамгийн ихийг, жишээ нь, бүх татварын 69 хувь, бусад хураамжийн 59 хувийг олж авдаг байна. Энэ хэмжээ Британи, Швед, Япон мэтийн нэгдмэл улсуудаас бага, харин холбооны улсууд дотроо хамгийн өндөр юм байна. АНУ-д ҮНБ-ий 29 хувийг татварын орлогоос бүрдүүлдэг нь аж үйлдвэржсэн орнууд дотор (хамгийн өндөр нь Швед- 56,9%) хамгийн доод хэмжээ ажээ. Америкийн засгийн газрын бүтцүүдийн нийт зарлагын тэн хагасаас илүү нь холбооны засгийн газарт, үлдсэн хэсэг нь муж, орон нутгийн засаг захиргаанд оногддог байна. Төсвийн 63 хувийг дотоод нийгмийн хэрэгцээнд, 18 хувийг батлан хамгаалахад, 15 хувийг улсын өрийг төлөхөд зарцуулах жишээтэй. Нэг хүнд ногдох эрүүл мэндийн зардлаар АНУ дэлхийд тэргүүлдэг бол 25-64 насны иргэдийн 24 хувь нь их сургуулийн боловсролтой байна.

Америкийн улстөрийг авч үзнэ гэдэг бол **Үндсэн хуулиас** нь эхэлнэ гэсэн үг. АНУ-ыг харьцангуй “залуу” улс гэх нь цөөнгүй. Гэвч эдүгээ дэлхийн улсууд мөрдөж байгаа бүх бичмэл үндсэн хуулиуд дотроос Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль хамгийн “ахмад” нь юм. Гэвч үндсэн хуульт ёсыг үүсгэж шинэ маягийн Холбооны улс байгуулж дэлхийн тэргүүлэх гүрэн болтол хөгжүүлсэн тэр зам америкчуудын хувьд шулуун дардан байгаагүй нь лавтай.

1775 – 1783 оны Хувьсгалын дайнд америкчууд тусгаар тогтнолоо олж авсан нь түүхэн үйл явдал байсан ч үүний дараа олон бэрхшээлүүдтэй тулгарчээ. Манай гариг дээр өдгөө 200 гаруй үндэсний төр улс байдаг гэвэл тэдгээрийн ихэнх нь харьцангуй саявтар тусгаар улс болсон юм. Дэлхийн улсуудын 73 гаруй хувь нь дэлхийн II дайны дараа тусгаар тогтнолоо зарлажээ. Тэдгээрийн заримынх нь улс төрийн байгуулал хөл гараа олигтой ололгүй өнөө хүрч цаашдын хөгжлийн загвараа сонгох гэж оролдож байна. Тэгвэл эдгээр улсуудын өмнө тулгарч байгаа сорилт бэрхшээлүүд олон шинжээрээ 1783 оны

дараахь Америктай төсөөтэй байгааг тэмдэглэсэн байдаг. Тэр үед америкийн муж улс бүр тусгаар тогтносон улс шиг авирлаж байв. Бүгд өөрсдийн үзэмжээр ажил хэргээ явуулж, үндэсний хэрэгцээ шаардлагыг үл хайхран хөрш улсууд бие биеийнхээ бараанд татвар ногдуулж байжээ. Зарим муж улсад бүр дахин зэвсэг барьж бослого гаргахдаа тулсан байна. Ийм нөхцөлд муж улсууд үндсэн хууль баталж, түүгээр дамжин нэг гэр дотор багтах зайлшгүй хэрэгцээ үүссэн нь илэрхий. Үндсэн хуулийг боловсруулж баталсан нь дэлхийн бөмбөрцгийн баруун хагаст төдийгүй дэлхийн хэмжээнд улс төрийн шинэ байгууллыг урлан дархалсан хэрэг байв. Учир нь хожим хойно чухамхүү олон улс эл зам мөрөөр замнасан байдаг. Энэ үйл явцад тухайлбал, *холбооны улсын* шинэ загварыг гаргаж, засаглал хуваах онолыг анх удаа америкийн бодит хөрсөн дээр буулгаж эрх мэдлийн харилцан хяналт, тэнцвэржилтийн зарчмыг (*checks and balances*) хэрэгжүүлсэн юм. Улс төрийн хурц асуудлуудыг зөвшилцлийн замаар шийдвэрлэж болдгийг нотлосон бөгөөд үй олон *харилцан буулт* хийсний дотор ялангуяа Сенат, Төлөөлөгчдийн танхим дахь хүн амын төлөөллийн тоо, боолчлол, хувь хүний эрхийн асуудлыг шийдснээс тод харагддаг. Мөн үндсэн хуулийн маргаан мэтгэлцээний явцад анхны улс төрийн намууд үүссэн байна. Ийнхүү улс төрийн ширүүн тэмцэл, их зөвшилцөл, өмнөх үеийн улс төрийн сэтгэлгээний өв, олон чухал баримт бичгүүдийг ашиглан боловсруулсан Үндсэн хууль 1787 онд бэлэн болж, 1789 онд албан ёсоор батлагдсан түүхтэй. Гарын үсэг зурсан 55 төлөөлөгч дотор Вашингтон, Франклин, Хамильтон, Мадисон, Моррис зэрэг шинэ үндэстний гарамгай удирдагчид, нэрт зүтгэлтнүүд байв. Угсаа гарвал, ашиг сонирхол, нийгмийн байдлаараа өөр өөр байсан ч тэд Үндсэн хуулийн оршилд тунхагласан “Нэгдсэн улсын **ард түмэн бид** улам төгс боловсронгуй холбооны улс төлөвшүүлэн бүрэлдүүлэхийн төлөө, шударга шүүх ёсыг тогтоох, дотоодын амгалан тайван байдлыг баталгаажуулах, хамтран батлан хамгаалах, бүх нийтийн сайн сайхан аж байдалд тус дөхөм болохын тулд түүнчлэн өөрсдөдөө болон хойч үеийнхэндээ Эрх чөлөөний үр шимийг эдлүүлэх зорилгоор Америкийн Нэгдсэн Улс даяар энэхүү Үндсэн Хуулийг тогтоож ёслол төгөлдөр тунхаглан баталж байна” гэсэн үндсэн зорилго дор нэгдэцгээсэн байна.

Америкийн Атлантын далайн эргийн орчмын өөр хоорондоо эрс ялгаатай 13 муж улсын 4 сая хүнийг засаглах үндсийг тогтоохоор XVIII зууны сүүлчээр анхлан боловсрогдсон тэрхүү баримт бичгийн үндсэн заалтууд зөвхөн 27 нэмэлт өөрчлөлттэйгээр хэвээр үлдэж, өнөөдөр Атлантын далайгаас Номхон далай хүртэл сунаж үргэлжилсэн уудам нутгийг эзэлж, улам олон янз болсон 50 муж улсын 300 сая гаруй америкчуудын хэрэгцээнд үйлчилсээр байгаа ажээ. Дурдсан 27 нэмэлт өөрчлөлтүүдээс хамгийн чухалд эхний 10 нэмэлт ордог. Тэдгээрийг бүхэлд нь Эрхийн тунхаглал гэдэг бөгөөд үндэсний засгийн газраас зөрчиж үл болох хувь хүний эрхүүдийг тоочиж жагсаасан байдаг. Иргэний дайн дууссаны дараахан оруулсан 14-р нэмэлт өөрчлөлт холбооны хуулиуд муж улсуудын хуулиас дээд хүчинтэйг зааж, муж улсуудад америк иргэдийн эрх, эрх чөлөөг зөрчихийг хориглосон бол 13-р нэмэлтээр боолчлолыг хориглож, 15-р нэмэлт боол байсан хүмүүст сонгуулийн эрх олгож, 19-р нэмэлт (1920) эмэгтэйчүүдэд сонгох эрх олгож, 22-р нэмэлт (1951) ерөнхийлөгчийн алба хаших хугацааг хоёр сонгуулиар хязгаарласан байх жишээтэй. Сүүлчийн 27-р нэмэлт нь (1992) Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын гишүүдийн ажлын хөлсөнд өөрчлөлт оруулж буй хууль дараагийн сонгууль болтол үйлчлэхгүй байх тухай заасан байна. Ийм нэмэлт өөрчлөлтүүд орсон хэдий ч 1789 оны Үндсэн хуулийн бүх үндсэн элементүүд хүчинтэй хэвээр үлджээ. Америкийн

төрийн байгуулал хөгжлийн явцад уламжлагдсан ёс заншил, хууль эрх зүйн шийдвэрүүдийн нөлөөгөөр өөрчлөгдсөөр байсан ч Үндсэн хууль дахь нэг ч үгийг хөндөөгүйг онцлон тэмдэглэдэг. Тухайлбал, шүүхийн хяналтын систем нэвтрүүлсэн, улс төрийн намууд гарч ирсэн, ерөнхийлөгчийн сонгуулийг хэдхэн хүний өрөө тасалгаанаас гаргаж бүх иргэдэд нээлттэй үндэсний хэмжээний үйл хэрэг болгосон зэрэг нь үүний жишээ юм. Ийнхүү АНУ-ын Үндсэн Хуулийн зүйл заалтууд, тэдгээрийг амьдрал дээр сахиж мөрдсөн практик нийлээд *Үндсэн хуулийн тогтолцоо* нь бүрдүүлдэг байна. Энэ нь -Холбооны улс, -Засгийн эрх мэдлийн хуваарилалт, -Шүүхийн хяналт гэсэн ялгарах гурван онцлог шинжтэй ажгуу.

Холбооны улс (federalism) гэдэг нь холбооны болон муж улсуудын засгийн газруудын хооронд эрх мэдлийг хуваасан, гэхдээ муж улс болгон өөрийн статусын хүрээнд хуулийн дагуу бүрэн эрх эдэлдэг улс төрийн систем юм. Түүхэнд ийм улсууд байсан боловч холбооны улсын анхны орчин үеийн загварыг америкийн Үндсэн хуулийг зохиогчид бий болгосон байна. Муж улсууд америкийн төрд үндэсний хүчирхэг засгийн газар хэрэгтэй гэдэг дээр санал нэгдэж байсан боловч зарим нь тэдэнд эрх мэдэл өгөөгүй цагт үндэсний засгийн газарт орохоос татгалзаж байв. Засаглалын эрх мэдлийг төв засгийн газар ба муж улсуудын засгийн газар хооронд хувааж, Сенатад муж улсуудын тэгш төлөөлөл олгох замаар энэ мухардлаас гарчээ. Гагцхүү ийм нөхцөлд том, жижиг муж улсууд шинэ үндсэн хуулийг батлахыг зөвшөөрөв. Үүний зэрэгцээ америкийг үндэслэгчид олонхийн бүлгийн зүгээс гарч болзошгүй дарангуйллын аюулаас ихэд болгоомжилж байсан учраас үндэсний засгийн газар ба муж улсуудын засгийн газар хооронд эрх мэдлийг хуваах зарчмыг бие биеэсээ хараат бус хууль тогтоох, гүйцэтгэх, шүүхийн салаа мөчрүүдийг байгуулахтай хослуулах хэрэгтэй гэж үзэж байв. Америкийн холбооны системийг Австрали, Канад, Герман, Швейцари зэрэг дэлхийн олон улсууд авч хэрэглэсэн юм. Америкийн холбооны систем төрийн эрх мэдлийг хуваарилахдаа, тухайлбал, холбооны засгийн газар дайн зарлах, гадаад орнуудтай гэрээ хэлэлцээр хийх, зоос мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, муж улсуудын хоорондын худалдааг зохицуулах эрх мэдэлтэй байхад муж улсуудын засгийн газарт үндсэндээ боловсрол, гэрлэлтийг батлах, цуцлах, бусад мужуудтай худалдаа хийх, жолооны үнэмлэх олгох зэрэг эрх мэдлийг олгосон байдаг. Холбооны засгийн газар сургууль барих, зам тавих, настнууд, өвчтнүүдэд тэтгэвэр тэтгэмж олгоход муж улсуудад татаас өгдөг байна. Татвар авах, гэмт хэргүүд, тэдгээрийн шийтгэлийг тодорхойлох зэрэг нь төв засгийн газар, мужуудын засгийн газрын аль алиных нь эрх мэдэлд багтдаг. Ийнхүү муж улсуудын засгийн газар үндсэн хуулийн тодорхой зүйл, нэмэлтүүдэд зааснаас давж эрх мэдэл эдэлдэггүй бол холбооны засгийн газар муж улсуудын эрх мэдэлд байдаг асуудлуудад хутгалдаж оролцох үндсэн хуулийн эрх байдаггүй.

АНУ-ын улс төрийн системийн нэг онцлог нь дээр дурдснаар **засаглалын эрх мэдлийг бие даасан гурван салаа мөчирт** хуваадаг. Өөрөөр хэлбэл засаглалын нэг салаа мөчирт ажиллаж байгаа хүн нөгөө хоёрт нэг зэрэг ажиллаж болохгүй гэсэн үг. Энэ нь парламентын засаглалтай улсуудад байдаг “*эрх мэдлийн нийлэлт*” буюу гүйцэтгэх засаглалын тэргүүн парламентын гишүүн байдаг.

Засаглал хуваадаг энэ системд засаглалын гурван салаа мөчрийг толгойлдог хүмүүс өөр өөр хэлбэрээр харилцан адилгүй хугацаагаар сонгогддог. Конгрессын гишүүд шууд сонгуулиар хоёр жилийн хугацаатай сонгогдох бөгөөд дахин сонгогдохыг хязгаарлаагүй. Сенатын гишүүд шууд

сонгуулиар 6 жилийн хугацаатай сонгогдох бөгөөд дахин хэдэн ч удаа сонгогдож болно, гэхдээ сенаторуудын гуравны нэг нь 2 жил тутам шинээр эсвэл дахин сонгогддог. Ерөнхийлөгчийг *сонгогчдын коллеги* 4 жилийн хугацаатай сонгох ба гэхдээ хоёроос илүүгүй удаа сонгогдоно. Холбооны бүх шүүгчид, түүний дотор Дээд шүүхийн гишүүдийг Ерөнхийлөгч томилж Сенатын олонхи батламжилна.

Төрийн эрх мэдлийн хуваарилалтын үндэс нь эрх мэдлийн **харилцан хяналт, тэнцвэрийн тогтолцоо** (checks and balances) юм. Түүний ачаар салаа мөчрийн нэг нь нөгөө хоёр салаа мөчир түүний үндсэн хуулийн эрхийг булаан авахаар завдахад саад хийх чадвартай байна гэсэн үг. Жишээ нь, Сенат нь ерөнхийлөгчийн өндөр албан тушаалд нэр дэвшүүлсэн хүмүүсийг батлахгүй байх, эсвэл олон улсын гэрээг соёрхохоос татгалзаж болно. Конгрессын хоёр танхим хамтарч ерөнхийлөгчд эсвэл холбооны шүүхийн гишүүдийг импичментээр огцруулж болно. Ерөнхийлөгч эргээд конгрессын ямар ч хуулийн төсөлд хориг тавих эрхтэй бөгөөд конгресс түүнийг гуравны хоёрын саналаар цуцална. **Америкийн Ерөнхийлөгч** төрийн тэргүүн. Түүнийг сонгогчдын коллегиор дамжуулж бүх ард түмэн 4 жилийн хугацаагаар сонгоно. Жилийн цалин 400000 доллар. Бүх нийтийн сонгууль 11-р сард болж 1-р сарын 20-ны өдөр албан үүргээ хүлээн авах ёслол болно. Америкийн уугуул иргэн, 35-аас доошгүй настай, Америкт доод тал нь 14 жил оршин суусан байна. Үндсэн үүрэг нь Үндсэн хуулийг хамгаалах ба Конгрессын баталсан хуулийг хэрэгжүүлэх. *Бусад эрх мэдэл:* Конгресст хуулийн төсөл санаачлах; Конгрессын тусгай чуулган зарлах; Конгресст илгээлт явуулах; хуульд гарын үсэг зурах, хориг тавих; холбооны шүүгчдийг томилох; холбооны департаментууд, агентлагуудын тэргүүн, холбооны бусад гол албан тушаалтнуудыг томилох; гадаад орнуудад суух төлөөлөгчдийг томилох; гадаад улсуудтай албан ёсоор харилцах; зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн үүрэг биелүүлэх; АНУ-ын эсрэг гэмт хэрэгт уучлал үзүүлэх. Гүйцэтгэх засаглалын 14 департамент ерөнхийлөгчд зөвлөгөө, туслалцаа үзүүлнэ (Хавсралт 5).

Дээд шүүх ерөнхийлөгч болон конгрессын ямарч хуулийн төслийг үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр хүчингүй болгох эрхтэй.

Үндсэн хуулийн шүүхийн хяналт (Judicial review) гэдэг нь хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын үйлдлийг үндсэн хууль бус гэж зарладаг эрх гэж ойлгож болох юм. Америкийн бүх шүүх, түүний дотор холбооны доод шатны шүүхүүд, мужуудын бүх шатны шүүхүүд энэ эрхийг эдэлж байдаг. Гэхдээ үндсэн хуулийг хөндсөн бүх асуудлаар эцсийн шийдвэр гаргах эрх АНУ-ын Дээд шүүхэд оногддог. АНУ бол уул эрхийг шүүхийн системийн жирийн бүрэлдхүүн хэсэг-даван заалдах дээд шүүхэд олгосон байдаг цөөхөн орнуудын нэг ажээ. Ийм журам Австрали, Канад зэрэг 12 оронд байдаг гэж судлаачид дурдсан байдаг. Гэвч тэдгээрийн заримд нь (Австри, Итали г.м.) эцсийн шийдвэрийг хууль эрхийн бүтцэд ордоггүй тусгай арбитрын байгууллага гаргадаг бол Мексик, Швейцари зэрэг улсуудад тэдгээрийн эрх мэдэл “холбооны зуучлагч”-ын чиг үүргээр хязгаарлагдаж хууль тогтоох, гүйцэтгэх төв байгууллагын шийдвэрт хориг тавьж чаддаггүй байна. Иймээс үндсэн хуулийн шүүхийн хяналт нь америкийн системийн нэг онцлог гэж хэлж болох юм.

Тухайн орны улс төрийн хөгжлийг, тухайлбал, төрийн тогтолцоо, улс төрийн нам, сонирхлын бүлгүүдийн институтжилт, үйл байдал, иргэдийн улс төрийн оролцоог илтгэн харуулах төвлөрсөн илэрхийлэл бол үндэстний улс төрийн соёл мөн. Энэ үүднээс аваад үзвэл америкийн улс төрийн нам,

сонирхлын бүлгүүд, сонгууль ихээхэн өвөрмөц онцлогтой болох нь ажиглагдана.

Америкийн улс төрийн намууд дээр дурдснаар Үндсэн хуулийг хэлэлцэх явцаас эхтэй ч *Үндсэн хуульд тусгагдаагүй*, харин өөрийн зүй тогтлын дагуу хөгжсөөр америкийн ардчиллын нэг гол шинж, дэлхийн анхны намууд болж чаджээ. Үндсэн хууль зохиогчид улс төрийн намын ролийг төдийлөн ойшоож үзэхгүй байснаас тэд эрх мэдлийн тусгаарлах, харилцан хяналт, тэнцвэр, холбооны байгуулал, ерөнхийлөгчийг сонгогчдын коллегитор дамжуулан сонгох зэрэг үндсэн хуулийн янз бүрийн заалтуудаар шинэ бүгд найрамдах улсыг улс төрийн намууд, бүлэглэлүүдээс тусгаарлаж болно гэж төсөөлж байв. Гэвч Ерөнхийлөгчд нэр дэвшүүлэх *намын үндэсний их хурал, анхан шатны сонгууль* нь хэдийгээр Үндсэн хуульд тусгалаа олоогүй ч түүхэн хөгжлийн явцад америк системийн ялгарах шинжүүдийн тоонд зүй ёсоор орох болжээ.

Намуудын хөгжил сонгуулийн эрхийн өргөжилтөөс шууд хамааралтай байсан бөгөөд энэ үйл явцад сонгогчдыг дайчлах гол хөшүүргийн үүрэг гүйцэтгэж, 1830-аад он гэхэд намууд америкийн ардчиллын салшгүй бүрэлдхүүн хэсэг болжээ. Америкийн улс төрийн тогтвортой байдлыг 100 гаруй жилийн турш *хоёр нам эрх барьж* байсантай холбож үзэх нь ч бий. Өнөөдөр Бүгд найрамдах нам (БНН), Ардчилсан намууд (АН) улс төрийн үйл явцад гүнзгий нэвтрэн орж чадсан байна. Америкчуудын 60 хувь нь энэ хоёр намын аль нэгийг талархан дэмждэг бөгөөд хэдийгээр өөрсдийгөө бие даагчид хэмээн нэрлэгчид ч намуудын аль нэгд нь тал өгдөг байна. Жишээ нь, 1980-1996 оны хоорондох ерөнхийлөгчийн таван удаагийн сонгуульд бие даагчдын 75 хувь хоёр намын аль нэг тийш “хэвийсэн” байна.

Намын нөлөө төр засагт нэвтэрч орсон байдаг нь илэрхий. Хоёр зонхилогч нам ерөнхийлөгч, Конгресс, мужийн захирагчид, мужуудын хууль тогтоох хуралд одоо ч ноёлох байр эзэлж байдаг. 1852 оноос хойш болон Дэлхийн II дайны дараа сонгогчдын 94,8 хувь нь БНН, АН-аас ерөнхийлөгчд нэр дэвшигчдэд санал өгч байгаа ажээ. 2002 оны конгрессын болон орон нутгийн сонгуулийн дараа 100 Сенатчдын дотор нэг бие даагч, 435 Төлөөлөгчдийн дунд 2 бие даагч байсан бол 50 мужийн захирагч бүгд хоёр намын гишүүн, муж улсуудын 7300 гаруй хууль тогтоогч нараас ердөө 21 нь сайхь хоёр намын гишүүн биш байв.

Ардчилсан Америкт 1860-аад оноос хойш хоёр нам сонгуульд “босоо” байж, хоёр намын системээ хадгалсаар байгаагийн учир юу вэ? *Нэгдүгээрт*, АНУ-д үндэсний болон мужийн хууль тогтоогчдын сонгууль нэг мандаттай тойргийн (SMD) системээр явж ирсэн. Энэ нь тухайн тойрогт харьцангуй олонхийн санал авсан нэр дэвшигч ялна гэсэн үг бөгөөд өөрөөр хэлбэл тойрогт зөвхөн нэг нам ялахыг л зөвшөөрдөг. Иймээс эл систем өргөн бааз суурь бүхий хоёр нам байх нөхцлийг бүрдүүлж байдаг. *Хоёрдугаарт*, ерөнхийлөгчийн сонгуулийн сонгогчдын коллегитой холбоотой. Энэ системээр америкчууд техник талаасаа ерөнхийлөгчид шууд санал өгөхгүй байна гэсэн үг. Үүний оронд тэд аль нэг нэр дэвшигчийн төлөө саналаа өгөх “сонгогчид”-ын нэрсийн жагсаалтад муж улс дотроо саналаа өгч байгаа хэрэг. Ерөнхийлөгчөөр сонгогдоход 50 муж улсын 538 саналын дийлэнхийг авах ёстой. Тэгвэл тойргийн сонгогчдын санал ялагч бүхнийг авах зарчмаар (WTA) хуваарилагддаг учраас гуравдагч намд онц бэрхшээлтэй болно. Учир нь нэр дэвшигч хэдхэн саналаар илүү байлаа ч тухайн мужийн сонгогчдын саналыг бүгдийг нь авлаа гэсэн үг. Иймд сонгогчдын коллеги SMD системийн нэг адил гуравдагч намд

ялах боломжийг бараг олгохгүй байна. *Гуравдугаарт*, хоёр том нам бусад намуудад таатай дүрэм журам батлах сонирхол бага байна. Саналын хуудсанд нэрээ бичүүлнэ гэдэг шинэ намын хувьд үнэхээр хэцүү, нэн өндөр өртөг шаардана. Жишээ нь, Хойд Каролина мужид сонгуулийн хуудсанд нэр дэвшигчээ байрлуулахад шинэ намаас 58842 хүний гарын үсэг нэхжээ. Үүнээс гадна Холбооны сонгуулийн кампанийн хууль ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийн зардлыг өндөр тогтоосон нь хоёр намд ашигтай, сонгогчдын саналын дөнгөж 5 хувийн босгыг арай чүү давсан жижиг намд горьдох хэрэггүй нь тодорхой. *Дөрөвдүгээрт*, америкийн сонгуулийн нэр дэвшүүлэх өвөрмөц үйл явц гуравдахь намд саад учруулдаг. Конгресс, мужийн албан тушаал, ерөнхийлөгчд намаас нэр дэвшүүлдэг анхан шатны сонгуулийн систем энд үйлчилнэ. Ихэнх оронд намаас нэр дэвшихийг намын байгууллагууд, намын удирдагчид хянаж байдаг. Тэгвэл АНУ-д БНН,АН-ын нэр дэвшигч хэн байх вэ гэдгийг эцсийн бүлэгт сонгогчид тодорхойлдог. Энэ систем намын дотоод зохион байгуулалтыг сулруулдаг ч сонгогчдыг өргөн оролцуулсан нэр дэвшүүлэх үйл явц хоёр намыг бараг 150 жил сонгуульд давамгайлахад хувь нэмрээ оруулжээ. Энэ нь гуравдагч нам байгуулах гэсэн зүтгэлийг үндсэнд нь ашиггүй болгодог байна.

Америкийн намуудын сонгуулийн дэмжлэг нь олон анги давхаргын өргөн бааз суурь дээр тулгуурладаг. Африк гаралтай америкчууд, эмэгтэйчүүд, орлого, боловсролын төвшин багатай хэсэг ихэвчлэн Ардчилсан намыг дэмждэг онцлогтой ч хоёр нам хоёулаа нийгэм-эдийн засгийн гол бүлэг бүрээс дэмжлэг авч чаддаг. Америкийн намууд дотоод нэгдэл сул, үзэл суртлын зөрчилдөөн багатай, ерөнхийдөө төвийн байр суурь баримталж байдгийг дурдаж болно. Энэ нь үүссэн цагаасаа намуудын гол ажил нь сонгууль, төрийн албан тушаалтнуудыг хянах явдал байсантай холбоотой юм. Хоёр гол намын аливаа нэг номлолтой хэт зууралддаггүй үйл байдал америкийн нийгмийн олон янз байдлыг харгалзах, эв зүйг хадгалахад нэг талаас бололцоо олгосон, нөгөө талаас гуравдагч намууд, эсэргүүцлийн хөдөлгөөнүүдийг саармагжуулахад нөлөөлдөг гэж болох билээ. Гэхдээ энэ хоёр намын улс төрийн бодлого огт ялгарддаггүй гэсэн хэрэг бас биш.

Үзэл суртлын ойлголтоор аваад үзвэл хоёр намыг либерал, консерватив үзэлтэй хүмүүсийн тодорхой хэсгүүд дэмждэг ч БНН-тай харьцуулахад АН-д либералууд илүүтэй байдаг нь Конгресс дахь намын бүрэлдхүүнээс харагддаг байна. АН-ынхан улс орны тулгамдсан зорилтуудыг шийдвэрлэхэд засгийн газар идэвхтэй үүрэг гүйцэтгэх ёстой гэж үзэж байхад бүгд найрамдахчууд эсрэг байр суурьтай байдаг. АН тэтгэвэр тэтгэмж, боловсрол, эрүүл мэндэд төсвөөс ахиу хуваарилалт хийх ёстой, харин засгийн газар иргэдийн зан суртхуун, оюун санаа, сүсэг бишрэлд аль болох бага оролцох ёстой гэдэг бол БНН садар самууны кино үзүүлэх, дунд сургуульд мөргөл үйлдэх гэх мэтийг хориглох ёстой гэж үздэг байна. АН тэгш байдалд нааштай хандаж байхад БНН тэгш бололцоо бий болгохыг уриалах жишээтэй.

Америкийн намууд бусад орнуудад байдаг шаталсан зохион байгуулалтаас үндсээрээ ялгаатай. Холбооны, муж улсын, орон нутгийн төвшинд тэдгээрийн хороодын эрх мэдэл хууль эрх зүй болон өөр бусад утгаар ихээхэн хязгаарлагдсан байдаг. Түүнчлэн үндэсний намын хороод үндэсний их хуралд нэр дэвшигчдийг сонгохоос бусад үед муж улсуудын хороодын ажилд хөндлөнгөөс оролцох нь ховор. Конгресс, сенат, сонгуулийн кампанийн намын хороод намын Үндэсний хорооноос тусдаа бие даасан үйл ажиллагаа явуулна. Энэхүү төвлөрсөн бус зохион байгуулалт нь “төр дэх нам”-ын үйл байдалд ч

илрэлээ олдог. Иймээс ерөнхийлөгч дэвшүүлсэн төсөлдөө Конгресс дахь өөрийн намын гишүүдээсээ дэмжлэг авна гэдэгт баттай итгэх аргагүй, мөн Конгресс дахь намын удирдагчид өөрийн намын гишүүд нь намын бодлогоор саналаа өгнө гэж хүлээх аргагүй болно. Америкийн намуудын ийм зохион байгуулалт, эрх мэдлийн тархалт нь үндсэн хуулийн эрх мэдэл хуваарилах систем, тухайлбал, заслал гурван салаа мөчирт хуваагддаг, салаа мөчир бүр нь өөр өөр дэг, өөр өөр хугацаагаар байгуулагддаг, бие биеэсээ хараат бус байдгийн үр дагавар юм. Энэ бүхэн Британи, Энэтхэг, Итали, Нидерланд, Япон зэрэг олон улсуудтай харьцуулахад намын сахилга сул байгаа нь илэрхий байна. Жишээ нь, Америкийн нэрд гарсан ерөнхийлөгчдийн нэг Ф.Рузвельт өөрийн шинэ бодлогын чиг шугамыг эсэргүүцдэг нэр дэвшигчдийг зарим мужаас гаргахгүйн тулд анхан шатны сонгуульд нөлөөлөх гэсэн 23 оролдлогоос 12 нь бүтэлгүйтэж байжээ. Үүнээс хойш намын тэргүүн муж, орон нутгийн сонгуулийн нэр дэвшигчдэд нөлөөлөх нь бүтэшгүй зүйл гэсэн итгэл үнэмшил бий болжээ. АНУ-ын намын сул зохион байгуулалт, эрх мэдлийн хуваарилалт, алба хаших хугацаа янз бүр, ерөнхийлөгч, конгрессын гишүүдийг сонгох дэг ёс өөр өөр зэрэг нь нэг намаас ерөнхийлөгч гарсан байхад нөгөө нам нь Конгрессын нэг эсвэл хоёр танхимыг хянах нөхцлийг гол төлөв үүсгэдэг байна. Жишээ нь, 1946-1998 оны хооронд 26 сонгууль болсноос 10 нь хоёр өндөрлөгийг нэг нам, 16 нь хоёр нам тусдаа ерөнхийлөгч, конгрессыг хянах нөхцөл бүрджээ. Одоогийн байдлаар Ерөнхийлөгч, Сенатыг АН, Төлөөлөгчдийн танхимыг БНН тус тус хянаж байна. Гэтэл парламентын засаглалтай улсуудад нэг нам засгийн газрыг, нөгөө нь хууль тогтоох хурлыг хянах боломж бараг байдаггүй байна. Хэрэв парламент засгийн газрын шаардлагыг хүлээн авахаас татгалзвал засгийн газар огцорч парламентын санаанд нийцсэн дараагийн засгийн газар гарч ирэх, эсвэл парламент тарж шинэ сонгууль зарлагдаж парламентын шинэ олонхийн дэмжлэг хүлээсэн шинэ кабинет бүрдэнэ.

Америкийн иргэдийн улс төрийн оролцоо, ашиг сонирхлоо илэрхийлэх үйл явц, сонирхлын бүлгүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслийг сонгуулийн кампанитай уялдуулж авч үзвэл учир холбогдол нь илүү сайн тодрох учраас америкийн сонгуулийн талаар товч дурдья.

Шударга чөлөөт сонгууль бол ардчилсан улсыг ардчилсан биш улсаас ялгах нэг гол шалгуур мөн. Сонгууль ардчилсан оронд иргэд улс орноо удирдахад оролцож байгаа үндсэн арга хэлбэр бөгөөд үүний мөн чанарыг сонгуулийн идэвхийн (саналаа өгсөн хүмүүсийн тоог насанд хүрсэн нийт хүн амд харьцуулсан хувь) үзүүлэлт гэрчилдэг гэж болно. Тэгвэл АНУ-д сонгуулийн идэвх бусад ардчиллуудтай харьцуулахад ихээхэн доогуур, 1960 оноос хойш тасралтгүй буурч 1996 онд ерөнхийлөгчийн сонгуулийн ирц 49 хувь, конгресс, муж, орон нутгийн хууль тогтоох хурлынх үүнээс ч доогуур байсан нь америкийн түүхэнд хамгийн тааруухан үзүүлэлт байв. Үүнийг зарим судлаачид сонгогчид улстөрөөс залхсантай холбож байхад нөгөө хэсэг нь сонгуулийн идэвхийг тооцох аргачлалаар тайлбарлажээ. АНУ-д бусад улсуудын нэг адил сонгогчын нэр санал хураахаас өмнө нэрсийн жагсаалтад бичигдэх ёстой байдаг. Бусад оронд үүнийг төр засгийн байгууллагууд сонгогчдын өмнөөс хийчихдэг учраас сонгогчоос ямар ч санаачилга шаарддаггүй бол АНУ-д сонгуулийн бүртгэлийг хэн нэгэн түшмэд хийдэггүй бөгөөд сонгогч өөрөө л идэвх гаргах журамтай. Бусад оронд оршин суугаа газраа сольсон сонгогч нэг жагсаалтаас хасагдаж автоматаар өөр жагсаалд ордог бол америк сонгогч нэг мужаас нөгөөд шилжихэд шинэ бүртгэлд ордоггүй. АНУ-д 1993 онд бүртгэлийг хөнгөвчилсөн шинэ хууль гарч мужийн засгийн газрууд жолооны үнэмлэх авахад нь сонгогчыг

нэг зэрэг бүртгэж байхаар журамласан. Иймээс иргэн шуудангаар эсвэл халамжийн байгууллагаас бланк авч бүртгүүлэх зэргээр илүү чөлөөтэй болов. Дээр хэлснээр сонгуулийн идэвх тооцох хоёр арга байна. Нэг нь бүртгүүлсэн сонгогчдын нийт тооноос хувь гаргах, хоёрдахь нь насанд хүрсэн иргэдийн нийт тооноос, үүнд бүртгүүлээгүй эсвэл шилжиж бүртгэлээс хасагдсан, бүр америкийн иргэн бус хүмүүсийг оруулж тооцдог. Хоёр дахь хувилбар нь АНУ-д хэрэглэгдэж байна. Хоёр дахь аргачлалаар бусад ардчилсан орнуудтай харьцуулахад АНУ (ерөнхийлөгчийн сонгуулийн дүн, 52,6%) 23-р байрт орсон бол нэг дэх аргачлалаар дундаж үзүүлэлт 86,8 хувь болж 11-р байранд “давхижээ”.

АНУ-ын сонгуулийн идэвхийг сонгогч олон удаа санал өгдөгөөр бас тайлбарладаг. Иргэн 4-5 жилийн дотор хэдэн зуун сонголт хийх хэрэгтэй болно. Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль, хоёр жил тутам Төлөөлөгчдийн танхимын сонгууль, 6 жилд хоёр удаа сенатын сонгууль, муж, хотын төвшинд гүйцэтгэх засгийн тэргүүнүүд, хууль тогтоох байгууллагын гишүүд, үүнээс гадна мужийн төрийн нарийн бичгийн дарга, ерөнхий прокурор, санхүү, боловсрол, шүүхийн удирдлага, сургуулийн захирал гэх мэт олон тооны албан тушаалтнуудын сонгууль болж бүгдэд нь иргэн саналаа өгөх хэрэгтэй бөгөөд жилд 19 удаа сонгуулийн хэсэг дээр очих шаардлагатай болно гэсэн үг. АНУ-д төрийн өндөр албан тушаалтнуудыг сонгох үйл явц гурван үе шатаар явах бөгөөд нэг дэх нь *нэр дэвшигчийг шилж сонгох*: энд улс төрийн намууд хэнийг намынхаа нүүр царай болгон гаргаж ирэх вэ гэдгийг шийдэх; хоёрдугаарт, *нэр дэвшүүлэх (номинаци)*: хэний нэрс саналын хуудсанд бичигдэх вэ гэдгийг эрх мэдэлтнүүд шийдэх; гуравдугаарт, *сонгууль*: сонгогч нэр дэвшигчдийн аль нэгэнд саналаа өгнө.

Судлаачдын үздэгээр нэр дэвшигчийг шилж сонгох нь тэргүүн зэргийн ач холбогдолтой байдаг. Энэ нь эцсийн бүлэгт сонгох олон хувилбаруудын бололцоог хумих үйл явц юм. Жишээ нь, АНУ-д ерөнхийлөгчд тавигдах шалгууруудыг хангасан хэдэн сая хүн байдаг ч тэднийг бүгдийг саналын хуудсанд бичих нь онолын хувьд байж болох ч практик дээр тэдний дотроос ухаалаг сонголт хийх ямар ч боломжгүй билээ. Иймээс өрсөлдөгчдийн хүрээг хумих үйл явцыг улс төрийн намууд хийдэг. Нам болгон өөрийн нэр дэвшигчдийг шилж сонгоод нэрсийг нь сонгуулийн хороонд өгч, энэ хороод тэдний нэрсийг саналын хуудсанд оруулдаг. АНУ-ын Ерөнхийлөгчийн сүүлийн 57 дахь удаагийн сонгуульд БНН-аас М.Ромни, АН-аас Б.Обама нар нэр дэвшсэн нь энэхүү номинаци сонгогчдод хоёр өрсөлдөгчийн хэнд нь санал өгөхийг хөнгөвчилж өгсөн гэсэн үг.

Нэр дэшигчдийг шилж сонгох нь хамгийн чухал гэдгийг тооцвол АНУ тэдгээр номинатуудын ихээхэн хэсгийг анхан шатны шууд сонгуулиар хийдэг дэлхийн ганц орон гэж болно. Бараг бүх ардчилсан улсуудад парламентад хэнийг нэр дэвшүүлэхийг намын удирдах байгууллагын хүрээнд шийдэх нь түгээмэл байдаг. Харин АНУ-д хэрэг дээрээ бүх чухал сонгуульд албан тушаалуудад анхан шатны шууд сонгуулиар (праймериз буюу “сунгаа”) нэр дэвшигчдийг гаргах буюу өөрөөр хэлбэл намын их хурлууд дээр биш, төрийн хяналт дор иргэд саналаа шууд илэрхийлэх замаар номинаци хийдгээрээ онцлог юм. Эдүгээ АНУ-д 25 мужид хаалттай праймериз байгаа бөгөөд энэ нь тухайн намын зөвхөн бүртгэлтэй гишүүд оролцоно. 14 мужийн шилжих праймериз – сонгогчид урьдчилсан сонгуулийн өдөр хүртэл ямар намыг дэмждэгээ тодорхойлоогүй байж болно. 9 мужийн нээлттэй праймериз – намын бүртгэл ерөөс байхгүй, сонгогчид аль намын нэр дэвшигчийн төлөө саналаа

өгөх, түүнийгээ зарлахгүй байж болно. Америкийн анхан шатны урьдчилсан шууд сонгууль нэр дэвшигчдийг шилж сонгох үйл явцыг илүү нээлттэй болгож, түүнд олон хүнийг татан оролцуулдагаараа бусад орнуудаас ялгаатай юм. Нэг үгээр АНУ-д бүртгэлтэй ямарч сонгогч өөрийн хүслээр ямарч нэр дэвшигчд саналаа өгөх эрхтэй бөгөөд энэ эрхээ америкийн сая сая иргэд сонгуулийн кампанид ашигладаг байна.

АНУ-д улс төрийн намууд төвлөрсөн бус зохион байгуулалттай, засаглалд нөлөөлөх нь харьцангуй сул байдагаас ашиг сонрхлыг илэрхийлэх, нэгтгэх үйл явцад **сонирхлын бүлгүүд** онцгой үүрэгтэй байдаг ажээ. Америкт зохион байгуулалттай, нөлөөтэй, хүчтэй сонирхлын бүлгүүд олон тоотой байдгаараа онцлог. Тэдгээрийг үндсэнд нь (1) Улс төрийн үйл ажиллагааны хороод (УТҮАХ); (2) шахалтын бүлгүүд буюу лобби гэж хоёр хувааж үзсэн байдаг.

УТҮАХ-д аль нэг намын харъяалалд багтаагүй, тодорхой нэр дэвшигчийг дэмждэггүй, гэхдээ сонгуулийн дүнд нөлөөлөхийн тулд тодорхой мөнгө хөрөнгө зардаг ямар ч улс төрийн шинжтэй байгууллагыг хамааруулж болдог. УТҮАХ –ын намаас ялгарах гол шинж нь тэдгээр нь өөрсдөө нэр дэвшүүлдэггүй бөгөөд тэдгээрийг юуны түрүүнд нэр дэвшигч аль намаас нэр дэвшсэн нь биш, харин түүний *улс төрийн чиг шугам ямар байгааг* сонирхож байдаг оршино. Иймээс тэд өөрт нь хамгийн чухал улс төрийн асуудлуудыг шийдвэрлэж чадна гэсэн хоёр гол намын нэр дэвшигчдийг ихэвчлэн дэмждэг байна. Жишээ нь, 1919 онд чухамхүү УТҮАХ-ы хүчээр Америкт “хуурай хууль”-ийг нэвтрүүлсэн 18-р нэмэлтийг оруулсан гэж түүхчид үздэг ажээ. ХХ зууны хамгийн нөлөөтэй УТҮАХ-ы нэг нь Улс төрийн боловсролын хороо бөгөөд зохион байгуулалттай хөдөлмөрийн үзэл санааг дэмждэг нэр дэвшигч нарт сая сая доллар, хэдэн мянган ухуулагчдыг гаргаж өгчээ. 1974 онд Холбооны сонгуулийн кампанийн тухай хуульд өөрчлөлт орсон үеэс эдгээр бүлгүүдийн үйл ажиллагаа илүү эрчимтэй болжээ. Учир нь энэ нэмэлт өөрчлөлтөөр сонгуулийн кампанийн санхүүжилтийн хэмжээг хатуу тогтоож өгчээ. ҮЭ, корпорациуд сонгуулийн кампанийг шууд санхүүжүүлэхийг хориглож, харин УТҮАХ-д санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг зөвшөөрсөн байна. Иймээс хороод улам олширч, 1974 онд 608 байсан бол 1994 онд 3954 болж өсчээ. УТҮАХ Холбооны Сонгуулийн комисст бүртгүүлж хэн хэдийг оруулсан, хэнийг дэмжихэд зарцуулагдсан тайлангаа тогмол танилцуулах ёстой. Хувь хүмүүс УТҮАХ –д жилд 5000-аас ихгүй доллар, нэр дэвшигч, нам, УТҮАХ-г дэмжихэд нийтдээ 25000-аас дээшгүй доллар оруулж болно. Хороо анхан шатны болон бүх нийтийн сонгуульд тус бүр 5000 доллар зарцуулах эрхтэй байдаг. Ерөнхийлөгчийн сонгууль үндсэндээ холбооны төсвөөс санхүүжигддэг учраас УТҮАХ хандивын ихэнхийг конгрессын сонгуульд зарцуулдаг байна. Хороодыг ерөнхийд нь - материаллаг сонирхлын мөр хөөсөн; -материаллаг бус тодорхой нэг асуудлыг хамгаалдаг; - үзэл суртлын гэж хувааж болно. Нэгдэх УТҮАХ нь сонгуульд ялбал тодорхой үйлдвэрийн газарт хууль тогтоомжийн дэмжлэг үзүүлэх нэр дэвшигчдийг санхүүжүүлнэ. Хоёрдахь нь, жишээ нь, “Үр хөндөх эрх” Үндэсний хороо (сонголт өгөх), “Амьдралын төлөө” Үндэсний хороо (үр хөндөлтийг хориглох) зөвхөн энэ асуудлыг шийдвэрлэхийн төлөө байна. Гуравдах нь либерал, эсвэл консерватив зарчмуудыг хэлбэрэлтгүй баримталдаг нэр дэвшигчдийг дэмждэг. УТҮАХ ашиг сонирхлоо хамгаалдаг өөр нэг арга нь төр дэх төлөөлөгчдөөрөө дамжуулан лобби хийх арга юм. Өнгөрсөн үед бүлгүүд өөрсдийн хүсэл сонирхлыг гүйцэлдүүлэхийн тулд конгрессын гишүүдийг худалдан авах аргыг

хэрэглэж байсан бөгөөд хууль боловсронгуй болж энэ нь хэт эрсдэлтэй болсноос одоо итгэн үнэмшүүлэх аргыг голдуу хэрэглэдэг болжээ.

Америкийн сонгуулийн кампанид сонирхлын бүлгүүд их үүрэгтэй байдгийн адил **олон нийтийн мэдээллийн хэрэгсэл** (ОНМХ) бас маш чухал байдаг. Өндөр хөгжсөн орнуудын нэг адил АНУ-д ОНМХ дотроос телевиз мэдээллийн хамгийн нөлөөтэй хэрэгсэл байдаг. Телевиз (ТВ) хувийн болон нийтийн мэдэлд байна. Улсын теле, радио сувгууд орлогынхоо 29 хувийг муж, орон нутгийн засгийн газруудын санхүүжилтээс, 22 хувийг сонсогч, үзэгчдийн хураамжаас, 19 хувийг холбооны засгийн газраас, 18 хувийг хувийн бизнесийн дэмжлэгээс, 12 хувийг сангууд, бусад эх үүсвэрээс авдаг байна. Сонин, сэтгүүл, ном хэвлэлийн улс төрийн агуулгыг төрөөс хянадаггүй. Гэхдээ гүтгэж гүжирдэх, нэр төрийг гутаасан тухай асуудлыг хуулиар зохицуулдаг.

Радио, телевиз илүү хяналттай бөгөөд Харилцаа холбооны комиссоос 5 жил тутам шинэчлэн олгодог зөвшөөрөл авсан тохиолдолд нэвтрүүлэг явуулна. Уг зөвшөөрөлд давтамжын цар хүрээ, нэвтрүүлэх цаг, дамжуулагчийн хүчин чадал, бүр антены өндөр зэргийг тусгасан байхаас гадна нэвтрүүлгүүдийн агуулгын тодорхой стандартуудыг зааж өгдөг байна. ТВ аль нэгэн нэр дэвшигчд эфирын цагийг өгөхгүй байж болох боловч хэрэв нэг нэр дэвшигчд өгсөн бол түүний бусад бүх өрсөлдөгч нарт ижил үнэлгээгээр, тэдний заасан ойролцоо цагт өгөх үүрэгтэй. Хэрэв ТВ сувгийн удирдлага улс төрийн рекламыг нэвтрүүлэхийг хүсэхгүй байлаа ч тэрбээр эфирын тодорхой цагийг арилжааны рекламн үнээс арай доогуур худалдан авахыг хүссэн нэр дэвшигч, намд борлуулах хэрэгтэй болно. Хэрэв нэвтрүүлгийн явцад нэр дэвшигч бусдын эсрэг ёс суртхууны дайралт хийсэн бол хариу өгөх эфирын цагийг нөгөө талд үнэгүй олгох ёстой.

Дээд шүүх сонин хэвлэлийн тоонд хязгаар тавьдаггүй хэрнээ радио, ТВ тоог хязгаарладаг нь техникийн учир шалтгаантай байна. Хоёр станц нэг давтамжаар нэг хүлээн авах бүс дээр нэвтрүүлэх нь тэд бие биеийнхээ нэвтрүүлгийг “дарж”, нэвтрүүлэг ямар ч боломжгүй болно. Иймээс нэвтрүүлэг нь үндэсний дархан цаазтай газар, хөлөг онгоц хөвдөг гол мөрөн зэрэг нийтэд хүртээлтэй баялагийн хэмжээнд тавигдаж засгийн газар зөвхөн давтамжийн хэмжээг төдийгүй, нэвтрүүлэг нь нийгмийн ашиг тусын тулд түүний хэрэгцээг хангаж байх шаардлагын үүднээс тодорхой стандартууд тавих эрхтэй байдаг ажээ.

1950-иад он хүртэл АНУ-д сонгуулийн кампанийг намын ажилтнууд явуулж, сонгогчидтой холбоо харилцаа тогтоож, улс төрийн реклам сонинд нийтлэх, ухуулах хуудас, товхимол хэвлэх зэргээр ОНМХ-ийг ашиглаж байв. Цаашдаа хэвлэл мэдээлэл хөгжихийн хэрээр сонгогчдыг татахын тулд АНУ-д нам, нэр дэвшигчдийн сонгуулийн технологи ихээхэн өөрчлөгдөж эхэлжээ. Төлбөртэй ТВ рекламууд, “Talk Show” ярилцлагын хэлбэрийг өргөн ашиглах болов. Олон нийтийн санаа бодлын судалгаа явуулж, сонгуулийн тойргуудын хүн амын бүтэц, сонгогчдын үйл байдлын талаар баримт цуглуулж дүн шинжилгээ хийх болжээ. Сонгуулийн кампанийг намын ажилтнууд бус, харин сонгуулиар мэргэшсэн мэргэжилтнүүд явуулдаг болсон. ТВ ярилцлага, мэтгэлцээнийг нэр дэвшигчдийн хооронд өргөн явуулах болов. Америкт ерөнхийлөгчд нэр дэвшигчдийн халз ярилцлагыг 1960 онд анх зохион байгуулсан нь эдүгээ бусад улс орнуудад түгээмэл хэрэглэгдэх болжээ. Ийнхүү америкийн ардчиллын бүх гол үнэт зүйлс сонгуультай ямар нэгэн шижмээр холбогдож байгааг харж байна.

Энэ бүхнээс бид Америкийн улс төрийн системийн мөн чанар, өвөрмөц онцлог шинжүүдийг үндсэн хуульт ёс, холбооны систем, засаглал хуваах зарчим, ерөнхийлөгчийн гүйцэтгэх засаглал, шүүхийн үндсэн хуулийн хяналт, хоёр намын систем, намын сул сахилга, анхан шатны урьдчилсан сонгууль, сонирхлын бүлгүүдийн плюраль систем, сонгуулийн кампанийн санхүүжилт, технологи тодорхойлж байдаг гэсэн дүгнэлтийг хийж болох юм.

БҮГД НАЙРАМДАХ СОЛОНГОС УЛСЫН ДЭГЛЭМИЙН ӨӨРЧЛӨЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ

Э.Саранцэцэг

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн докторант

Түлхүүр үг: Өмнөд Солонгос, улс, улс төрийн тогтолцоо, улс төрийн тогтолцоо, төр, эрх мэдэл, жагсаал, ардчилал, эдийн засаг

*Монголчуудын нэрлэж заншсан эртний Гуулин улс, хүйтэн дайны шуурганд дайрагдан Хойд, Өмнөдөөр хуваагдаад зогсохгүй үзэл суртал, хагацал тэмцлийн дунд хагас зуу гаруй жилийн хөгжил дэвшил, нийгмийн хэв шинжийн үлэмж их ялгааг бий болгосныг бид мэднэ. 60 гаруйхан жилийн хугацаанд Японы дарлал, дайн дажны хөлд нухчигдан ядарсан буурай орноос эдийн засгийн хөгжлөөрөө дэлхийн эхний 11 дэх байранд жагсах болсон Өмнөд Солонгосын бахдам амжилтанд дэлхий нийтээрээ баяр хүргэж байгаа ч тэдний энэ амжилтын нууц юу болохыг мэдэхсэн гэсэн сонууч занд хөтлөгдөх хүн олон бий.*¹⁹⁶

20-р зууны сүүлээс дэлхий дахинд өөрчлөлтийн салхи хүчтэй дэгдэж, нийгмийн тогтолцоо болон эдийн засагт олон олон өөрчлөлт гарсантай уялдан шинжлэх ухаан, техник технологи, мэдээллийн огцом хөгжил нэгэн зэрэг өрнөж байна. Энэ бүхнийг түргэн хугацаанд тусган авч, хөл нийлсэн улс орон ирээдүй өөд итгэлтэй замнаж яваа гэж хэлж болно. Үүний нэг нь БНСУ гэдэгт маргах хүн гарахгүй байх. Тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа тунхаглаж, зах зээлийн эдийн засгийн системээр ардчилсан нийгмийг цогцлоон бүтээж буй Солонгосын ард түмний амжилтын гол түлхүүрийг энэ ард түмний хөдөлмөрч, хичээнгүй зан чанар, хүчирхэг төрийн тогтолцоотой холбож болно.

Энэ тухай түүхийн хуудас сөхөн харвал, 19-р зууны Европын гүрнүүдийн эзлэн түрэмгийлэх бодлогын үр дүнд Хятадын хүч нөлөө сулран унаснаар Зүүн Азид хэн ноёлох бол гэсэн асуулт гарч ирэн энэ ноёрхлын төлөө Хятад, Орос, Япон тэмцэж эхэлсэн бөгөөд эхлээд Хятад, дараа нь Орос нөлөөгөө алдаж, удалгүй Япон голлох үүрэг гүйцэтгэх болсон билээ. 1904 оны Орос-Японы дайны үед Япончууд цэргээ Солонгосын хойгт оруулж, 1905 он гэхэд тус орныг бүхэлд нь мэдэлдээ авчээ. Зарим хүмүүс энэхүү булаан эзлэлтийг өөрийгөө хамгаалах чадваргүй хоцрогдсон бүдүүлэг ард түмнийг сэргээн босгож, шинэ орчин цагийн нийгмийг байгуулахад нь тусалсан хэрэг гэж үздэг. Ингээд 5000 жилийн түүхээрээ бахархдаг Солонгос үндэстэн 1910 онд Японы дарлалд орсноор үндэсний тусгаар тогтнол, эрх чөлөөгөө алдан ард нийтээрээ хүнд зовлонг амсжээ. “Солонгос орон Японы клони болж аж үйлдвэрүүдэд нь түүхий эд нийлүүлж, барааг нь зах зээл дээр борлуулдаг боллоо. Хоцрогдсон энэ улсын хорьдугаар зууны түүх ингэж эхэлжээ. 1945 онд Солонгосын хойг Японы дарлалаас чөлөөлөгдсөн хэдий ч улс орноо тэр даруй төвхнүүлж чадалгүй Америкийн цэргийн засаглал дор дахин 3 жилийг үдсэний дараа 1948 онд сая төр засгаа тогтоов. 1948 оны 5-р сарын 10-нд Өмнөд Солонгост Үндэсний Ассемблейн анхны парламентын сонгууль явагдаж, тус сонгуульд 21-ээс дээш насны бүх иргэд тэгш эрхтэйгээр оролцжээ. 198 гишүүнээс бүрдэх Үндэсний Ассемблей Японы колоничлолын үед түр засгийн газрын үеэс хэрэглэж ирсэн нэрээр буюу Бүгд Найрамдах Солонгос улс хэмээн улсаа нэрлэхээр тогтож, 7-р сарын 17-нд Үндсэн хуулийг тунхаглав. НҮБ тэр жилдээ БНСУ-ын засгийн

¹⁹⁶ Бүгд Найрамдах Солонгос улсын улс төрийн тогтолцоо. Сайнбилэгт Д. УБ., 2010 он

газрыг Солонгосын хойг дахь хууль ёсны цорын ганц засгийн газар болохыг хүлээн зөвшөөрсөн бөгөөд үүний дараахан Умард Солонгост 8-р сарын 25-нд “Ардын дээд хурал”-ын гишүүдийг сонгох сонгуулийг явуулж, 9-р сарын 8-нд Ардын Ардчилсан Үндсэн хууль батлан гаргаад, 9-р сарын 9-нд “Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс”-ыг тунхаглав. Тэгээд төрийн далбаа, төрийн сүлд дуулал бүтээж, Сөүл хотыг нийслэл хот гэж зарлаад, Пхеньяныг түр нийслэл хот болгожээ. Аль аль нь өөрийгөө Солонгосын хойг дээрх цорын ганц засгийн газар гэж үзэж байсан нь дээрхээс харагдана.

Үндсэн хуулинд заасны дагуу 1948 оны 8-р сарын 15-ны өдөр БНСУ нь ерөнхийлөгчийн засаглалтай, ардчилсан улс болохыг хуульчлан тогтоосон бөгөөд тэгэхдээ ерөнхийлөгчийг парламентаас сонгож байхаар болжээ (*weimar system*). Ийнхүү улс орныхоо эрхэм зорилго, бүрэн эрхт байдал, хүний эрх, эрх чөлөө, төрийн байгуулал, засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийг тодорхойлон улс даяар зарлан тунхагласан юм. Гэвч улс орноо эмхлэн хөгжүүлэх ажил гарын үзүүрээр хийчихдэг, амар зүйл биш болохыг тэдний өнгөрсөн 60 гаруй жилийн ээдрээтэй түүх гэрчлэнэ байх.

1948 онд И Сын Маныг анхны ерөнхийлөгчөөр сонгон, 8-р сарын 15-нд БНСУ-ын анхны засгийн газрыг байгуулжээ. Хойд Солонгос нь социалист тогтолцоог хүлээн зөвшөөрч, Ким Ил Соныг төрийн тэргүүнээр сонгож, 1950 оны 6-р сарын 25-нд өмнөд Солонгос руу дайралт хийж, улмаар НҮБ-аас цэрэг илгээн, Солонгост тусалсан ч Хятадын цэрэг оролцож, дайныг улам удаашруулав. 1953 оноос хоёр Солонгосын дайн түр завсарласан ба 1960 оны 3-р сарын 15-ны ерөнхийлөгчийн сонгуульд И Сын Ман ерөнхийлөгч болон Эрх чөлөөний намынхан засгийн эрхийг үргэлжлүүлэхийг зорьж, хууль бус сонгууль явуулж, үүнийг эсэргүүцсэн оюутнууд, иргэд жагсаал өрнүүлэв. Уг жагсаал орон даяар тархаж, эцэст нь И Сын Ман ерөнхийлөгчийн суудлаасаа огцорлоо. 1961 оны 5-р сарын 16-нд Паг Чон Хи тэргүүтэй цэргүүд хувьсгал хийж, засгийн эрхийг авав. Паг Чон Хигийн засгийн газар улс орноо орчин үежүүлэх зорилгоор эдийн засгийн хөгжлийн бодлого явуулснаар улс орны эдийн засаг сэргэж хөгжсөн ба үүнийг солонгосчууд “Хан мөрний гайхамшиг” хэмээн нэрлэдэг. 1979 оны 10-р сарын 26-нд Паг Чон Хи ерөнхийлөгч таалал төгсч, 1980 онд Жон Дү Хван ерөнхийлөгчөөр сонгогдож, түүний засгийн газар эдийн засгийн тогтворжилт, экспортыг нэмэгдүүлэх бодлого баримталсан ч цэргийн диктатур, хууль бус үйл ажиллагаанаас болж иргэдийн эсэргүүцэлтэй тулгарлаа. 1980-аад оны эхнээс эрч хүчээ авсан ардчиллын төлөөх хөдөлгөөн 1980-аад оны дунд үе гэхэд залуусын хүрээнээс хальж нийгмийн бүх давхаргыг хамрах болсоор 1987 онтой золгов. 1987 оны 6-р сарын 10-наас 29-ны хооронд болсон “6 сарын ардын бослого” хэмээн нэрлэгддэг гудамжны жагсаал нь олон нийтийг хамарч, цагдаагийн хүч хүрэлцэхээ больж, жагсаал цуглааны 17 дахь өдөр, АНУ ба ОУОХ-ны хүчтэй шахалтын дор засгийн газар ардчилсан шинэчлэл хийх ард түмний шаардлагыг хүлээн зөвшөөрсөн юм. 6-р сарын 29-ний “Ардчилсан Шинэчлэлийн Тунхаглал” хэмээх энэхүү хэлэлцээр нь Өмнөд Солонгосын ардчиллын тайван шилжилтийн үндэс болсон юм. Энэ нь Ерөнхийлөгчийг бүх ард түмний шууд сонгуулиар сонгох тогтолцоонд шилжих тухай гол утга, агуулга бүхий, 8 зүйлт төлөвлөгөөг засгийн газраас зарлан тунхагласан юм.


Мөн дэлхийн 24-р олимпийг Сөүлд зохион байгуулсан нь зүүн Европын орнууд, Орос, Хятадтай гадаад харилцаагаа өргөжүүлсэн томоохон алхам болсон. 1992 онд Цэргийн бус гаралтай Ким Ён Сам ерөнхийлөгчөөр сонгогдож, иргэний засгийн газар байгуулагдлаа. Ардчилал, даяарчлалын төлөө улс орны шинэчлэлийг өрнүүлсэн ч 1997 онд Азийн хямралд өртөж, эдийн засгийн хүнд

бэрхшээлтэй тулгарчээ. Ерөнхийлөгчөөр сонгогдсон Ким Дэ Жүн хойд Солонгосын харилцааг шинэчлэх бодлого хэрэгжүүлэн, 2000 оны 6-р сарын 15-нд Пхеньянд айлчлан Ким Чон Ил төрийн тэргүүнтэй түүхэн уулзалт хийж, өмнөд хойд хоёр Солонгосын хамтарсан тунхаглалын бичгийг нийтэд зарлав. Ингэснээр Кымган уулын аялал, дайнд хагацсан гэр бүлүүдийн уулзалт зэрэг иргэд хоорондын солилцоог өргөжүүлсэн ба өмнөд хойдын харилцааг шинэ уур амьсгалаар зохицуулсан хэмээн өндрөөр үнэлэгддэг. Мөн ерөнхийлөгчөөр сонгогдсон Ну Мү Хён ардчилал, нийгмийн тэнцвэртэй хөгжил, зүүн хойд Азийн орнуудын энх тайвнаар зэрэгцэн орших асуудал дээр засгийн газрын гол бодлогоо чиглүүлж байв.

1948 оноос 2008 оны И Мёнпаг-ийн засаглал хүртэл нийт 6 Бүгд Найрамдах улс (Sixth Republic)¹⁰ орчим жилийн мөчлөгтэйгөөр солигдон гарч байсан төдийгүй иргэний дайн, улс орны хуваагдал, цэргийн эргэлт, жагсаал цуглаан гээд олон зүйл Солонгосчуудын амар тайван байдлыг алдагдуулан сандаргаж байлаа. Ригийн засгийн газрын үе (1948-1960) бол БНСУ-ын анхны Бүгд Найрамдах улсын үе бөгөөд хожим 1948 онд бичигдсэн Үндсэн хуулийг нийт 5 удаа (1960, 1962, 1972, 1980, 1987) өөрчилж, дахин бичжээ. Мөн энэ хугацаанд Ерөнхийлөгчийн болоод Кабинетийн тогтолцооны аль алиныг нь хэрэгжүүлж, 10 ерөнхийлөгчийн нүүр үзэхдээ тайван замаар гэхээсээ зэвсэгт мөргөлдөөн, цэргийн эргэлтийн хүчээр гарч ирсэн удирдагчдаар удирдуулах нь их байв. Харин 6-р БНУ-ын үеэс иргэний засаглал руу шилжих алхам хийгдэж, 1993 оны Ким Ёнгсам-ын засаглалын үеэс Солонгосчуудын иргэний ардчилсан нийгэм байгуулах чин хүсэл биелэлээ олсон гэж болно. Өдгөө улс үндэстэн бүр уламжлал шинэчлэлээ хослуулан өөр өөрийн хөгжлийн түвшинд тохирсон төрийн тогтолцоог бий болгож, жинхэнэ ардчилсан иргэний нийгмийг байгуулахын төлөө мэрийн зүтгэсээр байна. Ардчиллын давалгаа эхэлсэн энэ үеэс хойших жилүүдэд Солонгос болон Зүүн Азийн бүс нутгийн ихэнх орон авторитаризмаас хөндийрч байгааг доор (Зураг 1) харуулж байна.

Ардчиллыг илүүд үзэж буй болон Авторитаризмаас хүнийссэн байдлын харьцаа¹⁹⁷


Зураг 1



¹⁹⁷ Азийн Барометр Улс Төрийн Боловсролын Академи. УБ., 2010 он

БНСУ-ын хувьд төрийн эрх мэдэл хуваарилалтыг нэг тал руу хэлбийлгэхгүй эрх тэгш, харилцан хяналттай байх зарчмын үүднээс Хууль тогтоох, Шүүх, Гүйцэтгэх гэсэн гурван засаглалын хэлбэрээр тогтоосон байдгийг дараах бүдүүвч (Зураг 2)-ээс тодруулан харж болно. Энэ гурван систем харилцан эн тэнцүү байр сууринаас өөр өөрийн үүргийг гүйцэтгэх ёстой байдаг байна.

Зураг 2



Эдийн засгийн хөгжил: Тус улсын хувьд 1962 оны байдлаар 1 хүнд оногдох ҮНБ-ний хэмжээ нь 80 ам доллартай тэнцэж, НҮБ, Дэлхийн банкны баримт бичгүүдэд дэлхийн хамгийн ядуу буурай, ядуу орны нэг гэсэн албан ёсны статус авч байсан. Гэвч 30 хүрэхгүй жилийн дотор 1 хүнд оногдох ҮНБ-нийхээ хэмжээг 125 дахин өсгөж, 10,000 орчим ам.долларт хүргэж чадсан юм.

Пак Чон Хи цэргийн эргэлтээр засгийн эрхийг авмагцаа эдийн засгийг сэргээх шаталсан гурван томоохон стратегийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн нь Солонгосын эдийн засгийн хөгжлийг өнөөдрийн түвшинд хүргэхэд томоохон хувь нэмэр оруулсан. Үүнд:

1. Импортын бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх
2. Экспортын чиглэлийн үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлэх
3. Оюуны багтаамжтай үйлдвэрлэлд шилжих орж байв.

Тиймээс Пак дээрх стратегид тулгуурлан эдийн засгийг хөгжүүлэх эхний 5 жилийн төлөвлөгөөг 1962 онд боловсруулан гаргав. Уг төлөвлөгөөнд Солонгосын нийтийг хамарсан ужиг ядуурлыг арилгах, эдийн засгийн хөгжлийн бие даасан бааз суурийг бий болгох гэсэн 2 гол зорилтыг тусгажээ. Эдгээр зорилтууд нь харилцан уялдаатай 6 бодлогоор (*Хүснэгт 1*) дамжин хэрэгжих аж.

Өмнөд Солонгосын анхны таван жилийн төлөвлөгөө /1962-1966/

Хүснэгт 1

Төлөвлөлт	Зорилт	Урт хугацааны зорилт
Эрчим хүчний нөөцийг хөгжүүлэх	Солонгос ядуурлыг арилгах	Үйлдвэржүүлэлт, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх, Амьдралын түвшинг сайжруулах
Эдийн засаг дахь бүтцийн өөрчлөлтийг хийх		
Суурь үйлдвэрүүд, дэд бүтцийг байгуулах		
Сул чөлөөтэй нөөц баялагийг үр бүтээлтэй зүйл болгон ашиглах	Өөрөө өөрийгөө санхүүжүүлэх эдийн засгийн хөгжлийн санг бий болгох	
Солонгосын төлбөрийн чадварыг ашиглах		
Технологийн хөгжилд туслалцаа үзүүлэх		

Юуг бид гаднаас авч байна түүнийгээ дотооддоо үйлдвэрлэж болно гэдэг бол Солонгосчуудын эдийн засгаа хөгжүүлэх эхний үе шатын гол зорилт байлаа. Аж үйлдвэрийн шийдвэрлэх гол салбаруудыг улс хяналтандаа авахын зэрэгцээгээр чөлөөт зах зээлийн зарчмуудыг өргөн ашиглан үндэсний хөрөнгөлөг хэсэг болон жижиг үйлдвэрлэл эрхлэгчдийг хөхүүлэн дэмжих аргыг өргөн хэрэглэж байв. Юуны түрүүнд дэд бүтцийг хөгжүүлэх явдлыг Пак чухалчилж байлаа. Цахилгаан эрчим хүч, гүүр, хурдын замыг дотоодын компаниуд дээр тулгуурлан барьж байгуулав. Дэд бүтэцгүйгээр эдийн засаг түргэн хугацаанд эргэлтэнд орж чадахгүй билээ.

Үүний дараа дотоодын зах зээлд эрэлт ихтэй өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг өөрт байгаа түүхий эдэндээ тулгуурлан, эсвэл гадаадаас

түүхий эд чигээр нь буюу хагас боловсруулсан байдлаар авч дотооддоо үйлдвэрлэх тийм үйлдвэрийг нэн тэргүүнд хөгжүүлэх зорилт тавьж хэрэгжүүлжээ. Энэ бол хөнгөн үйлдвэрийг голлосон үйлдвэржүүлэлт байв. Үүнийгээ эдэлгээ багатай нэхмэл бөс бараа, гутал, цемент зэргээс эхэлсэн байна. Дотоодын үйлдвэрлэлээ хангаад ирэхийн цагт валютын нөөцөө нэмэгдүүлэх нь чухал учир Солонгосчууд экспортод суурилсан үйлдвэрлэл рүү анхаарлаа хандуулжээ. Ингэхдээ Солонгосчууд дотоодын өсөн нэмэгдэж буй компаниуд дээрээ суурилсан юм. Япончууд кейрэцүг байгуулж, дотоодын компаниудаа санхүү болон техник, технологийн хувьд дэмжиж байсан бол Солонгосын корпорациудыг “Чаебол” загварт хамруулж ойлгож болно. Чаебол гэж нэг гэр бүлийн эзэмшилд багтдаг янз бүрийн чиглэлийн олон тооны компаниудаас бүрдсэн маш том бүлэглэлийг хэлдэг. Өнөөдөр Солонгост 50-иас дээш чаебол группууд бий. Худалдааны эргэлтээр нь жагсаахад, Хьюндай (1), Самсунг (2), Эл Жи (3), Дэу (4), Эс Кэй (5), Сангионг (6), Киа (7), Ханжин (8), Лотте (9) болон Ханва (10) гэсэн бүлэглэлүүд эхний 10 байранд орж байна. Эдгээрээс “Эл Жи”-г л хамаатан 2 гэр бүл удирдан ажиллуулдаг. Бусад нь бүгд нэг гэр бүлийн эзэмшлийнх ажээ. Эдгээр чаеболууд нь аль нэг салбараар дагнах биш, бүхий л салбарт хүч үздэг.

Дайны дараа Солонгосын компаниудад санхүүгийн хүчирхэг дэмжлэг гэж байсангүй. *Тэдний давуу тал юунд байв? гэсэн асуулт урган гарч ирнэ.* “Солонгосын хувьд өндөр хөгжилтэй улс орнуудтай өрсөлдөхөд цорын ганц давуу тал нь хямд ажиллах хүчин болж байсан ба хөдөлмөрийн хөлсний энэхүү таатай нөхцлийг ашиглан Солонгосын дийлэнхи фирмүүд үйлдвэрлэлээ ихээр нэмэгдүүлж, технологио боловсронгуй болгох замаар хөгжлийн гараагаа эхэлжээ.”¹⁹⁸ Солонгосын хамгийн том 10 чаебол дангаараа Солонгосын үндэсний нийт бүтээгдэхүүний талаас илүү хувийг бүрдүүлдэг байна.

Мөн Пакын засгийн газар хувийн секторуудын үйл ажиллагааг хянах янз бүрийн бололцоотой механизмыг ашиглаж байв. *Нэгдүгээрт*, засгийн газар бүх л арилжааны банкуудад гол хувьцаа эзэмшигч болдог. Хоёрдугаарт, Солонгост компаниудын зээлийн гол эх үүсвэр болсон гадаадын капиталын урсгалыг засгийн газар хяналтандаа авчээ. Гуравдугаарт, Солонгосын Төв банк, Сангийн ямаар дамжуулан бүх зээллэгт олгож байгаа хүүгийн түвшинг бас хяналтандаа оруулав. Банкны зээлийн хэмжээтэй олголт нь засгийн газарт экспортын бодлогыг дэмжих чухал хөшүүрэг болж өглөө. Мөн засгийн газрын зүгээс улсаас санхүүгийн зээл тусламж шууд үзүүлэх, тоног төхөөрөмж авахад нь валют олгох, татвараас түүний дотор цэвэр бүтээгдэхүүнээс авах татварт хөнгөлөлт үзүүлэх, тоног төхөөрөмжөө хугацаанаас нь өмнө солих, шинэчлэх эрх олгох, гадаадаас авах түүхийн эдийн үнийг хямдруулах, гадаад зах зээлийн түнш олж өгөх зэргээр дэмжиж байлаа. Эдгээр аргуудаас гадна, ерөнхийлөгч Пак том компаниудын ерөнхий захирлуудтай биечлэн уулзаж, сар болгон үндэсний худалдаанд оруулсан тэдний хувь нэмрийг авч хэлэлцэн, цаашдын төлөвлөгөөг ярилцдаг байжээ. Ерөнхийлөгч Пак “Экспортын тусламжтайгаар эх орноо хөл дээр нь босгоё” гэсэн үүрэг даалгавар бүхий уриаг дэвшүүлэн ажиллаж байв.

Пакын засгийн газар бодлого боловсруулахдаа үр дүнгээ ерөнхийлөгчид шууд тайлагнадаг, сайд нар, ерөнхий сайдын орлогч болон бусад өндөр мэргэшсэн хүмүүсээс бүрдэх “Эдийн засгийн төлөвлөлтийн хороо”-ны хатуу чанд эрх мэдэл дор хийгдэж байв. Уг хороо нь хөгжлийн төлөвлөгөө, улсын

¹⁹⁸ “Хүнд сорилт-Хэзээ ч бүү бууж өг: Чанг Жу Юнгийн намтар ба Хьюндайн замнал” Ричард М.Стурс. УБ., 2002 он

төсөв, гадаад орны хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын дэмжлэг ба Солонгосын 5 жилийн эдийн засгийн төлөвлөгөөг боловсруулах өндөр хариуцлага, онцгой эрх мэдлийг хүлээсэн байгууллага юм. Үйлдвэрлэлийн бодлогыг Худалдаа үйлдвэрийн сайд, Сангийн сайдтай зөвлөлдөн голлон тодорхойлно.

Сингапурын ерөнхий сайд асан Ли Куан Ю Падын бодлогыг дүгнэн бичихдээ “Тэрээр Японы туршлагаар дотоодын зах зээлээ чанд хамгаалж, бүтээгдэхүүн экспортлох түрэмгий гэмээр бодлого хэрэгжүүлсэн. Хүн ардаа хадгаламжтай байлгахыг дэмждэг, бүр шулуухан хэлэхэд шахаж шаарддаг, өнгөт телевизор мэт тансаглал хэрэглэхгүй харин өөрсдөө үй олныг үйлдвэрлэн гадагш гаргадаг байв”¹⁹⁹ гэжээ. Нэг ч техник, технологийн мэдлэгтэй хүнгүй байсан энэ үндэстэн богино хугацаанд аж үйлдвэржсэн улс болж чадсан нь үнэхээр гайхалтай билээ.

БНСУ өнөөдөр улс төр эдийн засгийн хүч нөлөө, олон улсын нэр хүнд нь өсөх хэрээр бүс нутагтаа түүний дотор Зүүн Азид идэвхитэй гадаад бодлого явуулж байгаа юм. Монгол Солонгосын харилцаа хэдийгээр олон зуун жилийн түүхтэй ч 13, 14-р зуунд нэн идэвхитэй байсан энэ харилцаа 20-р зуун хүртэл шууд утгаараа тасраад байсан юм. 20-р зуунд болсон дэлхий дахин, бүс нутаг, тус хоёр улсад өрнөсөн их өөрчлөлтүүдийн эргүүлгээр энэ харилцаа идэвхжин идэвхжсээр өнөөдрийн өдөртэй золгоод байна.

ДҮГНЭЛТ

Амьдрахын тулд хөдөлмөрлөдөг Барууныхнаас хөдөлмөрлөхийн тулд амьдардгаараа Солонгосчууд ялгагддаг. “Баян тансгаасаа энгийн нэгэн мухлаг хүртэл зэрэгцэн орших худалдааны гудамжууд шөнө дөл болтол ажиллаж, хүмүүс худалдаа наймаа хийж, хэлцэн тохирч байх нь Солонгосчуудын хувьд ердийн дүр төрх.” Үнэхээр ч Солонгосчууд эцэж цуцалтгүй хөдөлмөрлөж байж өнөөдрийн тэргүүлэх гүрнийг бий болгож чадсан юм. Солонгосчууд бол арвигч, хямгач зан чанараар баялгийг бүтээсэн ард түмэн юм. Тэд мөнгийг мөнгө дахин олж болох зүйлд л зарцуулдаг. Солонгосын компаниудын өрсөлдөөнч чанар гадаадын пүүсүүдтэй харьцуулахад удирдлага, ажиллагсадын хичээл зүтгэлээр ялгагдан тодорхойлогддог. Нэгэн үйлдвэрийн америк ажилтан: “Солонгосчууд маш шамдуу нэр ажилладгаараа өрсөлддөг” гэжээ. Америк, Солонгос ажилчдын хооронд ямар ялгаа байгаа болохыг түүнээс тодруулан асуухад, тэрбээр “Би Солонгос гагнуурчидтай хамт ажиллаж үзсэн. Тэд өдөрт 10 цаг ажилладаг. Ингэхдээ тэд металл гагнахад өдөрт 8 цагаа зориулдаг. Гэтэл Америк гагнуурчид өдөрт 8 цаг ажилладаг ч ихэнхидээ 7 юмуу 7 цаг хагас ажиллаж, гагнуурт зөвхөн 2 цагийг л зарцуулж харагддаг. Надад Солонгосчуудын хөдөлмөрч зан таалагдаж байна, харин Америкчууд ажил хийдэггүй юм” гэж хариулжээ.”²⁰⁰

Ли Куан Ю Солонгосчуудын тухай бичихдээ, “Солонгосчууд бол сүрдмээр улс. Үймж бужигнаж байхдаа ч өмнөө сөрөн зогсож байгаа цагдаагийнхнаас ялгаагүй дэг журамтай байдаг. Пластик бамбай барьж, пластик дуулга өмссөн цагдаагийнхан гладиаторуудыг санагдуулдаг. Солонгосын ажилчид, оюутнууд

¹⁹⁹ “Сингапур: Буурай орноос бусдын манлайд хурсэн замнал” *Ли Гуан Яао*. УБ., 2007 он

²⁰⁰ “Хүнд сорилт-Хэзээ ч бүү бууж өг: Чанг Жу Юнгийн намтар ба Хьюндайн замнал” *Ричард М.Стирс*. УБ., 2002 он

гудамжинд цагдаагийнхантай мөргөлдөж байгаа нь яг дайн шиг харагддаг. Солонгосын ажил хаягчид газар суучихсан, ярьж байгаа нэгнээ сонсон үе үе зангидсан гараа дээш шидэн зэрэг зэрэг орилж харагддаг. Ер нь Солонгосчууд сэтгэлийн их хөдөлгөөнтэй, төр засагтай зөрчилд орвол эвээ олохыг хичээдэггүй, ямар ч саадыг тоохгүй эрчимтэй тэмцдэг хүмүүс шиг санагддаг. Солонгосчууд бол эрч хүчтэй, ажилсаг, шийдмэг, өндөр чадвартай, зорилго тэмүүлэлтэй ард түмэн”²⁰¹ гэжээ

ABSTRACT

From 1948 till Lee Myung Pak of 2008, total of 6 republican countries changed with 10 years of duration undergoing civil wars, political divisions, military coup, riots and civil unrests. And during this period of time, Korea went through both presidential and cabinet forms of government and 10 presidents succeeded each other, and there was less peaceful time that that of armed rebellions, and military coup dictators. However, the 5th republican country underlay the transition to civil society rule, and it was only in 1993 that people of Korea fulfilled their desire for establishment of civil and democratic society.

The current Republic of Korea has a presidential system of governance and the balance of power is maintained through Judicial, Executive, and Legislative branches in a same way other countries have. These three branches are equally balanced and each branch has its own distinct role and functions.

²⁰¹ “Сингапур: Буурай орноос бусдын манлайд хүрсэн замнал” Ли Гуан Яао. УБ., 2007 он

The 19th National Assembly Election and Post-Election Political Changes in Korea²⁰²

Turtogtokh Janar

*Dr., Prof. of Department of Political Science
School of Social Sciences, National University of Mongolia*

Introduction: In this paper, the author will not examine whole issues of parliamentary institutions, but examine some aspects of Korea's legislature. At the beginning, this work covers historical and constitutional basis of the National Assembly of the Republic of Korea (ROK). Then it shows the National Assembly as a national law-making body as well as a political representative institution. In the field of parliamentary institutional research, the study of the electoral system and its realization is of the utmost importance. Therefore, this paper covers the issues on election system for a legislative institution, and its effect on the country's political process. Next part is about 19th Assembly election results and political parties of Korea, and election results implications for the presidential elections of Korea. Last but not least, Korean women's political achievements are discussed.

Historical Background of Korean National Assembly

History of Korean parliamentary institution is a rich of development changes and challenges. Historical development and significance of the legislature has been studied by parliamentary scholars (Kim and Pai, 1981; Yoon, 1991; Park, 1998: 66-68, 2002a: 330-32) and practitioners or politicians such as former Members of the National Assembly (Kil, 1964: 1-12; Pak, 1976: 115-34) by various attempts. For instance, Park (1998) investigated the changes of the Korean legislature's policy activity in the context of the historical dimension. As Park briefly emphasized, the Korean National Assembly has a relatively short but turbulent history (Park, 1998: 68). I, the author of this paper, concurred with this, however, not only in terms of parliamentary institutional changes but also development of contemporary Korean politics.

From the beginning of the First Republic through the current Sixth one, Korea has experienced a series of political alterations. In line with this, the place of the legislative institution in the Korean political system has ever changed (see Table 1). With the heavy influence of the Constitution, the legislature became the focal point of politics and exercised a great deal of power (See more on Kim and Pai, 1981: 23).

²⁰² This paper is based on field research results which held between 24 June and 15 August, 2012, Seoul, Korea. The research was supported by the Institute for Far Eastern Studies, Kyungnam University, Korea. The author would like to thank Professor Lee Su-Hoon, Director of the Institute for Far Eastern Studies, Kyungnam University, for his kind welcoming and giving the opportunities to do summer research in Korea. The author also thanks much Ms. Min Heeseon, international coordinator at the Institute for Far Eastern Studies, Kyungnam University, for her kind support, understanding and assistance.

For instance, in case of the Korean National Assembly of the Fourth Republic, Mezey classified that legislature as a marginal type, a category of legislatures with modest policy-making power and a relatively low degree of support (Mezey, 1979: 21-44).

Table 1. A Chronology of the Korean National Assembly.

Republic	Regime Type	System of Government	Assembly	Term
First	Authoritarian	Presidential	Constituent	May 1948-May 1950
			Second	May 1950-May 1954
			Third	May 1954-May 1958
			Fourth	May 1958-May 1960 (curtailed due to the student uprising)
Second	Democratic	Parliamentary	Fifth	July 1960-May 1961 (dissolved by the military coup)
Third	Authoritarian	Presidential	Sixth	December 1963-June 1967
			Seventh	July 1967-June 1971
			Eighth	July 1971-October 1972 (dissolved due to martial law)
Fourth	Authoritarian	Presidential	Ninth	March 1973-March 1979
			Tenth	March 1979-October 1980 (dissolved by the military coup)
Fifth	Authoritarian	Presidential	Eleventh	April 1981-April 1985
			Twelfth	April 1985-May 1988 (curtailed due to pro-democracy protest)
Sixth	Democratic	Presidential	Thirteenth	May 1988-May 1992
			Fourteenth	June 1992-May 1996
			Fifteenth	May 1996-May 2000
			Sixteenth	May 2000-May 2004
			Seventeenth	May 2004-May 2008
			Eighteenth	May 2008-May 2012
			Nineteenth	May 2012-present (Elected on 11 April 2012)

Source: Park: 2002²⁰³

Likewise, in his study of the National Assembly's place in the Korean polity, Park (1998: 68-71) defined about the current Sixth Republic's case. As shown in table 1,

²⁰³ Original form of this table is created on Park's article (Park, 2002: 331). However, last three lines of given table is added by the author.

Sixth Republic has started since May 1988 and the National Assemblies in the current Republic has still been moving forward. For instance, as Park more clearly viewed that the National Assembly in the first two years of the current Sixth Republic was a vulnerable legislature, having strong policy-making power but not being so well supported. It could be said to be a fairly weak form of vulnerable legislature. The legislature's strength of policy-making power has declined. More recently, the legislature has shown more vigor than at the peak of authoritarianism in terms of its policy-making power, but it still has modest policy-making power. The degree of support for the legislature has declined much further since the early years of the Sixth Republic. Presently²⁰⁴, the legislature is just a fairly strong form of marginal legislature (Park, 1998: 69). Although Republic of Korea is a country of presidential system of government²⁰⁵, its National Assembly is the most competitive²⁰⁶, open and democratic materialization of political life, and its role is a lot in Korean political system. The parliamentary institute of this country has overcome plenty of obstacles and hierarchy of political formation and development during the period of authoritarian and democratic political regime, presidential and parliamentary system of government.

Constitutional background of contemporary Korean polity

The Constitution of the Republic of Korea is the general instrument of Korean government and the supreme law of the land. For 60 years, it has guided the evolution of governmental institutions and has provided the basis for political stability, individual freedom, economic growth and social progress. The current constitutional system, which started in 1987, was based on a constitutional bill that was passed by the National Assembly on October 12, 1987, and subsequently approved by 93 percent of the voters in a national referendum on October 28. This change of constitutionalism transferred power from the authoritarian Fifth Republic into the Sixth Republic or the country's present-day government system. The current Sixth Republic constitution went into effect on February, 1988 when Roh Tae-Woo was inaugurated as the Republic's President.

In the Constitution, the system of governing of the Republic of Korea is a presidential system based on such principles as separation of powers, and checks and balances. According to the Constitution, the President is the Head of State (*The Constitution of Korea*, Article 66:1) and executive power is vested in the Executive branch headed by the President (*The Constitution of Korea*, Article 66:4). The President appoints a Prime Minister who runs the government as directed by him. The President has power to attend and address the National Assembly, to convene its extraordinary session, and to exercise a veto on the bill passed by it. He/she appoints high-ranking public officials, including the prime minister and chief justice, with consent by the

²⁰⁴ This article by Park is published in 1998.

²⁰⁵ The Constituent Assembly of the Republic of Korea adopted a constitution containing a basically this type of government in 1948 (Park, 1998: 65).

²⁰⁶ As Kim and Pai (1981: 37) noted in advanced manner, this legislature is the most important linkage institution. In this regard, one of ideas of this field research is found.

National Assembly. Constitution enables him that in time of internal turmoil, external menace, natural calamity, or a grave financial or economic crisis, the President may take in respect to them the minimum necessary financial and economic actions or issue orders having the effect of law, only when it is required to take urgent measures for the maintenance of national security or public peace and order, and there is no time to await the convocation of the National Assembly. In the executive branch, the prime minister is formally the second powerful next to the president.

The legislature called National Assembly or Daehan Minguk Kuk Hoe is a unicameral and has 299 members who are elected to four-year terms. Legislative power is vested in the National Assembly. It can also exercise power to investigate specific matters when deemed necessary. Moreover, the legislature has power for fiscal control which provided by the Constitution and the National Assembly Law. However, such fiscal control power is examined by Park as a passive role for the legislature (Park, 2003: 495). The National Assembly members and the President are elected respectively by universal, equal, direct, and secret ballot by the citizens of the Republic of Korea (*The Constitution of Korea*, Articles 41:1 and 67: 1).

Korea's judicial system comprises a Supreme Court, appellate courts, and a Constitutional Court. Korea has a legal system which combines certain elements of continental European civil law systems, Anglo-American law, and Chinese classical thought. Particularly, the German civil code has been the basis for the legal systems of South Korea because "...the expansion of the colonial empires of the European powers in the 19th century brought the civil law system based on Roman law to many countries in Asia and Africa" (Badr, 1977: 187).

As mentioned above, the Constitution provides for a three-branch governing system whereby law-making functions are in the preserve of the National Assembly, administrative functions are in the preserve of the executive branch, headed by the President, and judicial functions belong to the courts. Structurally, these three branches are highly independent of each other. The members of the National Assembly are elected by the people, and the National Assembly's leaders and officers are chosen by the members themselves. As for the President, he/she is not required to obtain the approval of the National Assembly in appointing top executive officials, except in the case of the Prime Minister and the Director of the Board of Inspection and Audit. The head of the Supreme Court, the Chief Justice, although appointed by the President with the consent of the National Assembly, possesses the power to recommend to the President the appointment of Supreme Court Justices, and has the power to appoint all other judges.

Another noticeable one is which the economic developments of the country have been strongly influenced by the constitutional principle which supports a free-market economy. The Constitution declares that the nation's economic order is based on recognizing individual and corporate freedom and creativity (See *The Constitution of Korea*, Article 119:1).

Election system reforms and party representations in the National Assembly

An election is a process in which a vote is held to elect candidates to an office. It is the mechanism by which a democracy fills elective offices in the legislature, and sometimes the executive and judiciary, and in which electorates choose local government officials.

Generally, democratic elections are viewed as possibilities through which voters influence political leaders. But even in free democracies they can also be seemed from the top down, as institutions which expand the authority of the rulers over the ruled. For some authors such as Ginsberg (1982), this is the major function of elections - competitive elections as well as elections without choice. King (1981) provides a very clear review of the rather technical literature on the consequences of competitive elections.

Precisely six decades have passed since the first election was held in ROK under the supervision of the temporary U.N. Korean Commission in May, 1948. In the past years Korea elected its National Assembly 19 times. In thirteen of these nation-wide elections, political leaders stood for office under election regulations that had been modified.

Elections and its historical lessons have faced many obstacles and hardships in Korea. At the beginning of independence in Korea, people had never experienced the election (Pak, 1976: 119). Very fortunate for the nation in newly democratizing era is free and fair elections have settled in this country. Park expressed importantly that “the only game in town” is this free, fair, and regular elections²⁰⁷. In accordance with Article 41 of the Constitution of Korea, the members of the National Assembly are elected by universal, equal, direct, and secret ballot by the citizens. The constituencies of members of the National Assembly, proportional representation, and other matters pertaining to National Assembly elections are determined by law.

Electoral systems are a set of rules for conducting an election and a matter for choice. These rules specify which public officials are subject to election, which is eligible to vote, how these eligible can claim their right to vote, how the candidates must be selected, and how the votes are to be counted so as to produce an overall result.

Since the establishment of the Korean government then, the election system has been changed many times. Since 2004 National Assembly election, according to the Constitutional court decision on July 19, 2001, there has been an important change in the electoral system. This was from “one-vote” to “two-ballot”. In 2001, the Constitutional court made decision on “one-vote” is unconstitutional as well as unfair and restrictive of voter’s rights. Why?

The previous one was a kind of mixed where plurality dominated proportional representation. This domination was not only in the seat allocation but also in the

²⁰⁷ The author strongly recommends to those who interested much in Korea’s parliamentary institutional study, professor Park Chan Wook’s tremendous and significant articles for the scholars. For instance, in this case, Park (2007: 103) noted it in his article.

balloting system. Although a voter was allowed to cast only one vote to a candidate in the single-member district, the vote would be also used in distributing proportional representation seats among the political parties. Therefore, this brings out that a voter’s single vote was counted two times for two different purposes. As Park notes:

In this ostensibly mixed system, the plurality component is dominant. A voter casts a single ballot in choosing his or her district representative. This vote is counted again as the vote for the candidate’s party list for proportional representation. The at-large seats are divided in proportion to each party’s nationwide vote share among the parties with at least five district seats, or with five per cent or more of the total valid votes. Of the legislative members, district representatives do not lose their seats when they change their party affiliation. Only at-large representatives are deprived of their legislative seats when they leave their own original party (Park, 1998: 75).

Anyway, Korean National Assembly passed new electoral law which reflected by the Constitutional court rule. The established system allows voters to cast two votes, one to a candidate in single-member district and the other to a party list in proportional representation. The first one determines the winner in each constituency, and the second one is used to distribute proportional representation seats among parties. One candidate from each electoral district is selected by a plurality of votes. Each voter casts two votes, one for an individual, and one for a closed party list in the proportional representation tier. Seats in both tiers are allocates separately; each party is allocated its parallel share of the proportional or at-large seats plus the district seats won by its candidates. The proportional representation system is aimed at appointing Assembly members who will represent national interests rather than local interests.

Under the revised electoral system, the National Assembly was composed of 300 seats. Out of the 300 members, 246 members are elected by popular vote in single-seat constituencies, while the remaining 54 seats allocated to each political party that has obtained 3/100 or more of the total valid votes or five or more seats in the local constituency election.

Post-democratic transition or during 24 years of 1988-2012, the following table shows briefly the general ratio of the parties’ seats obtained in the Assemblies.

Table 2. Political party representations in the 13th through 19th National Assembly (1988-2012)

Assembly	Year	Party	District seats	At-Large seats	Total
13 th	1988	DJP	87	38	125
		PPD	54	16	70
		RDP	46	13	59
		NDRP	27	8	35
		9 minor parties	1	0	1
		Independents	9	0	9
		Total	224	75	299

14 th	1992	DLP	116	33	149
		DP	75	22	97
		UNP	24	7	31
		NPP	1	0	1
		2 minor parties	0	0	0
		Independents	21	0	21
		Total	237	62	299
15 th	1996	NKP	121	18	139
		NCNP	66	13	79
		ULD	41	9	50
		DP	9	6	15
		Independents	16	0	16
		Total	253	46	299
16 th	2000	GNP	111	21	133
		MDP	96	19	115
		ULD	12	5	17
		DPP	1	1	2
		4 minor parties	1	0	1
		Independents	5	0	5
		Total	227	46	273
<i>Under revised system</i>			Local seats	Block seats	
17 th	2004	UP	129	23	152
		GNP	100	21	121
		DLP	2	8	10
		MDP	5	4	9
		ULD	4	0	4
		Other / Independents	3	0	3
		Total	243	56	299
18 th	2008	GNP	131	22	153
		UDP	66	15	81
		LFP	14	4	18
		PP	6	8	14
		DLP	2	3	5
		RKP	1	2	3
		SPP	12	0	12
		Independents	13	0	13
		Total	245	54	299
19 th	2012	NFP	127	25	152
		DUP	106	21	127
		UPP	7	6	13
		LFP	3	2	5
		Independents	3	0	3
		Total	246	54	300

Source: the data source of the table is from Park (2002b: 171-75) for the 13th to 16th National Assembly and some columns showing the percentage and advantage ratio is not used in this table. However, last three main rows for the 17th, 18th and 19th ones have been added by the author, respectively.

Note:

1. as for the 13th National Assembly: DJP = Democratic Justice Party; PPD = Party for Peace and Democracy; RDP = Reunification Democratic Party; NDRP = New Democratic Republican Party

2. as for the 14th National Assembly: DLP = Democratic Liberal Party; DP = Democratic Party; UNP = Unification National Party; NPP = New Politics Party

3. as for the 15th National Assembly: NKP = New Korean Party; ULD = United Liberal Democrats; NCNP = National Congress for New Politics

4. as for the 16th National Assembly: GNP = Grand National Party; MDP = Millennium Democratic Party; ULD = United Liberal Democrats; DPP = Democratic People's Party

5. as for the 17th National Assembly: UP = Uri Party; GNP = Grand National Party; DLP = Democratic Labour Party; MDP = Millennium Democratic Party; ULD = United Liberal Democrats

6. as for the 18th National Assembly: GNP = Grand National Party; UDP = United Democratic Party; LFP = Liberty Forward Party; PP = Park's Party; DLP = Democratic Labour Party; RKP = Renewal of Korea Party; SPP Independents = Solidarity for Pro-Park Independents

7. as for the 19th National Assembly: NFP = New Frontier Party or Saenuri-dang; DUP = Democratic United Party; UPP = Unified Progressive Party; LFP = Liberty Forward Party

As we can see here, ratio of the political parties on the level of the legislature has been going toward the formation of the two dominant or big parties. The table 2 shows that either party has obtained the seats of majority and main opposition power seats not depending on that a party managed to become a majority in the legislative institution; however, there has been not a few process of unification and separation among the political parties of Korea from one National Assembly to another one.

However, majoritarian and proportional, which are the most general two electoral systems, are being used for the election of the National Assembly as they are simplest and plainest variation for the election. Voters mostly tend to express dual opinion depending on the peculiarity of the electoral system. It is a requirement to elect a specific one party on the basis of party's election program and a candidate according to his/her order of list order in the party. Due to this "tiny" problem of the


mixed system the voters' participation is seen to drop. The reason is that if a voter decides to vote in the election, he/she needs to make a dual vote for the election.

This peculiarity of the electoral system, which can be “problem” for the voters, tends them to vote for the main parties which have long years of experience and are well-known among the public. Although a proportional system helps a lot of parties to be represented in the legislative institution, it is difficult for the small parties to obtain seats to compose legislative majority. Moreover, setting an electoral threshold limits the minimum amount of necessary votes to obtain seats in the parliament. It is, as well, becomes an obstacle for the small parties.

Election results and political parties

General election for the 19th term of the Korean National Assembly was held in April 11, 2012 as it was scheduled. The vote determined 300 members of the National Assembly and shaped the political arena for presidential elections on December, 2012. The election was conducted under a mixed system which consists of 246 directly elected seats and 54 nationwide proportional representation seats chosen under First-Past-The-Post – Proportional Representation parallel voting system. In Korea’s political system, the loss of control in the parliament could have hindered the head of state’s cabinet substantially.

Figure 1. 19th National Assembly Election Results Map



Source: National Election Commission (*The Korea Herald*, 2012-04-12)

Voter turnout was 54.3 percent, up from the all-time low in 2008 when voter turnout fell just short of 46 percent²⁰⁸. Voters want fair, responsible and clean politics and the election generated much enthusiasm and rocked big discussion among society.

The election was won by the ruling Saenuri-dang or New Frontier Party, which the largest conservative party in this country while incumbent government. With 152 seats, the party formed its majority in the National Assembly, despite losing seats. Not only caused by the largest conservative force but also the results were surprisingly heat politics which the party is former the Hannara-dang or the Grand National Party that renamed just two months before the general election. However, in case of Hannara-dang, it wanted to change its public confidence and broaden its political and public support base, thus took this new name as Saenuri.

Minju Tonghap-dang or the Democratic United Party, liberal, took 127 seats. This center-left one is a newly established party, which in December 2011 reorganized a liberal coalition by merging the Democratic Party, a group of former supporters of late president Roh Moo-hyun, and some activists from the Korean Trade Union.

As for other parties, Jayu Seonjin-dang or the Liberty Forward Party won 5 seats, Tonghap Jinbo-dang or the Unified Progressive Party won 13, while independents won 3 seats.

Table 3. National Assembly Election Results: 11 April 2012

Votes cast: 54.3 % voted.

Parties	District	Proportion al	Total Seats (% of all seats)
New Frontier Party (Saenuri-dang)	127	25	152 (50.66%)
Democratic United Party (Minju Tonghap-dang)	106	21	127 (42.33%)
Unified Progressive Party (Tonghap Jinbo- dang)	7	6	13 (4.33%)
Liberty Forward Party (Jayu Seonjin-dang)	3	2	5 (1.66%)
Independents	3	0	3 (1%)
Total	246	54	300

Source: National Election Commission

As see this, two main political parties were competing in the legislature elections which are the Saenuri Party and the Democratic United Party, and this figures newly established or newly formed parties were the main players of the 19th parliamentary elections, but in political reality the background of the ruling and opposition parties remains same as before.

²⁰⁸ National Election Commission announced the voter turnout was the lowest for any national election in the history of Korea (Ser, 2008).

Not so much surprisingly, however in order to create more challenging anticongervative coalition or opposing to the Government, left Tonghap Jinbo-dang has aligned with the main opposition Minju Tonghap-dang. Before the general election those of two left forces compromised on nomination. As a result of their agreement, the nominations of only one candidate of either party in each of 64 electoral districts have allowed. It helped finding more seats in the legislature by merging voters for those who supports liberals or lefts.

Several factors made the Saenuri Party's victory possible. First, the party undertook a massive makeover under the leadership of Park Geun-hye, who is the most likely presidential candidate from the conservative party. Park proved to be extremely successful in mobilising conservative voters. Second, even at the risk of diluting its conservative identity, the Saenuri Party not only distanced itself from the Lee administration, but also shifted its policy focus to issues such as social welfare. The strategy appears to have worked and attracted some swing voters who would otherwise have voted for the Democratic United Party or the Unified Progressive Party. And the last factor was the opposition parties' inability and failure to meet the expectations of their own supporters and dissatisfied swing voters (See more on Ryu, 2012). Saenuri Party and Democratic United Party are campaigned on platforms of strengthening Korea's welfare state and implementing policies that would help small and medium entrepreneurs. This could be provided opportunities for both parties work together until the Presidential elections. On another side, current President Lee Myung-bak will work for the rest of this year and he has political support within the legislature to keep going his policies.

Implications for the Presidential elections of Korea

The National Assembly election figures background for the 2012 presidential election. The presidential elections will be held in December²⁰⁹. At the moment, as ideology, conservative politics in both legislature and executive. Thus, the presidential elections will be formed on the basis of conservatives dominated background.

The Saenuri Party's victory came despite the current conservative administration, led by Lee Myung-bak, having a very low approval rating and the tactical alignment between the Democratic United Party and Unified Progressive Party (Ryu, 2012: 1). As Korean public see, Saenuri Party leader Park Geun-hye will continue (as she was challenged to Lee Myung-Bak for the presidential candidate run within the party in 2007) presidential candidate. However, things are not going easy for Park. Park's

²⁰⁹ This part of the paper's prepared in July, 2012.

leadership inside of the Saenuri will depend on public support for the Saenuri Party as a majority force in the National Assembly.

Despite the National Assembly election victory, the Saenuri Party has much to worry about in the upcoming presidential election. Recently, three of the Saenuri Party's presidential candidates – Kim Moon-soo, Kim Tae-ho and Yim Tae-hee announced that they will not take part in any of the upcoming primary events, including public speeches and debates, unless party chair Hwang Woo-yea resigns to take responsibility for the latest money fixed candidacy scandal, and moreover, they will boycott all primary-related activities until the results from the investigation into the scandal are out and party leader Hwang resigns.

For gathering and expanding public support, the above will bring a big challenge for the Saenuri as well as the party's leading presidential candidate Park Geun-hye. Meaningfully, Park criticized those of candidates for being disrespectful towards the people and the party. It is reasonable for avoiding downfall the entire party's image among public. Anyhow, the election results may enhance Park's chances in this December's presidential race. As a scholar Park noted, it would make her the first democratically elected female president in South Korea, an economically vibrant but largely male-dominated society (Park, 2012: 1). If the two liberal parties put forward united one candidate in the presidential election, Park Geun-hye or other candidate from the Saenuri will face tough fight. Because, the actual vote for the Saenuri Party was less than the combined share of the two liberals in the National Assembly election.

Briefly, the National Assembly elections affect the candidates from the parties for the Presidential elections especially in this Year of Election in Korea. Consecutive victories by conservatives since 2007 would be remained in December election.

In April election, domestic issues rather than foreign policy were key issues not only among parties but for public. This means that the National Assembly as a nationwide political represented institution has narrowly been focused on domestic issues seem to public foreign affairs which mainly ruled by the Executive as same as in presidential systems have been going correctly. Nevertheless, more clear policy or national issue differences will be appeared during the debates of the presidential election campaign.

Difficulties and challenges are not reasoned by outsourcing only. Inside the Saenuri, the battle between Park Geun-hye as a frontrunner and Kim Moon-soo as runner-up is heating up just before the final selection (*The Korea Herald*, 2012-08-13).

Now we'll see how the Saenuri Party set to elect its final presidential candidate at a national caucus on 20th August 2012²¹⁰.

Conclusion Remarks: Is It Political Time for Women in Confucius Society?

Korean female politicians' dramatic success and challenges in Korean society which heavily influenced by Confucianism are on the focus. In Confucian cultural society, women's social and political role was restricted to housing duties such as growing children and doing housework. However, since the 1990s Korean democratization, women's social status and their political activeness and participation has been increasing and strengthening. One of the crucial points is that of main political parties which are majority, principal opposition and third one are all ruling by women. Namely, Saenuri Party leader is Mrs. Park Geun-hye, main opposition Democratic United Party's leader is Mrs. Han Myeong-sook while third party in the legislature Unified Progressive Party's leader is Mrs. Lee Jung-hee respectively.

Figure 2. Saenuri Party Leader Mrs. Park Geun-hye



Source: The Telegraph (25 February 2013)

Figure 3. Democratic United Party Leader Mrs. Han Myeong-sook

²¹⁰ This part of the paper's prepared in July, 2012.



Source: Arirang News (13 April 2012)

Figure 4. Unified Progressive Party Leader Mrs. Lee Jung-hee



Source: Yonhap News Agency (25 September 2012)

Moreover, the revised electoral law which reflected by the Constitutional court decisions on July 2001 governing political parties stipulates that half of every party's proportional representation list has to consist of women candidates.

Thus, those of sub-parts as Confucius consideration of women in society and their historical social status, Korean adoption of Confucianism, and women's political participation in contemporary Korean politics, the latest phenomena would be integrated in this part if it may on.

References

Arirang News. 2012. *Han Myeong-sook Soundbite*. Available online at http://www.arirang.co.kr/News/News_View.asp?nseq=128023&category=2

[accessed on 13 May 2013]

Badr, Gamal Moursi. 1978. "Islamic Law: Its Relation to Other Legal Systems," *The American Journal of Comparative Law*. 26 (2), 187-198.

Cho, Wonbin. 2005. "The Geberal Election in South Korea, April 2004," *Election Studies* 24, 511-551.

Ginsberg, B. 1982. *The Consequences of Consent*. Reading, Mass: Addison-Wesley.

Hix, Simon and Hae-Won Jun. 2009. "Party Behaviour in the Parliamentary Arena: The Case of the Korean National Assembly," *Party Politics* 15 (6), 667-694;

Jun, Hae-won, and Simon Hix. 2010. "Electoral Systems, Political Career Paths and Legislative Behavior: Evidence from South Korea's Mixed-Member System," *Japanese Journal of Political Science*. 11 (2), 153-171;

Kang, Won-Taek. 2002. "Reform of Korea's National Assembly Electoral System," *Korea Focus*. 10 (6), 81-98.

Kil, Ki-sang, ed. 1964. *The National Assembly of the Republic of Korea*. Seoul: Kwang Myong Printing Co.

Kim, Chong Lim, and Byung-Kyu Woo. 1975. "Political Representation in the Korean National Assembly," In Boynton, G.R., and Chong Lim Kim, eds., *Legislative Systems in Developing Countries*. Durham: Duke University Press, 261-286.

_____, and Seong-Tong Pai. 1981. *Legislative Process in Korea*. Seoul: Seoul National University Press.

King, A. 1981. "What Do Elections Decide?," In Butler, D., Penniman, H. and Ranney, A., eds., *Democracy at the Polls*. Washington, DC: American Enterprise Institute, 293-324.

The Korea Herald. 2012-04-12. "19th National Assembly Election Results Map"

Lijphart, Arend. 1984. *Democracies: Patterns of Majoritarian and Consensus Government in Twenty-One Countries*. New Haven: Yale University Press.

Mezey, Michael L. 1979. *Comparative Legislatures*. Durham, NC: Duke University Press.

National Assembly of the Republic of Korea. 1948. *The Constitution of Korea*.

Pak, Chan Hyun. 1976. *A Comparative Study of the Congress of the United States and the Korean National Assembly*. Seoul: Kwang Myung Printing.

Pak, Chi Young. 1968. "The Third Republic Constitution of Korea: An Analysis," *The Western Political Quarterly*. 21 (1), 110-122.

Park, Chan Wook. 1998. "The National Assembly of the Republic of Korea," *The Journal of Legislative Studies*. 4 (4), 66-82.

_____. 2002a. "Change Is Short but Continuity Is Long: Policy Influence of the National Assembly in Newly Democratized Korea," In Gerhard Loewenberg et al. eds., *Legislatures: Comparative Perspectives on Representative Assemblies*. Ann Arbor: University of Michigan Press, 329-351.

_____. 2002b. "The Rules of the Electoral Game for the National Assembly in Democratic Korea: A Comparative Perspective," *Journal of Korean Politics*. 11 (1), 167-196.

_____. 2003. "Budget Review in the National Assembly of Democratic Korea," *Journal of East Asian Studies*. 3 (3), 493-521.

_____. 2007. "The National Assembly in the Quagmire of Public Distrust: A Stumbling Block or a Facilitating Agent on Korea's Path toward Democratic Consolidation?," *Political Science in Asia*. 2 (2), 103-114.

Park, Il Kyung. 1962. "Review of the 14-Year History of Korean Constitutional Government," *Koreana Quarterly*. 4 (2), 23-34.

Park, Myuonng-ho. 2012. "South Korea's Surprise Election Results," *East Asia Forum: Economics, Politics and Public Policy in East Asia and the Pacific*. 14th May.

Reilly, Benjamin. 2007. "Electoral Systems and Party Systems in East Asia," *Journal of East Asian Studies*. 7, 185-202

Ryu, Yongwook. 2012. "South Korea's 2012 National Assembly Elections," *East Asia Forum: Economics, Politics and Public Policy in East Asia and the Pacific*, 25th April.

Ser, Myo-ja. 2008. "Grand Nationals make big gains," *Joong Ang Daily*, April 10.

Shin, Myungsoon. 2005. "South Korea: Citizen's Confidence in Public Institutions," In Takashi Inoguchi, et al., eds., *Values and Life Styles in Urban Asia: A Cross-Cultural Analysis and Sourcebook Based on the AsiaBarometer Survey of 2003*. Institute of Oriental Culture, University of Tokyo.

Song, Sang-ho. 2008. "Lee renews calls for rule of law," *The Korea Herald*, August 26.

The Telegraph. 2013. *Park Geun-Hye Becomes South Korea's First Female President*. Available online at <http://www.telegraph.co.uk/news/worldnews/asia/southkorea/9891902/Park-Geun-Hye-becomes-South-Koreas-first-female-president.html>

[accessed on 13 May 2013]

Yonhap News Agency. 2012. *Minor Candidates Could Impact South Korea's Presidential Race: Observers*. Available online at <http://english.yonhapnews.co.kr/national/2012/09/25/0/0301000000AEN20120925010000315F.HTML>

[accessed on 13 May 2013]

Yoon, Young O. 1991. *Korean Legislative Behavior: a Longitudinal Analysis in Comparative Perspective*. Seoul: Kookmin University Press.

УЛС ТӨРИЙН РЕАЛИЗМ БА ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААН ДАХЬ БАГА УЛСЫН ЖИЖИГ “БОДОЛ”

С.Базарпүрэв

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн багш, дэд профессор

Түлхүүр үг: Олон улсын харилцаа, улс төрийн реализм, бага, жижиг улсын улс төрийн бодлого, их гүрэн

Олон улсын харилцааны уур амьсгал, чиг хандлага зэргийг тодорхойлон томъёолох нь тухайн улс орны үндэсний эрх ашиг, сонирхолд ямагт нийцэж байдаг билээ. Манай орны хувьд ч гэсэн энэ асуудал нэн чухал байх болно.

Монгол улс олон улсын харилцаанд бие дааж оролцох улс төрийн боломж нээгдэж улс орны хөгжлийг хангах эрх дан ганц өөрт нь ноогдох болсонтой уялдан олон улсын харилцаанд зохистой оролцох улс төрийн бодлого боловсруулах зорилго тулгарч байдаг. Ийм боломж бүрэлдэж, эрхээр хангагдах нь нэг талын асуудал юм. Харин түүнийг үр ашигтай, үндэсний сонирхолд нийцүүлэн зүй зохистой үр дүнд хүргэх нь чухал зорилт болоод байна.

Үүнийг хэрэгжүүлэх ажил нь юуны өмнө олон улсын харилцааны тулгамдсан асуудлыг судлан шинжлэхээс эхлэх учиртай ажээ. Олон улсын харилцаанд баримтлах бодлого, байр суурь, шинжлэх ухааны парадигм, онолтой танилцах нь нэн тэргүүнд хийх ажил болов уу.

Монголын дотоод нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал эрс өөрчлөгдөж, түүнд гаднаас үзүүлэх олон улсын субъект, хүчин зүйлсийн тоо чанар шинэчлэгдсэн ч олон улсын харилцаанд баримтлагддаг зарчим, байр суурь бага засварлагдсан ажээ.

Олон улсын харилцааны дүр төрхийг тодорхойлон тайлбар өгсөн олон төрлийн номлол байдаг ч улс төрийн реализм, улс төрийн идеализм гэсэн хоёр уламжлалт чиглэл зонхилдог хэвээр байна.

Олон улсын харилцаа хэмээх улс төрийн тавцанд их гүрэн ноёрхож, давамгайлна гэсэн ерөнхий байр суурийг улс төрийн реалистууд баримталдаг. Улс төрийн идеалистууд олон улсын харилцааг ёс зүйгээр шударга, эрх зүйн үндэстэй зохицуулж болно гэж үздэг. Хэдийгээр ийм хоёр өөр тайлбар байдаг ч аль аль нь олон улсын харилцаанд оршиж буй үндэсний гэх ашиг сонирхлын зөрчил, олон улсын нийгэм-эдийн засаг, соёлын асуудлыг шийдвэрлэх, олон улсын ба үндэсний аюулгүй байдлыг хангах, олон улсын зөрчил, мөргөлдөөнийг зохицуулах, дайныг зогсоох арга зам, хэлбэрийг олж тогтоох зэрэг тулгамдсан асуудлыг зохицуулах гэсэн өөрийн удирдамжаа боловсруулж, санал болгон хэрэгжүүлэх гэж бодит хүч чармайлт тавьдаг байна.

Хүн төрлхөтний эрт үеэс эдүүгээ хүртэл олон улсын харилцаан дахь улс төрийн бодлогыг их гүрэн (эзэнт гүрэн) эсхүл их гүрнээс бүрдсэн холбоод тодорхойлж байв. Тэд өөрсдийн эрх ашгийг урьтал болгож, олон улсын харилцаанд мөрдөгдөх журмыг тогтоож, улс төрийн мөргөлдөөнийг цэрэг зэвсгийн хүчээр шийдвэрлэж, бусад орны дотоод хэрэгт хөндлөнгөөс оролцон бага буурай улс оронд өөрийн бодлогоо тулгаж, бага улсуудын хооронд гарсан маргааныг шүүх ажил эрхэлж байв.

Дэлхийн нөөцийг хувиарлах, дэлхийн үнийн бодлогыг тогтоох, нөлөө үзүүлэх салбарыг тодорхойлох асуудлыг шийдвэрлэхэд хүчирхэг гүрнүүд

хяналт тавьдаг. Нэг улс нөгөө орны үйл ажиллагааг хянах нь олон улсын харилцааны чухал зарчим билээ. Үүнтэй уялдан дэлхийн улс төрийн бодлогыг судлан шинжлэх парадигмын дунд реализм давамгайлалч байр суурь эзэлдэг. Бага улсууд ч гэсэн эдийн засгийн болон үндэсний тусгаар тогтнолын төлөө байнга тэмцэж, улс төрийн холбоо, нэгдэлд багтаж, их гүрнүүдийн ашиг сонирхлын зөрчил мөргөлдөөн дээр тоглолт хийх бодлого баримталдаг байна.

Улс төрийн реализм нь олон улсын харилцаанд тайлбар өгсөн их эртний чиг хандлага юм. Фукидид, Макиавелли, Гоббс зэрэг сэтгэгчдийн бүтээлд улс төрийн реализм боловсрогдон агуулга нь томъёлогдсон байдаг.

Хүч хэрэглэх утга учир шалтгааныг үндэслэн түүнийг цагаатгахын тулд үнэмшилтэй тайлбар-тайлал хийхийг эртнээс ойлгож анхаарч байсныг улс төрийн реализмын түүхээс харж болно.

Улс төрийн реализм шинжлэх ухааны онол гэхээсээ илүү философийн байр суурь хэмээн ойлгох хэрэгтэй гэж америкийн судлаач Р.Гилпин тэмдэглэсэн байдаг. Тиймээс түүнд эмпирик шинжилгээ хийх боломжгүй бөгөөд үнэн худлыг нь тогтоох нөхцөлгүй юм гэжээ. Гэсэн хэдий ч олон улсын улс төрийн бодлогод реализм том байр суурь эзэлж, түүнийг тодорхойлоход голлох үүрэг гүйцэтгэдэг билээ. Улс төр, эдийн засгийн тусгаар тогтнолд заналхийлж болох бодит болон болзошгүй аюулд ямагт бэлэн байх шаардлагатайг Р.Гилпин сануулсан байдаг. (Gilpin R. A realist perspective on international governance // *Governing Globalization: Power, Authority and Global Governance* / D. Held, A. McGrew (eds.). Polity Press, 2002. P. 237)

Олон улсын харилцаанд оролцогч юуны өмнө үндэсний ашиг сонирхлыг урьтал болгодог тул бусдад найдах нь бага. Тийм учир “өөрөө өөртөө тусал” гэсэн зарчмыг улс орон олон улсын системд баримтлах ёстой гэж судлаач К.Уолц үзжээ. (Waltz K. *Theory of International Politics*. 1st ed. McGraw-Hill, Inc. 1979. P. 134)

Экспанс хийх бодол тусгаар улсуудад ямагт байдаг ч түүнийг хэрэгжүүлэх чадалтай улс цөөн ажээ.

Их гүрний экспанс хийх зорилго нь тодорхой шалтгаантай байдаг. Юуны өмнө өөрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилттой холбоотой юм. (Schwarzenberger G. *Power Politics*. P. 79-83.) Түүхийн эдийн эх сурвалж олж авч, зах зээлд дангаараа ноёрхох, стратегийн ач холбогдол бүхий орон зайд хяналт тавих сонирхолдоо хөтлөгдөн их гүрэн хүч хэрэглэн түрэмгийлэл хийдэг.

Английн эрдэмтэн Г.Шварценбергер олон улсын харилцаанд хүч чухал гэдгийг хүлээн зөвшөөрдөг ч тээвэр, холбоо, эдийн засаг-санхүүгийн хамтын ажиллагааны салбарт олон улсын эрх зүй өгөөжтэй “ажиллаж” болно хэмээн үзээд, олон улсын хууль нь ашигтай гэж үзвэл ямар ч хүчтэй улс орон “дүрмээр” тоглодог гэсэн дүгнэлт хийсэн байна. Тусгаар улс нь өөрөө өөрчлөгдөн олон улсын харилцаан дахь анарх тогтолцоог хууль, нийтлэг үнэт зүйлд захирагдсан нийгэмлэг болгон хувиргаж болно гэжээ.

Тусгаар улс нь олон улсын нийгэмлэгт ач холбогдолтой, нэн чухал үүрэгтэй олон улсын харилцаанд оролцдог хэмээн Г.Шварценбергер тэмдэглэсэн байдаг (Schwarzenberger G. *Power Politics*. P. 52-53.). Олон улсын харилцааны оролцогчийн хувьд төр улс нь өөрийн нийгмийг бүхэлд нь төлөөлдөг онцлогтой. Төр нь легитимт бүрэн эрхтэйгээр олон улсын харилцаанд оролцож дайн зарлах, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлдэг цорын ганц байгууллага тул олон улсын тавцан дахь төр улсуудын хоорондын харилцаа нь нэн ач холбогдолтойд тооцогддог. Тусгаар улс нь олон улсын харилцаанд харилцан адилгүй оролцож, түүнд нөлөөлдөг.

Эдийн засаг, цэрэг зэвсгийн хүчин чадал, байгалийн болон ажлын хүчний нөөц, шинжлэх ухаан, техник-технологийн хөгжлийн төвшин, нийгмийн тогтвортой байдал зэрэг нь улс орны олон улсын харилцаанд өрсөлдөх чадварыг тодорхойлдог хүчин зүйл болдог.

Орчин үед бага улс ч гэсэн олон улсын харилцаанд нэн идэвхтэй оролцох болсон байна. Дэлхийд олон орон байдгийн дийлэнх нь жижиг улс юм.

Олон улсын харилцаанд улс орон өөрийгөө багтаан эзлэх байр сууриа зохистой тодорхойлох, үндэсний үзэл, ашиг сонирхлоо хэрэгжүүлэх гэсэн улс төрийн бодлого, үйл ажиллагаа нь дэлхийн улс төрийн уур амьсгалыг тогтоох чухал хүчин зүйл болдог. Олон улсын харилцаанд өрнөж буй үйл явц нь жижиг улсын төр засгийн тэргүүн, тухайн орны олон улсын харилцааг судладаг шинжээчдийн анхаарлыг зүй ёсоор татдаг байна.

Олон улсын тавцанд гарч байгаа үзэгдэл, зүй тогтол зэргийг зүй зохистой таньж мэдэхгүй тохиолдолд тухайн орон өөрийн байр суурийг ойлгон тодорхойлж чадахгүй юм. Олон улсын харилцаа нь хэзээ ч тэгш эрхтэй оролцогчоос бүрдэхгүй гэдгийг хүмүүний түүх гэрчилсэн болно. Хэн хүчтэй нь өөрийн сонирхлыг тулган хүлээлгэж, бусад жижиг улс нь дасан зохицох ажил эрхэлдэг. Тодорхой нөхцөл байдалд гаднаас ямар хатуу хэмжээ хязгаар, хүрээ тогтоож байгааг тодорхойлон өөрийн тоглолтын эрх чөлөөт байдал, идэвхийг тогтоож, олон улсын харилцаанд ямар үүрэгтэй оролцох вэ гэсэн асуудал хурцаар тавигддаг. Их гүрний сонирхлыг “зохицуулах” арга замаар өөрийн аюулгүй байдлыг хангах шаардлага жижиг улсын өмнө байнга тавигдаж байдаг.

Жижиг улсын талаар нэгдсэн ойлголт байдаггүй. Газар нутгийн хэмжээ, хүн амын тоо болон бусад үзүүлэлтээр жижиг улсыг ангилах хандлага байдаг. Хэт бага нутагтай жижиг орон байхад хүн ам цөөтэй өргөн газар нутагтай улс байх жишээтэй тул жижиг улсуудыг хэмжиж шалгуур тогтоох нь боломж багатай юм.

Улс гүрний эдийн засаг, цэрэг зэвсгийн хүч, нөөцийн хэмжээ нь олон улсын харилцаанд үзүүлэх нөлөө бүхий жинтэй хүчин зүйл болдог нь өнөөдөр ч хэвээр байна. Үүний зэрэгцээ дэлхийн улс төрийн бодлогын хүрээнд жижиг төр улсууд олон улсын харилцаанд онцгой байр суурь эзэлдгийг харгалзан үзэх болжээ. Их гүрний зүгээс түүнд тавих анхаарал, сонирхол нэмэгдсэн гэж үзэж болно.

Бага, жижиг орны талаар судалгаа хийгдсэн байдаг ч улс төржсөн нөхцөлд жижиг улс өөрийгөө авч явах чадвар, олон улсын улс төр, эдийн засгийн системд түүний эзлэх орон зай, гүйцэтгэх үүрэг, төрт ёсний төлөвших үйл явц зэрэг асуудлыг эдгээр улсад идэвхтэй шинжлэн судлах болсон.

Америкийн эрдэмтэн Николас Спайкмен жижиг улс нь хүчтэй дарамтны бүсэд үүссэн хоосон зай гэжээ. Өөрөө хүчин чадалтайдаа бус зүгээр л түүний газар нутаг хэнд ч хэрэггүй учир тэрээр оршин тогтнож байгаа юм. Мөн жийрэг улсын хувьд ч гэдэг юм уу, эсхүл тэнцвэржилтийн системд тодорхой элемент болж, хүчтэй орны эрх ашигт нийцсэн тохиолдолд жижиг улс оршин байх боломжтой гэж тэрээр үзжээ. Хүчний тэнцвэржилт алга болсноор жижиг улс үгүй болдог хэмээн дүгэнсэн байдаг. (N.J.Spykman, цитировано по: Amy Vanderbosch, *The Small States in International Politics and Organization*, *The Journal of Politics*, 26, 1964, pp.294-295)

Жижиг улс нь дэлхийн болон бүс нутгийн хэмжээнд улс төрийн хүсэл бодлоо хэрэгжүүлэх, хүчний бодлогоор үндэсний сонирхлоо хамгаалах чадваргүй орон хэмээн голландын эрдэмтэн Л.Жаке тодорхойлсон байна. (L.G.M.Jaquet, *The Role of Small States Within Alliance Systems*, in A.Schou and

A.O. Brundtland (eds.), *Small States in International Relations*, Stockholm, Almquist and Wiksell, 1971, p.58)

Цөөн хүн амтай, бага газар нутагтай орныг жижиг улс гэж үзэхээс гадна мөн дэлхийн үйл ажиллагааны гадна байгаа аливаа улс орныг хэлнэ хэмээн Х.Голдхаммер тэмдэглэсэн байдаг. (H.Goldhammer, *The Foreign Powers in Latin America*, Princeton, Princeton University Press, 1972, p.237)

Өөрт байгаа боломжийг ашиглан аюулгүй байдлаа хангах чадваргүй гэдгээ ойлгож улмаар бусад орон, институт, үйл явц, үзэгдэлд тулгуурлан жижиг улс ашиг сонирхлоо хангах учиртай хэмээн Р.Ротстайн тэмдэглэсэн байдаг. Өөрийн хүчгүйдэлтийг ойлгож буй жижиг улсын “зовлонг” бусад улс орон хуваалцах ёстой гэжээ. (R.Rothstein, *Alliances and Small Powers*, Columbia University Press, New York, 1968, p.29)

Дээрх үнэлгээнд тулгуурлан үндэсний сонирхлоо өөрийн хүчээр хангах чадваргүй, цэрэг улс төрийн хувьд дорой орныг жижиг улс хэмээн тодорхойлж болно.

Өмнө нь дурьдсан үзүүлэлт нь жижиг улсыг тодорхойлоход тодорхой ач холбогдолтой ч түүнийг бүрэн илэрхийлэхгүй юм. Улс орон жижиг ч төр улсын хувьд тогтвортой хүчтэй бат бэх байж болох жишээг Швец, Норвег, Австри, Сингапур харуулж байна. Гэтэл цэрэг-эдийн засгийн хүчтэй улс орон төр улсын хувьд сул дорой асуудалтай байдаг тал ч бий. Тиймээс том, жижиг гэлтгүй улс орны дотоод эдийн засгийн хүчин чадал сул, улс төрийн бодлого тодорхой бус, нийгмийн задралтай, хүчтэй-тогтвортой төрийн байгууллаагүй, үндэсний үзэл санаа төлөвшөөгүй тохиолдолд улс орны өмнө хүндрэлтэй асуудал тулгарч түүнийг шийдвэрлэх зорилт тавигддаг.

НҮБ мэт олон улсын байгууллага үүсээгүй үед либерал ардчилсан дэглэм цөөн байсан ба жижиг улс орон нь хүчтэй гүрний “хоол” болж, тэдний дарамт шахалтанд оршин байсан билээ. Орчин цагт ийм байдал өөрчлөгдөж, нөхцөл сайжирсан ч өөрийн хөгжлийг хангаж чадах жижиг орны тоо нэмэгдээгүй байгааг тэмдэглэх нь зүтэй. Нэгдсэн иргэний нийгэм байгуулаагүй, иргэдийнхээ язгуур эрхийг хамгаалж чаддаггүй, тэдгээрийн нэн тэргүүний хэрэгцээг хангах чадваргүй улс өнөөдөр олон улсын нийгэмлэгт олон байна.

Эдгээр жижиг орон нь улс төрийн тусгаар тогтнолоо олж, зөвхөн олон улсын нийгэмлэг, НҮБ баталгаажсан учир оршин тогтнож байгаа ажээ. Бие дааж хөгжих нөөцгүй, засгийн газар нь иргэний засаглалын энгийн үүргээ гүйцэтгэж чадахгүй (иргэдийн гар дээр байгаа зэвсгийг хурааж авч чадахгүй байх, татварын системийг бүрэн ажиллуулахгүй байх, энгийн дэг журам тогтоох чадваргүй, хууль журам байгаа ч тэр нь мөрдөгддөггүй) байгаа учир энэ хариуцлага гадны хүчинд шилжиж хамтын гэрээгээр шийдвэрлэгдэх нөхцөл үүсдэг. Нөлөө үзүүлж ашиг гаргах гэсэн тэмцлийн үр дүн болж гадаад их гүрний мэдэлд ордог ч явдал бий.

Их гүрэн неореализмын парадигм дээр тулгуурлан хүмүүнлэгийн түрэмгийлэл хийж, эдийн засгийн хориг тавьж, ардчилсан институтийг тулган “дэвшүүлж”, янз бүрийн бүс нутагт хүний эрх, эрх чөлөөний салбарт өөрийн олон улсын хэмжүүрийг тогтоож жижиг орны дотоод хэрэгт оролцох улс төрийн үйл явц хэвийн үзэгдэл болсон байна.

Мэргэжлийн эх сурвалжид ийм орныг квази улс гэж тодорхойлсон байдаг. Жижиг орны талаарх формал тайлбар нь бодит байдлаас хол зөрдөг.

Олон улсын харилцааны нөлөө бүхий парадигм болох улс төрийн реализм, неореализм нь жижиг орны үүрэг, байр суурийг тусгайлан онолын боловсруулалт хийгээгүй байна. Геополитикийн аспектийн хүрээнд жижиг улсыг

огт үгүйсгэлгүй, олон улсын харилцааны гол оролцогч оронд хавсруулан доогуур үнэлдэг хандлага ажиглагддаг.

Бага улсын оршин тогтнож, идэвхтэй үйл ажиллагаа явуулах нь тухайн орны газар зүй, улс төр, эдийн засгийн хүчин зүйлээр нөхцөлддөг байна. Мөн хүчтэй улс орон бага улсыг байлгах сонирхолтой байдаг. Глобал болон бүс нутгийн төвшинд хүчний харьцааг тогтооход бага улс хувь нэмэр оруулдаг чухал үүрэгтэй.

“Хүйтэн дайн” төгсгөл болж, социалист систем задарч олон тооны тусгаар тогтносон бага улс олон улсын тавцанд гарч ирснээр тэднийг тооцож улс төрийн бодлогоо боловсруулах ач холбогдол улам өссөж байна. Үүнийг их гүрнүүд хүлээн зөвшөөрч улмаар олон улсын харилцаа либералчлагдсан болно.

Тусгаар тогтносон төр улс үүсэх нөхцөл, байдал олон янз байдаг. Дийлэнх тохиолдолд шинэ улс орон бүрэлдэн төрөх нөхцөл нь туйлын улс төржсөн шинжтэй байдаг төдийгүй ихэнхдээ хэт популизм дээр суурилсан байв.

ОХУ хэмээх их гүрний эрхшээлд өөрийн гэсэн улс төрийн бодлого баримтлах эрхгүй оршин тогтнож байсан бага улс нь нэгэн цагт улс төрийн эрх чөлөөтэй болж тусгаар тогтнон, туурга тусдаа бие даах болсон ч “нялхсын” өвчинд нэрвэгдэж, өөрийгөө авч явах бодит хүндрэлтэй тулгаран тодорхой субъектив хүчин зүйлээр хавсруулан бэрхшээл туулан урагшлах болсон байна. Эдгээр орнууд нийгэм-эдийн засгийн хүндрэлтэй тулгарч, шинэ улс төрийн системийг бүрдүүлж, төрт ёсны соёл төлөвшүүлэх үйл ажиллагааны зэрэгцээ нэн нарийн төвөгтэй улс төр, нийгэм, эдийн засгийн механизмыг бүтээж, газар зүй-гео улс төрийн бодит байдлыг таньж, улс төрийн бодлогоо тодорхойлох шаардлага төрийн эрх мэдэл эзэмшигчдийн өмнө тулгараад байна.

Бага улсын гадаад бодлого, үндэсний сонирхол зэрэг нь бүс нутгийн шинжтэй ба тухайн нутагт бодит үр дүнтэй, ашигтай үйл ажиллагаа явуулах боломжтой. Тив дамнан зорилгоо гүйцэлдүүлэх нь их гүрний төрийн сонирхол, ашигт нийцсэн тохиолдолд яригдах асуудал юм.

Их гүрний сонирхол, анхаарал төвлөрсөн, соёл иргэншлийн зааг дээр болон глобал улс төр, эдийн засгийн асуудал зангилагдсан орон зайд нутагтай бага улсын ач холбогдол өсөн нэмэгдэх чиг хандлагатай байдаг. ОХУ, БНХАУ зэрэг хүчирхэг хөрш гүрэнтэй хил залгаа Монгол улсын хувьд улс төрийн систем, эдийн засгийн хүчин чадал зэрэг үзүүлэлт нь бусад “жирийн” орноос нэн өөр утга агуулдаг онцлогтой ажээ.

Хүчирхэг хөрштэй байх нь бага улсад гадаад улс төрийн сонголт хийх боломж тун хомс юм. Хүчирхэг гүрний “нөлөөнд” орж сонирхлыг нь татах хариуцлагатай улс төрийн бодлого бага улсад байдаг. Үүнийг хэрэгжүүлснээр бага улсад нийгэм-эдийн засгийн ашиг хонжоотой төдийгүй мөн улс төр, үндэсний аюулгүй байдлыг хангаж, улс орны тусгаар тогтнолын баталгаа болдог байна.

“Тоглоомын дүрмийг” их гүрэн өөрөө тогтоож, бусдын үйлдэлд зохистой хариу өгч улс төрийн бодлого зохицуулан тохиргоо хийж байдаг ажээ. “Нөлөө үзүүлэх хүрээгээ” хүчирхэг орон харьцангуй тайван тохинуулах сонирхолтой байдаг ч хүч хэрэглэн дарамт үзүүлэх зэрэг “бохир” аргыг ч ашиглахаас буцдаггүй билээ.

Глобал болон бүс нутгийн интеграцлах үйл явц эрчимтэй явагдаж байгаа өнөө үед дэлхийн улс орнууд олон улсын харилцаанд унитар бус оролцогч болж хувирсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй болов уу. Үүнтэй уялдан чадвартай эдийн засагтай, тусгаар тогтносон төр улсыг бүтээх бодит, зүй зохистой чиг хандлага бол хөрш зэргэлдээ улс оронтой бүх талаар ойртон нягтрах, ашигтай түншлэх явдал юм. Ялангуяа хуучин холбоо, харилцаагаа сэргээх нь тун ач холбогдолтой ажээ.

Олон талт гадаад бодлого баримталж, бага орон аюулгүй байдлаа бэхжүүлэх тогтолцоонд (системд) аль болох олон орныг оролцуулах нь бага орны үйл ажиллагааны нэг чухал чиглэл болдог. Олон улсын харилцааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрүүлэх, олон улсын эрх зүйн системийг цаашид хөгжүүлэх үйл ажиллагааг бага улс нь бүх талаар дэмжих нь түүнийг өөрийнх нь хөгжилд нэмэртэй төдийгүй гадаад гүрний эрхшээлд орохгүй байх боломжийг нээдэг байна.

“Сайн удирдлага” тогтоох нь дотоод тогтвортой байдлыг бүрдүүлэн, их гүрэн бага орны дотоод хэрэгт хүмүүнлэгийн экспанс болон шууд түрэмгийлэл зэрэг ил, далд оролцох аюулыг багасгаж байдаг. Хүн төрөлхтний үнэт зүйлсийг эрхэмлэж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн, тогтвортой хөгжлийн бодлогыг баримтлах нь бага орны улс төрийн бодлогын нэн чухал зарчим, байр суурь юм.

Резюме

Малые страны вынуждены обеспечивать свою безопасность не балансом сил, а балансированием интересов великих держав, которые определяют характер стратегического поля, в котором находится данная малая страна. Малые страны должны всемерно поддерживать дальнейшее развитие системы международного права и легитимизации международных отношений, что усиливает легитимность их существования и выступает гарантией безопасности малых стран. Одним из важнейших направлений политики малых стран является установление "хорошего правления" (good governance) в своих странах, что уменьшает опасность внутренней нестабильности и устраняет возможность для великих держав вмешиваться во внутренние дела малых стран. Нужно принятие общечеловеческих ценностей, соблюдение прав человека, стратегии устойчивого развития являются важными моментами стратегической политики малых стран.

НИЙТЛЭЛИЙН ШААРДЛАГА, СТАНДАРТ

Эрдэмтэд, судлаачид Та бүхнийг **Политологи** сэтгүүлд эрдэм шинжилгээний өгүүлэл, судалгааны тайлан, илтгэл, шүүмж өгүүлэл зэргээ нийтлүүлэхийг урьж байна. Сэтгүүлийн зөвлөл нь тухайн бүтээлийг зөвхөн зохиогчийн зөвшөөрлийн дагуу албан ёсоор хүлээн авсны дараа сэтгүүлийн агуулга, зорилгод нийцүүлэн сонгон шалгаруулж нийтлэнэ.

Бүтээлээ ирүүлэхдээ хэвлэмэл 1 хувийг сэтгүүлийн хаягаар, түүнчлэн электрон файлаар ssrg@num.edu.mn хаяг руу хавсаргах шаардлагатай.

Бүтээлд тавигдах шаардлага:

- Сэтгүүлд ирүүлэх бүтээл нь урьд өмнө хэвлэгдээгүй байх
- Бүтээлийн хураангуй нь 150-иас ихгүй үгтэй байх ба монгол, орос, англи хэлний аль нэг дээр байх.
- Бусдын бүтээлээс текст, зураг, график зэргийг ашигласан бол эх сурвалжийг тодорхой дурьдах
- Бүтээлийн өмнө зохиогчийн нэр, эрдмийн зэрэг, цол, эрхэлж буй ажил, ажлын газар, бүтээлийн гарчиг зэргийг бичих

Сэтгүүлд нийтлэгдэх бүтээлтэй холбоотой аливаа асуудлыг зохиогч өөрөө хариуцна.

Сэтгүүлийн зөвлөл